

## Бүлэг 7 Аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ


Төслийн баг нь Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) болон Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) -тай хамтран 2019 оны 3-8 дугаар сарын хооронд 21 аймагт семинар, хэлэлцүүлэг зохион байгуулж, хөгжлийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Энэхүү бүлэгт аймгуудын хөгжлийн дүн шинжилгээг хийх болсон зорилго, үйл явц болон Бүлэг 6-д эдийн засгийн шинэ бүсчлэлийн талаар танилцуулна. Санал болгож буй эдийн засгийн зарим бүсүүд нь одоогийн бүсчлэлтэй давхцаж байгаа болно.

### 7.1 Хөгжлийн дүн шинжилгээний ач холбогдол, ажлын явц

#### 7.1.1 Хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулахад дүн шинжилгээ хийхийн ач холбогдол

Аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ нь ЖАЙКА-гаас хэрэгжүүлж буй үндэсний болон бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн шатанд онцгой ач холбогдолтой юм. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө (ҮХЦТ) нь Бүсчилсэн хөгжлийн бодлого (БХБ) болон Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн (ХАНСХЕТ) агуулгыг хамрах бөгөөд макро түвшний, салбарын түвшний, бүс нутгийн түвшний дүн шинжилгээг багтаана. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг Зураг 7.1.1-д үзүүлэв.

Зураг 7.1.1 Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Макро түвшний дүн шинжилгээг макро эдийн засаг, орон нутгийн дэд бүтцийн хөгжил, нөөц баялагтай уялдуулан боловсруулж, Монгол Улсын хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлсон. Энэхүү дүн шинжилгээнд үндэслэн макро түвшний хөгжлийн хувилбаруудыг боловсруулсан бөгөөд олон төрлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, цаашид дэлгэрүүлэн авч үзэх оновчтой хувилбарыг сонгосон. Хөгжлийн макро түвшний зорилт, үндсэн стратегид нийцүүлэн Монгол Улсын хөгжлийн хувилбарыг боловсруулсан.

Салбарын түвшний дүн шинжилгээг хийхдээ салбарын хөгжлийн стратегийг макро түвшний хөгжлийн зорилт, үндсэн стратегид суурилан боловсруулсан. Салбарын хөгжлийн стратегийг боловсруулах эхний үе шатанд одоо байгаа тайлан, статистик мэдээнд үндэслэн хөгжилд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон. Эдгээр асуудлуудыг Монголын талын хамтран ажиллагч

байгууллагуудтай хэлэлцүүлэг өрнүүлж, нягтлан тодруулсан бөгөөд одоогийн нөхцөл байдалтай биечлэн танилцаж дээрх тулгамдаж буй асуудлуудыг эцэслэн тодорхойлсны үндсэн дээр салбарын түвшний хөгжлийн стратегийг боловсруулсан.

Орон нутгийн түвшинд дүн шинжилгээ хийж, макро түвшний хөгжлийн зорилт, үндсэн стратегид тулгуурлан орон нутгийн хөгжлийн стратегийг боловсруулсан. Орон нутгийн түвшний дүн шинжилгээг засаг захиргааны бүтэц, бүсийн хөгжилд эзлэх байр суурь болон газар зүйн байршилд үндэслэн тодорхойлдог. Монгол орны хувьд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд орон нутгийн түвшний дүн шинжилгээ хийхэд тохиромжтой байна. Тиймээс хөгжлийн дүн шинжилгээ хийхдээ аймаг тус бүрээр газар зүйн нөхцөл байдал, хөгжлийг хязгаарлаж буй асуудал болон цаашдын хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломжийг тодорхойлсон.

ЖАЙКА-гийн төслийн хамрах хүрээ нь макро болон бүсийн түвшний хөгжлийн төлөвлөгөө боловч аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ хийх нь хөгжлийн алсын харааг оновчтой тодорхойлох, бүс нутгийн хөгжлийг өргөн хүрээгээр судлахад ач холбогдолтой гэж үзсэн. Энэ нь эдийн засгийн бүсчлэлийг шинээр тодорхойлох асуудал тавигдаж буй одоо үед маш чухал юм. Бүсийн хөгжлийг аймгийн түвшний мэдээлэл, дүн шинжилгээ, төлөвлөлтгүйгээр тодорхойлох нь учир дутагдалтай юм.

### **7.1.2 Аймгийн хөгжлийн дүн шинжилгээ хийх арга зүй**

Нэгдүгээрт аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ хийхдээ салбарын болон аймгийн нөхцөл байдал, статистик тоо баримтад тулгуурлахын зэрэгцээ тухайн салбарт ажилладаг цөөн тооны мэргэжилтнүүдээс ярилцлага авсан. Аймгуудын хөгжлийн урьдчилсан дүн шинжилгээг Хүснэгт 7.1.1-т үзүүллээ. Энэхүү хүснэгтэд одоогийн нөхцөл байдал, орон нутгийн хөгжилд тулгарч буй асуудал, хөгжлийн ирээдүйн хэтийн төлвийг урьдчилсан байдлаар тодорхойлон нэгтгэсэн.

Хоёрдугаарт ЖАЙКА-гийн төслийн багийн гишүүд аймгуудад томилолтоор ажиллаж, нутгийн удирдлагын байгууллага, иргэдийн төлөөлөгчид, хувийн хэвшил, нутгийн иргэдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, урьдчилсан дүн шинжилгээг нягталж тодруулах, нэмэлт мэдээлэл авах, орон нутгийн иргэдийн эрэлт хэрэгцээ, хүсэл эрмэлзлэлийг мэдэх зорилготой байсан. Аймгуудад хэлэлцүүлэг зохион байгуулж, хөгжлийн урьдчилсан дүн шинжилгээг танилцуулан, хэлэлцүүлэгт оролцогчдоос асуулга авч тодрууллаа. Мөн хэлэлцүүлэгт оролцогчид багаар ажиллаж аймагтаа тулгамдаж буй асуудлууд, аймгийн нөөц боломж, хэтийн төлвийг тодорхойлсон. Багуудын төлөөлөл хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулсан. Энэхүү аргачлал нь багийн гишүүд цөөн байх тусам оролцогчид өөрийн санал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгодог.

Гуравдугаарт ҮХЦТ-нд аймгийн хэлэлцүүлэг, олон нийтийн уулзалтаас гарсан үр дүнг харгалзан, аймгийн хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлж, тодорхой төсөл, хөтөлбөрийг санал болгоно. Төлөвлөлтийн шатны аймгуудын хөгжлийн дүн шинжилгээг тайлангийн дараагийн хэсэгт орууллаа. ЖАЙКА-гийн төслийн хүрээнд санал болгож буй төслүүдийн нийгэм болон байгаль орчны нөлөөллийг оролцооны аргаар аймгийн түвшинд үнэлэх болно. Аймгийн хэмжээнд зохион байгуулах хурал уулзалтад тухайн аймгийн бүх сумдын удирдлагуудын төлөөлөл болон бусад оролцогч талууд оролцож, Монгол Улсын хууль эрх зүйн хүрээнд санал болгож буй төслүүд Байгаль орчны стратегийн үнэлгээнд хэр нийцэж буйд үнэлгээ өгөн саналаа тусгах шаардлагатай.

### Хүснэгт 7.1.1 Ховд аймгийн хөгжлийн дүн шинжилгээ (загвар жишээ)

Үндсэн мэдээлэл		
Нутаг дэвсгэр: 76,1 мянган км <sup>2</sup>	Хүн амын тоо: 86,4 мянга (2017)	Хүн амын нягтрал: 1.14/км <sup>2</sup>
Хүн амын жилийн дундаж өсөлт: 0.60% (1990-2000); 0.00% (2000-17)		Хотжилтын түвшин: 34.1% (2017)
ДНБ бүтэц: ХАА 43%, Үйлдвэрлэл (барилгын салбарыг оролцуулан) 19%, Үйлчилгээ 38% (2017)		
Газрын нэгдмэл сан: Ойн сан 4,674км <sup>2</sup> (6.1%); Тариалангийн талбай 2,257 га (үр тариа 230 га, хүнсний ногоо 860 га, төмс 693 га, малын тэжээл 472га; 2017)		
Одоогийн нөхцөл байдал		
<u>Газар зүйн нөхцөл байдал</u> Дунд хэсгээрээ Монгол Алтайн Нуруу; хойд хэсгээрээ цөлөрхөг нутаг болон тал хээрээр хүрээлэгдсэн, давстай нууруудтай. Өмнөд хэсэгтээ Говь цөлийн нутагтай. Хар металл, өнгөт металл, барилгын материал, түлш, нүүрс, төмрийн хүдэр, зэс, хар тугалга, гантиг, боржин чулуу, шар зос зэрэг байгалийн баялагтай. Аргал, янгир, цоохор ирвэс, бөхөн гөрөөс, алагдаахай, тахь зэрэг ховор амьтад амьдардаг томоохон газар нутгийг дархлан хамгаалсан. Олон төрөл зүйлийн шувууд ирдэг нууруудтай. Далайд цутгадаггүй тул гол горхиуд нь элсэнд хучигдсан эсвэл давстай устай намгархаг газар шингэн, ширгэж байна. Цөлийн чулуу, давстай нуур, цаст оргил болон олон ястны соёл, уламжлалтай аймаг.		<u>Нийгмийн асуудлууд</u> 17 гаруй үндэстэн, ястны өв соёл бүхий хүн амтай; Ажиллах хүчний коэффициент: 62.3%; Ажиллах хүчний оролцооны түвшин: 71.0% (10-р байр); Эдийн засгийн идэвхтэй хүн ам: 46.5% (15-р байр); Ажилгүйдлийн түвшин өндөр: 13.5% (18-р байр); Төрийн албан хаагчдын харьцаа: 15.6% (6-р байр); Бага (11-р байр), суурь (8-р байр) болон бүрэн дунд (10-р байр) боловсролын элсэлтийн харьцаа хэвийн түвшинд; Сургуулийн өмнөх (11-р байр), бага (10-р байр) болон дунд (6-р байр) боловсролын сурагч-багшийн харьцаа дундаж; Эмч (8-р байр) болон сувилагч (9-р байр) хүртээмж дунджаас илүү; 10,000 хүн тутмын хөнгөн халдварт өвчин: 59 (3-р байр).
<u>Эдийн засаг</u> Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ бага: 3,789,000₮ (20-р байр); Хөдөлмөрийн бүтээмж харьцангуй бага: 9,436,000₮ (16-р байр); Нэг малчин өрхөд ногдох малын тоо: 438 (8-р байр); 100 га бэлчээрийн нутагт ногдох малын тоо: 102 (12-р байр); 44.1% нь мал аж ахуй эрхэлдэг (12-р байр); Ургац: амуу тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээл; тарвасаараа алдартай; Аж үйлдвэрийн салбарын борлуулалт: 125.9 тэрбум ₮ (8-р байр); ДНБ-д эзлэх хувь: 38.9% (14-р байр) Аж ахуйн нэгж, байгууллагын тоо - 1,934 (4-р байр), хувийн ААН, байгууллага 1,728 (4-р байр), томоохон ААН, байгууллага 46 (8-р байр); Хүнс боловсруулалт ба барилгын материалын зарим хөнгөн үйлдвэрүүдтэй;		<u>Дэд бүтэц</u> Томоохон хэмжээний усны цахилгаан станцын төсөл хэрэгжиж байна. Ховд аймгийн цахилгаан түгээх сүлжээ компани нь ОХУ-аас импортлосон эрчим хүчээр хангагддаг. Авто замын чанар муу (19-р байр) Хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ногдох тээврийн хэрэгслийн тоо: 16 (7-р байр) 1,000 айл өрх тутамд ногдох утасны шугам: 6 (19-р байр) 1,000 айл өрх тутамд ногдох ус хангамжийн цэг: 5 (9-р байр) Дулааны эрчим хүчний үнэ: 440м <sup>2</sup> /төгрөг (9-р байр) Эрчим хүчний доод үнэ: 106кВтц/төгрөг (1-р байр) Цахилгаан хэрэгсэлтэй малчин өрхийн харьцаа: 89.1% (4-р байр) Шатахууны дээд үнэ: 1,687төгрөг/литр

Зээлтэй өрхийн эзлэх хувь бага: 28.8% (19-р байр)	(21-р байр)
<b>Тулгамдаж буй асуудлууд</b>	
Аймгийн төвийн хүн ам цөөн: 29,800; Аймгийн хүн амын өсөлт бага; Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ том; Эдийн засаг төрөлжөөгүй; Хөдөө аж ахуйн салбарын бүтээмж бага; Аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувь бага; Эдийн засгийн бүтэц сул.	Хөдөлмөрийн бүтээмж бага, ажилгүйдэл, гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөн их; Үр дүнгүй төрийн үйлчилгээ; Нийгмийн үйлчилгээ, дэд бүтэц сул; Моргейжийн зээлэнд хамрагдах боломж хязгаарлагдмал; Хөрөнгийн хуримтлал бага.
<b>Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж</b>	
Ховд аймаг ОХУ-ын харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлж, Баруун бүсийн аж үйлдвэрийн төв болгож хөгжүүлэх; Жимс, ногоо, малын тэжээлийн аж ахуйд суурилсан бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх; Байгалийн баялаг нөөцийг ашиглан барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэх; Хуурай газрын газар тариалан, биологийн олон янз байдал, олон үндэстний өв соёлын судалгаанд чиглэсэн Баруун бүсийн дээд боловсрол, судалгааны төвийг байгуулж, олон улсын эрдэмтэн, судлаачдыг урьж авчрах;	Байгаль орчин, цэнгэг болон давстай нуурууд, уулс, хөндий, агуй, эртний хадны зураг болон хэрэм зэрэгт суурилсан аялал жуулчлалын хөгжил; Дотоодын болон олон улсын аялал жуулчлал, спорт агнуурын хөгжил; Уламжлалт гэр сууц, суурьшлын хэв маяг, хувцас өмсгөл, үндэстэн ястнуудын өв соёлын онцлог, утга зохиол, урлаг болон хөгжмийн уламжлалыг ашиглаж аялал жуулчлалыг төрөлжүүлэх.

Эх сурвалж: Монгол: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2018, Статистикийн эмхэтгэл 2017 болон бусад эх сурвалжууд

## 7.2 Баруун бүсийн аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ

### 7.2.1 Баян-Өлгий аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал

##### Газар зүйн нөхцөл байдал


Баян-Өлгий аймгийн газар нутгийн хэмжээ харьцангуй бага 48,7 мянган км<sup>2</sup> бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрийн хамгийн баруун захад Улаанбаатар хотоос 1260 км зайтай, ОХУ, БНХАУ-тай хил залгаа оршдог. Уур амьсгалын хувьд дунд зэргийн хэдий ч жилд орох хур тунадасны хэмжээ маш бага, жилийн дундаж агаарын температур -4-0 хэм байдаг. Аймгийн нийт нутаг дэвсгэр нь Монгол Алтайн нурууны бүсэд далайн түвшнээс дээш 1,500 м-т өргөгдсөн байдаг. Зөвхөн Увс аймагтай хиллэдэг нутгийн зүүн хойд хэсэгт Ховд голын сав газар үргэлжилдэг. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 10%-ийг ойн сан эзэлдэг. Алтай нурууны хамгийн өндөр оргил Таван Богд уул сүндэрлэх бөгөөд түүнээс Ховд гол эх аван Увс аймгийн Хяргас нуурт цутгадаг.

Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газар 6,362 км<sup>2</sup> нутаг дэвсгэрийг хамардаг бөгөөд Таван Богд уулын өмнөд хэсэгт оршдог. Энэхүү байгалийн цогцолбор газарт Хурган нуур оршдог бөгөөд мөнх цаст оргил, уулархаг нутгийн олон төрөл зүйлийн амьтад нутагладаг. Нутгийн малчид нь уламжлалт, нүүдлийн соёл ахуйгаа хадгалан, бүргэд сургаж ан агнах, сүү сүүн бүтээгдэхүүнийг өвөрмөц



аргаар боловсруулан амьдардаг байна.

### Зураг 7.2.1 Баян-Өлгий аймгийн байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

Баян-Өлгий аймгийн нийт хүн амын 90 гаруй хувь нь казахууд, үлдсэн хувийг тува, урианхай, дөрвөд, халхууд эзэлдэг. Казах, Монгол хэл гэсэн албан ёсны хоёр хэлтэй ба казах үндэстэн зонхилон амьдардгаараа бусад аймгуудаас өвөрмөц онцлогтой юм.

Баян-Өлгий аймгийн хүн ам 2010-2015 оны хооронд 2.76 хувиар өссөн ч 1989-2010 оны хооронд огт өсөөгүй байна. Төслийн багаас зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид хүн ам өсөж буй шалтгааныг 1) Казахстанас шилжин ирсэн эсвэл өмнө нь явсан хүмүүс буцаж ирсэн, 2) Нийгмийн халамж ялангуяа хүүхдийн мөнгө өгөх болсон гэдгээр тайлбарлаж байлаа.

Баян-Өлгий аймгийн эдийн засагт мал аж ахуй зонхилох байр суурь эзлэх бөгөөд

2017 онд 2,226,100 мал тоологдсон хэдий ч Баруун бүсийн аймгуудын дунд хамгийн бага малтай аймаг юм. Мал сүргийн дийлэнх хувийг хонь, ямаа эзлэх бөгөөд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй зонхилж буйг нэг өрхөд ногдох малын тоо 240 (19-р байр) байгаагаас харж болно. 1,222 га тариалангийн талбайтай Баян-Өлгий аймагт Баруун бүсийн нийт тариалангийн талбайн 10% ногддог. Хөдөлмөрийн бүтээмж хамгийн бага, дундаж цалингийн үзүүлэлтээр бусад аймгуудаас бага байна.

Баян-Өлгий аймгийн төсвийн орлогыг мал аж ахуй, аялал жуулчлалын салбар бүрдүүлдэг, аялал жуулчлалын нөөц газар элбэгтэй. Ялангуяа Цэнгэл сумын баруун хэсэгт орших Алтай Таван Богд байгалийн цогцолборт газарт жуулчид зуны улиралд олноор ирдэг. Монгол Алтайн нуруу, ялангуяа Алтай Таван Богд уул нь улсын хэмжээнд ч аялал жуулчлалын чухал нөөц газарт тооцогддог бөгөөд жилд 5,000 орчим жуулчид мөнх цаст уул, уулархаг бүсийн ургамал, ан амьтан, шилмүүст ойг үзэхээр ирдэг байна.

2017 онд Баян-Өлгий аймгийн аж ахуйн нэгж байгууллагын тоо 1,512 (7-р байр) байснаас дийлэнх нь буюу 1323 (6-р байр) нь хувийн хэвшлийн байгууллага бөгөөд 45 нь томоохон аж ахуйн нэгж байгууллага байв. Мөн эдийн засгийн төрөлжилт харьцангуй сайн бөгөөд улсын хэмжээнд 5-р байранд орж байна. Мал аж ахуй нь эдийн засгийн голлох салбар боловч аймгийн эдийн засаг бүхэлдээ түүнээс хамааралтай гэсэн үг биш юм. Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын салбар нь Монгол Улсын эдийн засгийн голлох салбар болох уул уурхайгаас шууд хамааралтай бус гэдгийг харж болно. Тус аймагт аж үйлдвэрийн салбар маш бага хувийг эзэлж байна.


Баян-Өлгий аймагт эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь 52.5 (2-р байр) байгаа ч ажилгүйдлийн түвшин 12.4%-тай байна. Аймгийн эдийн засагт үйлдвэрлэл, үйлчилгээний салбар бага хувийг эзэлж байгааг нэг хүнд ногдох БДНБ, ажиллах хүчний бүтээмж, дундаж цалингийн хамгийн бага үзүүлэлт зэргээс харж болно.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Баян-Өлгий аймгийн хотжилтын түвшин 2010 оноос хойш хамгийн тогтвортой түвшинд буюу 36 орчим хувьтай байна. Баруун бүсийн аймгуудын хувьд хотжилтын түвшин тогтвортой өсч байгаа ч улсын дундаж 67.2% (2017 оны байдлаар )-иас доогуур байна. Дээр дурдсанаар нэг хүнд ногдох БДНБ болон бусад үзүүлэлтүүд бага байгаа нь хотжилтын түвшинтэй шууд хамааралтай. Нөгөө талаар хотжилтын түвшин бага байснаар казак соёл, нүүдэлчдийн амьдралын хэв маяг хадгалагдаж байгаа гэж дүгнэж болох юм.

Баян-Өлгий аймаг авто замын сүлжээ харьцангуй сайтай бөгөөд АХБ-ны санхүүжилтээр Өлгий хотыг ОХУ-тай хил залгаа Цагааннуурын чөлөөт бүс болон аймгийн хойд хэсгийн сумдыг холбосон авто замыг барьж, 2020 онд ашиглалтад оруулна (Зураг 7.2.2). Мөн Ховд-Өлгий хотыг холбосон авто замыг (Зураг 7.2.3) АХБ-ны санхүүжилтээр барьж байгуулан, 2019 оны 9-р сард ашиглалтад оруулсан. Гэсэн хэдий ч сум хоорондын авто замын сүлжээ муугаас Алтай таван богд байгалийн цогцолборт газар руу жуулчид зорчиход хүндрэл тулгарсаар байна. 2018 оны “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан”-нд Баян-Өлгий аймгийн авто замын нөхцөл байдлыг хамгийн муу буюу 21-р байранд оруулсан байна.

### Зураг 7.2.2 АХБ-ны санхүүжилтээр баригдах авто зам



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Зураг 7.2.3 Ховд-Өлгий чиглэлийн АХБ-ны санхүүжилтээр баригдаж буй авто замын танилцуулга самбар



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Баян-Өлгий аймаг нь Баруун бүсийн Эрчим хүчний системд холбогдож, ОХУ-аас эрчим хүчээ импортлодог, цахилгааны өндөр зардалтай аймаг юм. Баруун бүсийн хөгжилд цахилгааны найдвартай, тогтвортой эх үүсвэр маш чухал үүрэгтэй. Аймаг нь газар зүйн байршлын хувьд уулархаг нутагтай тул усан цахилгаан станц байгуулах боломжтой. Баруун аймгуудын цахилгаан эрчим хүчний хэрэгцээг усан цахилгаан станцаар хангах төсөл хэдэн жилийн өмнөөс төлөвлөгдөж байсан боловч нарийвчилсан судалгаа, цахилгаан станцын зураг төсөл ч хийгдээгүй байсаар байна.

Аймгийн хэмжээнд 1000 өрхийг хангах уст цэг зөвхөн 2-той (19-р байр) бөгөөд усан хангамжийн барилга, байгууламж хангалтгүй байдаг. Гэхдээ энэ нь урт хугацаанд тийм ч ноцтой асуудал биш юм. Учир нь гадаргын усны нөөц харьцангуй сайтай учраас усан хангамжийн асуудлыг шийдэх боломжтой.

## (2) Тулгамдаж буй асуудлууд

### 1) Нийгэм, эдийн засаг

Баян-Өлгий аймгийн эдийн засагт аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн эзэлж буй хувь хэмжээ бага байгаа нь хөгжлийн хувьд тулгарч буй асуудал юм. Аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь бага байгаагийн шалтгаан нь мах, арьс шир, сүү сүүн бүтээгдэхүүнийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх чадавх, нөөц хангалтгүй байгаад оршино. Мөн зэргэлдээ орших

Баруун бүсийн тулгуур төв Ховд хот төдийгүй ОХУ, БНХАУ-тай харилцах давуу талаа төдийлөн ашиглаж чадахгүй байна.

Газар нутаг томтой боловч уулархаг нутагтай, тариалангийн талбай багатай учраас үр тарианы дотоодын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь аймгийн хөгжилд нөлөөлж байна. Үр тариа, төмс, хүнсний ногооны ургац бага авдаг нь хүнсний аюулгүй байдал болон иргэдийн эрүүл мэндэд нөлөөлдөг.

Аж үйлдвэрийн хөгжил дутмаг болон хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бүтээмж доогуур байгаа нь ажлын байр бий болгох боломжийг хязгаарлаж байна. Цэнгэл сумын нутагт вольфрамыг бага зэрэг олборлож байна. Их дээд сургууль төгсөгчдөд ажлын байр олдохгүй байгаагаас шалтгаалж Баян-Өлгий аймагт шилжин ирж, суурьших сонирхол бага байна. Баруун бүсийн бусад аймгуудтай харьцуулахад амьдрах орчны нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар ч төдийлөн сайн биш байна.

Сургуульд хамрагдалтын түвшин болон сурагч-багшийн харьцаа дунд зэрэг. Төвөөс алслагдсан сумдад сургуулийн анги, танхим хүрэлцээ муу, сурагчид сумын төвд малчин эцэг, эхээсээ хол амьдарч боловсрол эзэмшиж байна.

## 2) Байгаль орчин

2019 оны 6 сарын 14-ний өдөр Өлгий хотод зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн үеэр хуралд оролцогчид хатуу хог хаягдал, агаарын бохирдолын асуудлыг түлхүү хөндөж байсан. Хэлэлцүүлэгт оролцогчид хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн худгийн ус ихээр бохирдож байгаа талаар болон 2000 оноос хойш Өлгий хотын усан хангамж боломжийн түвшинд байгаа хэдий ч усны чанар сайн биш байгаа тухай дурдсан. Мөн аялал жуулчлалын үйл ажиллагаа нутгийн иргэдийн амьжиргаа сайжрахад нөлөөлж байгаа боловч байгаль орчны хамгаалалтын асуудал үүнээс ч чухал гэдгийг онцлон тэмдэглэж байлаа.

## 3) Дэд бүтэц

Баян-Өлгий болон Баруун бүсийн бусад аймгууд ОХУ-ын эрчим хүчний сүлжээнээс цахилгааны хувьд хамааралтай, Улаанбаатар хотоос алслагдмал байгаа нь сул талууд болж байна. Үүнээс үүдэж барилгын материал, тоног төхөөрөмжийн үнэ өндөр байдаг нь Баруун бүсийн иргэдийн амьдрах орчинг дээшлүүлэхэд тулгардаг түгээмэл бэрхшээл болж байна.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Баян-Өлгий аймгийн хөгжил нь Баруун бүсийн хөгжилд чухал ач холбогдолтой бөгөөд Улаанбаатар хотын эдийн засаг, үйлдвэрлэлээс хэт хамааралтай байх нь зохисгүй. АХБ-ны санхүүжилтээр баригдаж буй авто зам нь ОХУ, БНХАУ, Казахстан улсын эдийн засгийн коридорыг холбоход чухал ач холбогдолтой. Өлгий хот нь дээрх авто замын дагуу оршдог төдийгүй Ховд хоттой холбогдсон гол зам, коридорын дагуу байрлаж байгаагийн хувьд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, газар тариалан, аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлагатай.

БНХАУ-ын Даяннуураас Өлгий хотоор дамжих А15 авто зам нь ОХУ-ын Ташантатай холбогдох бөгөөд Баян-Өлгий аймгийн хөгжилд онцгой нөлөөтэй. Цагааннуурын чөлөөт бүсийг дайран гарах А306 авто зам ойрын хугацаанд ашиглалтанд орсноор зэргэлдээ бүсүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээний үйл

ажиллагааг дэмжихэд чухал түлхэц болно. Чөлөөт бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахын зэрэгцээ Засгийн газраас орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн бичил зээлийг олгох хэрэгтэй.

Баян-Өлгий аймагт хагас эрчимжсэн болон бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг зонхилон эрхэлдэг боловч тус аймагт эрчимжүүлсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх шаардлагатай байна. Бүсийн болон сум орон нутгийн хэмжээнд ойрын хугацаанд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, малын түүхий эдийг боловсруулж экспортод гаргах зах зээлийг хөгжүүлэх нь зүйтэй. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргах, ялангуяа халал аргаар бэлтгэсэн махыг мусульман шашинтнуудын зах зээлд гаргах шаардлагатай байна.

Хагас эрчимжсэн мал аж ахуйг бэлчээрийн уламжлалт мал аж ахуйтай хослуулан эрхлэх шаардлагатай. Бэлчээрийн талхагдлаас хамгаалж, бэлчээрийн менежментийн тухай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, нутгийн удирдлагын байгууллага болон иргэдийн үр ашигтай хяналтыг сайжруулах шаардлагатай.

Үр тарианы үйлдвэрлэлийн хувьд аймаг нь дунд болон урт хугацаанд дотоодын хэрэгцээгээ өөрсдөө хангадаг болох хэрэгтэй. Үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлсний үр дүнд газар тариалангийн үйлдвэрлэлийг механикжуулах болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх боломж байна. Ховд голын сав газрын дагуу усжуулалтын системийг өргөжүүлэх шаардлагатай. Эхний ээлжинд жимс жимсгэнэ, самрын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангасны дараа экспортод гаргах хэрэгтэй.

Олон ястны соёл, зан заншилд түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж их байна. Хэлэлцүүлгийн үеэр ихэнх оролцогчид олон ястны соёлыг давуу тал гэж үзэж байсан. Баян-Өлгий аймагт зохион байгуулагддаг 'Бүргэдийн баяр' нь жуулчдад орон нутгийн соёлыг сурталчлах нэгэн чухал арга хэмжээ юм. Засгийн газрын хүлээх үүрэг нь дэд бүтцийг барьж байгуулах, ялангуяа хатуу хог хаягдлыг зайлуулан, устгах байгууламж барих, жуулчид зорин очдог чиглэлийн авто замыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах хууль журмыг чангатгах зэрэг юм. Нөгөө талаар аялал жуулчлал эрхэлдэг компаниуд хөтөч орчуулагчийг чадавхжуулах, жуулчдын сонирхол татсан арга хэмжээг зохион байгуулах, байгаль орчны талаарх иргэдийн ухамсарыг дээшлүүлэхэд хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Цахилгааны эх үүсвэрээр найдвартай хангахын тулд урт хугацаанд усан цахилгаан станц байгуулах нь зүйтэй. Монгол Улсын Засгийн газар нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг тодорхой хэмжээнд хүргэх зорилт тавьсан. Хэдийгээр нар, салхины эрчим хүч үйлдвэрлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулдаг ч эрчим хүчний тогтвортой байдлыг хангаж чаддаггүй. Эдийн засгийн үйл ажиллагааг төрөлжүүлэх үйл ажиллагааг найдвартай эрчим хүчээр хангахын тулд усан цахилгаан станцыг барьж байгуулах шаардлагатай. Монгол Улсын хувьд цахилгаан эрчим хүчний хангамжийг нүүрснээс хэт хамааралтайгаар шийдэж байгаа энэ үед ногоон хөгжлийг дэмжих усан цахилгаан станцыг барьж байгуулах нь зүйтэй.

Эцэст нь дүгнэхэд Баян-Өлгий аймаг нь баруун бүсийн байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг жишиг аймаг болон хөгжинө. Мөн БНХАУ, ОХУ, Казахстан болон Төв Азийн улс орнуудын эдийн засгийн хөгжилд онцгой үүрэгтэй аймаг болох боломжтой.



## 7.2.2 Увс аймаг

### (1) Одоогийн нөхцөл байдал

#### Газар зүйн нөхцөл байдал


Увс аймгийн газар нутгийн хэмжээ 69,600 км<sup>2</sup> бөгөөд газар нутгийн хэмжээгээр улсын хэмжээнд дундаж аймагт орох ба нутгийн хойд хэсгээр ОХУ-тай хиллэдэг. Аймгийн төв Улаангом нь Улаанбаатар хотоос 1,120 км зайтай оршдог. Аймгийн баруун хэсгийг эс тооцвол агаарын дундаж температур хамгийн бага байдаг. Мөн жилийн дундаж хур тунадасны хэмжээ 135 мм бөгөөд харьцангуй хуурай уур амьсгалтай. Өндөр уулын, уулархаг 1,560 км<sup>2</sup> нутгийг хамарсан ойт хээрийн бүслүүрт багтдаг бөгөөд далайн түвшнээс дунджаар 1000 м-ээс дээш өргөгдсөн байдаг.

Увс нуурын сав газар нь ОХУ болон Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамнан оршдог бөгөөд уг сав газарт ЮНЕСКО-ийн соёлын өвд 2003 онд бүртгэгдсэн 12 дархан цаазат газар оршдог. Увс нуур нь Увс нуурын сав газарт оршиж буй Монгол орны хамгийн том нууруудын нэг бөгөөд нуурын урт 84 км, өргөн нь 79 км үргэлжилнэ. Тэсийн голын нийт урт 732 км бөгөөд Увс аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч (135 км) Увс нуурт цутгадаг.

**Зураг 7.2.4 Увс аймгийн байршил**







Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

2017 оны байдлаар Увс аймаг 82,604 хүн амтай, хүн амын нягтрал нь 1.2 хүн / км<sup>2</sup> байсан байна. Хүн амын жилийн дундаж өсөлт 2010-2015 онуудад 2.03%, 1989-2010 онд 0.64 % байсан бол 2000-2010 онд -1.69% болж буурсан байна. Увс аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос авсан санал асуулгад сүүлийн жилүүдэд хүн ам өсч буй шалтгааныг нийгмийн халамжийн бодлогын үр дүнд төрөлт нэмэгдсэн болон аймгийн эдийн засгийн өсөлтийн улмаас гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн багассанаар тайлбарлаж байна.

Увс аймгийн нэг хүнд ногдох БДНБ-ий бүтэц (хөдөө аж ахуй 37%, үйлдвэрлэл 37%, үйлчилгээ 39%) нь бусад аймгуудаас харьцангуй төрөлжсөн, зөв бүтэцтэй байна. 2017 онд 3,129,900 мал тоологдсон бөгөөд энэ нь Баруун бүсийн аймгуудын дундажтай ойролцоо үзүүлэлт юм. Нэг малчин өрхөд ногдох малын тоо 350 (15-р байрт) байсан. Тухайн онд Увс аймагт 11,775 га талбайд үр тариа тариалсан бөгөөд газар тариалангийн салбар хөгжиж байна. Бусад аймгуудтай харьцуулахад газар тариалан эрхлэхэд тохиромжтой газар нутаг ихтэй бөгөөд үр тариа 9,235 га, малын тэжээл 1,890 га талбайд тариалсан. Мөн төмс, хүнсний ногоог тус бүр 274 га газарт тариалсан байна.

2017 онд нэг хүнд ногдох БНДБ нь 3,818,000 төгрөг (17-р байранд), нэг ажилтанд ногдох хөдөлмөрийн бүтээмж нь 9,427,000 төг (17-р байранд) байсан нь Баруун бүсийн бусад аймгуудтай нэгэн адил үзүүлэлт байна. Боловсруулах үйлдвэрлэлийн борлуулалт харьцангуй бага буюу 14.3 тэрбум төгрөгөөр улсын хэмжээнд 15-р байранд жагссан бөгөөд БДНБ-ий 4.3% (20-р байр)-ийг эзэлсэн байна. БДНБ-нд эзлэх боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний харьцаа харьцангуй доогуур байна.

Увс аймагт 2017 онд аж ахуйн нэгжийн тоо 1,519 (6-р байр), хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тоо 1.323 (6-р байр), томоохон аж ахуйн нэгжийн тоо 449 (5-р байр) бүртгэгдсэн байна. Увс аймгийн банк санхүүгийн үйлчилгээ дунд зэрэг (9-байр) бөгөөд банкны салбар цөөхөн буюу нийт 40 салбар (16-р байр) үйл ажиллагаа явуулж байсан байна.

Увс аймгийн хүн ам олон ястнаас бүрддэг. Санал асуулгад оролцогчид соёл уламжлал, амьдралын хэв маягаа хадгалж үлдэхийг хүсч байгаа талаар онцолсон. Тиймээс үндэсний цөөнх буюу бага ястнууд өөрсдийн онцлог уламжлалыг хадгалахын зэрэгцээ бусад нийтлэг соёлыг ч өөрсдийн зан заншилд шингээж байгаа аж.

Увс аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 2017 онд 76.4% байсан нь улсын хэмжээнд 4-р байрт жагссан боловч ажилгүйдлийн түвшин өндөр буюу 13% (17-р байр) байсан. Энэ үзүүлэлтээс харахад мал маллахаас бусад ажил эрхлэх боломж хомс байгааг харж болно.

Увс аймагт бага, дунд, ахлах ангид суралцагчдын тоо дунд зэрэг бөгөөд нэг багшид ногдох сурагчийн тоогоор бага, дунд анги өндөр үзүүлэлттэй байна. 2017 онд 10,000 хүнд ногдох халдварт өвчний тоо 86 байсан нь улсын хэмжээнд 9-р байранд жагссан.

### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Увс аймгийн хэмжээнд хотжилтын түвшин 2017 онд 32.8%-тай, харьцангуй өндөр байгаа нь Баруун бүсийн аймгуудын дундаж түвшнээс өндөр ч улсын хэмжээний дунджаас (67.2 %) харьцангуй доогуур үзүүлэлт юм.

Увс аймгийг Улаанбаатар хоттой холбосон хатуу хучилттай авто замын чанар сайн (2-р байрт) гэж 2018 оны аймгуудын өрсөлдөх чадварын тайланд дурдсан байна. Гэвч аймгийн доторх авто замын чанар сайн биш бөгөөд улсын хэмжээнд 16-р байрт жагссан байна. Хэдийгээр Увс аймгийн төв Улаангом хот ОХУ-ын хилийн хоттой өндөр хурдны замаар холбогдсон ч хилийн боомт бүрэн ашиглагдаж чадахгүй байна.

Баруун бүсийн бусад аймгуудын нэгэн адил эрчим хүчний үнэ өндөр байна. Учир нь ОХУ-ын сүлжээнээс цахилгааны хувьд хамааралтай. Увс аймагт усан цахилгаан станц байгуулах боломж хомс, Баян-Өлгий, Ховд аймгуудыг бодвол өндөр уул нуруу багатай.

Улаангом хот нь төвлөрсөн ус хангамжийн системтэй. Харин гэр хороолол болон бусад сумдын иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд төвлөрсөн ус хангамжид холбогдоогүй. Зарим сумдад ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж барих төлөвлөгөө байгаа гэсэн мэдээлэл байна. Одоогоор ихэнх сумдын иргэд ундны усанд хатуулаг ихтэй гүний ус хэрэглэж байна.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

### 1) Нийгэм, эдийн засаг

2017 оны байдлаар аймгийн төвийн хүн ам 30,090 байсан бөгөөд Баруун бүсийн бусад аймгийн төвүүдийн адил хүн амын тоо цөөн байгаа нь аймгийн хөгжилд тулгарч буй бэрхшээл болж байна.

Хүний хөгжлийн индексээр улсын хэмжээнд 19-р байранд жагсаж байгаа нь Увс аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол бэрхшээлийн нэг болж байна. Боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлт дунд зэрэг боловч цалингийн түвшин доогуур, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хүний хөгжлийн индекс бага байх шалтгаан болж байна.

Увс нуураас эхлээд Увс аймаг нь жуулчдын зорин очих дуртай унаган байгаль, байгалийн үзэсгэлэнт газрууд ихтэй. Тиймээс Увс аймгийн газар нутгийн

нэлээдгүй хувийг Улсын тусгай хамгаалалттай газар болон Дэлхийн өвд бүртгэгдсэн газар эзэлдэг. Нөгөө талаар тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах шаардлагын улмаас аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал эрхлэхэд хязгаарлалт үүсдэг бэрхшээл байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарлаас шалтгаалсан бэлчээрийн хомсдол, мал аж ахуй эрхлэх нөхцөл байдлыг тооцоход Увс аймаг нь зудын эрсдэлд орж болзошгүй. Аймгийн төвөөс алслагдсан нутгууд мал аж ахуйгаас хэт хамааралтай байгаа нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэж байна.

## 2) Байгаль орчин

Увс аймаг нь Монгол Улсын хэмжээнд өвөлдөө хамгийн их хүйтэрдэг газрын нэг юм. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж ойн сан бүхий газрыг хамгаалах шаардлага үүсч, байгаль орчны тогтвортой байдалд онцгой үүрэгтэй цэвдэгт хөрсөнд аюул учирч байна.

Зарим сумдад хуучирсан цэвэрлэх байгууламж, түүний ашиглалт, менежментээс шалтгаалж усны бохирдлын асуудал тулгарч байна. Улаангом хотын орчимд уул уурхайн үйл ажиллагаанаас улбаатай байгаль орчинд сөрөг нөлөө учирч байна.

## 3) Дэд бүтэц болон бусад

Баруун бүсийн бусад аймгуудын нэгэн адил цахилгаан эрчим хүчний тогтвортой байдлыг хангах нь хамгийн тулгамдсан асуудал болж байна. ОХУ-аас шууд хамааралтай байдал нь цахилгаан эрчим хүчний хангамжийг эрсдэлд оруулах талтай. Аймгийн хөгжлийн хэтийн төлвийн хувьд усан хангамж, ялангуяа гэр хороолол, хот, суурин газруудаас алслагдан орших газруудын ус хангамжийн асуудал чухал юм.

Улаанбаатар хотоос хэт хол оршиж байгаагаас шалтгаалж барилгын материал, бусад тоног төхөөрөмжийн үнэ өндөр байдаг. Сум хоорондын авто зам, аймгийн төвтэй холбогдсон авто зам, харилцаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Улаангом хот нь ОХУ, БНХАУ-г холбосон Ховд-Өлгий чиглэлийн АХБ-ны санхүүжилтээр баригдаж буй авто замын дагуу байрлаж байна. Энэхүү боломжийг ашиглан ОХУ-тай холбогдсон худалдаа, логистикийн төв болж хөгжих, Баруун бүсийн барилгын материалын логистик төв болох боломж байна. Ингэснээр ойр орчмын бүсүүдийн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, үр тарианы үйлдвэрлэл, аялал жуулчлал, худалдааг дэмжих, өргөжүүлэх чухал зангилаа болох боломжтой.

Увс аймгийн хойд хэсгийн ОХУ-тай хил залгаа орчмын хот, суурин газрын хөгжил төдийлөн сайн биш байна. Гэсэн хэдий ч аймгийн иргэдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр иргэд Боршоо хилийн боомтоор үйлчлүүлдэг талаар дурдаж байсан. Одоогийн байдлаар Увс аймгаас ОХУ-д мах, арьс ширэн бүтээгдэхүүн экспортолж байна. Хэлэлцүүлэгт оролцогчид Боршоо боомтыг цаашид хөгжүүлэхэд төрөөс татвар, худалдааны тариф зэрэгт хөнгөлөлт үзүүлж боомтын үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай талаар хэлж байсан.

АХБ-ны санхүүжилтээр баригдаж буй авто зам нь Увс, Баян-Өлгий, Ховд аймгийг холбосон аялал жуулчлалын кластерын хөгжилд онцгой ач холбогдолтой. Увс нуурын сав дагуух үзэсгэлэнт байгаль, уламжлалт соёлд түшиглэн байгалийн

аялал жуулчлалыг хөгжүүлэх нь зүйтэй. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж, эко болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь хамгийн чухал байна.

Газар нутгийн тохиромжтой байдлын хувьд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломж төдийлөн сайн биш боловч аймгийн хөгжилд бэлчээрийн менежмент, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах нь онцгой ач холбогдолтой. Увс аймаг нь малын тэжээлийн тариалалт, Улаангом хотын ойролцоо болон Улаангом-Завхан аймгийн хооронд үр тариа тариалах талбайг нэмэгдүүлж байна. Тиймээс мал аж ахуй болон газар тариаланг хослуулан хөгжүүлсэнээр аймгийн иргэдийн хэрэгцээг дотооддоо хангаж, олон улсын стандартад нийцсэн хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нь зүйтэй юм.

Баруун бүсийн аймгуудаас газар тариалангийн хамгийн том талбайтай боловч малын тэжээл, зарим төрлийн жимс, жимсгэнээр л бүтээгдэхүүн нь хязгаарлагдаж байна. Богино хугацаанд дотоодын хэрэгцээг хангахын тулд хэвтээ тэнхлэгийн авто замын дагуу газар тариаланг төрөлжүүлэн хөгжүүлэх нь оновчтой юм. Увс аймаг нь Баруун бүсийн агро-паркийн үйлдвэрлэлийн төв байх боломжтой. Хэд хэдэн газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулж бүтээгдэхүүнийг, ялангуяа чацарганаас эхлэн дотоод, гадаадын зах зээлд гаргах, ОХУ, Казахстан улсад экспортлох нь зүйтэй.

Цахилгаан эрчим хүчний бие даасан байдал нь бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн олон төрөлт үйл ажиллагааны тогтвортой байдалд онцгой ач холбогдолтой. Нүүрсээр ажилладаг цахилгаан станцууд нь цаашид ирээдүйгүй. Баруун бүсийн хэмжээнд хэдэн жилийн өмнөөс усан цахилгаан станцыг барих төлөвлөгөөтэй байсан. Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд энэхүү төлөвлөгөөг дэмжих шаардлагатай байна. Дотоодын цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдох нь бүс нутгийн цаашдын аюулгүй байдалд онцгой ач холбогдолтой.

Увс аймгийн худалдаа үйлчилгээ эрхэлдэг жижиг аж ахуйн нэгжийн тоо, гуравдагч үйлдвэрлэлийн хөгжлийн эзлэх байр суурь өндөр байна. Энэ нөхцөл байдлыг ашиглан Улаанбаатар болон бусад хотуудаас үйлчилгээний салбар нэгж байгуулах боломжийг нээж өгөх хэрэгтэй. Интернетийн холболттой зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой. ОХУ, Казахстан, БНХАУ-ын мэдээлэл технологийн инженерүүдийг холбох боломж ч бий болж болно.

Хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж газар тариалан, мал аж ахуй хосолсон бэлчээрийн менежментийг сайжруулснаар зудын хохирлыг бууруулах боломжтой. Үүрэн телефон, интернетийн хэрэглэгч маш олон байгаа давуу талыг ашиглан мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээг нэвтрүүлэх боломж байна. Баруун бүсийн эрс тэс уур амьсгалд мэдээлэл харилцаа, технологийн давуу талыг ашиглан мал аж ахуй эрхлэхтэй холбоотой цаг уурын онцгой үзэгдлүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад ашиглаж болно.

### **7.2.3 Ховд аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**



##### Газар зүйн нөхцөл байдал

Ховд аймаг нь Монгол Улсын нутгийн баруун хэсэгт БНХАУ-ын Шиньжян-Уйгурын өөртөө засах оронтой хиллэн оршдог бөгөөд 76,100 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй. Ховд

аймгийн төв нь Ховд хот ба Улаанбаатар хотоос 1270 км зайтай оршдог. Ховд хот нь Баян-Өлгий аймгийн Өлгий хоттой А305 авто замаар, Увс аймгийн Улаангом хоттой А1701 авто замаар, Говь-Алтай аймгийн Алтай хоттой А304 авто замаар тус тус холбогддог. Одоогийн байдлаар Завхан аймгийн Улиастай хоттой холбосон авто зам тавигдаагүй байна.

Ховд аймгийн газар нутаг нь Алтайн уулсаар 3 хэсэгт хуваагддаг. Хойд хэсэг нь Алтай, Хангайн нурууны хооронд байрласан, давстай нууруудаар хүрээлүүлсэн, хагас цөлийн тал хээр нутаг юм. Урд хэсэг нь БНХАУ руу нийлдэг жижиг гол, горхи бүхий цөл нутаг юм. Ихэнх гол горхиуд нь далайд цутгадаггүй тул элсэнд хучигдаж эсвэл давстай устай намгархаг газар шингэн, ширгэж байна. Ховд аймгийн аргаль, янгир, цоохор ирвэс, бөхөн гөрөөс, алагдаахай, тахь зэрэг ховор амьтад амьдардаг томоохон газар нутаг, олон төрөл зүйлийн шувууд ирдэг нууруудыг дархлан хамгаалсан.

Зураг 7.2.5 Ховд аймгийн байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг



### Нийгэм, эдийн засаг

2017 онд Ховд аймгийн хүн ам 86,400, хүн амын нягтрал 1.14/км<sup>2</sup> байсан. Ардчилсан хувьсгалын дараа Ховд аймгийн хүн амын тоо бага зэрэг өссөн хэдий ч 2000-2017 оны хооронд том хотууд руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс үүдэн хүн амын өсөлт зогсонги байдалд орсон байна. Түүнчлэн ажилгүйдэл болон 2000-2001, 2009-2010 онд болсон зуд нь гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх хүчин зүйлс болсон байна.

Ховд аймагт олон ястан амьдардаг, 1700-аад оноос ОХУ, БНХАУ болон дэлхийн бусад улс орнуудаас хүмүүс ирж суурьшсан байна. Ховд хот нь 334 жилийн түүхтэй, Монгол Улсын баруун аймгуудын өв соёлыг хадгалсан, ард иргэд нь өөрсдийн соёл, уламжлалаа хадгалж, эвтэй найртайгаар оршин сууж иржээ.

Ховд аймаг нь нэг малчин өрхөд ногдох малын тоогоор 8-р байр, 100 га бэлчээрийн нутагт ногдох малын тоогоор 12-р байр, мал аж ахуй эрхэлдэг нийт өрх нь 44.1% буюу 12-р байрт тус тус орсон байна. Ховд аймагт үр тариа, хүнсний ногоо, төмс, малын тэжээл тариалдаг бөгөөд тарвас тариалалтаараа алдартай.

Тус аймгийн нийт аж ахуйн нэгж байгууллагын тоо нь 1,934 (4-р байр), хувийн аж ахуйн нэгж байгууллагын тоо нь 1,728 (4-р байр), томоохон аж ахуйн нэгж байгууллагын тоо нь 46 (8-р байр) байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ихэнх нь үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна. Ховд аймгийн аж үйлдвэрийн салбарын борлуулалт нь 2017 оны байдлаар 125.9 тэрбум ₮ (8-р байр) байсан бөгөөд тус салбарын ДНБ-д эзлэх хувь 38.9% (14-р байр) байв. Аж үйлдвэрийн салбарт хүнс боловсруулалт болон барилгын материалын зарим хөнгөн үйлдвэр зонхилдог. Аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ бага буюу 3,789,000 ₮ (20-р байр), хөдөлмөрийн бүтээмж харьцангуй бага буюу 9,436,000 ₮ (16-р байр) байна.

Ховд аймгийн ажиллах хүчний идэвхийн коэффициент харьцангуй бага буюу 62.3% байгаа нь ажлын байр хайж гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой. Ажиллах хүчний оролцооны түвшин харьцангуй өндөр буюу 71.0% байгаа нь хөдөө аж ахуйд тулгуурласан эдийн засагтай нь холбоотой. Дээрх 2 үзүүлэлтийн нөлөөгөөр эдийн засгийн идэвхтэй хүн ам бага буюу 46.5% (15-р байр), ажилгүйдлийн түвшин өндөр буюу 13.5% (18-р байр) байна.

Ховд аймагт сурагч-багшийн харьцаа дундаж буюу боловсролын үзүүлэлтүүд дундаж байгаа бөгөөд эмч, сувилагчийн хүртээмж дунджаас илүү буюу 8, 9-р байр, 10,000 хүн тутмын хөнгөн халдварт өвчин 59 (3-р байр) байна.

### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Ховд аймгийн эдийн засаг нь хөдөө аж ахуйд тулгуурласан хэдий ч 2017 оны байдлаар хотжилтын түвшин харьцангуй өндөр буюу 34.1% байна. Ховд хот нь Улаанбаатар хотоос алслагдсан ч Өлгий, Улаангом хотуудаар дамжин ОХУ-тай холбогддог. БНХАУ-тай хиллэдэг хэсгээр Алтайн нурууд сунаж тогтсон байдаг тул нэвтрэх нөхцөл тааруу байдаг.

Ховд аймгийн авто замын чанар муу буюу улсын хэмжээнд 19-р байр, хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ногдох тээврийн хэрэгслийн тоо 16 буюу 7-р байранд тус тус орж байна. Ховд хот нь ОХУ-ын эрчим хүчний сүлжээтэй холбогдсон ба аймгийн эрчим хүчний хэрэглээний тодорхой хувь нь ОХУ, БНХАУ-аас хамааралтай хэдий ч эрчим хүчний үнэ бусад аймгуудынхаас бага байна. Томоохон хэмжээний усан цахилгаан станцын төсөл хэрэгжиж байгаа бөгөөд тус




УЦС ашиглалтад орсноор аймгийн эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй, БНХАУ-д эрчим хүч экспортлох бололцоог бүрдүүлнэ.

Ховд аймгийн цахилгаан үүсгүүртэй малчин өрхийн харьцаа 89.1% (4-р байр) байгаа хэдий ч шатахууны үнэ хамгийн өндөр буюу 1,687 төгрөг/литр байна.

## (2) Тулгамдаж буй асуудлууд

Ховд аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр аймгийн хөгжилд тулгарч буй асуудлуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн ба асуудлын бүтцийн шинжилгээг Зураг 7.2.6-д үзүүлэв.

**Зураг 7.2.6 Ховд аймгийн асуудлын бүтцийн шинжилгээ**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Ховд аймгийн асуудлын бүтцийн шинжилгээнээс харахад тулгарч буй асуудлуудын ихэнх нь аймгийн алслагдсан байдалтай холбоотойг харж болно. Бараа, үйлчилгээний үнэ өндөр байдаг нь амьдрах зардлыг нэмэгдүүлж, барилгын материалын өндөр үнэ нь орон сууцны үнэ өндөр байхад нөлөөлж байна. Түлш, шатахууны үнэ өндөр байдаг нь эрчим хүчний үнэ өндөр байхад нөлөөлж, улмаар дулаан хангамжийг үнэтэй болгож байна. Эдгээр асуудлуудаас үүдэн зуны улиралд халуун ус тасрах, өвлийн улиралд дулаанаар хангаж чадахгүй байх зэрэг асуудлууд урган гардаг. Эрчим хүчний өндөр үнэ, экспортын зах зээл хөгжөөгүй зэргээс үүдэн аж үйлдвэр хөгжөөгүй бөгөөд үүний дүнд ажилгүйдлийн түвшин өндөр байна. Ажилгүйдлийн түвшин өндөр байхад гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөн ихсэж, хүн амын өсөлт багасахад орон нутгийн зах зээл хумигдана.

Түүнчлэн хэлэлцүүлгийн үеэр төрийн бодлоготой холбоотой хэд хэдэн асуудлыг

онцолж байв. Улс төрийн тогтворгүй байдлаас үүдэн бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх нөхцөл хангагдахгүй байна. Үүнээс улбаалан хөгжлийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, уялдаа холбоо хангалтгүй байна. Мөн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад зориулсан бүсийн нэмэгдэл байдаггүй.

Дээрх 2 үндсэн асуудал нь аж үйлдвэр хөгжихгүй байгаагийн шалтгаан болдог байна. Тухайлбал эдгээр асуудлуудаас үүдэн зээлийн хүү өндөр байдаг бөгөөд жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлалын салбар хөгждөггүй. Үүнээс үүдэн тогтвортой, байнгын ажлын байрны хомсдол үүсч, гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөн ихсэх ба ийнхүү хүн амын өсөлт саарахад орон нутгийн зах зээл хумигдана.

Ховд аймгийн хэлэлцүүлгийн үеэр ус хангамжтай холбоотойгоор ус дамжуулах шугам, хоолой хуучирч муудсан, улмаар усны чанар муу, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа тааруу, усны тоолуургүйн улмаас усны зохистой хэрэглээ дутмаг, хөдөө, орон нутагт ус түгээх цэг, ус хангамжийн хүрэлцээ дутмаг зэрэг асуудлуудыг хөндөж байв.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Ховд аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр Ховд аймгийг хөгжүүлэхийн тулд богино, дунд, урт хугацаанд авч хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийг хэлэлцэв. Богино хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд Ховд гол дээр усан цахилгаан станц барих, цементийн үйлдвэр байгуулах, дулааны цахилгаан станцыг өргөтгөх зэргийг дурдав.

Ховд гол дээр баригдах 90 мВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц нь Ховд аймгийн эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй, БНХАУ-д эрчим хүч экспортлох бололцоог бүрдүүлнэ. Цементийн үйлдвэрийг барьж байгуулснаар барилгын материалын үнэ, орон сууцны үнэ буурахад нөлөөлнө. Дулааны цахилгаан станцыг өргөтгөснөөр зуны улиралд халуун ус тасрах, өвлийн улиралд дулаанаар хангаж чадахгүй байх зэрэг асуудлуудыг шийдвэрлэнэ.

Дунд болон урт хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд Ховд аймгийн эдийн засгийн гол салбар болох мал аж ахуйн салбарыг кластераар хөгжүүлж, хагас эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан, малын тэжээлийн үйлдвэрлэлтэй нэгтгэн, малын гаралтай бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингээж, экспортлох ажлуудыг хийж, хэрэгжүүлэх ажлуудыг санал болгов. Хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд малыг бэлчээрлүүлэхээс гадна нэмэгдэл тэжээлээр тэжээнэ. Орон нутгийн зах зээлд нийлүүлэх сүү, сүүн бүтээгдэхүүнээс эхлээд хот, суурин газарт нийлүүлэх мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулна.

Малын тэжээл болон бусад төрлийн тариа, ногооны ургацыг нэмэгдүүлэхийн тулд усны нөөцийг ашиглан усжуулалтын системийг дунд болон урт хугацаанд хөгжүүлж болно. Ингэхийн тулд усны нөөц, түүний ашиглалттай холбоотой дээрх асуудлуудыг харгалзан үзэж Буянт, Булган, Ховд, Сэнхэрийн голын усны нөөц, менежментийн цогц төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчид Ховд аймгийг “Ногоон хөгжлийн загвар аймаг” болгож хөгжүүлэх саналыг гаргаж байсан бөгөөд үүний тулд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь тус санаачилгын чухал хэсэг гэж тооцсон. Ховд аймаг нь уул уурхайн үйл ажиллагаанд төдийлэн өртөөгүй бөгөөд тус аймагт стратегийн ач

холбогдол бүхий орд газрууд байхгүй. Тиймээс уул уурхайг хөгжүүлэхдээ хариуцлагатай уул уурхайн жишиг, туршлагыг хатуу мөрдүүлэх шаардлагатай.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх нь Ховд аймгийг “Ногоон хөгжлийн загвар аймаг” болгох зорилгын нэг хэсэг юм. Байгаль, цэнгэг уст болон давст нуурууд, уул нурууд, цэлгэр хөндий, агуй, хадны сүг зураг, хэрэм зэрэг үзэсгэлэнт газруудад түшиглэж аялал жуулчлалын салбарыг өргөн хүрээнд хөгжүүлэх боломжтой. Түүнчлэн дотоодын болон олон улсын аялал жуулчлал, спорт агнуурын салбарыг өргөжүүлж, хөгжүүлэх боломжтой. Олон ястны уламжлалт сууц, суурьшлын хэв маяг, хувцас өмсгөл, утга зохиол, урлаг болон хөгжмийн уламжлалуудыг ашиглаж аялал жуулчлалыг төрөлжүүлж болно.

Ховд аймгийг ОХУ-тай арилжаа хийх, Баруун бүсийн аж үйлдвэрийн төв болгож хөгжүүлэх ирээдүйтэй. Хуурай уур амьсгалтай газрын газар тариалан, биологийн олон янз байдал, олон ястан болон соёлын олон төрөл зүйлийн судалгаанд чиглэсэн Баруун бүсийн дээд боловсрол, судалгааны төвийг байгуулж, олон улсын эрдэмтэн, судлаачдыг урьж авчрах байдлаар Ховд хотын чиг үүргийг бэхжүүлэх хэрэгтэй. Мөн Ховд хот нь Баруун бүсийн аялал жуулчлалын гол түшиц болж хөгжих боломжтой. Ховд аймгийн хувьд байгалийн нөөц баялгаа ашиглаж барилгын материалын үйлдвэрийг барьж байгуулах нь ирээдүйтэй юм. Эдгээр чиг үүргийг дэмжихийн тулд Ховд хотын нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгож өргөжүүлэх шаардлагатай.

## **7.3 Хангайн бүсийн аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ**

### **7.3.1 Завхан аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**


##### Газар зүйн нөхцөл байдал

Завхан нь Улаанбаатар хотоос баруун зүгт орших 82,456 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй (7-р байрт) аймаг юм. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд батлагдсан Баруун бүсэд хамаарах аймаг бөгөөд нутгийн хойд хэсгийн багахан хэсгээр ОХУ-тай хиллэдэг. Аймгийн төв Улиастай хот нь Улаанбаатар хотоос 760 км зайтай оршдог. Завхан аймаг нь Монгол орны хамгийн хүйтэн уур амьсгалтай аймаг бөгөөд зарим үед зуны цагт цас орох тохиолдол ч байдаг. Аймгийн нутаг дэвсгэр 2 бүсэд хуваагдах бөгөөд говь цөлийн хэсэг нь баруун болон төвийн нутгаар, тал хээрийн бүс нь нутгийн зүүн хэсгээр оршино. Нутгийн зүүн хэсгийн уулархаг нутгаар жилийн дундаж хур тунадас 400мм байх бол баруун хэсгээр 80-100мм, бусад нутгаар 200-260 мм байдаг. Зүүн хэсгээр орших өндөр уулархаг нутаг нь Хангайн нурууны үргэлжлэл юм. Харин баруун болон төвийн нутаг нь далайн түвшнээс дээш дунджаар 1000-1500м -т оршдог.

Завхан аймгийн зүүн болон өмнөд нутгаар томоохон голууд урсдаг боловч усны нөөц төдийлөн хангалттай биш. Ундны болон ахуйн усыг газрын гүний ус, нуур цөөрөм, рашаанаас авч хэрэглэдэг.

Аймгийн зүүн хэсэг нь зэрлэг амьтан ургамалтай, өтгөн ой шугуйтай экологийн бүсэд багтана. Олон зүйлийн ойн, уулын, нүүдлийн шувууд ялангуяа, алтайн хойлог, ятуу, хун, тас, шонхор, харцага зэрэг шувууд нутагладаг.

### Зураг 7.3.1 Завхан аймгийн байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### Нийгэм, эдийн засаг

Завхан аймаг нь 2017 онд 72,104 хүн амтай, хүн амын нягтрал 0.87/км<sup>2</sup> байсан. Аймгийн хүн ам нь 2010-2015 онд жилд дунджаар 1.35%-иар өссөн ч улсын дундаж (2.2%)-аас доогуур байсан. 1989-2000 онуудад хүн амын өсөлт зогсонги байсан бол 2000-2010 онуудад 2.48%-иар буурсан үзүүлэлттэй байна. Завхан аймагт зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн үеэр хүн амын өөрчлөлтийг 1) Ажлын байрны хомсдол болон 2000-2010 онд боловсруулах үйлдвэр хөгжөөгүйгээс шилжин явсан 2) 2010-2015 онд төрөлт нэмэгдсэн, дэд бүтэц сайжирсан, өрхийн орлого нэмэгдсэн тул шилжин ирсэнтэй холбож тайлбарлаж байсан.

Завхан аймгийн эдийн засагт 2017 онд үйлчилгээний салбар БДНБ-ий 40%-ийг эзэлсэн бөгөөд үйлдвэрлэлийн салбар (барилгын салбарыг оролцуулан) 16%-ийг эзэлсэн байна. Аялал жуулчлалын салбар эдийн засагт онцгой үүрэгтэй байна. Байгалийн унаган төрх, үзэсгэлэнт байгалийн үр шимээр нутгийн иргэд аялал жуулчлал эрхлэхэд давуу тал болж байна.

Бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж байгаа нь 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоо 82 (15-р байрт) гэсэн үзүүлэлтээс харагдаж байна. 2017 онд нэг малчин өрхөд ногдох малын тоо 394 байсан нь улсын хэмжээнд 11-р байранд жагсчээ. 2019 оны 6-р сарын 18-ны өдрийн хэлэлцүүлэгт оролцогчид сүүлийн жилүүдэд малын тоо байнга өсч байгаа бөгөөд цаашид ч фермерүүд, малчид малын тоогоо өсгөх хандлагатай талаар дурдав.

2017 онд аж үйлдвэрийн салбарын борлуулалт 131.1 тэрбум төгрөг (7-р байрт), БДНБ-д эзлэх хувь 41.7% (8-р байрт) гэсэн үзүүлэлттэй байсан байна. Баруун бүсийн таван аймгуудаас Завхан аймаг нь аж үйлдвэрийн нөөц боломжоор харьцангуй өндөр юм. Энэ нь Улаанбаатар хоттой хамгийн ойр байршилтай нь холбоотой байж болзошгүй. 2017 онд нэг хүнд ногдох БДНБ-ий хэмжээ 4,421,000 (14-р байрт) төгрөг, хөдөлмөрийн бүтээмж 9,490,000 (15-р байрт) төгрөг байсныг аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбарын оролцоо бага байгаатай холбож тайлбарлаж болох юм.

2017 онд 1,284 аж ахуйн нэгж байгууллага (11-р байр) байснаас 1,062 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага (11-р байрт) байв. Зах зээлийн багтаамж бага, бизнес эрхлэгчдийн тоо харьцангуй цөөн тул жижиг дунд үйлдвэрлэл зогсонги байдалд байна. БНХАУ-аас бараа импортлон худалдаалах нь хялбар учраас үйлдвэрлэл хөгжихгүй байна.

Аймгийн хэмжээнд нийт тариалангийн талбай 1,863 га байгаа нь аймгийн нутаг дэвсгэрийн 17 орчим хувийг эзэлж байна. Завхан аймаг нь Баруун бүсийн хамгийн том тариалангийн талбай бүхий газар нутагтай аймаг юм. Үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээл тариалж байгаа ч дотоодын үр тарианы хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа нь 1 га талбайгаас хураах ургацын хэмжээ бага бусад аймгуудад нийлүүлдэгтэй холбоотой.

Ажилгүйдлийн түвшин бага 4.4%, улсын хэмжээнд 2-р байранд жагссан байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 74.5% (8-р байрт), эдийн засгийн идэвхтэй хүн ам 48.7% (9-р байрт)-ийн үзүүлэлттэй хэдий ч аймгийн хэлэлцүүлгийн үеэр зарим оролцогчид ажилгүйдэл маш их байсаар байна, ажилгүй иргэдийн тоон үзүүлэлтэд ажил идэвхтэй горилогчид л бүртгэгддэг тал бий талаар дурдсан. Тиймээс ажил эрхлэлтийн талаар маш сайн судлах шаардлагатай байна. 2017 онд дундаж цалин 635,000 төгрөг (15-р байрт), эдийн засгийн үйл ажиллагаа тийм ч сайн төрөлжөөгүй (19-р байрт) байна.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Завхан аймагт 2017 онд хотжилтын түвшин 22.4% байсан. Аймгийн төв Улиастай хот 16,265 хүн амтай. Улиастай болон Алтай хот нь газар зүйн байрлалын хувьд ОХУ, БНХАУ хоёр улсын дунд оршдог. Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид энэхүү газар зүйн байршил, өмнөд хойд тэнхлэгийн таталцал нь аймгийн ирээдүйн орон зайн хөгжилд онцгой ач холбогдолтойг дурдаж байсан. 2018 оны Аймгуудын өрсөлдөх чадварын тайланд, Завхан аймгийн авто зам харьцангуй сайн (9-р байрт) боловч хөндлөн, босоо тэнхлэгийн авто замтай гүйцэд холбогдоогүй, одоогийн байдлаар зөвхөн Алтай хоттой холбогдсон байна. Зүүн-баруун чиглэлийн Ховд-Улаанбаатарын авто зам тийм ч сайн биш, зарим хэсэгт зам баригдаж дуусаагүй байна.

Завхан аймагт 1000 өрхийг хангах ганцхан уст цэг байдаг тул улсын хэмжээнд 19-р байранд жагсаж байна. Төслийн багийн зохион байгуулсан аймгийн хэлэлцүүлгээр авсан санал асуулгын үеэр Завхан аймаг гол горхи, нууртай боловч

хүн амын ундны ус хангамж төдийгүй малын худаг хүрэлцээ муутай гэж хэлж байсан. Мөн усны чанар төдийлөн сайн биш, ялангуяа говийн бүсийн ус хангамжийн асуудал хурцаар тавигдаж байна.

Баруун бүсийн бусад аймгуудийн нэгэн адил цахилгааны үнэ өндөр, ОХУ-ын цахилгаан эрчим хүчний сүлжээнээс хэт хамааралтай байна.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

### **1) Нийгэм, эдийн засаг**

Завхан аймгийн төв Улиастай хотын хүн ам нь аймгийн эдийн засгийг хөдөлгөгч хүч болж чадахгүй байна. Хүн амын тоо цөөн байгаа нь ялангуяа аж үйлдвэр, боловсруулах салбарын хөгжилд том бэрхшээл үүсгэдэг. Цөөн хүн амтай аймагт аж үйлдвэрийн кластер байгуулах байтугай дотоодынхоо хэрэгцээг хангах бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар бусад аймгуудын зах зээлд гаргахад ч төвөгтэй байдаг. Мөн хүн ам хэт цөөн учир зах зээл маш хязгаарлагдмал байдаг. Аймгийн хувьд чацаргана тариалалт нилээд түгээмэл байна. Гэвч нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зах зээл, боловсруулах үйлдвэр хангалтгүй байна.

Газар тариалангийн салбарын бүтээмж бага байгаагийн суурь шалтгаан нь хөдөө аж ахуйн материаллаг баазыг устгасанд байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед ажиллаж байсан газрууд бүрэн ажиллаж чадахгүй, техник тоног төхөөрөмжийг сайжруулах, засах төвлөрсөн санхүүжилтийн сан огт байхгүй байна. Энэ нөхцөл байдал нь газар тариалан эрхлэгчидтэй хамтран газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэхэд бэрхшээл болсоор байна.

Мал аж ахуйн салбарт ч дээрхтэй адил асуудал тулгарч байна. Мах, махан бүтээгдэхүүний үнэ (ойролцоогоор 3 ам.доллар/кг) олон улсын зах зээлийн дундаж үнэ (ойролцоогоор 5 ам.доллар/кг)-ээс маш доогуур байгаа шалтгаан нь хамтарсан хоршооны хэлбэрээр ажиллахгүй, зах зээл, бизнесийн мэдлэг, мэдээлэл дутмаг, хүнсний аюулгүй байдлыг хангасан, найдвартай бүтээгдэхүүн эсэх нь тодорхойгүй байдагтай холбоотой.

Аймгийн баруун болон өмнөд нутгаар бэлчээрийн доройтол улам ихэссээр байна. Үүнд зөвхөн бэлчээрийн талхагдал төдийгүй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой цэвдгийн өөрчлөлт томоохон хүчин зүйл болж байна.

Аж үйлдвэрлэл, боловсруулах салбар нь дэд бүтцийн хөгжил тааруу, салбарын нэгдсэн бодлого дутмагаас болж хөгжиж чадахгүй байна. Томоохон аж ахуйн нэгж цөөхөн, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил сул байгаагаас шалтгаалж Завхан аймаг хөгжихгүй байна.

Завхан аймгийн хөгжилд хүн амын өсөлтийн зогсонги байдал нь хамгийн том бэрхшээлийн нэг болж байна. Хэрвээ хүн амын өсөлт буурвал нийгмийн үйлчилгээний барилга байгууламжаар хангахад төдийгүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний салбарын тогтвортой үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй юм.

### **2) Байгаль орчин**

Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ган зуд болох, цас их хэмжээгээр унах зэрэг үзэгдлүүд илэрч байна гэсэн. Нутгийн баруун өмнөд хэсэгт цөлжилт ихэсч байгаа тухай дурдсан.



### 3) Дэд бүтэц

Аймгийн төв нь эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн байдаг учраас алслагдсан сумдтай холбогдсон зам харилцаа сул хөгжсөн. Зам харилцааг сайжруулахад маш их хэмжээний төсөв хөрөнгө шаардагдаж байна. Мөн ОХУ-тай холбогдох авто замын нөхцөл байдал маш муу байна. Мөн аймгийн хэмжээний авто замын чанар сайн бус, сум хоорондын зам харилцаа ч төдийлөн сайн хөгжөөгүй байна.

Амьдрах орчин сайнгүй, тав тухтай байдлыг хангахгүй байгаагийн улмаас хот, хөдөөгийн иргэд шилжин явах хүсэлтэй байна. Жишээлбэл хамгийн хүйтэн өвөл болдог аймаг хэдий ч аймгийн хэмжээнд хөдөө орон нутагт төвлөрсөн халаалтын систем хангалтгүй байна.

Аймгийн хэлэлцүүлгийн үеэр хөгжилд саад болж буй бэрхшээлүүдийг 1) Аймгийн хөгжлийн тодорхой бодлого болон бүсийн хэмжээнд хөгжүүлэх үндэсний бодлого байхгүй, 2) Мал аж ахуйг хөгжүүлэхэд газар ашиглахтай холбоотой нэгдсэн менежмент байхгүй, 3) Нийслэлээс алслагдмал оршдог учраас бараа бүтээгдэхүүний үнэ өндөр зэргийг дурдаж байсан.

#### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Хэдийгээр Завхан аймаг одоогийн байдлаар Баруун бүсийн аймгуудын нэг боловч Хангайн бүсийн Хөвсгөл аймгийн Мөрөн хоттой ойрын хугацаанд холбогдох шаардлагатай. Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын кластерыг хөгжүүлж, Улаанбаатар-Улиастайг холбосон авто замыг сайжруулахын тулд Улиастай-Мөрөнгийн авто замыг сайжруулснаар дээрх ажлуудыг амжилттай хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл бүрдэнэ.

Дунд хугацаанд урд хэсгээрээ Говь-Алтай аймгийн Алтай хоттой, баруун хэсгээрээ Ховд хоттой холбогдох харилцааг сайжруулах нь Завхан аймгийн хөгжилд онцгой ач холбогдолтой. Алтай хоттой зам харилцааг сайжруулснаар БНХАУ болон ОХУ-тай босоо тэнхлэгээр зорчиход түлхэц болно. Завхан аймаг нь хэвтээ тэнхлэгийн эдийн засгийн коридор, Баруун бүсийн эдийн засгийн төвүүд болох Ховд, Өлгий, Улаангом хотыг Улаанбаатартай холбох гол зам дээр оршиж байгаа нь байршлын хувьд давуу тал болно. Аймгийн төв Улиастай хотын чиг үүргийг өргөжүүлж, Баруун бүсийг Улаанбаатар хоттой холбосон нийгмийн үйлчилгээ, засаг захиргааны төв болгон хөгжүүлэхийн тулд дэд бүтцийг сайтар хөгжүүлэх шаардлагатай байна.

Завхан аймагт зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт оролцогчид уул уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэх шаардлагагүй гэж санал асуулгад хариулсан байсан. Үүнтэй холбож үзвэл Завхан аймаг уул уурхайг хөгжүүлэх бус экспортод чиглэсэн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг илүүд үзэж байна. Мөн цементийн үйлдвэр, барилгын материалын үйлдвэр байгуулах нь зүйтэй.

Монгол орны хэмжээнд мал аж ахуйн салбарт мэдээлэл харилцаа холбооны технологи нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой. Завхан аймгийн төвийн нутагт адуунаас бусад малын чихэнд нь ухаалаг им суурилуулсан. Ингэснээр амьтны удам, угсаа, угшил, эрүүл мэндийн түүх зэргийг мэдэх боломжтой бөгөөд хулгайгаар мах борлуулах явдлыг ч бууруулах боломжтой. Ингэснээр, махны худалдаа эрхлэгчид, бөөний худалдаачид, фермерүүдийн хувьд мах махан бүтээгдэхүүний зах зээлийн үнийг тэнцвэржүүлэхэд чухал ач холбогдолтой. Монгол малын мах бэлчээрийнх учраас чанарын өндөр түвшний мах байдаг. Газар

зүйн байршлын хувьд ч ирээдүйд ОХУ, БНХАУ-ын зах зээлд мах махан бүтээгдэхүүн экспортлох боломж бүрдэнэ.

Сүүлийн жилүүдэд Завхан аймгийг зорих жуулчдын тоо өсөж байна. Аймгийн үзэсгэлэнт нуур, толгод жуулчдын анхаарлыг татсаар байна. Аймгийн зүүн хэсгийн байгалийн үзэсгэлэнт газрыг Хархорин, Цэцэрлэг, Баянхонгор зэрэг Хангайн бүсийн аялал жуулчлалын кластерт оруулах нь зүйтэй юм. Баруун бүсийн Баян-Өлгий зэрэг аймгуудаас ялгаатай нь Завхан аймаг гадаадын жуулчдаас илүү дотоодын жуулчдын сонирхолыг ихэд татаж байгааг анхаарах нь зүйтэй юм. Цаашид аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, аялал жуулчлалтай холбоотой мэдээллийг дээрх кластерын сүлжээнд оруулах нь чухал байна.

Монгол Улсад гар утас хэрэглэгчдийн тоо, интернетэд холбогдох боломж сайтай учраас мэдээлэл харилцаа холбооны технологийг өргөнөөр ашиглах боломжтой. Мал аж ахуй, газар тариалангийн салбарт цаг агаарын урьдчилсан мэдээлэл, ялангуяа ган зудаас сэрэмжлүүлэх, түүний хохирлоос урьдчилан сэргийлэх зэрэг найдвартай мэдээллийг фермерүүдэд урьдчилан мэдээлэх нь чухал юм. МХХТ-ийн хэрэглээг ашигласнаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, найдвартай байдлыг хангахад ашиглаж болно.

### **7.3.2 Хөвсгөл аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**


##### Газар зүйн нөхцөл байдал

Хөвсгөл аймгийн газар нутгийн хэмжээ 100,629 км<sup>2</sup> бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ улсдаа 6-рт жагсаж байна. Аймгийн нутаг дэвсгэр өндөр уулын, уулархаг, ойт хээрийн гэсэн байгалийн гурван бүслүүрт хуваагдана. Аймгийн төв нь Мөрөн хот бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 779 км зайтай оршдог.

Хөвсгөл нуур, ой тайга зэрэг байгалийн арвин их нөөц, үзэсгэлэнт байгалиараа алдартай. Монгол Улсын хэмжээнд хамгийн их ойн нөөцтэй аймагт тооцогддог ба нийт газар нутгийн 35.4%-ийг эзэлдэг. Үүний 90%-ийг шинэс мод эзлэх ба үлдсэн хувийг нарс болон бусад зүйлийн мод эзэлдэг байна. Хөвсгөл аймаг Идэр, Тэс, Бүгдгээн зэрэг нийт 400 орчим гол мөрөн, 300 орчим том, жижиг нууртай.

Хөвсгөл аймагт 5 баг, 13 овог, 31 төрөлд хамрагдах нийт 35 зүйлийн хөхтөн амьтан, тэр дундаа үнэг, чоно, хандгай, баавгай, хярс, хүдэр, зэрлэг гахай, буга, гөрөөс, булга, тарвага нутагладаг. Түүнчлэн ёл, хойлог, шонхор зэрэг олон зүйлийн шувууд байдгаас гадна өрөвтас, гангар хун, хээрийн галуу, байгалийн нугас, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, бүргэд, алтайн хойлог, Азийн цууцаль, итгэлэн цахлай гэх мэт улаан номонд орсон шувууд бий.

### Зураг 7.3.2 Хөвсгөл аймгийн байршил



Эх сурвалж: БОАЖЯ-ны зургийг ашиглаж ЖАЙКА-гийн Төслийн баг бэлтгэв.

#### Нийгэм, эдийн засаг

Хөвсгөл аймаг 2017 оны байдлаар нийт 131,600 хүн амтай, хүн амын нягтрал нь  $1.3/\text{км}^2$  байсан байна. 2000-2010 онд хүн ам нь жилд дунджаар 0.32%-иар буурч байсан бол 2010-2015 онд жилд дунджаар 2.30%-иар өссөн.

Хөвсгөл аймгийн эдийн засгийн голлох салбар нь газар тариалан, мал аж ахуй бөгөөд 2017 оны байдлаар ДНБ-ний 41%-ийг эзэлжээ. 2017 онд нийт 1,387,000 мал тоолуулж улсын хэмжээнд 3-т орсон байна. Нэг малчин өрхөд ногдох малын тоо 318 байсан нь улсад 18-рт орсон. Нийт ажиллагсдын тоонд малчин өрхийн эзлэх хувь 55 бөгөөд улсад 3-р байранд орсон байна. 2017 онд улаан буудай, төмс, хүнсний ногоо тариалсан талбайн хэмжээ 18,714 га байснаас харахад Хөвсгөл аймаг газар тариалан түлхүү эрхэлдэг аймаг гэж дүгнэж болохоор байна.

2017 оны байдлаар бүс нутгийн ДНБ харьцангуй өндөр буюу 499 сая төгрөг

байсан бөгөөд улсад 5-рт орсон байна. Харамсалтай нь бүсийн нэг хүнд ногдох ДНБ харьцангуй бага буюу 3,827,000 болж улсад 17-р байранд жагссан байна. Үүнээс гадна хөдөлмөрийн бүтээмжээрээ мөн л 17-р байранд орж, 8,869,000 төгрөг байсан нь доогуур үзүүлэлт болно. Үүнээс үзвэл нэмүү өртөг шингэсэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй байгаад хавтгайрсан нийгмийн халамжийн бодлого, улирлын чанартай аялал жуулчлал зэрэг нөхцөл байдал нөлөөлсөн гэж үзэж байна.

Хөвсгөл аймагт нийт 1,648 аж ахуйн нэгж байгууллага байдгаас 1,398 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага бөгөөд эдгээр үзүүлэлтээрээ улсад 5-рт орсон байна. Үүнээс 78 нь томоохон аж ахуйн нэгж байгууллагад тооцогддог бөгөөд тус үзүүлэлтээр улсад тэргүүлсэн байна. Хөвсгөл аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр эдгээрийн дийлэнх нь аялал жуулчлал, хөдөө аж ахуй, мал аж ахуй, хүнсний боловсруулах үйлдвэрүүд болох нь тодорхой болсон. Түүнчлэн ноос угаах, мах боловсруулах үйлдвэрүүд байдаг.

Хөвсгөл аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 2017 онд харьцангуй бага буюу 68.8% болж улсад 14-рт жагсжээ. Үүнд улирлын чанартай аялал жуулчлал, ЖДҮ-ийг дэмжих замаар ажлын байраар хангах асуудал хязгаарлагдмал байдаг нь нөлөөлсөн. Ажилгүйдлийн түвшин дунджаар 2017 онд 10-рт орсон буюу 8.5% байсан байна.

Хөвсгөл аймагт бага, дунд сургуульд хамрагдалтын түвшин дунджаас дээгүүр, багш, сурагчдын харьцаа өндөр. Эрүүл мэндийн үзүүлэлтийн хувьд Хөвсгөл аймаг доогуур байр эзэлж байна. Тухайлбал 2017 онд дундаж наслалт 66 байсан ба улсад 21-рт орсон.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Хөвсгөл аймгийн хотжилтын түвшин 2017 онд 32.2% байсан бөгөөд энэ нь харьцангуй доогуур үзүүлэлт юм. Аймгийн төв Мөрөн хотын хүн ам 2017 онд 39,407 байсан ба 2010-2017 оны хүн амын жилийн дундаж өсөлт 1.38%-тай байсан байна.

Мөрөн хот нь нийслэл Улаанбаатар хот болон Увс аймгийн төв Улаангомыг холбосон зам дагуу байрладаг. Хөвсгөл аймгийн хувьд авто замын сүлжээ харьцангуй сайн боловч Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын бүсээс бусад сум сууринд авто замыг сайжруулах шаардлагатай. Улаанбаатар, Мөрөн сумын чиглэлийн авто зам зарим хэсэгтээ эвдрэлтэй байна. Мөрөн сумаас Улаанбаатар руу тогтмол нислэг үйлддэг нисэх онгоцны буудалтай. Мөн тус аймагт Монгол Улсдаа ганцхан байдаг усан боомт нь Хөвсгөл нуурын Хатгал боомт юм. Тус боомтыг ачаа тээвэрлэх болон аялал жуулчлалын зориулалтаар завиар аялуулахад л ашигладаг байна.

Эрчим хүч, цэвэр ус, хог хаягдлын менежмент зэрэг дэд бүтцийн хүртээмжийн хувьд дунд зэрэг гэж тодорхойлогддог бөгөөд өргөн хэрэглээний барааны хангамж, томоохон үйлчилгээний төв зэрэг амьдралын үндсэн дэд бүтэц харьцангуй сайн буюу улсын хэмжээнд 2, 3-р байранд жагсдаг.

#### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Хэлэлцүүлэгт оролцогчдыг аймгийн хөгжлийн асуудлаар 4 багт хувааж хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд нийт 4 багийн 3 багаас тодорхойлсон тулгамдаж буй асуудлуудаас хамгийн ноцтой гэж үзсэн асуудал бол нэгдүгээрт хүний хөгжлийн суурь үзүүлэлтүүд доогуур байдал, хоёрдугаарт эрүүл мэндийн

салбарын асуудал, гуравдугаарт аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө алдагдсан байдал, дөрөвдүгээрт бэлчээрийн даац хэтэрсэн байдал зэрэг асуудлууд орж байна.

Хүний хөгжлийн индексийн үзүүлэлт бага байгаа нь Хөвсгөл аймгийн хөгжлийг хязгаарлаж буй асуудал бөгөөд ялангуяа эрүүл мэндийн суурь дэд бүтэц хангалтгүй, нэг их эмчид ногдож байгаа хүний тоо зэргээс харвал эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Эрүүл мэндийн дэд бүтэц сул байгаа нь Хөвсгөлчүүдийн эрүүл мэндэд төдийгүй эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Хүн амын дундаж наслалтын үзүүлэлтээр улсын хэмжээнд 21-р байранд, нялхсын эндэгдлийн түвшин 21-р байранд, халдварт өвчлөлийн үзүүлэлтээр 16-р байранд тус тус жагссан байгаагаас үзэхэд нийт 21 аймаг дотор эрүүл мэндийн үзүүлэлтээр илт доогуур байгаа нь харагдаж байна.

Хөвсгөл аймаг бол Хөвсгөл нуураас эхлээд байгалийн аялал жуулчлалын арвин их нөөц баялагтай аймаг. Харамсалтай нь аялал жуулчлалын салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө хангалтгүй байгаатай зэрэгцээд сүүлийн үед өсөн нэмэгдэх жуулчдаас үүдэлтэй байгаль орчны доройтол ихсэж байна. Түүнчлэн аялал жуулчлалын үйл ажиллагааг Улаанбаатар хотод байрлах аялал жуулчлалын агентлагууд зохион байгуулдаг тул орон нутгийн иргэдэд эдийн засгийн ямар нэгэн үр өгөөж өгдөггүй. Хэдийгээр аялал жуулчлалын нөөц баялаг арвин ч Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбар орон нутгийн иргэдэд хязгаарлагдмал ашиг, орлого өгдөг.

Мал аж ахуй нь Хөвсгөл аймгийн эдийн засгийг авч явдаг үндсэн салбарын нэг юм. Бэлчээрийн хязгаарлагдмал байдал, малын тоо аль хэдийнээ зохих түвшнээс давсан. Хэлэлцүүлэгт оролцогчдын дийлэнх нь бэлчээрийн даац хэтэрсэн байдал болон мал аж ахуй бодлого алдагдсанаас үүдэлтэй бэлчээр доройтож байгаа талаар онцолж байв. Мөн ойн нөөцийн зохистой менежмент сул бөгөөд модны хаягдал үртэс, зомгол, гишүү, мөчир зэргийг ашиглалгүй хаядаг. Ойн нөөцөд суурилсан модны аж ахуй, модон эдлэлийн үйлдвэрлэл хөгжөөгүй, гар урлал, өрхийн түвшинд хөгжиж байна гэж үзсэн. Зарим сумдын цэвэр ус хангамжийн хүртээмж муу, аялал жуулчлалын бүсэд хатуу хог хаягдлын менежмент хангалтгүй байгаа талаар хэлэлцүүлэгт оролцогчид хэлж байв.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Хөвсгөл аймаг алт, зэс, молибден зэрэг металл ашигт малтмалаас гадна фосфорит, нүүрс, бал чулуу зэрэг металл бус ашигт малтмалын баялагтай. Гэсэн хэдий ч хэлэлцүүлэгт оролцогчдын илэрхийлж байсанчлан Хөвсгөл аймаг уул уурхайгүй аймаг болохыг зорьж байна. Учир нь ашигт малтмалын орд газрууд нь ихэвчлэн ой мод бүхий газар нутагт тархсан байдаг. Металл бус ашигт малтмалыг бага хэмжээгээр олборлох боломжтой аж.

Хөвсгөл аймагт тэргүүлэх салбар болох аялал жуулчлал, газар тариалан, мал аж ахуй, ой модны аж ахуйд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй. Эдгээр салбарыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөний дагуу тогтвортойгоор дэмжиж ажиллах хэрэгтэй. Байгалийн баялагт суурилсан байгаль орчинд ээлтэй загварыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Байгалийн арвин их нөөц баялаг, соёл уламжлал, агаарын зорчигч тээврээр холбогдох боломж зэрэг харьцангуй давуу талууддаа түшиглэн аялал жуулчлалын төрөл, чиглэлийг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улсын аялал жуулчлалын гол төв гэдэг утгаараа давуу талаа нэмэгдүүлэхийн тулд байгалийн

аялал жуулчлал, эрүүл мэндийн аялал жуулчлал, соёлын аялал жуулчлал болон бусад олон хэлбэрийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Иргэдийн оролцоонд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд аялал жуулчлалаас олсон орлогыг Улаанбаатар болон бусад орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй иргэдэд алдалгүй нутгийн иргэд хүртэж болох хэлбэрийг хөгжүүлэх нийтлэг суурь баазыг бий болгох нь зүйтэй. Түүнчлэн нутгийн иргэдийн эрхэлдэг газар тариалан, мал аж ахуйгаас гаралтай шинэ жимс, хүнсний ногоо, мах болон махан бүтээгдэхүүн, боловсруулсан бяслаг, айраг, зөгийн бал зэргийг жуулчдад зориулж нийлүүлдэг.

Өргөн уудам, ой мод ихтэй газруудад жуулчдад зориулсан байгалийн болон адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бий. Шувууд ажиглах аялалд Европын жуулчид ихээр татагддаг. Мөрөн хотын төвд олон улсын зэрэглэлийн зочид буудал, урт хугацаагаар аялж байгаа жуулчдад зориулсан жижиг байшин, гэр баазууд зэрэг олон сонголтуудтай.

Мал аж ахуйн салбарт малын тоо толгойг зохих түвшинд барих, малын гаралтай түүхий эдийг нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болгон боловсруулалт хийхэд анхаарал хандуулах нь зүйтэй. Малын тоо толгой их тул Хөвсгөл аймаг нь мах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Орхон, Дархан-Уул зэрэг хот, суурин газруудад болон жуулчдад шинэ мах, сүүн бүтээгдэхүүн ханган нийлүүлж болно.

Ойн нөөцийг хамгаалах, үр дүнтэй ашиглах нь аймгийн хөгжилд чухал ач холбогдолтой юм. Ойн нөөцийг үнэлэх, ой модон бус бүтээгдэхүүний түүхий эдийн нөөцийг бүрэн хэмжээгээр нь тогтоож, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тусгасан урт болон дунд хугацааны ойн нөөцийг зохистой ашиглах мастер төлөвлөгөөг боловсруулах боломжтой.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх томоохон хэмжээний бүтээн байгуулалтыг хийхдээ түүнээс олох орлогын нэг хэсгийг ой хамгаалал төдийгүй нийгмийн дэд бүтцийг бий болгоход ашиглах нөхцөлтэйгээр мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой.

### **7.3.3 Архангай аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**

##### Газар зүйн нөхцөл байдал



Архангай аймаг нь Хангай нурууны хойд хэсэгт, хойноос урагш 260 км, зүүнээс баруун 350 км үргэлжилсэн газар нутагтай. Бүхэлдээ өндөрлөг газарт оршдог бөгөөд нутгийн өмнөд хэсгээр далайн түвшнээс дээш 2.500-3,000 м, нутгийн зүүн хойд хэсэг Булган аймагтай хиллэх бөгөөд 1,300-1,400м-ийн өндөрт оршдог. Аймгийн төв Цэцэрлэг хот нь 1,700 м-ийн өндөрт оршдог. Аймгийн хамгийн өндөр цэг нь Харлагтай уул бөгөөд 3,529 м-т оршдог.

Тамирын гол нь Цэцэрлэг хотын хажуугаар урсах ба 1290 м-т орших хамгийн нам дор цэг бөгөөд Орхон голд цутгадаг. Чулуут болон Хануйн гол нь хойшоо чиглэлтэй урсаж Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Тэрхийн цагаан нуур нь жуулчдын очих дуртай газрын нэг юм.

2018 онд 132 өдөр хур тунадастай байсан бөгөөд Хангайн бүсэд Эрдэнэт, Булган аймгийн дараа 3-р байранд жагссан. Жилийн хур тунадасны хэмжээ 296 мм байсан нь Эрдэнэт хотын дараа 2-р байранд жагссан.



**Зураг 7.3.3 Архангай аймгийн байршил**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

2018 онд БДНБ 431 тэрбум байсан нь улсын хэмжээнд 12-р байранд буюу 2010 онтой адил түвшинд байв. 2010 онд нэг хүнд ногдох БДНБ 1,428,000 (18-р байр) байснаас 2018 онд 4,328 мянган төгрөг (16-р байр) болж нэмэгдсэн. 2010 онд эдийн засгийн бүтцэд хөдөө аж ахуй 59%, аж үйлдвэр, барилга 13%, үйлчилгээ 28%-ийг эзэлж байсан бол 2017 онд 54%, 22%, 24% болж хөдөө аж ахуйн салбар голлох үүрэгтэй хэвээрээ байна. 2010 онд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгаар улсын хэмжээнд 5-р байранд, 2018 онд 2-р байранд жагссан байна.

Хөдөө аж ахуй дотроо мал аж ахуй түлхүү эрхэлдэг бөгөөд 2018 онд малын тоо 5,482,00 болж, улсад 2-р байранд жагссан нь 2010 оны 3-р байрнаас дээшилсэн байна. Малын тоо 2010-2018 онд 105 хувиар өсч, улсын дундаж өсөлт болох 103 хувиас бага зэрэг өндөр байсан. 1 хүнд ногдох малын тоо 2010 онд 32 (5-р байр), 2018 онд 57 (5-р байр) байв.

2018 оны байдлаар сарын дундаж цалин 621,000 төгрөг буюу улсын хэмжээний дундаж цалингийн 62% бөгөөд улсын хэмжээнд доороосоо 3-р байранд байсан.

Архангай аймгийн хүн ам 2000-2010 оны хооронд жилд 1.5%-иар буурч байсан боловч 2018 он хүртэл жилд 1.7%-иар өссөн байна.

2018 онд ажилгүйдлийн түвшин 5.4% байсан нь Төв (2.6%), Завхан (4.3%), Дундговь (5.0%) аймгийн дараа буюу улсын хэмжээнд доороосоо 4-р байранд жагссан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2010 онд 458 байснаас 2018 онд 519 болж өссөн бөгөөд 1000 хүн тутамд 5.4 тохиолдол бүртгэгдсэн хэвээр байна.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Архангай аймгийн төв Цэцэрлэг хот нь Улаанбаатар хотоос 488 км зайтай орших бөгөөд улсын чанартай А0301, А0601, А0602 асфальтан замаар холбогдоно. Цэцэрлэг хот нь Баруун бүсийн аймгуудыг Улаанбаатар хоттой холбодог төв зам дээр байрладаг. Цэцэрлэг хотоос эхлэлтэй улсын чанартай А0603 авто зам нь баруун зүгт чиглэн А1102 (замын ажил явагдаж байгаа) авто зам болж өөрчлөгдөн 533 км үргэлжлэн Улиастай хоттой холбогддог. Мөн А31 (шороон болон сайжруулсан зам) болон А305 (асфальтан) авто замаар Баян-Өлгий аймгийн Өлгий хоттой 1,044 км зайд холбогддог.

Архангай аймаг нь төвийн эрчим хүчний сүлжээнээс 1,100 мВт-ийн цахилгааны эх үүсвэрээ авдаг бөгөөд цахилгаан болон дулааны станц байхгүй.

Суурин утасны тоо 2010 онд 589 (21-р байр) байснаас 2018 онд 409 (21-р байр) болж буурсан. Уст цэгийн тоо 2010 онд 22 байснаас 2018 онд 34 болж өссөн. Үүнээс шалтгаалж нэг уст цэгээр үйлчлүүлэх хүний тоо 2010 онд 3823 (17-р байр) байснаас 2017 онд 2,823 (22-р байр) болж буурсан.

#### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Архангай аймгийн хөгжилд үндэсний өв уламжлал алдагдах эрсдэлтэй, аж үйлдвэр, үйлчилгээний хөгжил сул, бизнес эрхлэх таатай орчин бүрдээгүй, хүний нөөцийн хомсдол, дэд бүтэц хөгжөөгүй гэх мэт асуудлууд тулгарч байна.

Архангай аймаг нь үндэсний өв уламжлалаа хадгалсан байдлын үзүүлэлтээр улсын хэмжээнд 19-р байранд жагссан. Мал аж ахуй нь аймгийн эдийн засагт том байр суурь эзэлдэг боловч иргэд энэхүү уламжлалт амьдралын хэв маягтаа хайхрамжгүй ханддаг нь дээрх үзүүлэлтээс харагдаж байна. Мал аж ахуй эрхлэх нь бахархалтай, үр ашигтай ажил гэдгийг иргэдэд ялангуяа залуу үеийнхэнд ойлгуулах нь чухал байна. Мал аж ахуй эрхлэлтийг сайн сурталчлах нь хүмүүсийн эерэг хандлага, ирээдүйдээ итгэлтэй амьдрахад хувь нэмэр болно.

2018 онд Архангай аймгийн эдийн засаг төрөлжөөгүй, мал аж ахуйн үйл ажиллагаа давамгайлж байсан. Аж үйлдвэрлэл, бизнесийн салбарын хөгжил маш хангалтгүй, боловсруулах болон технологийн дэвшилтэт үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хөгжөөгүй. Аж үйлдвэр, бизнесийн хөгжил хангалтгүй байдлыг улсын түвшинтэй харьцуулахад: бизнес эрхлэхэд хялбар байдал - 18-р байр, бизнес эрхлэх зөвшөөрөл авах болон мэдээллийн ил тод байдал - 21-р байр, орон нутгийн тендерийн үйл ажиллагааны шударга байдал - 21-р байр, бизнесийн өрсөлдөөний шударга байдал - 21-р байр, хувиараа бизнес хийх боломж - 17-р байранд байна. Санхүүгийн эх үүсвэр олох боломжийн хувьд 17-р байранд, мөн банкны хүү өндөр (21-р байр) байна.

Орон нутгийн засаг захиргаа иргэдтэй хамтран хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь дутмаг байгааг орон нутгийн засаг захиргааны шийдвэр, бодлогын

ил тод байдал муу (21-р байр), төсвийн зарцуулалт орон нутгийн мэдлээр тодорхойлох, нөлөөлөх чадамж муу (21-р байр), орон нутгаас гаргасан тогтоол, шийдвэр нь орон нутгийн хөгжилд муу нөлөөлдөг (15-р байр) зэрэг үзүүлэлтээс дүгнэж болох юм.

Архангай аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр оролцогчид иргэдийн хандлага, сэтгэлгээ нь хөгжилд саад болж буйг онцолж байсан. Төрөөс нийгмийн халамжийн бодлогыг хэт хавтгайруулж, бэлэнчлэх сэтгэлгээг газар авхуулж байгаа талаар дурдсан. Архидан согтуурах явдал ажиглагдаж байна. Хүний нөөцийн үүднээс авч үзвэл, мэргэшсэн инженер дутмаг (19-р байр), бизнес эрхлэх ур чадвар бага (18-р байр), гадаад хэлний чадвар муу (19-р байр) зэрэг асуудлууд байна. Мөн хэлэлцүүлэгт оролцогчид Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь онолын хичээлд хэтэрхий анхаарч, суралцагчдад практик ур чадварыг эзэмшүүлж чадахгүй, төгсөгчид нь компаниудын эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсон хүчин болж бэлтгэгдэхгүй байгааг онцолж байсан.

Засгийн газрын хувьд сонгуулийн дөрвөн жилийн хугацаагаар хязгаарлагдсан улс төрийн мөчлөгт нөлөөлсөн бодлого нь тогтвортой хөгжлийг сааруулж байна. Цэвэр ус хангамжийн дэд бүтцийн байдал, халаалтын систем, халаалтын үнэ зэрэг үзүүлэлтээр улсын хэмжээнд 19,16,21-р байранд жагссан.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Архангай аймгийн эдийн засаг нь мал аж ахуйгаас хэт хамааралтай ч эдийн засгийн өсөлтөд давуу тал болж болно. Одоогийн эдийн засгийн энгийн, хязгаарлагдмал үйлдвэрлэлээс боловсруулах чиглэлийн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал байна. Энэхүү зорилгоор аймгийн төв Цэцэрлэг болон Цэцэрлэг-Хархорин чиглэлийн авто замын дагуу байрлаж буй Хотонт суманд үндсэн байгууламжуудыг байгуулж мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх боломжтой. Баруун болон төв аймгуудаас хүлээн авсан ноосыг угааж цэвэрлэдэг Хотонт сумын ноос угаах үйлдвэр ашиглалтад орсон. Дэд кластерыг холбоос замыг сайжруулсны дараа төв замаас хойд зүгт байрлах Эрдэнэмандал, Батцэнгэл, Өгий нуур, Хашаат сумдад байгуулах нь зүйтэй.

Эдгээр 4 сумын төвийн давуу талыг урьдчилсан байдлаар авч үзвэл, А0602/03 авто замын хойд талд харьцангуй тал хээрийн, өндөрлөг бус нутаг дэвсгэртэй, гадаргын ус элбэгтэй, эргэн тойрны авто замын сүлжээ сайн хөгжсөн. Хөдөө орон нутгаас тээвэрлэж ирсэн мах, сүү, ноос, ноолуур, малын арьс зэрэг түүхий эдийг үйлдвэрлэлийн кластерын төвүүдэд боловсруулан Улаанбаатар хот болон бусад суурин газруудад ханган, улмаар экспортод гаргах боломжтой.

Нэг үйлдвэрлэлийн кластерын төвд өдөрт 150 орчим малын түүхий эдийг хэрхэн боловсруулах талаар энгийн тооцоо хийж үзвэл:

- 2018 онд Архангай аймгийн нийт малын тоо: 5,482,000
- Жил бүр 5%-г нь эргэлтэд оруулах
- Жил бүр 274,000-г боловсруулах
- Архангай аймгийн хэмжээнд өдөрт 750 малын мах боловсруулах
- Нэг байршилд өдөрт 150 малын мах боловсруулах

Цаашид үйлдвэрлэлийн оновчтой хэмжээ, нэг кластерт ногдох малын тоо, зах зээлээс алслагдах байдалтай уялдуулан босоо тэнхлэгийн дагуу байршлаар хуваах зэргийг нарийвчлан тооцоолох шаардлагатай байна. Эдгээр байршилд

авто зам, цахилгаан эрчим хүч, дулаан, цэвэр ус хангамж, ариутгах татуурга, хатуу хог хаягдлын менежментийг сайжруулахад шаардлагатай дэд бүтцийг шинэчлэх шаардлагатай байна. Байгаль орчны зохистой менежмент нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах урьдчилсан нөхцөл болно. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл бусад аймгаас түлхүү хөгжихийн хирээр Архангай аймаг малын тоог хянах, бэлчээрийн даац хэтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор малын хөлийн татварын шинэ тогтолцоог бий болгох хэрэгтэй.

Энэхүү үйлдвэрлэлийн кластерт малын тэжээлийн үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй нь түүхий эдийг нийлүүлнэ. Архангай аймаг нь малын тэжээл, үр тарианы тариалалтаараа сайн туршлага хуримтлуулсан аймаг юм. 2018 онд 5,817 тн малын тэжээл тариалж, улсын хэмжээнд Төв, Сэлэнгэ аймгийн дараа жагссан. 2018 онд малын тэжээлийн 1 га-гаас авах ургац 2.7 тн, улсын хэмжээнд 12-р байранд жагссан. Харин Улаанбаатар хот орчмын 1 га-гаас авах ургацын хэмжээ хамгийн өндөр 10.6 тн буюу нийт ургацын 25%-ийг авдаг. 2018 онд Архангай аймаг тариалангийн газрын хэмжээгээр улсад 5-р байранд жагссан ч нийт авсан ургацын хэмжээгээр 10-р байранд жагссан нь 1 га-гаас авах ургацын хэмжээ хангалтгүй гэсэн үг юм (2018 онд га-гаас 0.96 тн ургац авсан бол хамгийн өндөр нь Орхон аймагт 3.13 тн байсан). Аймгийн ихэнх нутгийг хамарсан үржил шимт хар шороон хөрстэй, гадаргын усны нөөц сайтай аймгийн хувьд 1 га-гаас авах ургацын хэмжээг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Цэцэрлэг хотоос 170 км зайтай орших байгалийн өвөрмөц тогтоцтой, аялал жуулчлалын түшиц газар болох Тэрхийн цагаан нуурыг мал аж ахуйтай хослуулан тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх шаардлагатай байна. Үржил шимт хөрс, ус хангамжийн давуу талаа ашиглан газар тариаланг мал аж ахуйтай хослуулан аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, шинэ жимс жимсгэнэ, ногоогоор зах зээлийг хангах шаардлагатай байна. Мэдээлэл харилцаа холбооны технологийг зайнаас эмчлэх, зайнаас суралцах, эрчимжсэн болон бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдэд зориулсан цаг уурын урьдчилсан мэдээлэл өгөх, аялал жуулчлалын

Арьс, ширний бүтээгдэхүүн: БДНБ-д оруулах хувь нэмэр болон шаардлагатай ус хангамж, газар ашиглалтын урьдчилсан тооцоо

БДНБ-д оруулах хувь нэмэр, жишээлбэл:

- |                           |   |
|---------------------------|---|
| a) Арьс, шир (түүхий эд): | 42 кг/үхэр  |
| b) Үнэ:                   | 1.5 ам.доллар / кг                                  |
| c) Үхрийн тоо:            | 124 мян. үхэр = 20% нийт 621.2 мян. үхэр( 2018)     |
| d) Нийт борлуулалт:       | 13.0 сая ам.доллар эсвэл 32,599 сая төгрөг a)*b)*c) |
| e) БДНБ:                  | 430,740 сая төгрөг (2018)                           |
| f) Хувь нэмэр:            | 7.6% d)/e)  |

Шаардлагатай ус хангамж, газар ашиглалтын тооцоо

- |                          |  |
|--------------------------|--|
| a) 1 үхэрт ногдох газар: | 1 үхэрт 100 м <sup>2</sup>   |
| b) Үхрийн тоо:           | Жилд 24 мян. эсвэл өдөрт 340 үхэр                                      |
| c) Нийт газар:           | 34,000 м <sup>2</sup> эсвэл 3.4 га газар                               |
| d) Усны хэрэгцээ         | Нэгж: 1,000 м <sup>2</sup> тутамд өдөрт 26.9 м <sup>3</sup> (Япон улс) |
| e) Нийт ус хангамж:      | өдөрт 914 м <sup>3</sup>   |

**Урьдач нөхцөл:**

- (i) Бусад малыг орлуулахдаа тухайн малын арьс, ширний тооцоог авч үзэх нь зүйтэй.
- (ii) Түүхий эдийг хэдий чинээ сайн боловсруулна төдий чинээ БДНБ-д оруулах хувь нэмэр өснө.

мэдээлэл зэргийг солилцоход нэг талаас малчид нөгөө талаас орон нутгийн засаг

захиргаа ашиглаж болох юм. ‘Хот суурин газар руу иргэд татагддаг’ гэхийн оронд ‘Иргэдийн амьдарч буй газар руу таталцлыг бий болгох’ гэсэн ойлголтыг цаашид, ялангуяа шинэ үеийн малчид санаачлах хэрэгтэй.

### 7.3.4 Булган аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал

##### Газар зүйн нөхцөл байдал


Булган аймаг нь Хангайн бүсийн зүүн хойд хэсэгт нийслэл хотоос 280 км зайтай оршдог бөгөөд аймгийн газар нутгийн хэмжээ нь 48,700 км<sup>2</sup>. Аймгийн хойд хэсэг бүхэлдээ ойн сан бүхий газар нутаг юм. Аймгийн жилийн дундаж агаарын температур -0.9 -1.6 хэм хүйтэн, жилд дунджаар 300-350 мм хур тунадас ордог. Орхон, Сэлэнгэ гол нь Өвөрхангай аймгаар дайрч урсан өнгөрдөг. Аймгийн өмнөд хэсэг нь газар тариалан эрхлэхэд тааламжтай.

Ойн сан бүхий газар нутаг 19,050 км<sup>2</sup> (39.1%) бөгөөд нутгийн төв, хойд хэсэгт оршдог. Монгол орны хэмжээнд ихэнх ойн сан бүхий газар нь тусгай хамгаалалттай газарт хамаардаг. Булган аймгийн хувьд нутгийн нийт ойн 7% нь аж ахуйн зориулалттай байдаг.

**Зураг 7.3.4 Булган аймгийн байршил**







Эх сурвалж: БОАЖЯ-ны зургийг ашиглаж ЖАЙКА-гийн Төслийн баг бэлтгэв.

### Нийгэм, эдийн засаг

Булган аймаг нь 2017 оны байдлаар 61,300 хүн амтай, хүн амын нягтрал 1.26/км<sup>2</sup> байсан байна. 2010-2015 онд хүн ам жилд дунджаар 2.37%-иар өсч байсан бол 2000-2010 онуудад -1.20%-иар буурч байсан. Сүүлийн жилүүдэд хүн ам өсөж байгаа шалтгааныг 1) Эрдэнэт, Улаанбаатар зэрэг том хотууд руу иргэдийн шилжих хөдөлгөөн буурсан, 2) Увс зэрэг баруун аймгуудаас иргэд нүүн ирж байгаа, 3) Дэд бүтцийн хөгжил, амьдрах орчин, ажлын байр нэмэгдэж байгаа зэргээр тайлбарлаж болно.

Булган аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбар зонхилох байр суурийг эзэлдэг бөгөөд 2017 оны байдлаар БДНБ-ий 50.9%-ийг эзэлсэн байна. 2017 онд 974,000 (8-р байр) мал тоологдсон бөгөөд нэг малчин өрхөд ногдох малын тоо 396 (10-р байр) байсан. 48,559 га газар тариалангийн газартай бөгөөд улсын хэмжээнд 3-р байранд жагссан. Булган аймгийн үржил шимт хөрс, уур амьсгалын нөхцөл нь газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой. Хангайн бүсийн аймгуудын дунд хамгийн их буюу 42,993 га талбайд үр тариа, 288 га-д малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалдаг.

2017 онд нэг хүнд ногдох БДНБ нь 4,607,000 төгрөг байсан бөгөөд хөдөлмөрийн бүтээмж 10,211,000 (11-р байр) төгрөг байсан нь улсын хэмжээнд дундаж үзүүлэлт юм. Аймгийн хэлэлцүүлгийн үеэр, иргэд хөдөлмөрийн бүтээмж бага байдаг нь бэлчээрийн Мал аж ахуй давамгайлдаг болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж бага байдагтай холбоотойг дурдсан.

Булган аймагт 2017 онд нийт 1,186 аж ахуйн нэгж байгууллага (13-р байр) бүртгэгдсэнээс 1,008 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага (13-р байр), 30 томоохон аж ахуйн нэгж байгууллага (14-р байр) үйл ажиллагаа явуулж байсан. Аж үйлдвэрийн салбар төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд ажилгүйдлийн түвшин 10.7% (14-р байр)-тай байсан.

Нийгмийн хөгжлийн талаас бага, дунд, ахлах сургуульд хамрагдалтын түвшин бусад аймгуудтай харьцуулах хамгийн доогуур үзүүлэлттэй байна. Гэхдээ бага сургуулийн багш-сурагчийн харьцаа зохистой түвшинд буюу улсын хэмжээнд 5-р



байранд жагссан байна. Дээрх үзүүлэлтүүдээс харахад бага, дунд, ахлах ангийн элсэлт хамрагдалт хангалтгүй гэж харагдаж байна. Санал асуулгад оролцогчид Булган аймгийн боловсролын чанар сайн биш учраас олон хүүхэд Эрдэнэт, Улаанбаатар хот руу суралцахаар явдаг гэсэн.

Нөгөө талаар Булган аймгийн хэмжээнд эрүүл мэндийн үйлчилгээ харьцангуй сайн байна. 10,000 хүн тутамд ногдох халдварт өвчний тоо 77 (7-р байр), амьд төрсөн 1,000 төрөлт тутмын нялхсын эндэгдэл 11 байна. Өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, эмнэлгийн ажилтнуудын хамрагдах сургалтын байдлаас эрүүл мэндийн үйлчилгээ, эмнэлэг, эрүүл мэндийн төвийн чанарыг харж болно.

### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Булган аймгийн хотжилтын түвшин 2017 онд 19.8% байсан нь маш доогуур үзүүлэлт юм. Энэ нь хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын тоо, ялангуяа малчдын тоо өндөртэй холбоотой. 1,000 өрх тутамд ногдох утасны шугам 10 байгаа нь улсын хэмжээнд 11-р байранд жагссан байна.

Булган аймаг нь авто замын чанар сайтай аймгуудын нэг бөгөөд Эрдэнэт, Дархан, Улаанбаатар, Хөвсгөл аймгийн Мөрөнтэй холбогдсон. Улаанбаатар-Булганы хооронд тээвэрлэлтийн хувьд ямар ч асуудалгүй.

Булган аймгийн ус хангамжийн хүрэлцээ, усны чанар нь дунд зэргийн үзүүлэлттэй. Хатуу хог хаягдлын менежмент бусад аймгуудаас сайн байна.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

### 1) Нийгэм, эдийн засаг

Аймгийн төвийн хүн ам цөөн байгаа нь Булган аймгийн хөгжилд тулгарч буй асуудал бөгөөд олон төрлийн бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарладаг. Хөдөө орон нутагт мал аж ахуй зонхилж байна. Аймгийн төвд аж үйлдвэрлэлийн чадавх хангалтгүйгээс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд төвөгтэй байна.

БДНБ-д үйлчилгээний салбарын оролцоо бага байгаа нь асуудал үүсгэж байна. Булган аймгийн хувьд мал аж ахуй зонхилсон эдийн засгийн үйл ажиллагаанаас хот суурин газрын эдийн засгийн үйл ажиллагаанд чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хөгжих шилжилтийн үедээ байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар сайн хөгжихгүйгээр аж үйлдвэрлэлийн чадавх сайжрахгүй. Энэ нь зөвхөн уул уурхайн салбар бага хөгжсөнтэй холбоотой бус боловсролын салбарын хөгжил хангалттай бус, мэргэшсэн инженерүүдийн тоо бага байгаатай холбоотой. Эдгээр хүчин зүйл нь нийгэм, эдийн засгийн хөгжил, шилжилт хөдөлгөөн зэрэг олон асуудлыг үүсгэж байна.

### 2) Байгаль орчин

Булган аймгийн байгаль орчинд тулгарч буй асуудал нь бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй эрсдэл багатай байна. Гэхдээ аймгийн нутгийн хойд болон өмнөд хэсэг зудын эрсдэлд өртөх магадлалтай.

### 3) Дэд бүтэц

Монгол Улсын бусад аймгуудтай харьцуулахад технологийн дэд бүтэц ялангуяа мэдээллийн хүртээмжтэй байдал төдийлөн сайн биш байна. Энэ нь аймгийн иргэд

орон нутгийн нөхцөл байдлын талаар ерөнхий мэдээлэл хялбар олж авч чаддаггүй гэсэн үг юм. Булган аймгийн иргэд цаг үеийн болон үнэт бодит байдлын мэдээлэл олон нийтийн мэдээллийн сувгаар олж авч буй байдлын үзүүлэлтээр улсын хэмжээнд доороосоо 2-р байранд жагссан байна. Энэ нь нутгийн иргэд хөдөө орон нутагт амьдардагтай холбоотой.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Булган аймгийн хөдөө аж ахуйн салбар БДНБ-ий 50%-ийг эзэлдэг бөгөөд харьцангуй хотжилтын түвшин бага аймаг юм. Аймгийн боловсруулах үйлдвэрлэл болон боловсролын салбар тааруу хөгжсөн ч нэг хүнд ногдох БДНБ-ий хэмжээгээр дунд зэргийн үзүүлэлттэй байна. Анхдагч үйлдвэрлэл болох газар тариалан болон мал аж ахуйн салбар давамгайлж байгаа учраас дээрх тоон үзүүлэлт улсын хэмжээнд дунд зэрэг байгаагаар тайлбарлаж болно.

Булган аймаг нь ҮХЦТ-нд дэвшүүлж буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн загварыг дэмжсэн байгалийн нөөцөөс, ялангуяа уул уурхай, хүнд үйлдвэрлэлээс хэт хамааралтай бус, илүү байгаль орчинд ээлтэй бодлоготой аймаг болох нөөц бололцоотой. Ажилгүйдлийн түвшинг бууруулахдаа ажиллах хүчний оролцоог дэмжсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ технологийн дэвшлийг нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн бодлоготой хослуулсан байдлаар үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай байна.

Богино хугацаанд Булган аймаг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг дэмжих, сайжруулахын тулд газар тариалангийн механикжуулалт, услалтын системийн шинэчлэл хийх, дотоодын хүнсний хэрэгцээг бүрэн хангах шаардлагатай байна. Дунд хугацаанд үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэнээр илүү гарсан бүтээгдэхүүнээ бусад аймаг болон ОХУ руу экспортолж болох юм.

Эрчимжсэн мал аж ахуй болон өндөр ургацтай газар тариаланг хослуулж аймгийн төвийн боловсруулах үйлдвэрүүдийг гол зам дагуух газруудтай холбож хөгжүүлэх нь маш чухал юм. Анхдагч болон хоёрдогч үйлдвэрлэлийн салбарын боловсруулсан бүтээгдэхүүнийг нийслэл хот болон бусад зэргэлдээх Эрдэнэт зэрэг хотуудад борлуулж болох юм. Мөн зөгийний аж ахуйг, газар тариалантай хослуулан хөгжүүлбэл ач холбогдолтой гэж үзэж байна.

Булган аймаг нь Улаанбаатар-Эрдэнэт-Мөрөнгийн чиглэлийн гол авто зам дагуу байрладаг. Булган аймаг нь худалдаа, аялал жуулчлалын чухал транзит болон гол коридор зам дагуу байрлаж байгаа бөгөөд ОХУ-ын Буриадтай ч холбогдож болох юм. Японы МИЧИ НО ЭКИ буюу зам дагуу үйлчилгээний төв эсвэл аялал жуулчлал, үйлдвэрлэлийг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аймаг болох боломжтой.

Булган аймаг ой модоор баялаг учраас үйлдвэрлэл эрхлэхэд бэрхшээл учирдаг байж болзошгүй. Гэхдээ ойн аж ахуй, сайн чанарын дулаалгын материал эсвэл тавилга үйлдвэрлэлийг хөгжүүлж эдийн засгийг төрөлжүүлэх бүрэн боломжтой аймаг юм.

Том хотууд руу шилжих хөдөлгөөнийг багасгахад нийгмийн хөгжил онцгой ач холбогдолтой. Булган аймгийн эрүүл мэндийн үйлчилгээ сайн боловч боловсролын чанар төдийлөн сайн бус байна. Цаашид иргэдийн дуу хоолойг сайтар сонсож, амьдрал ахуйд нь гарч буй бэрхшээлийг шийдэхийн төлөө

ажиллах шаардлагатай. Мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглан иргэдийн оролцоог сайтар нэмэгдүүлэх нь маш чухал юм.

### 7.3.5 Сэлэнгэ аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал

##### Газар зүйн нөхцөл байдал


Сэлэнгэ аймаг нь 44,500 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй ба хойд хэсгээрээ ОХУ-тай хил залгаа оршдог. Хангайн нуруу нутгийн баруун хэсгээр, Хэнтийн нуруу нутгийн зүүн хэсгээр байдаг ба далайн түвшнээс 600-1200 м өндөрт өргөгдсөн. Далайн түвшнээс дээш өргөгдсөн дундаж 1,580 метртэй харьцуулахад нам дор хэсэгт оршино. Нутгийн ойролцоох уулс нь далайн түвшнээс дээш 1,600 метр өндөрт өргөгдсөн.

Сэлэнгэ мөрөн нь Монгол орны хамгийн том гол ба аймгийн нутаг дэвсгэр дундуур баруун өмнөд зүгээс зүүн хойд зүгт чиглэн урсаж ОХУ-ын Байгаль нуурт цутгадаг. Сэлэнгэ мөрний ус цуглуулах талбай нь 447,000 км<sup>2</sup> бөгөөд хоёрдугаар сард усны дундаж урсац 23 м<sup>3</sup>/сек, 8-р сард 601 м<sup>3</sup>/сек байна. Орхон гол нь Сүхбаатар хотын баруун хэсэгт Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Сэлэнгэ мөрний урт 1,124 м ба усны дундаж урсац 66 м<sup>3</sup>/сек байна.

Аймгийн нутаг дэвсгэрт дийлэнхдээ ойт хээрийн, төв хэсэгт тал хээрийн уур амьсгал зонхилно. 2017 онд 357 мм хур тунадас унаж, 125 бороотой өдөр байсан. Улаан буудай тариалахад тохиромжтой үржил шимтэй хар шороон хөрстэй.

**Зураг 7.3.5 Сэлэнгэ аймгийн байршил**





Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (БОАЖЯ-ны зургийг ашиглав).

### Нийгэм, эдийн засаг

Сэлэнгэ аймгийн хүн ам 1990- 2017 он хүртэл жилд дунджаар 0.75%-ийн өсөлттэй байсан ч 2000-2005 онд 1.0%-иар буурсан байсан. Хүн ам нь 2005 оноос нилээд өссөн. Үүнд: 2005-2010 онд хүн амын жилийн дундаж өсөлт 1.3%, 2016 онд 1.9%, 2017 онд 2.0% байжээ. Ердийн өсөлт (төрөлт – нас баралт ) жилд 1.2-1.7% -ийн хооронд хэлбэлзэж байсан нь шилжилт хөдөлгөөн хүн амын өсөлт бууралтад нөлөөлжээ. 2009 он хүртэл гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн ихтэй байсан бол 2010 оноос хойш шилжин ирэгсдийн тоо нэмэгдэж байна. 2019 оны 4-р сарын 24-ний өдөр зохион байгуулсан аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид ч сүүлийн үед Увс, Завхан зэрэг баруун аймгаас малчид зах зээлд ойртох, бэлчээр сайтай зэргээс шалтгаалан ирж суурьшиж байгаа талаар дурдсан. Тэдгээр малчдын дийлэнх нь боловсрол багатай, мэргэжилгүй байдаг байна.

Ядуурлын түвшин 36% болж улсад 12-р байранд орсон байна. Хэлэлцүүлгийн үеэр Сэлэнгэ аймгийн иргэд үр тарианы аж ахуй эрхэлдэг боловч баруун аймгаас ирсэн боловсрол багатай, мэргэжилгүй хүмүүсийн тоо нэмэгдсэнээр ажилгүйдлийн түвшинг ихэсгэж байгаа гэсэн.

Сэлэнгэ аймгийн эдийн засгийн голлох салбар нь үр тарианы үйлдвэрлэл юм. 2017 оны байдлаар улсын нийт тариалсан талбайн 40% буюу 157,000 га-д тариалалт хийсэн. Нийт тариалангийн талбайд улаан буудай (40%), хүнсний ногоо (31%), малын тэжээл (33%) тарьсан. Сэлэнгэ аймаг нь Монгол Улсын газар тариалангийн үйлдвэрлэлд гол байр суурь эзэлдэг бөгөөд улсын хэмжээнд улаан буудайн хэрэгцээний 64%, төмс, хүнсний ногооны хэрэгцээний 38%-ийг хангадаг. Монгол Улсын хэмжээнд 1 га талбайгаас хураасан ургацын хэмжээ харьцангуй өндөр буюу улаан буудай 0.96 тн/га ( Монгол Улсын дундаж 0.61 тонн/га), хүнсний ногоо 9.8 тн/га, төмс 8.0 тн/га байна. Энэ нь Монгол Улсын хувьд 1 га талбайгаас хураасан ургац өндөр мэт боловч бусад улсуудтай харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна. 2017 онд 1 га талбайгаас хураасан ургацын дэлхийн дундаж буудайны хувьд 3.5 тн/га байсан. Япон улс 2018 онд 1 га талбайгаас дунджаар хураасан ургац 4.0 тн/га байсан бөгөөд Хоккайдод 4.6 тн/га хамгийн их ургац, Осакад 1.2 тн/га ургац тус тус хураан авчээ. Хүнсний ногооны хувьд 2018 онд

Япон улс өргөст хэмх, баклажан, улаан лооль, ногоон чинжүүг 1 га талбайгаас 35-54 тн/га ургац хураан авсан байна. Сэлэнгэ аймагт 1 га талбайгаас хураах ургацын хэмжээг нэмэгдүүлэх асар их боломж бий.

2017 онд Сэлэнгэ аймгийн аж үйлдвэрийн салбар БДНБ-ий 53%, үйлчилгээний салбар 28%, газар тариалан 19%-ийг эзэлсэн. Энэ үзүүлэлт нь Сэлэнгэ аймгийн газар тариалангийн салбар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт бага байгааг харуулж байна. Үр тариа, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт нь аймгийн эдийн засгийн гол хөшүүрэг болох ёстой.

Нэг хүнд ногдох БДНБ нь 2017 онд 5,290,000 төгрөг ба улсад 7-р байранд жагссан нь уг үзүүлэлтээр тэргүүлсэн Орхон аймгийн 2010 оны үзүүлэлттэй харьцуулахад 2.1, 2017 оны үзүүлэлттэй харьцуулахад 3.3 дахин бага, маш их зөрүүтэй байна.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Сэлэнгэ аймгийн хэмжээнд хотжилтын түвшин 2017 онд 37.2%, улсад 8-р байранд жагссан байв. Улаанбаатар хотоос бусад хотуудад хотжилтын түвшин буурсан бөгөөд 2010-2017 онд 16 аймагт энэ үзүүлэлт буурсан байна. Сэлэнгэ аймаг ч гэсэн дээрх үзүүлэлт 2010 онд 49% байсан бол 2017 онд 37% болж буурсан байна. Шалтгаан нь иргэд газар тариалан эрхлэхээр хөдөө орон нутаг руу шилжин суурьшсан бөгөөд энэ онуудад аймгийн тариалангийн эргэлтийн талбай 42%-иар нэмэгдсэн байна. Хотжилтын түвшинд мал аж ахуйн үйл ажиллагаа нөлөөлөөгүй нь энэ онуудад малчдын тоо 7%-иар буурснаас харж болно. Сүүлийн жилүүдэд хүн амын тоо өсөж байгаа бөгөөд зэргэлдээ аймгаас малчид шилжин ирж, суурьшиж байна.

Сэлэнгэ аймаг нь харьцангуй сайн дэд бүтэцтэй. Улсын чанартай А0401, А0402, А0403 авто зам өмнөд чиглэлээс ОХУ-ын Улаан-Үд, Байгаль нуур хүрэх авто замтай холбогдоно. 2016 оноос Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Азийн хурдны зам АНЗ-тай холбогдсон. Аймгийн баруун өмнөд хэсгээр далайн түвшнээс дээш 700-1000 м-ийн өндөрт орших Хараа, Орхон голын сав газарт газар тариалан эрхлэх боломжтой Бүрэн, Сант, Орхон, Орхонтуул нь орон нутгийн чанартай авто замаар холбогдсон. Мөн ОХУ, БНХАУ-ыг холбосон олон улсын төмөр зам аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг.

Сэлэнгэ аймгийн ус хангамж, телефон утасны шугамын хүртээмж дунд зэрэг бөгөөд 1,000 хүн тутамд ногдох худгийн тоо 1,470 (11-р байр), телефон утасны шугам 10 (12-р байр) байна. 2015-2017 оны байдлаар Сэлэнгэ аймагт нэг хүнд ногдох барилгын болон дэд бүтцийн засвар үйлчилгээний нийт зардалд 1,177,000 төгрөг зарцуулсан байна.

#### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Сэлэнгэ аймаг нь байгалийн үзэсгэлэнт газар элбэгтэй боловч байгаль орчны доройтолтой холбоотой хэд хэдэн асуудлуудтай тулгарч байна. Баруун аймгаас шилжиж ирсэн малтай өрхийн тоо нэмэгдсэнээс үүдэн бэлчээрийн талхагдал, хөрсний доройтол, тариалангийн талбайн талхагдал, таримал модыг сүйтгэх зэрэг асуудлууд тулгарч байна. Дэлхийн дулаарлаас үүдэлтэй цөлжилт ялангуяа Алтанбулаг, Мандал, Жавхлант, Орхон, Орхонтуул, Сайхан зэрэг сумдад илэрхий мэдрэгдэж байгаа бөгөөд ойн түймэр, цаг агаарын эрс өөрчлөлт болох өвөлдөө хэт хүйтрэх, зундаа хэт халах зэрэг асуудлыг хэлэлцүүлэгт оролцогчид дурдсан. Хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн хууль бус үйл ажиллагаанаас

үүдэлтэй усны урсац багасах, загас олноороо үхэж үрэгдэхээс гадна хууль бусаар мод бэлтгэх явдал их байна.

Сэлэнгэ аймагт техникийн мэргэжил, ур чадварыг эзэмшүүлэх боломж буурч байна. МСҮТ-д суралцагчдын тоо 67%-иар буюу 2010 онд 2,352 байсан бол 2017 онд 773 хүртэл буурсан бол багш нарын тоо 121 байснаас 61 болтлоо буурсан байна. Хэлэлцүүлэгт оролцогчид МСҮТ татан буугдсан, байршил нь оновчтой бус, оюутны 70,000 төгрөгний тэтгэмж зогссон, сургалтын агуулга нь эрэлт хэрэгцээнд нийцэхгүй, багш нарын цалин хангамж тааруу, сургалтын орчин муугаас шалтгаалж багш нарын заах арга, сургалтын чанар дээшлэхгүй байгааг онцолж байлаа. Зарим оюутнууд Дархан хотын МСҮТ-д суралцдаг.

Боловсролын хувьд Сэлэнгэ аймаг нь бага сургуульд хамрагдалтын хувиар улсын хэмжээнд 19-р байранд, ЕБС болон ахлах сургуульд хамрагдалтын хувиар 16-р байранд тус тус орсон байна.

Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн үйлчилгээний талаар хоёрдмол байр суурьтай байна. Статистикийн мэдээллээс үзэхэд нялхсын эндэгдэлийн түвшин болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлийн түвшин 2010-2017 онуудад өссөн байна. 1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэлийн түвшин 6.8-11.0 харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлийн түвшин 10.6-15.1 болж өссөн байхад улсын хэмжээнд энэ үзүүлэлт буурсан. Хэлэлцүүлэгт оролцогчид үүнийг баруун аймгаас малчид олноор шилжин ирсэнтэй холбон тайлбарласан. Мөн эрүүл мэндийн боловсрол олгох, ухуулга сурталчилгаа хийх, тоног төхөөрөмжийг сайжруулах, эмч сувилагчийн тоог нэмэгдүүлэх шаардлагатайг дурдсан бөгөөд зарим иргэд эрүүл мэндийн бодлого, үйлчилгээ, тоног төхөөрөмж сайжирч байгаа гэсэн эерэг сэтгэгдэлтэй байсан.

Усжуулалтын систем хангалтгүйгээс үр тарианы үйлдвэрлэлд муугаар нөлөөлөх, хүлэмжийн аж ахуй, үйлдвэрлэлийг дэмжих бодлого, дүрэм журам хангалтгүй, сүүлийн үеийн дэвшилтэт технологи нэвтрээгүй, хуучин тоног төхөөрөмжтэй, борлуулалтын сүлжээ муу зэрэг асуудал тулгардаг талаар дурдаж байсан.

Мөн ажиллах хүчний оролцооны түвшин бага байгаагаас хамааран хүний нөөцийн хомсдол үүсэж байгаа бөгөөд мэргэжилтэй, ур чадвартай боловсон хүчний гадагшаа шилжих хөдөлгөөн их байна. Татвараас зайлсхийх нь орон нутгийн төсвийн бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд бизнесийн шударга бус орчин, банк санхүүгийн үйлчилгээ хангалтгүй, банкны хүү өндөр зэрэг асуудлууд аймгийн эдийн засгийн хөгжлийг удаашруулж байна.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Монгол Улсын хөгжлийн бодлого нь аймаг тус бүрийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж хөгжүүлэхээс илүүтэйгээр хөгжлийн бүх салбарыг жигд хөгжүүлэх хандлагатай байна. Хүн бүр бүгдийг хүсдэг. Тиймээс тухайн аймагт ямар салбарыг түлхүү хөгжүүлэх зэрэг хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал Дархан-Уул аймаг нь Сэлэнгэ аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй өөрийн хөгжлийн бодлогыг нийцүүлэх ёстой. Хоёр аймгийн хувьд хоёулаа Орхон, Сэлэнгэ голын сав газарт оршдог, байгаль цаг уурын нөхцөл байдал ижил төстэй. Дархан хот нь Монгол Улсын аж үйлдвэрийн томоохон төв бол Сэлэнгэ аймаг нь газар тариалангийн үйлдвэрлэлээр улсдаа тэргүүлдэг аймаг юм. Цаашдаа эдгээр давуу талуудад түшиглэсэн бодлого, төлөвлөлтийг боловсруулах шаардлагатай. Сэлэнгэ аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн давуу талыг дэмжихийн хамт Дархан-Уул аймгийг мэдээлэл,



харилцаа холбооны технологи, хиймэл оюун ухаан, 5G технологид суурилсан газар тариалангийн шинэ технологийг хөгжүүлэх, түгээх төв болгон хөгжүүлэх боломжтой.

Сэлэнгэ аймгийн хувьд үр тарианы үйлдвэрлэл тэргүүлэх салбар хэвээр байх болно. 1 га талбайгаас хураасан ургацын хэмжээгээр улсдаа тэргүүлдэг ч дэлхийн дунджаас хамаагүй доогуур үзүүлэлттэй байна. 1 га талбайгаас хураах ургацыг нэмэгдүүлэх асар их боломж байна. Орхон, Сэлэнгэ голын усыг усалгаатай газар тариаланд ашиглахдаа усыг хэмнэх, нэмүү өртөг шингэсэн хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжих хэрэгтэй. 1 га талбайгаас хураах ургацын хэмжээг нэмэгдүүлж, улмаар газар тариалангийн үйлдвэрлэл, хадгалалт, боловсруулалтын иж бүрэн системийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Зөгийн аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлэх нь ач холбогдолтой. Орхон гол, Сэлэнгэ мөрөнтэй нийлэн дэлхийн хамгийн цэнгэг нуур болох Байгаль нуурт цутгадаг, дээрх голын сав газруудад ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын өв ихтэй зэргээс үзэхэд усжуулалтын системийг зүй зохистой хэрэглэх болон усны чанарын менежмент маш чухал. Мөн суурин газруудын саарал усны хэрэглээг дэмжих хэрэгтэй. Хүлэмжийн аж ахуйг мэдээлэл, харилцаа холбооны технологи болон гидропоник технологитой хослуулан ашиглаж болно.

Байгаль хамгааллын талаас нь авч үзвэл дээрх хоёр голын усыг усалгаатай газар тариаланд ашиглах нь тийм зөв санаа биш юм. Үр тарианы үйлдвэрлэлийг сайжруулахад усалгаанаас илүү бордоо чухал юм.

Цахилгаан эрчим хүчийг усны эрчим хүчээр үйлдвэрлэхдээ байгаль орчны нөлөөллийг сайтар нягталж үзэх шаардлагатай.

Сэлэнгэ аймгийн газар тариалан эрхлэгчид болон малчдын хооронд бэлчээрийн маргаан үүсдэг учраас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг дэмжих нь зүйтэй. Гахай, тахианы аж ахуйг Улаанбаатар болон бусад хот, суурин газрын хэрэглэгчдийн махны хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх боломжтой.

Аялал жуулчлал нь маш ирээдүйтэй салбар тул бүс нутгийн хэмжээнд төлөвлөх нь зүйтэй. Орон нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, жуулчдыг нутгийн өв соёл, зан заншилтай танилцуулах аялалын маршрутыг ОХУ-ын Буриад улс, Байгаль нуур руу аялах аялалтай хослуулан хөгжүүлэх боломжтой (Японоос ОХУ зүүн хэсгээр Европ руу аялуулдагтай ижил). Жуулчид Улаанбаатар хотоос галт тэргээр зорчин шууд Иркутск хотод хүрэх бус Сэлэнгэ аймагт саатан гэрт хонох, морь унах, загас барих, шувуу ажиглах зэрэг Азийн өвөрмөц соёлтой танилцахын зэрэгцээ ОХУ-ын Буриадын түүх, Байгаль нуурын байгалийн үзэсгэлэнг бишрэн аялах боломжтой. Сэлэнгэ аймаг энэхүү боломжийг харгалзан дэд бүтцийг сайжруулж, аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа нь ихээхэн сайшаалтай юм. Улирлын чанартай аялал жуулчлалын салбарыг жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулдаг болгох зорилгоор Ерөө сумын халуун рашааныг түшиглэн өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, зөвхөн бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн худалдаа арилжаанаас гадна ОХУ-тай шинэ технологи, мэдээллийн салбарт хамтран ажиллах нь чухал. Энэхүү чөлөөт бүс нь шинэ боломжуудыг нээж өгөх нь гарцаагүй бөгөөд Монгол, Буриад улсын байгалийн нөхцөл байдал, соёлын харилцан шүтэлцээг жуулчдад таниулах боломжийг бүрдүүлнэ. ОХУ-ын технологийн ололтыг Монгол Улсад нутагшуулан,

мал аж ахуйн гаралтай шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ технологи хөгжүүлэхэд тустай. Энэхүү чөлөөт бүс нь Монгол Улс, ОХУ-ын харилцааны түүх, соёлтой биечлэн танилцах, жуулчдын танин мэдэхүйд чухал үүрэгтэй.

ЖДҮ нь Сэлэнгэ аймгийн эдийн засагт чухал үүрэгтэй бөгөөд ялангуяа, газар тариалангаас бусад үйлдвэрлэлийн салбарт компаниуд хоршин, хамтран ажиллах нь чухал. Зөв бодлого, дүрэм журмын хүрээнд газар тариалангийн жижиг аж ахуйнууд үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, томоохон компани болж өсөн дэвжих зэрэг асуудлыг зохицуулна. ЖДҮ-гийн үйл ажиллагаа идэвхжсэнээр дээд боловсролын чанар, МСҮТ-ийн үйл ажиллагаа сайжрах боломжтой.

### 7.3.6 Дархан-Уул аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал


##### Газар зүйн нөхцөл байдал


Дархан-Уул аймаг нь 3,280 км<sup>2</sup> газар нутагтай бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ Орхон аймгийн (840 км<sup>2</sup>) дараа 2-т ордог. 1994 онд Дархан-Уул аймгийг Сэлэнгэ аймгийн зарим сумдтай нийлүүлж байгуулжээ.

Аймгийн зүүн хэсгээрээ далайн түвшнээс дээш 800-1,300 метрт өргөгдсөн уулсаар хүрээлэгдсэн байдаг бол баруун хэсгээрээ 600-1,000 метрт Орхон голын сав, Хараа голын сав дагуу оршдог. Хараа голын ус цуглуулах талбай нь 15,000 км<sup>2</sup>, голын дундаж урсац 8 м<sup>3</sup>/сек, хамгийн их үедээ 99.3 м<sup>3</sup>/сек байдаг.

Тус аймагт тал хээрийн бүсийн уур амьсгал зонхилдог ба үр тариа тариалахад тохиромжтой, үржил шимтэй хар шороон хөрстэй.

**Зураг 7.3.6 Дархан-Уул аймгийн байршил**





Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

Дархан-Уул аймгийн хүн ам нь 1995-2000 онд жилд дунджаар 0.7%-иар буурсан бол 2005-2010 онд тогтмол байсныг эс тооцвол 1990-2017 оны хооронд жилд дунджаар 0.9%-иар өссөн байна. 2010 оноос хүн ам эрчимтэйгээр өсөж байгаа буюу 2010-2015 онд жилд 1.5%-иар, 2016, 2017 онд тус тус 2.1%-иар өссөн байна. 1995-2005 онд хүн амын өсөлт жилд дунджаар 0.9-1.2%, 2010-2017 онд хүн амын өсөлт жилд дунджаар 1.5-2.1% өссөнийг харахад хүн амын өсөлтөд ердийн цэвэр өсөлт (төрөлт – нас баралт) нөлөөлжээ.

2005-2014 оны хооронд аймгаас шилжин явагсдын тоо нэмэгдсэн бол 2016-2017 оны хооронд 300 орчим хүн Дархан-Уул аймагт шилжин суурьшсан. 2019 оны 3-р сарын 15-нд зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр энэхүү асуудлыг хөндсөн бөгөөд малчид бэлчээрийн хомсдол, цөлжилт, уул уурхайн олборлолт, амьдрах орчин тааруу зэргээс шалтгаалан ажлын байртай, эмнэлэг сургуулийн үйлчилгээ сайтай хот, суурин газар руу тэмүүлэх нь гол шалтгаан болсоныг дурдсан. Улаанбаатар хотод амьдрахад амьдралын өртөг өндөр учраас орон нутгийн иргэд Дархан хотод суурьшиж байна.

Дархан-Уул аймгийн ДНБ-ны 49%-ийг аж үйлдвэр, 43%-ийг үйлчилгээ, 8%-ийг хөдөө аж ахуйн салбар тус тус эзэлж байна. Дархан-Уул аймгийн төв Дархан хот нь Монгол Улсын 2 дахь том аж үйлдвэрийн бааз хот бөгөөд цемент болон бусад барилгын материал, төмөр, ган, нэхий, арьс ширний болон хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зарим бүтээгдэхүүнийг экспортолдог байсан. 1990-ээд онд ардчилсан нийгэмд шилжсэний дараа үйлдвэрүүд хувьчлагдаж, үйл ажиллагаа нь зогссон. Үүний үр дүнд ажиллагсад ажлын байргүй болсноос гадна мэдлэг боловсролтой, ур чадвартай хүний нөөцгүй болсон. Улмаар 2017 онд Дархан-Уул аймгийг аж үйлдвэрийн салбарын хөгжлөөр улсад 6-р байранд ороход хүргэсэн.

Гэвч зах зээлийн чөлөөт эдийн засагт бүрэн шилжээгүйн улмаас бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ буурч байгаа бөгөөд жижиг, дунд аж үйлдвэрлэл хангалттай өсөж дэвжиж чадахгүй байгаа талаар хэлэлцүүлэгт оролцогчид дурдаж байсан.

Дархан-Уул аймаг нь Сэлэнгэ аймгийн адилаар цаг уурын нөхцөл, ус хангамж сайтай учир газар тариалан түлхүү эрхэлдэг. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийн 6.8%-ийг тариалангийн талбай нь эзэлдэг бөгөөд энэ нь Сэлэнгэ

(5.1%), Орхон (3.3%) аймгийг эс тооцвол газар нутгийнх нь дөнгөж 0%-0.4%-ийг тариалангийн талбай эзэлдэг бусад аймгуудаас хамаагүй өндөр хувь юм. Гэвч Сэлэнгэ аймгийн адилаар тариалсан тариа буудай нь үнэд хүрдэггүй учир ДНБ-д оруулж байгаа хувь нэмэр нь бага байдаг.

Малын тооны хувьд нэг хүнд ногдох малын тоо 3 байдаг үзүүлэлтээрээ аймгуудаас 20-рт жагсдаг бөгөөд Улаанбаатар, Орхон хотуудын удаах байранд ордог.

### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Дархан-Уул аймгийн хотжилтын түвшин нь 1995-2005 онд 78.5%-иас 79.3% хүртэл өссөн бөгөөд энэ нь 2010 онд 82.4% болж өссөн. Харин 2017 он хүртэл бараг өөрчлөгдөөгүй бөгөөд тус түвшин 82.3% болжээ.

Дархан-Уул аймаг нь Төвийн бүсийн хойд хэсэгт зам харилцаанд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Улаанбаатар-Дарханы А0401 авто зам, үргэлжлүүлэн А0402 авто зам болж нутгийн хойд хэсэгт байрлах Сүхбаатар хот, Сэлэнгэ аймагтай холбогддог. Дархан-Эрдэнэтийн А1102 улсын чанартай зам нь цаашаа А1002 авто зам болж баруун зүгт Булган аймагтай холбогддог бөгөөд хойд талын хоёр том хотыг холбодог байна. Улаанбаатар хотоор дамжин ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам нь мөн л энэ аймгаар дамждаг байна.

Дархан-Уул аймаг нь 2015-2017 онд барилга дэд бүтцийн засвар үйлчилгээнд сайтар анхаарч 175 тэрбум төгрөгийн зарцуулалт хийсэн нь Улаанбаатар, Өмнөговь аймгийн дараа орсон байв. Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчдын хэлснээр энэ зардал нь барилгын дээвэр засвар, хүрээлэн буй орчны тохижилт, хүүхдийн тоглоомын талбай, гэрэлтүүлэг, зам, цэцэрлэг сургууль, дулааны шугам, эмнэлэг барьж байгуулахад зарцуулагджээ.

2017-н онд 1000-н хүн тутамд 35-н суурин телефон утас ногдох ба бүх аймгуудыг тэргүүлсэн байна. Нэг уст цэгээр үйлчлүүлэгчдийн тоо нь 1820 байж, улсад 15-рт жагссан.

### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Аймгийн баруун хилээр урсдаг Хараа гол нь Дархан-Уул аймгийн байгаль орчинд чухал нөлөөтэй. Гэвч арьс ширний үйлдвэрүүд, алтны уурхайн бохир усыг Хараа гол болон жижиг голуудад нийлүүлдэг, хотын ариутгах татуургын хэрэглээнээс гарсан бохир ус, жуулчид болон үйлдвэрүүдийн хог хаягдал зэргээс болж Хараа голын экосистемд аюул учирч байна.

Нийгмийн салбарт хүний нөөц, тоног төхөөрөмж, менежментийн олон асуудал тулгарч байна. Эрүүл мэндийн салбараар жишээ авахад эмч, сувилагч зэрэг мэргэжлийн боловсон хүчин хомсдолтойгоос гадна ажилчдын техник технологийн мэдлэг муу, харилцаа болон ёс суртахууны доголдолтой. Мөн ард иргэдийн эрүүл бус хооллолт, хэт таргалалт зэрэг нь эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлдөг. Тоног төхөөрөмжийн хувьд хугацаа нь хэтэрсэн төхөөрөмжүүд болон шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж дутмаг. Удирдлага зохион байгуулалтын хувьд авилга хээл хахууль, хүнд сурталтай эмч нар, улс төрийн сөрөг нөлөөлөл зэрэг нь хүндрэл учруулдаг.

Техник технологийн мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийн гол түлхүүр болдог. Харамсалтай нь Дархан-Уул аймагт байдал тийм биш байна. МСҮТ-д суралцагчдын тоо 2010 онд 2,449 байснаас 2017 онд 1,957

болж 20%-иар буурсан нь оюутны тэтгэмж болох 70,000 төгрөгийг зогсоосон, мөн залуучуудын МСҮТ-д мэргэжил эзэмшихээс илүү их дээд сургуулиудыг сонгон суралцаж байгаатай холбоотой. Дарханы МСҮТ-ийн боловсролын чанар нь иргэдийн хүлээлтэнд нийцэхгүй байгаа бөгөөд сургуулийн багш нарын техникийн хангалтгүй мэдлэг, хуучирсан төхөөрөмжүүд, сургалтын хөтөлбөр, агуулга бодит хэрэгцээнд нийцээгүйгээс төгсөгчид нь мэргэжлээрээ ажиллаж чадахгүй байна.

Ядуурал нь аймгийн хөгжлийг доош татаж байгаа нийгмийн асуудал болж, мөн ажилгүйдлыг дагаж хар тамхины хэрэглээ, биеэ үнэлэлт, дээрэм, малын хулгай, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг гэмт хэргийн бүртгэлүүд олширч байна.

Дархан хот өмнө нь аж үйлдвэрийн салбараар Монгол Улсад Орхон аймгийн дараа ордог байсан. Социализмын үед байсан аж үйлдвэрийн бүтцийг зах зээлийн үеийн эдийн засгийн нөхцөлд багахан хэмжээгээр өөрчилж чадсан боловч 2017 онд Дархан-Уул аймаг нь аж үйлдвэрийн салбарын хөгжлөөр улсад 6-р байранд орох болсон. Ажиллах хүчний нөөц, хөрөнгө мөнгөний боломж, хууль дүрмүүдтэй холбоотой асуудлууд нь аймагт аж үйлдвэрийн салбар хөгжихөд саад болж байна. Ажиллах хүчний харьцангуй өндөр боломжтой боловч ажиллах хүчний өөрсдийнх нь оролцооны түвшин бага байгаа нь боловсон хүчний дутагдалд хүргэж байна. Туршлагатай менежерүүд болон чадварлаг ажиллах хүчин бага байгаа нь боловсон хүчний чанарын асуудлыг үүсгэдэг. Ихэнхи байгууллагууд нь түүхий эдийн үнийн өсөлт, бүтээгдэхүүний ханш уналт зэрэг эдийн засгийн асуудлуудтайгаа зохицож ажиллаж чаддаггүй. Зээлийн хүү өндөр учир зээлэнд хамрагдах боломж хязгаарлагдмал. Улс төрийн тогтворгүй байдал нь аж үйлдвэрлэл тууштай, тулхтай хөгжихөд хүндрэл учруулж байна.

Газар тариалан эрхлэхэд маш тохиромжтой байгаль цаг уурын нөхцөлтэй боловч импортын бүтээгдэхүүнүүдтэй өрсөлдөх өрсөлдөөн, тогтвортой бодлого, дэмжлэг сайн хөгжиж чадахгүй байна.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Дархан-Уул аймаг нь газар тариалангийн салбартаа Сэлэнгэ аймагтай хамтран ажиллах хэрэгтэй, учир нь энэ хоёр аймаг газар зүйн байршлын хувьд хоорондоо хиллэдэг ба Орхон, Хараа голуудаас усны нөөцөө хангадаг. Усны хэмнэлттэй усжуулалтын системээр Хараа голын усыг ашигласнаар жимс ногооны чанарыг сайжруулж хотын дэлгүүрүүдийг хангах боломжтой. Хараа гол нь Орхон гол, Сэлэнгэ мөрөнтэй нийлэн дэлхийн хамгийн цэнгэг нуур болох Байгаль нуурт цутгадаг, дээрх голын сав газруудад ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын өв ихтэй зэргээс үзэхэд усжуулалтын системийг зүй зохистой хэрэглэх болон усны чанарын менежмент маш чухал. Мөн суурин газруудын саарал усны хэрэглээг дэмжих шаардлагатай. Хүлэмжийн аж ахуйг мэдээлэл харилцаа холбооны технологи болон гидропоник технологитой хослуулан ашиглаж болно.

Байгаль хамгааллын талаас нь авч үзвэл Хараа голын усыг усалгаатай газар тариаланд ашиглах нь тийм зөв санаа биш юм. Үр тарианы ургацын хэмжээг дээшлүүлэхэд услалт гэхээсээ илүү бордолт чухал юм.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийг (ICT) Монголын мал аж ахуйд нэвтрүүлснээр уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа орчин үеийн эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэх юм. Үүнийг Монголд анх удаа Дарханд турших боломжтой бөгөөд энэ технологийг нэвтрүүлснээр малчдад хотын тав тухтай амьдралаар хөдөө амьдрах боломжийг олгох юм.

Ардчилсан нийгэмд шилжсэний дараа үйл ажиллагаа нь зогссон тэдгээр үйлдвэрүүдийн барилга байгууламж, дэд бүтэц нь Дархан хотын үйлдвэрлэлийг цаашид хөгжүүлэхэд ашиглах чухал хөрөнгө юм. Үйлдвэрүүдийн эзэмшилд байсан их хэмжээний газрыг банк санхүүгийн байгууллагын барьцаанд байршуулсан байна. Тэдгээрийг үйлдвэрийн зориулалтаар ашиглах үүднээс эхний ээлжинд газар дээр нь ажиллаж, одоогийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх хэрэгтэй. Дархан хотод аж үйлдвэрийн паркийг дахин байгуулж, үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэхийн тулд үйл ажиллагаа явуулахгүй байгаа зарим үйлдвэрүүдийг сэргээн засварлах шаардлагатай. Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг боловсруулахдаа газар зохион байгуулалтын арга хэмжээг сайтар харгалзан үзэх нь зүйтэй юм. Түүнчлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дэд бүтцийг шинэчлэн сайжруулах, сурталчлан таниулах бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.

Дархан-Уул аймгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд Дарханы аж үйлдвэрийн давуу тал, монголчуудын өндөр боловсрол, оюуны чадамжийг ашиглах нь чухал. 'Internet of Things' буюу зүйлсийн интернет нь дэлхийн дахины шинэ хандлага бөгөөд үүнийг Монголд нутагшуулах боломжтой. Монгол Улс шиг өргөн уудам газар нутагтай, хүн ам нь тархан суурьшдаг учраас энэ аргын давуу талыг ашиглах хэрэгтэй. Одоо ажиллаж байгаа төмөрлөг, цемент, арьс ширний болон хүнсний үйлдвэрүүдэд мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглан аппликэшн суурилуулан автоматжуулж болох юм. Дархан-Уул аймагт энэ технологийн суурийг тавиад улмаар Улаанбаатар хотод олон улсын дэвшилтэт зүйлсийн интернетийн технологийг танилцуулж нэвтрүүлэх боломжтой.

Мэдээлэл харилцаа холбооны технологи нь Монгол Улсын нийгмийн салбар дах эрүүл мэнд, боловсролын салбарын чанарыг дээшлүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж чадна. Дархан хот нь энэхүү технологийг Улаанбаатар хот болон бусад хот суурингуудад хүргэхэд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж болно. Жишээ нь Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн хөдөө амьдардаг хүн заавал аймгийн төв руу очиж эмнэлэгт үзүүлэлгүйгээр оношоо тодорхойлуулж авч болно гэсэн үг. Малчдын хүүхдүүд төв газар руу эцэг эхээсээ хол дотуур байранд байрлан суралцахгүйгээр гэртээ интернет ашиглан хичээл үзэж болно. Улаанбаатар хотод гадаад орнуудын дэвшилтэт технологийг танилцуулж байхад эхний алхамуудыг Дарханд бодит амьдрал дээр хэрэгжүүлж болно гэсэн үг.

Мэдээлэл харилцаа холбооны технологи, хиймэл оюун ухаан, 5G зэрэг технологиудыг боловсролын системийн шинэчлэлд ашиглаж болно. Их сургуулиуд онол, суурь зарчмыг заадаг байхад, мэргэжлийн сургууль МСҮТ нь илүү ур чадвар, практик дээр суурилсан гэх мэт хичээлийн агуулгыг өөрчлөхдөө ялгааг нь сайн тусгаж өгөх шаардлагатай.

Орон нутгийн бие даасан байдлыг дэмжих бодлогыг Монгол улсын Засгийн газраас батлах ч, Дархан-Уул аймаг уриалан санаачилж, эхлүүлж болно. Хотын статустай болсноор шийдвэр гаргах, бие даан төсөв бүрдүүлэхэд илүү эрх мэдэлтэй болж, орон нутгийн хүн амын хэрэгцээ, хүсэл шаардлага нь хөгжлийн төлөвлөлтөд илүү тусгагдана. Ингэснээр оршин суугчдын дэмжлэгтэйгээр хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх боломжтой болох бөгөөд Улаанбаатар хотын улс төрийн нөлөөллийг бууруулна. Энэхүү санаачлага нь залуу үеийнхний шинээр бизнес эрхлэх сэдлийг идэвхжүүлнэ. Дархан-Уул аймаг хэт төвлөрсөн эрх мэдэл, хяналтыг сааруулах хөгжлийн загварыг боловсруулж болно.





### 7.3.7 Орхон аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал

##### Газар зүйн нөхцөл байдал

Орхон аймаг нь хамгийн бага газар нутагтай (840 км<sup>2</sup>) боловч хүн амын нягтрал хамгийн ихтэй аймаг юм. Аймгийн төв нь Эрдэнэт хот бөгөөд Улаанбаатар хотоос 371 км зайд оршино. Орхон аймаг нь ойт хээрийн бүсэд Хангай нурууны салбар уулс, Бүрэнгийн нурууны өвөрт Орхон, Сэлэнгэ голын сав газарт, тал хээр, уулын цөлөрхөг хээр ба карбонаттай хөрстэй.

Зураг 7.3.7 Орхон аймгийн байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (БОАЖЯ-ны зургийг ашиглав).

##### Нийгэм, эдийн засаг

Орхон аймгийн хүн ам нь 2017 онд 104,000 байсан бөгөөд хүн амын нягтрал нь

130/км<sup>2</sup>. 1990-2000 онд хүн ам нь жилд дунджаар 2.44% өссөн бол 2000-2015 онд 2.21% болсон бөгөөд дийлэнх иргэд Эрдэнэт хотод шилжин ирсэн.

Аж үйлдвэрийн салбар тэр дундаа уул уурхай, боловсруулах болон барилгын үйлдвэрлэл эдийн засгийн голлох салбар бөгөөд 2017 онд БДНБ-ий 89%-ийг эзэлсэн. Зэс, молибден зэрэг ашигт малтмалын нөөц ихтэй. Орос-Монголын хамтарсан Эрдэнэт үйлдвэр нь зэс, молибдений боловсруулах үйлдвэр бөгөөд аймгийн эдийн засагт онцгой үүрэгтэй. Мөн Эрдэнэт үйлдвэр нь хивс, хүнс болон ундааны, металл боловсруулах зэрэг салбар үйлдвэрүүдтэй.

Газар тариалан болон МАА-н салбар БДНБ-ий дөнгөж 1%-ийг бүрдүүлдэг. Нэг малтай өрхөд ногдох малын тоо 139, нийт малын тоо 47,000 бөгөөд бусад аймгуудаас хамгийн бага үзүүлэлттэй. 2017 онд МАА эрхлэлт нийт ажил эрхлэлтийн 4.3% байсан. Үр тарианы талбай хязгаарлагдмал, 2017 оны байдлаар 2,603 га тариалангийн талбайтай.

Бусад аймгуудтай харьцуулахад Орхон аймгийн эдийн засгийн нөхцөл байдал сайн. Дээр өгүүлсэнчлэн уул уурхайн үйл ажиллагаа зонхилж байгаа учраас нэг хүнд ногдох БДНБ нь улсад тэргүүн байрт жагсдаг. Үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллага 2,308, түүнээс хувийн хэвшил 2,181 байгаа нь улсад тэргүүн байрт жагссан хэдий ч эдийн засгийн чухал үзүүлэлтүүд эрс зөрүүтэй байна. Тухайлбал ажилгүйдлийн түвшин өндөр (2017 онд 23.5% ), орлогын тэгш бус байдал байсаар байна. Орхон аймагт уул уурхай чиглэлээр 6000 гаруй ажлын байр байдаг ч бусад салбарын ажил эрхлэлтийн байдал туйлын хангалтгүй байна.

Бага, дунд сургуульд хамрагдалт 100% хол давсан үзүүлэлттэй, улсад тэргүүлж байна. ЕБС-ийн тоо харьцангуй цөөн буюу 2017 онд 24 сургуультай, улсад 15-р байрт жагссан. Хэлэлцүүлэгт оролцогчид цэцэрлэг, бага сургуулийн хүрэлцээ муу гэдгийг онцолж байсан.

Нялхсын эндэгдэлийн түвшин 1,000 төрөлтөд 5, улсад хамгийн бага үзүүлэлттэй. Эрүүл мэндийн салбарын ажилтан, сувилагчийн тоогоор харьцангуй өндөр байна.

Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид гаднаас шилжин ирэгсдийн тоо өндөр учраас эрүүл мэндийн ажилчид хүрэлцэхгүй, эрүүл мэндийн үйлчилгээний чанар сайн учраас гаднаас шилжин ирэгсдийн тоо ч буурахгүй байна гэж ярьж байсан.

Соёлын барилга байгууламж дутагдалтай, аймгийн хэмжээнд 5 соёлын төв байдаг бөгөөд улсын хэмжээнд 19-р байрт жагсаж байна. Мөн нийтийн 5 номын сан л аймгийн хэмжээнд ажиллаж байна.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Орхон аймгийн хэмжээнд хотжилтын түвшин 2017 онд 96.2% байгаа нь харьцангуй бага газар нутагтай холбоотой. Улаанбаатар-Эрдэнэт хооронд авто замтай, зам харилцаа сайн. Аймгийн төв Эрдэнэт хот нь Дархан, Мөрөн хоёрын дунд оршдог. Транс-Монголын төмөр замаас салбарласан төмөр замтай, голдуу уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ руу экспортолдог. Мөн долоо хоногт нэг удаа ОХУ-аас олон улсын галт тэрэг дайран өнгөрдөг.

Эрдэнэт хотын инженерийн үндсэн дэд бүтцийн хөгжил нь харьцангуй сайн, суурь бааз сайтай. Гэхдээ хөдөө орон нутагт ус хангамж, усны чанарын асуудал их яригдаж байна.

2017 онд 1,000 хүнд ногдох телефон утасны шугам 17 (4-р байр), дулааны эрчим хүчний үнэ 553 төг/м<sup>2</sup> (15-р байр), шатахууны үнэ 1,498 төг/л (3-р байр) байсан.

Мөн 1,000 өрхөд ногдох уст цэгийн тоо 6 (4-р байр), цахилгааны эх үүсгүүртэй малчин өрх 91.5% (1-р байр) байсан.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Уул уурхайн салбар ялангуяа уурхайн ажилчид, тэдний гэр бүлийн бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалж нэг хүнд ногдох БДНБ, хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлт өндөр гарч байна. Орхон аймагт уул уурхайгаас бусад салбарын ажлын байр хомс байгаагаас болж ажилгүйдлийн түвшин өндөр, орлогын тэгш бус байдал байсаар байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо хамгийн их байгаа нь ч энэхүү эдийн засгийн тэгш бус байдалтай холбоотой байж магадгүй.

Хэлэлцүүлэгт оролцогчдыг 4 бүлэгт хуваасан бөгөөд оролцогчид гэр хорооллын төлөвлөлтгүй тэлэлт нь агаарын бохирдол, цагаан тоос, гал түймэр, хөрсний бохирдолд нөлөөлж байгааг онцолсон.

Уул уурхай хэт давамгайлсан эдийн засаг нь бусад салбарын тэнцвэртэй хөгжихөд саад болж байна. Газар нутаг багатай аймгийн хувьд газар тариалан, уламжлалт бэлчээрийн мал аж ахуй хөгжүүлэх боломж муу байна.

Нийгмийн хөгжлийн салбарт, гэр хороололд цэцэрлэг, сургуулийн хүртээмж муу, багш нарын тоо бага байгаа нь асуудал үүсгэж байгааг хэлэлцүүлэгт оролцогчид онцолсон.

Мөн ЖДҮ-ийг хөгжүүлэхэд банкны хүү хэт өндөр байна. Аймгийн засаг захиргаа хурдацтай өсч буй хүн амын хэрэгцээнд шаардлагатай нийгмийн үйлчилгээ үзүүлэх, ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж чадахгүй байгааг иргэд онцолж байсан.

## **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Монгол Улсын газрын нэгдмэл санд Төвийн бүсийн хойд хэсэг, Орхон аймгийн газар нутгийг оролцуулан газар тариалан, мал аж ахуйн өндөр ашиг шимтэй бэлчээр, үр тариа, атар газар зэрэг нь хадлан тэжээл, усны хангамжид онцгой ач холбогдолтой газар нутаг гэж тодорхойлсон байдаг. Газар нутгийн хэмжээ бага учраас эрчимжсэн мал аж ахуйг хадлан тэжээлийн үйлдвэрлэлтэй хослуулж үйлдвэрлэл явуулах боломжтой. Хүлэмжийн аж ахуйг дэмжиж туршлагатай боловсон хүчин болон хуучин барилга байгууламжийг ашиглан хөгжүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Улаанбаатар, Эрдэнэт, Дарханы зах зээлд гаргах боломжтой.

Орхон аймаг ялангуяа Эрдэнэт хот нь хүн амын төвлөрөл, мэргэжилтэй боловсон хүчин, дэд бүтэц, ашигт малтмал, зам харилцааны өндөр боломжоо ашиглан Монгол Улсын аж үйлдвэр, боловсруулах үйлдвэрийн төв болж болно. Хэдийгээр ашигт малтмалын нөөц үлдэгдэл байгаа ч аж үйлдвэрийн салбарыг төрөлжүүлж ажлын байр олноор нэмэгдүүлж, эдийн засгийн тэгш бус байдлыг багасгах шаардлагатай. Зэс молибден боловсруулах технологийг сайжруулснаар металлын үйлдвэрлэлийг дэмжих, мөн арьс шир, хүнс болон бусад хөнгөн үйлдвэрлэлийн хөгжүүлэлтийг ч дэмжих шаардлагатай байна.

Эрдэнэт хотын зохион байгуулалт, хөгжил нь олон монгол залуучуудыг ирж амьдрах сонирхлыг төрүүлж байна. Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид худалдааны салбарын хөгжил, хүн амын өсөлт, бизнесийн таатай орчин нь хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байсан. Эрдэнэт хот нь нийслэл хот болон ОХУ-ын дунд оршдог, дамжин өнгөрөх хот учраас олон ажил үйлчилгээг нэмэгдүүлэх боломжтой. Энэ утгаараа Эрдэнэт хот нь Монгол Улсын эдийн

засгийн хөгжилд том үүрэг гүйцэтгэх хүний нөөц, бараа, мөнгө, мэдлэгийн уурхай болсон хот болох боломжтой.

Хөвсгөл, Улаанбаатар, ОХУ-ын уулзвар дээр орших транзит хот гэдэг нь аялал жуулчлал хөгжилд чухал ач холбогдолтой байдаг.

Дунд болон урт хугацаанд Орхон аймгийн орос соёлын нөлөөтэй онцлог ахуйн соёл болон уурхайд түшиглэсэн аялал жуулчлалыг ногоон хот төлөвлөлтийн бодлоготой холбон хөгжүүлэх боломж бий. Орхон аймгийн Медипас эмнэлэг нь бүсийн хэмжээний, харьцангуй өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон нь эхийн болон нялхсын эндэгдлийг бууруулахад чухал нөлөөтэй. Эрүүл мэндийн аялал жуулчлал нь Орхон аймгийн хувьд ирээдүйн эрүүл мэндийн салбарын нэгэн боломж байж болно.

Эрдэнэт хивсний үйлдвэр нь өндөр чанартай бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой. Эрчимжүүлсэн мал аж ахуйн түүхий эдийн нийлүүлэлтийг сайжруулах ялангуяа, боловсруулаагүй ноосны чанарт хяналт тавих шаардлагатай. Брэнд бүтээгдэхүүн бий болгох нь экспортын зах зээлийг өргөжүүлэхэд түлхэц нь байх ёстой.

Хот, хөдөөд ус хангамжийн системийг сайжруулахын зэрэгцээ усны чанарыг давхар сайжруулах системийг бий болгох шаардлагатай. Энэ асуудлыг нь Эрдэнэт хотыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулахдаа гэр хорооллын амьдрах орчныг сайжруулахад чухалчлан анхаарч үзэх хэрэгтэй. Эрдэнэт хотыг ирээдүйд Монгол Улсын хамгийн их ногоон байгууламжтай, амьдрахад таатай загвар хот бөгөөд мөн нөхөн сэргээх ажлыг амжилттай гүйцэтгэсэн үлгэр жишээ, хариуцлагатай уул уурхай бүхий ирээдүйд жуулчдыг татсан хот болгохыг зорих хэрэгтэй.

## **7.4 Алтайн бүсийн аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ**

### **7.4.1 Говь-Алтай аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**

##### Газар зүйн нөхцөл байдал

Говь-Алтай аймаг нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт БНХАУ-ын ӨМӨЗО-той хиллэн оршдог ба 141,400 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэрийн хэмжээгээр Өмнөговь аймгийн дараа 2-р байранд ордог. Аймгийн төв Алтай хот нь Улаанбаатар хотоос 1,027 км зайд оршдог. Алтай хот нь Ховд хоттой А304 авто замаар, Завхан аймгийн Улиастай хоттой А1103 авто замаар, Баянхонгор хоттой А303 авто замаар, Бургастай-Лаомяо хилийн боомттой А1104 авто замаар тус тус холбогддог.


Монгол Алтайн нуруу баруунаас зүүн тийш сунаж, зарим уулсын оргил нь далайн түвшнээс 4000м орчим өндөрт аймгийн нутаг дэвсгэрийн дунд орших бөгөөд аймгийн нийт нутаг дэвсгэр гурван хэсэгт хуваагдана. Өндөр уулын, хуурай хээрийн бүсэд орших бөгөөд нутгийн урд хэсгээр говийн бүс үргэлжилнэ. Өндөр уулсын дунд 20 гаруй давст нуур тархан оршдог. Уур амьсгалын 3 мужлалд хуваагдах ба нутгийн хойд хэсэгт өндөр уулын хуурай уур амьсгал, уулсын бэл, тал хээр нутагт (1,600-2,000м) хуурай хээрийн бүс, өмнөд хэсэгт дулаан, цөлөрхөг говь хээрийн уур амьсгал зонхилно.

Завхан гол нь аймгийн хойд захаар урсаж Увс аймгийн Хяргас нуурт цутгана.



Байгалийн унаган төрхөө хэвээр хадгалж үлдсэн говь цөлийн өвөрмөц экосистем бүхий Их говийн дархан цаазат газар (44,000 км<sup>2</sup>) зэрэг тусгай хамгаалалттай газар нутаг ихтэй, дэлхийд дөрөвдүгээрт ордог биосферийн нөөцтэй газар юм. Аймгийн нутагт дэлхийд нэн ховордсон мазаалай, хавтгай, хулан, ирвэс зэрэг олон амьтад амьдардаг.

**Зураг 7.4.1 Говь-Алтай аймгийн байршил**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

Говь-Алтай аймгийн хүн ам 2017 онд 57,500, хүн амын нягтрал 0.41/км<sup>2</sup> байв. Аймгийн хүн ам 1990 онд 64,700 байсан бол 2000 онд 53,500 болж багагүй буурсан байна. Түүнээс хойш бага багаар өсч 2017 онд 57,500-д хүрснийг иргэд ажлын байрны хомсдол, зудын хохирлоос болж хот, суурин газар руу нүүсэн боловч нийгмийн халамжийн бодлогын нөлөө, дэд бүтэц болон бизнесийн орчин сайжирснаар буцаж ирсэн гэж тайлбарлаж байсан.

Говь-Алтай аймгийг малын тоо толгойг өсгөхөд хамгийн тохиромжгүй аймаг гэж үздэг. Тиймээс 100 га бэлчээрийн нутагт ногдох малын тоо 57 байсан нь улсын хэмжээнд 18-р байранд, нэг малчин өрхөд ногдох малын тоо 529 байсан нь улсын хэмжээнд 3-р байранд жагсжээ. Нийт хүн амын 49.9% нь малчид байна.

Аймгийн эдийн засгийн голлох салбар хөдөө аж ахуй бөгөөд 2017 онд энэ салбар БДНБ-ий 47%, барилгын салбар 23%, үйлчилгээний салбар 31% -ийг эзэлсэн байна. Аж үйлдвэрийн салбарын борлуулалт бага 7.5 тэрбум (17-р байрт), БДНБ-д 2.81% (15-р байрт)-ийг эзэлж байна. Хүнс, арьс шир, барилгын материал нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг төлөөлж байна. Аж ахуйн нэгж байгууллагын тоо харьцангуй цөөн 838 (18-р байр), үүнээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага 641 (18-р байрт), томоохон аж ахуйн нэгж байгууллага 32 (13-р байрт) байна.

Хэдийгээр хөдөө аж ахуйн салбар түлхүү хөгжсөн боловч нэг хүнд ногдох БДНБ, дундаж цалин харьцангуй өндөр байна. Үүний шалтгааныг аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид ноолуурын үйлдвэрлэлийн өсөлт болон Цээл суманд явуулж буй төмрийн хүдрийн үйл ажиллагаатай холбон тайлбарлаж байсан.

Говь-Алтай аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин нь 2017 онд улсын түвшнээс доогуур буюу 63.9% байв. Энэ үзүүлэлтэнд иргэд өөр газар руу ажил эрхлэхээр шилжсэн мөн хөдөө аж ахуйд 75.3% нь ажиллаж байгаа зэрэг нь нөлөөлсөн. Нийт ажил эрхлэлтийн 16.7% нь төрийн албан хаагч (3-р байрт) -ын тоо өндөр байгаа шалтгааныг өргөн уудам газар нутагт нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй байлгах аар тайлбарлаж болно. Дундаж цалин, ажилгүйдлийн түвшингээр улсын хэмжээнд 11-р байранд жагссан байна.

Засгийн газраас явуулж буй нийгмийн халамжийн бодлогоор бага, дунд сургуулийн багш-сурагчийн харьцааны үзүүлэлтээр улсын хэмжээнд 2-р байрт жагссан байна. Нэг эмчид ногдох хүний тоо 305 (3-р байр), нэг сувилагчид ногдох хүний тоо 225 (1-р байр) байгаа ч 10,000 хүн тутамд ногдох халдварт өвчин 137 (19-р байр) байсан. Үүний шалтгааныг аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид тайлбарлахдаа усны чанар болон хатуулаг ихтэй уснаас болж өвчлөл ихсэж байгаагаар холбож байсан.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Говь-Алтай аймгийн хэмжээнд хотжилтын түвшин 2017 онд 32.5%-тай, харьцангуй өндөр үзүүлэлттэй байсан. Хэдийгээр аймгийн төв Алтай хот Ховд, Улиастай, Баянхонгор зэрэг зэргэлдээ аймгуудтай холбогдох зам харилцаа сайн болсон ч нутгийн өмнөд хэсгийн Алтай нурууны өндөр уулс, говийн нутгийн чиглэлийн авто зам сайн хөгжөөгүй байна.

Авто замын чанарын хувьд улсын хэмжээнд 17-р байранд жагссан. Говь-Алтай аймаг Улаанбаатар хотоос алслагдмал оршдог учраас дулааны үнэ (16-р байр), бензиний үнэ (17-р байр) өндөр байна. Цахилгаан үүсгүүртэй малчин өрх 86.5%-ийг (7-р байр) эзэлж байна. Хатуу хог хаягдлын менежмент тааруу, мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжлийн боломж муу бөгөөд улсын хэмжээнд 20-р байранд жагсаж байна.

Аймгийн нутгийн хойд хэсгээр дайран урсдаг Завхан гол дээр 2009 онд Австрийн засгийн газрын санхүүжилтээр Тайширын 11МВт хүчин чадалтай усан цахилгаан станц баригдсан. Нутгийн хойд хэсгээр газрын гүний ус ашигладаг бөгөөд уст давхарга 150-200м-н гүнд оршдог.



## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Цөөн хүн амтай, алслагдмал байдал нь мал аж ахуй болон бусад бараа бүтээгдэхүүний зах зээлд нөлөөлж байна. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ харьцангуй доогуур байна. Алслагдмал байдал нь бараа бүтээгдэхүүний үнэ, аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, амьдрах орчныг сайжруулахын тулд зарцуулах цахилгаан эрчим хүчний үнэ өндөр байгаад нөлөөлж байна. Газар тариалангийн талбай багатай, цаг уурын эрс тэс нөхцөл, хөрсний бүтцээс шалтгаалж газар тариалангийн салбар хөгжих нөхцөл муутай. Бэлчээрийн талхагдал, цөлжилтөөс шалтгаалж МАА эрхлэхэд хүндрэл тулгарч байна.

Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид хэдийгээр Тайширын усан цахилгаан станц ажиллаж байгаа ч цахилгаан эрчим хүч хүрэлцэхгүй байгааг онцолсон. Иргэд дулааны цахилгаан станц баригдах, халуун усны хангамж шаардлагатайг илэрхийлсэн.

Төрөөс нийгмийн халамжийн бодлого сайжирч байгаа ч авто замын сүлжээ сайн биш, ус хангамж, цахилгаан эрчим хүчний нийлүүлэлт төдийлөн хангалттай биш байна. Энэхүү нөхцөл байдал нь Говь-Алтай аймагт аж үйлдвэрийн төв байгуулах боломжгүйг харуулж байна. Жижиг, дунд үйлдвэрлэл ч сайн хөгжиж чадахгүй байна. Мөн ажилгүйдэл, ядуурал байсаар байна.

Аймгийн хэлэлцүүлгийн үеэр оролцогчид иргэдийн эрүүл мэндийн байдал, ажиллах хүчний хомсдол, бүсийн хөгжлийн сул бодлогыг онцолж байсан. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд төрийн зөв бодлого, улс төрийн тогтвортой байдал маш чухлыг онцолсон.

## **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Говь-Алтай аймгийн өргөн уудам нутаг дэвсгэр, цаг уурын байдал нь аймгийн хөгжилд давуу болон сул талыг үүсгэж байна. Хөгжлийн хоёр чиглэлийг сонгож болох юм. Үүний нэг нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломжтой. Тусгай хамгаалалттай өргөн уудам газар нутгийг ашиглан байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь зүйтэй. Монгол Алтайн нурууны үзэсгэлэнт байгаль бүхий 4,000 м өндөр уулсууд руу авирах, явган аялал хийх, түүх дурсгалын газруудад урт хугацаагаар саатах зэрэг боломж бий. Алтай хотын үйлчилгээний салбарыг сайжруулснаар жуулчдыг ялангуяа өндөр хөгжилтэй орны жуулчдыг мэдээлэл, харилцаа холбоо, технологийн дэвшлийг ашиглан жуулчны бааз, газруудтай холбож өгөх шаардлагатай.

Алтай хотын инженерийн дэд бүтэц, үйлчилгээний барилга байгууламжийг сайжруулах шаардлагатай. Энэ хотод аймгийн нийт иргэд үйлчлүүлэх боломжтой боловсрол, соёл, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. Боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг бэлтгэдэг сургалтын төвийг засгийн газраас явуулж буй нийгмийн халамжийн бодлого, нийгмийн үйлчилгээний бодлогын хүрээнд байгуулах шаардлагатай.

Хөгжлийн нөгөө чиглэл нь өргөн уудам газар нутаг, уур амьсгалын олон янзын бүсийг ашиглан “Сэргээгдэх эрчим хүчний төв” байгуулах юм. Говь-Алтай аймгийн хойд хэсэгт Завхан гол дээр усан цахилгаан станц барьсан бөгөөд нутгийн өмнөд хэсэгт нарны зайн эрчим хүчний байгууламж барьж байгуулж болох юм. Говийн бүсэд салхин тээрэм байгуулах боломжтой. Уулсын дунд газрын гүний дулааны ордыг илрүүлж газрын гүний дулааныг хуримтлуулж цахилгаан гаргах боломж бий. Аймгийн цахилгааны хэрэгцээг хангахуйц бага оврын газрын дулааныг ашигласан

цахилгаан станц барьж болох бөгөөд байгалийн халуун усыг хэрэглэж болно. Засгийн газрын тогтоолоор хайгуул хийж баталгаажуулсан газрын гүний дулааны энергийн нөөцөд түшиглэн үр ашигтай үйл ажиллагаатай, чадварлаг менежменттэй бүс нутгийн хэмжээний эрчим хүчний компанийг байгуулж болох юм.

Үр ашиг багатай мал аж ахуй болон үр тарианы ургац багатай газар тариалангийн салбарын бодлогыг зайлшгүй өөрчлөх шаардлагатай. Хагас эрчимжсэн мал аж ахуйг голлон дэмжиж малын тэжээлийн тариалалттай хослуулан хот, суурин газрын зах зээлд ойр байршуулж, улирлын сэлгээ хийж мал маллах нь зүйтэй. Малчид бэлчээрийн менежментдээ онцгой анхааран сүргийн бүтэц дэх ямааны тоо толгойд хяналт тавих, бэлчээрийн талхагдлаас урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай байна.

Говь-Алтай аймгийн хөрс, уур амьсгалын өөр өөр онцлогоос шалтгаалж газар тариалангийн төрөл зүйлийг олшруулах шаардлагатай. Гэхдээ зах зээлээс хэт алслагдмал байдал нь зарим нэгэн эмийн ургамлаас бусад төрлийн ургацын борлуулалтад чирэгдэл учруулах тул газар тариалангийн талбайн байршлыг сайн төлөвлөх шаардлагатай. Өвөл газар дор хагас байршуулсан хүлэмжийн аж ахуйг нэвтрүүлэн ажиллуулж болох юм. Өвлийн улиралд газрын гүний дулааныг хүлэмжинд ашиглах боломжтой гэж үзэж байгаа учраас хүйтний улиралд газар тариалан, мал аж ахуй эрхлэх цогц байгууламж байгуулах боломжийг судлах хэрэгтэй.

Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчдоос социализмын үед ажиллаж байсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний усалтын системийг сэргээх нь зүйтэй гэж санал тавьж байсан. Үр тарианы дотоодын зах зээл, усны эх үүсвэрийн боломжийг сайтар судлах шаардлагатай. Завхан голын усан цахилгаан станцын даланг цахилгаан үйлдвэрлэл, усжуулалт, ус хангамж зэрэг олон зориулалтаар ашиглах талаар төлөвлөх шаардлагатай.

Говь-Алтай аймгийн төв орчмын газрыг эс тооцвол нутгийн нийт газар нутаг уул уурхайн нөлөөлөл багатайд тооцогддог. Гэхдээ стратегийн чухал ач холбогдолтой уурхай байхгүй ч жижиг уурхайнууд олборлолт хийж байна. Нүүрс, алт, төмөр олборлож байгаа бөгөөд барилгын материалын цемент, тоосго үйлдвэрлэл хөгжих боломжтой.

## **7.4.2 Баянхонгор аймаг**

### **(1) Одоогийн нөхцөл байдал**


#### Газар зүйн нөхцөл байдал

Баянхонгор аймаг нь Монгол Улсын баруун төв хэсэгт оршдог. 116,000 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй бөгөөд улсын хэмжээнд газар нутгийн хэмжээгээрээ 4-т ордог. Баянхонгор аймаг нь хойд, баруун, зүүн талаараа Архангай, Завхан, Говь-Алтай, Өмнөговь зэрэг аймгуудтай хиллэдэг. Аймгийн төв Баянхонгор хот нь нийслэлээс 630 км зайтай оршдог. Баянхонгор аймаг нь өндөр уулын бүс, говийн бүс, хойд талаараа ойт хээр, дунд талаараа хээрийн, өмнөд талаараа цөлөрхөг бүсээс бүрддэг. Нүүрс, алт зэрэг ашигт малтмал болон барилгын материалын түүхий эдийн нөөцтэй.

Ойн сан бүхий газар 3,307 км<sup>2</sup> нутгийг эзлэх бөгөөд энэ нь аймгийн нийт газар нутгийн дөнгөж 2.9%-ийг эзэлдэг. Баянхонгор аймаг нь олон төрөл, зүйлийн зэрлэг

ан амьтан, ургамлаар баялаг бөгөөд тус аймагт аргаль, янгир, буга, гөрөөс, зэрлэг гахай, дорго, бор гөрөөс зэрэг ховордсон амьтад амьдардаг. Монгол орны нийт ургамлын аймгийн гуравны нэг нь энэ аймагт ургадаг. Нутгийн хойд хэсгээр ойт хээрийн, дунд болон өмнөд хэсгээр говь хээрийн ургамлууд зонхилж ургадаг.

**Зураг 7.4.2 Баянхонгор аймгийн байршил**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

Баянхонгор аймаг 2017 онд 87,243 хүн амтай, түүний нягтрал нь 0.75/км<sup>2</sup> байсан байна. Ардчилсан хувьсгалын дараа 1990-2000 онд хүн ам нь жилд дунджаар 0.79%-иар өсч байсан бол 2000-2017 онд 0.14%-иар буурсан.

Баянхонгор аймгийн эдийн засгийн голлох салбар нь хөдөө аж ахуй бөгөөд тус салбар нь 2017 оны байдлаар БДНБ-ний 47%-ийг эзэлжээ. 2017 онд нийт 1,074,000 мал тоолуулж улсын хэмжээнд 6-р байранд жагссан байна. Нэг малчин өрхөд ногдох малын тоо 388 байсан нь улсад 13-р байранд орсон. Нийт ажил эрхлэлтэд ногдох малчин өрхийн эзлэх хувь 54.4 ба тус үзүүлэлтээр улсад 4-р

байранд жагссан байна. Баянхонгор аймагт газар тариалангийн салбар тааруу хөгжсөн бөгөөд 2017 оны байдлаар зөвхөн 754 га тариалангийн талбайтай байсан. Бага хэмжээний улаан буудай, төмс, хүнсний ногоо тариалдаг.

Баянхонгор аймгийн эдийн засгийн нөхцөл байдал дунд зэрэг, 2017 онд БДНБ 380 сая төгрөг (11-р байр), нэг хүнд ногдох БДНБ 4,431,000 төгрөг (13-р байр) байсан.

Баянхонгор аймагт 2017 онд нийт 1,083 аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдсэнээс 889 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, 28 нь томоохон аж ахуйн нэгж байгууллага байсан бөгөөд эдгээр үзүүлэлтээр улсын хэмжээнд 16, 15-р байранд тус тус жагссан байна. Баянхонгор аймаг нь бизнес эрхлэхэд таатай орчинтой (8-р байр), зээлд хамрагдалт (2-р байр), хувийн бизнес эрхлэх боломж (4-р байр) сайн юм.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам 2017 онд 50.5% (5-р байр) байсан боловч ажиллах хүчний оролцооны түвшин бага 65.1% (16-р байр) байсан. 2017 онд ажилгүйдлийн түвшин 5.6% байсан бол ажил эрхлэлт 94.5%-тай байсан.

Боловсролын хувьд цэцэрлэгт хамрагдалтаар улсын хэмжээнд 3-р байранд жагссан ч бага, дунд боловсролын хамрагдалтаар 14,15-р байранд тус тус жагссан байна.

Эрүүл мэндийн салбарын хувьд иргэдийн бодит хэрэгцээг хангаж чадахгүй байгаа бөгөөд улсын хэмжээнд эмнэлгийн хүртээмжээр 18-р байранд жагсаж байна. 2017 онд 10,000 хүн тутамд ногдох халдварт өвчний тоогоор улсын хэмжээнд 17-р байранд байсан байна.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Баянхонгор аймгийн хотжилтын түвшин харьцангуй доогуур 2017 онд 35.5% байсан. Баянхонгор аймгийн төв нь Монгол Улсын хэвтээ тэнхлэгийн авто замын дагуу оршдог. Аймгийн нутаг дэвсгэрийн өмнөд хэсэг нь бүхэлдээ тусгай хамгаалалттай газар нутаг бөгөөд БНХАУ-тай хиллэдэг.

Авто замын чанараар дунд зэрэг улсын хэмжээнд 12-р байранд жагсдаг бөгөөд хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тээврийн хэрэгслийн тоо 2017 онд 10 (17-р байр) байсан.

Бусад дэд бүтцийн нөхцөл байдал дундаж түвшинд байна. 1,000 хүнд ногдох суурин утасны шугам (7-р байр), 1,000 өрхөд ногдох уст цэгийн тоо 4 (11-р байр), дулаан хангамжийн үнэ 495м<sup>2</sup>/төгрөг (11-р байр), цахилгаан хөдөлгүүртэй малчин өрхийн эзлэх хувь 84.5% (9-р байр), бензин түлшний үнэ 1,578 төг/л (15-р байр) байна. Баянхонгор аймаг нь томоохон үйлчилгээний төвүүдтэйгээрээ улсын хэмжээнд 2-р байранд ордгийг дурдах нь зүйтэй.

#### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Баянхонгор аймгийн газар нутгийн уулархаг тогтоц нь бэрхшээл учруулдаг. Хойд талын өндөр уулс нь Төвийн бүсийн аймгуудтай авто замаар холбогдоход хүндрэл үүсгэдэг. Өргөн уудам газар нутагтай учраас бусад аймгууд болон сум хоорондын зам харилцаа сайтар хөгжөөгүй. Хойноос урагшаа сунаж тогтсон газар зүйн байршилтай тул уур амьсгалын хувьд эрс тэс, өөр бүсүүдэд хуваагддаг.

Аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид бэлчээрийн даацын хэтрэлт, уур амьсгалын өөрчлөлт зэргээс хамааран цөлжилт, бэлчээрийн доройтлын асуудал үүсэж байгаа нь аймгийн хөгжилд тулгарч буй бэрхшээл гэдгийг онцолсон. 2010 онд нийт малын тоо толгой 1,963,000 байсан бол 2017 онд 4,588,000 тоо

толгой болж огцом өссөн нь бэлчээрийг ихээхэн доройтуулах шалтгаан болсон.

Аймгийн эдийн засгийн байдал дундаж түвшинд байгаа боловч эдийн засаг төрөлжөөгүй, уламжлалт мал аж ахуй хэт давамгайлсан, аж үйлдвэр, бизнесийн салбар сайн хөгжөөгүй байна. Мал аж ахуйгаас хэт хараат байдал нь бэлчээрийн даац хэтрэлт, цөлжилтийг түргэсгэж байна. Энэ нь үйлдвэрийн хоёрдогч болон гуравдагч салбарыг хөгжүүлэхэд эдийн засгийн сул талуудыг бий болгоно. Эдийн засаг төрөлжөөгүй, сул бүтэцтэйгээс үүдэн ипотекийн зээл авах шаардлага хангахгүй байх, орлогын эх үүсвэр бага, хөрөнгийн хуримтлал хомс зэрэг асуудал үүсдэг.

Аймгийн төв болон сум хоорондын нийгэм, эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдлыг зарим үзүүлэлтүүдээс тухайлбал орлогын тэгш бус байдал (21-р байр), эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж доогуур зэргээс харж болно.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчид төрийн албан хаагчдын хүрэлцээ муугаас үзүүлэх үйлчилгээний чанар хангалтгүй (15-р байр), бизнесийн таатай орчныг бүрдүүлэх орон нутгийн засаг захиргааны зохицуулалт хангалтгүй (13-р байр), бага боловсролын чанар муу (13-р байр), эмнэлгийн хүртээмж тааруу (18-р байр) зэрэг асуудлууд үүсэж буйг дурдаж байсан.

Баянхонгор аймгийн иргэд ялангуяа гэр хорооллын иргэд төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй учраас түүхий нүүрсийг хэрэглэж байна. Энэ нөхцөл байдал агаарын бохирдолыг үүсгэж байна.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Баянхонгор хот нь газар зүйн хувьд ойр байрлалтай Арвайхээр, Цэцэрлэг хоттой иргэдийнхээ сайн сайхан амьдралын төлөө нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, хамтарч ажиллах нь зүйтэй. Эдгээр 3 аймгийн төвийг холбосон тойрог коридор, авто замыг барьж байгуулах нь маш чухал юм. Баянхонгор хот нь зүүн, баруун тийш гарцтай транзит хот болох боломжтой. БНХАУ-тай хил залгаа нутгийн өмнөд хэсэг нь тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах тул эдийн засгийн зорилгоор хөгжүүлэх боломжгүй. Харин Өмнөговь аймгийн боомтоор нэвтрэх нь зүйтэй.

Баянхонгор аймгийн эдийн засаг уламжлалт мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай тул эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай. Эрчимжсэн мал аж ахуйг аймгийн төвийн ойролцоо болон Алтай, Арвайхээр хот хүрэх авто зам дагуу байршуулах нь зүйтэй. Тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй байршилтай уялдуулан байгуулах нь чухал юм. Мал аж ахуйд түшиглэсэн боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд буюу баруун болон зүүн бүсийн хот, суурин газруудын зах зээлд нийлүүлж, арьс шир, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх нь ач холбогдолтой юм.

Баянхонгор аймгийг зорих нэг шалтгаан нь аялал жуулчлалын салбар юм. Баянхонгор аймгийн ихэнх сум байгалийн үзэсгэлэнт газар, түүхэн дурсгалт газруудтай. Баянлиг сумын Цагаан хадны болор агуй, Өлзийт сумын Уран хайрхан, Заг Байдраг нь эртний хүний ул мөр бүхий олдворууд элбэгтэй. Түүнчлэн Баянхонгор аймаг нь халуун рашаан, эмийн ургамлын төрөл зүйлээр баялаг бөгөөд түүнийг ашиглах замаар эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой аймаг юм. Аялал жуулчлалыг бүрэн хөгжүүлэхийн тулд авто зам,

зочид буудал зэрэг аялал жуулчлалын суурь дэд бүтцийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах шаардлагатай.

Баянхонгор нь олон зүйлийн ургамал ургах таатай орчинтой тул эмийн ургамал элбэгтэй. Одоогийн байдлаар зөвхөн байгалийн эмийн ургамлыг түүж байгаа учраас бүтээгдэхүүний хувьд хязгаарлагдмал байна. Цаашид нутгийн иргэдэд түшиглэсэн эмийн ургамлын гаралтай малын тэжээл, тэжээлийн ургамал тариалах нь сайн чанарын ургамлын тогтвортой үйлдвэрлэлийг хангахад онцгой ач холбогдолтой. Одоо байгаа их сургуулиудыг түшиглэн эмийн ургамлын иж бүрэн судалгаа хийх, ирээдүйтэй төрөл, зүйлүүдийг сонгох, брэнд хөгжүүлэлт хийх, сурталчлах зорилгоор судалгааны төв байгуулах боломжтой.

Баянхонгор аймгийн аж үйлдвэрийн салбарыг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болох арьс шир, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн зэргээр төрөлжүүлж, жимсний тариалалт, эмийн өвс, ургамлын үйлдвэрлэл зэргийг жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай. Засгийн газар мэргэжлийн сургалт болон судалгаанд суурилсан бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр ЖДҮ-ийг дэмжих хэрэгтэй.

Дээр дурдсан боломжуудыг хэрэгжүүлэхийн тулд Баянхонгор аймагт авто зам, цахилгаан хангамж, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм, эдийн засгийн суурь дэд бүтцийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна. Цахилгаан эрчим хүчний хангамжийн тогтвортой байдлыг хангахад сэргээгдэх эрчим хүчийг ашиглахыг зөвлөж байна. Баянхонгор аймгийн өргөн уудам газар нутгийн онцлогийг харгалзан сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нь боломжит хувилбар юм. Говийн бүсэд салхи, нар, гүний дулааны эрчим хүчийг ашиглах боломжтой. Цаашид Говь-Алтай, Өмнөговь, Дундговь, Баянхонгор зэрэг аймгууд нь сэргээгдэх эрчим хүчний дэвшилтэт загварыг бий болгох бүрэн боломжтой газрууд юм.

### **7.4.3 Өвөрхангай аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**

##### Газар зүйн нөхцөл байдал

Өвөрхангай аймаг хойноос урагш 360 км, баруунаас зүүн 240 км үргэлжлэх газар нутагтай бөгөөд хойд хэсгээрээ Хангай нурууны салбар уулс бүхий нутаг дэвсгэрт далайн түвшнээс дээш 1,500-2,200 м өндөрт оршдог. Нутгийн баруун урд зүгт байрлах Баруунбаян-Улаан сумаас зүүн тийш Дундговь аймаг тийш 1500-1000м болж өндөржилт аажмаар буурдаг. Мөн Алтайн нурууны салбар уулс өмнөд хэсгийг дайран өнгөрдөг бөгөөд Өмнөговь аймагтай хил залгаа нутаг нь далайн түвшнээс дээш 1,100 м орчим өндөрт оршино.


Уур амьсгалын хувьд нутгийн хойд хэсэг тал хээрийн, өмнөд хэсэг нь говийн бүсэд хамаарна. 2018 онд бороотой өдрийн тоо 89, жилийн хур тунадасны хэмжээ 310 мм байсан нь Хангайн бүсийн аймгуудын хувьд хамгийн бага үзүүлэлт юм. Жилийн дундаж агаарын температур 2.5 хэм байсан нь Хангайн бүсийн хэмжээнд Булган аймгийн дараа орох өндөр үзүүлэлт юм.

Орхон гол нь нутгийн хойд хил буюу Архангай аймгийн хил орчмын дагуу зүүн хойд зүгт урсдаг. Орхон гол 1,124 км урттай, урсгалын дундаж хурд нь  $66\text{м}^3/\text{сек}$ , голын ай сав газар нийтдээ  $132,835\text{ км}^2$  ус хурах нийт талбайтай. Орхон гол нь Хархорин орчимд хойд зүгт чиглэх бөгөөд Булган аймгийн нутаг дэвсгэрт Сэлэнгэ мөрөнд цутгадаг.



Орхон голын дагуух Орхоны хөндий нь нүүдлийн өвөрмөц соёл иргэншлийн голомт нутаг тул ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгэгдсэн билээ.

**Зураг 7.4.3 Өвөрхангай аймгийн байршил**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

**Нийгэм, эдийн засаг**

Өвөрхангай аймгийн хүн ам 2010 оноос хойш жилд дунджаар 1.9%-ийн өсөлттэй байсан бол 2000-2010 онуудад 1.2%-иар буурсан. Энэ өөрчлөлт нь хүн амын ердийн өсөлт ба шилжилт хөдөлгөөний бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой. Хүн амын ердийн өсөлт 2000 онд 1000 хүн тутамд 18.1 төрөлт байсан бол 2010 онд 17.5 төрөлт болон буурч, 2018 он хүртэл энэ үзүүлэлт хэвээр хадгалагдсан. Өвөрхангай аймагт 2000-2018 он хүртэл гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөн үргэлжилж байсан боловч 2010 оноос хойш шилжин суурьших хөдөлгөөн

нэмэгдсэн. Үүнийг аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид Өвөрхангай аймагт баруун бүсийн аймгийн иргэд шилжин ирсэнтэй холбон тайлбарласан.

2018 оны байдлаар Өвөрхангай аймгийн БДНБ нь 489,370 сая төгрөг байсан бөгөөд улсдаа 7-р байранд орсон. 2018 онд нэг хүнд ногдох БДНБ нь 4,197,000 төгрөг (20-р байр) болж 2010 оны түвшинд очсоныг бусад салбартай харьцуулахад нэмүү өртөг багатай анхан шатны үйлдвэрлэл хэт давамгайлснаар тайлбарлаж болох юм. 2010 онд хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 39%, аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 17%, үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 45% байсан бол 2018 оны байдлаар ДНБ-д хөдөө аж ахуйн салбар 44%, аж үйлдвэрийн салбар 25 %, үйлчилгээний салбар 31% -ийг эзэлжээ. 2018 оны байдлаар хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарын БДНБ-нд эзлэх хувь хэмжээ өссөн байна. БДНБ-нд эзлэх хэмжээгээр хөдөө аж ахуйн салбар 5-р байранд, аж үйлдвэрийн салбар 11-р байранд тус тус орсон байна. 2018 оны дундаж цалин 653,000 төгрөг буюу улсын дундаж үзүүлэлтийн 65%-тай тэнцэж, улсдаа 18-р байранд жагссан байна.

2018 оны байдлаар нийт малын тоо толгой 5,461,000-д хүрч улсад 3-р байранд орсон нь 2010 онд улсад 6-р байранд орж байснаас дээшилсэн үзүүлэлт юм. Өвөрхангай аймгийн нийт малын тоо 2010-2018 оны хооронд 172%-иар өссөн бол улсын хэмжээнд 103%-иар өссөн байна. Ялангуяа адуу, үхэр, хонь илүү өссөнийг Хүснэгт 7.4.1-д үзүүлэв.

#### **Хүснэгт 7.4.1 Өвөрхангай аймгийн малын тоо**

Нэгж: мянган мал

Малын нэр	2010	2018	Өсөлт (%)
Адуу	113.8	323.6	184
Үхэр	76.2	272.3	257
Тэмээ	14.7	31.5	114
Хонь	896.6	2,588.1	189
Ямаа	909.2	2,245.8	147
Бүгд	2,010.6	5,461.3	172

#### **Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил**

Аймгийн төв Арвайхээр хот нь Монгол Улсын авто замын сүлжээний тэнхлэгийн төвд байрладаг. Энэ нь зүүн талаараа А0301 (хатуу хучилттай) авто замаар, баруун зүгт Өлгий чиглэлийн А0301, А0302, А0303, А0304, А0305 авто замуудтай холбогдсон бөгөөд Баянхонгор, Алтай, Ховд чиглэлийн авто замын хучилтын ажлын заримаас бусдаар засмал замтай холбогдсон байна. Өмнөд хэсгээр, Өмнөговь аймгийн Шивээхүрэн, Сэхээ боомт А29 (шороон зам) авто замаар, зүүн хэсгээр Дундговь аймгийн Мандалговь хоттой А3401 (шороон зам) авто замаар холбогддог.

Өвөрхангай аймгийн цахилгаан эрчим хүчийг 1,100 мВт-ын хүчин чадалтай Төвийн эрчим хүчний системээс хангадаг бөгөөд дулааны цахилгаан станц байхгүй. 2018 онд суурин утасны тоогоор (629) улсын хэмжээнд 12-р байранд орж, 100 хүн тутамд ногдох суурин утасны цэг 0.54 үзүүлэлтээр улсын хэмжээнд 20-р байранд жагссан байна.

Уст цэгийн хүртээмж 2010 онд 67 (3-р байр) байсан бол 2018 онд 97 (4-р байр) болж өссөн. Нэг уст цэгээр үйлчлүүлэх хүний тоо дунджаар 1,500 байснаа 832 болж сайжирсан ч улсын хэмжээнд 5-р байрнаас 8-р байранд жагсаж буурсан

байна.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Тухайн улсын ард түмэн нь хөгжлийн гол хөдөлгөгч хүч байдаг. Ард түмнээс эерэг санаачилга, идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй бол хэдийгээ байгалийн баялагтай байсан ч хөгжил дэвшил гардаггүй. Энэ хүрээнд Өвөрхангай аймагт нааштай зүйлс төдийлөн харагдахгүй байна. Аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид хүнсний талон олгох зэрэг нийгмийн халамжийн бодлого иргэдийг ажиллах дур сонирхолгүй, залхуу, бүр ажилгүй байхыг илүүд үзэх хандлагатай болгож буйг дурдаж байв. Иймэрхүү бэлэнчлэх сэтгэлгээ бий болгохоос гадна улсаас үзүүлэх тусламж үйлчилгээ, хэн нэгэнд найддаг социализмын үеийн сэтгэхүйгээс салаагүй байна. Хэрэв ийм сэтгэлгээг өөрчлөхгүй бол хөгжлийг сааруулна.

Малын хулгай, орон байрны хулгай зэрэг гэмт хэргийн тоо ч ихсэж байгаа нь иргэд нийгмийн идэвхгүй байгаагийн үр дүн юм. Архидалт бас ажиглагдаж байна. Мэргэжлийн ур чадварыг сайжруулах, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, суурь боловсролын багш нарын ур чадварыг сайжруулах, сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх гэх мэт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх болон боловсролын чанарыг сайжруулах шаардлагатай байна. Эдгээртэй зэрэгцүүлэн хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна.

Сүүлийн үеийн боловсролын тогтолцооны шинэчлэлийн улмаас хүүхдүүд найман настайдаа бус зургаан настайдаа сургуульд элсэн суралцдаг болсноор малчин гэр бүлийн гишүүд тусдаа амьдрах хэлбэрт шилжиж, нийгмийн олон асуудал үүсэж байна. Нялх балчир хүүхдээ сургуульд сургахын тулд ээжүүд сум, аймгийн төвд суурьшиж, аав нь малаа маллан хөдөө амьдрах болсон. Энэхүү асуудлыг шийдвэрлэхгүй бол нүүдлийн мал аж ахуй эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлж, гадаад руу шилжих хөдөлгөөнийг хурдасгаж, мал аж ахуйн салбарт ажиллах хүч дутагдах болно.

Малын тоо толгой өсөх нь богино хугацаандаа малчдын амьжиргаанд нэмэр болж байгаа ч бэлчээрийн даац хэтрэх, хөрсний доройтол, газрын гарц муудах зэрэг асуудлууд үүсгэж байна. Малын тоог хянахын тулд малын хөлийн татвар ногдуулах хэрэгтэй. Жишээлбэл татварыг 500-гаас дээш толгой малтай малчдад ногдуулж болно. Малчдын үйлдвэрлэсэн мах, сүү, сүүн бүтээгдэхүүний дийлэнх нь өөрсдийн хувийн хэрэглээнд зориулагдаж, худалдаа арилжааны хэлбэрт орж чадахгүй байна. Иймээс малчдад эхний ээлжинд бизнесийн мэдлэг, зах зээлийн эрэлтийг хангах талаар мэдлэг олгох шаардлагатай байна.

Өвөрхангай аймагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж их байгаа бөгөөд Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө боловсруулсан ч одоогоор тодорхой арга хэмжээ авсан нь харагдахгүй байна. Ялангуяа нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг цогцоор хэрэгжүүлэх менежментийн чадвар хомс байгаа нь хэдий төлөвлөгөө байсан ч хэрэгжихгүй байх шалтгаан болж байна. Аялал жуулчлалыг сурталчлах чиглэлээр тодорхой чиглэл байхгүй, мэргэшсэн хүний нөөцийн хомс байдал, авто зам, цахилгаан хангамж, ариутгах татуургын асуудлыг бүрэн шийдэж чадаагүй байна.


Өвөрхангай аймагт бизнесийг дэмжиж буй олон эерэг өөрчлөлтүүд байгаа ч логистикийн сүлжээ муу (18-р байр), банкны зээлийн хүү өндөр (17-р байр), банк, санхүүгийн үйлчилгээ муу (16-р байр), интернет гэх мэт мэдээлэл харилцаа

холбоо, шуудангийн үйлчилгээ сул хөгжсөн (19-р байр), аж ахуйн нэгж байгууллагуудын харилцаа холбооны төхөөрөмжүүдийн хязгаарлагдмал хэрэглээ (19-р байр) зэрэг сул талууд байна.

### (3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж

Өвөрхангай аймгийн газар зүйн байршил, бизнесийн хөгжилд эерэгээр нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан логистикийн хөгжлийг дэмжих талаар санал болгож байна. Зураг 7.4.4-ээс харахад Өвөрхангай аймаг газар зүйн хувьд Монгол орны төв хэсэгт уулархаг газар нутаг бүхий хойд аймаг болон баруун аймгуудын дунд оршдог. Энэ нь Сайншанд, Шивээхүрэн Сэхээгийн хилийн боомтоор БНХАУ руу хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход хойд болон баруун аймгуудын хувьд гарц болж чадна. Мөн 'Нэг бүс нэг зам'-ын хойд хэсэгт оршдог нь бараа бүтээгдэхүүн импортлоход ч давуу талтай байршилд байна. Бусад аймаг орон нутгийн бараа бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотод төвлөрүүлж, ОХУ руу экспортлоход боломжтой байршилд оршиж байна.

**Зураг 7.4.4 Өвөрхангай аймгийн логистикийн төвийн үүрэг**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Өвөрхангай аймагт хөдөө аж ахуйн үйл ажиллагаа давамгайлдаг ч бизнес эрхлэхэд таатай буюу бизнес эрхлэхэд хүнд суртал багатай (3-р байр), хээл хахууль, авилгал бага (4-р байр), зөвшөөрөл авахад хялбар (2-р байр), удирдах ажилтны ур чадвар сайн (5-р байр), санхүүгийн мэдлэг сайн (2-р байр), компаниудын өнгөрсөн жилийн хөрөнгө оруулалт (1-р байр), аймгийн төвд дэд бүтэц шинээр барих, засварлах ажилд хөрөнгө оруулалт хийсэн (3-р байр) зэрэг нөхцөлүүд бүрдэж, улсын



хэмжээнд сайн үзүүлэлттэй байна. Төрийн албан хаагчдын эзлэх хувь бага буюу улсад хамгийн цөөн байгаа нь хувийн хэвшилд илүү хөрөнгө оруулалт хийдэгтэй холбож үзэж болох юм. Орон нутгийн санаачилга нь төсвийн зарцуулалтыг үр ашигтай зарцуулах (2-р байр), аймгийн хөгжилд хувь нэмэр оруулж буй орон нутгийн засаг захиргааны бодлого, шийдвэр (3-р байр), төрийн үйлчилгээний шударга байдал (4-р байр) зэргээс ажиглагдаж байна. Тиймээс логистикийн хөгжлийг газар зүйн байршлын давуу талыг ашиглан хөгжүүлж, олон төрлийн сул талуудыг даван туулж, төлөвлөх, сурталчилж дэмжих шаардлагатай байна.

Өвөрхангай аймагт мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл ирээдүйтэй байна. Бусад аймгуудын нэгэн адил аж үйлдвэрийн салбарын хөгжлийн түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал сорилт болж байна. Тиймээс хэд хэдэн байршилд үндсэн байгууламж бүхий мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластеруудыг байгуулан хэрэгжүүлж болно. Гол санаа нь малчдаас авсан малын гаралтай түүхий эдийг эдгээр төвүүдэд төвлөрүүлж мах, сүү, сүүн бүтээгдэхүүн ялангуяа бяслаг, цэцгийн тос, арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үндсэн байгууламжуудыг аймгийн төв Арвайхээр хотод байгуулах бөгөөд дэд кластерыг нутгийн өмнөд хэсэгт Баруунбаян-Улаан, зүүн хэсэгт Баянгол, зүүн хойд хэсэгт Баян-Өндөр сумдад тус тус байгуулах боломжтой. Эдгээр байршлыг одоо байгаа тээвэр логистикийн байдалтай холбож Зураг 7.4.4-т үзүүлсэн логистикийн маршрутын дагуу байршуулахыг урьдчилан байдлаар санал болгож байна.

Урьдчилсан тооцоогоор мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын нэг төвийн талбайн хэмжээ 12,000-13,000 км<sup>2</sup> байх бөгөөд 63 км радиустай тойрог бүхий газрыг хамарч, өдөрт 150 орчим малын түүхий эдийг боловсруулах тооцоог хийсэн байна. Тооцоог дор үзүүлэв. Үүнд:

- (a) Төхөөрөх малын тоо, өдөрт : 150
- (b) Нийт малд эзлэх хувь : 5%
- (c) Төхөөрөх нийт малын тоо, жилээр : 1,095,000
- (d) Өвөрхангай аймгийн малын тоо толгойн нягтрал:  
 $5,461,000 \text{ мал} / 62,900 \text{ км}^2 = 87 \text{ толгой мал} / \text{км}^2$
- (e) Хамрагдах талбай: c)/d) ойролцоогоор 12,500 км<sup>2</sup>

Малын тоо толгойн нягтралыг аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээгээр тооцсон бөгөөд бэлчээрийн талбай нь бага учраас бодит нягтрал өндөр байх болно. Энэ нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын төвийн бодит нутаг дэвсгэрийн хэмжээ нь 12,000-13,000 км<sup>2</sup> талбайгаас бага байна гэсэн үг юм. Энэхүү урьдчилсан тооцоог ашигласнаар Өвөрхангай аймгийн хэмжээнд кластерын төв ойролцоогоор 5 байхад болно. (  $62,500 \text{ км}^2$  газрыг нэг төвд ногдох  $12,500 \text{ км}^2$  -т хуваахад = 5.03 болж байна)

Дээрх тооцоог урьдчилсан байдлаар хийж байгаа бөгөөд нарийвчлан судлах шаардлагатай. Хамгийн чухал нь урт хугацааны зорилтоо хэрэгжүүлэхийн тулд зорилтот талбайн өнөөгийн нөхцөл байдлыг сайтар тооцон төлөвлөх шаардлагатай. Илүү нарийвчлан судалж, тэргүүлэх чиглэлээ тодорхойлсны дараа хувийн хөрөнгө оруулагчдад танилцуулж болно. Туршилтын төслийг аймгийн засаг захиргаа, хувийн хөрөнгө оруулагчид хамтарч хэрэгжүүлэх боломжтой.

Хархорин, Орхоны хөндийгөөр байгалийн болон соёл, нүүдлийн амьдралын хэв маягийг сурталчилсан аялал жуулчлалыг цогц байдлаар хөгжүүлэх шаардлагатай



байна. Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг эхний ээлжинд боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

## 7.5 Өмнөд бүсийн аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ

### 7.5.1 Дундговь аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал


##### Газар зүйн нөхцөл байдал

Дундговь аймаг нь Монгол Улсын газар нутгийн төв хэсэгт оршдог. Аймгийн газар нутгийн хэмжээ нь 74,690 км<sup>2</sup> бөгөөд улсад 11-р байрт ордог бөгөөд Төв, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь аймгуудтай хиллэдэг. Аймгийн төв Мандалговь хот нь Улаанбаатар хотоос 160 км зайтай оршдог. Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хойт хэсэг нь хуурай хээр, өмнөд хэсэг нь говь цөлийн бүсэд хамаарна. Дундговь аймаг 27,100 га ойн сантай. Томоохон гол, нуур байхгүй бөгөөд цөөн тооны булаг шандтай. Газар зүйн болон хүрээлэн буй орчны онцлогоос хамааран амьтан, ургамлын төрөл, зүйл элбэгтэй.

Зураг 7.5.1 Дундговь аймгийн байршил







Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

Дундговь аймгийн хүн ам нь 2000-2010 онд -2.24% буурсан үзүүлэлттэй байсан бол сүүлийн жилүүдэд буюу 2010-2015 оны хооронд хүн ам жилд дунджаар 2.89 хувиар өссөн байна. Аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгээс үзэхэд 2000-2010 оны хүн амын энэхүү бууралт нь ган, зудын нөлөөгөөр мал аж ахуйн салбарт ноцтой хохирол учирсаны улмаас иргэд нүүж явсантай холбоотой юм. Сүүлийн жилүүдийн хүн амын өсөлт нь аймгийн эдийн засгийн байдал сайжирсанаас гадна зам, харилцаа холбоо зэрэг дэд бүтэц сайжирсантай холбоотой.

Дундговь аймгийн эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд БДНБ-д салбарын эзлэх хувь 59 байна. 2017 оны байдлаар аймгийн нэг хүнд дунджаар 77 толгой мал ногдож, улсад 1-р байранд эрэмбэлэгдсэн. Дундговь аймгийн малын тоо толгой 2010 онд 1,112,000 байсан бол 2017 онд 3,593,000 болон мэдэгдэхүйц өсөж, улсад 9-р байранд орсон байна. 2010 онд аймгийн хэмжээнд ган, зуд нүүрлэж, малын тоо толгой ихээхэн хорогджээ. Түүнээс хойш малын тоо толгой өссөн. 2010 онд нийт тариалсан талбайн хэмжээ 125 га байсан бол 2017 онд 92 га болж, буурчээ.

2017 оны байдлаар нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь харьцангуй өндөр 52.4% байна. Ажилгүйдлийн түвшин 2010 онд 10.1 байсан бол 2017 онд 4.4 болж, эрс сайжирсан үзүүлэлттэй байна. Аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгээс үзэхэд энэ нь мал аж ахуй, холбогдох боловсруулах үйлдвэр болон төрийн байгууллагад хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдсэнтэй холбоотой юм.

2017 оны байдлаар Дундговь аймгийн нэг хүнд ногдох БДНБ 5,579,000 төгрөг байсан бөгөөд улсад 5-р байранд орсон нь 2010 онтой харьцуулбал сайжирсан үзүүлэлт юм. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 639 байгаа нь улсад 20-р байранд байна. 20 гаруй томоохон компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 13, аж үйлдвэрийн салбарын борлуулалт бусад аймгуудтай харьцуулахад хамгийн доогуур үзүүлэлттэй байгаа нь Дундговь аймагт аж үйлдвэрийн салбарын хөгжил сул байгааг харуулж байна.

Дундговь аймгийн бага боловсрол, ерөнхий боловсролын нэг багшид ногдох сурагчийн тоо, хамран сургалтын хувь хангалттай, сайн байна. Гэвч дээд боловсрол эзэмшигчид нь өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээг хангаж чадахгүй байна. Дундговь аймгийн эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны үзүүлэлтүүд харилцан адилгүй байна. Их эмчийн тоо хангалттай, нялхсын эндэгдлийн түвшин бага байна. 10,000 хүнд ногдох халдварт өвчний тархалт 106 байгаа бөгөөд улсад 14-р байранд эрэмбэлэгдсэн байна.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

2017 оны байдлаар Дундговь аймгийн хувьд хотжилтын түвшин 26.6% байсан байна. 2010-2015 онд хүн амын жилийн дундаж өсөлт бага 0,91 хувьтай байсан хэдий ч 2017 оны байдлаар Мандалговь хотын нийт хүн амын тоо 14,294 болж, өссөөр ирсэн.

Мандалговь хот нь Улаанбаатар хоттой А0201, Даланзадгад хоттой А0202 авто замаар, Сайншанд хоттой орон нутгийн чанартай авто замаар тус тус холбогддог. Мандалговь, Даланзадгад, Сайншанд хотуудыг холбосон авто замын дэд бүтэц хангалтгүй байгаа бөгөөд тухайн авто замууд нь стратегийн хувьд өндөр ач холбогдолтой хэдий ч хайрга, асфальтан хучилттай байна. Дундговь аймгийн авто замын чанарын хувьд улсад 18-р байранд орсон.

Дундговь аймгийн нутаг дэвсгэрээр төмөр замын шугам дайран өнгөрдөггүй бөгөөд нисэх онгоцны буудалгүй. Дундговь аймгийн хэрэглэгчид телефон утасны шугам, ус хангамж, эрчим хүчний шугам сүлжээнд холбогдсон ба цэвэр усны хүртээмж, хог хаягдлын менежмент зэрэг суурь дэд бүтцийн хөгжил сул байна.

#### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Дундговь аймагт тулгамдаж буй асуудлуудын нэг нь аймгийн хүн амын тоо бага байгаа явдал юм. Дундговь аймгийн газар нутаг байгалийн нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд тийм ч тохиромжтой биш юм. Бэлчээрийн даац хэтрэлт, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн бэлчээрийн доройтол, цөлжилтөд өртсөн. Бэлчээрийн доройтол, цөлжилт нь мал аж ахуй эрхлэхэд хүндрэл учруулж байна. Дундговь аймаг нь 2009, 2010 онуудад тохиолдсон зудын гамшигт нэрвэгдэж, бэлтгэл арга хэмжээ хангалтгүй байсны улмаас олон тооны мал хорогдсон.

Аялал жуулчлалын салбарын хувьд Улаанбаатар хот болон Өмнөговь аймгийн хооронд оршдог аймгийн байршлаас нь шалтгаалан жуулчид зөвхөн дайран өнгөрөх төдий байна. Дундговь аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц боломж бий.

Мэргэжилтэй, ур чадвартай ажиллах хүчин хомс байгаа нь мал аж ахуйгаас бусад үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. Дээд боловсрол эзэмшигчид нь өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээг хангаж байгаа эсэх байдлаар улсад 17-р байранд орсон нь аймгийн хүний нөөцийн эрэлт, хэрэгцээг хангахгүй байгааг харуулж байна. Дундговь аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид аймагт их, дээд сургууль байхгүй байгаа нь эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байгааг онцолсон.

Аймгийн хүн амын ундны усны хүртээмж, чанарын хувьд улсад 21-р байранд орсноос үзэхэд ноцтой бэрхшээл тулгарч байгаа бол зөөврийн ус хэрэглэдэг 1000 өрхөд 10 уст цэг ногдож, улсад 1-р байранд эрэмбэлэгдсэн байна. Хэлэлцүүлэгт оролцогчид аймгийн хэмжээнд хогны асуудлаа шийдвэрлэж чадаагүйд (21-р

байр) сэтгэл зовниж буйгаа илэрхийлсэн.

Төрөөс нийгмийн халамжийг хавтгайруулан олгож, иргэдэд бэлэнчлэх сэтгэлгээ суулгаж байгаа нь аймгийн хөгжилд хүндрэл учруулж байгааг хэлэлцүүлэгт оролцогчид онцолж байв.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Дундговь аймаг нь Монгол Улсын төв хэсэгт Улаанбаатар болон БНХАУ-ын зах зээлд ойрхон оршдог. Тиймээс Дундговь аймаг нь газар зүйн байршлын давуу талаа ашиглаж төвийн бүсийн дэд төв болон хөгжих боломжтой. Аймгийн төв Мандалговь хот нь Улаанбаатар - Даланзадгад чиглэлийн авто замын тэнхлэгийн дагуу байрладаг. Түүнчлэн Мандалговь хот нь стратегийн чухал ач холбогдол бүхий Чойр, Сайншанд, Арвайхээр хотуудтай хайрган хучилттай болон ердийн шороон замаар холбогддог. Дөрвөн чиглэлд дамжин өнгөрөх цэгийн хувьд ачаа ачих, буулгах, ачаа түр хадгалах зэрэг далд эрэлт байж болох юм.

Логистикийн төв байгуулах болон Дундговь аймгийг дамжин өнгөрөх төв болгон хөгжүүлэх үүднээс авто замын сүлжээг сайжруулах шаардлагатай. Чойр, Айраг, Сайншандыг холбосон хатуу хучилттай авто замыг барьж байгуулснаар аймаг нь хойноос урагш чиглэсэн төмөр замтай хялбархан холбогдох боломжтой. Логистикийн төв байгуулахтай уялдуулан Мандалговь хот нь үйлчилгээний зангилаа хотын чиг үүрэгтэйгээр хөгжих боломжтой. Түүнчлэн дамжин өнгөрөх төвийн хувьд Дундговь аймагт уул уурхай, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулан, Замын-Үүд, Гашуунсухайт болон Шивээхүрэнгийн боомтоор дамжуулан БНХАУ руу экспортолно.

Дундговь аймаг нь мал аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжих нь зүйтэй. Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх үүднээс ган, зудаас урьдчилан сэргийлэх ажлыг сайтар төлөвлөн, хадлан, малын тэжээл бэлтгэх, хадгалах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Улаанбаатар хот болон БНХАУ-ын зах зээлд нийлүүлэхийн тулд малын гаралтай анхан шатны бүтээгдэхүүнийг сайжруулан, үйлдвэрлэх шаардлагатай. Аймаг нь мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тохиромжтой бүсэд байршдаг тул Улаанбаатар хот болон түүний орчмын хот, суурингийн зах зээлд шинэхэн мах, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой.

Эдийн засгийг төрөлжүүлэхийн тулд уул уурхайн олборлолт, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг тодорхой хэмжээгээр дэмжих шаардлагатай. Дундговь аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид хариуцлагатай уул уурхай хөгжүүлэн, аймгийн хөгжилд хувь нэмэр оруулах шаардлагатай талаар онцлон, тэмдэглэсэн. Дундговь аймагт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд байхгүй боловч нүүрс, төмрийн хүдэр, мөнгө зэрэг ашигт малтмалын нөөцийг ашиглах боломж байсаар байна. Эдгээр ашигт малтмалын нөөцийг одоо хүртэл ашиглаагүй байна. Дундговь аймагт ашигт малтмалын ордын олборлолтоос гадна нэмүү өртөг шингээх үүднээс анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр байгуулах шаардлагатай. Анхан шатны боловсруулалт хийсний дараа Өмнөговь аймгийн боловсруулах үйлдвэрт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, БНХАУ руу экспортолно.

Аялал жуулчлалын салбарын гол стратеги болох байгаль болон соёлын өв санд суурилсан аялал жуулчлалын маршрутыг бий болгосноор Дундговь аймагт жуулчид наад зах нь нэг хоног саатан, нутгийн иргэдэд үр өгөөжөө өгөх юм. Дундговь аймаг нь соёлын өв санд суурилсан аялал жуулчлалаас гадна уртын

дууны өлгий нутаг юм. Хөдөө аж ахуй, дуу хөгжим, түүх, байгалийн нөөц баялаг, урлаг, гар урлал, үзэсгэлэнт газар, соёлын өвийг нэгтгэн аялал жуулчлалыг хөгжүүлснээр бүсийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл орон нутгийн нөөц, бололцоог нэгтгэн, аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэн, Дундговь аймгийг жишиг загвар болгон хөгжүүлэх боломжтой юм. Жуулчдыг татах зочид буудал, ресторан, музей, цэцэрлэгт хүрээлэн, ариун цэврийн байгууламж зэрэг аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах шаардлагатай.

Дундговь аймаг нь сэргээгдэх эрчим хүч ялангуяа фото цахилгаан үүсгүүр ашиглан, нарны эрчим хүчээр цахилгаан үйлдвэрлэн хөрш Өмнөговь, Дундговь аймагт нийлүүлэх боломжтой. Говь нутаг нь нүүрс зэрэг ашигт малтмалын хэрэглээнээс сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ рүү аажмаар шилжих шаардлагатай.

Хэлэлцүүлэгт оролцогчид говь нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал дэвшүүлж байсан. Энэхүү саналыг гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй. Дундговьчууд мал аж ахуй, уул уурхай, аялал жуулчлалд суурилсан чанартай, тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр зорин, ажиллах шаардлагатай.

## 7.5.2 Говьсүмбэр аймаг


### (1) Одоогийн нөхцөл байдал

#### Газар зүйн нөхцөл байдал

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ нь 5,541.8 км<sup>2</sup> ба харьцангуй жижиг газар нутагтай аймаг юм. Аймгийн төв нь Чойр хот бөгөөд Улаанбаатар хотоос зүүн өмнөд зүгт 226 км зайтай оршдог. Аймгийн жилийн дундаж агаарын температур нь -37-37 хэм, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Далайн түвшнээс дээш 1,000-1,200 м өргөгдсөн, жилд дунджаар 200-250 мм хур тунадас ордог. Тал хээр нутагтай бөгөөд газар нутгийн 80%-ийг бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжтой. Ойн сангүй учраас зэрлэг амьтдаас зөвхөн цагаан зээр нутагшдаг.

Зураг 7.5.2 Говьсүмбэр аймгийн байршил





Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (БОАЖЯ-ны зургийг ашиглав).

### Нийгэм, эдийн засаг

Говьсүмбэр аймгийн хүн ам сүүлийн жилүүдэд өсөж байгаа бөгөөд 1995-2005 онд 0.57 хувь байсан бол 2005-2017 онд 2.73 хувь болж өссөн байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээлснээр хүн амын өсөлтийн шалтгаан нь: 1. Хонины ноос боловсруулах үйлдвэр байгуулагдсан 2. Ус хангамж сайн учраас малчид шилжиж суурьшсан 3. Газрыг өмчлүүлсэн.

2017 онд малын тоо толгой 97,000 байсан бөгөөд хэдийгээр улсын хэмжээнд малын тоо толгойгоор сүүлээсээ хоёрдугаарт жагсаж байгаа ч малтай нэг өрхөд ногдох малын тоо 616 байсан нь улсдаа тэргүүлж байна. Тариалангийн талбайн нийт хэмжээ 38.7 га бөгөөд үр тариа тариалдаггүй. БДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хэмжээ 2016 онд 24% байснаас 2017 онд 20% болж буурсан. Харин үйлчилгээний салбарын борлуулалт энэ хугацаанд 38%-иас 41% болж өссөн байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын хувь 2017 онд 44.9 % болсон нь өмнөх жилийн 37.1% байснаас сайжирсан үзүүлэлттэй байна. Ажил эрхлэлтийн түвшин 2016-2017 онд 82.3%-иас 92.2% болж нэмэгдсэн байна. Эдгээр үзүүлэлтүүд сайжирснаар мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн бөгөөд ажиллах хүчний оролцооны түвшин мөн дээрх онуудад 52.4%-иас 69.0% болж нэмэгдсэн байна.

Говьсүмбэр аймгийн хувьд бүсийн хэмжээнд нэг хүнд ногдох ДНБ 2017 онд 5,080,000 төгрөг болсон нь өмнөх оныхоос 3.8%-иар өсөж, улсын хэмжээнд 8-р байранд жагссан байна. Нэг хүнд ногдох хувийн хэвшлийн зээлийн хэмжээ болон төсөв, зарцуулалтын харьцаа хамгийн их байгаа нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаатай аймаг мэт харагдаж байгаа ч нэг хүнд ногдох хадгаламжийн хэмжээ нь харьцангуй доогуур үзүүлэлттэй байна. Дундаж цалингийн хэмжээ 874 мянган төгрөг байсан нь улсад 2-р байранд жагссан бөгөөд ажилгүйдлийн түвшин 2016-2017 онд 18.1% -иас 7.8% болж буурсан байна.

### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Говьсүмбэр аймгийн хотжилтын түвшин 2010 онд 74.5% байснаас 2017 онд 40.9% хүртэл буурсан. Энэ нь дээр дурдсанаар гаднаас шилжин ирсэн малчдын



урсгалаас шууд хамааралтай гэж үзэж байна. 2017 оны байдлаар Чойр сум 10,434 хүнтэй. 2000-2010 онуудад хүн амын өсөлт жилд дунджаар 0.78%-тай байсан нь 2010-2017 онуудад 1.04% болж өсчээ.

Говьсүмбэр аймагт дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн. Улсын чанартай А101 авто зам болон Орос, Хятад улсыг холбодог олон улсын төмөр зам аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг. Хэдийгээр Говьсүмбэр аймгийн хүн ам өсөхийн хирээр дэд бүтцийн хүрэлцээ муудаж байгаа ч эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг болох суурин телефон утасны шугам, цахилгаан болон ус хангамж сайтай аймаг юм. Мөн нийгмийн болон худалдаа үйлчилгээний барилга байгууламжийн хүрэлцээ сайтай бөгөөд нэг худалдаа, үйлчилгээний барилга байгууламжид ногдох хүний тоогоор улсад хамгийн цөөн үзүүлэлттэй байна.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Газар нутгийн хэмжээ нь Говьсүмбэр аймгийн хөгжилд саад болж байна. Аймгийн эдийн засгийн багтаамж бага бөгөөд газар тариалан эрхлэлт бага, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл зонхилсон. Хүн амын хэт өсөлтөөс болж хот, хөдөөгийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хангамж хүрэлцэхгүй болж байна. Хэдийгээр Хэрлэн голоос усаа хангаж байгаа нь давуу тал боловч усны нөөцийн хомсдолын эрсдэл байгааг хэлэлцүүлэгт оролцогчид дурдсан.

Говьсүмбэр аймгийн хувьд мал аж ахуйн голлох үйл ажиллагаанаас ноос боловсруулах үйлдвэр болон үйлчилгээний салбарыг шинээр хөгжүүлж, хотжиход чиглэсэн шилжилтийн үедээ байна. Хэдийгээр ажилгүйдлийн түвшин буурч, дундаж цалингийн хэмжээ өндөр байгаа ч 2016 онд ядуурлын түвшин хамгийн өндөр 52.4%-тай байсан. Том үйлдвэрүүдийн ажилчдын цалин болон хотын ядуу иргэдийн орлогын зөрүүтэй байдал мөн олон малтай малчид болон хөдөөгийн ядуу иргэдийн орлогын зөрүү маш их байна. Хот суурин газар болон хөдөөгийн нийгмийн үйлчилгээнд тэгш бус байдал байсаар байна.

Хот төвтэй эдийн засгийн хөгжлийн үүднээс авч үзвэл мэргэжилтэй боловсон хүчний хомсдол нь асуудал үүсгэж байна. Хэдийгээр бага, дунд, ахлах сургуульд хамрагдалтын тоо өндөр ч дээд боловсролын үзүүлэлтээр улсын хэмжээнд дундаж түвшинд байна. Хэлэлцүүлгийн үеэр дээд боловсролын байгууллагыг өргөжүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглэж байсан.

## **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Чойр сум нь Улаанбаатар - Замын-Үүд чиглэлийн авто зам болон ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр замын дагуу оршдог. Ирээдүйд ОХУ болон БНХАУ-ын харилцаа холбооны чадамж сайжрах бөгөөд гол шугамын дагуу байрласан. Эдгээр дэд бүтцийн таатай байршлыг ашиглан Чойр сум нь цаашид логистикийн томоохон төв болон хөгжиж, авто тээврийн болон төмөр замын ачаа тээвэрлэлтийн байгууламж байгуулахад тохиромжтой. Чойр хот нь автомашины засвар үйлчилгээний төв болох боломжтой гэдгийг аймгийн хэлэлцүүлгийн үеэр онцолж байсан.

Говьсүмбэр аймаг нь хүрэн нүүрс, газрын тос, хар тугалга, тоосгоны шавар, жонш зэрэг ашигт малтмалын арвин нөөцтэй. Эдгээр ашигт малтмалыг бараг олборлоогүй бөгөөд зэргэлдээ Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын жоншны уурхайн орчимд л олборлолт хийж байна. Уурхайгаас олборлосон ашигт малтмалын дараагийн шатны боловсруулалтыг Чойр болон бусад сумдад хийж, өндөр үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн логистик төвөөр дамжуулан гадагш



нийлүүлэх боломжтой.

Говьсүмбэр аймаг хүрэн нүүрсний өндөр нөөцтэй. Энэ нөөцийг ашиглах боломж нь Хятад улсын нэгэн адил хямд цахилгаан үйлдвэрлэх том хэмжээний цахилгаан станц барих явдал юм. Түүхий нүүрс экспортолж байснаас цахилгаан экспортлох нь оновчтой боловч байгаль орчинд сөрөг нөлөөтэй. Цэвэр нүүрсний технологийн төвийг байгуулж орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан чанар муутай нүүрснээс өндөр үр ашигтай түлш боловсруулах нь ашигтай хувилбар байж болно. Дэвшилтэт технологи ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэх нь маш чухал юм. Бага орлоготой иргэдийг боловсруулсан нүүрс хэрэглэхийг төрөөс дэмжиж татаас өгөх системийг хэрэгжүүлж ч болох юм. Энэхүү цэвэр нүүрсний дэвшилтэт технологи нь байгаль орчинд ээлтэй тохиолдолд газрын хэвлийн баялгийг ийм байдлаар ашиглаж болох юм.

Оросын цэргийн ангид ашиглагдаж байсан нислэгийн зурвас нь Говьсүмбэр аймгийн дунд, урт хугацааны эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой. Үүнийг үр өгөөжтэй ашиглахын тулд Эдийн Засгийн Чөлөөт Бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлж ашигт малтмал боловсруулах, ноос, ноолуур боловсруулалтыг өргөжүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болох арьс шир, сүү, сүүн бүтээгдэхүүн, эхэс болон бусад бүтээгдэхүүнийг боловсруулах, автомашины засвар үйлчилгээний газрууд болон бусад үйлдвэрлэл үйлчилгээний газрууд байгуулах хэрэгтэй юм. Эдгээрийн ихэнхийг орон нутгийн иргэдэд түшиглэсэн ЖДҮ-лэлд тулгуурлан хөгжүүлж болох бөгөөд үүнд Засгийн газрын зүгээс нийгмийн болон бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Бас нэгэн чухал боломж нь телефон холбооны үндсэн суурь болгож, ус, эрчим хүчний нөөц, зам тээврийн дэд бүтцийн давуу талыг ашиглан Эдийн Засгийн Чөлөөт Бүсэд мэдээлэл харилцаа холбоо технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал юм. Үүний урьдчилсан нөхцөл нь олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу мэргэшсэн боловсон хүчнийг бэлдэх хэрэгтэй.

Хотыг хөгжүүлэхтэй зэрэгцэн Говьсүмбэр аймгийн орон нутгийн түүх, соёлын өвийг үгүйсгэж болохгүй. Хөдөөгийн эдийн засгийн хөгжлийн үндэс суурь бол эрчимжсэн мал аж ахуй юм. Дээр дурьдсанаар мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тулгуурласан боловсруулах үйлдвэрийг байгуулах нь энэ салбарыг дахин сэргээнэ. Мал аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж ус, тэжээлийн хангамжийг сайжруулснаар малчдыг энэ нутагт суурьшин амьдрах урсгалыг нэмэгдүүлнэ. Хот, хөдөөд аялал жуулчлал эрхлэлт бага ч эдийн засагт чухал ач холбогдолтой. Улаанбаатар хотын жуулчдыг татах зорилгоор амралтын өдрүүдэд амрах боломжтой резорт, амралтын газрыг Баянтал сумын зуны сэрүүн цаг агаар, Чойр хотын ойролцоох Халзан уулын рашаан болон хүний гараар бүтээгдсэн үзмэрүүдэд түшиглэн байгуулах боломжтой. Түүх, соёлыг хадгалсан гар урлал, хоол хүнс зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж, жуулчдад үйлчлэх боломжтой. юм.

### **7.5.3 Дорноговь аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**

##### Газар зүйн нөхцөл байдал


Дорноговь аймаг нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт оршдог ба 109,472 км<sup>2</sup> газар нутагтай Монгол Улсын 5 дахь том нутаг дэвсгэртэй аймаг юм. Аймаг нь урд талаараа БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Оронтой хиллэдэг. Нийт газар

нутаг нь говь, хээр хосолсон бөгөөд говийн бор хөрс болон элсэрхэг хөрс зохилдог. Говь цөлийн бүсэд орших тул байнга элсэн шуурга болдог бөгөөд хамгийн халуун салхитай бүс болно. Нөгөөтэйгүүр өвлийн улиралд цасан шуурга болж, цаг агаарын хүнд нөхцөлийг бий болгодог. Сайншанд нь Улаанбаатар хотоос 450 км зайтай оршдог бөгөөд улсын чанартай А0102/0103 босоо тэнхлэгийн авто зам болон төмөр зам дагуу оршдог.

Аймгийн нийт газар нутгийн ердөө 1.5% ойн сан бүхий газар бөгөөд 122 га талбайд газар тариалан эрхэлдэг байна. Томоохон гол мөрөн байхгүй, усны нөөцийн хувьд газар доорх ус, жижиг нуур, гол, булаг шанд зэргээс ундны усны хэрэгцээгээ хангадаг.

Ан амьтадын хувьд хулан, аргаль, янгир, хар сүүлт, цагаан зээр зэрэг олон төрөл зүйлийн зэрлэг ан амьтад байдаг.

### Зураг 7.5.3 Дорноговь аймгийн байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

Дорноговь аймаг 2017 оны байдлаар 68,192 хүн амтай, хүн амын нягтрал нь 0.62 хүн/км<sup>2</sup> байсан. Хүн амын жилийн дундаж өсөлт 2000-2010 онд -1.93% байсан бол 2010-2017 онд 1.93% болж өссөн.

Дорноговь аймгийн эдийн засгийн голлох салбар нь үйлчилгээний салбар бөгөөд

2017 онд ДНБ-ний 51 хувийг эзэлж байсан. Үүнд аялал жуулчлалын салбар ихээхэн хувь нэмэр оруулдаг. Дорноговь аймагт уламжлалт мал аж ахуй зонхилдог бөгөөд 2017 оны байдлаар бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 35 гарсан ба үүгээрээ улсад 20-рт жагссан байна. Гэвч нэг малчин өрхөд ногдох малын тоо 2017 онд 480 мал байж, улсад 5-рт оржээ. Нийт өрхүүдийн 23% нь мал аж ахуй эрхэлдэг ба үүгээрээ улсад 17-р байранд оржээ.

Дорноговь аймгийн аж үйлдвэрийн салбарын борлуулалтын орлого 2017 онд 272.8 тэрбумд хүрч улсын хэмжээнд 4-р байранд эрэмбэлэгдсэн бөгөөд энэ нь ДНБ-ний 91.05 хувьтай тэнцэх ба улсын хэмжээнд 3-рт оржээ. Үүнд уул уурхайн үйл ажиллагаа ихээхэн нөлөөлсөн байна. Харин нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2016 онд 4,451,000 төгрөг байсан ба улсад 12-р байранд, хөдөлмөрийн бүтээмжийн хувьд харьцангуй бага буюу 9,541,000 төгрөгөөр 14-р байранд тус тус оржээ.

Дорноговь аймагт 2017 оны байдлаар нийт 1,069 бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллага (17-р байр) байсан ба үүнд хувийн хэвшлийн эзлэх хувь хэмжээ харьцангуй бага буюу 886 байсан бөгөөд улсад 12-рт орж байжээ. Уул уурхайн, хүнсний, цементийн, барилгын үйлдвэр зэрэг нийт 34 томоохон хувийн хэвшилтэй ба мөн 50 гаруй тооны жижиг, дунд үйлдвэрүүд байдаг. Гэсэн хэдий ч өндөр цалинтай томоохон үйлдвэрүүд болон бага цалинтай жижиг үйлдвэрүүд хоорондын цалингийн ялгаатай байдал нь эдийн засгийн бүтцийг 2 хэсэгт хуваасан буюу сулруулж байгаа нь ажиглагдаж байна.

Нийгмийн асуудлын хувьд нийт хүн амд эзлэх хөдөлмөрийн насны хүн ам харьцангуй бага буюу 63.3% байгаа нь 2017 оны улсын дундаж үзүүлэлт болох 67.7%-иас бага гарсан байна. Төслийн багаас Дорноговь аймгийн хөгжлийн асуудлаар аймагт очиж хэлэлцүүлэг зохион байгуулсан ба 4 баг болж ажилласан. Хэлэлцүүлэгт оролцогчдын дурдсанаар 2000 оноос хойш хүн ам өссөн нь шилжилт хөдөлгөөнөөс илүү төрөлтийн тоо өссөнтэй холбоотой байна. Сарын дундаж цалин харьцангуй өндөр буюу 839,000 төгрөг гарч, улсад 4-рт жагссан нь цалингийн зөрүүтэй байдлын бас нэг үр нөлөөг харуулж байна. Дорноговь аймгийн ерөнхий боловсролын чанар төв суурин газарт харьцангуй өндөр гэж харагдаж байгаа ч сурагч-багшийн харьцааны хувьд бага боловсрол 18-рт, дунд боловсрол 19-рт тус тус жагсжээ. Мөн сурагчид 3 ээлжээр хичээллэсээр байна. 10,000 хүнд ногдох халдварт өвчний тархалтын тоо 101 буюу улсад 13-рт, нэг хүнд ногдох эмчийн тоо 304 буюу улсад 2-рт тус тус оржээ.

#### Орон зайн төлөвлөлт ба дэд бүтцийн хөгжил

Дорноговь аймгийн хотжилтын түвшин 2017 онд 63.1%-д хүрч харьцангуй өндөр гарчээ. Аймгийн төв Сайншанд сумын хүн ам 2017 онд 24,772 байсан.

Сайншанд хот БНХАУ-тай хиллэдэг Замын-Үүд сум болон Говьсүмбэр аймгийн төв Чойрын дунд байрлах бөгөөд харьцангуй сайн чанарын авто замаар холбогддог хэдий ч тээвэр, логистикийн гол ачаа урсгалыг нэвтрүүлэхэд хангалтай өргөн зам биш. Түүнчлэн зорчигч, ачаа тээврийн гол ачааллыг төмөр зам үүрдэг.

1000 хүнд ногдох суурин утасны цэгийн тоогоор улсад 2-р байр, ус хангамжийн цэгийн тоогоор 4-р байр, хөдөлмөрийн насны хүн амын эзэмших авто машины тоогоор 3-р байранд тус тус орсон буюу дэд бүтцийн хүртээмж харьцангуй өндөр байгааг харуулж байна. Гэхдээ харилцаа холбооны технологийн түвшингээр улсад 21-рт, мэдээллийн хүртээмжээр 18-рт тус тус орсон буюу доогуур

үзүүлэлттэй гарсан байна. Хатанбулаг сумаас бусад авто зам, төмөр замаас алслагдмал бүх сумд шилэн кабельд холбогдсон.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Хагас цөлжилт бүхий эрс тэс уур амьсгал нь аймгийн хөгжилд тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Урд хил орчмын цөлжилт анхаарал татсан асуудлын нэг болж байна. Сайншанд сум улсын чанартай авто зам, төмөр зам дагуу стратегийн хувьд сайн байршилтай хэдий ч эдийн засгаа сайжруулахад хүн ам, зах зээл нь хэтэрхий бага байна.

Ус хангамжийн хүртээмж сумдад харилцан адилгүй, Сайншанд хот 27 км зайтай газраас ундны усаа хангадаг. Бусад сумд 100-150м гүнээс газар доорх усны нөөцөд түшиглэсэн. Мөн зарим сумдад усны хатуулаг их байдаг. Замын-Үүд суманд усны хомсдол байдаг талаар хэлэлцүүлэгт оролцогчид онцолж байсан.

Томоохон болон жижиг аж ахуйн нэгж байгууллагын хоорондох цалингийн ихээхэн зөрүүтэй байдал нь эдийн засгийн бүтцийг сулруулж, цаашлаад аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд тулгарч буй гол бэрхшээл болж байна. ДНБ-ний дийлэнхийг үйлчилгээний салбар бүрдүүлж байгаа хэдий ч томоохон уул уурхайн компаниудын үйл ажиллагаа үйлчилгээний салбартай шууд уялддаггүй. Түүнчлэн бага орлого, худалдан авах чадвар доогуур зэрэг хүчин зүйлс нь орон нутгийн үйлдвэрлэлийн хөгжлийг хязгаарлаж байна. Үүнээс харахад аймгийн санхүүгийн суурь нөөц боломж хязгаарлагдмал байгаа учраас хөдөө сумдаар нийгмийн үйлчилгээг хүргэх, дэд бүтцийг бий болгоход хүндрэлтэй байна. Хэлэлцүүлгийн үеэр зарим оролцогчид эдийн засгийн үр ашиггүй уул уурхайн тусгай зөвшөөрлүүд олгогдсон гэж онцолсон.

Хэлэлцүүлэгт оролцогчид төрийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлууд хөгжлийг сааруулж байгааг онцолж байв. 1. Аймгийн хөгжлийн тогтворгүй бодлого 2. Маш олон лиценз, шаардлагууд нь бизнес эрхлэхэд төвөг учруулдаг 3. Газрын менежмент, төлөвлөлт байхгүй 4. Өндөр татвар болон гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах эрх зүйн орчин байхгүй. Мөн мал аж ахуйн хөгжилд бэлчээрийн хомсдол болон ариун цэврийн шаардлага хангасан аялал жуулчлалын чанартай материаллаг баазын хүрэлцээ хангамж асуудал болж байна.

## **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Сайншанд нь стратегийн байршлын хувьд одоогоор хүн ам цөөн, цаашид хотыг дайран өнгөрөх босоо тэнхлэгийн дагуух хот, суурингуудыг холбосон замыг сайжруулах шаардлагатай. Сайншандыг үйлчилгээний салбар ялангуяа логистик болон аялал жуулчлалын төв болгож, Сайншанд – Замын-Үүдийн хөгжлийн коридорыг хөгжүүлэх боломжтой. Сайншандыг музей, хүний гараар хийгдсэн үзмэрийн газрууд болон археологийн олдворуудтай байгалийн ер бусын үзэсгэлэнт говь цөлийн, хилийн хотууд болон шоппингийн гэсэн аялал жуулчлалын сүлжээ болгон хөгжүүлж болно. Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийг цаашид хилийн чөлөөт бүс/хот болгон хөгжүүлэх шаардлагатай.

Иргэд чихэр өвс зэрэг эмийн ургамлуудыг олон янзаар ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж амьжиргааны эх үүсвэрээ хангах боломжтой. Эмийн ургамал, тарвас, арвайн будаагаар янз бүрийн бүтээгдэхүүн хийж, жуулчдад шууд худалдах, экспортод гаргах боломжтой.

Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг явуулснаар жуулчдын сонирхолыг татсан олон үзэсгэлэнт газрууд хадгалагдан хамгаалагдана. Жоншны үйлдвэрлэл, Зүүнбаянгийн нефть боловсруулах үйлдвэр, Алтанширээгийн алт, төмөр, уран, мөн битумын ордыг ашиглах боломжтой. Эдгээр уурхайгаас олсон үр ашгийг дэд бүтэц, орон нутгийн санхүүгийн чадавхыг сайжруулахын зэрэгцээ нийгмийн салбарын хөгжүүлэхэд чухал дэмжлэг болно. Уул уурхайгаас олсон ашгаас Олон нийтийн хөгжлийн санг бий болгож, нийгмийн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж болох юм.

Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг явуулах нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажлын байр нэмэгдүүлж, олон нийтийн хөгжлийн сан бүрдүүлэх боломжийг бий болгоно. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг үйл ажиллагаа болон дүрэм журмаар дэмжих хэрэгтэй. Уул уурхайн чиглэлээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын нэг жишээг дараах Зурагт үзүүлэв.

Дорноговь аймаг нь аялал жуулчлалын арвин нөөцтэй, эмзэг байгаль экологитойн хувьд байгаль орчинд ээлтэй шинэлэг технологийг нэвтрүүлсэн үлгэр жишээ аймаг болох боломжтой. Жишээ нь найдвартай усны менежмент бүхий бохир усыг дахин ашиглах технологийг нэвтрүүлж болно. Өсөн нэмэгдэж байгаа хүн ам, жуулчид ирэхийн хирээр нийгмийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай. Хээрийн болон говь хээрийн бүсэд байгаль орчныг хэрхэн тогтвортой хамгаалж, ашиглаж буй талаар иргэдийн байгаль орчны боловсролыг дээшлүүлж, нийтэд түгээх онцгой шаардлагатай. Орон нутагт ургасан эмийн ургамлаар хийсэн эм бэлдмэлийг эрүүл мэндийн салбарт дэлгэрүүлж болно. Мэргэшсэн инженер, сувилагч дутагдаж байгааг ч шийдэж болох юм.

Японы MEGATECH корпорацийн хөрөнгө оруулалттай Мегатех Монгол ХХК нь нь цахиур баяжуулах үйлдвэр байгуулах боломжийг 10 жилийн өмнөөс судалж, улмаар 2019 оны 6-р сард үйлдвэрээ бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Үйлдвэрийн хүчин чадал нь 1 сард 200-400 тонн бөгөөд Сайншанд хотоос 90 км –т түүхий эдээ олборлоно. Түүхий эдийн нөөц нь 400 орчим жил ашиглах боломжтой бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Япон, Солонгос, БНХАУ-д экспортлохоор төлөвлөж байна.

#### Зураг: Сайншанд дах цахиур баяжуулах үйлдвэр



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг



### 7.5.4 Өмнөговь аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал

##### Газар зүйн нөхцөл байдал

Өмнөговь аймаг нь Монгол Улсын өмнөд хэсэгт оршдог, хамгийн том газар нутагтай буюу 165,000 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй аймаг юм. Дундговь, Дорноговь,




Баянхонгор, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг. Өмнөговь аймгийн нийт нутаг дэвсгэр говь цөлийн бүсэд багтана. Алтайн нурууны хамгийн зүүн үргэлжлэл, Говь гурван сайхан, Сэврэй, Ноён Богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтан уул, Гилбэнт зэрэг далайн түвшнээс дээш 3000 м-ийн өндөр уулсууд энэ нутагт оршино. Аймгийн төв Даланзадгад нь Улаанбаатар хотоос 550 км-ийн зайтай орших бөгөөд босоо тэнхлэгийн дэд замын дагуу байрладаг.

753,700 га ойн сан бүхий газар нутагтай боловч 185 га тариалангийн талбайтай. Өмнөговь аймагт том нуур, голууд байдаггүй ч зарим газар баянбүрд, жижиг нуур цөөрөм бий. Газрын гүний усны нөөц 260.5 сая м<sup>3</sup> гэж тооцоологдсон.

Өмнөговь аймаг нь аргаль, янгир, ирвэс, хар сүүлт, мазаалай, өмхий хүрэн, мануул, шилүүс, суусар, зээр зэрэг ховордсон зэрлэг ан амьтадтай. Өмнөговь аймагт цөлийн, халуун уур амьсгалд тэсвэртэй эмийн ургамал, 250 гаруй зүйлийн жижиг навчит, тэжээллэг, тачирхан ургамал ургадаг.

**Зураг 7.5.4 Өмнөговь аймгийн байршил**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймгийн хүн ам 2017 онд 65,600 байсан бөгөөд хүн амын нягтрал 0.39/км<sup>2</sup> байсан. Хүн амын жилийн дундаж өсөлт 2000-2010 онд 2.80%, 2010-2015 онд 0.11% болсон байна.

Өмнөговь аймгийн эдийн засаг бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй сайн, БДНБ-ний хэмжээ 540 сая төгрөг (4-р байр) байсан бөгөөд нэг хүнд ногдох БДНБ-ий хэмжээгээр улсын хэмжээнд 3-р байранд жагссан. Мөн дундаж цалин 858,000 төгрөг байсан нь улсад 3-р байранд жагсжээ. 2017 онд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь нь 47.1 байснаар улсад 13-р байранд жагссан байна. Ажил эрхлэлтийн хувь хэмжээ 83.5% байсан нь улсад сүүлээсээ 2-р байранд жагсаж байна. Аймгийн эдийн засагт уул уурхайн үйл ажиллагаа давамгайлж, аж үйлдвэр болон барилгын салбарын үйл ажиллагаа хязгаарлагдмал байна.

Өмнөговь аймгийн аж үйлдвэр, барилгын салбар 2017 онд БДНБ-ий 53%-ийг эзэлж байсан. Энэхүү үйл ажиллагааны дийлэнх хувь Таван Толгойн нүүрсний уурхай, Оюу Толгойн зэс, алтны уурхай зэрэг Монгол Улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулдаг уул уурхайн салбарт суурилсан.

Уул уурхайн салбар нь боловсруулах үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарыг хөгжүүлэхэд түлхэц өгдөг. Өмнөговь аймгийн аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2017 онд 2055.7 тэрбум төгрөг байсан ба тус үзүүлэлтээр улсын хэмжээнд 2-т орсон байна. Энэ нь уул уурхайн үйл ажиллагаатай шууд холбоотой. 2017 онд 1,429 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байсан байснаас 1,218 нь хувийн хэвшлийн байгууллага байсан бөгөөд дээрх үзүүлэлтүүдээр улсын хэмжээнд 9-р байранд жагссан байна. Үүнээс томоохон аж ахуйн нэгж байгууллага 51 байсан нь улсад 4-р байранд жагссан байна. Эдийн засгийн бүтцийг уул уурхай, аж үйлдвэр, барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг томоохон компаниуд голчлон бүрдүүлдэг байна.

Уур амьсгал, байгалийн нөхцөл байдлаас шалтгаалан анхдагч үйлдвэрлэлийн салбар, тэр дундаа газар тариалангийн салбар БДНБ-ий дөнгөж 20%-ийг бүрдүүлж байна. МАА-н салбарын хувьд, 2017 онд нэг малчин өрхөд ногдох малын тоо 456 байсан бол нийт малын тоо 662,000 мал тоологдсон нь улсын хэмжээнд 15-р байранд жагссан байна.

Нийгмийн хөгжлийн хувьд Өмнөговь аймгийн бага, дунд боловсролын чанар нь тааруу (15-р байр) байгаа нь бага сургуулийн сурагч-багшийн зохистой харьцаа (15-р байр), дунд сургуулийн сурагч-багшийн зохистой харьцаа (11-р байр)-наас харагдаж байна. Үүнээс гадна дээд боловсролын чанарын үзүүлэлтээр улсад 19-р байранд жагссан. 2017 онд эрүүл мэндийн салбарын дэд бүтцийн хүртээмжийн байдлаар улсын хэмжээнд 17-р байранд жагссан. Нэг эмчид ногдох хүний тоо 342 байсан нь улсад 6-р байр, 10,000 хүнд тутамд ногдох халдварт өвчлөлийн тоо 109 байсан нь улсад 15-р байранд эрэмбэлэгдсэн.

### Нутаг дэвсгэр, орон зайн төлөвлөлт ба дэд бүтцийн хөгжил

Өмнөговь аймгийн хотжилтын түвшин харьцангуй доогуур 2017 онд 33.7% байсан нь өргөн уудам газар нутагтай холбоотой. 2000-2010 онд хүн ам өссөн шалтгаан нь зэргэлдээ аймгуудаас иргэд Оюу Толгойн уурхайн бүтээн байгуулалтад ажиллахаар шилжин ирсэнтэй холбоотой. Аймгийн төв Даланзадгад нь Гашуун Сухайт, Шивээхүрэнгээр дамжин БНХАУ-тай холбогдож, уул уурхай, аялал жуулчлал хосолсон хот болж байна.

2010 онд суурин телефоны шугам 1,614 байснаа 2018 онд 950 болж буурсан байна. 2010 онд уст цэгийн тоо 37 байснаа 2018 онд 71 болж өссөнөөр нэг уст цэгт ногдох хүн амын тоо 2010 онд 1,651 (16-р байр) байсан нь 2018 онд 924 (20-р байр) болж буурсан байна.

Өмнөговь аймгийн авто замын чанар муу (20-р байр) болон хүнсний аюулгүй байдал (21-р байр) -аас бусад үзүүлэлтүүд барилга болон засвар үйлчилгээ (1-р байр), тээвэр (1-р байр), харилцаа холбооны технологи (1-р байр) зэрэг дэд бүтцийн чанар, хөгжил харьцангуй өндөр байна.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Өмнөговь аймагт уул уурхайн үйлдвэрлэл илүү хөгжиж байгаа ч эдийн засгийн үр өгөөж төдийлөн сайн биш, байгаль орчны асуудал хурцаар тавигдаж байна.

БДНБ болон нэг хүнд ногдох БДНБ-ий хэмжээ өндөр байгаа нь уул уурхайн салбарын үйл ажиллагаа голлон явуулдагтай холбоотой бөгөөд ихэнхдээ энэ салбарт ажиллагсад, тэдний гэр бүлийнхэн үр ашгийг нь хүртдэг. Уул уурхайгаас бусад салбарт ажлын байрны олдоц хязгаарлагдмал байдгаас шалтгаалж ажилгүйдлийн түвшин, орлогын зөрүүтэй байдал үүсч байгаа ба эдгээр үзүүлэлтээс эдийн засгийн тэгш бус байдлыг харж болно.

Аймгийн хэлэлцүүлэгт оролцогчид уул уурхайн үйл ажиллагаанаас болж газрын доорх ус, тоос шороо, бэлчээр, цөлжилт, хөрс, амьтдад сөрөг нөлөө ихээр үзүүлж байгааг онцолсон. Үүнээс гадна уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт, гүний усны хэт хэрэглээнд төдийлөн анхаарахгүй байгааг онцлон хэлж байв. Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчдийн ногоон эдийн засгийн талаарх ойлголтын түвшингийн үзүүлэлтээр бүх аймгуудаас хамгийн доод 21-р байранд жагсаж байна.

Өмнөговь аймагт банк санхүүгийн үйлчилгээ, мэргэжлийн сургалт, бизнес эрхлэхэд хялбар зэрэг нааштай эерэг үзүүлэлтүүд байгаа ч төр, хувийн хэвшлийн түншлэл (21-р байр), гадаадын төсөл (21-р байр), шударга бус өрсөлдөөн (20-р байр) зэрэг нөхцөлүүд саад болж байна. Хүний нөөцийн хувьд чадварлаг ажиллах хүчин дутмаг (21-р байр), мэргэжилтэй боловсон хүчний шилжилт хөдөлгөөн их (20-р байр) зэрэг бэрхшээлүүд байна. Аймгийн усны нөөцийн хязгаарлагдмал байдал нь үйлдвэрлэл хөгжүүлэхэд ноцтой саад болж болзошгүй юм.

## **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Өмнөговь аймаг нь зүүн талаараа Гашуун сухайт, баруун талаараа Шивээхүрэнгийн боомтоор БНХАУ-тай хиллэдэг. Энэ байршил нь зөвхөн худалдааны чиг үүргийг гүйцэтгэх төдийгүй нэмэлт олон үүргийг хэрэгжүүлсэн газар байх ёстой.

Өмнөговь аймгийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч Таван Толгойн нүүрсний уурхай, Оюу Толгойн зэс, алтны уурхайн хөгжилд хил рүү төмөр зам тавих нь маш чухал ач холбогдолтой. Төмөр зам нь зөвхөн уул уурхайд ашиглагдаад зогсохгүй бусад ачаа тээвэр, хүн тээвэр зэрэг ирээдүйд аялал жуулчлалыг хөгжүүлэх чухал ач холбогдолтой болох юм.

Төмөр зам болон авто замын сүлжээг сайжруулах нь Монгол Улсын өмнөд хэсгийн логистикийн хөгжилд чухал дэм болно. Бусад аймгаас ирж буй зорчигч, ачаа тээвэр логистикийн төвүүдээр дамжин БНХАУ-руу холбогдох юм. Логистикийн төвийг хөгжүүлэхдээ хатуу болон зөөлөн дэд бүтцийг нь сайжруулж, дэд

коридороор хөгжүүлэх шаардлагатай. Зөөлөн дэд бүтцэд түгээлтийн тогтолцоо, хил дээр экспорт, импортын журам, гааль болон бусад холбогдох үйл явцыг хялбаршуулах зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагаа орно. Хатуу дэд бүтцэд хил дээр агуулах, өртөөний барилга байгууламжийг байгуулах ажлууд орно. Логистикийн төвийн үүрэгт Даланзадгад, Гашуун Сухайт, Шивээхүрэн зэрэг газруудын худалдаа, үйлчилгээний суурь баазууд түлхэц болно.

Таван Толгойн нүүрсний уурхай, Оюу Толгойн зэс, алтны уурхай гэх мэт уул уурхайн салбар нь ирээдүйтэй салбар боловч нийгэм, байгаль орчны асуудлыг байнга чухалчилж үзэх ёстой. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар хамгийн оновчтой бүс нутгийн хөгжлийн загвараар хөгжих ёстой. Аймгийн хэлэлцүүлгийн үеэр нийт оролцогчид уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөлд ихэд санаа зовж байгаагаа илэрхийлж байв. Үр дүнтэй зохицуулалт бүхий ногоон хөгжлийн бодлогыг томъёолж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Орон нутгийн хөгжлийн санг уул уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас олсон ашгийн тодорхой хувийг ашиглалтын талбайн эргэн тойронд болон ойр орчмын иргэдийн амьдрах орчныг сайжруулах, нийгмийн дэд бүтцийг сайжруулахад зарцуулах ёстой. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой усны нөөцийн менежмент нь ногоон хөгжлийн бодлогын нэгэн чухал хэсэг байдаг. Газрын гүний усны хомсдолоос сэргийлэх зорилгоор ус дамжуулах хоолой барихаар төлөвлөж байгааг сайтар шалгаж нягтлах ёстой.

Ухаалаг утас, тоног төхөөрөмжийн хэрэглээгээр Өмнөговь аймаг 1-р байранд орсон бөгөөд энэ давуу талаа ашиглан зарим салбарт мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглан шинээр ажлын байр бий болгож болно. Олборлох шатны үйлдвэрлэлийн шатанд дрон ашигласан хяналт мониторингийн урьдчилан сэргийлэх систем, БНХАУ руу интернетийн худалдаа хийх, бүтээгдэхүүний байршлыг тогтоох, агро-технологийн парк зэрэгт мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглаж болох юм. Аймаг болон орон нутгийн иргэд ялангуяа малчидтай харилцах харилцааг сайжруулахад мэдээлэл харилцаа холбооны технологийг Өмнөговь аймагт туршин хэрэгжүүлж болох юм.

Өмнөговь аймаг нь Ёлын ам, Баянзаг, Галуут хад зэрэг цэвэр агаар, байгалийн өвөрмөц тогтоцтой аялал жуулчлалын түшиц газруудыг түшиглэж аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломжтой.

Хөрш зэргэлдээ аймгуудтай хамтран говийн нутгийн брэндийг сурталчилсан мах, сүүн бүтээгдэхүүн, ноос ноолуур, гоёо, халгай зэргээр өндөр чанартай өөрийн гэсэн хэв загвар, дүр төрхийг шингээсэн бүтээгдэхүүн бий болгох, сурталчлах ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Говийн бүсийн бусад аймгуудын нэгэн адил нар, салхины сэргээгдэх эрчим хүчний асар их нөөц бий. Говийн бүсэд сэргээгдэх эрчим хүчийг туршиж үзэх зорилгоор Өмнөговь аймагт сэргээгдэх эрчим хүчний загвар хүрээлэн байгуулж болно.

## **7.6 Зүүн бүсийн аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ**

### **7.6.1 Хэнтий аймаг**

#### **(1) Одоогийн нөхцөл байдал**

##### Газар зүйн нөхцөл байдал

Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ 80,300 км<sup>2</sup> бөгөөд нутаг дэвсгэрийн


---



хэмжээгээрээ улсад 9-р байранд ордог. Аймгийн төв Өндөрхаан хот нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 335 км зайтай оршино. Хэнтий аймаг нь Евразийн шилмүүст ой болон Төв Азийн хээрийн бүсэд оршдог. Аймгийн хойд хэсэгт орших Хан Хэнтийн дархан цаазат газар нь 1.2 сая га талбай бүхий нутаг дэвсгэрийг хамардаг. Аймгийн хамгийн өндөр цэг нь Асралт Хайрхан бөгөөд далайн түвшнээс дээш 2800 метр өргөгдсөн. Аймгийн нутаг дэвсгэрээр гурван том гол дайран урсдаг бөгөөд Туул гол ОХУ-ын Байгаль нуурт цутгадаг бол Онон, Хэрлэн гол нь Амар мөрнөөр дамжин Номхон далайд хүрч усаа юүлдэг.

Ойн сангийн хэмжээ 11,301 км<sup>2</sup> ба аймгийн нийт нутаг дэвсгэрийн 14.1%-ийг эзэлдэг. Аймгийн газар нутаг нь маш чухал экологийн бүсэд хамаардаг бөгөөд олон төрөл зүйлийн ургамал, цэцэгсээр баялаг. Зэрлэг ан амьтад, нэн ховордсон хүдэр, хандгай, хүрэн баавгай, чоно, шилүүс, дорго, элбэнх, үен, булга, бор гөрөөс, шивэр хандгай болон олон төрөл зүйлийн шувууд байдаг.

**Зураг 7.6.1 Хэнтий аймгийн байршил**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

**Нийгэм, эдийн засаг**

Хэнтий аймгийн хүн ам 2017 онд 75,700 байсан бөгөөд 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0.94

хүн амьдардаг . 1990-2000 онд хүн ам жилд дундажаар -0.57% -иар буурч байсан бол 2010-2017 онд 1.47%-иар өсөж, 2010 оноос хойш хүн ам өссөн хэвээр байна.

Хэнтий аймгийн эдийн засгийн голлох салбар нь хөдөө аж ахуйн салбар бөгөөд 2017 оны байдлаар хөдөө аж ахуйн салбар нь БДНБ-ийн 59.7%-ийг бүрдүүлсэн байна. 2017 онд 1,216,000 толгой мал тоологдож улсын хэмжээнд 5-р байранд, малтай нэг өрхөд 562 мал ногдож улсын хэмжээнд 2-р байранд тус тус орсон. Мөн тухайн онд мал аж ахуй эрхэлдэг өрх нь аймгийн нийт өрхийн 45.2%-ийг эзэлж байсан байна. Хэнтий аймаг газар тариалангийн үйлдвэрлэлээр улсдаа дээгүүр тооцогддог. 2017 оны байдлаар 28,143 га тариалангийн эргэлтийн талбайтай байсан бөгөөд үүнээс 19,170 га-д үр тариа, 170 га-д төмс, хүний ногоо тариалсан байна.

2017 оны байдлаар нэг хүнд ногдох БДНБ нь 4,498,000 төгрөгтэй тэнцэж улсдаа 11-р байранд , нэг ажилтанд ногдох хөдөлмөрийн бүтээмж нь 11,702,000 төгрөгтэй тэнцэж улсдаа 8-р байранд тус тус орсон байна. Цаг агаарын таатай нөхцөл байдал мал аж ахуй эрхлэлтэд эерэгээр нөлөөлж, 2017 оны байдлаар хөдөө аж ахуйн салбар ДНБ-ий 12.5%-ийг эзэлжээ. Гэвч боловсруулах үйлдвэрлэлийн салбарын борлуулалт 5.7 тэрбум төгрөг байсан нь улсын хэмжээнд 19-р байранд орсон бөгөөд БДНБ-ий 1.70% (20-р байр)-ийг эзэлсэн байна.

2017 оны байдлаар Хэнтий аймгийн нийт аж ахуйн нэгж байгууллагын тоо 1,087 (14-р байр) байсан бөгөөд үүнээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага 892 (14-р байр), томоохон аж ахуйн нэгж 25 (18-р байр) бүртгэгдсэн байна. Хэнтий аймгийн банк санхүүгийн үйлчилгээ харьцангуй сайн (4-байр) бөгөөд банкны нийт 75 салбар үйл ажиллагаа явуулж байна. Хэнтий аймаг нь Монгол улсын түүх, өв соёлын өлгий нутаг бөгөөд нийслэл Улаанбаатар хоттой ойрхон оршдог зэрэг нь энэхүү амжилтанд нөлөөлсөн.

Хэнтий аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 2017 оны байдлаар 62.3% буюу улсын хэмжээнд 20-р байранд орсон үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлтэд ажиллах хүчний оролцоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага эсвэл их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо их байгаа нь нөлөөлсөн байж болзошгүй. Хөдөө аж ахуй нь эдийн засгийн голлох салбар бөгөөд энэ салбарт эмэгтэйчүүд олноор ажиллаж байна. Тиймээс ажиллах хүчний оролцооны түвшин бага байгаа шалтгаан нь их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо их байгаатай холбоотой байж болох юм. Энэхүү таамаглалыг 2016-2017 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид элсэн суралцагчдын тоо нэмэгдсэнээр тайлбарлаж болно. Ажил хөдөлмөр эрхлэхээр Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалж, ажиллах хүчний оролцооны түвшин болон ажиллах хүчний коэффициентийн үзүүлэлт бага байгаа нь аймгийн нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь багасахад нөлөөлж байна.

Аймгийн хэмжээнд ажлын байр дутагдалтай нь ажилгүйдлийн түвшин 10.3% байгаагаас харагдаж байна. 2016 онд ядуурлын түвшин 43.8% байсан нь хамгийн их ядууралтай аймгуудын 4-рт орсон байна.

Хэнтий аймаг нь бага, дунд, ахлах ангид суралцагчдын тоогоор харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. 2017 онд 10,000 хүнд ногдох халдварт өвчний тоо 91 байснаас улсын хэмжээнд 10-р байранд орсон.

#### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

2017 оны байдлаар Хэнтий аймгийн хотжилтын түвшин 36.1% байгаа нь хөдөө аж ахуйн салбар чухал байр эзэлдэг аймгийн хувьд төдийлөн сайн үзүүлэлт биш юм.



Өндөрхаан хотоос 53 км зайд Чандганын нүүрсний уурхай мөн Бор-Өндөр, Бэрхийн жоншны уурхай үйл ажиллагаа явуулж байгаа нь хотжилтын түвшинд нөлөөлсөн. Аймгийн ихэнх сумдын хүн ам 2001-2010 онуудад буурсан ч Хэрлэн сум нь Өндөрхаан хоттой ойр, Дадал сум нь ОХУ-тай хил залгаа, Цэнхэрмандал сум нь Улаанбаатар хоттой ойр оршдогдоос шалтгаалж дээрх онуудад хүн ам нь өссөн байна.

Аймгийн төв Өндөрхаан хот нь Улаанбаатар хот болон зүүн бүсийн аймгуудыг холбосон А0501 авто зам зам болон Дорнод аймгийн Чойбалсан хотыг холбосон А0502 авто замын уулзвар, Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотыг холбосон А2001 авто замын уулзвар дээр оршдог. Мөн Өндөрхаан хотоос зүүн хойд зүгт Баян-Уул сумыг холбосон А19 авто зам нь Чойбалсан хот болон ОХУ-ын хилийн хотыг холбосон А21 авто замтай огтлолцдог.

Хэнтий аймгийн авто замын чанар харьцангуй сайн, улсад 2-р байранд ордог боловч хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тээврийн хэрэгслийн тоо 8 байдаг нь сонирхолтой үзүүлэлт юм. Бусад дэд бүтцийн хөгжил бусад аймгуудтай харьцуулахад дундаж үзүүлэлттэй байна. 1,000 хүнд ногдох телефон утасны шугам нь 10 (10-р байр), 1,000 өрхөд ногдох ус түгээх цэг 4 (11-р байр), дулааны эрчим хүчний үнэ 620төг/м<sup>2</sup> (18-р байр), цахилгаан үүсгүүртэй малчин өрх 82.0% (11-р байр), шатахууны үнэ 1,555 төг/л (9-р байр) зэрэг статистикийн мэдээлэл байна.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

2017 оны байдлаар аймгийн төвийн хүн амын тоо 20,935 байсан. Аж ахуйн нэгж байгууллагын тоо цөөн, үйл ажиллагааны чиглэл нь төрөлжөөгүй, 2017 онд бүсийн ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 12.5 байсан байна. Хэнтий аймагт ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин өндөр, хүн амын гадагш чиглэх шилжилт хөдөлгөөн их зэрэг асуудлууд тулгарч байна. Хэдийгээр боловсролын салбарт бага зэрэг ахиц дэвшил гарч байгаа ч дээд боловсролын чанар муу, ур чадвартай ажиллах хүчний тоогоор 2018 онд улсад 19-р байранд орсон байна.

Хэнтий аймгийн эдийн засгийн бүтэц сул байгаагаас шалтгаалж моргейжийн зээлэнд хамрагдах боломж хязгаарлагдмал, хөрөнгийн хуримтлал хангалтгүй зэрэг иргэдийн худалдан авах чадвар муу байна. Аж үйлдвэрийн салбар хөгжөөгүй, томоохон үйлдвэрүүд цөөн байна.

Нийт ажиллагсадын 16.1%-ийг төрийн албан хаагчид эзэлж байгаа (5-р байр) бөгөөд төсвийн алдагдал ихтэй. Төрөөс үзүүлж буй нийгмийн үйлчилгээ хангалтгүй.

Аймагт зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн үеэр оролцогчид 4 багт хуваагдан, Хэнтий аймагт тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон. Үүнд: 1) Ажилгүйдэл, ядуурал 2) Аж үйлдвэрийн хөгжил сул 3) Дэд бүтэц хангалтгүй 4) Аялал жуулчлал хөгжөөгүй 5) Бэлчээрийн доройтол, цөлжилт, усны нөөц багасах, агаар, хөрсний бохирдол, усны чанар, орчны эрүүл ахуй зэрэг байгаль орчны асуудлууд.

## **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Хэнтий аймаг нь мал аж ахуй, газар тариалан хөгжүүлэхэд нэн таатай үржил шимт хөрстэй, усны нөөц ихтэй. Эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг малын тэжээлийн тариалалттай хослуулан хөгжүүлэх боломжтой. Байгалийн бүс, бүслүүрийн давуу талыг ашиглан үр тариа, төмс хүнсний ногоо тариалах, мал аж

ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хот, суурин газрын зах зээлд нийлүүлэх улмаар экспортод гаргах боломжтой. Хэнтий аймгаар дайран Зүүн бүсийн аймгуудад хүрэх газар зүйн байршлын давуу талыг ашиглан мах, сүү, цагаан идээ боловсруулж, Улаанбаатар хот, бусад суурин газруудын зах зээлд борлуулах боломжтой.

Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлж, ойн нөөцөд тулгуурлан бараа бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэх боломжтой. Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг цемент, бетон блок, тоосго болон олон төрлийн модон эдлэл үйлдвэрлэхэд төрөөс бодлогоор дэмжих шаардлагатай. Модон эдлэлийн хувьд ойн нөөц хязгаарлагдмал учраас хаягдал бага гаргах сайн чанарын боловсруулсан зоргодсон хавтан (OSB) болон гуалин үйлдвэрлэх боломжтой.

Нүүрс, жоншны олборлолтоос гадна утаат болор, асбест, гянт болд, төмөр, алт, мөнгө, зэс зэрэг ашигт малтмалыг олборлох боломжтой. Эдгээрийг олборлохоос өмнө уул уурхайгаас олох орлого, хариуцлагатай уул уурхай, уурхайн нөхөн сэргээлт хийх зардал зэргийг сайтар тооцох ёстой.

Дунд болон урт хугацаанд аялал жуулчлалыг хөгжүүлэх нь үр өгөөжтэй. Хан Хэнтийн тусгай хамгаалалтай газар нутаг дахь байгалийн аялал жуулчлалын маршрутыг Тэрэлжийн Байгалийн цогцолборт газартай уялдуулах хэрэгтэй. Зэрлэг ан амьтантай холбогдолтой аялал жуулчлалын маршрутыг Онон, Балжийн Байгалийн цогцолборт газар болон Дадал сумын түүх, соёлтой холбож хөгжүүлэх боломжтой.

Чингис хааны үеийн соёл, шашинтай холбоотой хот суурин, эд өлгийн зүйлс, газар нутгийг хадгалж хамгаалан, арчилж тордсоноор түүх, соёлын үнэт өвд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх асар их боломж бий. Гурван нуурын рашаан зэрэг эмчилгээ, алжаал тайлах газрууд, эмийн ургамлын нөөцийг ашиглан жуулчдад үйлчилгээ үзүүлэх нь дунд болон урт хугацаанд маш их үр өгөөж өгнө.

Аялал жуулчлалын салбараар дамжуулан нутгийн иргэдийн гар урлалын бүтээгдэхүүн, онцлог хоол, байгалийн цэвэр жимс жимсгэнэ, хүнсний ногоо зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх боломжтой. Морь, тэмээ унуулах, орон нутгийн бэсрэг наадам зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа нь нүүдлийн соёлыг сурталчилах онцгой ач холбогдолтой. Монгол гэрт саатаж, үнээ, гүү саах, мал хариулах зэрэг жуулчдад сонирхолтой, сэтгэлд хоногшим дурсамжийг үлдээх боломжтой. Орон нутгийн онцлогийг шингээсэн онцлог бүтээгдэхүүн хөгжүүлэх, маркетинг явуулах нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд түлхэц болно.

Хэнтий аймгийн хөгжилд Өндөрхааны хот байгуулалтын бодлого нь онцгой чухал үүрэгтэй. Өндөрхааныг зүүн бүсийн аялал жуулчлалын гол хаалга, барилгын материал нийлүүлэх бааз суурь, фермерийн аж ахуйн төв, ногоон хөгжлийн загвар хот зэрэг олон талт хот болж хөгжүүлэх хэрэгтэй.

## **7.6.2 Сүхбаатар аймаг**

### **(1) Одоогийн нөхцөл байдал**


#### Газар зүйн нөхцөл байдал

Сүхбаатар аймгийн газар нутгийн хэмжээ 82,287 км<sup>2</sup> ба нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ улсад 8-р байранд ордог. Аймгийн төв Баруун-Урт нь Улаанбаатар хотоос 549 км зайтай, Улаанбаатар-Хэнтий аймгийг холбосон А2001 авто зам,

БНХАУ-тай хил залгаа Бичигт хүрэх А2002 авто зам болон Чойбалсан хүрэх А22 авто замын гол зангилаа дээр оршдог.

Сүхбаатар аймаг нь уулархаг, хээр тал зонхилсон газар нутагтай, далайн түвшнээс дээш 1,000-1,200 метр өргөгдсөн. БНХАУ-тай хиллэдэг хэсэгтээ сунаж тогтсон галт уултай. Нутгийн өмнөд хэсгээр элсэрхэг болон элсэн манхантай. Ойн сан нь зөвхөн 100 га талбайг эзэлдэг. Сүхбаатар аймаг нь тал хээрийн ургамлын сан хөмрөг арвинтай, цагаан зээр, тарвага, үнэг, чоно, хярс, дорго, зурам, шилүүс зэрэг ан амьтан нутагладаг. 8 -10-р сард Ганга нууранд хун шувууд хуран чуулдаг.

### Зураг 7.6.2 Сүхбаатар аймгийн байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (БОАЖЯ-ны зургийг ашиглав).

### Нийгэм, эдийн засаг

Сүхбаатар аймгийн хүн ам 2017 онд 61,323 байсан бөгөөд 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0.75 хүн амьдардаг . 1990-2000 онд хүн ам жилд дунджаар 0.56%-иар өссөн бол

2000-2017 онд эдийн засгийн зогсонги байдал, ундны усны чанар, төрөлт бага зэргээс шалтгаалж -1.00%-иар буурсан байна. Аймгийн статистикийн газрын мэдээлэл болон хэлэлцүүлгийн үеэр 2008 оноос хүн ам өсөж эхэлсэн шалтгааныг дэд бүтэц сайжирсантай холбоотойгоор амьдралын нөхцөл, ажил эрхлэлтийн таатай орчин бүрдсэн гэж тайлбарласан.

Эдийн засгийн голлох салбар нь эрчимжсэн болон бэлчээрийн мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд малчдын тоо болон малын тоо толгой өсөж байна. Ажиллах хүчний оролцооны түвшин харьцангуй өндөр. Малтай нэг өрхөд ногдох малын тоо 463 (улсад 6-р байр), 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоо 87 (улсад 14-р байр) байна. 2017 оны байдлаар нийт өрхийн 56.6% нь мал аж ахуй эрхэлдэг. 9,219 га тариалангийн талбайтай бөгөөд 2017 онд 7,481 га талбайд үр тариа тарьсан байна.

Хэдийгээр эдийн засгийн голлох салбар нь хөдөө аж ахуй боловч боловсруулах үйлдвэр тэр дундаа барилгын материалын үйлдвэрлэлийн БДНБ-д эзлэх хувь 49% байна (2017 он). Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага болон томоохон аж ахуйн нэгж байгууллагын тоо цөөн байна. Хүнсний, ноолуурын болон барилгын материалын үйлдвэрүүд зонхилдог.

Сүхбаатар аймагт Төмөртэйн цайр болон Тал Булагийн нүүрсний уурхай үйл ажиллагаа явуулдаг. Төмөртэйн цайрын уурхай нь Баруун-Урт сумын ойр байршдаг бөгөөд Монгол-Хятадын хамтарсан Цайрт Минерал ХХК компани эзэмшдэг. Энэ уурхай нь Монгол Улсын стратегийн орд газарт тооцогддог. Тал Булаг нүүрсний уурхай нь аймгийн төвөөс баруун хойд зүгт байрладаг. Сүхбаатар аймгийн нэг хүнд ногдох БДНБ 6,836,000 төгрөг, хөдөлмөрийн бүтээмж 15,835,000 төгрөг (4-р байр) –ийн үзүүлэлттэй байгаа нь уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой.

Бага, дунд сургуулийн нэг багшид ногдох сурагчдын тоо болон ЕБС-д элсэн суралцагчдын тоо өндөр. Хэлэлцүүлэгт оролцогчид аймгийн сургалтын чанарыг муу биш гэж дүгнэсэн. 2017 оны байдлаар аймгийн хэмжээнд 16 ЕБС үйл ажиллагаа явуулдаг бөгөөд улсад 20-р байранд ордог.

10,000 хүнд ногдох халдварт өвчний тоо 2017 онд 208 байсан. Хэлэлцүүлэгт оролцогчид ундны усны чанараас шалтгаалж элэг, хоол боловсруулах системийн өвчлөл ихсэж байгааг онцолсон. Мөн боловсрол болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц хүрэлцэхгүй, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас гаргаж буй бодлого сул гэж онцолсон.

#### Орон зайн төлөвлөлт ба дэд бүтцийн хөгжил

2017 оны байдлаар Сүхбаатар аймгийн хэмжээнд хотжилтын түвшин 29% байсан. Ийнхүү харьцангуй бага байгаа шалтгаан нь газар тариалан эрхэлдэгтэй холбоотой. Сүүлийн жилүүдэд зэргэлдээ аймгаас малчид шилжин суурьшиж, хүн амын тоо өсч байна. Аймгийн төв, суурин газар руу шилжин ирэгсэд нэмэгдэхгүй байгаа нь боловсруулах үйлдвэр болон үйлчилгээний салбарын ажлын байрны хүрэлцээ муутай холбоотой.

Дээр дурдсанаар Баруун-Урт нь баруун хойноос зүүн өмнө рүү чиглэсэн авто замын уулзвар, зүүн хойд чиглэлийн Чойбалсан хот хүрэх авто замын уулзварт оршдог. Хятадын хилтэй залгаа оршдог Бичигт чиглэлийн А2002 авто замтай холбогддог. Зөвхөн аймгийн баруун өмнөд тал руу чиглэсэн авто замын сүлжээ одоогоор хангалтгүй байна.

Сүхбаатар аймгийн дэд бүтцийн хөгжил сайжирч амьдрах, ажиллах орчин дээшилж байгаа ч инженерийн дэд бүтцийн хангамж тийм ч сайн биш, харин авто замын чанар харьцангуй сайн. 2017 онд 1,000 хүнд ногдох телефон утасны шугам 8 (15-р байр), дулааны эрчим хүчний үнэ 616 төг/м<sup>2</sup> (16-р байр), шатахууны үнэ 1,627 төг/литр (17-р байр), цахилгаан үүсгүүртэй малчин өрх 88.5% (6-р байр), 1,000 өрхөд ногдох уст цэгийн тоо 6 (4-р байр) гэсэн үзүүлэлттэй байв.

## **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд нутгийн өмнөд хэсгээр цөлжилт эрчимтэй явагдаж байна. Аймгийн төвийн хүн амын тоо харьцангуй цөөн 2017 оны байдлаар 18,190 байна. Баруун-Урт сумын ус хүхэртэй, ус хангамж зөвхөн нэг эх үүсвэртэй зэрэг хот байгуулалтын асуудал тулгарч байна. Аж ахуйн нэгж байгууллагын тоо харьцангуй цөөн, төрөлжөөгүй, үйлчилгээний салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөө сул байна. Иргэд бага орлоготой, худалдан авах чадвар сул зэрэг нь боловсруулах салбарт сөргөөр нөлөөлж байна.

Аймгийн эдийн засгийн голлох салбар хөдөө аж ахуй боловч дэд бүтцийн хангамж муу, нийгмийн үйлчилгээ тааруу. Хэлэлцүүлэгт оролцогчид төрийн албан хаагчдын тоо хангалтгүйгээс илүүтэй нийгмийн үйлчилгээний бодлого дутмаг талаар дурдсан.

Эдийн засгийн бүтэц сулаас шалтгаалж моргейжид хамрагдах боломж муу, хөрөнгийн хуримтлал байхгүй зэрэг иргэдийн санхүүгийн чадавх муу байна. БДНБ харьцангуй өндөр, хөдөлмөрийн бүтээмж сайн байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлтэй шууд холбоотой бөгөөд хөдөөгийн хүн амын амьжиргаанд үзүүлж буй үр ашиг бага байна. Хэлэлцүүлэгт оролцогчид хэдийгээр Хятадын хөрөнгө оруулалттай цайрын уурхайгаас Орон нутгийн хөгжлийн сан байгуулсан ч тэр сангийн захиран зарцуулалт үйл ажиллагаа эргэлзээ төрүүлдэг талаар дурдсан. Оролцогчдын ихэнх нь уул уурхайгаас үүдэлтэй нийгэм, байгаль орчны асуудлууд тулгарч байгаа тул цаашид байгаль орчинд ээлтэй техник, технологи ашиглах, орон нутгийн иргэдийг чадавхжуулах, уурхайн нөхөн сэргээлт хийхийн чухлыг дурдаж байсан.

## **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Сүхбаатар аймаг нь хөдөө аж ахуй зонхилсон эдийн засагтай учраас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нь аймгийн эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүний зэрэгцээ малын гаралтай түүхий эдийг боловсруулж нэмүү өртөг шингээн экспортод гаргах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг бий болгох боломжтой. Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрийн кластер байгуулж, мах махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, арьс ширэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой. Дунд хугацаанд адуу хонины эхэсээр эм, гоо сайхны бүтээгдэхүүн, малын яс болон малаас гарч буй хаягдлаар гэрийн тэжээвэр амьтны хоол тэжээл, мөн халал махны үйлдвэрлэл зэргийг хөгжүүлж болох юм.

Эрчимжсэн мал аж ахуйг илүүтэйгээр дэмжих нь бэлчээрийн мал аж ахуйг орхигдуулна гэсэн үг биш юм. Аймгийн хувьд усны нөөц багатай учраас эрчимжсэн болон бэлчээрийн мал аж ахуйг тэнцвэртэй хөгжүүлэх нь зүйтэй. Мэдээж малаа бэлчээрлүүлэх эсвэл ус зөөж эрчимжсэн мал аж ахуйд ашиглахын нь аль дээр вэ гэдэг нь ойлгомжтой.

Эрчимжсэн болон уламжлалт мал аж ахуйг цаашид хөгжүүлэх урьдчилсан нөхцөл болгон ойрын ирээдүйд малын өвчингүй бүс байгуулах ёстой. Дунд болон урт

хугацаанд мал аж ахуйг хөгжүүлэхийн тулд эхний ээлжинд уламжлалт болон өндөр ашиг шимт малын удмын санг бий болгох шаардлагатай.

Уул уурхайн олборлолт аймгийн нийгэм, байгаль орчинд сөргөөр нөлөө үзүүлж байгаа учраас хариуцлагатай, уян хатан уул уурхайн олборлолтыг дэмжих нь чухал. Хэлэлцүүлэгт оролцогчид уул уурхайн салбарт гадны хөрөнгө оруулагчидтай байгуулах гэрээнд тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлагатай уул уурхайг дэмжих заалт бүхий гэрээ байгуулах хэрэгтэйг онцолсон.

Мал аж ахуйд эрхлэлтэд үзүүлэх уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн нөлөөллийг хамгийн бага байлгах шаардлагатай. Уул уурхайд байгальд ээлтэй технологи ашиглах, нөхөн сэргээлт хийх зайлшгүй хэрэгтэй. Монголын тал гадаадын хамтран ажиллагч байгууллага мэргэжилтнүүдээс ур чадвар, технологийн дэвшил, арга барил, механизмыг сайтар эзэмшиж, орон нутагт хөрөнгийн хуримтлал бий болгох нь маш чухал юм. Орон нутгийн иргэдийн хөгжлийн санг байгуулж, нийгмийн дэд бүтцийг сайжруулах нь шийдлийн жишээ юм.

Сүхбаатар аймагт мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, ялангуяа арьс ширэн бүтээгдэхүүн, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн мөн хөнгөн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн, барилгын материалын үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарт гар урлалын бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг орон нутгийн ЖДҮ-ийг дэмжих замаар өргөжүүлэх боломжтой. ЖДҮ-ийг хөгжүүлэх төрийн тогтвортой бодлого хэрэгтэй байна.

Сүхбаатар аймагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж бий. Дарьгангын Ганга нуурын байгалийн цогцолборт газар (28,000 га) нь байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх асар их нөөц юм. Энэ БЦГ-т 6 нуур, Шилийн Богд уул, Талын агуй зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд байдаг. Хэлэлцүүлэгт оролцогчид нүүдлийн соёл, зан заншил, амьдралын хэв маяг, угсаатны аж амьдрал, хувцас эдлэлийг жуулчдад танилцуулах өргөн боломж байгааг дурдаж байсан. Бичигт боомтод Эдийн засгийн чөлөөт бүс байгуулбал тал хээрийн бүсийн байгалийн аялал жуулчлал болон хөрш зэргэлдээ улс орны хилийн хотуудад худалдаа хийх, аялах боломжтой. Үүнтэй холбоотойгоор Бичигт боомтын логистик төв болон бусад барилга байгууламжуудыг өргөжүүлэх хэрэгтэй.

Аялал жуулчлалыг дунд ба урт хугацаанд хөгжүүлэхэд зарим авто замыг сайжруулах шаардлагатай. Жишээ нь Эрдэнэцагаан - Дарьганга, Баруун-Урт - Бичигт боомтыг холбосон авто замыг сайжруулах онцгой шаардлагатай. Хэлэлцүүлэгт оролцогчид Улаанбаатар-Өндөрхаан-Түвшинширээ-Баяндэлгэр-Онгон-Наран-Дарьганга-Эрдэнэцагаан чиглэлийн авто замыг сайжруулах шаардлагатайг онцолсон.

Дээр дурдсанаар усан хангамжийг сайжруулах нь чухал. Хэлэлцүүлэгт оролцогчид Баруун-Урт сумын ус хангамжийн шугам сүлжээнд ус цэвэршүүлэгч суурилуулах, аймгийн хойд хэсэгт оршдог Асгат сумаас ус татах боломжийг судлах шаардлагатайг санал болгосон.



### 7.6.3 Дорнод аймаг

#### (1) Одоогийн нөхцөл байдал


##### Газар зүйн нөхцөл байдал


Дорнод аймаг нь хойд талаараа ОХУ-тай, зүүн, өмнөд талаараа БНХАУ-тай хиллэдэг Монгол Улсын хамгийн зүүн талын аймаг юм. 123,600км<sup>2</sup> газар нутагтай ба улсдаа том газар нутагтай гурав дахь аймаг юм. Нийт хүн амын тоо 79,500 бөгөөд 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0.67 хүн амьдардаг. Аймгийн нийт нутаг баруунаас зүүн тийш урсгалтай Хэрлэн, Улз зэрэг голын сав газар дагуу тэгш талд үргэлжилнэ. Аймгийн газар нутаг баруун талаараа Хэнтий аймаг, Сүхбаатар аймагтай хил залгаа, далайн түвшнээс дээш 800-1,100 м-т, зүүн талаараа 600 м-т ОХУ, БНХАУ-тай хиллэн оршдог. Уур амьсгалын хувьд тал хээрийн бүсэд хамаарагддаг бөгөөд жилийн дундаж хур тунадас 250-300 мм байдаг.

Буйр нуур нь Монголын орны томоохон цэнгэг уст нуур юм. Давст нуур болон олон тооны булаг шанд элбэгтэй. Дорнод Монгол (5,704км<sup>2</sup>), Нөмрөг (3,112км<sup>2</sup>), Монгол Дагуур (1,030 км<sup>2</sup>) гэсэн гурван тусгай хамгаалалттай газар нутагтай. Яхь нуур, Угтам, Тосон Хустай гэсэн гурван байгалийн нөөц газар байдаг.

Дорнод аймгийн ургамлын сан хөмрөг нь Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн ургамлын 10%-ийг эзэлдэг бөгөөд үүнд 40 гаруй зүйлийн өвс ургамал, 10 гаруй зүйлийн эмийн ургамал багтдаг. Дорнод аймаг нь ургамлын төрөл зүйл элбэгтэй байхын зэрэгцээ буга, хандгай, элбэнх, бодон гахай, халиу, цагаан гөрөөс зэрэг амьтад Онон, Улз голын сав газар, Хянганы нурууны орчмоор, тарвага тал хээрийн бүсүүдэд амьдардаг. Онон голын сав газарт баавгай, бодон гахай, халиу амьдардаг.

**Зураг 7.6.3 Дорнод аймгийн байршил**





Эх сурвалж: БОАЖЯ-ны зургийг ашиглаж ЖАЙКА-гийн Төслийн баг бэлтгэв.

### Нийгэм, эдийн засаг

Дорнод аймгийн хүн ам 2010 оноос хойш жилд дунджаар 2.3%-иар өсч байгаа ч, 2000-2010 онуудад -0.7%-иар буурч байсан байна. Хэлэлцүүлэгт оролцогчид хүн ам буурсан шалтгааныг ажлын байр, амьдрах орчны таатай боломжийг хайж иргэд Улаанбаатар хот руу нүүсэн бөгөөд хүн амын өсөлт нь 2010 оноос хойш аймгийн эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, ОХУ болон БНХАУ-тай худалдаа, наймаа хийх боломж нэмэгдсэн, амьдрах орчин, дэд бүтэц сайжирсан зэргээс шалтгаалсан гэж тайлбарласан. Дорнод аймгийн хүн амын 57%-ийг хот, суурин газарт амьдарч буй хүн ам эзэлдэг бөгөөд бусад аймгуудын дундаж үзүүлэлт болох 40% -иас их байгаа нь Дорнод аймагт хотжилтын түвшин өндөр байгааг харуулж байна.

Дорнод аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн ам 40.1%-ийг эзэлдэг бөгөөд энэ нь улсын хэмжээнд хамгийн бага үзүүлэлт юм. Тус үзүүлэлтээс уул уурхайгаас хэт хамааралтай, ажил эрхлэлтийн түвшин маш доогуур байгаа дүр зураг харагдаж байна.

Дорнод аймгийн нэг хүнд ногдох БДНБ нь 2018 онд 10,983,000 төгрөг байсан ба улсын хэмжээнд Орхон аймаг (17,779,000 төгрөг), Улаанбаатар хотын (14,793,000 төгрөг) дараа 3-р байранд эрэмбэлэгдсэнээр 2005 онд 20-р байранд байсан түвшинг дээшлүүлсэн байна. Газрын тосны олборлолт нь нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болсон. Дорнод аймгийн эдийн засгийн бүтцийн хувьд 2018 онд газрын тосны үйлдвэрлэл бүхий боловсруулах буюу анхдагч үйлдвэрлэлийн салбар түлхүү хөгжсөн буюу 70% байсан нь улсын хэмжээний дундаж үзүүлэлт 34%-иас харьцангуй өндөр байна.

Дорнод аймаг 2018 онд 29,862 га тариалангийн талбайтай байсан нь Сэлэнгэ, Төв, Булган аймгийн дараа 4-р байранд орсон байна. Улаан буудай, малын тэжээл тариалах талбай харьцангуй том, улсын хэмжээнд 4, 3-р байранд тус тус орсон байна. Дорнод аймаг малын тоогоор улсад 15-р байранд орсон. Нийт адуу, үхрийн тоогоор улсад 6, 8-р байранд тус тус орсон байна. Тэмээ, хонь, ямааны тоогоор 11,13,17-р байранд тус тус жагссан байна. 2010-2018 онд малын өсөлт 10.0%

байсан нь улсын дундаж өсөлт 9.3%-иас өндөр байжээ.

### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Чойбалсан хот нь социализмын үеэс хойш Зүүн бүсийн томоохон төв болсоор ирсэн. Дорнод аймгийн болон Зүүн бүсийн аймгуудын хэмжээнд тээвэр логистикийн төвийн үүргийг гүйцэтгэж байна. Аймгийн төв Чойбалсан хот нь Улаанбаатар хотоос 640 км зайтай оршдог бөгөөд улсын чанартай А0501, А0502 авто замаар холбогддог. ОХУ-тай гурав, БНХАУ-тай хоёр хилийн боомтоор харилцдаг. Чойбалсан хотоос Чулуунхороот хүртэлх А0503 авто зам нь шороон, Дээд Ульхан (А21) хүртэл хайрган замтай юм. ОХУ-тай хиллэдэг өөр нэг боомт нь Ямалхын гол Сайн Дурулгуй А21 гэсэн замын нөхцөл нилээд муу газар юм. БНХАУ-тай хиллэдэг Хавирга Ар Хашаат нь хамгийн идэвхтэй үйл ажиллагаатай бөгөөд А23 авто замаар Чойбалсан хоттой холбогдсон байна. Нөгөө нэг нь Баянхошуугийн боомт бөгөөд ердийн шороон замтай.

Чойбалсан хот нь ОХУ-ын Боржоос салбарласан Сибирийн төмөр замын салаа шугамын төгсгөл дээр байдаг. Урдаас хойшоо 220 км-ийн зайтай. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, малын тэжээл, улаан буудайг Зөвлөлт Холбоот улс, түүний Бүгд найрамдах улсууд руу тээвэрлэдэг байсан. Одоо ч бага хэмжээгээр тээвэрлэлт хийж байна.

Зүүн бүсийн 33 мВт-ын хүчин чадалтай цахилгаан эрчим хүчийг Чойбалсан хотын дулааны цахилгаан станц үйлдвэрлэж байна. Хүн амын ус хангамжийн хүрэлцээ төдийлөн сайн биш бөгөөд 1,000 хүн тутамд ногдох уст цэгийн тоогоор улсын хэмжээнд 18-р байранд жагсаж байна.

### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Улаанбаатар хотоос алслагдмал байдал нь тээврийн зардлыг өсгөж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэд нөлөөлдөг бэрхшээл тулгарч байна. Шатахууны үнэ өндөр, улсын хэмжээнд 6-р байранд жагсаж байгаа бөгөөд хэрэглээний үнийн индекс өндөр (7-р байр) байна.

Гурилын үйлдвэр, хивсний үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, тоосгоны үйлдвэр зэрэг социализмын үеийн үйлдвэрүүд байгаа хэдий ч газрын тосны үйлдвэрлэлээс ихээхэн хамааралтай, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын эзлэх хувь бага, эдийн засгийн тэнцвэргүй бүтэцтэй байдал харагдаж байна. Энэ нь орон нутгийн аж үйлдвэрийн салбараас орон нутгийн төсөвт оруулах татварын орлогод сөргөөр нөлөөлж байна. Төсөв болон БДНБ-ий харьцаа маш доогуур бөгөөд улсын хэмжээнд 20-р байранд жагсаж байна. Иргэдийн хадгаламж доогуур (21-р байр), чанаргүй зээлийн хэмжээ өндөр (2-р байр), иргэдийн санхүүгийн мэдлэг, чадвар сул (3-р байр) зэрэг үзүүлэлттэй байна.

Хүний нөөцийн дутагдал нь суурь тулгамдсан асуудал юм. Ахлах менежерүүд (14-р байр), чадварлаг боловсон хүчин (17-р байр), мэргэшсэн инженерүүд (15-р байр) дутагдалтай байна. Ажилчдыг чадавхжуулах, сургалтанд хамруулахад ач холбогдол өгдөг эсэх үзүүлэлт дээр улсын хэмжээнд 15-р байранд жагссан байна. Хэлэлцүүлгийн үеэр Дорнод аймагт мэргэжилтэй боловсон хүчин шилжин ирэх нөхцөлийг хангахгүй, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа хийхгүй, иргэдийн ажилдаа сэтгэлээсээ хандах, хариуцлагатай байх ёс зүй дутмаг байгаа зэргийг оролцогчид онцолж байсан.

Дорнод аймагт халдварт өвчний өвчлөл өндөр байна. ОХУ, БНХАУ-тай хиллэдэг учраас эдгээр улсууд руу иргэд харилцан зорчдог тул халдварт өвчин, ялангуяа

бэлгийн замын халдварт өвчин тусах эрсдэл өндөр байна. Эрүүл мэндийн үйлчилгээний дутагдалтай байдал, эрүүл мэндийн тогтмол хяналтад орохгүй байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг асуудлууд байсаар байна.

Өв уламжлал, зан заншил, байгаль орчинд эрсдэл учирсаар байна. Дорнод аймаг уламжлалт соёл, нүүдэлчин ахуйгаа алдаж магадгүй үзүүлэлтээр 2-р байранд жагссан байна. Уул уурхайн үйлдвэрлэл нь эдийн засагт хувь нэмрээ оруулж байгаа боловч байгаль орчин, амьдрах орчныг сүйтгэсээр байна. Жишээлбэл хөрс ургамлыг сүйтгэж буй шинэ зам, байгаль орчин, бэлчээрийг сүйтгэсэн газрын тосны үйлдвэрлэл, түүхий эд тээвэрлэж байгаа хүнд даацын машинууд байгаль орчинд маш том эрсдэлийг дагуулж байна.

### (3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж

#### Олон улсын худалдаа

Газар зүйн байршил, социализмын үеэс баригдсан төмөр замын дэд бүтцийн боломжийг ашиглан ОХУ, БНХАУ-тай хийх худалдааг өргөжүүлэх шаардлагатай. Транс-Сибирийн төмөр замаар ОХУ, БНХАУ хоорондын бараа бүтээгдэхүүний урсгал байсаар байна. БНХАУ-ын хамгийн том, дотоодын тээврийн логистик төв болох Өвөр Монголын өөртөө засах орны Манжуур хот нь Чойбалсан хотоос 270 км зайтай оршдог. 2016 онд БНХАУ-ын Манжуураас Европ руу нийт 1,036 вагон буюу ойролцоогоор 83,000 контейнер ачаа (TEU) тээвэрлэсэн байна.

Чойбалсан хотоос эхтэй төмөр зам Манжуураас баруун хойд зүгт 110 км-т ОХУ-ын Борж дахь Транс-Сибирийн гол шугамтай холбогддог. Дорнод аймгийн нутгийн брэнд бүтээгдэхүүнүүдийг Эрээнцавын хилийн боомт, Боржоор дамжуулж, Европ, Япон улс руу экспортлох боломжтой. Дорнод аймагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнүүдийг Чойбалсан хотод цуглуулж, Хавирга хилийн боомтоос Манжуур руу экспортолно. Бусад 3 боомтыг ОХУ, БНХАУ-ын дотоодын зах зээлийн түвшинд чиглүүлж хөгжүүлэх хэрэгтэй.

ОХУ, БНХАУ-тай хийх олон улсын худалдааг өргөжүүлэхийн тулд эн тэргүүнд Монголын талаас логистикийн төвийн дэд бүтцийг сайжруулах нь чухал юм. Хүснэгт 7.6.1-д Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын логистикийн гүйцэтгэлийн индексийг Дэлхийн банкнаас гаргасан дэлхийн улсуудад хийсэн үнэлгээнээс харуулав.

#### **Хүснэгт 7.6.1 Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын логистикийн гүйцэтгэлийн индекс**

Үзүүлэлтүүд	Монгол	ОХУ	БНХАУ
LPI эзэлсэн байр	141	94	27
Нийт үнэлгээ	2.25	2.61	3.49
Гаалийн үйл ажиллагааны үр ашигтай байдал (цаг хугацаа, хялбар байдал, урьдчилан тооцоололт зэрэг) хилийн цэгүүд дээрх гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа	1.81	2.15	3.16
Дэд бүтэц: Худалдаа, тээврийн дэд бүтцийн чанар (боомт, төмөр зам, авто зам, мэдээлэл харилцаа холбооны технологи)	1.94	2.38	3.54
Олон улсын тээвэрлэлт: Тээвэрлэлтийн үнийн шударга өрсөлдөөн	2.46	2.72	3.31
Логистикийн өрсөлдөх чадвар: Логистикийн үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар (тээврийн оператор, гаалийн ажилтнууд)	2.24	2.51	3.49
Ачаа тээврийн мэдээлэл; Илгээсэн барааны мэдээллийг найдвартай хүлээн авах чадвар	2.42	2.60	3.55
Цаг хугацаа: Төлөвлөсөн болон товлосон хугацаанд хүрсэн эсэх	2.55	3.23	3.91

Эх сурвалж: Дэлхийн банк, LPI Global Rankings 2018,  
<https://lpi.worldbank.org/international/global/2018>

Жич: 155 орон үнэлгээнд оролцсон

Судалгаанд хамрагдсан 155 орноос Монгол Улс 141-р байранд, ОХУ болон БНХАУ 94-р байр, 27-р байранд тус тус эрэмбэлэгдсэн байна. Иймд хөрш орнуудын бараа бүтээгдэхүүний урсгал нь харьцангуй жигд байгаа ч Монгол Улсын гүйцэтгэл, ялангуяа дотоод логистикийн гүйцэтгэлд асуудал байгаа нь харагдаж байна. Эхний хоёр 'Гаалийн үйл ажиллагааны үр ашиг' 'Дэд бүтэц' үзүүлэлтүүд доогуур байгааг Засгийн газраас сайжруулах ёстой. Бусад 'Олон улсын тээвэрлэлт', 'Логистикийн өрсөлдөх чадвар', 'Ачаа тээврийн мэдээлэл', 'Цаг хугацаа' гэсэн дөрвөн үзүүлэлт харьцангуй өндөр байгаа бөгөөд хувийн хэвшлийн хүрээнд шийдвэрлэх боломжтой. Монгол Улсын Засгийн газар нь ОХУ болон БНХАУ-тай хийх худалдаа тээврийг хөнгөвчлөхөд онцгойлон анхаарах хэрэгтэй.

### Чойбалсан хотын хот байгуулалт

Чойбалсан хотын чиг үүрэг, дэд бүтцийг сайжруулснаар олон улсын логистик, худалдааны төв, Зүүн бүсийн аймгуудын аялал жуулчлалын зангилаа хот болох боломжтой. Чойбалсан хотод дараах давуу талууд байна.

- Бизнес эрхлэхэд хялбар: I
- Банк, санхүүгийн үйлчилгээний чанар: III
- Хээл хахууль багатай: III
- Орон нутгийн засаг захиргааны тогтоол, шийдвэрийн нээлттэй байдал: IV
- Хүнд суртал багатай: III
- Компани байгуулахад хялбар: II
- Цахилгаан эх үүсвэртэй: IV
- Дулаан хангамж сайтай: I
- Мэдээллийн хүртээмж: I
- Шударга, цаг үетэй хөл нийлсэн байдал, орон нутгийн мэдээллийн хэрэгслийн хүртээмж: I

Чойбалсан хотын хөгжлийг дэмжихийн тулд зөөлөн, хатуу дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. Зөөлөн дэд бүтцэд зах зээлийн эдийн засгийн тухай мэдлэг, эдийн засгийн суурь зарчмууд, зах зээлийн суурь судалгаанд суурилагдсан бизнесийн сургалт, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүд, бизнесийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, санхүүгийн дэмжлэг үзүүлэх загварчлал, олон улсын хэмжээний зорилт болон гэрээ хэлэлцээрт суурилсан олон улсын бизнесийн загвар зэргийг сурталчлах гэх мэт хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээнүүд орно. Хатуу дэд бүтцэд хот суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, мэдээлэл харилцаа холбоо, авто зам зэрэг ирээдүйн эрэлт хэрэгцээнд нийцсэн байгууламжууд орно. Мөн агро-аж үйлдвэрлэлийн паркийг мэдээлэл харилцаа холбооны технологитой уялдуулан бизнес цогцолборыг хатуу дэд бүтцэд оруулна. Дорнодын Их сургуулийг хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр судалгаа шинжилгээ, инновацийн төв болгон өргөжүүлэх боломжтой. Олон улсын хэмжээний аялал жуулчлал, бизнес хөгжүүлэлтийг сурталчлахын тулд Дорнод аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон өргөжүүлэх шаардлагатай.

### Ирээдүйтэй үйлдвэрлэл, бүтээгдэхүүн

Дорнод аймагт дараах үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ирээдүйтэй харагдаж байна.



- Импортыг орлох ногоо, жимс жимсгэнийг томоохон голуудыг дагасан усалгааны системтэй хослуулан тариалах, мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашигласан, байгалийн эрс тэс уур амьсгалд тохирох сувгийн, туннел маягийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх;
- Япон болон бусад өндөр хөгжилтэй улсууд руу олон төрлийн байгалийн жимс экспортлох;
- Температур, агаар чийг хэмжигч, хөрсний чийг хэмжигч зэрэг тариалангийн талбайн орчныг хянах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хагас эрчимжсэн мал аж ахуйг малын тэжээлийн үйлдвэрлэлтэй хослуулан мал аж ахуйн үйлдвэрлэлийн цогц байгууламж дахь боловсруулах үйлдвэрүүдтэй холбож, кластераар хөгжүүлэх;
- Дорнод аймагт ургадаг төрөл бүрийн өвс ургамлыг (40 гаруй зүйлийн ургамал, 10 гаруй зүйлийн эмийн ургамал) ашиглан амьсгалын замын болон үрэвсэлт өвчнийг анагаах бүтээгдэхүүн хөгжүүлэх;
- Аялал жуулчлалын олон төрлийг сурталчлах боломж: Монгол Улс-ОХУ-БНХАУ Дагуурын байгалийн нөөц газар, Зүүн хойд хэсгийн ус намгархаг газарт шувуу ажиглах аялал, Чингис хааны өлгий нутгийн түүх дурсгалт газрын аялал, Буйр нуур, Халхын гол орчмын түүхийн дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газрын аялал.

## **7.7 Нийслэлийн бүсийн Төв аймгийн хөгжлийн дүн шинжилгээ**

### **(1) Одоогийн нөхцөл байдал**

#### Газар зүйн нөхцөл байдал



Төв аймаг нь Улаанбаатар хотыг багтаасан хойноос урагш 250 км, зүүнээс баруун 330 км үргэлжлэх газар нутагтай. Нутгийн зүүн хойд хэсэг нь далайн түвшнээс дээш 1800 м-т өргөгдсөн ба энэ хэсгээр Хэнтий нурууны салбар уулс сунаж тогтсон. Нутгийн өмнөд болон баруун хэсэг нь Туул голын сав газрыг даган харьцангуй нам дор газар үргэлжилнэ. Баруун өмнөд хэсгээр Хангай нурууны үргэлжлэл хэсэг далайн түвшнээс дээш 1,500-1,600 м-т оршдог.

Улаанбаатар хотын усны эх үүсвэр болох Туул гол нь Хэнтий нуруунаас эх авч, баруун зүгт урсаж хойд зүг рүү чиглэн урссаар Сэлэнгэ аймгийн нутагт Орхон голд цутгадаг. Туул голын нийт урт нь 704 км бөгөөд ус хурах талбай нь 49,840 км<sup>2</sup>, жилийн дундаж урсац 26.6 м<sup>3</sup> /сек, нэн ховордсон хилэм загасны өлгий нутаг билээ.

Төв аймгийн нутаг дэвсгэрт Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Хустайн нурууны байгалийн цогцолборт газар, Гүн-Галуутайн байгалийн нөөц газар гэсэн гурван тусгай хамгаалалттай газар байдаг. Аймгийн нутгийн дийлэнх хэсэг нь тал хээрийн бүс зонхилдог ч нутгийн зүүн хойд хэсгээр ой тайгын бүс оршино.

Нутгийн зүүн хойд зах хэсгээс бусад газар бүхэлдээ үржил шимтэй, хар шороон хөрстэй. Сэлэнгэ аймагтай хил залгаа нутаг болон Туул голын сав дагуу газар нутаг нь үржил шимтэй, газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой. Жилийн 126 өдөр нь хур бороотой, 262 мм хур тунадас ордог бөгөөд Төвийн бүсийн аймгуудаас Сүхбаатар аймаг (346 мм) болон Дархан-Уул (320 мм) аймгийн дараа ордог.

### Зураг 7.7.1 Төв аймгийн байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### Нийгэм, эдийн засаг

Төв аймгийн хүн ам нь 2010 оноос хойш жилд дунджаар 1.5%-иар өссөн бол өмнөх арван жилд нь дунджаар -1.4%-иар буурч байсан нь дийлэнхдээ хүн амын шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалсан. Цэвэр шилжилт хөдөлгөөн нь (шилжин явсан тооноос ирсэн тоог хассан дүн) 2000-2009 оны хооронд 23,400 байсан бол 2010-2018 онд 5,300 болсон байна. Дээрх хугацаанд 1000 хүнд ногдох төрөлтийн тоо 2000 онд 20.0, 2010 онд 23.6, 2018 онд 24.6 болж байнга өссөн. Төв аймгийн иргэд Улаанбаатар руу дийлэнхдээ шилждэг боловч Хэнтий, Сүхбаатар аймагт бэлчээр сайтай учраас малчид нүүдэллэн очдог. Нөгөө талаар Төв аймагт Баруун бүсийн аймгуудаас шилжин ирдэг байна. 2010-2018 оны шилжилт хөдөлгөөний дүн нь 5300 байсан нь шилжин явсан хүний тоо 25,600, шилжин ирсэн хүний тоо 20,300 байсан байна.

Төв аймгийн БДНБ нь 2018 онд 594,207 сая төгрөг байсан нь улсын хэмжээнд 6-р байранд, нэг хүнд ногдох БДНБ нь 6,255,000 төгрөг байсан нь 7-р байранд жагсжээ. Төв аймгийн эдийн засгийн бүтэц 2010 оноос хойш маш их өөрчлөгдсөн. 2010 онд хөдөө аж ахуй 64%, аж үйлдвэр 13%, үйлчилгээ 23%-ийг эзэлж байсан бол 2018 онд хөдөө аж ахуй 48%, аж үйлдвэр 30%, үйлчилгээ 22% болж аж үйлдвэр 17%-иар нэмэгдсэн байна. Аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчид аж үйлдвэрийн салбарын өсөлтийг тайлбарлахдаа шинээр олон тооны үйлдвэр ялангуяа мөөг, ган бөмбөлөг, гутал, тоосго, утаагүй түлш, 'Монгол ноос' ноосон эдлэл, ноолууран эдлэл, гурил, хонины ноосоор хийсэн бордоо зэрэг бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэдэг болсон гэж тайлбарлаж байсан. 2018 онд Төв аймаг газар тариалангийн үйлдвэрлэлээр улсад тэргүүлсэн бөгөөд аж үйлдвэрийн салбар 9-р байранд жагссан.

2018 онд 4,582,000 мал тоологдсон бөгөөд улсын хэмжээнд 5-р байранд жагссан нь 2010 оны 2-р байрнаас ухарсан байна. 2010-2018 онд малын өсөлт 69%-тай байсан нь улсын хэмжээний 103%-иас бага өсөлттэй байсныг бэлчээрийн хүрэлцээ, мал аж ахуйн салбарын бусад хязгаарлагдмал боломжоос үүдэлтэй гэж үзэж байна. Адуу, хонины тоо толгойн өсөлтийг дараах хүснэгт 7.7.1-ээс харж болно.

### Хүснэгт 7.7.1 Төв аймгийн малын тоо

Нэгж: мянган тоо толгой

Нэр	2010	2018	Өсөлт (%)
Адуу	199.8	341.4	71
Үхэр	172.0	282.3	64
Тэмээ	2.2	3.5	59
Хонь	1,358.7	2,449.3	80
Ямаа	977.9	1,506.0	54
Бүгд	2,710.7	4,582.4	69

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2017, 2018 он

Төв аймаг нь газар тариалан түлхүү эрхэлдэг аймаг бөгөөд Монгол Улсын газар тариалангийн салбарт тэргүүлж буйг Хүснэгт 7.7.2-т үзүүлж байна. Хаалтанд улсад орсон байрыг харуулсан болно.

### Хүснэгт 7.7.2 Төв аймгийн тариалангийн талбай (ургацын төрлөөр)

Нэгж: га; улсын хэмжээнд эзлэх байр

Ургац	2010	2018	Өсөлт (%)
Үр тариа	50,284 (2)	78,014 (2)	55
Төмс	3,983 (1)	5,723 (1)	44
Хүнсний ногоо	1,119 (2)	1,185 (3)	6
Малын тэжээл	4,175 (1)	10,925 (2)	162
Бүгд	64,813 (2)	109,002 (2)	68

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2017, 2018 он

Малын тэжээлд зориулсан тариалангийн талбайн хэмжээ ихэссэн. Сэлэнгэ аймаг малын тэжээлийг 2010 онд 1,264 га-д, 2018 онд 15,292 га-д тариалсан буюу 12 дахин нэмэгдүүлсэн нь Төв аймгийг улсын хэмжээнд 2-р байранд жагсахад хүргэсэн. Монгол Улсын хэмжээнд 1 га талбайгаас авах ургацын хэмжээ бусад орныхтой харьцуулахад маш доогуур байдаг. Үр тарианы хувьд 1 га талбайгаас 1.2 тн, төмс 14 тн ургац хурааж байхад дэлхийн дунджаар үр тариаг 1 га талбайгаас 3.5 тн, төмс 18тн-ыг хурааж байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд 1 га талбайгаас хураах ургацыг нэмэгдүүлэх талаар дэмжлэг, сурталчилгаа хийх

шаардлагатай байна.

Төв аймгийн хувьд дундаж цалин 2018 онд 671,000 төгрөг байсан нь улсын хэмжээнд 13-р байранд, улсын дундажийн 67%-тай тэнцэж байна.

### Орон зайн төлөвлөлт болон дэд бүтцийн хөгжил

Аймгийн төв Зуунмод хот нь 16,000 хүн амтай, Улаанбаатар хотын өмнөд хэсэгт оршино. Зуунмод хот нь Улаанбаатар хотын урд орших Богдхан уулын дархан цаазат газрыг тойрч, Сүхбаатарын талбайгаас 45 км зайтай оршдог. Улаанбаатар хотоос бусад аймгууд руу чиглэсэн бүх томоохон гол замууд Төв аймгийн нутгаар дайран өнгөрдөг (А0401 нь хойд чиглэлд, АН32 болон А0901 нь баруун чиглэлд, А0501 нь зүүн чиглэлд, А0101 болон А0201 нь өмнөд чиглэлд). А0901 авто замаас бусад нь хатуу хучилттай зам юм. Төв аймаг нь авто замын чанар (5-р байр), Улаанбаатартай холбогдох тээвэр, логистик (5-р байр), бензиний үнэ (хамгийн хямдаас 2-р байр) зэрэг үзүүлэлтээс харахад тээвэр логистикийн таатай нөхцөлд байна.

Төв аймаг нь Төвийн эрчим хүчний системээс 1100 мВт -ын цахилгаан эрчим хүчээ хангадаг. Эрчим хүчний асуудлаа шийдсэн үзүүлэлтээр улсын хэмжээнд 12-р байранд жагсаж байгаа бөгөөд 1кв цахилгааны үнэ 116 төгрөг байгаа нь улсад 15-р байранд жагсаж байна. Дулааны хангамжийн асуудлаа харьцангуй сайн шийдсэн үзүүлэлтээр улсад 5-р байранд жагсаж байна.

2018 онд уст цэгийн тоо 1,421, нэг уст цэгт ногдох хүний тоо 1,421 байсан нь улсын хэмжээнд тус тус тэргүүн байранд орж байна. Төв аймагт ундны ус хангамж бүхий айл өрхүүд 2018 онд нийт хүн амын 80%, Булган аймагт 98%-ийг эзэлдэг бөгөөд Монгол Улсын дундаж үзүүлэлт нь 57% байсан. Төв аймаг цэвэр ус хангамжийн хүртээмжээр улсад 8-р байранд байна.

2018 онд Төв аймагт 34 хог тээвэрлэдэг машин хог зайлуулдаг бөгөөд нэг машин нь 2,794 хүнд ногдог бөгөөд улсын хэмжээнд 6-р байранд жагссан байна. Хог хаягдлын зохистой менежментийн түвшингээр улсын хэмжээнд 8-р байранд жагссан байна.

Төв аймагт 2018 онд 743 суурин утасны шугаманд холбогдсон бөгөөд улсын хэмжээнд 10-р байранд орсон байна. 100 хүнд ногдох суурин утасны тоогоор 0.78 байсан байна. Төв аймагт интернет, суурин утас, шуудангийн үйлчилгээ зэрэг харилцаа холбооны таатай орчны хувьд 6-р байранд жагссан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд мэдээллийн үнэн зөв байдал болон цаг тухайд нь хүртээмжтэй байдлаар хүргэдэг үзүүлэлтэд 5-р байранд орсон.

Төв аймагт 2018 онд 32 халуун усны газар, нэг халуун усны газарт 2,969 хүн ногдож байгаа нь улсын хэмжээнд 9-р байранд жагсаж байна.

### **(2) Тулгамдаж буй асуудлууд**

Төв аймаг нь Улаанбаатар хоттой ойр оршиж буй нь эерэг болон сөрөг талуудтай байна. Төв аймгийн хотжилтын түвшин 2018 онд 19.1% байсан нь Монгол Улсын хэмжээнд хамгийн бага үзүүлэлт юм. Төв аймгийн БДНБ-нд үйлчилгээний салбар 22% байгаа нь улсын хэмжээнд 19-р байранд жагсаж байна. Эдгээр үзүүлэлт нь Төв аймгийн хотын болон бизнесийн үйл ажиллагаа доогуур түвшинд байгааг харуулж байна. Учир нь бизнесийн үйл ажиллагаа Улаанбаатар хотод төвлөрч, Төв аймагт зөвхөн суурь үйлчилгээ хөгжсөнөөс хэтрэхгүй байгааг харуулж байна.

Олон хүүхдүүд Улаанбаатар хотын сургуульд хамрагддаг бөгөөд энэ нь

боловсролын чанар сайн бусаас Улаанбаатар хотыг сонгож байж болох юм. Бага, дунд сургуульд хамрагдалтын түвшин нь тус тус 21, 20-р байранд жагсаж байна.

Бизнес эрхлэлтийг дэмжихтэй холбоотой орон нутгаас гаргаж буй бодлого, тушаал шийдвэр нь бизнесийн орчны бодит байдалтай нийцэхгүй байх тал бий. Эерэг талуудаас дурдвал аймгийн төсвийн үр ашигтай зарцуулалтаар улсын хэмжээнд 2-р байранд; аймгийг хөгжүүлэх орон нутгийн захиргааны байгууллагаас гаргаж буй тогтоол, шийдвэрээр 5-р байранд; бодлого, шийдвэрийн ил тод байдлаар 5-р байранд; нийгмийн үйлчилгээний таатай байдлаар 5-р байранд; зөвшөөрөл авахад хялбар байдлаар 3-р байранд; хээл хахуульгүй байдлаар 1-р байранд; тендерийн ил тод байдлаар 2-р байранд; шударга бус өрсөлдөөн бага 1-р байранд; бизнесийн таатай орчинг дэмжсэн тогтоол шийдвэр 4-р байранд; гадаадын төслүүдэд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж буй байдлаар 2-р байранд; хуулийн хэрэгжилтийн байдлаар 3-р байранд орсон зэрэг үзүүлэлттэй байна.

Хэдийгээр бизнесийн орчны таатай нөхцөлүүд байгаа ч зах зээлийн эдийн засгийн үндсэн суурь зарчмууд бизнесийн орчны бодит байдалд нийцэхгүй зүйлүүд байсаар байгаа бөгөөд ихээхэн хүчин чармайлт шаардлагатай байна. Бизнес хөгжүүлэхэд сөрөг хүчин зүйлүүдэд хувиараа бизнес эрхлэх боломж (21-р байр), бизнес эрхлэх таатай байдал (20-р байр), төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд (20-р байр), бизнес хөгжүүлэхэд аймгийн дүр төрх (20-р байр), экспорт хийх боломж (19-р байр), зээл авахад хялбар байдал (19-р байр), банкны хүү өндөр (18-р байр), компаниудын зах зээлд дасан зохицох байдал (17-р байр), бизнес эрхлэгч, менежерүүдийн сэтгэлгээ, гүйлгээ ухаан (19-р байр), цахилгааны үнэ (хамгийн өндөр), компаниудын инновацийн чадвар (19-р байр) зэргээр бусад аймгуудтай харьцуулахад тааруу үзүүлэлттэй байна.

Аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогчдын ихэнх нь нүүдлийн соёл уламжлал бол бидний амьдралын чухал үнэт зүйл тул үүнийг хойч үедээ өвлүүлэн үлдээх ёстойг дурдсан. Үндэстний бахархал бол уламжлал, зан заншил дээр тогтдог гэж зарим оролцогчид үзэж байсан. Гэсэн хэдий ч Төв аймгийн хувьд соёл уламжлал алдагдах эрсдэлтэй аймгуудын эгнээнд байгаа юм. Жишээлбэл хэлэлцүүлгийн үеэр малчид малаа мориор, тэмээгээр биш мотоциклоор малладаг болсныг хэлж байсан. Мөн бэлчээрийн даац хэтрэх зэрэг уламжлалт мал маллах арга ухаан алдагдсанаас байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Оюутан, сурагчдыг зуны амралтаар нь хөдөө малчдын амьдралтай танилцуулан уламжлалт мал мал ахуйн туршлагаас суралцуулах шаардлагатай гэдгийг ч онцолсон.

### **(3) Хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломж**

Төв аймгийн ирээдүйн хөгжлийг төлөвлөхдөө хоёр хүчин зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Нэг нь Улаанбаатар хотын чиг үүргийн заримыг хэрэгжүүлэх, нөгөө нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжихэд эдийн засгийн хүчин чадлыг бэхжүүлэхэд оролцох явдал юм.

Төв аймаг нь Улаанбаатарт ойр байршлаа ашиглан улс төр, засаг захиргаа, эдийн засгийн чиг үүргийн хэт төвлөрлийг сааруулахад хувь нэмрээ оруулах боломжтой. Үүнд хоёр чухал байршил байна. Нэг нь Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын ойролцоох шинэ Зуунмод хот, нөгөө нь аймгийн төв Зуунмод хот юм.

Шинэ Зуунмод хотын ТЭЗҮ боловсруулагдаж байна. Энэ хот нь Улаанбаатар




хотоос гадагш, эдийн засгийн хөгжлийг дэмжих, хот байгуулалтын шинэ цөм болж болох юм. Шинээр баригдсан нисэх онгоцны буудлыг ашиглаж, орчин үеийн дэвшилтэт технологи, шинэлэг дизайны үзэл баримтлалыг шингээсэн гадаадын болон дотоодын экспортод чиглэсэн бүтээгдэхүүнийг Монгол Улсын өнцөг булан бүрт байгаа агро-парктай холбох чухал газар болох юм. Төр, хувийн хэвшлийн түншлэл эхний шатанд зайлшгүй шаардлагатай. Дараа нь төслийн үйл явц жигдрэх үед хувийн хэвшил голлох үүрэг гүйцэтгэж болно.

Зуунмод хот нь Улаанбаатар хотын улс төрийн болон засаг захиргааны чиг үүргийг хүлээж авснаар Улаанбаатарын хэт ачаалал багасгахад хувь нэмрээ оруулна. Шинэ Зуунмод хот болон Зуунмод хотын усны нөөцийн судалгааг сайтар хийх шаардлагатай.

Зураг 7.7.2-т үзүүлсэний дагуу Төв аймагт шинэ үйлдвэрлэл, логистикийн сүлжээг байгуулснаар бүс нутгийн хөгжлийг тэнцвэржүүлэх юм. Үндсэн санаа нь бараа бүтээгдэхүүний урсгалыг Улаанбаатар хотын гадна тойрог маягаар үйлдвэрлэл, логистикийн бааз суурийг байгуулах явдал юм. Хөдөө орон нутгаас нийлүүлсэн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж шууд Улаанбаатар хот руу эсвэл экспортлох боломжтой. Бусад аймгуудаас ирсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг босоо кластерын дагуу хүлээн авч эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж болно.

Логистикийн хувьд бусад аймгуудаас ирүүлсэн бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авч, хуваарилаад, эргэн аймаг, сумд руу тарааж, түгээж болно. Зураг 7.7.2-т үзүүлснээр эдгээр таван үйлдвэрлэл, логистикийн төвийг хооронд нь холбоно. Улаанбаатарт бараа бүтээгдэхүүн орох, гарах урсгал байсаар байх боловч энэ логистикийн төвүүд ажилласнаар Улаанбаатарын ачааллыг багасгах юм. Төв аймгийн зүүн хойд хэсэгт орших Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг экотуризмын чиглэлээр холбож харуулсан.

### Зураг 7.7.2 Төв аймагт шинээр санал болгож буй Үйлдвэрлэл, логистикийн төв



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Эдгээр үйлдвэрлэл, логистикийн төвийг байгуулахдаа дэд бүтцийг сайжруулах, хувийн бизнес эрхлэгчдийг татахуйц орчинг бүрдүүлэх шаардлагатай байна. Орон нутгийн санаачилгууд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэх

ёстой. Сэлэнгэ аймагт ойр, Туул голын сав газар дагуу газар тариалангийн үйлдвэрлэл нь 1 га талбайгаас хураах ургацын хэмжээг нэмэгдүүлэх төрөл бүрийн арга техник ялангуяа хүлэмжийн аж ахуй (цаг уурын хүнд нөхцөлд тэсвэртэй суваг, шуудуу маягийн), усжуулалтын систем, бусад дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх шаардлагатай. Борнуур, Лүн сум нь газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг боловсруулах гол газар байж болно. Мал аж ахуйн гаралтай мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, ноолуур, ноос зэрэг бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг Баян-Өнжүүл, Баян, Багануурт төвлөрүүлэн хөгжүүлж болно.

Төв аймаг Улаанбаатар хотод дөт, жуулчид дайран өнгөрдөг давуу талаа ашиглан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж их бий. Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт эко туризм, агро эко туризм, түүх соёлын аялал жуулчлал хөгжүүлэх ирээдүй бий. Олон улсын нисэх онгоцны шинэ буудал баригдсантай холбогдож Бизнес (MICE) аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжууд ч бий болж байна. Аялал жуулчлалын маршрутыг, бүтээгдэхүүнийг олон янзаар боловсруулж, дэд бүтэц хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

## **Бүлэг 8            Гол төсөл, хөтөлбөр бүхий үе шаттай хөгжлийн төлөвлөгөө**

Энэхүү бүлэгт өмнөх бүлгүүдэд тусгасан макро түвшний, салбарын болон аймгийн түвшний судалгааны үр дүнг нэгтгэж, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж тусгав. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг салбарын түвшний дүн шинжилгээг нэгтгэсэн Салбарын тайлан (тусдаа боть), Бүлэг 2-ын макро түвшний асуудлуудын хүрээнд боловруулсан аймгуудын хөгжлийн дүн шинжилгээ (Бүлэг 7), Бүлэг 4-д тусгасан нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт болон Бүлэг 5-д тусгасан орон зайн төлөвлөлтийн судалгаанд үндэслэж боловсрууллаа.

Нэгдүгээрт үе шаттай хөгжлийн төлөвлөгөөг хөгжлийн хувилбараар боловсруулж, хоёрдугаарт салбарын болон аймгийн түвшинд төсөл, хөтөлбөрүүдийг санал болгосон бөгөөд дараа нь гол төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлсон. Бүлэг 3-т тусгасан хөгжлийн стратегийн хүрээнд эдгээр төслүүдийг хэрэгжүүлснээр тус бүлэгт дэвшүүлсэн зорилтуудад хүрэхэд хувь нэмэр болох юм. Гуравдугаарт шинээр тодорхойлсон эдийн засгийн 6 бүсэд Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг төсөл, хөтөлбөрийн хамт санал болгосон. Дөрөвдүгээрт төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх институцийн арга хэмжээг салбар тус бүрээр санал болгож, тусгасан. Тавдугаарт төслүүдийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор Монгол Улсын хөгжлийн удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох институци, зохион байгуулалтын арга хэмжээг санал болгосон.

### **8.1    Хөгжлийн загварын хувилбарууд**

#### **8.1.1    Хөгжлийн шинэ загвар, үе шат**

##### **(1) Хөгжлийн загварууд**

Энэхүү бүлэгт 2040 он хүртэлх төлөвлөлтийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлон, тусгав. Хөгжлийн хувилбарыг судлах зорилгоор хөгжлийн ялгаатай 2 хувилбарыг авч үзэв. Үүнд: 1) 20-р зууны хөгжлийн загвар ба 2) нийгэм, эдийн засгийн загварын хувилбар болно. Монгол Улс нь байгалийн нөөц баялгийг зүй бусаар хэтрүүлэн ашиглаж, эдийн засгийн үр ашигт чиглэсэн үйл ажиллагаагаар тодорхойлогддог 20-р зууны хөгжлийн загвараас татгалзах шилжилтийн үе шатанд байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайн салбарын өсөлтийг даган тэлж байгаа хэдий ч уламжлалт, бэлчээрийн мал аж ахуй эрхлэлтэд хүндрэл учирч байгаа бөгөөд эдийн засаг, экспортын бараа бүтээгдэхүүн төрөлжөөгүй байна. Уул уурхайгаас хамааралтай эдийн засгийн өсөлт нь байгалийн нөөц баялгийг зүй бусаар хэтрүүлэн ашиглаж, эдийн засгийн үр ашигт чиглэсэн үйл ажиллагаагаар тодорхойлогддог 20-р зууны хөгжлийн загварын дагуу хөгжиж байгааг илтгэнэ. Энэ нь нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна ажлын байрыг төдийлөн нэмэгдүүлдэггүй бөгөөд маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг юм. Үүнээс улбаалан Монгол Улсын эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн өөрчлөлтийн үр нөлөө болон уур амьсгалын өөрчлөлт, ган, зуд зэрэг байгалийн гамшигт өртөмтгий, эмзэг байна.

НҮБ-аас санаачлан хөгжлийн загварыг өөрчлөхийг уриалсан дэлхийн Тогтвортой

хөгжлийн зорилгуудын (ТХЗ) хүрээнд боловсруулан, хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (ТХҮБ) баримт бичгийн дагуу Монгол Улс нь 20-р зууны хөгжлийн загвараас татгалзан, хөгжлийн шинэ загвараар хөгжихөөр зорьж, үйл ажиллагааг эхлүүлээд байна. Хөгжлийн шинэ загварыг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлэх вэ гэсэн асуудал тулгарна. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд тодорхой арга зүй, аргачлалыг тодруулах замаар тус асуудлыг шийдвэрлэнэ. Тухайлбал ҮХЦТ нь хөгжлийн загварын алсын хараа, зорилгыг тодорхойлж, хэрэгжүүлэх стратеги, арга хэмжээг танилцуулна.

ЖАЙКА-гийн Төслийн баг нь Монголын талын хамтран ажиллагч байгууллагуудын мэргэжилтнүүдэд хөгжлийн 2 хувилбарын талаар тайлбарлаж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. ЖАЙКА-гийн Төслийн баг нь Монголын талын хамтран ажиллагч байгууллагуудын хамт хөгжлийн алсын хараа, зорилго, стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулсан. Эрдэмтэн, судлаачид, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн төлөөлөл, аймгуудын удирдах албан тушаалтнуудыг оролцуулан Оролцогч талуудын нэгдсэн хурлыг 2020 оны 1-р сарын 21-нд зохион байгуулсан бөгөөд хөгжлийн загвар, алсын хараа, зорилго, стратегийг танилцуулсан.

Хурлаар бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчид хөгжлийн ямар загварыг илүү зөв гэж үзэж байгаа болон үндэслэл, шалтгааныг тайлбарласан. Хуралд оролцогчдын ихэнх нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбарын загварыг хүлээн зөвшөөрсөн боловч оролцогчдын тал хувь нь 20-р зууны хөгжлийн загвар ба нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбарыг хослуулсан холимог загварыг илүү зөв гэж үзсэн юм.

Хуралд оролцогчид улс төрийн тогтворгүй байдал, бодлогын уялдаагүй байдал, Улаанбаатар хот дахь эдийн засгийн үйл ажиллагаа, хүн амын хэт төвлөрөл, бүс нутаг, хот, хөдөөгийн иргэдийн орлогын ялгаа, хүрээлэн буй орчны доройтол, эдийн засаг ба экспортын бараа бүтээгдэхүүн төрөлжөөгүй, уул уурхайгаас хамааралтай эдийн засгийн өсөлт зэрэг өнөөгийн чиг хандлага үргэлжилж байгаа үед хөгжлийн боломжит үр дүнгийн талаар санал бодлоо солилцов.

Тэд хөгжлийн алсын харааг хэрэгжүүлэх нийгэм, эдийн засаг, орон зайн хөгжлийн өөрчлөлтөд нөлөөлөх зүйлсийн талаар санал бодлоо илэрхийлэв. Үүнд суурь боловсрол, мэдлэг ойлголтыг сайжруулах, дээд боловсрол, мэргэжлийн сургалт, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, дахин боловсруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бусад улс орнуудтай байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээрийн үйл хэрэгт идэвхитэй оролцох, нүүрсний хэрэглээнээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих, зам тээврийн дэд бүтцийг хөгжүүлэн хотуудын харилцаа холбоог сайжруулах, орон нутгийн захиргааны байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, шинэчлэл хийх, мэдлэгийн үйлдвэрлэл, хиймэл оюун ухаан, зүйлсийн интернет, дэвшилтэт тенхологи, ойн сан, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, бэлчээрийг хамгаалах, бэлчээр ашиглалтын хяналт бүхий газрыг тодорхойлох зэрэг болно.

2020 оны 8-р сарын 17-ны өдөр залуучуудын төлөөллийг оролцуулсан Оролцогч талуудын нэгдсэн хурлыг онлайнаар зохион байгуулж, ҮХЦТ-г танилцуулсан. 100 гаруй монгол залуус Улаанбаатар хотоос, орон нутгаас мөн гадаадын 12 улсаас холбогдож, оролцсон. Тус хурлын дараа 100 гаруй асуулт, санал сэтгэгдэл хүлээж авсан бөгөөд Төслийн баг (ЖТБ) тэдгээрт хариу өгч, түүнийгээ онлайнаар нээлттэй байршуулсан. Хүснэгт 8.1.1-д Оролцогч талуудын нэгдсэн хуралд оролцсон залуучуудын төлөөллийн саналыг нэгтгэн харуулав. Дараагийн хурлыг

9 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулж, тус хуралд өмнөх хурлын оролцогчид оролцож, онлайнаар багийн хэлэлцүүлэг хийсэн. Хүснэгт 8.1.2-т Оролцогч талуудын нэгдсэн хурлын хэлэлцүүлэг, илтгэлтэй холбогдуулан Төслийн багаас өгсөн хариултыг нэгтгэн үзүүлэв. Оролцогч талуудын нэгдсэн хуралд оролцогчид тодорхой асуудлуудын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн ч ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд өргөн цар хүрээтэй судалгаа (аймгуудын судалгаа г.м.) бүхий цогц, хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж буйд сайшаалтай байгаагаа илэрхийлж байв.

### Хүснэгт 8.1.1 Оролцогч талуудын нэгдсэн хуралд оролцсон залуучуудын төлөөллийн санал

Ангилал	Санал
ҮХЦТ-д тусгагдсан саналууд	1) Дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, ашиглах; 2) Бүсчлэлийг тогтоохын тулд соёл, уламжлал, газар нутаг, уур амьсгалтай холбоотой үзүүлэлтүүдийг ашиглах; 3) Малын өвчлөлгүй бүсийг тогтоох.
Судлах шаардлагатай саналууд	1) Модон бүтээгдэхүүний чанарын лаборатори байгуулах; 2) Саарал ус ашиглах; 3) Эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн эрүүл мэндийн мэдээллийн төвүүд; 4) Залуучуудын хөгжлийн төв.
ҮХЦТ-д тусгагдахгүй саналууд	1) Соёлын салбарын төсөл, хөтөлбөрүүд; 2) Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт; 3) Шуудангийн үйлчилгээг сайжруулах хаягжуулалтын систем; 4) Азийн эрчим хүчний сүлжээний хүрээнд эрчим хүч экспортлох.
Ерөнхий санал	“Алсын хараа 2050”, ХАНСХЕТ, БХБ, ҮХЦТ хоорондын уялдааг тодорхой болгох.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Хүснэгт 8.1.2 Оролцогч талуудын нэгдсэн хурлын хэлэлцүүлэг, илтгэлтэй холбогдуулан Төслийн багаас өгсөн хариулт

Баг	Хэлэлцсэн асуудлууд	Төслийн багаас өгсөн хариулт
А	Мал аж ахуй, газар тариалан	1) ҮХЦТ-д мал аж ахуй, газар тариалан, экспортын зах зээлд чиглэсэн анхан шатны боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг уялдуулах зорилгоор үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх стратегийг санал болгосон. 2) Энэ стратегийг дэмжихээр хэрэгжүүлэх арга хэмжээнд хөдөө аж ахуй эрхлэгчдийг зохион байгуулах, ур чадварын сургалтад хамруулж тэдний чадавхыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний хөгжилд зориулагдсан судалгаа, хөгжүүлэлт хийх, чанартай бүтээгдэхүүнийг хөгжүүлж экспортлох зэрэг үйл ажиллагаа багтана. 3) Түүнчлэн замын байгууламжийг сайжруулж, үйлдвэрлэлийн анхан шатны бүс, боловсруулах үйлдвэрүүд, экспортын баазыг хооронд нь холбох шаардлагатай.
	Хагас эрчимжсэн мал аж ахуй	1) Хагас эрчимжсэн мал аж ахуйг тэжээлийн үйлдвэрлэлтэй хослуулан мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын нэгэн хэсэг болгон хөгжүүлэх боломжтой. 2) Кластер нь мах, сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулалтаас эхэлж, цаашлаад экспортод чиглэсэн нэмүү өртөг шингээсэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулна.
	Малын өвчлөлгүй бүс	ҮХЦТ-д мах, сүүн бүтээгдэхүүний Ази болон бусад улс орнууд руу чиглэсэн экспортыг дэмжих зорилгоор Зүүн бүсэд малын өвчлөлгүй бүсийг хөгжүүлэх саналыг боловсруулсан.
	Газар тариалангийн	1) ҮХЦТ-д үр тариа, хүнсний ногоо, чацаргана зэрэг зарим жимс, жимсгэнэ, тосны ургамал зэрэг техникийн ургамлын тариалалт болон

	үйлдвэрлэл, боловсруулалт	<p>боловсруулалтыг нэмэгдүүлэхийг санал болгосон.</p> <p>2) Үүний тулд ҮХЦТ-д томоохон гол мөрөн, хүлэмжийн аж ахуй, мэдээлэл харилцаа холбооны технологийг ашигласан ухаалаг хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн паркард суурилсан услалтын системийг нэвтрүүлэх саналыг дэвшүүлсэн.</p> <p>3) А багийн санал болгосон хөдөө аж ахуйн лабораторийг аж үйлдвэрийн паркард байгуулж болно.</p>
	Газар тариалангийн үйлдвэрлэл, маркетинг	<p>1) ҮХЦТ-д үйлдвэрлэл, маркетингийг дэмжих зорилгоор хүнсний гарал үүслийг хянах платформ, хөргүүртэй систем бүхий сүлжээ, МХХТ-ийн хяналт, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ зэргийг санал болгосон.</p> <p>2) А багийн санал болгосон өргөн уудам газар нутгийг гадаадын улс орнуудад түрээслэн, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх тухай саналыг ҮХЦТ-д оруулаагүй.</p>
В	Хотын дэд бүтэц	ҮХЦТ-д В багийн санал болгож буй явган хүний зам, дугуйн зам, хотын цэцэрлэгт хүрээлэн, хотын тээвэр, орон сууц зэрэг хотын дэд бүтцийн асуудлыг бус, харин хот, суурины ус хангамж, ариутгах татуурга, хатуу хог хаягдлын менежментийг авч үзэж байна.
	Хатуу хог хаягдлын менежмент	<p>1) Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ҮХЦТ-д хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл, эко-парк байгуулах төслийг санал болгосон.</p> <p>2) Түүнчлэн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялгахын тулд хүнсний бүтээгдэхүүний хаягдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.</p>
	Гэр хороолол	<p>1) ҮХЦТ-д гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл, гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төслийг санал болгосон.</p> <p>2) В багийн санал болгосон ногоон байгууламжийг өргөжүүлэх ажлыг эдгээр төслүүдэд багтааж болно.</p>
	Бүсчилсэн хөгжил	<p>1) ҮХЦТ нь хөрш зэргэлдээ аймгуудын ижил төстэй байдлыг байгаль орчин, эдийн засаг, газар ашиглалт, санхүү зэрэг 30 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн дүн шинжилгээ хийсний дүнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 баримт бичигт шинээр санал болгосон бүсчлэлийг дэмжсэн.</p> <p>2) Ижил төстэй аймгуудыг нэг бүсэд оруулан бүлэглэсэн шинэ бүсчлэл нь бүс тус бүрийн нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх илүү үр дүнтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжийг олгоно.</p>
	Орон нутгийн удирдлага	1) ҮХЦТ-д В багийн санал болгосончлон төсвийн ил тод байдал, хариуцлагатай удирдлагыг дэмжиж, аймгийн бие даасан байдлыг хангах зорилгоор төсвийн удирдлагыг тухайн орон нутагт шилжүүлэх саналыг санал болгосон.
	Боловсролын салбар	<p>1) ҮХЦТ нь боловсролын салбарын цогц шинэчлэлийг дэмжиж, дээд болон мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсрол, ерөнхий боловсролын чанарыг сайжруулах арга хэмжээнүүдийг санал болгосон.</p> <p>2) Ялангуяа үндэсний үнэт зүйлсээ дээдэлсэн сургуулийн өмнөх боловсролын тогтолцооноос эхлэн боловсролын салбарыг цогцоор нь шинэчлэх ажлыг эхлүүлж хөгжлийн шинэ загварыг дэмжих суурийг бүрдүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог бий болгох саналуудыг дэмжиж байна.</p> <p>3) В багийн багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, МХХТ-ийг ашиглан алсын зайны сургалтыг дэмжин боловсролын тэгш хүртээмжийг хангах, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зэрэг боловсролын салбарын тодорхой зөвлөмжүүдийг шинэчлэн боловсруулсан ҮХЦТ-д тусгана.</p>
С	Аялал жуулчлал	<p>1) С багаас гарсан аялал жуулчлалын хөгжлийн санаанууд ерөнхийдөө ҮХЦТ-д тусгагдсан байсан.</p> <p>2) ҮХЦТ-д “Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах төслийг санал болгосон бөгөөд ҮХЦТ-г боловсруулах төслийн хүрээнд уг төслийн туршилтын үе шатыг хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>3) Дотоод болон гадаадын жуулчдад зориулсан соёлын аялал жуулчлал, хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай танилцах аялал жуулчлалын хувьд олон нийтийн оролцоо нь зайлшгүй юм.</p>



		<p>4) Улаанбаатар хотын иргэд амралтын өдрүүдээр хөдөө орон нутгаар аялан цэцэрлэгжүүлэлтийн ажилд оролцох зэргээр дотоодын аялал жуулчлалыг төрөлжүүлж болно.</p> <p>5) Орон нутгийн иргэд нутгийнхаа бүтээгдэхүүнийг жуулчдад нийлүүлж, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх боломжтой.</p> <p>6) Монгол Улс нь олон улсын аялал жуулчлалын зах зээлд шинээр нэгдэж байгаа тул аялал жуулчлалын өрсөлдөх чадвар бүхий чиглэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээс илүүтэйгээр бие биенээ нөхөн дэмжсэн өөрийн гэсэн онцлог бүхий өвөрмөц аялал жуулчлалын чиглэлийг бий болгоход бүх оролцогч талууд хамтран ажиллах нь чухал юм.</p> <p>7) ҮХЦТ-д зөвхөн жуулчид болон аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдийг төдийгүй хамтарсан маркетинг явуулах олон төрлийн аж ахуйн нэгжүүдийг хооронд нь холбох аялал жуулчлалын мэдээллийг солилцох платформыг санал болгосон.</p>
	Хувийн хэвшлийг татан оролцуулсан дэд бүтцийн бүтээн байгуулалт	<p>1) С багийн санал болгосноор Монгол Улсад авто замын бүтээн байгуулалтад хувийн хэвшлийг оролцуулах нь хүндрэлтэй байх магадлалтай. Учир нь хөдөлгөөний эрчим өндөртэй авто зам бага тул төлбөртэй авто замыг ашиглахад ашигтай байх баталгаа бага.</p> <p>2) Авто замыг хөгжүүлэхтэй холбоотойгоор ҮХЦТ-д аялал жуулчлалын хөгжилд шаардлагатай олон нийтийн дэд бүтэц, тухайлбал авто зам, нийтийн зориулалттай барилга, байгууламжийг барьж байгуулах ажлыг санхүүжүүлэх Олон нийтийн хөгжлийн санг уул уурхай, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтаар байгуулахыг санал болгосон.</p>
D	Боловсролын салбар	<p>1) ҮХЦТ-д тусгасан боловсролын салбартай холбоотой саналуудыг 2021 онд Монгол Улс PISA үнэлгээнд хамрагдахаар санхүүгийн болон техникийн дэмжлэгийг авсан гэсэн үндэслэлд суурилан боловсруулсан.</p> <p>2) Тус үнэлгээнд хамрагдахын тулд ① бүх сургуулийг 2 ээлжтэй болгох (ингэхийн тулд багш нарын тоог нэмэх, зарим сургуулиудыг сэргээн засварлах шаардлагатай), ② малчдын амьдралын хэв маягт зохицсон ерөнхий боловсрол олгох үйл ажиллагааг нэвтрүүлэх гэсэн 2 нөхцөлийг юуны түрүүнд хангах шаардлагатай юм.</p> <p>3) D багийн санал болгосон багшийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх, гадаад хэлний мэдлэгийг сайжруулах, сургуулийн орчин, барилга байгууламжийг сайжруулах зэрэг боловсролын салбарт чиглэсэн ихэнх арга хэмжээнүүдийг дээрх нөхцлийн хүрээнд хэрэгжүүлэхээр ҮХЦТ-д тусгасан.</p> <p>4) Түүнчлэн ҮХЦТ-д мэргэжлийн сургууль, технологийн коллежид дэмжлэг үзүүлэх төлөвлөлтүүдийг тусгасан.</p> <p>5) Хувийн болон төрийн өмчийн сургуулиудын боловсролын чанарын ялгааг бууруулах ганц арга зам бол төрийн өмчийн сургуулиудын барилга байгууламж, сургалтын хөтөлбөр, багш нарын чадавхыг дээшлүүлэх, сайжруулах юм.</p>
	Аж үйлдвэрийн салбар	<p>ҮХЦТ-д аж үйлдвэрийн салбарыг дэмжихээр дараах арга хэмжээнүүдийг санал болгосон. Үүнд: хууль эрх зүйн болон бодлогын хүрээг тодорхойлох; ЖДҮ-ийн ажилтнуудыг сургахад туслалцаа үзүүлэх зэргээр хүний нөөцийг хөгжүүлэх; худалдааны чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлэх замаар гадаадын шууд хөрөнгө оруулалт болон дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих; санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах; старт-ап бизнес, бизнес инкубатор, инновацийг дэмжих.</p>
	Импорт, экспорт	<p>1) ҮХЦТ-д импорт, экспорт, дотоодын ачаа тээвэрлэлтийг дэмжих тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан.</p> <p>2) Гэрийн тэжээвэр амьтдын хоолыг үйлдвэрлэх нь хэрэгжих боломжтой санал боловч экспортод чиглэсэн хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ихээхэн хугацаа шаардлагатай.</p>
	Мал аж ахуй	А багт өгсөн хариултыг харна уу.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## **(2) Хөгжлийн үе шат**

Хөгжлийн хувилбар нь 20-р зууны хөгжлийн загвараас илүүтэйгээр нийгэм, эдийн засгийн хөгжлийн өөр загвар руу Монгол Улс шилжин, хөгжих үйл явцыг үзүүлсэн болно. Өөрөөр хэлбэл ТХҮБ 2030 баримт бичгийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс нь 20-р зууны хөгжлийн загвар болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбарыг хослуулсан холимог загвараар хөгжиж эхлэн цаашдаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбар руу аажмаар шилжин хөгжих болно. ҮХЦТ-г Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 баримт бичгийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулж байгаа бөгөөд ҮХЦТ-ний хөгжлийн хувилбарууд нь хөгжлийн шинэ загвар руу шилжих үйл явцыг дүрслэн харуулж байгаа юм. Хөгжлийн хувилбарыг гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд: I үе шат 2025 он хүртэл, II үе шат 2026-2030 он, III үе шат 2031-2040 он. Үе шат тус бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг дараагийн хэсэгт тусган, оруулав.

Монгол Улсын 20-р зууны хөгжлийн загвар бус нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг үе шат тус бүрээр тодорхойлон, тусгах нь зүйтэй. Тэдгээр үйл ажиллагааг доор дурдан оруулав. Үүнд:

- (a) Соёл, байгалийн нөөц баялийг Монгол Улсын хөрөнгө гэдгийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн менежментийг сайжруулах, хадгалан хамгаалах шаардлагатай бөгөөд ингэснээр соёл, байгалийн нөөц баялаг нь хэдэн арван жилийн туршид ард иргэдэд үр өгөөжөө өгөх болно.
- (b) Нутгийн захиргааны байгууллага болон олон нийтийн оролцоотойгоор байгалийн нөөцийн менежментийг сайжруулах үүднээс хөгжлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хэрэгтэй.
- (c) Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс эдийн засгийн үйл ажиллагаа, экспортыг төрөлжүүлэх шаардлагатай.
- (d) Эдийн засгийн төрөлжилтийг дэмжих эдийн засгийн шинэ үйл ажиллагаа болон дэд бүтцийг барьж байгуулахад хөрөнгө оруулах зорилгоор хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загвараар хөгжихөд эдгээр үйл ажиллагаа нь харилцан бие биенээ дэмжиж, үе шаттайгаар хэрэгжинэ.

### **8.1.2 I үе шат 2025 он хүртэл**

#### **(1) Тойм**

I үе шат бол нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загвар руу шилжин хөгжих бэлтгэл үе шат юм. 20-р зууны хөгжлийн загварын дагуу эдийн засгийн ихэнх үйл ажиллагаа үргэлжлэн явагдана. Тухайбал эдийн засгийн өсөлтийг хангах, хөрөнгийн хуримтлалыг бий болгох уул уурхайн салбарын өсөлт хэвээр хадгалагдах боловч аажимдаа хариуцлагатай уул уурхайн зарчимд шилжинэ. Хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах хариуцлагатай уул уурхайн зарчмыг бэлтгэл үе шатанд нарийн чанд тогтоох

шаардлагатай бөгөөд Бүлэг 8.4.1-т санал болгон тусгав.

Хариуцлагатай уул уурхайн салбараас олох орлогоор хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлж, эрдэс, газар тариалан болон мал аж ахуйн гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх зэрэг эдийн засгийн шинэ үйл ажиллагаанд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх болно. Боловсруулалт хийж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, төрөлжүүлнэ. Боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эд бэлтгэн, нийлүүлэх бүсэд байгуулна. Цаашид нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эд болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг хадгалах агуулахуудыг байгуулна.

Боловсруулах үйлдвэрүүдээс хот, сууриныг болон хот, сууринаас экспортын зах зээлийг холбосон зам, тээврийн сүлжээ, гол дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийнэ. Эдгээр хот, суурины чиг үүргийг эрэмбэлэн сайжруулна. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ажлын хүрээнд уул уурхайгаас олсон орологоор уул уурхай дагасан хотуудын дэд бүтцийг сайжруулна. Энэхүү зорилгоор олон нийтийн хөгжлийн сан бүрдүүлэх боломжтой.

I үе шатанд нутгийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх шаардлагатай. Аймгуудад зохион байгуулсан хэлэлцүүлгийн хүрээнд олон нийтийн санал авах үйл ажиллагааг өргөжүүлэн, орон нутгийн иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх үүднээс олон нийтийн оролцоотойгоор эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, эрчимжсэн мал аж ахуйн барилга байгууламжийг төлөвлөн, барьж байгуулах нь зүйтэй. Хөрөнгийн эх үүсвэрийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өөр эх үүсвэр, нөөц бололцоог дайчлах хэрэгтэй (гадаадад ажиллаж буй иргэдийн мөнгөн гуйвуулга). Энэ үе шатанд бүх салбарт дижитал шилжилт нэвтрүүлнэ.

Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн COVID-19-ийн хариу арга хэмжээ нь энэ үе шатанд бүх салбарт ялангуяа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, малчдад үзүүлэх дэмжлэг зэрэгт нөлөөлнө. Энэхүү цар тахлын нөхцөл байдал нь нийгмийн салбарт шинэ системийг нэвтрүүлэх боломжийг олгож байгаа тул хямралыг даван туулсны дараа эерэг нөлөө гарсан байна.

## **(2) Эдийн засгийн хөгжил**

Эдийн засгийн харьцангуй өндөр өсөлтийг хангах зорилгоор ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах бөгөөд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр бий болгох зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх нь зүйтэй. Түүхий нүүрсийг угаан, баяжуулж, шахмал түлш үйлдвэрлэн, чанартай нүүрсийг дотоодын зах зээлд нийлүүлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ цэвэр нүүрс үйлдвэрлэх шинэ технологи нэвтрүүлэх ажлыг санаачлан, эхлүүлэх хэрэгтэй. Төмөр, зэсийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн, зах зээлд нийлүүлнэ.

Томоохон хотуудын орчим болон томоохон хотуудыг холбосон гол авто замын дагуу илүү эрчимжсэн суурин мал, амьтны аж ахуйг хөгжүүлэн, чанартай мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хот, суурины зах зээлд нийлүүлнэ. Хот, суурин, гол замуудаас зайтай хөдөө орон нутагт уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх, бэлчээрийн доройтол, даац хэтрэлтээс сэргийлэн бэлчээр ашиглалтыг хянах бүсийг тогтооно. Энэхүү бүсэд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй болон хагас эрчимжсэн суурин мал, амьтны аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.

Эрчимжсэн, хагас эрчимжсэн суурин мал, амьтны аж ахуйг хөгжүүлэхийн тулд тухайн бүс нутагт малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. Үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг бүрэн хангах үйл ажиллагааны хүрээнд тариалангийг талбайг өргөтгөх шаардлагатай. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх ажлын хүрээнд хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ. Нарийн ногоо тарьж, ургуулах газар доорх хүлэмж зэрэг шинэ төрлийн хүлэмжийг нэвтрүүлэх ажлыг туршиж үзэх хэрэгтэй.

Уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг төрөлжүүлж, эрчимжүүлэн хөгжүүлнэ. Эдгээр үйлдвэрүүд нь түүхий эдийн анхан шатны үйлдвэрлэл болон орон нутгийн боловсруулах үйлдвэрүүдийг холбон үйлдвэрлэлийн кластерыг үе шаттайгаар үүсгэх бөгөөд тэдгээрийн зарим нь экспортын баримжаатай үйлдвэр болон хөгжинө. Зах зээл, экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх зорилгоор хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын технологийн шинэчлэл, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаарх санаачилгыг төрөөс дэмжин, ажиллах шаардлагатай. Чацаргана жимсний үйлдвэрлэлийн кластер нь Монгол Улсын экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийн кластерын анхдагч болох боломжтой. Түүний дараагийнх нь мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэлийн кластер байж болох юм.

Төлөвлөсөн аж үйлдвэрийн паркуудаас Улаанбаатар хотын ойролцоо байрших аж үйлдвэрийн парк хурдацтай хөгжинө. Дархан хотод Үйлдвэрлэл технологийн парк, Сайншанд хотод Хүнд аж үйлдвэрийн цогцолборыг байгуулж эхэлнэ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийг үйлдвэрлэл, технологийн паркийн үзэл баримтлал, холбогдох технологи, зах зээлийг хамруулан үйлдвэрлэлийн кластер байгуулах үүднээс нарийвчлан судалсны дараа байгуулах нь зүйтэй. Хилийн боомтод худалдааны чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулахаар төлөвлөсөн бөгөөд Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын орчимд Төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар шинэ чөлөөт бүсийг үе шаттайгаар байгуулах шаардлагатай.

### **(3) Нийгмийн хөгжил**

Уул уурхайгаас хамааралтай эдийн засгийн өсөлт, Улаанбаатар хот болон түүний орчимд хөрөнгө оруулалт төвлөрч байгаа тохиолдолд гадаад улс руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн болон хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн үргэлжлэх бөгөөд хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал хэвээр хадгалагдана. Орон нутгийн хотуудад ажлын байр бий болгох эдийн засгийн шинэ үйл ажиллагаа хязгаарлагдмал байх тул ур чадварыг сайжруулах, техникийн болон мэргэжлийн сургалтын хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэнэ. Орлого нэмэгдэхийн хэрээр суурь болон дээд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт аажмаар нэмэгдэнэ.

Хүлээгдэж буй эдгээр өөрчлөлтийн улмаас улсын төсвөөс нийгмийн салбарт хуваарилах төсөв, хөрөнгийг эргэн харах шаардлагатай. Энэхүү ажлын хүрээнд боловсролын салбарын шинэчлэлийг үндсэн хоёр чиглэлээр эхлүүлэх хэрэгтэй. Нэг нь эдийн засаг тэлэхийн хэрээр хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг мэргэжлийн боловсрол, сургалт болон дээд боловсролын тогтолцоог бүрдүүлнэ. Нөгөө нь хөгжлийн шинэ загвараар хөгжихөд шаардлагатай үндэсний үнэт зүйлсээ дээдэлсэн Монгол хүнийг төлөвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсролын тогтолцооноос эхлэн сайжруулах нь зүйтэй. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

нь анхан шатны болон урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд анхаарлаа хандуулах ёстой. Улсын төсвийн хуваарилалтыг илүү оновчтой болгохын тулд халамж, тэтгэвэр, нийгмийн даатгалд хамрагдалтыг илүү зорилтот бүтэцтэй болгож нийгмийн халамжийн үйлчилгээг шинэчлэх шаардлагатай.

Хөрш орнуудыг холбосон тээврийн коридорын дагуу байрладаг далайд гарцгүй Монгол Улсын хувьд COVID-19 цар тахлын улмаас худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа удааширсан нь өрхийн амьжиргаанд ихээхэн нөлөө үзүүлж байна. Гэвч Засгийн газраас социалист маягийн уламжлалт нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлснээр түүний үр нөлөөг бууруулсан. Цар тахлын дараах үед социалист маягийн уламжлалт нийгмийн хамгааллын үйлчилгээг ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй заяагдмал нөөц баялаг, гадагш чиглэсэн бодлого, дээр дурдсан нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэлд үндэслэсэн хөгжлийн шинэ загвартай хослуулбал 'илүү хурдан сэргэх' боломж олдоно.

#### **(4) Орон зайн төлөвлөлт**

Улсын чанартай гол замуудыг сайжруулах, аймгийн төвүүдийг холбосон болон хайрган замуудыг хатуу хучилттай болгох шаардлагатай. Түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалт, экспортын зах зээлийг холбосон авто замуудыг сонгон, барьж байгуулна. Улаанбаатар хот болон зарим орон нутгийн хотуудын дэд бүтцийг сайжруулах шаардлагатай. Үүнд аялал жуулчлал, аж үйлдвэр, уул уурхай дагасан хотууд орох бөгөөд цөөн хэдэн хотыг сонгож, олон улсын худалдаа логистикийн төв болгон хөгжүүлэх боломжтой.

Зарим чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт, хилийн боомтын барилга, байгууламж зэрэг тээвэр, логистикийн сүлжээг бүрдүүлдэг томоохон байгууламжийн ТЭЗҮ-г боловсруулан, барьж байгуулна.

Баруун, Хангайн, Алтайн, Зүүн бүсийн дэд бүтцийн босоо тэнхлэгийг байгуулахад хувь нэмэр оруулах үүднээс зарим хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах талаар ОХУ, БНХАУ-тай яриа, хэлэлцээр хийх хэрэгтэй.

Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эд бэлтгэх, тээвэрлэх, хөдөө аж ахуйн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах зорилгоор хөдөө орон нутгийн зарим авто замыг сайжруулах шаардлагатай. Дээрх бүлэгт санал болгосон Олон нийтийн хөгжлийн сангийн хөрөнгөөр уул уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд тэдгээр замыг сайжруулах боломжтой юм.

#### **(5) Байгаль орчин**

Уул уурхайгаас хамааралтай эдийн засгийн хөгжлөөс шалтгаалан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө үргэлжлэх боловч байгаль орчны боловсрол, олон нийтэд сурталчлах үйл ажиллагааны үр дүнд хариуцлагатай уул уурхайн талаарх иргэдийн мэдлэг ойлголт сайжирна. Улаанбаатар хотод тулгарч буй байгаль орчны асуудлууд хэвээр үргэлжлэх боловч Улаанбаатар хотын дагуул хотуудын хөгжил нь байгаль орчны доройтлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ. Хөгжлийн энэхүү үе шатанд орон нутгийн захиргааны байгууллагуудын чадавх бэхжсэнээр байгаль орчны хяналтад орон нутгийн иргэдийн оролцоо нэмэгдэж, албан ёсны тогтолцоо бүрдэнэ. Энэ нь газар тариалан, мал аж ахуйг зүй зохистой эрхлэн, бэлчээр ашиглалтын хяналт бүхий газрыг тогтоосноор газрын доройтлыг бууруулна.

### 8.1.3 II үе шат 2026-2030 он

#### (1) Тойм

Энэ үе шатанд нийгэм, эдийн засгийн бүтцийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварт тохируулан өөрчлөх ажил идэвхтэй хийгдэнэ. I үе шатанд санаачлагдсан эдийн засгийн шинэ үйл ажиллагаанууд бүрэн хөгжиж, эдийн засгийн нэмэлт шинэ үйл ажиллагаа явагдана. Эдгээр үйл ажиллагааны ихэнх нь анхдагч бүтээгдэхүүн дээр суурилсан аж үйлдвэрийн босоо кластер хэлбэрээр хөгжинө.

Хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа өргөжин, тэлж уул уурхайн салбар аажмаар хөгжсөөр байх болно. Уул уурхайн салбарын өсөлт нь үе шаттайгаар саарах ба II үе шатны төгсгөлд тэг өсөлтийн байдалд хүрнэ. Гэсэн хэдий ч нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, илүү олон ажлын байрыг бий болгох зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх хэмжээ нэмэгдэх тул уул уурхайн салбарын эдийн засагт оруулах хувь нэмэр ач холбогдолтой хэвээр байх болно.

II үе шатны бүхий л хугацаанд төрийн удирдлагын зарим чиг үүрэг, эрх мэдлийг орон нутгийн захиргааны байгууллагуудад шилжүүлэх ажил үргэлжилнэ. Төрийн зарим чиг үүргийг орон нутгийн захиргааны байгууллагуудад шилжүүлэх болно. Байгаль орчны хяналт, менежментийг хамгийн түрүүнд шилжүүлэх болно. Орон нутгийн байгууламжийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх хамтын ажиллагааны механизмыг институцийн хэлбэр оруулна.

#### (2) Эдийн засгийн хөгжил

Чацарганы аж ахуй болон МАА-н кластерууд зэрэг I үе шатанд байгуулсан аж үйлдвэрийн кластеруудыг бүрэн хөгжүүлнэ. Чацарганы аж ахуйн кластер нь зөвхөн чацарганы шүүс үйлдвэрлээд зогсохгүй шүүснээс гаргаж авсан эфирийн тосоор гоо сайхны болон эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Эдгээр өндөр үнэ цэнэтэй бүтээгдэхүүнүүдийн зарим нь барууны өндөр хөгжилтэй орнуудын ашигтай зах зээлд гарах боломжтой.

МАА-н үйлдвэрлэлийн кластер нь сайн чанарын мах, сүүн бүтээгдэхүүн болон ноос, ноолуур, арьс ширээр хувцас хэрэглэл үйлдвэрлээд зогсохгүй халал хүнс, гэрийн тэжээвэр амьтны хоол болон хонь, адууны ихэсээр эм, гоо сайхны бүтээгдэхүүн, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Эцэст нь яс, цус гэх зэрэг МАА-н бүхий л түүхий эдийг хаягдалгүйгээр бүрэн ашиглах боломжтой болно. Технологийн шинэчлэл, зах зээлийн хөгжлийн хамт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Засгийн газрын дэмжлэгтэйгээр бусад үйлдвэрлэлийн кластерууд хөгжиж эхэлнэ.

Уул уурхай нь ажлын байрыг нэмэгдүүлэх бөгөөд орон нутгийн үйлдвэрүүдийг түүхий эдээр ханган, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувь нэмэр оруулна. Төмөр, зэс дээр суурилсан эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь эдгээр бүтээгдэхүүнийг олон улсын зах зээл дээр борлуулах боломжийг Монгол Улсад олгоно. Гадаадын хөрөнгө оруулалт болон технологийг нэвтрүүлснээр уран болон газрын ховор элементүүд зэрэг уул уурхайн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эхлүүлэх боломжтой болно.

Улаанбаатар хотод болон хотоос гадуур аж үйлдвэрийн паркуудыг нэмж байгуулна. ОХУ болон БНХАУ-ын хил дагуух худалдааны чөлөөт бүс, эдийн засгийн онцгой бүсийг хөгжүүлэх ажлыг хилийн худалдааг дэмжих байгууламж



болон институцүүдийг сайжруулах ажилтай хамтаар түргэтгэх хэрэгтэй.

Олон төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор дотоодын аяллын агентлаг, тур операторууд нь олон улсын аялал жуулчлалын агентлагуудтай шууд хамтран ажиллана. Өвлийн аялал жуулчлалын хөтөлбөр зэргийг багтаасан олон төрлийн аяллын хөтөлбөрийг боловсруулж Мөрөн, Ховд, Цэцэрлэг зэрэг цөөн хотуудыг аялал жуулчлалын суурь болгон бэхжүүлэх хэрэгтэй.

### **(3) Нийгмийн хөгжил**

Орон нутаг дахь эдийн засгийн шинэ үйл ажиллагааны улмаас ажлын байр нэмэгдэж, гадаад улс руу болон хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурч, хот хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал багасна. Хөгжлийн I үе шатанд сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны боловсрол олгосноор нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ. Үүгээр дамжуулан хүүхдийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Нийгмийн халамж, аюулгүй байдлыг хөгжлийн тэргүүн эгнээнд тавих үзэл санааг үндэслэлтэй болгож, нийгэмд өргөнөөр хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй. Эрүүл ажиллах хүчийг дэмжихийн тулд эрүүл мэндийн анхан шатны болон урьдчилан сэргийлэх тусламжид ихээхэн анхаарал хандуулах ёстой. Нийгмийн халамжийн үйлчилгээнээс хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хувийн хэвшилд шилжүүлэх боломжтой.

### **(4) Орон зайн төлөвлөлт**

Тайлангийн дэд Бүлэг 4.3-т санал болгосон Монгол Улсын төвийн бүсийн нутаг дэвсгэрийг хамруулан тойрог коридорыг байгуулах бөгөөд ингэхдээ шаардлагатай хатуу хучилттай замыг барьж, байгуулах буюу замын чанарын шаардлага хангахгүй хэсгүүдийг коридорын чиглэлд тохируулан өөрчилж, сайжруулна. Тойрог коридорын хойд хэсэг нь ОХУ-ын хил дагуух аялал жуулчлалын бүсүүдийг үр дүнтэй холбох бөгөөд урд хэсэг нь БНХАУ-тай хиллэх хил орчмын бүс нутгаас хөгжингүй төвийн бүс рүү хүрэх боломжийг нэмэгдүүлнэ. Тойрог коридорын зүүн төгсгөлд орших Өндөрхаан хот нь Зүүн бүс рүү холбогдох гарц болох бөгөөд коридорын баруун төгсгөлд орших Улиастай хот нь Баруун бүс рүү холбогдох гарц болно. Тойрог коридор нь бүхэлдээ улсын нутаг дэвсгэрийн орон зайн нэгдсэн байдлыг бэхжүүлнэ.

Тойрог коридорын дотор орших нутаг дэвсгэр нь 21 дүгээр зуунд Монгол Улсын хөгжлийг түүчээлэх, чанартай дэд бүтэц бүхий гол бүс нутаг болон хөгжих боломжтой. Энэ үе шатны эхэн үед Баруун бүсийн Улиастай болон Зүүн бүсийн Өндөрхаан хотыг Улаанбаатар хотоор дайруулан холбосон харилцаа холбооны бас нэгэн суурь шугамыг барьж болно.

Хотын зэрэглэлийн ангиллын хувьд дээгүүр зэрэглэлтэй томоохон хот, суурингуудыг тодорхойлсон чиг үүргийн дагуу хөгжүүлнэ. Бүсийн хөгжлийн тулгуур төв хотуудыг хэд хэдэн чиг үүрэгтэйгээр хөгжүүлэх хэрэгтэй ба магадгүй зарим нь засаг захиргааны шинэ статустай болно. Тойрог коридор дагуух Өндөрхаан болон Улиастай зэрэг хотуудын дэд бүтцийг сайжруулахад нэн тэргүүний ач холбогдол өгөх шаардлагатай.

Тойрог коридор болон I үе шатанд аймгуудыг холбосон замуудыг барьж, байгуулснаар улс даяар хөдөө орон нутаг руу аялах боломжийг бүрдүүлнэ. Уул

уурхай болон аялал жуулчлалын томоохон бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг Олон нийтийн хөгжлийн сангийн хөрөнгөөр барьж, байгуулна.

## **(5) Байгаль орчин**

Хариуцлагатай уул уурхайг эрчимтэй хөгжүүлснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө буурна. Улаанбаатар хотын дагуул хотууд хөгжихийн хэрээр хотын байгаль орчны доройтол багасна. Орон нутгийн хотуудын хүн ам өсөж, эдийн засгийн үйл ажиллагаа эрчимжихийн зэрэгцээ эдгээр хотуудад байгаль орчны асуудлууд тулгамдах магадлалтай байна. Нутгийн удирдлагын байгууллагуудын байгаль орчны хяналтыг иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх замаар бэхжүүлнэ.

### **8.1.4 III үе шат 2031-2040 он**

#### **(1) Тойм**

Энэ үе шатанд Монгол Улс нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангасан шинэ загвар руу бүрэн шилжсэн байна. Хөгжлийн шинэ загвар руу бүрэн шилжихийн тулд ТХЗ, ТХҮБ 2030-ын биелэлтийг дүгнэж, хөгжлийн стратеги, тэргүүлэх чиглэлүүдийн өөрчилж, шинэчлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлно. Монгол Улсын ОХУ, БНХАУ болон бусад улс, орнуудтай харилцах идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаа, худалдаа болон гадаадаас Монгол Улс руу, Монгол Улсаас гадагш чиглэсэн эрчимтэй шилжилт хөдөлгөөн энэ үе шатны онцлог нь байна. Энэ үе шатанд, гадаадын улс орнуудад ажиллаж амьдарч байгаа Монголчууд эх орныхоо хөгжил дэвшилж гар бие оролцохын тулд буцаж ирнэ.

Улаанбаатар хот нь Монгол Улсын улс төр, эдийн засгийн гол төв төдийгүй дэлхийн улс орнуудтай худалдаа, харилцаа, хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх олон улсын бизнесийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. МХХТ-ийн сүлжээ, дэд бүтэц, магадгүй метроны сүлжээ бүхий нийтийн тээврийн дэвшилтэт системтэй, ногоон байгууламжтай, тохилог орчин бүрдүүлсэн ногоон хөгжлийн загвар мега хот болон хөгжинө.

Энэхүү үе шатанд төрийн зарим чиг үүргийг нутгийн удирдлагын байгууллагуудад үе шаттайгаар шилжүүлэх, хуваарилах үйл ажиллагаа үргэлжилнэ. Хөгжлийн удирдлагыг нутагшуулах ажлын хүрээнд оролцоонд суурилсан төлөвлөлт, хэрэгжилтийн механизмыг улсын хэмжээнд бүрэн нэвтрүүлнэ.

#### **(2) Эдийн засгийн хөгжил**

Анхан шатны бүтээгдэхүүнд суурилсан аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлж, эдийн засаг, экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх үйл ажиллагаа хамгийн өндөр түвшинд хүрнэ. Зарим үйлдвэрийн кластер нь орон нутгийн үйлдвэрүүдийг экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидтэй холбож, нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүний үр дүнд 2040 он гэхэд ядуурлын түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулна. Үйлдвэрлэл, маркетинг болон бусад туслах үйл ажиллагааны уялдаатай байдал хангагдаж, аж үйлдвэрийн кластеруудыг үр дүнтэйгээр хөгжүүлэхийн тулд оролцогч талууд мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглаж холбоно.

Аж үйлдвэрийн кластеруудын үйл ажиллагаа уялдаж, хамтарч ажилласнаар аж үйлдвэрийн цогцолборыг байгуулна. Аялал жуулчлалын салбарыг өргөжүүлэх бодлогын хүрээнд эрүүл мэндийн бүтээгдэхүүн, косметик, эм, эмийн түүхий эд

зэргийг ашиглаж аялал жуулчлал, алжаал тайлах үйлчилгээг хослуулсан цогцолборыг байгуулж болно. Логистик, аялал жуулчлалын гэх мэт үйлчилгээнд суурилсан кластеруудыг дагнан хөгжүүлж болно. Түүнчлэн экспортод гаргах уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлнэ. Дэлхийд танигдсан экспортын бараа бүтээгдэхүүнүүдийг нийлүүлж эхэлнэ.

Хил орчмын хот, суурин газруудад ОХУ, БНХАУ-тай хамтран ажиллаж, дотоодын нөөц баялагтаа түшиглэж ЭЗ-ийн чөлөөт бүс байгуулах ажил шинэ шатанд гарна. Чөлөөт бүсэд үйлчилгээний салбарын ААН, байгууллагуудыг түлхүү дэмжсэнээр иргэд чөлөөтэй худалдаа эрхлэх, хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

### **(3) Нийгмийн хөгжил**

Орон нутгийн хотуудад ажлын байр нэмэгдэх нь гэр бүлийн харилцаа, хамт олны эв нэгдлийг хангахад тустай боловч хотжилттой холбоотой зарим нэг нийгмийн асуудлууд үүсэж болзошгүй. Эдийн засгийн шинэ үйл ажиллагаа эрхлэн явуулах иргэд олноор шилжин ирэх нь нутгийн уугуул иргэд болон шилжин ирэгсэдийн хооронд ус зэрэг байгалийн нөөц баялгийг ашиглахтай холбоотой зөрчил үүсгэж магадгүй юм.

Эдийн засгийн өсөлтийг хангаж, капиталын хуримтлал, улсын төсвийн хэмжээг нэмэгдүүлснээр гадаадад ажиллаж, амьдарч байгаад Монгол Улсад буцаж ирсэн иргэдийн нийгмийн асуудлыг орхигдуулалгүй бүх хүнд хүртээмжтэй, чанартай нийгмийн цогц үйлчилгээг үзүүлж, нийгмийн хөгжлийг ахисан түвшинд хүргэнэ. Иргэдийн амьжиргаагаа дээшлүүлэх үйл ажиллагааг экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд нийлүүлэлт хийдэг орон нутгийн үйлдвэрлэлтэй нийцүүлж, уялдуулснаар ядуурлын түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулна.

### **(4) Орон зайн төлөвлөлт**

Тойрог коридорыг байгуулснаар гол авто замын сүлжээ бүрэн ашиглалтад орох бөгөөд түүнийг даган хөдөө, орон нутгийг холбосон замын сүлжээ өргөжин, хөгжинө. Түүхий эд бэлтгэл, боловсруулах үйлдвэр, логистикийн төвүүдийг холбосон олон үйлдэлт системд суурилсан тээвэр, логистикийн сүлжээг байгуулна. Олон үйлдэлт системийн нэг хэсэг болох төмөр замыг зорчигч тээвэрт түлхүү ашиглана.

Том хотуудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсноор хотуудын зэрэглэл илүү боловсронгуй болно. Бүсийн хөгжлийн тулгуур төв хотуудын чиг үүрэг өргөжинө. Мөрөн, Ховд хотуудад олон улсын аялал жуулчлал, худалдааны үйлчилгээг төвлөрүүлж, Эрдэнэт, Дархан, Чойбалсан хотуудад дээд боловсролын сургалтын байгууллагууд, нийгэм, эдийн засгийн хөгжлийн загварын судалгааны төвүүдийг байршуулж, Чойр хотод цэвэр эрчим хүч үйлдвэрлэх станц, Алтай хотод сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх станцыг барьж байгуулах боломжтой. Түүнчлэн эрүүл мэндийн болон алжаал тайлах үйлчилгээ үзүүлэх, байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх зэрэг чиг үүргийг том хотуудын чиг үүрэг дээр нэмж болно.

Нэг нэгнийхээ хөгжилд эерэгээр нөлөөлдөг томоохон хотуудын сүлжээг бий болгохын тулд хөрш зэргэлдээ орнуудын хотуудыг хотын зэрэглэлд хамруулж болно. Тухайлбал Өвөр Монголын өөртөө засах орон, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын хотуудыг хамруулж болно. Хил орчмын хотуудын хөгжлийн нэгдсэн менежмент нь хөгжлийн хамтын ажиллагааны жишиг болно.

## **(5) Байгаль орчин**

Бүс нутгийн эдийн засгийн хөгжлөөс хамааран нутгийн удирдлагын байгууллагуудын санхүүгийн, удирдлагын чадавх дээшилсний үр дүнд орон нутагт байгаль орчны хяналт нэлээд сайжирна. Энэ нь орон нутгийн хотуудад хатуу хог хаягдлын менежмент, ус хангамж, ус зайлуулах суваг зэрэг байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд тус нэмэр болно. Цаашдаа Улаанбаатар хотын дагуул хотууд хөгжсөнөөр нийслэл хот нөөц бололцоогоо дайчлан хангалттай ногоон байгууламж, амарч зугаалах орчин бүхий чанартай амьдрах орчинг бүрдүүлнэ.

### **8.1.5 Монгол Улсын хөгжлийн төсөөлөл (2040 оноор)**

Монгол Улсын 2040 оны дүр төрх, онцлог шинжийг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

- (a) Төв Азийн улс, орнуудтай эдийн засгийн харилцаагаа бэхжүүлсэн, дэлхийн эдийн засаг, засаглалын хөгжилд хувь нэмэр оруулдаг тогтвортой, хүчирхэг улс;
- (b) Үр ашигтай үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлсэн, уламжлалт мал аж ахуй эрхэлдэг, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлсэн, иргэдийн оролцоотой нөөц, баялгийн ашиглалт, менежментийг хэрэгжүүлдэг өөрийн онцлогтой, байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөц, баялгийн зүй бус ашиглалтаас зайлсхийсэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг цогцлоосон жишиг улс;
- (c) Ард түмнийхээ баялаг соёлын өв, байгалийн өвөрмөц тогтоцтой газруудад түшиглэсэн, гадаад, дотоодын жуулчдад зориулсан төрөл бүрийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, аяллын хөтөлбөр бүхий аялал жуулчлалын бүс нутаг;
- (d) Говьсүмбэр аймагт цэвэр эрчим хүч үйлдвэрлэх станц, Говь-Алтай аймагт сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх станц, Дархан-Уул аймагт байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх төвийг байгуулж, өндөр чанартай боловсрол, судалгааны институтуудад түшиглэж байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлсэн улс;
- (e) Хөрш орнуудтай холбогдсон логистикийн сүлжээ, тусгай чиг үүрэг бүхий томоохон хотуудын сүлжээ, нийгэмд эзлэх байр суурь, оюун санаа, сэтгэхүй, соёлоороо ялгаатай олон ястан хамтран амьдардаг худалдаа, харилцаа холбоог эрчимтэй хөгжүүлсэн бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжсэн улс;
- (f) Олон зуун км үргэлжлэх уул нурууд, баялаг ойн сан, өргөн уудам бэлчээрийнхээ байгалийн унаган төрхийг хамгаалах, хадгалах ногоон хөгжлийн бодлоготой улс;

(г) Орон нутгийн нөөц баялгаа нутгийн иргэд өөрсдөө ашиглаж, боловсруулж үр ашгийг нь хүртдэг зохион байгуулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үр дүнтэйгээр нэвтрүүлсэн бие даасан бүсүүдтэй улс.

## 8.2 Гол төсөл, хөтөлбөрүүд бүхий хөгжлийн төлөвлөгөө

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулсан бөгөөд аймгуудад хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрүүдийн саналыг мөн боловсруулав. Төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс цогц байдлаар нарийвчилж судалсан болно. Төсөл, хөтөлбөрүүдийн уялдаатай байдлыг хангахын тулд дараах байдлаар 4 ангилав. Үүнд:

- i. Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд;
- ii. Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд;
- iii. Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд болон
- iv. Ногоон хөгжлийг дэмжих төслүүд багтаж байна.

Санал болгосон төслүүдээс Монгол Улсыг 20-р зууны хөгжлийн загвараас нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангасан шинэ загвар руу шилжих үйл явцыг дэмжих гол төслүүдийг сонгоно. Гол төслүүдийг хэрэгжүүлснээр хөгжлийн нэг загвараас нөгөө рүү шилжих явцад нийгэм, эдийн засаг, орон зайн төлөвлөлтийг хийх нөхцөл бүрдэх ба төслүүдийг хэрэгжүүлж эхлэхийн тулд шилжилтийн I үе шатанд тодорхой арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн танилцуулгыг Бүлэг 9-д үзүүлэв.

### (1) Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд

Хүснэгт 8.2.1-д тусгасан төсөл, хөтөлбөрүүд нь байгаль, түүх, соёлын нөөц баялаг ихтэй, дотоодын зах зээлийн багтаамж харьцангуй жижиг Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн бодлогын нэг болох гадагш чиглэсэн хөгжлийн бодлогын хүрээнд эдийн засаг, экспортын бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх зорилготой. Нэн ялангуяа анхан шатны бүтээгдэхүүнд суурилсан аж үйлдвэрийн босоо кластерыг хөгжүүлж эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ. “\*” тэмдэглэгээгээр гол 10 төслийг тэмдэглэв.

#### Хүснэгт 8.2.1 Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд

I. Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд	
Д/д	Төслийн нэр
I1	Чөлөөт худалдааны бүс, Эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлэх төслүүд
	I1.1 Хилийн Чөлөөт худалдааны бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл *
	I1.2 Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлын Эдийн засгийн тусгай бүс /ЭЗТБ/-ийг хөгжүүлэх төсөл
I2	Аж үйлдвэрийн кластеруудыг дэмжих хөтөлбөрүүд
	I2.1 Чацарганы үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл*
	I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл *
I3	Инновацид суурилсан ХАА-н салбарыг хөгжүүлэх төслүүд
	I3.1 Ухаалаг хөдөө аж ахуйг дэмжих төсөл

	13.2	Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл *
	13.3	Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх төсөл *
14		МАА, газар тариалангийн салбар хосолсон төслүүд
	14.1	Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл
	14.2	Мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх төсөл*
15		Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх төслүүд
	15.1	Усжуулалтын төсөл
	15.2	Тосны ургамлын тариалалтын төсөл
	15.3	Чацарганы тариалалтын төсөл*
16		Үхрийн аж ахуйн хосолсон төслүүд
	16.1	Үхрийн аж ахуй эрхлэх төсөл
	16.2	Эрдэнэ шиш даршлах үйлдвэрийн төсөл
	16.3	Малын тэжээлийн төв байгуулах төсөл
	16.4	Хуурай сүү үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх төсөл
17		Хөдөө аж ахуйн салбарын зах зээлийн орчинг сайжруулах төслүүд
	17.1	Хөргүүр, зоорийн сүлжээ байгуулах төсөл
	17.2	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл*
18		Уул уурхайн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх төсөл, хөтөлбөрүүд
	18.1	Газрын ховор элементийн хайгуулын төсөл
	18.2	Эрдэс металлын нөөцийн хайгуулын төсөл
19		Нүүрсний салбарын шинэчлэлийн төслүүд
	19.1	Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл*
	19.2	Нүүрсний ордын хайгуулын төсөл
	19.3	Нүүрсний салбарын мастер төлөвлөгөөг боловсруулах төсөл
	19.4	Нүүрс боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх төсөл
110		Жуулчдыг татах шинэ үзмэрүүд бүхий аялал жуулчлалыг цогц хөгжүүлэх төслүүд
	110.1	Үлэг гүрвэлийн музей байгуулах төсөл
	110.2	“Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл*
	110.3	Гэр хороололд гар урлалын гудамж байгуулах төсөл
	110.4	Өвлийн спорт, амралтын төв байгуулах төсөл*
	110.5	Налайхын уурхайн музей, соёл, боловсролын төв байгуулах төсөл
	110.6	Аялал жуулчлалын салбарын мэдээллийн сан байгуулах төсөл
	110.7	Аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх төсөл

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

11 дугаартай төслүүд нь эдийн засаг, экспортын төрөлжилтийг нэмэгдүүлэх зорилгоор худалдааны чиглэлээр эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, хилийн бүсүүд болон олон улсын нисэх онгоцны шинэ буудлын ойролцоо тусгай бүс байгуулах, бүсүүдийн үйл ажиллагааг нь бэхжүүлэх зорилготой. 12 дугаартай 2 төслийг 14, 15 дугаартай төслүүдийн хамт хэрэгжүүлснээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. 13 дугаартай 3 төслийг хэрэгжүүлснээр МХХТ-ийн тусламжтайгаар хөдөө аж ахуйн салбарт шинэ техник, технологийг нэвтрүүлнэ. 16 дугаартай 4 төслийг хэрэгжүүлснээр үхрийн аж ахуй болон боловсруулах үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

17 дугаартай төслүүд нь дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар ХАА бүтээгдэхүүний маркетингийг сайжруулна. 18 дугаартай төслүүдийг хэрэгжүүлснээр уул уурхайн үйл ажиллагааг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. 19



дугаартай 4 төсөл нь нүүрсний экспортыг дэмжиж, нүүрсний салбарыг шинэчилнэ. I10 дугаартай 7 төслийг хэрэгжүүлснээр хүний гараар бүтсэн аялал жуулчлалын үзмэрүүдийг нэмж, аялал жуулчлалын үйл ажиллагааг төрөлжүүлж, Монгол Улсад ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэн аялал жуулчлалын салбарын хөгжилд түлхэц өгнө.

## (2) Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд

Энэхүү Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд нь МХХТ-ийн дэмжлэгтэйгээр мэдлэг, мэдээлэл өгөх бөгөөд боловсрол, сургалтаар дамжуулан эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, ажил эрхлэлтийг өргөжүүлэх замаар хөгжлийн шинэ загвар руу шилжин хөгжихөд иргэдийг чадавхжуулна. Эдгээр төсөл, хөтөлбөрүүдээс иргэдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээ, тэдний амьжиргаатай холбоотой хэрэгцээ шаардлагад нийцсэн төслүүдийг сонгохыг зорьсон болно. Хүснэгт 8.2.2-т төсөл, хөтөлбөрүүдийг жагсааж, “\*” тэмдэглэгээгээр гол 7 төслийг тэмдэглэсэн бөгөөд 5 төсөл бүхий МХХТ-д суурилсан тусгай хөтөлбөрийг тусгасан.

### Хүснэгт 8.2.2 Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд

II. Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд	
Д/д	Төслийн нэр
II1	Залуу малчдыг дэмжих төслүүд
II1.1	Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл *
II1.2	Малчдын хүүхдэд гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл
II2	Мэдээлэл, харилцаа холбооны технологийг мал аж ахуйн салбарт нэвтрүүлэх төслүүд
II2.1	Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл *
II2.2	Малчдын цогц мэдээллийн санг бий болгох төсөл
II3	Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл
II4	Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр *
II5	Бизнест чиглэсэн хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр
II6	Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл*
II7	Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл, хөтөлбөрүүд
II7.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл *
II7.2	Эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах төсөл
II7.3	Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), тэмбүү, гепатитын халдвар эхээс хүүхдэд дамжихаас урьдчилан сэргийлэх төсөл
II7.4	Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө өгөх /Телемедицин/ болон Оношлогооны зорилго бүхий эрүүл мэндийн хөдөлгөөнт цахим тусламж үйлчилгээг нэвтрүүлэх төсөл
II8	Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн төсөл
II9	Бизнесийн шинэ соёл, сэтгэлгээг хөгжүүлэх төслүүд
II9.1	Бүлгийн динамикийн төв байгуулах төсөл*
II9.2	Гүйцэтгэлийг үр дүнтэй болгоход чиглэсэн үйл ажиллагааны зөвлөгөө өгөх хөтөлбөр
II10	МХХТ-д суурилсан тусгай хөтөлбөр
II10.1	МХХТ-д суурилсан боловсролын салбарыг бэхжүүлэх төсөл
II10.2	Хөдөө, орон нутагт МХХТ-ийг хөгжүүлэх, МХХТ-т суурилсан загвар хотыг хөгжүүлэх
II10.3	Хөдөө, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээллийн нэгдсэн сүлжээ

	байгуулах төсөл
II10.4	Програм хангамжийн аутсорсингийг дэмжих төсөл
II10.5	МХХТ-ийн экосистемийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх төсөл

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

II1 дугаартай төслүүдийг хэрэгжүүлснээр уламжлалт болон орчин үеийн мал аж ахуй эрхлэх залуу үеийг бэлтгэж, иргэдийн амьжиргаа, аялал жуулчлалын салбарын суурь болсон уламжлалт мал аж ахуйн хэв шинжийг хадгалахад хувь нэмэр оруулна. II2 дугаартай төслүүд нь малчид болон нутгийн удирдлагын байгууллага, мэдээллийн баазыг холбосон үр дүнтэй харилцаа холбооны системийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. II3 дугаартай төслийг хэрэгжүүлснээр залуучуудын ур чадварыг сайжруулах, тэдний ур чадварт тохирсон ажлын байрны зуучлалыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. II4, II5 дугаартай төслүүдийг хэрэгжүүлснээр залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх дээшлүүлэх, бизнест чиглэсэн хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

II6 дугаартай төслийг хэрэгжүүлснээр хөгжлийн шинэ загвар руу шилжин хөгжихийн тулд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанарын болон тоон үзүүлэлтийг сайжруулж, хувьсан өөрчлөгдөж буй бизнесийн хэрэгцээ шаардлагыг хангах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, шинжлэх ухаанд суурилсан сургалтын сайжруулсан хөтөлбөрийг боловсруулж дээд болон техникийн боловсролын чанарыг дээшлүүлж, насан туршийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна. II7 дугаартай төслүүд нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой. II8 төсөл нь тэтгэмжид хамрагдагсадыг сонгох шалгуур, тэтгэвэр, тэтгэмжийн реформ, сангийн менежмент зэрэг нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулахад хувь нэмэр оруулна. II9 дугаартай төслүүдийг хэрэгжүүлсэнээр хөгжлийн шинэ загварыг нэвтрүүлэх зорилгоор бизнесийн шинэ соёл, сэтгэлгээг хөгжүүлнэ.

II10 дугаартай 5 төсөл нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, хувийн хэвшлийн бизнесийн хөгжлийг дэмжих, эдийн засгийн шинэ бүсүүдэд ажлын байрыг бий болгоход хувь нэмэр оруулна.

### (3) Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд

Хүснэгт 8.2.3 дахь төслүүд нь нийслэл хот болон бусад том хот, аймгийн төвүүдийг холбосон авто замын гол, дэд тэнхлэгүүдийн сүлжээг өндөр түвшинд төлөвлөж, хотын зэрэглэлээр томд тооцогддог сонгогдсон хот, суурин газруудын чиг үүргийг шинэчилж Монгол Улсын нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтыг бэхжүүлэх зорилготой. “\*” тэмдэглэгээгээр гол 5 төслийг тэмдэглэв.

#### Хүснэгт 8.2.3 Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд

III. Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд	
Д/д	Төслийн нэр
III1	Авто замын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл*
III2	Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл *
III3	Аймгуудын тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах төсөл
III4	Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл*
III5	Хойд-өмнөд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл *
III6	Улаанбаатар хотын тойруу зам, сүлжээг хөгжүүлэх төсөл
III7	Улаанбаатар хотын ачаа тээврийн терминалын газрыг дахин төлөвлөн

	байгуулах төсөл
III8	Хотын захын болон орон нутгийн тойруу замуудыг хөгжүүлэх төсөл
III9	Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хот байгуулах төсөл *
III10	Орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэх төсөл
III11	Бүсийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх төсөл
III12	Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг


III1 ба III2 дугаартай төслүүд нь томоохон хотуудыг аймгийн төвүүдтэй холбосон авто замын тойрог сүлжээ барьж байгуулах бөгөөд хилийн бүс нутаг, гадаадын улс орнууд руу нэвтрэх боломжийг нэмэгдүүлнэ. III3 дугаартай төслийн хүрээнд аймгуудын аялал жуулчлал, уул уурхай, хилийн худалдааг хөгжүүлэхэд шаардлагатай тусгай зориулалтын авто замыг сайжруулан, барьж байгуулна. III8 дугаартай төсөл нь хот хоорондын зам, тээврийн үр өгөөжийг сайжруулахад туслах ба томоохон хотуудад таатай, аюулгүй орчинг бүрдүүлэх боломж олгоно.

III4, III5, III6 дугаартай төмөр замын төслүүд нь хойд-өмнөд чиглэлийн коридороор дотоодын болон олон улсын худалдаа, тэр дундаа дамжин өнгөрөх худалдаа хийх боломжийг нэмэгдүүлнэ. III7 дугаартай төслийн хүрээнд нийслэл хотын орон зайн төлөвлөлт, чиг үүрэгтэй уялдуулан Улаанбаатар хотын ачаа тээврийн терминалын газрыг дахин хөгжүүлнэ. III9 дугаартай төсөл нь нийслэлийн бүсэд шаардлагатай байгууламжуудыг барьж байгуулан, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах замаар нийслэлийн бүс нутгийн чиг үүргийг сайжруулах зорилготой.

III10 ба III11 дугаартай төсөл нь орон нутгийн томоохон хотуудын агаарын тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, томоохон хотуудын чиг үүргийг сайжруулах замаар бүс нутгийн бие даасан хөгжлийг дэмжинэ.

III12 дугаартай төслийн хүрээнд Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулснаар говийн бүсийн ус хангамжийг сайжруулна. Ингэснээр нутаг дэвсгэрийн орон зайн илүү тэнцвэртэй зохион байгуулалтыг бий болгоход туслах хүн амын болон эдийн засгийн үйл ажиллагааны жигд тархалтыг дэмжинэ.

### **Зураг 8.2.1 Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### (4) Ногоон хөгжлийг дэмжих төслүүд

Хүснэгт 8.2.4-т тусгасан төслүүд нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна. Хог хаягдлыг дахин боловсруулдаг нийгмийг бий болгоход чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэх нь чухал юм. Түүнчлэн усны нөөцийг нэмэгдүүлэх, усыг зүй зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой. “\*” тэмдэглэгээгээр гол 8 төслийг тэмдэглэв.

#### Хүснэгт 8.2.4 Ногоон хөгжлийг дэмжих төслүүд

IV. Ногоон хөгжлийг дэмжих төслүүд	
Д/д	Төслийн нэр
IV1	Хөрс хамгаалах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх төсөл
IV2	Хог хаягдлыг дахин боловсруулах төслүүд
IV2.1	Хүнсний бүтээгдэхүүний хаягдлыг бууруулах төсөл

IV2.2	Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл*
IV2.3	Цементийн үйлдвэрийг ашиглан хатуу хог хаягдлыг эргэлтэд оруулах төсөл
IV2.4	Эко-парк байгуулах төсөл*
IV3	Гэр хорооллыг хөгжүүлэх төслүүд
IV3.1	Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл*
IV3.2	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл*
IV4	Хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламж-ландфилл байгуулах төсөл
IV5	Барилга байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах, сэргээн засварлах төсөл
IV5.1	Насжилт урттай байгууламжийг барьж байгуулах төсөл
IV5.2	Хот байгуулалтын салбарын хууль эрх зүйн баримт бичгийн уялдааг хангах, эрх зүйн тогтолцоог шинэчлэх төсөл
IV6	Туул голд усан цогцолбор байгуулах төсөл*
IV7	Ус хангамжийг сайжруулах төслүүд
IV7.1	Хот, суурины ус хангамжийг сайжруулах төсөл *
IV7.2	Хөдөө, орон нутгийн ус хангамжийг сайжруулах төсөл
IV8	Бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулах төслүүд
IV8.1	Бохир ус цэвэрлэх байгууламж барих, шинэчлэх төсөл
IV8.2	Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин боловсруулж, дулааны цахилгаан станцуудад ашиглах үйлдвэр байгуулах төсөл
IV8.3	Ариутгах татуургын сүлжээг шинэчлэх, өргөтгөх төсөл
IV8.4	Сумын төвд бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл *
IV8.5	Мал аж ахуйн фермийн бохир усыг цэвэрлэх байгууламж барих төсөл
IV9	Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөл*
IV10	Орон нутгийн эрчим хүчний сүлжээг хөгжүүлэх төсөл

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

IV1 дугаартай төслийн хүрээнд хөрс хамгаалах арга хэмжээ, газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар газар тариалан эрхэлж, хөрс, газрын доройтлыг бууруулж, урьдчилан сэргийлнэ. IV2 дугаартай төслүүд нь хүнсний алдагдал, хаягдалыг бууруулах замаар дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, хаягдал автомашиныг задалж дахин боловсруулах парк байгуулах, хатуу хог хаягдалыг боловсруулж, дахин ашиглах зорилготой юм. IV3 дугаартай төслүүд нь гэр хорооллыг бүтээн байгуулалт болон институцийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн, сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. IV4, IV5 дугаартай төслүүдийг хэрэгжүүлснээр орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан байгаль орчинд ээлтэй байгууламжуудыг барьж, ашиглалтад оруулна. IV6 дугаартай төслийн хүрээнд Улаанбаатар хотод усны шинэ эх үүсвэрийг (далан) тодорхойлж, барьж байгуулна. IV7 дугаартай төслүүдийг хэрэгжүүлснээр хот, суурин газрын ус хангамжийг сайжруулна. IV8 дугаартай төслүүд нь дулааны цахилгаан станц, мал аж ахуйн фермийн бохир усыг цэвэрлэх байгууламжуудыг барьж байгуулснаар хот, хөдөөгийн бохир ус цэвэрлэх системийг сайжруулах зорилготой юм. IV9 дугаартай төслийн хүрээнд Сэлэнгэ мөрний усан цахилгаан станц барьж байгуулахтай холбоотойгоор усны нөөцийг нэмэгдүүлнэ. IV10 дугаартай төслийг хэрэгжүүлснээр нар, салхи, ус, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний нөөц, ашиглалтыг нэмэгдүүлнэ.


## 8.3 Бүсчилсэн хөгжлийн цогц төсөл, хөтөлбөрүүд

### 8.3.1 Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотуудын чиг үүрэг, уялдаа холбоо

Хувийн хэвшлийн хэрэгжүүлэх төслүүдээс бусад санал болгож буй төслүүдийг холбогдох яам, агентлагууд хэрэгжүүлнэ. Холбогдох байгууллагуудын төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан Засгийн газрын тогтвортой бодлогыг тодорхойлох төсөл, хөтөлбөрүүдийг санал болгов. Зарим төсөл, хөтөлбөрүүд нь тодорхой байршлуудад хэрэгжих тул үр дүнтэй хэрэгжилтийг нь хангахын тулд тухайн орон нутагт хэрэгжүүлэх төслүүдтэй цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай.

Тодорхой байршлуудад хэрэгжүүлэх төслүүдийг Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрт тусгасан болно. Бүлэг 6-д 6 Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг шинээр тусгав. Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр нь 8.2-т үзүүлсэн төслүүд болон тухайлсан байршлуудад санал болгож буй хөгжлийн төслүүдээс бүрдэнэ (Зураг 8.3.1). Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг 10.1.2-р хэсэгт санал болгов.

**Зураг 8.3.1 Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийг хөгжүүлэх хөтөлбөр**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Хүснэгт 8.3.1 болон Зураг 8.3.2-т бүсчилсэн хөгжлийг тэтгэх хотуудын чиг үүрэг, тэдгээрийн уялдаа холбоог харуулав.

#### Хүснэгт 8.3.1 Бүсчилсэн хөгжлийг тэтгэх хотуудын чиг үүрэг, тэдгээрийн уялдаа холбоо

Бүс	Хот	Чиг үүрэг	Уялдаа холбоо
-----	-----	-----------	---------------




<b>Баруун бүс</b>			
Бүсийн хөгжлийн тулгуур төв хот	Ховд	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх биологийн олон янз байдал, чацаргана боловсруулах чиглэлээр дээд боловсрол олгох, судалгаа шинжилгээний төв; Баруун аймгийн аялал жуулчлалын зангилаа; Барилгын материал, хангалтын төв.	Ховд~Улаангом~Өлгий хөдөө аж ахуйн коридор
Аймгийн төв	Өлгий	Байгаль, соёлын аялал жуулчлалын төв.	Ховд~Улаангом~Өлгий хөдөө аж ахуйн коридор
	Улаангом	ОХУ-тай хийх худалдаа, арилжааны төв; Барилгын материал, бараа бүтээгдэхүүн түгээх төв.	Ховд~Улаангом~Өлгий хөдөө аж ахуйн коридор
Бусад суурин	Цагааннуур	Боловсруулалт болон үйлчилгээ эрхлэх ХЧБ	Хилийн боомт
	Боршоо	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Улаан байшинт	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Даяннуур	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
<b>Хангайн бүс</b>			
Бүсийн хөгжлийн тулгуур төв хот	Эрдэнэт-Булган	Эрдэнэт: Транзит худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээний төв; Бүсийн оношлогоо, эмчилгээний төв; Медипас эмнэлэг. Булган: Транзит худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээний төв.	Дархан-Мөрөн худалдаа, аялал жуулчлалын коридор
Аймгийн төв	Дархан	МХХТ, хиймэл оюун ухаан, 5G-г ашиглан газар тариалангийн салбарт инноваци ашиглах, шинэ технологи нэвтрүүлэх төв	Дархан-Мөрөн худалдаа, аялал жуулчлалын коридор
	Мөрөн	Аялал жуулчлалын зангилаа	Дархан-Мөрөн худалдаа, аялал жуулчлалын коридор
	Улиастай	Баруун аймгуудын төрийн үйлчилгээний төв.	Тойрог коридор
	Цэцэрлэг	Төвийн бүсийн МХХТ-ийн төв; Өвлийн аялал жуулчлалын төв.	Хархорин~Орхоны хөндийн соёл, аялал жуулчлалын гурвалжин
Бусад суурин	Сүхбаатар	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Алтанбулаг	ХЧБ	Хилийн боомт
<b>Алтайн бүс</b>			
Бүсийн хөгжлийн тулгуур төв хот	Баянхонгор	Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн кластерын үндсэн байгууламж; Анагаах ухаан, эрүүл мэндийн аялал жуулчлалын төв.	Алтай~Баянхонгор~Арвай-хээр мал аж ахуй эрхлэх бүс
Аймгийн төв	Алтай	Байгалийн, өв соёлын, эрүүл мэндийн аялал жуулчлалын төв; Боловсрол, эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын төв;	Алтай~Баянхонгор~Арвай-хээр мал аж ахуй эрхлэх бүс

		Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх судалгааны төв.	
	Арвайхээр	Логистикийн төв; Байгаль, соёлын аялал жуулчлалын дэд төв.	Алтай~Баянхонгор~Арвайхээр мал аж ахуй эрхлэх бүс
Бусад суурин	Хужирт	Аялал жуулчлалын үйлчилгээ	Аялал жуулчлал
	Шанх	Аялал жуулчлалын үйлчилгээ	Аялал жуулчлал
	Бургастай	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Хархорин	Аялал жуулчлалын үйлчилгээ	Хархорин~Орхоны хөндийн соёл, аялал жуулчлалын гурвалжин
<b>Өмнөд бүс</b>			
Бүсийн хөгжлийн тулгуур төв хот	Сайншанд	Логистик болон аялал жуулчлалын үйлчилгээний төв; Байгаль орчинд ээлтэй, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн жишээ	Мандалговь ~ Чойр ~ Сайншанд-ын логистикийн коридор; Сайншанд~Замын-Үүд ~Говийн аялал жуулчлалын гурвалжин
Аймгийн төв	Мандалговь	Дотоодын бараа бүтээгдэхүүнийг хадгалах, түгээх логистикийн төв; Улаанбаатар хот болон Өмнөд бүсийн хооронд орших түгээлт, үйлчилгээний төв.	Мандалговь ~ Чойр ~ Сайншандын логистикийн коридор;
	Чойр	Өмнөд бүсийн экспорт, импортын бараа бүтээгдэхүүний логистикийн төв; Автомашины засвар үйлчилгээний төв; Цэвэр эрчим хүчний технологийн төв; МХХТ-д суурилсан үйлдвэрийн бүс.	Мандалговь ~ Чойр ~ Сайншандын логистикийн коридор;
	Даланзадгад	БНХАУ руу экспортлох бараа бүтээгдэхүүний логистикийн төв; Худалдаа, үйлчилгээний төв, бааз; МХХТ ашиглалтын төв.	УБ~ Мандалговь ~ Даланзадгадын тэнхлэг; Чойбалсан ~ Баруун-Урт ~ Сайншанд ~ Даланзадгадын тэнхлэг;
Бусад суурин	Тавантолгой	Уул уурхай	Уул уурхай
	Замын-Үүд	Хил орчмын худалдаа	Сайншанд~ Замын-Үүд ~Говийн аялал жуулчлалын гурвалжин
	Хатанбулаг	Аялал жуулчлалын үйлчилгээ	Сайншанд~ Замын-Үүд ~Говийн аялал жуулчлалын гурвалжин
	Гашуунсухайт	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Шивээхүрэн Сэхээ	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
<b>Зүүн бүс</b>			
Бүсийн хөгжлийн тулгуур төв хот	Чойбалсан	Олон улсын логистик, бизнесийн төв; Зүүн бүс дэх аялал жуулчлалын бааз; Дорнод их сургуулийг судалгаа, инкубацийн бааз.	Чойбалсан ~ Баруун-Урт ~ Өндөрхааны хөдөө аж ахуйн нэгдсэн бүс
Аймгийн	Баруун-	Малчдад зориулсан хагас	Чойбалсан ~ Баруун-Урт ~

төв	Урт	эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, ус, нэмэлт тэжээл нийлүүлэх бааз.	Өндөрхааны хөдөө аж ахуйн нэгдсэн бүс
	Өндөрхаан	Зүүн бүсийн аймгуудын аялал жуулчлалын түшиц газар; Барилгын материал нийлүүлэх бааз.	Чойбалсан ~ Баруун-Урт ~ Өндөрхааны хөдөө аж ахуйн нэгдсэн бүс
Бусад суурин	Эрдэнэ-цагаан	Аялал жуулчлалын үйлчилгээ	Аялал жуулчлал
	Бичигт	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Дарьганга	Аялал жуулчлалын үйлчилгээ	Аялал жуулчлал
	Жаргалт-хаан	Аялал жуулчлалын үйлчилгээ	Аялал жуулчлал
	Өмнө-дэлгэр, Биндэр	Аялал жуулчлалын үйлчилгээ	Аялал жуулчлал
	Норовлин, Дадал	Аялал жуулчлалын үйлчилгээ	Аялал жуулчлал
	Эрээнцав	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Хавирга	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
	Ульхан	Хил орчмын худалдаа	Хилийн боомт
<b>Нийслэлийн бүс</b>			
Бүсийн хөгжлийн тулгуур төв хот	УБ+ Налайх	Төрийн захиргааны үйл ажиллагаа, үйлчилгээний төв; Олон улсын бизнесийн төв дэлхийн хот; Хотын ногоон байгууламж, амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх газруудаараа жишиг болсон ногоон хот; МХХТ-ийн бааз, хөрш зэргэлдээ улс орнуудтай холбогдсон, хотын тээврийн дэвшилтэт систем бүхий олон улсын тээврийн төв.	Хойд-өмнөд эдийн засгийн коридор Цацраг хэлбэрийн тэнхлэг
Аймгийн төв	Зуунмод	Суурьшлын бүс; Худалдаа, үйлчилгээний төв.	Дагуул хотын хөгжил (Төв)
Бусад суурин	Шинэ Зуунмод	Нисэх буудлын ажилчдын орон сууцны цогцолбор; Чөлөөт бүс, Импортын болон дотоодын бараа бүтээгдэхүүний худалдааны төв.	Дагуул хотын хөгжил (Төв)
	Майдар Эко хот	Улс төр, шашны шинэ төв; Өндөр чанартай, тансаг зэрэглэлийн орон сууцны цогцолбор; Хог хаягдлыг дахин боловсруулдаг эко хот.	Дагуул хотын хөгжил (Төв)
	Борнуур	Логистикийн үйлчилгээ	Логистикийн холболт
	Лүн	Логистикийн үйлчилгээ	Логистикийн холболт
	Баян өнжүүл	Логистикийн үйлчилгээ	Логистикийн холболт
	Баян	Логистикийн үйлчилгээ	Логистикийн холболт
	Багануур	Логистикийн үйлчилгээ	Логистикийн холболт

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Зураг 8.3.2 Бүсчилсэн хөгжлийг тэтгэх хотуудын чиг үүрэг, тэдгээрийн уялдаа холбоо



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### 8.3.2 Баруун бүсийн ногоон хөгжлийн загвар хөтөлбөрүүд

Тус хөтөлбөрт доорх төслүүд багтана.

- (a) Ховд-Өлгий-Улаангом чиглэлийн авто замын төсөл (АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна),
- (b) Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барих төсөл (хэрэгжүүлж байна),
- (c) Ховд аймагас Баян-Өлгий, Увс аймаг хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам барих төсөл (хэрэгжүүлж байна),
- (d) Даян нуур-Ташинт чиглэлийн авто замыг сайжруулах төсөл (А15) [III3],
- (e) “Цагааннуур” чөлөөт бүсийг хөгжүүлэх төсөл [I1.1],
- (f) Ховд аймагт дээд боловсрол, судалгааны төв байгуулах төсөл [III11],
- (g) Байгаль, соёлын аялал жуулчлалыг нэгдсэн байдлаар хөгжүүлэх төсөл [III3],
- (h) Ховд хотын нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгож хөгжүүлэх төсөл зэрэг болно [III12].

Түүнчлэн бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахын тулд хөдөө, орон нутагт доорх төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Ховд-Улаангом-Өлгий хотуудыг холбосон коридорыг хөдөө аж ахуйн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөгжүүлэх

- (a) Ховд, Увс аймагт төвлөрсөн хагас эрчимжсэн мал аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэхийн зэрэгцээ МАА-н үйлдвэрлэлийн кластерыг үе шаттайгаар хөгжүүлэх [I2.2],

- (b) Увс аймгийн бүтээгдэхүүн экспортлох нөөц боломжийг ашиглан МАА-н салбарын бүтээмж, ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор амьдралын хэв маяг, уламжлалт мал аж ахуй эрхлэлтийг дэмжих, ингэснээр соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах [I1.1],
- (c) Чацаргана тариалалтыг нэмэгдүүлж, чацаргана жимсний үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх [I2.1],
- (d) Өлгий хотыг байгаль, соёлын аялал жуулчлалын төв, Улаангом хотыг ОХУ-тай хийх худалдаа, барилгын материал, бараа бүтээгдэхүүний борлуулалтын төв, Ховд хотыг дээд боловсрол, судалгаа шинжилгээ, аялал жуулчлалын төв, барилгын материалын үйлдвэрлэл, хангамжийн бааз болгон хөгжүүлэх [III11].

### **8.3.3 Хангайн бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц хөтөлбөрүүд**

Тус хөтөлбөрт доорх төслүүд багтана. Үүнд:

- (a) Тойрог коридорын хойд хэсгийг сайжруулах, хөгжүүлэх төсөл [III1],
- (b) Аялал жуулчлал, хилийн боомттой холбох авто замыг барьж байгуулах төсөл (Хатгал~Ханх, Бат-Өлзий~Цэнхэр~Цэцэрлэг, Хутаг Өндөр~Тэшиг~Бага Илэнх) [III3],
- (c) Дархан, Цэцэрлэг хотуудад мэдээлэл, технологийн сүлжээг хөгжүүлэх төсөл,
- (d) Алтанбулагийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын хамт Сүхбаатар хотын төлөвлөлтийг сайжруулах төсөл [I1.1],
- (e) МХХТ-д суурилсан мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх төсөл [I4.2],
- (f) Сэлэнгэ, Булган аймагт хагас эрчимжсэн мал аж ахуйг малын тэжээлийн үйлдвэрлэлтэй хослуулан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх төсөл [I4],
- (g) Завхан, Архангай аймагт чанартай мах, сүү үйлдвэрлэх зорилгоор бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх төсөл [I2.2],
- (h) Булган аймагт ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлэх төсөл [I3.1],
- (i) Сэлэнгэ, Орхон голын дагуу усжуулалтын системийг байгуулах төсөл [I5.1],
- (j) Ойн нөөц баялгийг хамгаалахын зэрэгцээ ойн дагалт баялгийг зүй зохистой ашиглан ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх төсөл [институцийн арга хэмжээ].

Түүнчлэн бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахын тулд доорх төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

#### **Дархан-Мөрөнг холбосон худалдаа, аялал жуулчлалын коридор**

- (a) Эрдэнэт, Булган хотуудын нийгмийн барилга, байгууламжуудыг барьж байгуулах,

- (b) Дархан, Эрдэнэт, Мөрөн хотын байгууламж, тохижилт, нийгмийн болон бизнесийн үйлчилгээг Улаанбаатар хоттой холбогдсон МХХТ-ийг ашиглан сайжруулах [III11],
- (c) Хөвсгөл аймгийн аялал жуулчлалыг төрөлжүүлэх [I10],
- (d) Коридорын дагуу аялал жуулчлалын байгууламжуудыг барьж байгуулах [I10],
- (e) Сүхбаатар хотыг хилийн худалдааны бааз, Дархан хотыг газар тариалангийн дэвшилтэт технологийг түгээн дэлгэрүүлэх төв, Эрдэнэт, Булган хотыг транзит худалдаа, аялал жуулчлалын үйлчилгээний бааз, Цэцэрлэг хотыг МХХТ-ийн төв, өвлийн аялал жуулчлалын бааз, Улиастай хотыг баруун аймгуудын нийгмийн үйлчилгээний бааз болгон хөгжүүлэх [III11].

#### **8.3.4 Алтайн бүсийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, эрчим хүчний нөөцийг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд**

Тус хөтөлбөрт доорх төслүүд багтана. Үүнд:

- (a) Тойрог коридорын өмнөд хэсгийг сайжруулах, хөгжүүлэх төсөл [III1],
- (b) Аялал жуулчлал, хилийн боомттой холбох авто замыг барьж байгуулах төсөл (Арвайхээр~Хужирт, Хархорин~Шанх~Төвхөн, Алтай~Бургастай) [III3],
- (c) Говь-Алтай аймагт сэргээгдэх эрчим хүчний судалгааны төвийг байгуулах төсөл [III11],
- (d) Арвайхээр хотын төлөвлөлтийг сайжруулж, логистикийн байгууламжуудыг барьж байгуулах төсөл [III11],
- (e) Алтай хотыг аялал жуулчлалын бааз, боловсрол, эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын төв, Баянхонгор хотыг эрүүл мэндийн аялал жуулчлалын төв, Арвайхээр хотыг аялал жуулчлалын дэд төв болгон хөгжүүлэх төсөл [III11],
- (f) Завхан голын усыг усан цахилгаан станц, усжуулалтын систем зэрэгт зүй зохистойгоор ашиглах төсөл [I5.1].

Түүнчлэн бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахын тулд доорх төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

#### **Алтай-Баянхонгор-Арвайхээрийн мал аж ахуй эрхлэлтийг дэмжих бүс**

- (a) Баянхонгор аймагт гол байгууламжийг барьж байгуулан, хагас эрчимжсэн мал аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хослуулан МАА-н үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх [I4],



- (b) Жимс жимсгэнэ, ургамлын тос, эмийн ургамал, малын тэжээлийн тариалалтыг төрөлжүүлэх [I5],
- (c) Орон нутагт жимс жимсгэнэ, эмийн ургамал боловсруулах үйл ажиллагааг дэмжих [институцийн арга хэмжээ].

#### Хархорин, Орхоны хөндийн соёл, аялал жуулчлалын гурвалжин

- (a) Аялал жуулчлалын чиглэлийн авто замуудыг сайжруулах [I3],
- (b) Жуулчдад зориулан жимс жимсгэнэ, эмийн ургамал боловсруулах орон нутгийн ЖДҮ-ийг дэмжих [институцийн арга хэмжээ],
- (c) Хархорин сумын аялал жуулчлалын байгууламжуудыг хөгжүүлэх [III11].

#### **8.3.5 Өмнөд бүсийн хариуцлагатай уул уурхай, олон нийтийн хөгжлийн хөтөлбөрүүд**

Тус хөтөлбөрт доорх төслүүд багтана. Үүнд:

- (a) Аялал жуулчлалын маршрутын дагуух авто замыг хөгжүүлэх төсөл (Сайншанд-Замын-Үүд-Хантанбулаг гурвалжин) [I3],
- (b) Уурхайг холбосон авто замыг хөгжүүлэх (Тавантолгой-Гашуун сухайт; Чойр-Дархан чиглэл) [I3],
- (c) Чойр хотын усан хангамжийг сайжруулах [IV7.1],
- (d) Говьсүмбэр аймагт МХХТ-т суурилсан аж үйлдвэрийн парк хөгжүүлэх [III11],
- (e) Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор орон нутгийн иргэдэд зориулсан дэд бүтэц, ногоон байгууламжийг сайжруулах, хөгжүүлэх [институцийн арга хэмжээ].

Түүнчлэн бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахын тулд доорх төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

#### Мандалговь-Чойр-Сайншанд хотуудыг холбосон логистикийн коридор

- (a) Мандалговь хотын төлөвлөлтийг сайжруулж, логистикийн байгууламжуудыг барьж байгуулах [III11],
- (b) Чойр хотод цэвэр эрчим хүчний технологи, логистикийн төв байгуулах [III11],
- (c) Сайншанд хотод логистик, аялал жуулчлалын үйлчилгээний төв байгуулах [III11].

#### Сайншанд-Замын-Үүд-Говийн аялал жуулчлалын гурвалжин

- (a) Замын-Үүдэд хилийн худалдаа, аялал жуулчлалыг хөгжүүлэх [III11],
- (b) Сайншанд хотыг музей, гар урлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэл бүхий аялал жуулчлалын бааз болгон хөгжүүлэх [III11],
- (c) Говийн онгон дагшин байгаль, археологийн олдвор, соёлын өв уламжлалд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх [I10],

- (d) Тал хээр, цөлөрхөг газруудад хээрийн судалгаа хийх байдлаар байгаль орчны мэдлэг, боловсрол олгох.

### **8.3.6 Зүүн бүсийг хөдөө аж ахуй-худалдаа-аялал жуулчлалыг хөгжүүлсэн хилийн бүс болгож хөгжүүлэх хөтөлбөрүүд**

Тус хөтөлбөрт доорх төслүүд багтана. Үүнд:

- (a) Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто замын төсөл [III3],
- (b) Хилийн боомттой холбох авто замын төсөл (Хавирга, Чойбалсан-Ульхан боомт руу салсан Чойбалсан-Эрээнцав чиглэлийн авто зам) [III3],
- (c) Аялал жуулчлалын авто замын төсөл (Эрдэнэцагаан~Дарьганга, Жаргалтхаан~Өмнөдэлгэр~Биндэр, Норовлин~Дадал) [III3],
- (d) Чойбалсан хотыг олон улсын логистик, бизнесийн төв, аялал жуулчлалын бааз болгон хөгжүүлэх [III11],
- (e) Дорнод их сургуулийн судалгаа, инкубацийн баазыг хөгжүүлэх [II6],
- (f) Өндөрхаан хотыг аялал жуулчлал, барилгын материалын хангамжийн бааз болгон хөгжүүлэх [III11],
- (g) Хэрлэн голын ай савд усжуулалтын системтэйгээр импортыг орлох жимс, хүнсний ногоог тариалах [I5.1],

Түүнчлэн бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахын тулд доорх төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Чойбалсан, Баруун-Урт, Өндөрхаан хотуудыг хамарсан фермерийн нэгдсэн бүс

- (a) Хэнтий аймгийн газар тариаланг төрөлжүүлж, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тосны ургамал, төмсний тариалалтыг нэмэгдүүлэх [I5],
- (b) Хэрлэн голын дагуу усжуулалтын систем бүхий импортыг орлох жимс, хүнсний ногооны тариалалтыг эрхлэх [I5],
- (c) Хагас эрчимжсэн мал аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүнийг хот, суурин болон экспортын зах зээлд нийлүүлэх [I6],
- (d) Баруун-Урт хотод уламжлалт мал аж ахуй эрхлэлтийг дэмжих байгууламжуудыг барьж байгуулах [III11].

### **8.3.7 Нийслэлийн бүсийн дэвшилтэт технологи бүхий эцсийн боловсруулалт, логистикийн баазыг хөгжүүлэх хөтөлбөрүүд**

Тус хөтөлбөрт доорх төслүүд багтана. Үүнд:

- (a) Борнуур, Лүн, Баян-Өнжүүл, Баян, Багануурыг холбосон авто замуудыг сайжруулах [III3],
- (b) Улаанбаатар хотын ойр орчмын зам харилцааг сайжруулах [III3],
- (c) Улаанбаатар хот болон түүний дагуул хотуудын ус хангамжийн системийг өргөтгөх [IV7.1],

- (d) Улаанбаатар хотыг жишиг ногоон хот болгож хөгжүүлэх,
- (e) Төв болон бусад аймгуудтай харилцах харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын МХХ-ны станцыг сайжруулах [III4, III6],
- (f) Улаанбаатар хотод шинэ мах, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэхийн тулд эрчимжсэн мал аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрлэл хосолсон нэгдсэн аж ахуйг хөгжүүлэх [I4],
- (g) Аялал жуулчлалын өндөр зэрэглэлийн байгууламжийг барьж байгуулах [I10],
- (h) Нисэх онгоцны шинэ буудлын ойролцоо чөлөөт бүсийг байгуулах [I1.2].

Түүнчлэн доорх тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### Төв аймагт дагуул хотуудыг хөгжүүлэх

Төв аймагт дагуул хотуудыг хөгжүүлснээр Улаанбаатар хотын улс төр, засаг захиргаа, эдийн засгийн чиг үүргүүдийн төвлөрлийг дараах байдлаар задлах юм.

Хот	Чиг үүрэг
Шинэ Зуунмод	- Нисэх буудлын ажиллагсадын орон сууцны цогцолбор; - Чөлөөт бүс; - Импортын болон дотоодын бараа бүтээгдэхүүний худалдааны төв.
Майдар эко хот	- Улс төр, шашны шинэ төв; - Өндөр чанартай, тансаг зэрэглэлийн орон сууцны цогцолбор; - Хог хаягдлыг дахин боловсруулдаг эко хот.
Зуунмод	- Суурьшлын бүс; - Худалдаа, үйлчилгээний төв.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## **8.4 Институцийн тогтолцоо, зохицуулалт (эдийн засгийн салбаруудаар)**

### **8.4.1 Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг тодорхойлох**

#### **(1) Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал**

ҮХЦТ нь бүс нутаг болон аймаг, хот, суурин болон хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэхээр зорьж байна. Бүсчилсэн хөгжил нь тухайн бүс нутгийн нөөц баялгаас уугуул нутгийн хүн ам ашиг хүртэхэд суурилсан нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлалыг илэрхийлж байгаа юм. Энэхүү үзэл баримтлал нь эрх тэгш байдлыг хангах бөгөөд төслийн баримталж буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбартай нийцнэ.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нь хэд хэдэн чухал урьдчилсан нөхцөлийг агуулж байна. Тэдгээрээс хамгийн чухал нь нөөцийг өмчлөх, эзэмших асуудал юм. Уугуул нутгийн иргэд орон нутгийнхаа нөөц, баялгийг өөрсдийн хөгжил, ашиг тусын тулд ашиглах, хамгаалах үүднээс тухайн нөөц, баялаг нь ард түмний өмч байх ёстой. Хүний нөөц, нийгэм, соёл, байгалийн нөөц зэрэг өөрт байгаа бүхий л нөөц, баялагтаа тулгуурлан нутгийн уугуул иргэд өөрсдийн хөгжлийн гарцыг бий болгож чаддаг байх нь хамгийн төгс хувилбар болох юм. Энэ нь ерөнхийдөө "нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тухайн нутгийнхан бүтээх, хэрэглэх" гэсэн санааг илэрхийлж байна.

Гэхдээ зарим нөөцийг тухайлбал технологи, хөрөнгө санхүүг гаднаас татах шаардлагатай болох тул бүсчилсэн хөгжлийн энэ загварыг бодит байдал дээр

бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Түүнчлэн орон нутгийн иргэдийн чадавхыг бэхжүүлэхийн тулд гаднаас хүний нөөц, мэргэжилтэн авах шаардлага тулгарч болзошгүй юм. Энэ тохиолдолд гаднаас татсан эдгээр нөөцийг ашигласны төлөө ямар нэгэн байдлаар төлбөр төлөх шаардлагатай болно.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нь тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бий болгох үндэс суурь болно. Зарчмын хувьд бүс нутаг эсвэл улсын эрдэс баялгийн нөөц нь тухайн бүс нутаг эсвэл төрийн өмч байна. Тухайн бүс нутаг эсвэл нийт ард иргэд энэхүү нөөцийг хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргах шаардлагатай. Түүнчлэн уул уурхайн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалт, технологи, нэмэлт хүний нөөцийг гаднаас татах, нэвтрүүлэх шийдвэрийг тухайн бүс нутаг эсвэл нийт ард иргэд гаргана.

Гадаадын хөрөнгө оруулагчид ихэвчлэн тодорхой ашигт малтмалын ордын ашиглалтын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хөрөнгө, технологи, хүний нөөцөөр хангадаг. Тэд өөрсдийн хөрөнгө, хүний нөөц болон шаардлагатай технологиудыг ашиглан орд газрын нөөцийн олборлолт, ашиглалтын зардлыг даадаг. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо нь нөөцийн өмчлөлд өөрчлөлт оруулахгүй гэдгийг тодорхой болгох нь чухал. Хөрөнгө оруулагчид өөрсдийн хөрөнгөөр геологи хайгуулын судалгаа хийж, орд газруудыг нээсэн байсан ч хөрөнгө оруулагчдад тэдгээр ордуудыг өмчлөх эрх байхгүй.

## **(2) Зардал, ашиг хуваах урьдчилсан нөхцөл**

Өмчлөгч болон хөрөнгө оруулагч хоорондоо ордыг ашигласны зардал болон ашгийг хэрхэн хуваах нь өөр нэг асуудал юм. Өмчлөгч нь эрдэс баялгийнхаа ашиглалтаас зохих ашиг хүртэх бөгөөд түүнийг баталгаажуулах шаардлагатай. Үүний тулд өмчлөгч нь хөрөнгө оруулагч компанийн шийдвэр гаргах үйл явцад оролцоно. Орчин үеийн хувьцаат компанийн хувьд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд гишүүнээр орох эсвэл олон тооны хувьцаа эзэмших байдлаар үүнийг хэрэгжүүлнэ.

Хариуцлагатай уул уурхайн урьдчилсан нөхцөлүүдийг доорх байдлаар нэгтгэн, дурдав. Үүнд:

- (a) Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй иргэд шийдвэрийг гаргана;
- (b) Уул уурхайн үйл ажиллагааны үр ашгийг эдгээр хүмүүсийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр хуваана;
- (c) Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой зардлыг эдгээр оролцогч талууд гаргана.

Гэхдээ эдгээр нь хангалттай биш юм. Нэгдүгээрт компанийн өмчлөл, төлөөллийг илүү нарийн тодорхойлох хэрэгтэй. Өмчлөл нь тухайн бүс нутаг эсвэл тухайн улсад хамааралтай буюу илүү тодруулбал бүс нутаг эсвэл нийт ард иргэдэд хамаарах бөгөөд нэг эсвэл цөөн тооны иргэдийн өмч биш юм. Үүнийг тусгах эсвэл дурын болон эрх бүхий этгээдийн өмч болгохоос зайлсхийхийн тулд институцийн механизм шаардлагатай. Төлөөлөл нь уул уурхайн компанийг хамтран эзэмшигчдийн үр ашигт нөлөөлөхүйц хэмжээний саналын эрхтэй олон тооны хувьцааг эзэмших шаардлагатай.

### **(3) Хувьцаа эзэмших журам ба хөрөнгийг хадгалах**

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийн тулд хамгийн багадаа хоёр нөхцөлийг хангасан байх ёстой. Иргэдийн хувьцаа нь шийдвэр гаргахад нөлөөлөхүйц хэмжээний байх ба Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь бүс нутгийн эсвэл нийт ард иргэдийн ашиг сонирхолыг төлөөлж чадахуйц ёс зүйтэй төлөөлөл байх шаардлагатай. Өөр нэг чухал нөхцөл нь энэ хувьцаа эзэмших зохицуулалт болон төлөөлөл нь урт хугацаанд тогтвортой ажиллах ёстой.

Ерөнхийдөө аливаа хууль ёсны уул уурхайн компанийн хувьцааг дэлхийн аль ч хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалах боломжтой. Хувьцаа эзэмшигчид хувьцаагаа нэмэгдүүлэх эсвэл бууруулах зорилгоор арилжаа хийж болно. Тиймээс хэрэв хэн нэгэн эхэндээ олон тооны хувьцаа эзэмшиж байсан хэдий ч хэсэг хугацааны дараа түүнийгээ арилжаалбал өөр хэн нэгний эзэмших хувьцаа нэмэгдэх болно. Энэ нь бүс нутаг эсвэл нийт ард иргэдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Учир нь хувьцаа эзэмшинэ гэдэг нь үйлдвэрлэл болон ашгийг хуваахад ашигт малтмалын эрэл, хайгуулын нөхөгдөшгүй зардал зэргийг багтаасан хөрөнгө оруулалтын хэмжээнд үндэслэхгүй, харин эзэмшиж буй хувьцааны тоонд үндэслэнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл өнгөрснийг биш ирээдүйг хуваана гэсэн үг юм. Ирээдүйд нөхөгдөшгүй зардлыг зөвхөн хувьцааны үнээр илэрхийлнэ.

Уул уурхайн компани нь хариуцлагатай уул уурхайн туршлага хуримтлуулах хүртэл хэсэг хугацаанд хувьцаа эзэмшигчдийг хувьцаагаа арилжаалахыг хязгаарлах шаардлагатай. Чухамдаа уул уурхайн компанийн хувьцаа нь өмчлөгч болон хөрөнгө оруулагчдын хуваалцах компанийн хөрөнгийг бүрдүүлдэг. Хөрөнгөө хадгалах гэдгийг уул уурхайн нөөцийг хадгалахаас илүүтэйгээр нийгэм, эдийн засгийн хувилбарын үзэл санаанд тусгасан хөрөнгийг хадгалах гэж үзэх ёстой.

Уул уурхайн компанийн хувьцаа эзэмшигчид өөрийн хувьцаагаа эзэмшсээр байх тохиолдолд тэд өөрсдийн хөрөнгийг оруулан, эзэмшиж буй уул уурхайн ордыг хадгалах боломжтой. Уул уурхайн ордыг хадгалах шаардлагатай хөрөнгө гэж үзэх хэрэгтэй бөгөөд ингэснээр энэ хөрөнгө нь бүс нутаг эсвэл нийт ард иргэдэд үр ашгийг бий болгосоор байна. Эсрэгээрээ уул уурхайн ордыг орлогын эх үүсвэр гэж үзвэл хэтрүүлэн олборлож, илүү их орлого олох бөгөөд уг ордын нөөц түргэн шавхагдаж, дуусах хандлагатай байдаг.

Уул уурхайн компанийн хувьцааг эзэмшиж буй иргэд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой зардлыг ч хуваалцах ёстой. Тэд олборлолт хийсний дараа уул уурхайн талбайд зохих ёсны нөхөн сэргээлт хийх ёстой гэсэн үг. Тэд тухайн бүсэд амьдарч байгаа тул уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж буй байгаль орчны нөлөөллийг хянах хамгийн сайн нөхцөл боломжтой юм. Монгол Улсын хөгжлийн удирдлагыг үе шаттайгаар шилжүүлэх ажлын хүрээнд байгаль орчны хяналтын чиг үүргийг орон нутгийн засаг захиргаанд шилжүүлж байгаа нь тэдэнд дэмжлэг болно.

### **(4) Тогтвортой байдлын гэрээ**

Өмчлөгч болон хөрөнгө оруулагчид аль аль нь одоо болон ирээдүйд хариуцлагатай уул уурхайн зохицуулалтыг шударга зохицуулалт гэж хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд л энэхүү зохицуулалтыг тогтоож хадгалах боломжтой. Үүнийг хоёр талаас тогтвортой байдлын гэрээгээр баталгаажуулж

болно. Уул уурхайн компанийн хувьд хууль эрх зүйн орчны ирээдүйн өөрчлөлт нь өмчлөгч болон хөрөнгө оруулагчдын хооронд хэдийнээ хийгдсэн зохицуулалтад нөлөөлөхгүй байх ёстой.

Ард иргэдийн болон бүс нутгийн эсвэл улсын эдийн засгийг дэмжих зорилгоор дараах нөхцлүүдийг мөрдөх хэрэгтэй. Үүнд:

- (a) Уул уурхайн компани нь аль болох тухайн бүс нутаг эсвэл төрийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг худалдан авах ёстой;
- (b) Уул уурхайн компани нь нэн тэргүүнд тухайн улсын, бүс нутгийн иргэдийг ажиллуулах ёстой;
- (c) Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг төрийн захиргааны төв байгууллага буюу холбогдох нутгийн захиргааны байгууллагын албан ёсны бодлого, төлөвлөлтийг дагаж мөрдөх үүрэгтэй;
- (d) Монополь эрх эсвэл ашиглалтын тэгш бус байдлыг үүсгэхгүйн тулд дэд бүтцийн ашиглалт нь олон нийтэд нээлттэй байх ёстой.

Тогтвортой байдлын гэрээнд Монголын талын эрх ашгийг зөрчсөн тохиолдол хэд хэд гарсан. Үүнээс зайлсхийхийн тулд хэлэлцээрийн ил тод байдал, Засгийн газар болон холбогдох нутгийн захиргааны байгууллагын хариуцлагыг сайжруулах нь зайлшгүй чухал юм.

#### **8.4.2 Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлого, институцийн арга хэмжээ**

ҮХЦТ-ний Газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарын тайлангийн Бүлэг 4-т аж үйлдвэрийн салбарын одоогийн нөхцөл байдал, хөгжилд тулгарч буй асуудлууд, хэрэгжүүлж буй бодлогод дүн шинжилгээ хийж, салбарыг хөгжүүлэх бодлого, институцийн арга хэмжээний саналыг боловсруулан, доор дурдав. Үүнд:

##### **(1) Бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох**

- Чөлөөт бүсийг хөгжүүлэх дүрэм, журам боловсруулах, батлах;
- Салбарын урт хугацааны хөгжлийг хангах зорилгоор салбарын хөгжлийн асуудлыг нэг яаманд төвлөрүүлэх арга хэмжээг авах;
- Чөлөөт бүсийг хөгжүүлэхийн тулд ТХХТ эсвэл түүнтэй төстэй хамтын ажиллагааны хэлбэрийг нэвтрүүлэх;
- Одоо мөрдөж буй хөгжлийн алсын хараа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг тогтвортойгоор хэрэгжүүлэх;
- Үндэсний чанарын стандартыг эцэслэн боловсруулах;
- Олон улсын хамтын ажиллагааг дэмжих.

##### **(2) Хүний нөөцийг хөгжүүлэх**

- ЖДҮ-т ажиллагсадыг сургахад дэмжлэг үзүүлэх;
- Мэргэжлийн ур чадварыг үнэлж гэрчилгээ, шагнал урамшуулал олгодог тогтолцоог нэвтрүүлэх.



### **(3) Хувийн хэвшлийг бэхжүүлэх, төрөлжүүлэх**

- ХХААХҮЯ болон салбарын холбоод ЖДҮ эрхлэгчдэд зориулж хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- ЖДҮ-ийн техник, технологийг сайжруулах арга хэмжээний талаар судлах;
- Чанарын стандартын гэрчилгээ олгох, үнэлгээ хийх үйл ажиллагааг сайжруулах;
- Менежмент, технологи, МХХТ, маркетингийг сайжруулах татаас, урамшуулал олгох системийг нэвтрүүлэх;
- Уул уурхайн салбарын нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд нөөц бололцоо бүхий компаниудад дэмжлэг үзүүлэх;
- Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд хүнсний үйлдвэрлэлийг дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх (резин, хуванцар бүтээгдэхүүн, тавилга, ундаа, савангийн г.м. ирээдүйтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх).

### **(4) Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих**

- Үндэсний хөгжлийн газар арьс шир, ноос, ноолуур, сүү, махны үйлдвэрүүдийн байршлыг тодорхойлох судалгааг хийж байна. Энэ төрлийн судалгаа нь бүсийн болон салбарын хөрөнгө оруулалт, хөнгөлөлтийн системийг нэвтрүүлэхэд хувь нэмэр болно.
- Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээллийн багц, цахим хуудсыг хөгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хурал, уулзалт зохион байгуулах, хилийн чанадад Төлөөлөгчийн газар ажиллуулах үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- Чанартай дэд бүтцийг барьж байгуулах ажлыг урт хугацаанд тогтвортойгоор үргэлжлүүлэх;
- Аж үйлдвэрийн парк, эдийн засгийн чөлөөт/тусгай бүсүүдийг хөгжүүлэхийн тулд аж үйлдвэрийн бүсүүдийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөгжлийн бодлогын уялдаатай байдлыг хангах, менежментэд хувийн хэвшлийг оролцуулах;
- Үйлдвэрүүдийг хотоос нүүлгэх тохиолдолд шинэ аж үйлдвэрийн парк, бүсэд үйлдвэрийн түрээсийн барилга байгууламжуудыг барьж байгуулах.

### **(5) Нэмүү өртгийн сүлжээ, үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, бизнесийн холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх**

- Дотоодын болон экспортын зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, тогтвортой хэрэгжилтийг хангах;
- ААН, байгууллагуудын мэдээллийн санг аж үйлдвэрийн салбарын мэдээллээр баяжуулж үүсгэх;
- Гадаадын хөрөнгө оруулагч, дотоодын компани хамтарч ажиллах, технологи дамжуулах үйл ажиллагаанд зориулж хөнгөлөлт, татаас олгох талаар судлах;
- ХХААХҮЯ, ҮХГ, МҮХАҮТ-тай хамтарч туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулах компанийг зуучлах, компаниудад дэмжлэг үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх;

- Үйлдвэр, бизнесийн холбоод, дотоодын компаниудын сүлжээг байгуулах ажлыг дэмжих;
- Хөгжлийн шинэ загварыг тодорхойлох явцад үйлдвэрлэлийн кластерын хөгжлийг тусгах, хөдөө аж ахуйн “брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх.

#### **(6) Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх**

- ЖДҮ эрхлэгчдэд зээл олгох нөөц, боломжийг нэмэгдүүлэхийн тулд тусгай сан/банк, арилжааны банкуудын хамтын ажиллагааны уялдааг хангах;
- Сонгогдсон үйлдвэрлэлд зориулсан арилжааны банкны татаастай зээл эсвэл хоёр үе шаттай зээл олголтыг дэмжих;
- Үйл ажиллагааны дүн шинжилгээ, бизнесийн зөвлөгөө бүхий тогтолцоотой зээл олголтыг холбох талаар судлах.

#### **(7) Гарааны бизнес, инкубаци, инновацийг дэмжих**

- Судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаатай мэдээллийн болон инкубатор төвийг тухайн салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулах ажлыг дэмжих;
- ШУ, технологийн мэдээллийг (оюуны өмчийн эрхийн асуудлыг оролцуулаад) үр дүнтэй ашиглах чадавхыг бэхжүүлэх;
- Инновацийн кластер нь шинэ технологи бүхий боловсролын болон судалгааны институтууд хөгжихөд түлхэц үзүүлдэг. Цаашид инновацийн кластерын хөгжил эсвэл Оюутны хотхоны бүтээн байгуулалтыг дэмжих.

#### **(8) Дижитал шилжилт, МХХТ-ийг ашиглах замаар мэдээллийн технологийн салбарын хөгжлийг дэмжих**

Хүн ам нь өргөн уудам газар нутагтаа тархан суурьшсан тул Монгол Улсын аж үйлвэр болон холбогдох бусад салбарт дижитал шилжилт, МХХТ-ийг ашиглах зайлшгүй шаардлагатай юм. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дор дурдсаны дагуу бие биенээ харилцан дэмжиж, зохион байгуулалттай системтэйгээр хамтран ажиллах хэрэгтэй. Үүнд:

- МХХТ-ийн дэд бүтэц, програм хангамжийн хөгжүүлэлтийг институцийн арга хэмжээтэй хослуулан бизнесийн экосистемийг төлөвшүүлэх;
- Монгол залуучуудын технологийн өндөр ур чадвар, харьцангуй бага цалин хөлс, гадаадын олон хэл эзэмшсэн зэрэгт үндэслэн хувийн хэвшлийн санаачилгаар оффшор аутсорсинг хөгжүүлэх;
- Иргэд, нутгийн захиргааны байгууллагын харилцаа холбоог сайжруулах зорилгоор Засгийн газрын дэмжлэгтэйгээр “нээлттэй эхийн систем”-ийн шаардлагыг хангасан мэдээллийн нээлттэй орчныг бий болгох;
- Стратегийн байршилд төрөл бүрийн програм ашиглахад хөдөлгөөнт холбооны 5G технологийг хамтран турших;
- Дэд бүтэц, гарааны бизнес, сургалт бүхий дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн загвар хот/аймаг хөгжүүлэх.

### **8.4.3 Эдийн засгийн бусад салбаруудыг хөгжүүлэх бодлого, институцийн арга хэмжээ**

#### **(1) Газар тариалангийн салбар**

Газар тариалангийн салбар нь ТХҮБ 2030-ын зорилтуудад хүрэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загвар руу шилжин, хөгжихөд чухал үүрэгтэй тул тус салбарт шинэ техник, технологийг нэвтрүүлж, нутагшуулах бодлогыг баримтлах нь чухал юм. Түүнчлэн Засгийн газар нь газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, хоршоод, иргэдийг дэмжсэн институци, технологийн бодит, үр дүнтэй санаачилга, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Газар тариалангийн салбарт шинэ техник, технологийг нэвтрүүлж, нутагшуулахдаа хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, бэлчээрийн даац хэтрэлт, доройтлыг багасгах тал дээр анхаарах нь чухал. Нэн ялангуяа усжуулалтын систем байгуулах газар нутгийг сонгох, усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглах төлөвлөлт, менежментийг хийхэд Засгийн газрын санаачилга, үйл ажиллагаа ихэхэн үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн орон нутгийн нөхцөл байдалд зохицсон шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд татаас олгох байдлаар хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг дэмжиж болно.

Засгийн газраас дэмжлэг үзүүлэх шаардлагатай бусад арга хэмжээнүүдэд тэг элдэншүүлэлтийн технологийг нэвтрүүлэх, газрын хөрсийг сэргээх, ургацын төрөл сортыг нэмэгдүүлэх, үрийн чанарыг сайжруулах зэрэг багтана. Газар тариалангийн салбарт шинээр нэвтрүүлж болох арга, технологийн саналыг Газар тариалан, мал аж ахуйн салбарын тайланд тусгасан.

Газар тариалангийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх маркетинг, сурталчилгааг хийхэд төрийн оролцоо шаардлагатай нь дамжиггүй юм. Өнөө үед экспортын зах зээлд эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнийг нийлүүлэх, хэрэглэгчдэд тухайн бүтээгдэхүүнийг хэрхэн, хаана үйлдвэрлэснийг мэдэх боломжийг хангаж өгөх шаардлагатай болсон. МХХТ-ийг ашиглаж маркетингийн болон үйлдвэрлэлийн дамжлага, түүхийг шалгах боломжтой системийг нэвтрүүлэх нь маш чухал бөгөөд үүнийг Засгийн газар загвар төсөл болгож хэрэгжүүлэх хэрэгтэй.

Засгийн газар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглах эсвэл экспортод гаргах боломжтой ургац хураалтыг нэмэгдүүлэх зорилгоор татаас олгож арга хэмжээг авч болно. Энэ төрлийн ургац хураалтыг нэмэгдүүлэхээр хувийн хэвшил кластер хэлбэрээр хамтарч ажиллах боломжтой ч Засгийн газар нь газар тариалан эрхлэгчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид, маркетингийн агентлагууд, судалгааны институтууд болон бусад холбогдох үйлчилгээг үзүүлэх компаниудыг холбож, хамтарч ажиллахад нь дэмжлэг үзүүлэх боломжтой. Түүнчлэн кластеруудад экспортын бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн технологи, маркетингтай холбоотойгоор Засгийн газрын оролцоо байж болно.

МХХТ ашиглалтыг нэмэгдүүлэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой. 2014 онд Японы Засгийн газар нийгэмд тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэх зорилгоор “Яам хоорондын стратегийн инновацийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөр нь судалгаа, хөгжүүлэлтийг дэмжсэн, шинэчлэх стратеги бүхий шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх зорилготой. Тус хөтөлбөр нь 1) тэргүүлэх хөтөлбөрүүдийг салбар дундын шинжлэх ухаан, технологи, инновацийн хороо сонгодог, 2) хөтөлбөрийг салбар хоорондын хамтын ажиллагаагаар хэрэгжүүлдэг, 3) суурь судалгаанаас эхлээд хэрэгжүүлэх хүртэл цогц арга хэмжээг авдаг, 4) зохицуулалт,

тусгай тогтолцоог бий болгодог 5) цаашид оюуны өмчийн тогтолцоог бэхжүүлдэг зэрэг онцлогтой.

Эхний үе шатанд сонгогдсон 10 хөтөлбөрөөс судалгааны байгууллага, их, дээд сургуулиуд, хувийн хэвшил зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуйн салбарт тариалан эрхлэлтийг дэмжих системийг хөгжүүлсэн. Уг систем нь цаг уурын параметр, өсөлтийн симуляци загвар, эрт сэрэмжлүүлэх систем, тариалалтын арга техник зэрэг мэдээллээр хангадаг. Хувийн хэвшил өөрсдийн системээ тус системтэй холбох боломжтой бөгөөд ингэснээр өөрсдийн системээ шинэчилж, үйлдвэрлэгчдэд хамгийн сүүлийн үеийн мэдээллийг түгээх боломжтой болно. Дээр дурдсан хөтөлбөрөөс гадна Японы Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасчлалын яам нь МХХТ-ийн хэрэглээг сурталчлах зорилгоор МХХТ-ийн каталогийг боловсруулсан. 2019 оны 9-р сарын байдлаар 226 төрлийн технологийг танилцуулга, компанийн нэр, холбоо барих хаягийн хамт жагсаасан байна. Түүнчлэн Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасчлалын яам нь МХХТ ашиглалтыг эрчимжүүлэх шинэ төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ төслийн зорилго нь 2026 он гэхэд хөдөө аж ахуйн чиглэлээр ажилладаг үйлдвэрлэгч, компаниудад хөдөө аж ахуйн салбарын нэгдсэн мэдээллийг гаргах юм. Туршилтаар ашиглах технологийг нээлттэйгээр сонгон шалгаруулж, хэрэгжүүлэх төсөв, хөрөнгийг хуваарилж өгнө.

## **(2) Мал аж ахуйн салбар**

Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд малын халдварт өвчний тархалтыг хянах шаардлагатай. Монгол Улсын Засгийн газар малын гоц халдварт шүлхий өвчин нь 1) маш богино хугацаанд тархдаг, 2) эдийн засагт хор хохирол ихээр учруулдаг, 3) малчид өөрсдийн хүчээр тэмцэхэд нэн хүндрэлтэй байдаг зэрэг шалтгааны улмаас тус өвчний дэгдэлттэй тэмцэхэд онцгой анхаардаг. Цаашид Засгийн газар малчидтай хамтарч малын халдварт өвчингүй бүсийг байгуулах ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Малын халдварт өвчний дэгдэлттэй холбоотой мэдээ, цуу яриа нь сөрөг үр дагавартай тул нэн даруй шийдвэрлэх арга хэмжээ авч байх шаардлагатай. Түүнчлэн үнэн бодит мэдээлэл түгээх нь шүлхий мэт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Монгол Улсын нийгэм, соёл, эдийн засгийн тулгуур байсаар ирсэн мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах, байгаль орчныг хамгаалах, хадгалах зорилгоор бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, зохистой менежментийг хэрэгжүүлэх тулгамдсан шаардлага байна. Мал аж ахуйн салбарын өсөлт Засгийн газрын ган, зуд, бусад байгалийн гамшгууд, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол зэрэгтэй тэмцэж буй үйл ажиллагаанаас ихээхэн хамаардаг. Мөн малчид, орон нутгийн засаг захиргааг холбосон үр дүнтэй харилцаа холбооны системийг ашигладаг болох шаардлагатай.

## **(3) Аялал жуулчлалын салбар**

Аялал жуулчлалын салбар нь нөөц, баялгийн ашиглалтаас хамааралгүй нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ хувилбарын үндсэн салбарын нэг болох боломжтой салбар юм. Тус салбарын хүчин чадлыг дайчлахын тулд Засгийн газар, хувийн хэвшил хамтарч ажиллах шаардлагатай. Аялал жуулчлалын компаниудын маркетинг, сурталчилгаа салбарын өсөлтөд чухал ач холбогдолтой ч Засгийн

газар үндэсний хэмжээнд сурталчлах арга хэмжээг авч Монгол Улсын аялал жуулчлалын салбарын имиж бүрдүүлэлтийг үр дүнтэйгээр хийх боломжтой. Түүнчлэн Засгийн газар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийн тулд дотоодын нислэгийн тоог нэмэгдүүлэх, нислэгийн шинэ гарцыг нэмэгдүүлэх, аяллын визний шаардлагыг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал.

Засгийн газрын тус салбарыг хөгжүүлэх санаачилгын бас нэг чухал чиглэл бол аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бүс нутаг хоорондын болон олон улсын холбооны үйл ажиллагааг дэмжих явдал юм. Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь Монгол Улсын хувьд тун ирээдүйтэй бөгөөд үүнийг Засгийн газар аймаг дундын аялал жуулчлалын тулгуур төвүүдийг байгуулж, бүсийн аялал жуулчлалын тулгуур төвүүд рүү шууд нислэг үйлддэг болгож дэмжих хэрэгтэй. Түүнчлэн ОХУ, БНХАУ-тай хийх худалдааны хэлэлцээрүүдийн хүрээнд олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр ажиллах хэрэгтэй. ОХУ-тай хил залгаа оршиж буй аймгуудын аялал жуулчлалыг Бүгд Найрамдах Буриад улс, Байгаль нууртай холбож, БНХАУ-ын Манжуур, ОХУ-ыг холбосон аялал жуулчлалын гурвалжинг хөгжүүлнэ.

Засгийн газар аялал жуулчлалын салбарын дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд санхүүжилтийн шинэ механизмыг бий болгох шаардлагатай. Үүний хүрээнд орон нутгийг хөгжүүлэх санг байгуулж, уул уурхайн салбар болон аялал жуулчлалын томоохон бүтээн байгуулалтуудын орлогын тодорхой хувийг тус санд төвлөрүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд ойн сан, байгалийн нөөцийг хамгаалах зэрэг зардалд зарцуулах хэрэгтэй.

#### **(4) Банк, санхүүгийн салбар**

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн түүхэн үе шатанд Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулсан. Монголын хөрөнгийн бирж нь 2006 оны байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээгээр дэлхийн хамгийн жижиг хөрөнгийн биржид тооцогдож байсан бол 2010 онд дэлхийн хамгийн сайн үзүүлэлттэй хөрөнгийн бирж болжээ. 2019 оны 2 дугаар сарын байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 218 хувьцаат компанийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2.5 их наяд төгрөг хүрсэн бөгөөд 2021 оны 2 дугаар сарын байдлаар хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 3 их наяд төгрөг болжээ. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Дэлхийн аливаа улс орны хөрөнгийн биржийн үйл ажиллагаа нь үндэстэн дамнасан корпорациудаас хамааралтай болсон. Жишээлбэл Ирланд улс 1990-ээд онд АНУ-ын хөрөнгийн биржийн дэргэдэх судалгааны хүрээлэнгүүдэд “campus компаниудыг” амжилттай бүртгүүлснээр биржийн капитализацийг нэмэгдүүлсэн. Үүнийг хүний нөөц, програм хангамж хөгжүүлэх судлаачдын чадавхыг Засгийн газрын дэмжлэгтэй хослуулснаар хэрэгжүүлэх боломжтой. Японы хөрөнгийн биржийн идэвхтэй үйл ажиллагааг Японы пүүсүүдийн хувьцааг худалдаж авсан гадаадын хөрөнгө оруулагчид голчлон дэмждэг. Гол нь эдгээр Японы пүүсүүд гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй. Хөрөнгө оруулагчид АНУ дахь Японы пүүсүүдийн хувьцааг арилжиж, Японы хөрөнгийн биржид бүртгэлтэй

ижил пүүсийн хувьцааг худалдаж авах мөн эсрэгээрээ зэргээр санхүүгийн арбитраж хийх боломжтой.

Тиймээс Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэхийн тулд Монгол Улсад үндэстэн дамнасан корпорациуд бизнес эрхлэх нь чухал юм. Монголд Улсад тэдгээр пүүс компаниудыг үүсгэн байгуулахад дөхөм болгох үүднээс олон үндэстний корпорациудын үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Түүнчлэн өөр нэг нөхцөл нь олон улсын банкуудын салбар нэгжийг байгуулах шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын голлох хөрөнгө оруулагчид уул уурхайн корпорациуд байсан боловч цаашдаа уул уурхайн үйл ажиллагаа нийгэм, экологийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хүндрэл бэрхшээл учирч байна. 8.4.1 дүгээр хэсэгт санал болгосноор хариуцлагатай уул уурхайн урьдчилсан нөхцөл нь уул уурхайн үйл ажиллагаанаас олох ашгийг орон нутгийн иргэдтэй хуваалцах юм. Одоогийн байдлаар үндэстэн дамнасан корпорациуд хөрөнгө оруулаагүй байгаа газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн хувьд илүү боломж олдож магадгүй юм. Мах боловсруулах (худалдан борлуулах) томоохон пүүс компанийн хөрөнгө оруулалтаар хэдэн зуун мянган га газарт асар том фермерийн аж ахуйг Эдийн засгийн чөлөөт бүс болгон байгуулж, Монголын түншүүдтэй хамтарсан компани байгуулж, олон улсын хүнсний чанарын стандартыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортод гаргах санал дэвшүүлж байна. Тухайн хамтарсан компани нь АНУ, Япон, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй байх шаардлагатай.

Сампус компани, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх пүүс компани бол зөвхөн нэг жишээ юм. Бусад өөр боломжуудыг эрэлхийлэх нь зүйтэй. Үүний гол санаа нь зөвхөн уул уурхайн боловсруулах үйлдвэрлэл төдийгүй газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх гадаадын хөрөнгө оруулагчдыг урьж Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэх явдал юм ( Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хамтарсан компаниуд). Монгол Улсын хүний нөөц, судалгааны байгууллагуудын оролцоотойгоор энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Засгийн газар үндэстэн дамнасан корпорациудад бизнесийн таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.

## **8.5 Хөгжлийн удирдлага, санхүүгийн тогтолцооны институцийн арга хэмжээ**

### **8.5.1 Тойм**

ҮХЦТ-д санал болгож буй төсөл, хөтөлбөрүүд нь өнөөгийн хөгжлийн удирдлага, санхүүжилтийн хүрээнд хэрэгжиж байна. Хэрэгжилтийг илүү үр дүнтэй болгохын тулд энэ хэсэгт зарим зөвлөмжийг тусгасан болно. 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш хөгжлийн удирдлага, санхүүжилтэд өөрчлөлт орсон боловч социалист дэглэмийн өв уламжлал зарим талаар нөлөөлсөөр байна. Аливаа тогтолцоог хүн удирддаг тул уг тогтолцооны үйл ажиллагаа нь байгууллагын соёл, нийгмийн хандлагыг бүрдүүлж буй ажилтан, албан хаагчдын сэтгэлгээтэй ихээхэн холбоотой. Түүнчлэн засаг захиргаа, санхүүгийн тогтолцоог нэн яаралтай өөрчилсний улмаас Монгол Улсын макро эдийн засгийн шинэ асуудлууд үүссэн.

Менежменттэй холбоотой зарим асуудлуудын хувьд байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой буюу байгууллагын зохисгүй соёл, харин гадаад хүчин



зүйлээс үүдэлтэй гэвэл сонгуулийн үр дүнгээс шалтгаалан удирдах албан тушаалтан солигдсоноос үүсэх улс төрийн хэт их нөлөөлөл байна. Хэдийгээр Монгол Улс хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хөгжил, удирдлагын хувьд маш их боломж, давуу талуудтай боловч 1990 он хүртэл хүчтэй үйлчилж байсан Зөвлөлтийн нөлөөг арилгах, өөрчлөгдөж буй үнэт зүйлсэд дасан зохицохын тулд институцийн хөгжлийн хувьд сайжруулах шаардлагатай олон зүйлс ажиглагдаж байна.

Монгол Улсад уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалт олширч эдийн засгийн өндөр өсөлтийг дагуулсан хэдий ч энэ нь эргээд экспортын бүтээгдэхүүн, чиглэлийн хязгаарлагдмал байдлыг үүсгэн улмаар гадаад валютын өрийг нэмэгдүүлсэн нь макро эдийн засгийн бүтцийн асуудал үүсэхэд хүргэсэн. COVID-19-ийн эсрэг онцгой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа нь Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны чиг үүрэг, санхүүгийн чадавхыг дахин шалгах боломжийг олгож байна. Бүтцийн асуудлыг шийдвэрлэх, COVID-19-ийн сөрөг нөлөөллийг арилгах тогтвортой өсөлтийг хэрэгжүүлэх аргуудыг энд санал болгож байна.

## **8.5.2 Институци, байгууллагын хөгжилтэй холбоотойгоор тулгарч буй асуудлууд**

### **(1) Нийгмийн зөв тогтолцоо**

Монгол Улсыг Зөвлөлтийн нөлөөнд байсан улс орнуудтай харьцуулвал эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр байна. Мөн яам, агентлаг болон компаниуд хоорондын харилцаа холбооны хувьд хамгийн сайн нь байна.

Хөдөө орон нутагт нүүдэлчдийн аж төрөх ёс, ахуй амьдралаас үүдэн хөвгүүд нь эцэг эхээсээ малаа өвлөн авч, малчин болж амьдардаг бол эцэг, эхчүүд нь охидуудаа Улаанбаатар хот руу дээд боловсрол эзэмшүүлэхээр явуулдаг. Дээр дурдсанаар их дээд сургуульд суралцаж буй нийт оюутнуудын 60-70<sup>1</sup> хувь нь эмэгтэй оюутнууд байгаа бөгөөд энэ нь төр, хувийн хэвшлийн байгууллагууд боловсролтой эмэгтэй ажиллагсад ажиллуулахад нөлөөлж байна.

Ялангуяа 1990-ээд онд социалист систем задрах хүртэл ерөнхий боловсролын сургалтын тогтолцоо маш сайн байсан тул Монгол Улсын хүн амын бичиг үсгийн түвшин 100 хувь хүрсэн. Монгол Улс нь харьцангуй өндөр боловсролтой, сахилгатай, олон хэл эзэмшсэн хүний нөөцийг бэлтгэсэн. Энэ нь улам бүр даяаршиж буй нийгэмд томоохон давуу тал болох нь дамжиггүй юм.

Монгол Улсын нүүрс, зэс зэрэг байгалийн баялагт суурилсан уул уурхайн салбарын хөгжлийн улмаас 2011 онд ДНБ 16 хувиар өссөн бөгөөд энэ нь дэлхийн хамгийн өндөр үзүүлэлт байсан билээ. 2014 оноос хойш Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл мөн эерэг үзүүлэлттэй байсан.

### **(2) Улс төрийн тогтворгүй байдал болон төрийн албан хаагчдын халаа, сэлгээ**

Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх байгалийн нөөц баялаг, ард иргэдийг мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах мал аж ахуй эрхлэлт зэрэг давуу тал байгаа хэдий ч Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй

---

<sup>1</sup> 2019 оны 4-р сарын 9-ний АХБ-ны зөвлөлдөх уулзалтын үеэр Др. Б. Отгонтөгсийн илтгэлд дурдсанаар статистикийн сүүлийн үеийн мэдээллээр их, дээд сургуулийн оюутнуудын 64%-ийг эмэгтэй оюутнууд эзэлж байна.

төслүүдэд улс төрийн хүрээнд хангалттай дэмжлэг үзүүлж чадахгүй байна. Үүний гол шалтгаан нь улс төрийн тогтворгүй байдал, төрийн албан хаагчдын халаа сэлгээ (төрийн албан хаагчдыг олноор нь удаа дараа халж, сольдог) бөгөөд ихэвчлэн сонгуулийн дараа яам, агентлаг, төслийн нэгжийн ажилтан, албан хаагчдыг халж, сольдог.

1990 оноос хойш УИХ-ын ээлжит сонгуулийн үр дүнд төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт байнга өөрчлөгдөж улмаар улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэсэн. Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, мэргэжилтнүүдийн ихэнх нь өөрчлөгдөж, сонгогдсон улс төрчид төрийн албаны томилгоо, халаа сэлгээ хийдэг. Дээр дурдсанаар төрийн албанд эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоотой, зөв бүтэц бүхий нийгэм нь ажилтан, албан хаагчдад ажиллах урам зориг төрүүлдэг ч улс төрийн тогтворгүй байдлын улмаас тэдгээрийн ажлын гүйцэтгэл муудах хандлагатай байна. Бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс мэдлэг туршлагадаа үндэслэн баг хамт олноороо идэвхи зүтгэлтэй хамтран ажиллах байдал хангалттай бус байна.

Энэхүү төрийн албаны байнгын халаа сэлгээний үр дүнд ихэнх яам, байгууллагуудад ажлын туршлага багатай удирдах ажилтнууд, мэргэжилтнүүд ажиллаж байгаагаас ажлын бүтээмж хангалтгүй, баг хамт олноороо идэвх зүтгэлтэй хамтран ажиллах нь учир дутагдалтай байгаа бөгөөд төсөл хэрэгжүүлэхэд холбогдох яам, байгууллагуудын хооронд зөвшилцөл, ойлголцлыг бий болгоход саад учруулж байна.

Ажилтнуудын тухайн жилд ажилд орж байгаа болон ажлаас гарч байгаа түвшин 30%-иас бага байх, тухайн байгууллагад ажиллаж, туршлага хуримтлуулсан тул тус түвшин 15% -иас бага байхыг зөвлөдөг. Одоогийн энэхүү түвшинг 20% болон түүнээс доош бууруулахын тулд баг хамт олноороо идэвх зүтгэлтэй ажиллах, эерэг сэтгэлгээг бий болгох зарим сургалтыг зохион байгуулснаар байгууллагын соёлыг өөрчилж, өөрийн ажлаас гадна бусдын ажлын талаар огт анхаардаггүй ажиллагсадын харилцан ойлголцол, дэмжлэгийг бий болгох бөгөөд байгууллагын бүх ажиллагсад өндөр бүтээмжтэй, харилцан ашигтай ажиллах боломжийг бүрдүүлдэг.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2019 оны 1-р сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Энэхүү хуульд заасны дагуу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглосон.

### **(3) Нийгэм болон иргэдийн сэтгэлгээ**


Дээд дурдсанаар улс төрийн тогтворгүй байдал, ажилтны халаа сэлгээ нь нийгэм, иргэдийн сэтгэлгээ болон төр, хувийн хэвшлийн байгууллагад ч нөлөөлсөн. Аливаа байгууллагын ажилтан, албан хаагчид нь байгууллагынхаа хамтын үнэ цэнээс илүүтэй хувь хүний ашиг, сонирхолыг дээгүүр тавьдаг. Энэ нь гадаадын зочид, бизнес эрхлэгчдийн сонирхолыг татахгүй байх нөхцөл бүрдүүлж улмаар хөгжлийн боломжоо алдахад хүргэдэг. Яам, агентлаг, байгууллага, компаний ажилтан, албан хаагчид хариуцаж буй ажил үүрэгтээ үнэнч бус, идэвх зүтгэлгүй хандаж байгаа нь хамгийн муу үзүүлэлт юм.

2018<sup>2</sup> оны Аймгуудын өрсөлдөх чадварын тайлангийн /10-р хуудас/ "Тооноос чанар руу" бүлэгт тусгаснаар төрийн албан хаагчид нь эдийн засаг өсөхийн хэрээр хүний хамгийн анхан шатны хэрэгцээ болох хоол хүнс, хувцаснаас илүүтэйгээр чанарт анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай болдог. Энэ нь эдийн засгийн хувьд тоо хэмжээ хангалттай болсны дараа хүмүүс үйлчилгээний чанарыг эрэлхийлж, ерөнхийдөө амьдралын чанар илүү чухал гэдгийг ойлгодог.

Зураг 8.5.1-д одоогийн дээрээс доош чиглэсэн урсгалыг доороос дээш, дээрээс доош хамтад нь хэрэгжүүлж, харилцааны болон сэтгэлгээний өөрчлөлт хийх хэрэгтэйг харуулсан болно. Энэ нь "чанарыг дагаж тоо хэмжээ" гэдэгт хэт их анхаарахгүйгээр бүх хэрэглэгчдийн хувьд "чанар ямар ч бизнест зайлшгүй байх ёстой" гэсэн үг юм.

### Зураг 8.5.1 “Enterprise Mongolia” үзэл баримтлал<sup>3</sup>

**Mongolia can participate in the Olympics of Economies,  
if you stop the Soviet style ...**



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### (4) Үйлчлүүлэгчид чиглэсэн үйл ажиллагаа

2019 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2017 оны 12-р сарын 7-ны өдөр батлагдсан Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчдын үйлчлүүлэгчдийн талаар баримтлах үзэл баримтлал тусгагдаагүй болно.

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

<sup>2</sup> Эдийн засаг, өрсөлдөх чадварын судалгааны төвийн тайлан 2018 он (web site: eee.ecrc.mn info@ecrc.mn)

<sup>3</sup> 2016 оны 5-р сард ШУТИС дээр зохион байгуулагдсан "Иноваци, бизнес эрхлэлтийг хөгжүүлэх" олон улсын хурлын илтгэл. Монгол Улсын ард иргэд бүгд өөрсдийгөө "Enterprise Mongolia" ганцхан компаний ажилтан гэж ойлгох хэрэгтэй. Энэхүү санааг уулзалтуудаар хэлэлцэх нь зүйтэй.

Харин Япон улсын Төрийн албаны тухай хуульд доорхи зүйл орно. Үүнд:

1 дүгээр зүйл. Энэхүү хууль нь төрийн албан хаагчдад хамаарах үндсэн стандартыг (үүнд төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн, нийгмийн баталгааны зохих арга хэмжээг багтаасан) бий болгож, төрийн албан хаагчдыг ардчилсан зарчмаар сонгосноор ажлын байрны гүйцэтгэл өндөр байж, ард иргэдэд зориулсан ардчилсан, үр ашигтай үйлчилгээ үзүүлнэ.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйлд төрийн албан хаагчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг ард иргэдэд хүргэх үйлчилгээг үл харгалзан тогтоосон байхад Японы хуульд төрийн албан хаагчдыг ард иргэдийн төлөө хамгийн өндөр гүйцэтгэлтэй үйлчилгээг үзүүлэхийн тулд хэрхэн ажиллах ёстойг тодорхойлсон байдаг. Японы төрийн албан хаагчид ард иргэддээ үйлчлэх ёстой гэдгийг ухамсарласан, үүнийгээ үүрэг даалгавар гэсэн хандлагатайгаар ажилладаг.<sup>4</sup>

Төрийн албан хаагчид нарийн тодорхойлсон үйлчлүүлэгч байхгүй тул зөвшилцөлд хүрэх боломжгүй, учир нь хэний төлөө ажиллаж байгааг хэн ч ойлгоогүй бөгөөд төрийн албан хаагч бүр өөр өөрийн ашиг сонирхолын төлөө ажиллах боломжтой байдаг.

#### **(5) Инфляцийг тогтвортой түвшинд байлгах**

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт зааснаар Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах зэрэг эрхийг эдэлдэг. Инфляцийг 10%<sup>5</sup>-иас доош түвшинд хянаж чадвал Засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сайн боловсрол олгох, хүүхэд, хөдөлмөрийн чадвар алдсан, өндөр настай иргэдэд халамж өгөх хангалттай төсвийг бүрдүүлж чадна. Түүнчлэн ядуурлын шугамын доор орсон иргэдийг байшин, сууцаар хангах ч боломжтой болно.


1990 оны Зөвлөлт Холбоот Улсын задралын дараа 1991-1995 онуудад Монгол Улс ТУХН-ийн орнуудаас хангагдаж байсан түлш, хоол хүнс болон бусад үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний хомсдолд орж эхэлсэн. Энэ хомсдолын улмаас 1990-ээд оны эхэн үед 50 гаруй хувийн өндөр инфляцитай байсан (Зураг 8.5.2).

#### **Зураг 8.5.2 Монгол Улсын инфляцийн түвшин, хэрэглээний үнийн индексээр, 1991-2018 он**

---

<sup>4</sup> Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд Төрийн албаны эрхэм зорилгыг тусгасан. Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

<sup>5</sup> Инфляцийг гадаад валютаас хараат байдлыг багасгах, мөнгө хэвлэж зах зээлд нийлүүлэх замаар бууруулах боломжтой. Энэ талаар дараагийн хэсэгт тусгана.



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын инфляцийн түвшинг 10%-иас бага түвшинд барьж худалдааны эерэг баланстай байж ирсэн (Зураг 8.5.3). Тиймээс илүү том тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой байв. Инфляцийг 4 орчим хувьтай байлгах нь ихэнх бизнес эрхлэгчдийн хувьд бизнесээ цаашид хөгжүүлэхээр тэлэх, хөрөнгө оруулах шийдвэр гаргахад хамгийн таатай байдаг гэж үздэг. Тиймээс инфляцийг тогтвортой түвшинд байлгах тал дээр анхаарах шаардлагатай.

### Зураг 8.5.3 Монгол Улсын сүүлийн 10 жилийн инфляцийн түвшин, хэрэглээний үнийн индексээр



Эх сурвалж: Trading Economics

## (б) Улсын өр

Хүснэгт 8.5.1-д үзүүлснээр Монгол Улсын гадаад өр ДНБ-ний 270%-тай тэнцэж байгаа бөгөөд дотоод өр гадаад өрийн 0.26%-тай тэнцэхүйц бага байна. Энэ нь Монгол Улс гадаад валютын зах зээлээс хамааралтай бөгөөд Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээл хангалттай хөгжөөгүй байна гэсэн үг юм. Энэхүү нөхцөл байдал нь Монгол Улсын эдийн засаг нүүрс, зэс, алт, ховор металл зэрэг байгалийн баялгийн экспортоос ихээхэн хамааралтай байгаатай холбоотой. Засгийн газар үнэт цаасыг хангалттай гаргахгүй байгаа нь зээлийн хүү өндөр буюу 10% болон түүнээс дээш байгаа нь төрийн санд дарамт болж байгаатай холбоотой.

### Хүснэгт 8.5.1 Монгол Улсын нийт өр

Нэгж: сая ам.доллар

Өр	Хэмжээ
Гадаад валютын өр	30,599,63
Богино хугацаат	2,926.19

Урт хугацаат	27,674.44
<b>Дотоод валютын өр</b>	78.25
Богино хугацаат	37.45
Урт хугацаат	40.71
Тодорхойгүй	-
<b>Нийт өр</b>	30,677.88

Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Энэхүү статистикийг ОУВС-гийн Мэдээлэл тархаалтын тусгай стандартын дагуу бэлтгэсэн. (Өрийн хэмжээ 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар)

Импортын бараа бүтээгдэхүүнийг гадаадын валютаар худалдаж авдаг тул төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсаар байна (Зураг 8.5.4). Хэдийгээр Монгол Улс түүхий ноолуур их хэмжээгээр бэлтгэдэг хэдий ч БНХАУ-аас самнасан ноолуур, өргөн хэрэглээний бараа, үйлдвэрийн түүхий эдийг гадаад валютаар худалдаж авдаг. Зөвхөн бизнес эрхлэгчид төдийгүй Монгол Улсын ихэнх иргэд өөрийн мөнгөн тэмдэгт-төгрөгийн зээлээс 15%-иар өндөр хүүтэй гадаадын валютын зээлийг илүүд үздэг.

### Зураг 8.5.4 Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: <https://tradingeconomics.com/mongolia/currency>

### 8.5.3 COVID-19 цар тахлын дэгдэлтээс авсан сургамж

#### (1) COVID-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн санхүүгийн арга хэмжээ

2019 оны сүүлээр дэлхий даяар COVID-19 вирусийн халдвар тархсанаас хойш дэлхийн улс орнууд ялангуяа эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй орнуудын Засгийн газар цар тахлын нөлөөг даван туулахын тулд хариу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Ихэнх орны Засгийн газар онц байдал зарлаж, улс орондоо олон төрлийн бизнесийн үйл ажиллагааг зогсоосны дараа бизнес эрхлэгчид, хувь хүмүүст их хэмжээний санхүүгийн туслалцаа үзүүлж эхэлсэн. Олон төрлийн шалтгааны улмаас улсын төсвөөс санхүүжилт гаргах хэрэгтэй болж байгаатай холбоотойгоор онцгой байдлаас улбаатай асуудлуудыг богино хугацаанд даван туулахад, улмаар эдийн засгийн тогтвортой хөгжлийн урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэхэд дотоод болон гадаад өрийг хэрхэн төлөх нь ихээхэн анхаарал татсан асуудал болж байна.

Монголбанк онцгой байдалд хариу арга хэмжээ болгон мөнгөний бодлогын хүүгээ 11% байсныг 3-р сард 1%-иар, 4-р сард дахин 1%-иар буулган 9% болгосон. 1-р сарын эхээр эдийн засгийн арга хэмжээ авч эхэлсэн БНХАУ-ын Засгийн газартай харьцуулахад Монгол Улсын Засгийн газар нь дөнгөж 4-р сард 5.1 их наяд төгрөгийг (1.9 тэрбум ам.доллар) эдийн засгийн эрсдлийг бууруулах Засгийн газрын хөтөлбөрийг санхүүжүүлэхээр баталсан. Одоогийн байдлаар Монголбанкны харьяа арилжааны банкуудаас зээл авах хүсэлтэй бизнес эрхлэгчид хэр их байгаа вэ гэсэн асуулт үүсэж байна (Дефакто тойм, 4 дүгээр сарын 24).

#### (2) COVID-19 цар тахлын үед эдийн засгийн хариу арга хэмжээ авсан зарим улс орнуудын жишээ

АНУ-ын Холбооны нөөцийн сан: 2020 оны 3-р сард АНУ-ын Төв банк нь цар тахлын улмаас санхүүгийн хохирол амссан компаниуд, муж/орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад туслахаар эдийн засгийн тусламжийн багц болгон төлөвлөсөн нийт 6 их наяд ам.доллар (ДНБ-ий 30%-тай тэнцэх хэмжээний мөнгө) дээр нэмэлтээр 2.3 их наяд ам.долларыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой гэж зарласан. Конгрессын зөвшөөрлөөр Сангийн яамны сангууд нь төрийн сан хөмрөгөөс 10 тэрбум долларын санхүүжилт авсан төслийн нэгжээр (special-purpose vehicle) дамжуулан хотын болон компанийн бондыг худалдаж авна. Түүнчлэн Холбооны засгийн газар жижиг бизнесийн удирдлагын зээлийн



хөтөлбөрийн хүрээнд зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэхээ зарласан (New York Times, 4 дүгээр сарын 9).

Их Британийн Засгийн газар цар тахлын үед бизнесийг дэмжиж, мөнгөн гүйлгээг нэмэгдүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээ авахаар амлаж 330 тэрбум гаруй фунтын зээл, баталгааг олгож компаниудын үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд нь туслахаа зарласан. Жижиг, дунд бизнесийн хувьд коронавирусын улмаас үйл ажиллагаа тасалдсан бизнест олгох зээлийн хөтөлбөрийн хүрээнд ирээдүйтэй бизнесийн үйл ажиллагаанд Засгийн газрын баталгаатай, эхний жилийн хүүгийн төлөлтийг Засгийн газраас даасан 5 сая хүртэлх фунтын санхүүжилтийг шийдвэрлэсэн (Express & Stars, 3 дугаар сарын 17).

Их Британийн Засгийн газар хөдөлмөр эрхлэгчдийнхээ цалингийн 80%-ийг олгож дэмжлэг үзүүлсэн. ХБНГУ-ын Засгийн газар цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өртөгсдөд зориулж нийт 0.8 их наяд ам.долларын тэтгэмжийг олгосон.

Японы Засгийн газар нь онцгой байдлын үед нийт 1 их наяд ам.долларын тусламжийн сангаас 46 тэрбум орчим ам.долларыг компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүнээс зөвхөн 0.17 их наяд ам.доллар нь бэлэн мөнгөний дэмжлэг байсан. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд эдийн засгийн нөхцөл байдал хурдацтайгаар хумигдаж байгаатай холбогдуулан хүүгүй зээл олгохоор 3-р сард зарласан 1.9 тэрбум ам.долларын дэмжлэг дээр нэмэлтээр энэхүү хөтөлбөр хэрэгжсэн (NHK World Japan, 4 дүгээр сарын 4).

### **(3) Цар тахлын үеийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын ажиллагсад**

COVID-19 цар тахлын дэгдэлтээс үүдэн галын шугаманд ажилладаг чухал шаардлагатай ажиллагсадын ажил бөгөөд тэдний авдаг цалин хөлс маш бага байдаг талаар дэлхийн улс орнууд мэддэг болсон. Үүнд зөвхөн эмнэлгийн болон нийгмийн ажилтнуудыг хамруулаад зогсохгүй зайлшгүй шаардлагатай хүнс, бараа бүтээгдэхүүний логистик үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт ажилладаг хүмүүс багтаж байна. Түүнчлэн ХАА-н салбарын буюу хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ажилчдыг зайлшгүй шаардлагатай ажилчид гэж тооцож байна. Өөрөөр хэлбэл өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай бараа, бүтээгдэхүүнээр хангахад оролцож буй ажилчдыг чухал шаардлагатай ажилчид гэж үзэж байна.

Улс орнуудын цар тахлын дараах хөгжлийн асуудалд нийгэм, эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангахын тулд хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр ажиллагсадыг шаардлагатай ажилчдын түвшинд авч үзэх шаардлага тулгарч болох юм. Үүнд бага, дунд боловсрол олгох багш нар багтах бөгөөд өргөн хүрээнд судалгаа хийдэг судлаачдыг ч мөн хамруулж болно. Эдгээр хүмүүс нь зах зээлд шууд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлдэггүй тул өрсөлдөөн ихтэй нийгэмд хөдөлмөрөө харьцангуй багаар үнэлүүлдэг.

### **(4) Мөнгөн тусламж (үр дүнтэй богино хугацааны арга хэмжээ)**

Японы Засгийн газраас үзүүлсэн бэлэн мөнгөний дэмжлэг нь COVID-19-ийн дэгдэлтээс болж санхүүгийн хүнд байдалд орсон хүмүүсийн хувьд дэмжлэг болсон ч чинээлэг хүмүүсийн хувьд ач холбогдол багатай байсан гэж үзсэн байна. Санхүүгийн хувьд хүнд байдалд орсон тэдгээр иргэд мөнгийг зарцуулж, эдийн засгийг эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Энэ нь эдийн засгийг идэвхжүүлэхийн тулд мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх нь чухал болохыг харуулж

байна.

### **(5) Төв болон орон нутгийн захиргааны байгууллага**

Европын улс орнууд COVID-19 цар тахлын тархалтыг хумихын тулд нийслэл хот болон бусад томоохон хотууддаа хөл хорио тогтоосон. Ийм арга хэмжээг зөвхөн төвлөрсөн, хүчтэй эрх мэдэл бүхий засгийн газартай улсууд авсаар ирсэн. Энэ нь нэг талаар Европын хотуудын бие даасан байдалтай зөрчилдөж байв. Нөгөө талаас бие даасан, эрх мэдэл бүхий орон нутгийн захиргааны байгууллага илүү үр дүнтэй арга хэмжээг авч болох юм. COVID-19 цар тахлын тархалтыг хумихад БНХАУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төвлөрсөн удирдлагын арга хэмжээ ихээхэн үр дүнтэй байсныг дэлхий нийт харсан.

Ийнхүү төвлөрсөн байдлаар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудын баримталж буй эрх мэдлийг задлах, орон нутгийн захиргааны байгууллагуудыг эрх мэдэлтэй, бие даасан болгох чиглэлтэй нийцэхгүй. Харин хотууд, орон нутгийн захиргааны байгууллагууд хамтарсан байдлаар хуулийн хүрээнд хөл хорио тогтоох, хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авах зохицуулалтууд байх боломжтой. Хямралыг даван туулахтай холбоотойгоор төв болон орон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн хуваарилалтыг эргэн харах шаардлагатай байна.

### **8.5.4 Санал болгож буй арга хэмжээ**

#### **(1) Монгол Улсын эдийн засгийн бүтцийн асуудал**

Сүүлийн жилүүдэд ажиглагдсан эдийн засгийн өндөр өсөлт нь гадаадын хөрөнгө оруулалттайгаар олборлосон нүүрсний болон бусад ашигт малтмалын экспортоос үүдэлтэй юм. Үүнээс шалтгаалан Монгол Улсын гадаад өр ДНБ-ний 270%-тай тэнцэж байна. Төгрөгийн зээлийн хүү өндөр байдаг тул олон хувийн компаниуд гадаад валютаар зээл авахыг илүүд үздэг. Төгрөгийн хүү өндөр байгаа нь мөнгөний урсгалыг хязгаарлаж, энэ нь эргээд зээлийн хүүг нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Дотоодын валютын гүйлгээ багасч байгаа тул томоохон аж ахуйн нэгжүүд энэхүү дутагдлыг нөхөх зорилгоор гадаадын валют нэвтрүүлж байна. Үүний үр дүнд төгрөгийн ханш суларч, импортын үнийн хөөрөгдөл бий болсон. Томоохон аж ахуйн нэгжүүд гадаад валютын гүйлгээг нэмэгдүүлэх чадалтай. Харин жижиг аж ахуйн нэгжүүд ийм боломжгүй юм. Тиймээс баян ядуугийн ялгаа улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь Монгол Улсад тулгараад удаж буй асуудал бөгөөд өөр капиталист орнуудад ч гэсэн тулгардаг асуудал юм. Дотоодын валютын гүйлгээ хязгаарлагдмал байгаа тул энэ асуудал Монгол Улсад илүү хүндээр тусах магадлалтай байна. Засгийн газар 2012 оноос Монголбанкаар, 2014 оноос Монголын хөрөнгийн биржээр дамжуулан бонд арилжаалж эхэлсэн. Гэсэн хэдий ч Засгийн газрын бондын дийлэнх хэсгийг цөөхөн арилжааны банкууд эзэмшиж, хэт өндөр хүүтэй болсон нь Сангийн яаманд дарамт учруулж байсан тул 2017 оны 10 дугаар сараас эхлэн арилжааг зогсоосон бөгөөд 2020 онд бонд шинээр гаргах ажлыг эхлүүлжээ.

Хөгжлийн удирдлага, санхүүтэй холбоотой одоо байгаа нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, дээр дурдсан COVID-19-өөс үүдэлтэй нөхцөл байдлын сургамжид үндэслэн нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээг санал болгон дэвшүүлж байна. Эдгээр нь байгууллагын соёл, хувь хүн, нийгмийн сэтгэлгээтэй холбоотой,

засгийн газар ба орон нутгийн засаг захиргааны хоорондын үүрэг хариуцлагын хуваарилалтыг дахин шалгах, санхүүгийн арга хэмжээ зэргээс бүрдэнэ.

## (2) Байгууллагын соёл, хувь хүн болон нийгмийн сэтгэлгээ


Шинэ засгийн газрыг байгуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 5-р сард хүчин төгөлдөр болгосон нь улс төрийн тогтворгүй байдлыг бодитойгоор шийдвэрлэх алхам болсон бөгөөд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн залгамж чанарыг хангаж өгсөн. Гэсэн хэдий ч төрийн байгууллагуудын боловсон хүчний халаа сэлгээ их хэвээр үлдэж “үйлчлүүлэгч төвтэй” сэтгэлгээ албан хаагчдын дунд дутагдсаар байна.

Монгол Улсын улс төрийн албан тушаалтан, төрийн албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Үр дүнтэй сургалтын хөтөлбөрт тусгагдсан байх ёстой. Үүнд:

- (a) Зөвшилцөлд хүрэх бүлгийн хэлэлцүүлгээр дамжуулан тууштай тэвчээртэй байх сэтгэлгээг дээшлүүлэх,
- (b) Иргэдэд учирч буй хүндрэл бэрхшээлийг үйл ажиллагаанд тулгуурласан аргаар шийдвэрлэх.


Засгийн газрын холбогдох байгууллагууд нь динамик аргачлалыг нэвтрүүлэх санаачилга дэвшүүлж, Монгол Улсад тулгарч буй олон асуудлыг шийдвэрлэх арга замыг судлах, хэрэгжүүлэх шаардлагатай. Динамик аргачлалын сургалтад хамрагдагсад "Enterprise Mongolia" төслийг хэрэгжүүлэгчийн гол байр сууринд өөрийгөө тавьж, бүлгийн хэлэлцүүлгээр дамжуулан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. Ямар ч асуудлыг хөндөн ил гаргаж төлөвлөгөө боловсруулж болно. Тухайлбал "Ажлын байрны тодорхойлолтыг сайжруулах", эсвэл "Монгол Улсын бизнесийн шударга орчин бүрдүүлэх", "Тодорхой бүс нутгийг хөгжүүлэх", "Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ" гэх мэт бүс нутгийн болон үндэсний хэмжээний хөтөлбөрүүд байж болно. Үйлчлүүлэгч хэмээх ойлголтод ард иргэд, залуучууд, хүүхдүүд, Монгол Улсын ирээдүй хойч үеийнхэн бүгд хамрагдах болно. Динамик аргачлалын үйл явц, түүний хэрэгжилтийг Зураг 8.5.5, Зураг 8.5.6-д тус тус харуулав.

### Зураг 8.5.5 Удирдагч, санал сонгох процесс



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Зураг 8.5.6 Бүлгийн динамикийг сайжруулах



Implement your training cycle for those stakeholders with problems.

1. Understand the current situation with some problems.
2. Develop and visualize ideal image as a vision without such problems.
- 3-a. Identify missing links or troubled steps in the recent activities.
- 3-b. Discuss barriers in realizing the ideal image.
4. Develop a training module focusing on the barriers  
to come up with **action plans** as solutions.
5. Implement the action plans, repeating the same training cycle.

**“Small Meeting” should be repeated 3 times at least, and  
its positive effect can be seen after 5 times of “Small Meetings”**

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### (3) Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны үүргийн хуваарилалт

COVID-19-ийн тархалт нь олон хөгжингүй болон зарим хөгжиж буй орнуудад хямралын нөхцөл байдлыг даван туулах засгийн газар, орон нутгийн засаг захиргааны үүрэг хариуцлагын хуваарилалтыг дахин авч үзэх боломжийг олгосон. Хөл хорио зэрэг эрс арга хэмжээ авахад засгийн газар хууль эрх зүйн хувьд эрх мэдэлтэй боловч хувь хүн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хянах арга хэмжээг орон нутгийн засаг захиргаа илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой юм. Ялангуяа орон нутаг дахь байнгын өөрчлөгдөж буй нөхцөл байдалд цаг алдалгүй арга хэмжээ авах шаардлагатай үед ийнхүү үүрэг хариуцлагыг хуваарилах нь илүү үр дүнтэй.

Монгол Улсын Засгийн газар улсын хилийг хааж, нийслэл хотод хөл хориог тогтоон арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэн нь үр дүнтэй байсан. Сургуулиудыг эрт хаахын зэрэгцээ гадаадаас ирж буй хүмүүсийг тусгаарлалтад оруулснаар 2020 оны 11 дүгээр сарыг хүртэл дотоодын халдварын тархалтаас амжилттайгаар сэргийлж чадсан. Засгийн газраас яаралтай тусламжийн арга хэмжээ авч байгаа хэдий ч Европын ноолууран бүтээгдэхүүний эрэлт буурч, хятад ченжүүд ноолууран түүхий эд болон бусад бараа бүтээгдэхүүнийг авах боломж хязгаарлагдмал байгаа нь олон малчдад ихээхэн хохирол авчирсан.

COVID-19-ийн тархалтын үеэр болон үүнээс хойшх хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааг тэтгэх, эдийн засгийг сэргээхэд орон нутгийн засаг захиргаа нь Монгол Улсын Засгийн газрын удирдлага дор ихээхэн үүрэг хариуцлага үүрэх шаардлагатай. ҮХЦТ-д санал болгосон бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь аймгийн засаг захиргааны үүргийг нэмэгдүүлэх, Монгол Улсын Засгийн газар болон аймгийн засаг захиргаа хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх тулгуур болж өгнө. Энэ талаар Бүлэг 10, Хэсэг 10.2-т тодорхой тайлбарласан.

#### **(4) Санхүүгийн арга хэмжээ**

Монгол Улсад тулгараад буй макро эдийн засгийн бүтцийн асуудлыг шийдэх гол түлхүүр нь дотоодын валютын эргэлтийг нэмэгдүүлэх явдал юм. Төгрөгийг зах зээлд илүү ихээр нийлүүлэх нь дотоодын валютын эргэлтийг нэмэгдүүлэх шууд арга зам байж болно. Гэтэл үүнээс үүдэн инфляци өсөх магадлалтай. Гэхдээ Монгол Улс байгалийн баялаг нөөц бүхий газар нутгийнхаа ачаар түүхэндээ ноцтой өлсгөлөнд нэрвэгдэж байгаагүй гэдгийг санах хэрэгтэй. Газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг хүмүүс ус, газрын нөөцийг зохистой ашиглан үндсэн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсээр байвал инфляцийг хэвийн түвшинд барих боломжтой. Газар тариалан, мал аж ахуй эрхэлж буй иргэд улсын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Монгол Улс сүүлийн жилүүдэд инфляцийн түвшинг амжилттайгаар барьж чадсан. Хэрэв ард иргэдийн гар дээр бэлэн мөнгө ихээр очвол тэд хяналт дор хэвийн түвшинд баригдаж буй инфляцийн нөхцөлд илүү их худалдан авалт хийнэ. Нийлүүлэлт хийх хүчин чадал хангалттай байгаа тул инфляцийг хянах боломжтой. Өөрөөр хэлбэл нийлүүлэгчдийн дунд өрсөлдөөн байгаа тул ханган нийлүүлэгчид үнийг зориудаар хэт өндөр өсгөх боломжгүй юм.

Улсын ирээдүйн хөгжилд гол үүрэг гүйцэтгэх ажилтнуудад чиглэсэн төсөв нь бас нэгэн чухал асуудал юм. Дээр дурдсанаар өрсөлдөөнт зах зээлд нэн даруй биет бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэдэггүй тул улсын ирээдүйн хөгжилд гол үүрэг гүйцэтгэх ажилтнуудын хөдөлмөрийн хөлс харьцангуй бага байдаг. Бага, дунд сургуулийн багш, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсийг бүрдүүлдэг нийгмийн үйлчилгээнд шаардлагатай төсвийг Засгийн газраас хуваарилах боломжгүй байна. Түүнчлэн олон сэдвээр суурь судалгаа хийж буй профессоруудад зориулсан төсвийн хуваарилалт нь шинэ эринд бий болж буй бизнесийн боломжуудыг ашиглахад шаардлагатай технологийн хөгжлийг хангахуйц хэмжээний биш байна.

Улсын гадаад өрийг нэмэгдүүлэлгүйгээр санал болгож буй төслүүдийн хэрэгжилтийг санхүүжүүлэхийн тулд төсвийн тогтмол хуваарилалтаас гадна санхүүгийн шинэ арга хэмжээг нэвтрүүлэх шаардлагатай. Засгийн газрын бонд гаргах нь нэг арга байж болно. Монгол Улсын Засгийн газар 2010 оны эхээр бонд гаргасан боловч хэт өндөр хүүтэй болсон нь Сангийн яаманд дарамт учруулж байсан тул арилжааг зогсоосон. Тиймээс богино хугацаатай бонд илүү ашигтай. Тухайлбал 3-4%-ийн хүүтэй, 3 сарын хугацаатай засгийн газрын богино хугацаат бонд гаргаж болно. Хугацаа дуусахад төгрөгийн нийлүүлэлт нэмэгдэнэ. Засгийн газар богино хугацаат бонд гаргах замаар дотоодын валютыг худалдан авах төлөвлөгөө гаргах хэрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх өөр нэг арга бол тусгай зориулалтын санг байгуулах явдал юм. Монгол Улсын Засгийн газраас нийгмийн даатгалын сан, орон сууцны сан, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан зэрэг олон санг байгуулсан. Эдгээр сангуудын зарим нь улс төрийн ашиг сонирхолд буруугаар ашиглагдаж, зарим нь алдагдалтай ажилласан. “Алсын хараа-2050” баримт бичигт уул уурхайн орлого, Засгийн газрын хувьцааны ногдол ашиг, хувьцааны арилжааны орлого, газрын тос, байгалийн хийг боловсруулах гэрээнээс олох ашиг, сангийн хөрөнгө оруулалтаас олох цэвэр ашгаас тодорхой хувийг төвлөрүүлэн Үндэсний баялгийн сан байгуулахыг санал болгож байна. Тус сангийн хөрөнгийг Засгийн газрын удирдамжаар уул уурхайн томоохон бүтээн байгуулалтыг дэмжих тээврийн дэд бүтцийн мега төслүүдэд ашиглахаар байна.

ҮХЦТ-д Олон нийтийн хөгжлийн сан байгуулахыг санал болгож байгаа бөгөөд уг сангийн хөрөнгийг олон нийтийн хэрэгцээнд зарцуулж, Засгийн газрын удирдамжаар тухайн аймгийн засаг захиргаа удирдан зохион байгуулна. Байгалийн баялгийг хүн бүтээдэггүй, харин байгалиас заяагддаг тул байгалийн арвин баялаг нөөцтэй аймгийн иргэн бүр байгалийн баялгаас хувь хүртэх эрхтэй.

Дотоодын валютын эргэлтийг нэмэгдүүлэх өөр нэг арга зам бол “Equity currency” буюу “Хөрөнгийн валют” юм. Өнөөдрийг хүртэл дэлхийн бүх валютыг “Өрийн валют” гэж нэрлэж ирсэн. Учир нь зээл/өр бий болгох нь мөнгийг зах зээлд шинээр оруулах цорын ганц арга юм. Харин “Хөрөнгийн валют” нь ямарваа зээл/өр бий болгохгүйгээр мөнгийг зах зээлд нийлүүлэх арга юм. Засгийн газрын бонд болон мөнгөн тэмдэгт (мөнгө) нь санхүүгийн хувьд ижил утгатай. Эдгээрийг гаргаж буй банк (Сангийн яам, Монголбанк)-ны хувьд энэ нь өр гэж тооцогддог. Гэхдээ худалдаж авсан/хадгалж байгаа хүмүүсийн хувьд эдгээр нь хөрөнгө юм.

Улсын ирээдүйн хөгжилд гол үүрэг гүйцэтгэх ажилтнуудын хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэхэд хөрөнгийн валютыг ашиглаж болох юм. Эдийн засгийн хувьд нэн даруй үр өгөөжийг өгөх бусад салбар, үйл ажиллагаанд чиглэгдсэн төсвийн хуваарилалт буурах тул Засгийн газраас эмнэлгийн болон нийгмийн ажилтнуудад чиглэсэн төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэх боломжгүй. Өөрөөр хэлбэл эмнэлгийн болон нийгмийн ажилтнуудад чиглэсэн төсвийн хуваарилалт өндөр байвал алдагдсан боломжийн зардал гарна. Гэтэл хөрөнгийн валютыг нэвтрүүлсэн тохиолдолд хүүгүй тул алдагдсан боломжийн ямар ч зардал гарахгүй.

Эмнэлэг, нийгмийн ажилтнууд болон хямралын үеэр ихээхэн хүндрэлтэй тулгарч буй хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийн валютыг нэвтрүүлэх талаар нухацтай бодож үзэх нь зүйтэй. Хөрөнгийн валютыг нэвтрүүлэх нь COVID-19 тархалтын үеэр иргэдэд бэлэн мөнгө тарааж буйтай адил үр нөлөө үзүүлнэ. Хөрөнгийн валютыг нэвтрүүлэхэд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай: 1) санхүүгийн сахилга батыг хангах механизмыг бий болгох; 2) нэвтрүүлэхээс өмнө нарийн үнэлгээ хийх; 3) инфляциас урьдчилан сэргийлэх хяналт хийх. Урьдчилсан байдлаар одоо мөрдөгдөж буй дараах хуулийг хянан үзэж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай: 1) Төв банк /Монголбанк/-ны тухай хууль (2001 оны 5 дугаар сарын 13-ны өдөр); 2) Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр); 3) Төсвийн тухай хууль (2012 оны 2 дугаар сарын 1-ний өдөр); 4) Банкны тухай хууль (2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр).

## **8.6 Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх**

### **8.6.1 Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага**

#### **(1) Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага**

Монгол Улсын Засгийн газар 1990-ээд оны улс төрийн тогтолцооны шилжилтээс хойш улс орноо хөгжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргаж ирсэн. Социалист дэглэмээс өвлөгдсөн либерал бодлоготойгоор социалист нийгмээс капиталист нийгэм рүү шилжих шилжилтийг амжилттай хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгосон. Гэвч хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа болон иргэдийн орлогын ялгаа нэмэгдсэн. Монгол Улсын нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийн хангахын тулд Монгол Улсын Засгийн газар бүсчилсэн хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгөх болсон.

Хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад хөгжлийн удирдлагыг орон нутагт шилжүүлэх нь нийтлэг хандлаа болсон. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд нутгийн захиргааны байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх шаардлагатай. Бүсчилсэн хөгжил гэдэг нь нутгийн захиргааны байгууллагын дэмжлэгтэйгээр тухайн бүс нутгийн заяагдмал нөөц баялгийг нутгийн иргэдийн ашиг тусын тулд ашиглаж, бүс нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх явдал юм. Монгол Улсын өргөн уудам газар нутагт тархай бутархай суурьшиж буй цөөн хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааг харгалзан аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх хүчин чармайлт гаргах шаардлагатай.

## **(2) Чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага**

ҮХЦТ-ний хүрээнд аймгуудыг ижил төстэй байдлаар нь үнэлэн эдийн засгийн шинэ бүсчлэлийг санал болгож, бүс тус бүрээр Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг боловсруулсан. Энэ нь тухайн бүс нутагт илүү үр дүнтэй хөгжлийн бодлого, арга хэмжээг томъёолж, бүс нутаг тус бүр хүний нөөц болон нөөц бололцоогоо бүрэн дайчилж бие даасан хөгжлийг хангах боломжийг олгоно. Засгийн газар болон нутгийн захиргааны байгууллагуудын нягт хамтын ажиллагааны хүрээнд бүсчилсэн хөгжлийг хангана. Орон нутгийн засаг захиргааны чадавх хязгаарлагдмал байсны улмаас бүс нутгийг хөгжүүлэх хүчин чармайлтууд үр дүнд хүрээгүй болно. Засгийн газар болон нутгийн захиргааны байгууллагууд үр дүнтэй хамтран ажиллахын тулд нутгийн захиргааны байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх шаардлагатай.

ҮХЦТ-ний хүрээнд нутгийн захиргааны байгууллагуудын чадавхын талаар нэмэлт судалгаа хийсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг нь хууль эрх зүй/институци, аймгийн төрийн байгууллага болон мэргэжилтнүүдийн түвшинд чадавхын үнэлгээ хийсэн. Булган, Хөвсгөл аймгийг Улаанбаатар хотоос алслагдсан байдал, хүн ам, төсвийн тэнцлийн (төсвийн алдагдал/төсвийн үлдэгдэл) урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн судалгаанд хамруулсан.

Туршилтын төслүүд болон нэмэлт судалгааны тайланд чадавхын үнэлгээ, үр дүнг нэгтгэн тусгасан. Судалгааны гол үр дүн, зөвлөмжийг доор дурдав.

### **8.6.2 Орон нутгийн засаг захиргааны байгууллагын чадавхын үнэлгээний үр дүн**

#### **(1) Мэргэжилтний чадавх**

Булган, Хөвсгөл аймгийн төрийн албан хаагчдын чадавхыг 2 түвшинд үнэлэв. Үүнд: (i) Танин мэдэхүйн ур чадвар/мэргэжлийн чадавх, (ii) Танин мэдэхүйн бус ур чадвар /үндсэн чадавх.

##### **1) Танин мэдэхүйн ур чадвар/мэргэжлийн чадавх**

Судалгаанд хамрагдагсадын өөрсдийгөө үнэлэх үнэлгээнээс үзэхэд мэргэжлийн чадавх сайн байна. Гэвч судалгаанд хамрагдагсадын ихэнх нь харьцангуй найдвартай бус мэдээллийн эх сурвалж болох фэйсбүүк, интернетээс мэдээлэл авдаг бөгөөд мэдээлэл хайж олох чадварын талаар өөрсдийгөө үнэлэх нь өрөөсгөл болохыг тэмдэглэх нь зүйтэй. Тэдний мэдээлэл олж авах, түүнийг үр дүнтэй ашиглах чадвар нь мэдээллийн сан, data visualization чиглэлээр ажиллахад хангалтгүй байж магадгүй юм. Түүнчлэн судалгаанд хамрагдагсад мэдээлэл олж авахад тулгарч буй бэрхшээлийг дурдсан. Үүнд: “үнэн зөв мэдээлэл



олж авахад хүндрэлтэй”, “интернетийн хурд муу”, “хэлний бэрхшээл” зэрэг болно. Түүнчлэн судалгаанд хамрагдагсад баримт бичиг боловсруулах, хүснэгт, илтгэл бэлдэх зэрэг компьютерийн анхан шатны мэдлэг эзэмшсэн боловч видео хурал, мэдээллийн сан зэрэг шинэ технологийг ашиглах чадвар хангалтгүй байна гэж дүгнэжээ.

## 2) Танин мэдэхүйн бус ур чадвар /үндсэн чадавх.

Судалгаанд хамрагдагсад өөрсдийнхөө танин мэдэхүйг сайн гэж үнэлсэн. Дотоод танин мэдэхүй (internal) болон гаднах (external) буюу бусад хүмүүс таныг хэрхэн хүлээж авч байгааг харьцуулахад 38.5% “Seekers” ангилалд багтсан нь тэдний дотоод болон гаднах танин мэдэхүйн өөрсдийн үнэлгээ оролцогчдын дундаж үнэлгээнээс доогуур байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдагсад хүсэл эрмэлзэлтэй, урам зоригтой байна. Тэд төрийн албан хаагч гэдгээрээ бахархдаг бөгөөд ажил үүргээ сайн гүйцэтгэхийг эрмэлздэг. Тиймээс тэд одоогийн ажил үүргээ итгэл үнэмшилтэй гүйцэтгэдэг гэж дүгнэж болох юм. Судалгаанд хамрагдагсад өөрсдөө идэвх чармайлттай боловч тэдний идэвхийг сэргээх арга хэмжээ хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдагсадын нийгмийн ур чадвар хангалттай сайн биш байна. Тэдний харилцааны ур чадвар, төрийн албанд иргэдийн оролцоог хангах талаарх мэдлэг нь боломжийн боловч сүлжээний ур чадвар, хүн төвтэй зарчмуудын талаарх ойлголтыг сайжруулах шаардлагатай байна. Ялангуяа тэдний хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон ганц бие эх, эцэг, эмзэг бүлгийнхний талаарх ойлголт, хүндлэл харьцангуй сул байна.

## (2) Байгууллагын чадавх

Байгууллагын түвшний чадавхын үнэлгээнд хүний нөөц, төсөв, үйлчилгээний чанар, орон нутгийн төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын асуудлуудыг хамруулав.

### 1) Хүний нөөц

2019 оны байдлаар Монгол Улсад 4,374 төрийн байгууллагад 198,463 төрийн албан хаагч ажиллаж байсан нь нийт хүн амын<sup>6</sup> 6.0%, нийт ажиллагсадын 15.6% -ийг эзэлж байна. Энэхүү харьцаа нь дэлхийн бусад хөгжиж буй орнуудын үзүүлэлттэй ижил байна. Төрийн албан хаагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь АНУ-д 13.3%, Канадад 20.2%, Малайзад 15.1% байна<sup>7</sup>. 2019 оны байдлаар орон нутгийн төрийн байгууллагуудад 97,374 төрийн албан хаагч ажиллаж байсан нь орон нутгийн нийт хүн амын 5.5% эзэлж байсан байна. 1 төрийн албан хаагч дунджаар 18 хүнд үйлчилж байна. Орон нутгийн төрийн байгууллагуудад ажиллаж буй нийт төрийн албан хаагчдын 67.5% нь эмэгтэйчүүд байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд Булган аймгийн төрийн 10 байгууллагад 273, Хөвсгөл аймгийн төрийн 10 байгууллагад 339 төрийн албан хаагч ажиллаж байна. Булган, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газарт 78, 76 төрийн албан хаагч тус тус ажиллаж байна. Судалгааны хүрээнд ярилцлага авах үеэр ихэнх байгууллагын батлагдсан орон тоо цөөн, батлагдсан орон тооноос цөөн ажилтан ажилуулдаг тухай дурдсан. Нийт байгууллагын тал хувь нь (11) төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар албан үүргээ гүйцэтгэхэд нь

<sup>6</sup> Төрийн албаны зөвлөл (2020), Төрийн албан хаагчдын талаарх статистикийн мэдээ

<sup>7</sup> [https://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_countries\\_by\\_public\\_sector\\_size](https://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_public_sector_size)

хангалттай гэж үнэлсэн бол үлдсэн тал хувь нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Орон нутгийн төрийн байгууллагуудын албан хаагчдад шаардлагатай мэдлэг, ур чадварыг доор дурдав. Үүнд: 1) мэргэжил дээшлүүлэх, 2) мэдээллийн технологи, 3) харилцааны ур чадвар, хандлага, 4) гадаад хэл 5) бодлого, төлөвлөлт.

Орон нутгийн төрийн байгууллагуудын албан хаагчдын халаа сэлгээ бага байна. 2020 оны УИХ-ын сонгуулийн дараа шинэ Засгийн газар эмхлэн байгуулагдсантай холбоотойгоор орон нутгийн төрийн байгууллагуудын албан хаагчид бараг солигдоогүй. Төрийн байгууллагуудад тулгарч буй хүнд сорилтуудад цалин хөлс бага, ажлын ачаалал их зэрэг орж байгаа бөгөөд цаашлаад мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт, хүний нөөцийн хомсдол зэрэг сорилтууд тулгарч байна.

## 2) Төсөв

Орон нутгийн суурь төсөв нь орлого, зарлага гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Тэнцвэржүүлсэн орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Татварын болон татварын бус орлогоос урсгал орлого бүрдэнэ. Хөрөнгийн орлого нь өмч хувьчлалын орлого болон хөрөнгө борлуулсны татварын орлогоос бүрдэнэ. Тусламжийн орлого нь улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогоос бүрдэнэ.

Төсвийн тухай хуулийн 23.6-р зүйлд заасны дагуу орон нутгийн татварын орлогын тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлдэг. Жишээ нь орон нутгийн газрын төлбөрийн 40%, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60%-ийг улсын төсөвт төвлөрүүлдэг. Орон нутгийн төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг байгууллагыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, улсын төсвийн байгууллагыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг.

Аймгийн ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас бусад ихэнх байгууллага орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээддэггүй. Төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанаас хамааран батлагдсан төсөв харилцан адилгүй байна. Байгууллагуудын батлагдсан төсвийн зарцуулалтын ихэнх хувийг ажиллагсадын цалин хөлс, шатахууны зардал эзэлдэг.

Хүснэгт 8.6.1-д 21 аймгийн 2021 оны Орон нутгийн төсвийг үзүүлэв. Үүнд орон нутгийн төсвийн орлого, зарлага, тэнцэл болон орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг багтана. Нутаг дэвсгэрт нь уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 5 аймгийн төсвийн орлого, зарлагаасаа давсан байна. Эдгээр аймгууд төсвийн илүүдлээ улсын төсөвт төвлөрүүлэх бөгөөд 2021 онд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг авахгүй. Бусад 16 аймаг төсвийн алдагдлаа орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр нөхнө. Эдгээр аймгууд дунджаар төсвийн зарлагын 43%-тай тэнцэх санхүүгийн дэмжлэг авдаг.

**Хүснэгт 8.6.1 2021 оны Орон нутгийн төсөв (сая төгрөг)**

Аймаг	Суурь зарлага			Тэнцэл	Үлдэгдэл		Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг
	Суурь орлого	Төсвөөс санхүүжүүлсэн	ОНХС-аас санхүүжүүлсэн		Орон нутгийн төсвийн үлдэгдэл	Улсын төсөвт төвлөрүүлэх	
	(1)	(2)	(3)	(4)=(2)-(1)	(5)	(6)	(7)
Архангай	9,390.5	20,454.2	540.0	-11,063.7	0.0	0.0	11,063.7
Баян-Өлгий	11,156.4	16,952.2	358.6	-5,795.8	0.0	0.0	5,795.8
Баянхонгор	11,127.7	27,472.9	635.4	-16,345.3	0.0	0.0	16,345.3
Булган	23,266.0	24,843.7	534.3	-1,577.7	0.0	0.0	1,577.7
Говь-Алтай	8,361.7	21,354.0	479.4	-12,992.3	0.0	0.0	12,992.3
Дорноговь	29,438.2	21,665.8	184.5	7,772.4	5,440.7	2,331.7	0.0
Дорнод	21,886.0	17,177.6	500.0	4,708.4	3,295.9	1,412.5	0.0
Дундговь	6,735.3	17,204.4	244.5	-10,469.1	0.0	0.0	10,469.1
Завхан	9,335.6	26,003.9	308.4	-16,668.3	0.0	0.0	16,668.3
Өвөрхангай	13,609.5	29,170.2	489.4	-15,560.6	0.0	0.0	15,560.6
Өмнөговь	154,694.0	44,576.1	376.8	110,117.9	31,203.3	78,914.6	0.0
Сүхбаатар	10,013.3	18,226.7	494.8	-8,213.3	0.0	0.0	8,213.3
Сэлэнгэ	22,827.5	26,937.4	482.5	-4,109.9	0.0	0.0	4,109.9
Төв	23,007.0	30,790.5	538.7	-7,783.5	0.0	0.0	7,783.5
Увс	10,801.0	24,200.2	443.0	-13,399.2	0.0	0.0	13,399.2
Ховд	12,488.5	21,002.8	523.9	-8,514.3	0.0	0.0	8,514.3
Хөвсгөл	14,036.0	31,696.5	962.4	-17,660.5	0.0	0.0	17,660.5
Хэнтий	13,468.3	25,136.9	577.4	-11,668.6	0.0	0.0	11,668.6
Дархан-Уул	25,402.4	16,226.7	1,025.1	9,175.7	6,423.0	2,752.7	0.0
Улаанбаатар	974,006.4	325,513.8	205.9	648,492.6	227,859.7	420,632.9	0.0
Орхон	58,323.8	18,107.2	301.1	40,216.6	12,675.1	27,541.5	0.0
Говьсүмбэр	5,809.6	6,890.2	61.2	-1,080.7	0.0	0.0	1,080.7
Бүгд	1,469,184.7	811,604.0	10,267.3	657,580.7	286,897.6	533,586.0	162,902.9

Эх үүсвэр: 2021 оны МУ-ын нэгдсэн төсөвт үндэслэн ЖТБ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж иргэдийн саналыг авах, сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих замаар иргэдийн оролцоог хангадаг. Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл юм. Тухайн орон нутгийн иргэд нь өөрсдөө тус сангийн

хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийн санаачлан шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг олгодог. Тус сангийн хөрөнгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт жил бүр хуваарилдаг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлгийг сайжруулах, бэлчээрийг хамгаалах, инженерийн хийцтэй худаг гаргах, булаг, шандыг хамгаалах зэрэг олон салбарын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж байна<sup>8</sup>.

### 3) Үйлчилгээний чанар

Булган, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт цахим засаглалыг хөгжүүлэх, мэргэжлийн, ёс зүйтэй, хүнд сурталгүй төрийн үйлчилгээ үзүүлж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахаар тусгасан.

2019 онд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх хэрэглэгчийн үнэлгээний судалгааг орон даяар явуулсан. Судалгааны үр дүнгээс харахад Булган, Хөвсгөл аймгийн төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанарыг иргэд сайн гэж үнэлжээ.

Төрийн үйлчилгээ үзүүлэхэд дараах сорилтууд тулгарч байна. Үүнд: 1) цахим засаглалыг хөгжүүлэхтэй холбоотой технологи, мэдлэг 2) ажлын өрөө тасалгаа жижиг 3) тоног төхөөрөмж дутмаг 4) байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагаа сул.

### 4) Төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах

Олон нийтийн оролцоог хангах албан ёсны үйл ажиллагааны дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт олон нийтийн саналыг авдаг. Иргэдийн саналыг уламжлалт болон ЗДТГ-ын вэб хуудсаар цахим хэлбэрээр мөн утсаар хүлээн авдаг. Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагууд (16) эрхэлж буй ажил үүргийнхээ хүрээнд жилд 1-2 удаа иргэдтэй уулзалт зохион байгуулдаг. Түүнчлэн аймгийн ЗДТГ төрийн бодлого шийдвэр, хөтөлбөр, үйл ажиллагаанд иргэдийн саналыг вэб хуудсаараа дамжуулан авдаг.

### 5) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон ганц бие эцэг, эх, эмзэг бүлэг

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд, өрх толгойлсон ганц бие эцэг, эхчүүдийн асуудлыг хариуцан ажилладаг. Тухайн байгууллагууд нь тэдгээр иргэдийн хэрэгцээ шаардлагыг тогтмол судалж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангадаг. Боловсрол, соёлын урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг судалгаанд хамрагдсан зарим байгууллагууд эдгээр байгууллагуудтай үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хамтран ажилладаг.

### 6) Олон нийтийн оролцоо, мэдээллийн ил тод байдал

Иргэдийн өргөдөл, гомдол, саналыг бичгээр болон цахим хэлбэрээр хүлээж авдаг. Төрийн байгууллагуудын тэн хагас нь иргэдийн гомдлыг цахим сүлжээгээр болон бичгээр хүлээн авдаг. Иргэдийн өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч

<sup>8</sup> <http://tusuv-oronnutag.mof.gov.mn/?p=117>

шийдвэрлэдэг зөвхөн ганц байгууллага байдаггүй. Үүнээс гадна иргэдийн сэтгэл ханамж, санал хүсэлтийг санал асуулгаар болон нээлттэй хаалганы өдөр цуглуулдаг. Төрийн бүх байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг харилцах утсаар, цахим сүлжээгээр эсхүл албан бичгээр мэдэгддэг.


Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, төр, иргэдийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор 2009 онд Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг, 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан. Иймээс улсын болон орон нутгийн төрийн байгууллагууд мэдээллийг цаг тухайд нь ил тод, хүртээмжтэйгээр хүргэх шаардлагатай. IRIM судалгааны хүрээлэн нь 2010 оноос мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх зорилгоор төрийн байгууллагын веб сайтуудын ил тод байдалд мониторинг хийсэн.

21 аймгийн захиргааны байгууллагуудын цахим засаглалын ил тод байдлын дундаж индекс 0.576 байгаа нь улсын дунджаас (0.537) дээгүүр үзүүлэлт юм. 2020 оны байдлаар Дархан-Уул аймгийн захиргааны байгууллага нь улсын болон орон нутгийн нийт 86 байгууллагаас хамгийн өндөр оноо авсан байна. Цахим засаглалын ил тод байдлын индексийн хувьд 7 аймаг “хангалттай” үнэлгээ авсан бол 6 аймаг “хангалтгүй” үнэлгээ авсан байна. Булган, Хөвсгөл аймаг дундаж үнэлгээ авсан. Орон нутгийн төрийн байгууллагын веб сайтуудын сул тал нь (i) гадаад хэлний сонголтгүй (ii) хэрэгтэй мэдээлэл болон нээлттэй өгөгдлийг татаж авах боломжгүй (iii) шууд харилцах менежментийн системгүй зэрэг болно.

#### 7) Аймгийн ИТХ, ЗДТГ-ын бүтэц зохион байгуулалт

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар (i) Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, (ii) Багийн Иргэдийн нийтийн хурал, (iii) Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Багийн Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид (iv) аймаг, сум, багийн Засаг дарга нар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлнэ. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд тухайн орон нутгийн байнгын оршин суугч байна. Зураг 8.6.1-д ЗДТГ-ын бүтэц, зохион байгуулалтыг үзүүлэв. Хүснэгт 8.6.2-т ЗДТГ-ын хэлтсүүдийн чиг үүргийг үзүүлэв.

**Зураг 8.6.1 ЗДТГ-ын бүтэц, зохион байгуулалт**



Эх сурвалж: ЖТБ

**Хүснэгт 8.6.2 ЗДТГ-ын хэлтсүүдийн чиг үүрэг**

#	Хэлтэс	Чиг үүрэг
1	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн хэмжээнд төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын зөвлөлгөө, дэмжлэгээр хангах</li> <li>- Тамгын газрын дотоод ажил болон нутгийн захиргааны боловсон хүчний бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг сургах, давтан сургах, төрийн албанд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах,</li> <li>- Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, түүнд судалгаа, шинжилгээ хийх, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг тооцон дүгнэх,</li> <li>- Аймгийн гадаад харилцааны асуудлыг хариуцах</li> </ul>
2	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөгөөг /Үндсэн чиглэл/ боловсруулах;</li> <li>- Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнес эрхлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.</li> </ul>
3	Нийгмийн бодлогын хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн нийгмийн хөгжлийн стратеги, бодлогыг төлөвлөх, боловсруулах,</li> <li>- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, хөдөлмөр, нийгмийн халамж, хамгаалал, хүн амын хөгжлийн чиглэлээр бодлого, хөтөлбөр, төсөл</li> </ul>

		боловсруулах, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах
4	Санхүү, төрийн сангийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарлага санхүүжилтийг гүйцэтгэх,</li> <li>- Улсын болон орон нутгийн төсөвт орлого бүрдүүлэх ажлыг зохион байгуулахын зэрэгцээ бүх шатны төсөвт орлого бүрдүүлэлтийн ажлын зохион байгуулалтанд хяналт тавих, бодлогын удирдамжаар ханган ажиллах,</li> <li>- Урсгал зардлыг төлөвлөх, хуваарилах, батлуулах</li> <li>- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, төлөвлөгөөт зорилтын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж, зарлага санхүүжилтийг гүйцэтгэх</li> </ul>
5	Хууль эрх зүйн хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн засаг, захиргаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх, хүчин төгөлдөр хууль тогтоомжуудаар хангах,</li> <li>- Аймгийн Засаг даргын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх,</li> <li>- Орон нутгийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, ЗД-ын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх;</li> </ul>
6	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсын Их хурал, Засгийн газар, Аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-аас гаргасан тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтэд хяналт тавин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх замаар аймгийн удирдлагууд, хэрэглэгчдийг нэгдсэн мэдээ, мэдээллээр хангах, дүгнэлт, санал боловсруулах ажлыг зохион байгуулах,</li> <li>- Төрийн үйлчилгээг сайжруулах санал оруулах, дэмжлэг үзүүлэх</li> </ul>

Эх үүсвэр: Булган, Хөвсгөл, Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын вэб сайт

## 8) Байгууллагын төлөвлөлтийн чадавх

Булган, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүд аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөөг өөрсдөө боловсруулах боломжтой. Төсөв хөрөнгийн хүрэлцээнээс хамааран тухайн баримт бичгийг мэргэжлийн багаар боловсруулдаг. Төсөв батлагдсанаар зарим бодлогын баримт бичгийг мэргэжлийн байгууллага боловсруулсан. Тухайлбал Монголын Аялал жуулчлалын холбоо Хөвсгөл аймгийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулсан. Мөн Mercu Corps олон улсын ТББ нь 7 сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан байна. Булган аймгийн хөгжлийн цогц бодлого баримт бичгийг (2010-2020) эрдэмтэд, судлаачдын баг боловсруулсан.

## 9) Сургалт

Орон нутгийн төрийн байгууллагуудын албан хаагчдыг байгууллагын дотоод сургалт болон бусад сургалтанд хамруулдаг. Байгууллага өөрсдийн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан сургалт зохион байгуулдаг бол бусад сургалтыг төрийн захиргааны төв байгууллага болон олон улсын байгууллага, хандивлагч орнууд зохион байгуулдаг. Хэдийгээр шинэ хууль тогтоомжийг танилцуулах, Монгол бичиг, ERP системийг ашиглах зэрэг анхан шатны сургалтыг зохион байгуулдаг ч орон нутгийн төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх сургалтанд хамруулах үйл ажиллагаа хангалтгүй байна.



### (3) Институцийн чадавх

- 1) Орон нутгийн захиргааны байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлого, арга хэмжээний төлөвлөгөө

Нутгийн захиргааны байгууллагууд хөгжлийн бодлогын баримт бичиг, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулдаг бөгөөд эдгээр баримт бичгийн агуулга нь аймаг бүрт харилцан адилгүй байдаг. Үүнд: Аймаг, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн хэмжээний салбарын хөгжлийн төлөвлөгөө<sup>9</sup>, үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө<sup>10</sup>, дотоод дүрэм журам, Засаг даргын захирамж зэрэг болно. Эдгээр төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн уялдаа холбоо хангалтгүй бөгөөд салбар дундын зохицуулалт сул байна.

- 2) Төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлага/авилга

Аймгийн ЗДТГ-ын вэб сайт нь ил тод байдлын цэстэй. Гэвч мэдээлэл авах боломж, хүртээмж харилцан адилгүй байна. Булган аймагтай харьцуулбал Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны нээлттэй байдал илүү байна. Бодлогын түвшинд Булган, Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт авилгатай тэмцэх зорилтыг тусгасан.

Байгууллагын түвшинд тус 2 аймгийн ихэнх байгууллага Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Авилгатай тэмцэх төлөвлөгөө боловсруулсан.

Үүнтэй холбогдуулан дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:

- Төрийн албан хаагчдыг авилгын эсрэг сургалтад хамруулсан
- Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс нь Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулдаг
- Байгууллага тус бүр Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар товч тайлан боловсруулдаг.

- 3) Төвлөрлийг сааруулах эрх зүйн тогтолцоо

Тухайн хоёр аймгийн хувьд төвлөрлийг сааруулахтай холбоотой тусгайлсан баримт бичиг байхгүй хэдий ч Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт зарим үйл ажиллагааг тусгасан (Хүснэгт 8.6.3).

---

<sup>9</sup> Хөвсгөл аймаг Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө, Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө, Насан туршийн боловсролын хөтөлбөрийг боловсруулсан.

<sup>10</sup> Орон нутгийн захиргааны байгууллагууд үндэсний хөтөлбөртэй нийцүүлэн орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулдаг. Саяхан Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөртэй нийцүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан.

---

### Хүснэгт 8.6.3 Булган, Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төвлөрлийг сааруулахтай холбоотой зорилтууд

Зорилт	Булган	Хөвсгөл
Цахим засаглалыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг хариуцлагатай, хүртээмжтэй, чанартай хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх.	X	X
Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах	X	X
Аймгийн ЗДТГ-ын дэргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг шинээр байгуулах	X	
Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх		X
Нутгийн өөрөө удирдах байгууллагыг дэмжиж, бүтэц зохион байгуулалтыг сайжруулж, шийдвэр гаргах үйл ажиллагаа, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.		X
Сум, багийн үйл ажиллагааг сайжруулж, бие даан хөгжих боломжийг бүрдүүлнэ		X

Эх үүсвэр: Булган, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

#### 4) Зүй зохистой засаглал

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангахад оршино. Тиймээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу засаглалын зохих арга хэмжээг орон нутгийн захиргааны байгууллагуудад хэрэгжүүлдэг. Хэдийгээр удирдлагын баг 4 жил тутам солигддог ч засаглалын гол зарчмыг хэвээр хадгалах боломжтой юм. Учир нь орон нутгийн төрийн байгууллагуудын туршлагатай төрийн албан хаагчид Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулдаг.

### 8.6.3 Бүсчилсэн хөгжлийг дэмжих чадавхыг бэхжүүлэх санал

#### (1) Бүс нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх

##### 1) Хүн ам, хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулах

Байгууллагын төлөвлөлтийн чадавхын үнэлгээний судалгаанаас харахад тухайн 2 аймгийн төрийн байгууллагууд аймгийн хөгжлийн төлөвлөгөө, хүн амын хэтийн тооцоо бүхий хотын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах чадвартай байна. Бодит байдалд ҮХГ болон бусад төрийн байгууллагууд бодлого төлөвлөлтийг боловсруулахад нь дэмжлэг үзүүлдэг. Ихэнх аймгуудад цогц бодлого боловсруулах чадавх дутмаг байгаа нь нарийн мэргэжлээр мэргэшсэн төрийн албан хаагчдын тэнцвэртэй байдлаас шалтгаалж байж болох юм. Салбар дундын удирдлага зохицуулалтыг хангах чадвартай төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлж, хүний нөөцийн бүрэлдэхүүнийг өөрчлөх боломжтой.

2) Бүс нутгийн хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Аймгуудын эдийн засгийн үйл ажиллагаа, хүн амын тоо бага байгаа тул ҮХЦТ-ний хүрээнд дэвшүүлсэн Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр зэрэг хөгжлийн хөтөлбөрийг хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан бүс нутагт тухайн нөөц баялаг, хүний нөөцөд тулгуурлан боловсруулах шаардлагатай. Мөн Засгийн Газар нь бүс нутгуудад үндсэн хөрөнгө, нөөцийг тэнцвэртэйгээр хуваарилах шаардлагатай. Бүс нутагт хамаарах аймгууд хамтран төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх нь бүтээн байгуулалтын төсвийг уялдуулах, нэгтгэхэд тус дэм болохоос гадна бүс нутаг болон аймаг хоорондын хөгжлийн ялгааг бууруулахад хувь нэмэр оруулна.

3) Төрийн үйлчилгээг хүргэх

Монгол Улс нь төвлөрсөн удирдлагатай загвараас ҮХЦТ-ний хүрээнд дэвшүүлж буй төвлөрсөн бус загвар болох нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загвар руу шилжиж хөгжих шаардлагатай. Энэхүү үзэл баримтлалын дагуу орон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтнууд зөвхөн төрийн үйлчилгээ үзүүлэхээр хязгаарлахгүйгээр идэвх чармайлт гаргаж орон нутгийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, хариу арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлж, үнэлж дүгнэх шаардлагатай. Судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдагсадын ихэнх нь орон нутгийн иргэдийн оролцоотойгоор хөгжлийн төлөвлөгөө, төсөл боловсруулах, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг үйл ажиллагааг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөөгүй байна. Тухайлбал нийгмийн халамжийн үйлчилгээний хувьд хөгжлийн төлөвлөлтийг хувийн хэвшлийн оролцоотойгоор боловсруулж, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тусгах нь илүү үр дүнтэй байх боломжтой.

**(2) Улс, орон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо**

Нийт 21 аймгаас 5 аймаг улсын төсөвт орлого төвлөрүүлдэг бол 16 аймагт улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг олгодог. Улаанбаатар хотод эдийн засгийн үйл ажиллагаа, хүн ам төвлөрсөн. Орон нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн асуудал Засгийн газраас хамааралгүй байна. Мөн сонгуулийн дараа шинэ Засгийн газар эмхлэн байгуулагдахтай холбоотой халаа сэлгээнд орон нутгийн төрийн албан хаагчид өртөх нь бага байна. Тиймээс энэ нь тухайн бүс нутаг тогтвортой хөгжих боломжийг олгоно.

Судалгаанаас үзэхэд орон нутгийн захиргааны байгууллагууд Орон нутгийн хөгжлийн сан бүрдүүлэх зэргээр ирээдүйн сайн сайхны төлөө олон нийтийн оролцуулах хүчин чармайлт гаргаж байгаа нь харагдаж байна. Орон нутгийн засаг захиргааны чухал зорилтуудын нэг нь тухайн бүс нутгийн иргэдийн амьдралд нөлөөлж буй асуудлыг хамтын хүчээр зүй зохистойгоор шийдвэрлэх замаар иргэдийн сайн сайхан байдлыг хангах явдал юм. Энэ тал дээр Засгийн газар болон орон нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг тодруулах нь зайлшгүй чухал юм.

Иргэдийн оршин сууж буй тухайн орон нутгийн засаг захиргаа нь нэр хүндтэй, ёс зүйтэй байхын сацуу төрийн үйлчилгээ үзүүлж, сайн засаглалыг бэхжүүлэх хэрэгтэй. Орон нутгийн захиргааны байгууллагууд иргэд олон нийт, оршин суугчдын холбоо, хөршүүдийн холбоодтой нягт хамтран ажиллах үүрэгтэй.

Гэвч эдгээр үйл ажиллагааг зүй зохистой хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн

захиргааны байгууллагуудын хүний нөөцийг хөгжүүлэх, системийн дизайн, хүний нөөцийн хуваарилалт, төвлөрлийг сааруулах зайлшгүй шаардлагатай бөгөөд улсын төсвөөс орон нутагт санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

### (3) Бүс нутгуудын хөгжлийн ялгааг бууруулах

#### 1) Бүс болон аймгуудын төсвийн тэнцэл

Хүснэгт 8.6.4-т үзүүлснээр аймгуудын төсвийн тэнцэл харилцан адилгүй, уялдаагүй байгаа бөгөөд ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй эдийн засгийн шинэ бүсчлэлийн дагуу төсвийн тэнцлийг сайжруулах боломжтой. Төсөв, удирдлага, нийгмийн капиталын хувьд аймаг тус бүр төвлөрсөн удирдлагаас хэт хамааралгүй байх, аймаг хоорондын хөгжлийн ялгааг бууруулах зэрэг нь хялбар бус боловч бие даасан хөгжилд хүрэх зорилгыг бүс нутгаар хэрэгжүүлбэл үр дүнд хүрч болох юм. Улсын үндсэн хөрөнгө, нөөц баялгийг дахин хуваарилж бүс нутгийн хэмжээнд үр ашигтай ашиглах боломжтой.

#### Хүснэгт 8.6.4 Монгол Улсын эдийн засгийн бүс, аймгуудын төсвийн тэнцэл

Аймаг	Орлого	Зарлага	Ашиг/Алдагдал	Хүн ам
Баруун бүс				
Баян-Өлгий	77,785.90	77,913.60	-127.7	94,994
Увс	80,456.20	79,797.10	659.1	69,187
Ховд	70,832.50	68,989.70	1,842.80	77,957
Дүн	229,074.60	226,700.40	2,374.20	242,138
Хангайн бүс				
Архангай	68702.8	67550.4	1152.4	94,994
Булган	59,919.60	60,254.30	-334.7	88,672
Дархан-Уул	77,727.30	72,723.60	5,003.70	62,089
Орхон	95,978.70	96,039.90	-61.2	135,095
Хөвсгөл	85,736.20	83,624.50	2,111.70	89,712
Сэлэнгэ	44,843.00	44,241.20	601.8	107,634
Завхан	66,287.30	66,526.20	-238.9	116,732
Дүн	499,194.90	490,960.10	8,234.80	694,928
Алтайн бүс				
Баянхонгор	76,612.40	69,878.80	6,733.60	108,530
Говь-Алтай	59,639.60	61,701.20	-2,061.60	47,104
Өвөрхангай	108,864.10	99,513.60	9,350.50	83,223
Дүн	245,116.10	231,093.60	14,022.50	238,857
Өмнөд бүс				
Говьсүмбэр	82,848.00	79,916.10	2,931.90	57,748
Дорноговь	16,527.20	16,530.90	-3.7	82,054
Дундговь	66,696.20	65,818.70	877.5	71,014
Өмнөговь	68,690.30	69,022.30	-332	94,250
Дүн	234,761.70	231,288.00	3,473.70	305,066
Зүүн бүс				
Дорнод	63,934.00	63,962.50	-28.5	107,018
Сүхбаатар	53,995.60	53,175.10	820.5	110,110
Хэнтий	65,947.80	64,532.10	1,415.70	17,928
Дүн	183,877.40	181,669.70	2,207.70	235,056
Нийслэлийн бүс				

Улаанбаатар	1,381,386.40	1,353,132.60	28,253.80	1,539,810
Төв	169,433.20	194,247.40	-24,814.20	63,182
Дүн	1,550,819.60	1,547,380.00	3,439.60	1,602,992
Бүгд	2,942,844.30	2,909,091.80	33,752.50	3,319,037

Эх үүсвэр: ҮСХ-ны 2019 оны мэдээлэлд үндэслэн ЖТБ

## 2) Хүн амын тархалт, байршил

Бүлэг 5-д тусгаснаар ҮСХ нь 2018-2030 оны хүн амын өсөлтийн хэтийн тооцоог аймгуудаар таамаглаж гаргасан. Хэтийн тооцоогоор аймгуудын хүн амын өсөлт ихээхэн ялгаатай байна. Жишээ нь Төв аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт хамгийн бага буюу -0.2% байгаа бол Говьсүмбэр аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт хамгийн өндөр буюу 1.9% байна. Алс хэтдээ хүн амын тархалт байршлын хувьд хүндрэл учирна. Хүн амын өсөлтөд тухайн аймгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэх боломж ихээхэн нөлөөлөх бөгөөд хүн амын тархалт байршлыг тэнцвэртэй болгохын тулд орон нутгийн засаг захиргаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах, тогтвортой ажлын байрыг бий болгох үүрэг хариуцлага хүлээх хэрэгтэй.

### 8.6.4 Аймгийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх

Монгол Улс нь эдийн засгийн өсөлтийг хангахын тулд социалист нийгмээс капиталист нийгэм рүү шилжих шилжилтийг амжилттай хэрэгжүүлсэн. Мөн НҮБ-ын ТХЗ-ын хүрээнд тогтвортой хөгжлийн загвараар хөгжихөөр болсон. Энэ цаг үед Монгол Улс нь нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах бүсчилсэн хөгжлийг дэмжих шаардлагатай. Энэ нь дэлхийд өрсөлдөх чадвартай, хүчирхэг, уян хатан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад хувь нэмэр оруулна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хамгийн чухал хүчин зүйл бол орон нутгийн засаг захиргааг бэхжүүлэх явдал юм. Тухайлбал аймгийн захиргааны байгууллагыг төсөв санхүү, хүний нөөцийн хувьд бэхжүүлэх шаардлагатай бөгөөд үүнийг Засгийн газрын санаачилгын хүрээнд бүс нутгийн засаглалын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх замаар үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой юм. Эдийн засгийн шинэ бүсчлэлийн дагуу бүс тус бүрээр Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, Бүсийн зөвлөлийг байгуулах нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хүснэгт 8.6.5-д үзүүлснээр аймгийн чадавхыг бэхжүүлэх хэрэгцээг мэргэжилтэн, байгууллага, институцийн түвшинд тодорхойлов.

### Хүснэгт 8.6.5 Бүсчилсэн хөгжлийг хангах чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ

	Нэр	Орон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээ	Орон нутгийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ		
			Мэргэ-жилтний түвшинд	Байгууллагын түвшинд	Хууль эрх зүй/Институцийн түвшинд
1	БХНХ боловсруулах, БЗ байгуулах зэрэг бүс	БХНХ-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх (1): Хөтөлбөрийг сайжруулж өөрчлөх	✓		
		БХНХ-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх (2): БЗ-ийг байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	✓	✓	✓

	нутгийг хөгжүүлэх арга зам	Эдийн засгийн шинэ бүсчлэлийн дагуу бүс нутаг хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх	✓	✓	
		Дэлхийн эдийн засагтай нэгдсэн заяагдмал нөөц баялагт түшиглэсэн бие даан хөгжих бүс нутаг	✓	✓	✓
2	Бүсчилсэн хөгжлийн удирдлагыг үе шаттайгаар бэхжүүлэх	Бүсчилсэн хөгжилтэй холбоотой хууль эрх зүй, институци			✓
		Бүс нутаг хоорондын хөгжлийн ялгааг (төсөв, хүний нөөц, аж үйлдвэр) бууруулах	✓	✓	✓
		Татварын тотолцоог үе шаттайгаар өөрчлөх		✓	✓
		Тодорхой бүс нутгийн хариуцлагатай, ил тод төсөв/хөрөнгө оруулалтын менежмент	✓	✓	✓
		COVID-19 болон түүнтэй төстэй хямралыг даван туулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх		✓	✓
		Сэргээгдэх эрчим хүч зэрэг эрчим хүчний заяагдмал нөөцийг ашиглах	✓	✓	
3	Аймгуудын хамтын ажиллагааны хүрээнд дижитал шилжилт, МХХТ-ийг ашиглах	Бүс нутгийн хэмжээнд буюу хэд хэдэн аймгийг хамруулан МХТ-ийн сүлжээг хөгжүүлэх	✓	✓	
		Орон нутгийн мэдээллийн платформыг байгуулах	✓	✓	
		Бүс нутгийн төв хэсэгт МХТ-ийн үйлдвэрлэлийг байгуулах	✓	✓	✓
		Өгөгдөл хуваалцах тогтолцоо болон Аппликейшн програмчлалын интерфейс хөгжүүлэх	✓	✓	
4	Олон нийтийн оролцоотой хөгжил	Нийтийн зориулалттай дэд бүтэц, ногоон байгууламжийн төлөвлөлт хийх	✓		✓
		Нийтийн зориулалттай дэд бүтэц, ногоон байгууламжийг байгуулах	✓	✓	
		Орон нутгийн захиргааны байгууллага/иргэд байгаль орчны мониторинг хийх	✓	✓	
		Нутгийн уугуул иргэд орон нутгийн заяагдмал нөөц баялгийн ашиглалтыг хянах	✓	✓	
5	Төвлөрлийг сааруулах	Төвлөрлийг сааруулах зорилгоор холбогдох хулиудыг боловсруулах		✓	✓
		Орон нутгийн засаг захиргааны санаачилгаар дэд бүтцийг барьж байгуулах	✓	✓	✓
		Орон нутгийн засаг захиргааны санаачилгаар барьж байгуулсан дэд бүтцийн ашиглалт, засвар үйлчилгээ хийх	✓	✓	
		Орон нутгийн засаг захиргааны санаачилсан ТХХТ зэрэг институцийг хөгжүүлэх	✓	✓	✓
		Сэргээгдэх эрчим хүч зэрэг эрчим хүчний заяагдмал нөөцийг ашиглах	✓	✓	

Эх сурвалж: ЖТБ

## **Бүлэг 9 Төлөвлөлтийн хувилбарын аргачлал болон төслийн эхний үнэлгээний Байгаль орчны стратегийн үнэлгээ**

Энэхүү бүлэгт Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан Байгаль орчны стратегийн үнэлгээний (БОСҮ) үр дүнг тусгав. Байгаль орчны стратегийн үнэлгээг Монгол Улсын институцийн хүрээнд хэрэгжүүлэхдээ оролцогч талуудын үзэл бодол, саналыг тусгах зорилгоор төлөвлөлтийн хувилбарын (scenario planning) аргыг ашигласан. Бүлэг 9-ийн 1 дүгээр хэсэгт ҮХЦТ-ний Байгаль орчны стратегийн үнэлгээг боловсруулахдаа ашигласан төлөвлөлтийн хувилбарууд, Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэхэд баримтлах зарчим, Монгол Улсын институцийн хүрээнд БОСҮ-г хэрэгжүүлэх тухай тайлбарлах бөгөөд төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны талаар тусгана. Бүлэг 9-ийн 2 дугаар хэсэгт ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй төслүүдийн эхний үнэлгээний аргачлал болон гол төсөл хөтөлбөрүүдийн үнэлгээний үр дүнгийн талаар нэгтгэн оруулсан. Бүлэг 9-ийн 3 дугаар хэсэгт ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй гол төсөл хөтөлбөрүүдийн байгаль орчны урьдчилсан үнэлгээний талаар тусгав. Энэхүү бүлэгт Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, аргачлал, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй тусгасан тул Үндсэн тайлан болон Салбарын тайлангуудад тусгагдсан зарим агуулга давтагдсан болно.

### **9.1 Төлөвлөлтийн хувилбарын аргачлалын хүрээнд Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх**

#### **9.1.1 Төлөвлөлтийн хувилбарын үзэл баримтлал, аргачлал**

Төлөвлөлтийн хувилбарын аргачлалыг урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад ашигладаг бөгөөд аль ч салбарт хэрэглэх боломжтой. Дасан зохицох чадвартай цэргийн тагнуулын стратеги төлөвлөлт болон түүний аргачлалыг нэгтгэх замаар үүссэн гэж үздэг. Төлөвлөлтийн хувилбарын аргачлалыг ихэвчлэн ашигт малтмал эсвэл газрын тосны хайгуул зэрэг тодорхойгүй үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлтөд ашигладаг. Аливаа улс, бүс нутаг, компанийн урт хугацааны үйл ажиллагааны үр дүн, шийдвэрт тодорхойгүй байдал нөлөөлөх тохиолдолд оролцогч талуудын хамтын ирээдүйн төлөө зөвшилцлийг бий болгохын тулд төлөвлөлтийн хувилбарын аргачлалыг ашигладаг. Ирээдүйд нөлөөлөх гадны хүчин зүйлсийг хэрхэн тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авах талаар оролцогч талуудын сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй.

Төлөвлөлтийн хувилбарыг ерөнхийд нь дасан зохицох төлөвлөлтийн хувилбар болон хувиран өөрчлөгдөх төлөвлөлтийн хувилбар гэж ангилж болох юм. Эхнийхийг нь ихэвчлэн цэргийн тагнуулын стратегийн төлөвлөлтөд ашигладаг. Урт хугацааны хөгжлийн төлөвлөлтийг боловсруулахад ашигладаг төлөвлөлтийн хувилбарын аргачлал нь ихэвчлэн хувиран өөрчлөгдөх төлөвлөлтийн хувилбарт хамаардаг (Adam Kahen, “Transformative Scenario Planning,” 2012). Ялангуяа



хөгжингүй болон хөгжиж буй улс орны бүс нутгийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн хүрээнд нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хувьд төрөл бүрийн бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай болдог. Энэ нь хөгжлийн шинэ загвараар хөгжих шаардлагатайг харуулж байгаа бөгөөд үүнд гадны төрөл бүрийн нөхцөл байдлыг урьдчилан тооцож, хэрэгжүүлэх төлөвлөлтийн хувилбаруудын талаар оролцогч талууд зөвшилцөлд хүрэх шаардлагатай.


ҮХЦТ-ний хүрээнд төлөвлөлтийн хувилбарын аргачлалын дагуу хөгжлийн шинэ загвараар хөгжих саналыг дэвшүүлсэн. Төлөвлөлтийн шийдлийг ард түмэн, оролцогч талуудын оролцоогүйгээр ихэвчлэн Засгийн газар нь гаргадаг хуучин социалист дэглэмтэй байсан улс орнуудын хувьд төлөвлөлтийн хувилбарыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг. Тиймээс төлөвлөлтийн хувилбарын аргачлалыг өөрчилж ашигласан болно.

### **9.1.2 Төслийн төлөвлөлтийн хувилбарын аргачлал**

Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийг Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхээр хэрэгжүүлж байна. Төслийг ЖАЙКА-гийн Төслийн баг нь Монгол Улсын хамтран ажиллагч байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, хэрэгжүүлнэ. Монгол Улсын хамтран ажиллагч гол байгууллагууд нь Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг (ХАНСХЕТ) хариуцан ажиллаж буй Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) болон Бүсчилсэн хөгжлийн бодлого (БХБ) боловсруулах ажлыг хариуцаж буй Үндэсний Хөгжлийн Газар (ҮХГ) болно. Төслийн Хамтарсан зохицуулах хороо нь төслийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх бөгөөд ТХЗХ-ны даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, дэд даргаар БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, ҮХГ-ын дарга, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн Газрын дарга нар тус тус ажиллана. 2018 оны 8 дугаар сарын 22-нд Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-гийн төлөөлөл харилцан тохиролцож, гарын үсэг зурсан Хэлэлцүүлгийн тэмдэглэлд төслийн Хамтарсан зохицуулах хорооны гишүүдийн нэрсийг оруулсан.

ЖАЙКА-гийн Төслийн багтай өдөр тутамд хамтран ажиллах Монголын талын хамтран ажиллагч байгууллагаар ТХЗХ-ны удирдлаган дор Төслийн Ажлын хэсэг (ТАХ) байгуулагдсан (Зураг 9.1.1). ТАХ-ийн бүрэлдэхүүнд хамтран ажиллагч гол байгууллагууд болох БХБЯ, ҮХГ болон Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгагдсан бусад холбогдох яам, агентлагуудын төлөөлөл багтана. Өдөр тутам нягт хамтран ажиллахын тулд ТАХ нь дэд ажлын хэсгүүдэд хуваагдаж үйл ажиллагаагаа явуулна. Үүнд: 1) хөдөө аж ахуй болон мал аж ахуй, 2) аж үйлдвэр, 3) байгаль орчин, аялал жуулчлал, 4) нийгмийн салбар 5) хотын дэд бүтэц болон зам тээврийн дэд бүтэц зэрэг болно. Эдгээр дэд ажлын хэсгүүд нь хуралд оролцогчдод чөлөөтэй, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.


### Зураг 9.1.1 Төслийн Хамтарсан зохицуулах хороо, Дэд ажлын хэсэг бүхий төслийн хэрэгжилт болон удирдлагын бүтэц



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

ҮХЦТ боловсруулахдаа оролцогч талуудын үзэл бодол, саналыг тусгах зорилгоор төлөвлөлтийн хувилбарын (scenario planning) аргачлалыг ашигласан. Дээр дурдсанаар төлөвлөлтийн хувилбарын аргачлал нь оролцогч талууд хөгжлийн хэтийн төлвийн талаар зөвшилцөлд хүрэхэд чиглэсэн олон нийтийн оролцоотой төлөвлөлтийн үйл явц юм. ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан төлөвлөлтийн хувилбарын үйл явцыг Зураг 9.1.2-т үзүүлэв. Төслийн Хамтарсан зохицуулах хороо, Ажлын хэсэг, дэд Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанаас гадна ҮХЦТ-г боловсруулах явцад Оролцогч талуудын нэгдсэн хурлуудыг зохион байгуулсан.

### Зураг 9.1.2 ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан төлөвлөлтийн хувилбарын үйл явц



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### 9.1.3 Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ)

#### (1) Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэхэд баримтлах зарчим

Байгаль орчны стратегийн үнэлгээг (БОСҮ) Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хамруулан

улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчинд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллийг тодорхойлох зорилгоор хийдэг. Байгаль орчны стратегийн үнэлгээг бодлого болон ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын эхний үе шатнаас эхлэн хийж гүйцэтгэдэг.

БОСҮ нь байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй орон зайн болон түр зуурын эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг өргөн хүрээнд үнэлдэг бол төслийн хүрээнд хийх байгаль орчны үнэлгээ нь ихэвчлэн түр зуурын үр нөлөөг үнэлнэ. Өөрөөр хэлбэл БОСҮ нь томоохон газар нутгийг хамруулан урт хугацааны, дунд болон богино хугацааны нөлөөллийг үнэлдэг. Мөн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах явцад нөлөөлөлд өртөж болзошгүй бүхий л салбар, асуудлыг хамруулан өргөн хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд хуримтлагдсан, цогц нөлөөллүүдэд үнэлгээ хийдэг юм.

Эцэст нь дүгнэхэд БОСҮ нь байгаль орчны асуудлуудыг иж бүрнээр авч үзэн, байгаль орчны хөгжлийн үр өгөөжтэй төлөвлөлтийг хийдэг. Эдийн засгийн өсөлтийг хангах бүтээн байгуулалтыг чухалчлан байгаль орчин, нийгмийн асуудлыг орхигдуулдаг. Харин Байгаль орчны стратегийн үнэлгээ нь бүтээн байгуулалтаас илүүтэй байгаль орчин, нийгмийн асуудлыг эн тэргүүнд авч үздэг.

Энэхүү бүх нөхцөлүүдийг үр дүнтэй хангах үүднээс БОСҮ-г хөгжлийн үйл ажиллагааны эхэн үеэс эхлэн оролцогч талуудыг өргөн цар хүрээтэйгээр оролцуулах замаар хэрэгжүүлнэ. Үүнийг (1) Оролцогч талуудын нэгдсэн хурал (2) холбогдох мэдээллүүдийг хуваалцах арга замаар хэрэгжүүлнэ.

Өндөр мэдлэг, туршлагатай мэргэжилтнүүд ч томоохон нутаг дэвсгэрийн байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг урт хугацаанд бүхий л салбар, асуудлыг хамруулан тодорхойлж чадахгүй тул оролцогч талуудын оролцоо чухал юм. Томоохон бүтээн байгуулалтын урт хугацаанд үзүүлэх нөлөөллийг харгалзан шийдвэр гаргахад оролцогч талуудыг олноор оролцуулах зайлшгүй шаардлагатай. Энэхүү шийдвэрийг хөгжлийн бодлого, хөгжлийн чиглэлээс хамааруулан гаргадаг.

БОСҮ-ний хүрээнд хийгдэх үйл ажиллагаанд нөөц бололцоо, цаг хугацаа, хүний нөөц хангалттай хүрэлцэхгүй тул прагматик арга, хандлагыг ашиглах хэрэгтэй. Бүтээн байгуулалтын эхний үе шатанд оролцогч талуудын хурал, уулзалтыг зохион байгуулж, нэгдүгээрт бүтээн байгуулалтай холбоотой бүхий л асуудлуудыг тодорхойлж, хоёрдугаарт нэн тэргүүний ноцтой асуудлыг тодруулж, эрэмбэлэх шаардлагатай. Оролцогч талуудын хурал, уулзалт нь мэдлэг, мэдээллийг хуваалцах зорилготой. Байгаль орчинд тулгарах ноцтой, нэн тэргүүний асуудлуудыг хамтран тодорхойлох нь бүтээн байгуулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгоход шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлох прагматик арга юм.

Байгаль орчинд тулгарах ноцтой, нэн тэргүүний асуудлуудад үндэслэн бүтээн байгуулалттай холбоотой байгаль орчныг хамгаалах зорилтыг оролцогч талуудын оролцоотойгоор тодорхойлно. Хөгжлийн шинэ бодлого, хөтөлбөр нь хоорондоо харилцан хамааралтай олон зорилготой байдаг. Энэхүү үе шатанд зөвхөн эдийн засгийн асуудлаар хязгаарлагдахгүйгээр хэтийн төлвийг өргөн цар хүрээнд харах нь хамгаас чухал юм. Бүтээн байгуулалтаас үүдэх сөрөг нөлөөллийг тодорхойлж тусгах үр дүнтэй, прагматик арга бол байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг тодорхойлох явдал юм.

БОСҮ-г бүсийн хөгжлийн төсөлтэй зэрэгцүүлэн хийдэггүй. Энэ нь бүсийн

хөгжлийн төслийн салшгүй хэсэг юм. БОСҮ-ний хүрээнд хийгддэг оролцогч талуудын хурал уулзалт, мэдээлэл солилцоо нь бүсийн хөгжлийн төслийн барим бичгийг боловсруулахад зайлшгүй шаардлагатай нөхцөл юм.

## **(2) ҮХЦТ, ХАНСХЕТ, БХБ-ын хүрээнд боловсруулах Байгаль орчны стратегийн үнэлгээ**

ҮХЦТ нь хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө тул Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай. Монгол Улсад Байгаль орчин, аялал жуулчлалын яамны боловсруулсан Байгаль орчны стратегийн үнэлгээтэй холбогдолтой дараах хууль, дүрмүүд үйлчилж байна. Үүнд: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 он); Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам (2014 он); Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх аргачлал (2013 он) зэрэг болно. Байгаль орчны стратегийн үнэлгээг тухайн асуудлыг хариуцсан салбарын яам нь санаачлан, БОАЖЯ-аас эрх авсан мэргэжлийн байгууллага, тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, бие даасан шинжээч, мэргэжилтнүүдийн багийн оролцоотойгоор боловсруулна.

БХБЯ-наас боловсруулж буй Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл (ХАНСХЕТ) болон ҮХГ-аас боловсруулж буй Бүсчилсэн хөгжлийн бодлогын (БХБ) баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор ҮХЦТ-г боловсруулж байна. ҮХЦТ нь хууль тогтоомжид томъёологдоогүй бөгөөд БОСҮ-г хэрэглэх хууль, эрх зүйн үндэс нь өндөр бус юм. Нөгөө талаар ЖАЙКА болон Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгаснаар ЖАЙКА-гийн “Байгаль орчин ба нийгмийн асуудлуудын удирдамж”-ийн (2010 он) дагуу Байгаль орчны стратегийн үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

ХАНСХЕТ болон БХБ-ын хүрээнд Байгаль орчны стратегийн үнэлгээг хийхэд мөрдөх Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 он) болон ЖАЙКА-гийн “Байгаль орчин ба нийгмийн асуудлуудын удирдамж”-ийн (2010 он) ижил төстэй заалтууд:

- (a) Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэх,
- (b) Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг сайжруулан боловсруулах, оролцогч талуудын холбогдох асуудлууд, тэргүүлэх чиглэлийг шийдвэрлэх үүднээс талуудыг татан оролцуулах,
- (c) Нөлөөллийн үнэлгээний ерөнхий үйл явц, дараалал,
- (d) БОСҮ-ний ерөнхий агуулга.

Хүснэгт 9.1.1-д Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон ЖАЙКА-гийн Хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх ялгааг нэгтгэн үзүүлэв.

### Хүснэгт 9.1.1 БОСҮ-ний тухай Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журам болон ЖАЙКА-гийн удирдамж хоорондын харьцуулалт

ЖАЙКА-гийн удирдамж / Хэлэлцүүлгийн тэмдэглэл / Төслийн Эхлэлийн тайлан	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 он)
1) Хууль тогтоомжид томъёологдоогүй	1) БОАЖЯ-наас эрх авсан хууль ёсны үйл ажиллагаа
2) Албан болон албан бус хоёр баримт бичигт ашиглах боломжтой ҮХЦТ: Ашиглах боломжтой боловч Монгол Улсын холбогдох хуулийн дагуу боломжгүй	2) Улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахад ашиглана ҮХЦТ: Хууль тогтоомжид томъёологдоогүй тул ашиглахгүй ХАНСХЕТ/БХБ: Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмын дагуу хэрэгжүүлнэ
3) БОСҮ-г БХБЯ, ҮХГ, ЖАЙКА-гийн Төслийн багийн хариуцсан зөвлөх, мэргэжилтнүүд боловсруулна	3) БОАЖЯ-аас эрх авсан мэргэжлийн байгууллага, тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, бие даасан шинжээч, мэргэжилтнүүдийн багийн оролцоотойгоор боловсруулах бөгөөд БОАЖЯ-наас мэргэжлийн удирдлагаар хангана => Эрх бүхий зөвлөх ажиллуулах нь өндөр өртөгтэй
4) Уян хатан аргачлал хэрэглэх боломжтой бөгөөд БХБЯ, ҮХГ болон ЖАЙКА-гийн Төслийн багийн хариуцсан зөвлөх, мэргэжилтнүүд тодорхойлно	4) Эрх бүхий мэргэжлийн байгууллага тайлангийн төслийг боловсруулна Тайланг БОАЖЯ-нд ирүүлж, Мэргэжлийн Зөвлөлөөр хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулна
5) БОСҮ-г i) төлөвлөлтийн хувилбарт (зөвхөн хөгжлийн концепц) мөн ii) эхний хөтөлбөр, төсөл сонгоход ашиглана	5) Баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Монгол талын хамтран ажиллагч байгууллагуудтай хэлэлцсэний үндсэн дээр ЖАЙКА-гийн Төслийн баг нь Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгасны дагуу Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэнэ. ХАНСХЕТ ба БХБ боловсруулах ажлын хүрээнд Байгаль орчны стратегийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэхээр шийдвэрлэвэл ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан БОСҮ-г ашиглах боломжтой.

### (3) ҮХЦТ-ний хүрээний БОСҮ

Дээр дурдсанаар ЖАЙКА-гийн төслийн хүрээнд бүсийн хөгжлийн төслийн адилаар олон салбарыг хамарсан орон зайн хөгжлийн төлөвлөлт хийх тул ҮХЦТ боловсруулахад Байгаль орчны стратегийн үнэлгээг хийж гүйцэтгэнэ. ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан төлөвлөлтийн хувилбарын аргачлалыг хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, хөгжлийн загвар, хөгжлийн хувилбаруудыг боловсруулах, үнэлэхэд ашигласан. ҮХЦТ-ний хүрээнд боловсруулж буй Байгаль орчны стратегийн үнэлгээ нь төлөвлөлтийн эхний үе шатанд холбогдох мэдээллийг хуваалцаж, оролцогч талуудын оролцоог хангадгаараа төлөвлөлтийн хувилбарын аргачлалтай ижил төстэй юм.

2019 оны 1 дүгээр сарын 15-нд зохион байгуулсан семинарын үеэр төлөвлөлтийн хувилбаруудын талаар тайлбарласан. Үүнд:

- (a) Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд хөгжлийн алсын хараа, хөгжлийн хувилбар, хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийх замаар тодорхойлох,
- (b) Оролцогч талуудын дэмжлэгтэйгээр хэрэгжих боломжтой ҮХЦТ-г боловсруулахад хувь нэмэр оруулах.

Мөн семинарын үеэр оролцогч талуудын хурлын талаар тохиролцсон. Үүнд:

- (a) Хуралд төслийн Ажлын хэсгийн бүх гишүүд оролцоно;
- (b) Төслийн хэрэгжилтийн үе шатуудад ЖАЙКА-гийн Төслийн багаас зохион байгуулах төрөл бүрийн сэдэвт хэлэлцүүлэгт Төслийн 5 дэд Ажлын хэсгийн гишүүд оролцоно;
- (c) Төслийн 5 дэд Ажлын хэсгийн гишүүд болон тухайн сэдвээс хамааран холбогдох мэргэжилтнүүдийг урьж оролцуулан Оролцогч талуудын нэгдсэн хурлыг зохион байгуулж, тодорхой сэдвээр ярилцлага өрнүүлнэ.

2019 оны 1 дүгээр сарын 18-нд зохион байгуулсан ТХЗХ-ны хурал болон хамтран ажиллагч байгууллагуудтай хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр ҮХЦТ-ний хүрээнд төлөвлөлтийн хувилбарын аргачлалд дараах асуудлуудыг тусган өөрчилсөн. Үүнд:

- (a) 1990 он хүртэлх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үр нөлөөгөөр доороос дээш чиглэсэн буюу олон нийтийн оролцоотой төлөвлөлтийн хувилбар нь Монгол Улсын хувьд шинэлэг арга юм;
- (b) Монголын талын хамтран ажиллагч байгууллагын мэргэжилтнүүд доороос дээш чиглэсэн төлөвлөлтийн аргачлалыг сонирхож байгаагаа илэрхийлсэн;
- (c) БХБЯ нь салбарын асуудал хариуцсан яам тул Монгол Улсыг бүхэлд нь хамарсан үндэсний хэмжээний (бүхий л салбар) төлөвлөгөө боловсруулах хууль эрх зүйн үндэслэл байгаа эсэхэд эргэлзэж байсан.

Тиймээс ЖАЙКА-гийн Төслийн баг хамтран ажиллагч байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдтэй төслийн үйл ажиллагааг хамтран хэлэлцсэний дараа бусад оролцогч талуудтай хэлэлцэхээр тохиролцов. Төслийн хүрээнд боловсруулах төлөвлөлтийн хувилбарын аргачлалын Байгаль орчны стратегийн үнэлгээний үйл явцыг доор дурдав.

#### **9.1.4 Ажлын хэсэг, дэд Ажлын хэсгийн гишүүдийн оролцоотой төлөвлөлт**

##### **(1) Хөгжлийн чиг хандлага болон хөгжлийн хувилбарууд**

###### Өнөөгийн нөхцөл байдал, макро түвшний хөгжлийн зорилт, үндсэн стратеги

Ажлын хэсэг болон дэд Ажлын хэсгийн гишүүдийн хурал, холбогдох төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтууд, мэдээлэлд үндэслэн салбаруудын өнөөгийн байдлын дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг нь эдгээрт үндэслэн олон асуудлуудын харилцан хамаарлыг тодруулж, асуудлын бүтцийн диаграмыг байгуулсан. Асуудлын бүтцийн дүн шинжилгээ нь ҮХЦТ-ний хүрээнд шийдвэрлэх илүү чухал асуудлын феномен болон олон тооны харилцан

хамааралтай асуудлуудын үндэс болсон хүчин зүйлсийг тодорхой болгоно. Асуудлын бүтцийн шинжилгээнд үндэслэн макро түвшний хөгжлийн зорилтыг асуудлын феноменыг харгалзан тодорхойлох бол эдийн засаг, байгаль орчин, институци зэрэг бүрэлдэхүүн хэсэг бүхий үндсэн стратегийг асуудлын хүчин зүйлсийг харгалзан тодорхойлно.

Аргачлалын талаарх хэлэлцүүлэгт зориулан ЖАЙКА-гийн Төслийн баг “Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах аргачлал” хэлэлцүүлгийн материалыг боловсруулсан (2019 оны 1 дүгээр сарын 29). Удаа дараагийн хэлэлцүүлгийн үр дүнд макро түвшний хөгжлийн зорилтыг бага зэрэг өөрчлөн дараах байдлаар томъёолов. Үүнд:

- (a) Хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн бүтэц, экспортын бараа, бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх (эдийн засгийн зорилт);
- (b) Ядуурал, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдлыг бууруулахын тулд хөдөө, орон нутагт үр өгөөжтэй, тогтвортой ажлын байрыг бий болгох (нийгмийн зорилт);
- (c) Улаанбаатар хотын эдийн засаг, хүн амын хэт төвлөрлийг сааруулж, хотын байгаль орчинтой холбоотой асуудлуудыг шийдвэрлэх (байгаль орчны зорилт).

Түүний ижил үндсэн стратегийг бага зэрэг өөрчилж, доор дурдсанаар тодорхойлов. Үүнд:

1) Эдийн засгийн стратеги

- (a) Үр ашигтай анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд байгалийн баялгийг үр дүнтэй, ухаалгаар ашиглах;
- (b) Экспортын анхдагч бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгох.

2) Орон зайн хөгжлийн стратеги

- (a) Дэлхийн зах зээлд гарахын тулд хөрш орнуудын байршлын онцлог байдлыг ашиглах;
- (b) Ногоон хөгжлийг хангахын тулд усны нөөцийг хөгжүүлэх, нөөцийн менежмент хийх.

3) Институцийн стратеги

- (a) Хөгжлийн удирдлагын тогтолцооны төвлөрлийг тасралтгүйгээр сааруулж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх.

4) Үйлдвэрлэлийн кластерын хөгжлийн стратеги

- (a) Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үр ашигтай дэд бүтцийн хөгжлийг хангахын тулд анхан шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тулгуурласан үйлдвэрлэлийн босоо кластеруудыг хөгжүүлэх.

Хөгжлийн чиг хандлага, хөгжлийн хувилбарууд

Ирэх хэдэн арван жилд Монгол Улсын дагаж мөрдөх хөгжлийн чиг хандлагын талаар хэлэлцүүлэг өрнүүлэхийн тулд ЖАЙКА-гийн Төслийн баг хөгжлийн 2



ялгаатай загварыг танилцуулсан. Бүсчилсэн хөгжлийн загвар нь байгалийн нөөц баялаг (заяагдмал эсвэл импортын) болон зах зээлийг (дотоод эсвэл экспортын) нэгтгэх замаар өргөн цар хүрээтэй хөгжлийн хувилбаруудыг тодорхойлдог. Семинарт оролцогчид ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй хөгжлийн загвар болох нутгийн заяагдмал нөөц баялгийг экспортын зах зээлтэй хослуулсан экспортыг дэмжих хувилбарыг сонгосон.

ЖАЙКА-гийн Төслийн баг нийгэм, эдийн засгийн хөгжлийн алтернатив загвар хэмээх хөгжлийн шинэ загварыг нөөц баялгийг зүй бусаар хэтрүүлэн ашиглаж, эдийн засгийн үр ашигт чиглэсэн 20 дугаар зууны хөгжлийн загвартай харьцуулан тайлбарласан. 20-р зууны хөгжлийн загвар нь нөөц баялгийг орлого эсвэл хурдан ашиг өгөх зүйл гэж үздэг. Энэ нь шатах ашигт малтмал болон бусад газрын доорхи нөөц баялаг бөгөөд одоогийн байдлаар Монгол Улсад эдгээрийг ашиглаж байна. Тус үзэл бодол нь нөөц баялгийг хэтрүүлэн ашиглах байдлыг дэмжих хандлагатай байдаг. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбар нь нөөц баялгийг хөгжлийн үндэс суурь болох хөрөнгө хэмээн үздэг. Тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор хөрөнгийг аль болох хадгалан, хамгаалах шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэх явцад эдгээр хөгжлийн загварын алийг сонгох талаар олон удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

ЖАЙКА-гийн Төслийн баг хөгжлийн хувилбарын талаарх хэлэлцүүлэгт зориулан “Монгол Улсын макро түвшний хөгжлийн хувилбаруудын урьдчилсан дүн шинжилгээ” хэлэлцүүлгийн материалыг боловсруулсан (2019 оны 2 дугаар сарын 14). Энэхүү материалд ЖТБ нь Монгол Улсын макро эдийн засгийн дүн шинжилгээнд үндэслэн ДНБ-ий өсөлтийн чиг хандлагыг 3 хувилбараар тооцож тусгасан. Эдгээр хувилбаруудыг ДНБ-ий өсөлт, ажил эрхлэлт, хотжилт, хүн амын байршил, нийгэм, байгаль орчин, хөгжлийн менежмент зэрэг үзүүлэлтээр харьцуулсан.

Семинарт оролцогчид дараах асуултын дагуу хэлэлцүүлэг өрнүүлэв. Үүнд:

- (a) Уул уурхайн салбараас хамааралтай хөгжлөөр замнах нь зөв үү? Үргэлжлүүлэх хэрэгтэй юу? Энэхүү хөгжлийн замаар замнаснаар ямар үр дагавар гарах вэ?
- (b) Уул уурхайн салбарт хэт найдалгүйгээр эдийн засгийн өндөр өсөлтийг хангаж чадах уу?
- (c) Уул уурхайн салбараас бусад ямар салбар эдийн засгийн өсөлтийг хангах боломжтой вэ?

Семинарт оролцогчид уул уурхайн салбараас хэт хамааралтай эдийн засгийн өсөлтийг бий болгох нь нийгэм, байгаль орчны доройтолд хүргэх тул бусад салбарыг хөгжүүлэх шаардлагатай талаар санал нэгдэв. Зарим оролцогчид транзит тээврийн чиг баримжаатай хөгжлийг харгалзан үзэхийг санал болгов. Эдгээр саналуудыг тусгасан макро түвшний хөгжлийн 4 хувилбарыг судалж, хувилбар тус бүрээр салбарын өсөлтийн хэтийн тооцоог хийж Хүснэгт 9.1.2-т үзүүлэв.

### Хүснэгт 9.1.2 Макро түвшний хөгжлийн хувилбарууд

Хувилбар	Тодорхойлолт
A. Уул уурхайд түшиглэсэн хөгжил	Эдийн засаг болон экспортын өсөлтийг дэмжих уул уурхайн салбарт үргэлжлүүлэн түшиглэх бөгөөд уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт нэн бага байна.
B. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил	Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл нь хөгжлийн гол хөдөлгөгч хүч болно.
C. Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил	Үйлчилгээний салбарын өндөр өсөлтийг хангах Монгол Улсын транзит тээвэр нь хөгжлийн өөр нэг хөдөлгөгч хүч болно.
D. Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил	Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл болон транзит тээвэр нь эдийн засгийн өндөр өсөлтийг хангана.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

ЖАЙКА-гийн Төслийн баг нь хот, тосгон, бусад суурины хүн амын өсөлтийн чиг хандлага, хэтийн тооцоо болон одоо байгаа авто зам дагуу эдийн засгийн коридорыг хөгжүүлэх боломжид дүн шинжилгээ хийж танилцуулсан. Эдийн засгийн коридоруудыг хөгжүүлэх боломж нь Улаанбаатар хотоос алслагдсан байдлаас ихээхэн хамаарах бөгөөд Улаанбаатар хотоор дайран өнгөрөх хойд-өмнөд коридор нь бусад коридоруудтай харьцуулахад хөгжих ирээдүйтэй байгаа талаар хэлэлцсэн. Түүнчлэн Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувийг 3 хувилбараар тооцож үзүүлсэн. Семинарт оролцогчдын ихэнх нь Монгол Улс бие даан хөгжихөд Улаанбаатар хотын хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны төвлөрөл зайлшгүй шаардлагатай гэдэгтэй санал нэгдлээ. Улаанбаатар хотын тэргүүлэх байр суурийг хэвээр хадгалж, цаашид Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувийг 46% байхаар тохиролцов.

#### (2) Хөгжлийн хувилбаруудын харьцуулалт

Оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлгээр тодорхойлсон 4 хувилбарыг ЖАЙКА-гийн Төслийн баг үнэлэв. Үр дүнг Хүснэгт 9.1.3-т нэгтгэн үзүүлэв. Түүнчлэн хувилбаруудыг хүн ам, эдийн засгийн өсөлтөөс гадна байгаль орчны асуудлуудын хүрээнд харьцуулалт хийсэн.

### Хүснэгт 9.1.3 Макро түвшний хөгжлийн хувилбаруудын үнэлгээ

Үзүүлэлт	A: Уул уурхайд түшиглэсэн хөгжил	B: Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил	C: Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил	D: Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил
Хүн ам, 2030 оноор, мянган хүн	3,740			
Эдийн засгийн өсөлт, ж.д %			6.7	7.1
Нэг хүнд ногдох ДНБ, 2030 оноор, мянган төгрөг			17,933	18,848
Хөдөлмөр эрхлэлт, мянган хүн	1,562	1,559	1,556	1,555
Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өсөлт	7.0	9.4	7.6	9.4

Үйлчилгээний салбарын өсөлт	7.5	7.5	8.0	8.3
Газар болон усны нөөц	-Уул уурхайн үйл ажиллагааны улмаас газрын доройтол ихсэж, нутгийн өмнөд хэсгээр усны хомсдол үүснэ.	-Зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагааны улмаас хөрс, усны бохирдол үүснэ.	-Газар болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага байна.	-Зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагааны улмаас хөрс, усны бохирдол бага зэрэг үүснэ
Агаарын бохирдол	-Ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын бохирдол ихэснэ.	- Зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагааны улмаас хөрсний бохирдол үүснэ.	- Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага байна.	- Зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагааны улмаас агаарын бохирдол бага зэрэг үүснэ.
Биологийн олон янз байдал	-Уул уурхайн олборлолтоос шалтгаалан бэлчээрийн ургамалжилттай холбоотой биологийн олон янз байдал алдагдана.	-Зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагааны улмаас хөрс, ус, агаарын бохирдол үүснэ.	-Худалдааны коридор, аялал жуулчлалын гол бүс нутагт биологийн олон янз байдал алдагдана.	-Үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлалын үйл ажиллагааны улмаас биологийн олон янз байдал бага зэрэг алдагдана.
Хог хаягдлын менежмент	-Уул уурхайн боловсруулалтаас үүсэх хаягдлыг дахин боловсруулах, уурхайн ашиглагдсан талбайг нөхөн сэргээх шаардлагатай.	-Хөрс, ус, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор зарим үйлдвэрийн хог хаягдлыг боловсруулна.	-Худалдааны коридор, аялал жуулчлалын гол бүс нутагт хог хаягдал ил задгай хаяхаас сэргийлэх шаардлагатай.	-Аж үйлдвэр, худалдаа, аялал жуулчлалын үйл ажиллагаанаас шалтгаалан сайн менежмент шаардлагатай.
Уур амьсгалын нөлөө	-Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах зорилгоор уурхайн эдэлбэр газрыг усжуулна.	-Аж үйлдвэрийн усны хэрэглээ нэмэгдсэнээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг нэмэгдүүлнэ.	-Харьцангуй бага нөлөөлөл үзүүлнэ.	-Усыг зөв зохистой,үр ашигтай хэрэглэж хэвшүүлэх шаардлагатай.
Хотын орчин	-Улаанбаатар хотын хэт төвлөрлөөс үүдэн хотын байгаль орчин доройтно.	- Орон нутгийн хотуудад байгаль орчны асуудлууд үүснэ.	- Улаанбаатар хотын байгаль орчин доройтож болзошгүй. - Орон нутгийн хотуудад байгаль орчны асуудлууд үүснэ.	- Улаанбаатар хотын байгаль орчин доройтож болзошгүй. - Орон нутгийн хотуудад байгаль орчны асуудлууд үүснэ.
Нийгмийн орчин	- Хөдөө, орон нутагт ажлын байр хязгаарлагдмал байгаагаас үүдэлтэй хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа ихэснэ. - Иргэд гадаад улсад ажиллаж, амьдрах болсны улмаас нийгмийн болон гэр бүлийн харилцаа муудна.	- Орон нутгийн хотуудад ажлын байр нэмэгдсэнээр хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа багасна. - Орон нутгийн хотууд болон хөдөө орон нутагт бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, мал аж ахуй эрхлэлт нэмэгдсэнээр нийгмийн болон гэр бүлийн харилцаа сайжирна.	- С Ихэвчлэн дэд бүтцийн гол тэнхлэгийн дагуу хүн ам төвлөрч буйгаас үүдэлтэй хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал үргэлжилнэ. - Орон нутагт хотжилт, үйлчилгээний чиг баримжаатай хөгжлөөс үүдсэн нийгмийн асуудлууд тулгарна.	- Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа багасна. - Хөдөө орон нутагт анхан шатны бүтээгдэхүүний боловсруулалттай холбоотойгоор ажлын байр нэмэгдэж, нийгмийн болон гэр бүлийн харилцаа сайжирна. - Гадаад улс орноос шилжин ирэгсэдтэй холбоотойгоор нийгмийн асуудал үүсч болзошгүй.

Байгаль орчны менежмент	<ul style="list-style-type: none"> <li>- Нийгэм, байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх менежментийг сайжруулах шаардлага үүснэ.</li> <li>- Капиталын хязгаарлагдмал хуримтлалаас үүдсэн хөгжлийн менежментийн хүндрэл үүснэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бүтээгдэхүүн хөгжүүлэх боловсруулах үйлдвэрийг технологи, зах зээлээр дэмжинэ.</li> <li>- Орон нутгийн байгаль орчны асуудлуудыг орон нутгийн захиргаа шийдвэрлэх шаардлагатай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар болон орон нутгийн хотуудад дэд бүтцийг сайжруулах шаардлагатай.</li> <li>- Улаанбаатар хотын үйлчилгээний өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд менежментийг сайжруулна.</li> <li>- Орон нутгийн засаг захиргаа орон нутгийн хотуудын дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотыг дэлхийн хот болгох зорилгоор менежментийг сайжруулна.</li> <li>- Боловсруулах үйлдвэрийг технологи, зах зээлээр дэмжинэ.</li> <li>- Орон нутгийн засаг захиргаа орон нутгийн хотуудын дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай.</li> </ul>
-------------------------	--	---	--	---

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### (3) Хөгжлийн алсын хараа болон хөгжлийн хүрээ

#### Хөгжлийн алсын хараа

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн алсын харааг тодорхойлох ажлын хүрээнд хөгжлийн үзэл баримтлалд тусгагдах Монголчуудын үнэт зүйлсийн талаар санал солилцох семинарыг зохион байгуулсан (“Монгол үндэстний аз жаргалын тухай” Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах үндэс - иргэдийн аз жаргалтай амьдрал семинар, 2019 оны 3 дугаар сарын 5). Хүснэгт 9.1.4-т үр дүнг нэгтгэн үзүүлэв.

#### **Хүснэгт 9.1.4 Хөгжлийн алсын хараанд тусгах монголчуудын үнэт зүйлс**

Баг 1				
Оролцогчид	Баяр баясал (Pleasure)	Зорилго (Purpose)	Бахархал (Pride)	Бусад
Эмэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>- Гэр бүл</li> <li>- Өргөн уудам тал нутаг</li> <li>- Ойр дотны хүмүүстэйгээ цагийг өнгөрүүлэх</li> <li>- Мөнгө, дэлгүүр хэсэх</li> <li>- Найз нөхөд</li> <li>- Чөлөөт цаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нүүдлийн соёлд тулгуурласан дэлхийн аялал жуулчлалын үүд хаалга болсон улсад амьдрах</li> <li>- Аялал</li> <li>- Эрүүл амьдрал</li> <li>- Албан тушаал ахих</li> <li>- Ажлын үүрэг даалгаврыг зохицуулах чадвартай байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эх, эхнэр, охидоо хүндэлдэг Монгол эрчүүд</li> <li>- Ажил хөдөлмөр</li> <li>- Ажлын ололт амжилт</li> <li>- Гэр бүл</li> <li>- Боловсрол</li> <li>- Ажил, ажлын хамт олон, найз нөхөд, гэр бүл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай улсын оюуны өндөр чадамжтай (IQ) хүүхдүүдийн мэдлэг боловсролд тулгуурлан хиймэл оюун ухааныг (ХОУ) хөгжүүлэх</li> <li>- Шинэ зүйлс сурах</li> </ul>
Эрэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>- Тогтвортой байдал</li> <li>- Гэр бүл</li> <li>- Найз нөхөд</li> <li>- Амьдралын таатай нөхцөл (байр сууц, аюулгүй байдал г.м)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Засаглал</li> <li>- Боловсрол</li> <li>- Мөрөөдөл</li> <li>- Ур чадвар, мэдлэг эзэмших</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Түүх</li> <li>- Соёл</li> <li>- Өөрийн мэдлэг, чадвар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Орлогын ялгаатай байдлыг багасгах</li> </ul>

Баг 2				
Оролцогчид	Баяр баясал (Pleasure)	Зорилго (Purpose)	Бахархал (Pride)	Бусад
Эмэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>- Тус хүргэсний дараа хүмүүсийн царайнд илрэх инээмсэглэл</li> <li>- Ээжтэйгээ хамт байх</li> <li>- Чөлөөт цаг</li> <li>- Хобби</li> <li>- Экологийн тэнцвэрт байдал</li> <li>- Өөрөөрөө байх</li> <li>- Эрүүл байх</li> <li>- Гэр бүл (миний гурван хүүхэд, нөхөр)</li> <li>- Эрүүл, эрх чөлөөтэй амьдрах, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд (эцэг эх, хүүхдүүд, ач зээ)</li> <li>- Аюулгүй, эрүүл орчинд амьдрах</li> <li>- Ажилтай байх</li> <li>- Дуртай зүйлээ хийх боломжтой байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн мэргэшсэн шинжээч болох</li> <li>- Мөрөөдлөө биелүүлэх</li> <li>- Улс эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах</li> <li>- Боловсрол</li> <li>- Мөрөөдлөө биелүүлэх</li> <li>- Санхүүгийн боломж, бололцоотой байх</li> <li>- Мэдлэг</li> <li>- Спортоор хичээллэх</li> <li>- Дэлхийг тойрон аялах</li> <li>- Дуртай зүйлээ хийх (зураг зурах, керамик урлал)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Миний эцэг, эх</li> <li>- Эх орны түүх, соёл</li> <li>- Эх орон, гэр бүл</li> <li>- Өөрийн эзэмшсэн мэргэжил</li> <li>- Амлалтаа биелүүлэх</li> <li>- Монгол Улсын аз жаргалтай иргэн байх</li> <li>- Итгэл даах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аялал</li> <li>- Аюулгүй, эрүүл орчин</li> <li>- Гамшиг, эрсдэлгүй орчин</li> </ul>
Эрэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>- Тэтгэвэрт эрт гарах</li> <li>- Гэр бүл</li> <li>- Эрүүл мэнд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдүүдийн боловсрол</li> <li>- Боловсрол</li> <li>- Монгол Улсаа хөгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аз жаргалын индекс</li> <li>- ҮХЦТ-д оролцож байгаа нь</li> <li>- Түүх</li> <li>- Монгол эр хүн</li> </ul>	-

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Семинарын үеэр тодорхойлсон Монголчуудын үнэт зүйлсийг тусгаж, асуудлын бүтцийн шинжилгээнд үндэслэн Монгол Улсын хөгжлийн алсын харааг тодорхойлж, доор үзүүлэв. Монгол Улсын хөгжлийн алсын харааны талаар төслийн Хамарсан зохицуулах хорооны хурал, Оролцогч талуудын нэгдсэн хурлуудаар удаа дараа танилцуулж, хэлэлцсэн бөгөөд тухайн асуудлаар нэмэлт хэлэлцүүлэг хийгээгүй болно.

### Монгол Улсын хөгжлийн алсын хараа

Байгалийн нөөц баялгийг зохистой ашигладаг, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааг ажлын байр бий болгох үйл явцтай нягт уялдуулсан, олон нийтийн оролцоог хангасан ил тод, хариуцлагатай засаглалтай, баялаг өв соёлтой, олон ястан амьдардаг, бүх салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, өөрийгөө шинэ мэдлэг, боловсролоор тасралтгүй хөгжүүлдэг хүний нөөц бүхий нэг талаас дэлхий нийтэд нээлттэй, өөрчлөгдөж буй дэлхий ертөнцийн үр нөлөөнд дасан зохицох чадвартай хүчирхэг, уян хатан нийгэм, эдийн засагтай, нөгөө талаас тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг хангана.

#### Нийгэм, эдийн засгийн хөгжил

Дээр дурдсан хөгжлийн 4 хувилбарын хүрээнд ДНБ-ний өсөлтийг салбаруудаар тооцож, Хүснэгт 9.1.5-т үзүүлэв. Эдгээр хувилбаруудаас ажлын байрыг хамгийн ихээр нэмэгдүүлэх, Монгол Улсын нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах, байгаль орчинд ээлтэй өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжлийн хувилбарыг сонгосон. Монголын талын хүсэлтээр нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлвийн хугацааг 2040 он болгож өөрчилсөн.

#### Хүснэгт 9.1.5 ДНБ-ий өсөлт 2030 оны байдлаар, салбараар, хөгжлийн хувилбаруудаар

Салбар	А: Уул уурхайд түшиглэсэн хөгжил	В. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өндөр хөгжил	С. Транзит тээврийн чиг баримжаатай хөгжил	Д. Өндөр өсөлттэй, холимог бүтэцтэй хөгжил
Хөдөө аж ахуй	3.5	3.5	3.5	3.5
Уул уурхай	6.3	5.0	5.0	5.0
Аж үйлдвэр, нийтийн аж ахуй	7.0	9.4	7.6	9.4
Үйлчилгээ	7.5	7.5	8.0	8.3
ДНБ	6.7	6.7	6.7	7.1

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### Орон зайн төлөвлөлт

ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлт нь хотын зэрэглэл, авто замын сүлжээ, газар зохион байгуулалтын асуудлуудыг хамарна. Хотын зэрэглэлийг Монголын талын хамтрагч байгууллагуудтай хамтран тодорхойлж, хотуудыг нийслэл хот, бүсийн хөгжлийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн төв хот, орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хот зэрэг 4 зэрэглэлд хуваасан. Үүнд:

- Улсын нийслэл хот: Налайх, Зуунмод хотыг багтаасан Улаанбаатар хот
- Бүсийн хөгжлийн тулгуур төв хотууд: Булганыг багтаасан Эрдэнэт хот, Дархан, Чойбалсан, Сайншанд, Ховд, Баянхонгор
- Орон нутгийн хөгжлийн төв хотууд: Багануур, Чойр, Замын-Үүд, Сүхбаатар, Мөрөн, Даланзадгад, Өндөрхаан, Мандалговь
- Орон нутгийн үйлчилгээний чиг үүрэг бүхий хотууд: Бусад 12 хот

#### (4) Ажлын хэсэг, дэд Ажлын хэсгийн хурал болон семинар

Энэхүү 9.1.3-ын (1) “Хөгжлийн чиг хандлага болон хөгжлийн хувилбарууд”, (2) “Хөгжлийн алсын хараа болон хөгжлийн хүрээ”-нд тусгаснаар Ажлын хэсэг, дэд Ажлын хэсгийн гишүүдийн оролцоотойгоор төлөвлөлтийн асуудлуудыг хэлэлцэх цуврал семинар, холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнуудтай хийх ярилцлага, Ажлын хэсэг болон дэд Ажлын хэсгийн хурлуудыг төсөл хэрэгжиж эхлэх үед ЖАЙКА-гийн Төслийн баг болон Монголын талын хамтран ажиллагч байгууллагуудтай харилцан тохиролцсоны дагуу зохион байгуулав. Хүснэгт 9.1.6-д төслийн эхэн үед зохион байгуулсан семинаруудыг нэгтгэн үзүүлэв. Хүснэгт 9.1.7-д төслийн эхэн үед зохион байгуулсан Ажлын хэсэг, дэд Ажлын хэсгийн хурлуудыг нэгтгэн харуулав.

#### Хүснэгт 9.1.6 Төслийн эхэн үед зохион байгуулсан семинар

Огноо	Семинарын нэр	Илтгэгч	Хариуцан ажилласан
2019 оны 1 дүгээр сарын 15	Төлөвлөлтийн хувилбарууд, ТХЗ ба хөгжлийн чиг хандлага	Цүёоши Хашимото	ЖАЙКА-гийн Төслийн баг
2019 оны 3 дугаар сарын 05	“Монгол үндэстний аз жаргалын тухай” Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах үндэс - иргэдийн аз жаргалтай амьдрал	Харүо Яманэ	ЖАЙКА-гийн Төслийн баг
2019 оны 3 дугаар сарын 11	Япон улсын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулсан туршлага	Тошиясү Нода	Япон улсын Сэйнан Гакүин Их сургууль
	Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, олон улсын туршлагын харьцуулалт	Саторү Оба	Япон улсын Хот, байгаль орчны хөгжлийн судалгааны хүрээлэн
	Орон зайн төлөвлөлтийн платформ ба газрын мэдээллийн санг ашиглан улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах нь	Эико Тояама	Япон улсын Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам
2019 оны 3 дугаар сарын 18	Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө (ҮХЦТ): Төлөвлөлтийн хувилбарууд; Макро түвшний хөгжлийн хувилбарууд	Цүёоши Хашимото	ЖАЙКА-гийн Төслийн баг

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### Хүснэгт 9.1.7 Төслийн эхэн үед зохион байгуулсан дэд Ажлын хэсгийн хурал

Салбар	Огноо	Сэдэв
Хотын дэд бүтэц болон зам, тээврийн дэд бүтэц	2019 оны 3 дугаар сарын 12	Дэд бүтцийн салбарын судалгааны ерөнхий аргачлал, хоёрдогч хотуудын судалгаа, хот, тосгон, бусад суурины зэрэглэл, замын хөдөлгөөний эрчмийн судалгаа ба эрчмийн тооцоолол
Байгаль орчин, аялал жуулчлал Нийгмийн хөгжил (Хамтарсан хурал)	2019 оны 3 дугаар сарын 13	ҮХЦТ-ний хүрээнд хийсэн нийгэм, аялал жуулчлалын салбарын одоогийн нөхцөл байдлын дүн шинжилгээ болон аргачлал



Аж үйлдвэр, хөдөө аж ахуй (Хамтарсан хурал)	2019 оны 4 дүгээр сарын 16	ҮХЦТ-ний хүрээнд хийсэн аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын одоогийн нөхцөл байдлын дүн шинжилгээ болон аргачлал
Хотын дэд бүтэц ба зам тээврийн дэд бүтэц (Хоёрдугаар хурал)	2019 оны 4 дүгээр сарын 17	Нутаг дэвсгэр, орон зайн хөгжлийн дүн шинжилгээний арга зүй, эдийн засгийн коридорын хөгжил болон хотуудын чиг үүрэг

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## 9.1.5 Оролцогч талуудын оролцоотойгоор ҮХЦТ-г боловсруулах нь

### (1) Төслийн Явцын тайлангийн талаарх хэлэлцүүлэг

Өмнөх хэсэгт дурдсанаар төслийн эхэн үед хийж гүйцэтгэсэн олон нийтийн оролцоотой төлөвлөлтийн үр дүнг нэгтгэж, ЖАЙКА-гийн Төслийн баг нь 2019 оны 5 дугаар сард төслийн Явцын тайланг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Төслийн Хамтарсан зохицуулах хорооны 2 дугаар хурлыг 2019 оны 6 дугаар сарын 7-ний өдөр зохион байгуулж, Явцын тайлангийн талаар хэлэлцсэн. Төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлаар макро түвшний хөгжлийн зорилт, үндсэн стратеги, хөгжлийн хүрээ болон макро түвшний хөгжлийн хувилбаруудыг төслийн Ажлын хэсгийн гишүүдээс гадна бусад холбогдох мэргэжилтнүүд, байгууллагуудын төлөөллөөр хэлэлцүүлэх талаар хоёр тал санал нэгдэв. Энэхүү зорилгоор ойрын хугацаанд Эхлэлийн тайланд санал болгосон Оролцогч талуудын нэгдсэн хурлыг зохион байгуулж, Оролцогч талуудын дараагийн хурлын сэдэв, товыг анхны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэхээр болсон.

Монгол Улсын Засгийн газар нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахаар шийдвэрлэж, Монгол Улсын Ерөнхий сайд 4 дүгээр сарын 30-ны өдөр 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох баримт бичгийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулах захирамж гаргасан. Монголын тал урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулах хурлуудтай андуурагдахгүйн тулд олон оролцогчдыг хамруулсан Оролцогч талуудын нэгдсэн хурлыг түр хугацаагаар хуралдуулахгүй байхыг хүссэн. ЖАЙКА-гийн Төслийн баг хүсэлтийг хүлээн авч, цөөн тооны оролцогчтой хурал уулзалт зохион байгуулж, холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнуудтай ярилцлага хийхээр шийдвэрлэсэн.

### (2) Оролцогч талуудын хурал, семинарын хэлэлцүүлэгт үндэслэн ҮХЦТ-г боловсруулах нь

#### ҮХЦТ-ний эхний төсөл

Төслийн Явцын тайланг боловсруулж хүргүүлсний дараа ЗГХЭГ, СЯ, ХНХЯ, БХБЯ, БХТ, ҮХГ, НЗДТГ, Дархан хотын төлөөллөөс Явцын тайланд ирүүлсэн саналуудыг тусгаж ҮХЦТ-ний эхний төслийг боловсруулсан. Энэ хугацаанд Ажлын хэсэг, дэд Ажлын хэсгийн хурлуудыг үе үе зохион байгуулсан.

Төслийн Явцын тайланд тусгасан хөгжлийн алсын хараа, зорилт, стратегийг оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийх замаар тодорхойлсон бол санал болгож буй төслүүдийг (салбаруудаар) холбогдох яам, агентлагуудтай хамтран боловсруулсан. Хөгжлийн алсын хараа/хөгжлийн загвар, хөгжлийн хүрээ, хөгжлийн зорилт, стратегийн талаар хэлэлцэж, нарийвчлан боловсруулах зорилгоор Хүснэгт 9.1.8-д үзүүлсэн нэмэлт семинаруудыг зохион байгуулсан.

### Хүснэгт 9.1.8 ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан алсын хараа, хөгжлийн хүрээний талаар хэлэлцсэн семинарууд

Огноо	Семинарын нэр	Илтгэгч	Хариуцан ажилласан
2019 оны 6 дугаар сарын 19	Ази-Европын бүс нутгийн логистикийн чиг хандлага ба Монгол Улсын тээврийн салбарын үүрэг, оролцоо	Риючи Шибасаки Б. Гэрэлням Б. Гүнболд Ёошия Накагава	Токиогийн Их сургууль ЗТХЯ БХБЯ ЖАЙКА-гийн Төслийн баг
2019 оны 8 дугаар сарын 21	Тогтвортой хөгжлийн зорилгууд, ТХҮБ-2030 ба хөгжлийн шинэ загвар	Ёожи Кавамура	ЖАЙКА-гийн Төслийн баг
	Дэлхийн улс орнуудын орон зайн төлөвлөлтийн туршлага	Масару Токура	
2019 оны 10 дугаар сарын 9	Тогтвортой хөгжлийн зорилгууд, ТХҮБ-2030 ба хөгжлийн шинэ загвар (хоёр дахь удаагийн семинар)	Ёожи Кавамура	ЖАЙКА-гийн Төслийн баг
	Нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	Харүо Яманэ	

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Төслийн эхний үр дүнг таниулах зорилгоор улс төрчид, эрдэмтэд, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хурал, уулзалтуудыг зохион байгуулсан. Оролцогч талуудын нэгдсэн хурлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч түүнийг төлөөлүүлэн холбогдох, мэргэжилтэн албан тушаалтнуудтай уулзалт ярилцлага хийсэн. Оролцогч талуудын хурал, уулзалтыг Хүснэгт 9.1.9-д нэгтгэн үзүүлэв.

### Хүснэгт 9.1.9 Оролцогч талуудын хурал

Огноо	Оролцогч талууд	Сэдэв
2019 оны 8 дугаар сар	Хэлэлцүүлэг хийсэн мэргэжилтнүүд: 1) МУИС-ийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн захирал Т. Чулуун 2) ХАНСХЕТ-ийн Зөвлөх багийн ахлагч Н. Тогтох 3) De Facto институтийн гүйцэтгэх захирал Д. Жаргалсайхан 4) Японд их, дээд сургууль төгсөгчдийн нийгэмлэгийн тэргүүн Б. Насанбилэг 5) Б. Түвшинтөгс, МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн захирал	Хөгжлийн алсын хараа/ загвар, хөгжлийн хүрээ
2019 оны 8 дугаар сарын 21	Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын төлөөлөл, холбоод болон бусад	ҮХЦТ-ний эхний төсөл
2019 оны 11 дүгээр сарын 21	Монгол Японы бизнесийн зөвлөл	ҮХЦТ-ний эхний төсөл

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Төлөвлөлтийн асуудлуудыг олон нийтийн оролцоотойгоор хэлэлцэх хурал, уулзалтаас гадна аймгуудын өнөөгийн нөхцөл байдлыг судлах, аймгуудын удирдлага, иргэдийн санаа бодлыг тусгах зорилгоор зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах журмын дагуу орон нутгийн түвшинд олон нийтийн хэлэлцүүлгийг хийж буй явдал юм.

ЖАЙКА-гийн Төслийн баг статистик тоо баримт болон холбогдох тайланд үндэслэн аймгуудын өнөөгийн нөхцөл байдал, орон нутгийн хөгжилд тулгарч буй асуудлууд, хөгжлийн хэтийн төлвийг урьдчилсан байдлаар тодорхойлсон. 2019 оны 3 дугаар сараас 8 дугаар сарын хооронд БХБЯ, ҮХГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран 21 аймагт томилолтоор ажилласан. Аймгуудын хөгжлийн урьдчилсан дүн шинжилгээг нягталж тодруулах, нэмэлт мэдээлэл авах, орон нутгийн хөгжлийн талаар тэдний санал бодлыг сонсох зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хүснэгт 9.1.10-т аймгуудад томилолтоор ажилласан хуваарийг үзүүлэв.

### Хүснэгт 9.1.10 2019 онд аймгуудад томилолтоор ажилласан хуваарь


Аймаг	Огноо	Аймаг	Огноо	Аймаг	Огноо
Говьсүмбэр	3-р сарын 15	Дархан-Уул	4-р сарын 26	Завхан	6-р сарын 18
Хэнтий	3-р сарын 26	Өвөрхангай	5-р сарын 7	Булган	6-р сарын 20
Сүхбаатар	3-р сарын 27	Архангай	5-р сарын 9	Дорнод	8-р сарын 1
Орхон	4-р сарын 8	Говь-Алтай	6-р сарын 10	Дундговь	8-р сарын 6
Хөвсгөл	4-р сарын 10	Ховд	6-р сарын 12	Өмнөговь	8-р сарын 8
Дорноговь	4-р сарын 18	Баян-Өлгий	6-р сарын 14	Баянхонгор	8-р сарын 13
Сэлэнгэ	4-р сарын 24	Увс	6-р сарын 17	Төв	8-р сарын 16

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### (i) Хөгжлийн загвар

Зураг 9.1.2-т үзүүлсний дагуу төлөвлөлтийн хувилбарыг боловсруулсан. ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний хүрээнд 20 дугаар зууны хөгжлийн загвараас нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувилбарын загвар руу шилжин хөгжих санал дэвшүүлсэн бөгөөд хөгжлийн хувилбар нь хөгжлийн загварыг тодорхойлно. Хөгжлийн загвар, хөгжлийн шинэ загвар руу шилжин хөгжих талаар ойлголт өгөхийн тулд Зураг 9.1.3 -т социализмын үеэс өнөөг хүртэл Монгол Улсын дагаж мөрдөж ирсэн хөгжлийн загварыг үзүүлж, Монгол Улс нь үнэндээ хөгжлийн шинэ загвар руу шилжин хөгжиж байгааг тодруулсан.

### Зураг 9.1.3 Монгол Улсын хөгжлийн загварын өөрчлөлт



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загвараар хөгжихөд эдгээр үйл ажиллагаа нь харилцан бие биенээ дэмжиж, үе шаттайгаар хэрэгжинэ. Үүнд:

- (a) Соёл, байгалийн нөөц баялийг Монгол Улсын хөрөнгө гэдгийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн менежментийг сайжруулах, хадгалан хамгаалах шаардлагатай бөгөөд ингэснээр соёл, байгалийн нөөц баялаг нь хэдэн арван жилийн туршид ард иргэдэд үр өгөөжөө өгнө;

- (b) Нутгийн захиргааны байгууллага болон олон нийтийн оролцоотойгоор байгалийн нөөцийн менежментийг сайжруулах зорилгоор хөгжлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хэрэгтэй;
- (c) Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг хангах зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаа, экспортыг төрөлжүүлэх шаардлагатай;
- (d) Эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, эдийн засгийн шинэ үйл ажиллагаа болон дэд бүтцийг барьж байгуулахад хөрөнгө оруулах зорилгоор хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Хөгжлийн хувилбарыг 2040 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд үе шат тус бүрийн үйл ажиллагааг Хүснэгт 9.1.11-д үзүүлэв.

### Хүснэгт 9.1.11 Хөгжлийн загварын үе шатуудын онцлог

I үе шат: 2025 он хүртэл	II үе шат: 2026-2030 он	III үе шат: 2031-2040 он
<p><b>Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварт шилжин, хөгжих бэлтгэл үе шат</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Капиталыг хуримтлуулах;</li> <li>- Эдийн засгийн шинэ үйл ажиллагаануудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийх;</li> <li>- Нутгийн захиргааны байгууллагын чадавхыг тогтвортой бэхжүүлэх;</li> <li>- Хөрөнгийн эх үүсвэрийн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өөр эх үүсвэр, нөөц боллоцгоог дайчлах;</li> <li>- Бүх салбарт дижитал шилжилтийг хурдацтай нэвтрүүлэх.</li> </ul>	<p><b>Нийгэм, эдийн засгийн бүтцийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварт тохируулан өөрчлөх ажил идэвхтэй хийгдэх үе шат</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн удирдлагын хөгжлийн зарим чиг үүргийг, байгаль орчны хяналт, менежментээс эхлүүлэн нутгийн удирдлагын байгууллагуудад шилжүүлэх;</li> <li>- Орон нутгийн нийгмийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх хамтын ажиллагааны механизмыг институцчилэх.</li> </ul>	<p><b>Монгол Улс нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангасан шинэ загварт бүрэн шилжсэн байх үе шат</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ТХЗ, “Алсын хараа 2050”-ын хэрэгжилтийг дүгнэж, хөгжлийн стратеги, тэргүүлэх чиглэлүүдийн өөрчилж, шинэчлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлох;</li> <li>- ОХУ, БНХАУ, бусад улс, орнуудтай худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх;</li> <li>- Төрийн зарим чиг үүргийг нутгийн удирдлагын байгууллагуудад үе шаттайгаар шилжүүлэх, хуваарилах үйл ажиллагааг үргэлжлүүлэх.</li> </ul>

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### ҮХЦТ-г хэлэлцүүлэхээр Оролцогч талуудын нэгдсэн хурлуудыг зохион байгуулах нь

Төслийн баг 2019 оны 11-р сард ҮХЦТ-ний төслийг эхний байдлаар боловсруулж, дунд хугацааны тайлан 1-ийг хүргүүлсэн. 2019 оны 11-р сарын 25-ны өдөр дунд хугацааны тайлан 1-ийг ТХЗХ-ны 3 дугаар хурал дээр танилцуулж, хэлэлцүүлсэн. Тус хурлын үеэр ЖАЙКА болон Монголын тал ҮХЦТ-ний төслийг сайжруулан боловсруулахын тулд Төслийн баг, Монголын тал хамтарч оролцогч талуудын нэгдсэн хурал, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах нь чухал болохыг онцолсон. ТХЗХ-ны хурлын дараа ҮХЦТ-ний төслийг нарийвчлан боловсруулахад шаардлагатай чухал асуудлуудыг тодруулах зорилгоор оролцогч талуудын

нэгдсэн хурлыг зохион байгуулж, өргөн хүрээнд уулзалт, хэлэлцүүлэг өрнүүлэхээр тохиролцсон (ТХЗХ-ны 3-р хурлын тэмдэглэл).

ҮХЦТ-ний төслийг өргөн хүрээнд танилцуулах, сурталчлах зорилгоор 2020 оны 1 дүгээр сарын 22-нд оролцогч талуудын нэгдсэн хурлыг зохион байгуулсан. Хуралд эрдэмтэн судлаачид, хэвлэл мэдээллийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл, 21 аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нар, төслийн Ажлын хэсгийн гишүүд зэрэг нийт 162 оролцогч оролцсон. Төслийн багаас ҮХЦТ-ний төслийг танилцуулж, илтгэл тавьсны дараа хуралд оролцогчид 1) хөгжлийн загвар, алсын хараа, зорилт, стратеги 2) нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөө сэдвээр хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлгийн явцад 3 чиглүүлэх асуултыг өгсөн ба оролцогчид багаараа ярилцаж, хариултаа нэгтгэн танилцуулсан. Хэлэлцүүлгийн асуулт, хариултын хураангуйг дараах хүснэгтээс харна уу.

1) Хөгжлийн загвар, алсын хараа, зорилго, стратеги

1-р асуулт: Монгол Улс ирэх хэдэн арван жилд хөгжлийн ямар загвараар хөгжих нь зүйтэй вэ?

Баг	Хөгжлийн загвар	Тайлбар
1	Холимог бүтэцтэй хөгжлийн загвар	Социалист нийгмийн үеийн хүртээмжтэй нийгмийн үйлчилгээний тогтолцоог дахин нэвтрүүлэх хэрэгтэй.
2	Нийгэм, эдийн засгийн хөгжлийн загвар: 4 оролцогч Холимог бүтэцтэй хөгжлийн загвар: 2 оролцогч	20-р зууны хөгжлийн загвараас өөр загвараар замнах шаардлагатай.
3	Оролцогчид 20-р зууны хөгжлийн загварын үр нөлөөг ойлгож байгаа ч нийгэм, эдийн засгийн хөгжлийн загвараар замнах болоогүй байна гэж үзсэн.	Хөгжилд хөтлөх гол салбаруудыг тодорхойлж хөгжлийн загварыг тодорхойлох хэрэгтэй.
4	Нийгэм, эдийн засгийн хөгжлийн загвар	Уул уурхайн салбарын өсөлт чухал хэвээр байх төлөвтэй ч нийгэм, эдийн засгийн хөгжлийн загвар руу шилжих нь чухал.
5	Холимог бүтэцтэй хөгжлийн загвар	Тогтвортой удирдлага, бодлогын хүрээнд нийгмийн асуудлуудын чиг баримжаатай эдийн засгийн хурдацтай, хүртээмжтэй хөгжил чухал.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

2-р асуулт: Хэрэв одоогийн хөгжлийн загвараар цаашид үргэлжлүүлэн замнавал ямар үр дүнд хүрэх вэ?

Баг	Хөгжлийн загварын үр дагавар
1	Тогтворгүй удирдлага, бодлого; оновчтой бодлогын хэрэгжилт хангалтгүй; урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх механизм шаардлагатай; зөвхөн Засгийн газрын санаачилгаар хэрэгжүүлэх бус хувийн хэвшилтэй хамтарч ажиллах шаардлагатай; орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх механизмыг санал болгох хэрэгтэй.
2	Уул уурхайн салбарын өсөлт үргэлжлэх ч ирэх 30 жилийн хугацаанд нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлд шилжинэ; хот, хөдөөгийн орлогын зөрүүтэй байдлыг багасгахын тулд бүсүүд тухайн орон нутгийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх шаардлагатай; Улаанбаатар хот тэргүүлэх байр суурь, төвлөрлийг ашиглаж ажлын байр, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх

	шаардлагатай; удирдлага, бодлогын тогтвортой байдал, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай.
3	Уул уурхай, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал, дамжин өнгөрөх худалдаа зэрэг нь чухал ач холбогдолтой.
4	Салбарын бодлогуудын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай; Засгийн газар уул уурхайн өсөлтөд хэт түшиглэж байгаа нь орлогын зөрүүтэй байдлыг бууруулах, эдийн засгийг төрөлжүүлэх, нийслэл дэх хэт төвлөрлийг бууруулах зэрэгт төдийлөн сайн нөлөө үзүүлэхгүй байна. Энэ нь улс төрийн тогтворгүй байдал, бодлогын нэгдмэл бус байдлын шалтгаан болдог. Үүний үр дүнд хүрээлэн буй орчин, хүний нөөц, соёлын өвийн асуудлууд орхигдох, доголдох явдал ч гарна.
5	Эдийн засгийг солонгоруулж, дамжин өнгөрөх худалдааг хөгжүүлж, экспортыг дэмжиж, ашигт малтмалыг боловсруулах замаар баялгийг нэмэгдүүлж, уул уурхайгаас хэт хамааралтай байхаас зайлсхийх хэрэгтэй.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

3-р асуулт: Нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлт, байгаль орчны хувьд ямар өөрчлөлт шаардлагатай байна вэ?

Баг	Бүтцийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлс
1	Боловсролын салбарыг чухалчилж авч үзэх; боловсролын хүртээмжийн хязгаарлагдмал байдал, хүрэлцээ муутай орчин, багш, ажилчдын хомсдол зэргийг анхаарч үзэх; экологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, дахин боловсруулалт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг хөхүүлэн дэмжих; бусад улс орнуудтай худалдааны гэрээ байгуулж, идэвхтэй маркетинг хийх; нүүрснээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих; хот хоорондын холбоог бэхжүүлэх тээврийн дэд бүтцийг сайжруулах; захиргааны шинэчлэл, орон нутгийн захиргааны байгууллагыг бэхжүүлэх шинэчлэл хийх.
2	Аялал жуулчлал ба дамжин өнгөрөх ачаа тээврийг хөгжүүлэх; бага боловсрол, ур чадвар олгох сургалт, ахисан шатны боловсрол, мэргэжлийн сургалтад хамрагдах боломжийг сайжруулах; усны нөөцийн менежмент болон зохистой ашиглалтыг дэмжих; хөрөнгө оруулалтыг дэмжих, нийгэм, эдийн засгийн хөгжилд чиглэсэн шинэ үйл ажиллагааг дэмжих, технологийн шинэчлэл хийх.
3	Орон нутгийн нөхцөлд тохирсон малын төрөл зүйлийг сонгож МАА эрхлэлтийг дэмжих; алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж нүүрс олборлолт, үйлдвэрлэлийн эзлэх жинг бууруулах; дамжин өнгөрөх худалдаа ач холбогдол багатай; чанартай ажиллах хүчийг бүс нутгууд руу татах/шилжүүлэх зорилгоор бүсүүдэд дээд боловсролын байгууллагуудыг байгуулах; МХХТ-ийн эрин үед залуучуудын хөдөлмөрийг ашиглах; цаг уурын өөрчлөлтөөс үүдэн баруун аймгуудад газрын доорх усны нөөц, гол, нуурын ус багасч байгаатай тэмцэх арга хэмжээ авах; орон нутгийн захиргааны байгууллагыг бэхжүүлэх шинэчлэл хийх.
4	Уул уурхай, мал аж ахуй, газар тариалангийн салбарт шинэ технологийг ашиглах; МХХТ-ийг ашигласан, ухаалаг, дэвшилтэт технологид тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх, үндэсний үнэт зүйлсээ дээдэлсэн иргэнийг төлөвшүүлэх сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог хөгжүүлэх, сэтгэлгээг өөрчлөх насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх, дэвшилтэт технологийн дээд болон мэргэжлийн боловсрол олгох; усны нөөцийн менежмент; ойжуулалт, хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх; бэлчээрийн газрыг хамгаалах, менежмент бүхий бэлчээрийг тогтоох; хөгжлийн удирдлага, бүс нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг нутагшуулах.
5	Мэдлэгийн салбар: AI, IoT ашиглалт ба технологи хөгжүүлэлт.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг



2) Орон зайн төлөвлөлт, газар ашиглалт

1-р асуулт: Улаанбаатар хот дахь төвлөрөл нь улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна уу?

Баг	Саналууд
1	Орон нутгийн захиргааны байгууллагууд хувийн хэвшлийг татах санхүүгийн эх үүсвэртэй болсны дараа Улаанбаатар хот дахь төвлөрлийг бууруулж, шилжилт хөдөлгөөний татах боломжтой болно. Гэвч орон нутагт төвлөрүүлсэн татварыг Засгийн газраас буцаад орон нутгуудад хуваарилдаг. Нийслэлд төрийн албан хаагчид их байдаг ч бусад салбаруудад ажиллах, хөдөлмөр эрхлэх боломж бага байдаг. Эрүүл мэндийн байгууллагууд, чиг үүргийг орон нутгийн хотуудад шилжүүлж, хуваарилж болно.
2	Улаанбаатар дахь хэт төвлөрлийг шийдвэрлэхэд анхаарахаас илүүтэй бүс нутгийн онцлог, орон нутгийн нөөцийг ашиглан бүсчлэн хөгжүүлэхэд анхаарах нь чухал.
3	Хэт төвлөрөл үүссэнээр асуудлууд үүсэх тул бүс нутгуудад төвлөрлийг татах төлөвлөлтийг хийх нь чухал.
4	Бэрхшээлээс илүү боломжууд дээр анхаарлаа төвлөрүүлэх нь чухал. Бүс нутгийн хөгжилд хөгжлийн удирдлагыг нутагшуулах үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай.
5	байхгүй.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

2-р асуулт: Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахын тулд хотын ямар чиг үүрэг, үйл ажиллагааг аль хот/бүсэд шилжүүлэх нь тохиромжтой гэж үзэж байна вэ?

Баг	Саналууд
1	байхгүй.
2	Улаанбаатар хотын чиг үүргээс Улаанбаатар хотыг тойрсон дагуул хотууд руу шилжүүлэх хэрэгтэй. Налайхад барилгын үйлдвэрүүд, Тэрэлжид аялал жуулчлалын үйлчилгээ, үйл ажиллагаа, Жаргалантад газар тариалан, мал аж ахуй эрхлэлт г.м.
3	Хоёрдогч том хотуудыг тодруулах шаардлагатай (Улиастай, Өндөрхаан тохиромжгүй); Баруун бүсэд Ховд, Зүүн бүсэд Чойбалсан хотыг стратегийн ач холбогдол бүхий хот болгон хөгжүүлэх нь зүйтэй; баруун талд Ховдыг Булган, Цагааннуураар холбосон, зүүн талд Чойбалсан, Эрээнцавыг холбосон АН-4 дагуух байршлууд хөгжлийн потенциалтай байх боломжтой; Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр, Зүүн Хойд Азийн бүс нутгийн улс орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй үр дүнтэйгээр хамтарч ажиллах.
4	Улаанбаатар хот дахь хэт төвлөрлийг шийдвэрлэхийн тулд сонгогдсон хотуудад нийслэлийн чиг үүргээс шилжүүлэх нь хангалтгүй ба хөгжлийн удирдлагыг нутагшуулах шаардлагатай; Засгийн газар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүс нутгуудад татах, дэмжих, татвар, урамшууллын бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлагатай.
5	Баруун бүсийн гурван аймгийг Цагааннуур, Яргуйг холбосон зам дайран өнгөрч байгаа ба Орос, Казахстан, Хятадыг холбосон худалдаа, аялал жуулчлалын коридорыг байгуулах боломжтой; Төвийн бүсэд Арцсуурь, Гашуунсухайт, Алтанбулаг, Замын-Үүдийг холбосон маршрут; Зүүн бүсэд Эрээнцав, Бичигтийг холбосон маршрутыг хөгжүүлж болно (ОХУ, БНХАУ, БНСУ, Монгол Улсын хамтарсан Түмэн голын төслийн хүрээнд хөгжүүлж болно).

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг



3-р асуулт: Улиастай, Өндөрхаан, Цэцэрлэг, Хархорин, Арвайхээр хотуудын ямар чиг үүрэг, үйл ажиллагааг өргөжүүлж, сайжруулах вэ?

Баг	Саналууд
1	Аялал жуулчлалд хөрөнгө оруулах; дэлхийн хэмжээний аж ахуйн нэгжүүдийн чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, ялангуяа хотын дэд бүтцийг сайжруулах замаар МХХТ-ийн компаниудыг төвлөрүүлэх; дүрвэгсдийг хүлээн авах таатай орчныг бий болгох замаар ажиллах хүчийг нэмэгдүүлэх гэх мэт санал байж болох юм.
2	Улиастайд хөнгөн үйлдвэр, ойн аж ахуй, Өндөрхаанд аялал жуулчлал, Цэцэрлэгт эрүүл мэндийн төв, логистикийн төв, Хархоринд соёлын өвийн аялал жуулчлал, Арвайхээрт мал аж ахуй үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
3	байхгүй.
4	Улиастайд чацаргана жимсний боловсруулалт, барилгын материалын үйлдвэр, Баруун бүсийн гурван аймагт мал аж ахуй, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, Өндөрхааныг аялал жуулчлал хөгжүүлсэн “эко хот” болгох.
5	Сонгогдсон хотуудыг тэргүүлэх чиглэлд хөгжүүлж, боловсролын байгууллагууд, нийгмийн дэд бүтэц, аж үйлдвэрүүдийг байршуулна. УИХ-ын гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн улмаас аливаа үйл ажиллагаа, чиг үүргийг нутагшуулах үйл ажиллагаанд хүндрэл учирдаг.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Төслийн баг 2019 оны 1-р сарын 24-нд улс төрийн намуудын төлөөлөлтэй уулзаж ҮХЦТ-ний талаар мэдээлэл өгч, тэдний саналыг сонсов. Уулзалтад Үндэсний Хөгжлийн Нам (2016 онд байгуулагдсан), Дэлхийн монголчууд нам (2018 онд байгуулагдсан), Монголын Ардчилсан Хөдөлгөөний Намын зургаан хүний төлөөлөл оролцсон. Уулзалтын үеэр дурдагдсан гол саналуудыг доор нэгтгэв.

#### Үндэсний Хөгжлийн Нам

- Монгол Улсын хөгжлийн бодлого нь өөрийн гэсэн онцлогтой ба энэ нь ҮХН-ын баримт бичгүүдэд тусгагдсан байдаг.
- ҮХЦТ-д 1) сүүлийн 30 жилийн хугацаанд бэхжүүлээгүй нутгийн захиргааны байгууллагуудын чадавхыг сайжруулах, 2) иргэний нийгмийг төлөвшүүлэх, 3) хувийн хэвшлийг хөгжүүлэх зэрэг төлөвлөлтүүдийг тусгах нь чухал юм.
- Эдгээр асуудлууд нь Ардын нам, Ардчилсан намын удирдлага, засаглалтай холбоотой ба хандивлагчдын дэмжлэг нь хөгжилд хөрөнгө оруулалт болдог гэхээс илүү эдгээр томоохон намуудыг дэмжих хэрэгсэл болдог.
- Нүүрс тээвэрлэх, боловсруулах шийдлүүдийн талаар олон удаа ярилцаж, хэлэлцсэн ч тодорхой үр дүнд (NEDO, Кюүшюүгийн их сургуультай хамтарсан төсөл г.м.) хүрэхгүй байсаар байна.
- Геотермаль эрчим хүчийг ашиглах нь ирээдүйтэй бөгөөд сургууль, эмнэлгийн байгууллагуудын дулаан хангамжид туршиж үзэж болно.

#### Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам

- Гол мөрнүүдтэй холбоотой төслүүдийг сайн судлах шаардлагатай. Урсацын тохируулга хийх зэрэг төслүүдийг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор судлах шаардлагатай.
- Усны нөөцийн хомсдол нь Улаанбаатар хотын хөгжилд хязгаарлалт болно.

- (с) МАХН нь 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулж буй багтай хамтран ажиллаж байна.

Дэлхийн монголчууд нам

- (а) Монголд Монгол Ардын нам, Ардчилсан намаас гадна 10 гаруй улс төрийн нам байдаг. ДМН нь төв үзэлтэй нам.
- (b) Улс төрийн намын тухай хуулийн дагуу намууд олон улсын хамтын ажиллагааны төсөлд оролцох боломжтой байдаг.
- (с) ДМН нь ҮХЦТ-д санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хамтран ажиллаж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж болно.

**(3) ҮХЦТ-ний төслийг нарийвчлан боловсруулах үйл явц**

ТХЗХ-ны 3 дугаар хурлын дараа дунд хугацааны тайлан 1-д ЗГХЭГ, ЭХЯ, БОАЖЯ, ХНХЯ, СЯ, ЗТХЯ, БХБЯ, ҮХГ, ГЗБГЗЗГ, БХТ, НЗДТГ зэрэг байгууллагуудаас санал ирүүлсэн. Үүний дараа Төслийн баг ирүүлсэн саналуудыг тусгаж, япон мэргэжилтнүүд төлөвлөгөөний дагуу Монгол Улсад томилогдон ажиллаж, ҮХЦТ-ний төслийг сайжруулан боловсруулах ажлыг үргэлжлүүлсэн. Түүнчлэн Монголын талаас Төслийг хэрэгжүүлэх хуваарийг урагшлуулах буюу 2020 оны 6 дугаар сард хүргүүлэх байсан дунд хугацааны тайлан 2-ын оронд Эцсийн тайлангийн төсөл 1-ийг боловсруулж хүргүүлэх хүсэлт тавьсныг ЖАЙКА хүлээн авсан.

2020 оны 3-р сарын эхээр COVID-19 цар тахлын тархалтын улмаас Төслийн багийн япон мэргэжилтнүүд Монгол Улсад томилогдон ажиллах боломжгүй болсон. Тиймээс Төслийн баг Монголын талтай цахимаар холбогдох, имэйлээр харилцах замаар төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд Төслийн АХ, ДАХ-үүдийн хурлуудыг хуралдуулаагүй ч төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын мэргэжилтнүүдтэй холбогдож, хамтарч ажиллалаа.

ҮХЦТ-ний төслийг нарийвчлан боловсруулах ажлын чухал хэсэг нь бүс бүрийн бүсчилсэн хөгжлийн алсын хараа, стратеги, хөтөлбөрийг боловсруулах юм. Ингэхийн тулд одоогийн бүсчлэлийг судалж, аймгуудыг шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан харьцуулсны дүнд шинэ бүсчлэлийг санал болгосон.

Эдийн засгийн бүсчлэлийн саналд үндэслэж бүсчилсэн хөгжлийн алсын хараа, стратегийг боловсруулсан. Төслийн баг ҮХЦТ-д тусгагдах бүсчилсэн хөгжлийн саналын талаар ойлголт өгөх, хэлэлцүүлэг хийх зорилгоор доорх хоёр хэлэлцүүлгийн материалыг бэлдсэн.

- (а) Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийн санал (2020 оны 1-р сарын 18);
- (b) Бүсчилсэн хөгжлийн алсын хараа болон стратеги (2020 оны 1-р сарын 26).

Эдгээр хэлэлцүүлгийн материалыг нэгтгэн 2020 оны 2-р сард Монголын талд хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор санал ирээгүй бөгөөд 2020 оны 5-р сард УИХ-д өргөн барьсан урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд тусгасан эдийн засгийн шинэ бүсчлэл нь хэлэлцүүлгийн материалд санал болгосон эдийн засгийн бүсчлэлийн саналтай нийцэж байсан. Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн эдийн засгийн шинэ бүсчлэлийн саналтай хэсэг УИХ-аар дэмжигдээгүй бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” баримт бичгийг батлахдаа эдийн засгийн бүсчлэлгүйгээр баталсан.

Төслийн баг Монголын талтай эдийн засгийн шинэ бүсчлэлийн саналынхаа талаар хэлэлцэж байсан бөгөөд “Бүсчилсэн хөгжлийн алсын хараа ба стратеги” хэлэлцүүлгийн материалдаа саналаа дэлгэрүүлж боловсруулсан. ҮХЦТ-нд бүс тус бүрийн хөгжлийн стратегид суурилан Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрүүдийг (БХНХ) боловсруулсан бөгөөд БХНХ-ийг хэрэгжүүлэх зорилгоор Бүсийн хөгжлийн зөвлөл (БХЗ) байгуулахыг санал болгосон.

ХАНСХЕТ-ийг боловсруулж буй БХБЯ, БХТ-ийн саналыг тусгасан орон зайн төлөвлөлтийг хийх нь ҮХЦТ-ний чухал хэсэг юм. Үүний хүрээнд хотын зэрэглэлийн саналыг нийцүүлсэн ба гол зам, коридорын төлөвлөлтийн саналыг нийцүүлэхээр ажиллаж байна. Мөн COVID-19-ийн дэлхийн эдийн засаг болон Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлж болох нөлөөллийг зарим салбаруудаар судалж, тусгасан. Энэ нэмэлт судалгааг хийж гүйцэтгэх явцад нөхцөл байдлаас шалтгаалан Төслийн баг болон Монголын талын хамтын ажиллагаа хязгаарлагдмал байсныг дурдах шаардлагатай.

### **9.1.6 ҮХЦТ-г олон нийтэд таниулах үйл явц**

#### **(1) ҮХЦТ-ний гол агуулгыг дэмжүүлэх үйл явц**

ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний төслийг шинэчлэн боловсруулж тусгасан Эцсийн тайлангийн төсөл 1-ийг 2020 оны 6-р сард хүргүүлсэн. 2020 оны 6-р сарын 11-ний өдөр ТХЗХ-ны хурлыг цахимаар хуралдуулж, ҮХЦТ-ний төслийг танилцуулж, хэлэлцүүлэв. Хурлын үеэр оролцогч талуудад ҮХЦТ-ний шинэчилсэн төслийг танилцуулах, төслийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Төслийн баг Монголын талтай хамтарч, өргөн хүрээний оролцогч талуудыг хамруулж, цахим болон бусад хэлбэрээр хэлэлцүүлгүүдийг зохион байгуулахаар тохиролцсон.

ТХЗХ-ны хурлын үеэр Монголын тал Эцсийн тайлангийн төсөл 1-д тусгасан хөгжлийн загвар, алсын харааг ерөнхийд нь дэмжиж, хөгжлийн хувилбаруудыг илүү боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж буйгаа илэрхийлсэн. Мөн ЖАЙКА-гийн тал болон Монголын тал ҮХЦТ-ний төслийг өргөн хүрээний оролцогч талуудыг хамруулан хэлэлцүүлэх, төсөлд тусгасан саналуудыг танилцуулж, санал болгож буй хөгжлийн шинэ загварын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, гүнзгийрүүлэх талаар санал нэгдэв.

#### **(2) ҮХЦТ-г олон нийтэд таниулах үйл явц**

ТХЗХ-ны хурлын үеэр Эцсийн тайлангийн төсөл 1-д санал авсны дараа ЗГХЭГ, БОАЖЯ, ХХААХҮЯ, ХНХЯ, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ, БХБЯ, ҮХГ-аас бичгээр саналууд ирүүлсэн. Төслийн баг нь эдгээр байгууллагуудад саналыг нь хэрхэн тусгах талаараа бичгээр хариу өгсөн.

2020 оны 8-р сарын 17-ны өдөр залуучуудын төлөөллийг оролцуулсан Оролцогч талуудын нэгдсэн хурлыг цахимаар зохион байгуулж, ҮХЦТ-г танилцуулсан. 100 гаруй монгол залуус Улаанбаатар хотоос, орон нутгаас мөн гадаадын 12 улсаас холбогдож, оролцсон. Тус хурлын дараа 100 гаруй асуулт, санал сэтгэгдэл хүлээж авсан бөгөөд Төслийн баг тэдгээрт хариу өгч, түүнийгээ цахимаар нээлттэй байршуулсан. Хүснэгт 9.1.11-д Оролцогч талуудын нэгдсэн хуралд оролцсон залуучуудын төлөөллийн саналыг нэгтгэн харуулав.

### Хүснэгт 9.1.12 Оролцогч талуудын нэгдсэн хуралд оролцсон залуучуудын төлөөллийн санал

Ангилал	Санал
ҮХЦТ-д тусгагдсан саналууд	1) Дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, ашиглах; 2) Бүсчлэлийг тогтоохын тулд соёл, уламжлал, газар нутаг, уур амьсгалтай холбоотой үзүүлэлтүүдийг ашиглах; 3) Малын өвчлөлгүй бүсийг тогтоох.
Судлах шаардлагатай саналууд	1) Модон бүтээгдэхүүний чанарын лаборатори байгуулах; 2) Саарал ус ашиглах; 3) Эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн эрүүл мэндийн мэдээллийн төвүүд; 4) Залуучуудын хөгжлийн төв.
ҮХЦТ-д тусгагдахгүй саналууд	1) Соёлын салбарын төсөл, хөтөлбөрүүд; 2) Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт; 3) Шуудангийн үйлчилгээг сайжруулах хаягжуулалтын систем; 4) Азийн эрчим хүчний сүлжээний хүрээнд эрчим хүч экспортлох.
Ерөнхий санал	"Алсын хараа 2050", ХАНСХЕТ, БХБ, ҮХЦТ хоорондын уялдааг тодорхой болгох.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Дараагийн оролцогч талуудын нэгдсэн хурлыг 9 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулж, тус хуралд өмнөх хурлын оролцогчид оролцож, цахимаар багийн хэлэлцүүлэг хийсэн. Хүснэгт 9.1.13-т Оролцогч талуудын нэгдсэн хурлын хэлэлцүүлэг, илтгэлтэй холбогдуулан Төслийн багаас өгсөн хариултыг нэгтгэн үзүүлэв. Оролцогч талуудын нэгдсэн хуралд оролцогчид тодорхой асуудлуудын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн ч ҮХЦТ боловсруулах төслийн хүрээнд өргөн цар хүрээтэй судалгаа (аймгуудын судалгаа г.м.) бүхий цогц, хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж буйд сайшаалтай байгаагаа илэрхийлж байв.

### Хүснэгт 9.1.13 Оролцогч талуудын нэгдсэн хурлын хэлэлцүүлэг, илтгэлтэй холбогдуулан Төслийн багаас өгсөн хариулт

Баг	Хэлэлцсэн асуудлууд	Төслийн багаас өгсөн хариулт
А	Мал аж ахуй, газар тариалан	1) ҮХЦТ-д мал аж ахуй, газар тариалан, экспортын зах зээлд чиглэсэн анхан шатны боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг уялдуулах зорилгоор үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх стратегийг санал болгосон. 2) Энэ стратегийг дэмжихээр хэрэгжүүлэх арга хэмжээнд хөдөө аж ахуй эрхлэгчдийг зохион байгуулах, ур чадварын сургалтад хамруулж тэдний чадавхыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний хөгжилд зориулагдсан судалгаа, хөгжүүлэлт хийх, чанартай бүтээгдэхүүнийг хөгжүүлж экспортлох зэрэг үйл ажиллагаа багтана. 3) Түүнчлэн замын байгууламжийг сайжруулж, үйлдвэрлэлийн анхан шатны бүс, боловсруулах үйлдвэрүүд, экспортын баазыг хооронд нь холбох шаардлагатай.
	Хагас эрчимжсэн мал аж ахуй	1) Хагас эрчимжсэн мал аж ахуйг тэжээлийн үйлдвэрлэлтэй хослуулан мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын нэгэн хэсэг болгон хөгжүүлэх боломжтой. 2) Кластер нь мах, сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулалтаас эхэлж, цаашлаад экспортод чиглэсэн нэмүү өртөг шингээсэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулна.

	Малын өвчлөлгүй бүс	ҮХЦТ-д мах, сүүн бүтээгдэхүүний Ази болон бусад улс орнууд руу чиглэсэн экспортыг дэмжих зорилгоор Зүүн бүсэд малын өвчлөлгүй бүсийг хөгжүүлэх саналыг боловсруулсан.
	Газар тариалангийн үйлдвэрлэл, боловсруулалт	1) ҮХЦТ-д үр тариа, хүнсний ногоо, чацаргана зэрэг зарим жимс, жимсгэнэ, тосны ургамал зэрэг техникийн ургамлын тариалалт болон боловсруулалтыг нэмэгдүүлэхийг санал болгосон. 2) Үүний тулд ҮХЦТ-д томоохон гол мөрөн, хүлэмжийн аж ахуй, мэдээлэл харилцаа холбооны технологийг ашигласан ухаалаг хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн паркад суурилсан усжуулалтын системийг нэвтрүүлэх саналыг дэвшүүлсэн. 3) А багийн санал болгосон хөдөө аж ахуйн лабораторийг аж үйлдвэрийн паркад байгуулж болно.
	Газар тариалангийн үйлдвэрлэл, маркетинг	1) ҮХЦТ-д үйлдвэрлэл, маркетингийг дэмжих зорилгоор хүнсний гарал үүслийг хянах платформ, хөргүүртэй систем бүхий сүлжээ, МХХТ-ийн хяналт, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ зэргийг санал болгосон. 2) А багийн санал болгосон өргөн уудам газар нутгийг гадаадын улс орнуудад түрээслэн, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх тухай саналыг ҮХЦТ-д оруулаагүй.
В	Хотын дэд бүтэц	ҮХЦТ-д В багийн санал болгож буй явган хүний зам, дугуйн зам, хотын цэцэрлэгт хүрээлэн, хотын тээвэр, орон сууц зэрэг хотын дэд бүтцийн асуудлыг бус, харин хот, суурины ус хангамж, ариутгах татуурга, хатуу хог хаягдлын менежментийг авч үзэж байна.
	Хатуу хог хаягдлын менежмент	1) Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ҮХЦТ-д хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл, эко-парк байгуулах төслийг санал болгосон. 2) Түүнчлэн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялгахын тулд хүнсний бүтээгдэхүүний хаягдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.
	Гэр хороолол	1) ҮХЦТ-д гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл, гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төслийг санал болгосон. 2) В багийн санал болгосон ногоон байгууламжийг өргөжүүлэх ажлыг эдгээр төслүүдэд багтааж болно.
	Бүсчилсэн хөгжил	1) ҮХЦТ нь хөрш зэргэлдээ аймгуудын ижил төстэй байдлыг байгаль орчин, эдийн засаг, газар ашиглалт, санхүү зэрэг 30 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн дүн шинжилгээ хийсний дүнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 баримт бичигт шинээр санал болгосон бүсчлэлийг дэмжсэн. 2) Ижил төстэй аймгуудыг нэг бүсэд оруулан бүлэглэсэн шинэ бүсчлэл нь бүс тус бүрийн нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх илүү үр дүнтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжийг олгоно.
	Орон нутгийн удирдлага	1) ҮХЦТ-д В багийн санал болгосончлон төсвийн ил тод байдал, хариуцлагатай удирдлагыг дэмжиж, аймгийн бие даасан байдлыг хангах зорилгоор төсвийн удирдлагыг тухайн орон нутагт шилжүүлэх саналыг санал болгосон.
	Боловсролын салбар	1) ҮХЦТ нь боловсролын салбарын цогц шинэчлэлийг дэмжиж, дээд болон мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсрол, ерөнхий боловсролын чанарыг сайжруулах арга хэмжээнүүдийг санал болгосон.

		<p>2) Ялангуяа үндэсний үнэт зүйлсээ дээдэлсэн сургуулийн өмнөх боловсролын тогтолцооноос эхлэн боловсролын салбарыг цогцоор нь шинэчлэх ажлыг эхлүүлж хөгжлийн шинэ загварыг дэмжих суурийг бүрдүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог бий болгох саналуудыг дэмжиж байна.</p> <p>3) В багийн багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, МХХТ-ийг ашиглан алсын зайны сургалтыг дэмжин боловсролын тэгш хүртээмжийг хангах, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зэрэг боловсролын салбарын тодорхой зөвлөмжүүдийг шинэчлэн боловсруулсан ҮХЦТ-д тусгана.</p>
С	Аялал жуулчлал	<p>1) С багаас гарсан аялал жуулчлалын хөгжлийн санаанууд ерөнхийдөө ҮХЦТ-д тусгагдсан байсан.</p> <p>2) ҮХЦТ-д “Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах төслийг санал болгосон бөгөөд ҮХЦТ-г боловсруулах төслийн хүрээнд уг төслийн туршилтын үе шатыг хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>3) Дотоод болон гадаадын жуулчдад зориулсан соёлын аялал жуулчлал, хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай танилцах аялал жуулчлалын хувьд олон нийтийн оролцоо нь зайлшгүй юм.</p> <p>4) Улаанбаатар хотын иргэд амралтын өдрүүдээр хөдөө орон нутгаар аялан цэцэрлэгжүүлэлтийн ажилд оролцох зэргээр дотоодын аялал жуулчлалыг төрөлжүүлж болно.</p> <p>5) Орон нутгийн иргэд нутгийнхаа бүтээгдэхүүнийг жуулчдад нийлүүлж, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх боломжтой.</p> <p>6) Монгол Улс нь олон улсын аялал жуулчлалын зах зээлд шинээр нэгдэж байгаа тул аялал жуулчлалын өрсөлдөх чадвар бүхий чиглэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээс илүүтэйгээр бие биенээ нөхөн дэмжсэн өөрийн гэсэн онцлог бүхий өвөрмөц аялал жуулчлалын чиглэлийг бий болгоход бүх оролцогч талууд хамтран ажиллах нь чухал юм.</p> <p>7) ҮХЦТ-д зөвхөн жуулчид болон аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдийг төдийгүй хамтарсан маркетинг явуулах олон төрлийн аж ахуйн нэгжүүдийг хооронд нь холбох аялал жуулчлалын мэдээллийг солилцох платформыг санал болгосон.</p>
	Хувийн хэвшлийг татан оролцуулсан дэд бүтцийн бүтээн байгуулалт	<p>1) С багийн санал болгосноор Монгол Улсад авто замын бүтээн байгуулалтад хувийн хэвшлийг оролцуулах нь хүндрэлтэй байх магадлалтай. Учир нь хөдөлгөөний эрчим өндөртэй авто зам бага тул төлбөртэй авто замыг ашиглахад ашигтай байх баталгаа бага.</p> <p>2) Авто замыг хөгжүүлэхтэй холбоотойгоор ҮХЦТ-д аялал жуулчлалын хөгжилд шаардлагатай олон нийтийн дэд бүтэц, тухайлбал авто зам, нийтийн зориулалттай барилга, байгууламжийг барьж байгуулах ажлыг санхүүжүүлэх Олон нийтийн хөгжлийн санг уул уурхай, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтаар байгуулахыг санал болгосон.</p>
D	Боловсролын салбар	<p>1) ҮХЦТ-д тусгасан боловсролын салбартай холбоотой саналуудыг 2021 онд Монгол Улс PISA үнэлгээнд хамрагдахаар санхүүгийн болон техникийн дэмжлэгийг авсан гэсэн үндэслэлд суурилан боловсруулсан.</p> <p>2) Тус үнэлгээнд хамрагдахын тулд ① бүх сургуулийг 2 ээлжтэй болгох (ингэхийн тулд багш нарын тоог нэмэх, зарим сургуулиудыг сэргээн засварлах шаардлагатай), ② малчдын амьдралын хэв маягт зохицсон ерөнхий боловсрол олгох үйл ажиллагааг нэвтрүүлэх гэсэн 2 нөхцөлийг юуны түрүүнд хангах</p>

		шаардлагатай юм. 3) D багийн санал болгосон багшийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх, гадаад хэлний мэдлэгийг сайжруулах, сургуулийн орчин, барилга байгууламжийг сайжруулах зэрэг боловсролын салбарт чиглэсэн ихэнх арга хэмжээнүүдийг дээрх нөхцлийн хүрээнд хэрэгжүүлэхээр ҮХЦТ-д тусгасан. 4) Түүнчлэн ҮХЦТ-д мэргэжлийн сургууль, технологийн коллежид дэмжлэг үзүүлэх төлөвлөлтүүдийг тусгасан. 5) Хувийн болон төрийн өмчийн сургуулиудын боловсролын чанарын ялгааг бууруулах ганц арга зам бол төрийн өмчийн сургуулиудын барилга байгууламж, сургалтын хөтөлбөр, багш нарын чадавхыг дээшлүүлэх, сайжруулах юм.
	Аж үйлдвэрийн салбар	ҮХЦТ-д аж үйлдвэрийн салбарыг дэмжихээр дараах арга хэмжээнүүдийг санал болгосон. Үүнд: хууль эрх зүйн болон бодлогын хүрээг тодорхойлох; ЖДҮ-ийн ажилтнуудыг сургахад туслалцаа үзүүлэх зэргээр хүний нөөцийг хөгжүүлэх; худалдааны чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлэх замаар гадаадын шууд хөрөнгө оруулалт болон дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих; санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах; старт-ап бизнес, бизнес инкубатор, инновацийг дэмжих.
	Импорт, экспорт	1) ҮХЦТ-д импорт, экспорт, дотоодын ачаа тээвэрлэлтийг дэмжих тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан. 2) Гэрийн тэжээвэр амьтдын хоолыг үйлдвэрлэх нь хэрэгжих боломжтой санал боловч экспортод чиглэсэн хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ихээхэн хугацаа шаардлагатай.
	Мал аж ахуй	А багт өгсөн хариултыг харна уу.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Оролцогч талуудын нэгдсэн хурлыг онлайн байршуулж, оролцогчдын асуулт, саналууд, Төслийн багийн хариултыг мөн нээлттэй байршуулсан. Түүнчлэн Төслийн баг ҮХЦТ боловсруулах төслийн талаар “Unread Today” медиа компанийн цахим хуудас дээр нийтлэл гаргасан ба ҮХЦТ-г илүү өргөн хүрээнд сурталчлахын тулд видео контент бэлтгэж, мэдээллийн хэрэгслүүдээр цацсан.

### 9.1.7 ҮХЦТ-ний төслийг эцэслэн боловсруулах үйл явц

#### (1) Эцсийн тайлангийн төсөл 2

ҮХЦТ-ний талаар өргөн хүрээний оролцогч талуудад таниулах зорилгоор Эцсийн тайлангийн төсөл 1-ийг хүргүүлсний дараа хэд хэдэн туршилтын төслийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн. Туршилтын төслүүдийг Төслийн багийн удирдлага дор монгол мэргэжилтнүүд болон цөөн тооны гадаад мэргэжилтнүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлсэн. Төслүүдийн бүрэлдэхүүн, хэрэгжилт, үр дүнг тус тусад нь нэгтгэв.

Төслийн багийн салбарын төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүд 2020 онд нийтлэгдсэн сүүлийн үеийн статистик мэдээллүүдийг авч ашиглаж ҮХЦТ-д тусгасан тоо мэдээллийг шинэчилсэн. Төслийн баг нь ТХЗХ-ны гишүүд, бусад холбогдох талууд болон ЖАЙКА-гийн саналыг тусгахын тулд цахимаар холбогдож, төслийн багийн Монгол гишүүдээр дамжуулж харилцаж байлаа. ҮХЦТ-г шинэчлэн боловсруулж тусгасан Эцсийн тайлангийн төсөл 2-ыг 2020 оны 12-р сарын 15-ны өдөр ЖАЙКА-д хүргүүлсэн. ЖАЙКА хянаж, нэмж засвар оруулсны дараа тайланг 2-р сарын 28-нд Монголын талд хүргүүлсэн.



## **(2) ҮХЦТ-г ХАНСХЕТ, БХБ-ын баримт бичигт тусгах нь**

Төслийн зорилго нь Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл (ХАНСХЕТ), Бүсчилсэн хөгжлийн бодлогыг (БХБ) агуулсан Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулах юм. ҮХЦТ-г боловсруулахын тулд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа ч зөрүүтэй төлөвлөлтүүд байгаа ба БХБЯ, БХТ болон ҮХГ-тай хамт эдгээр төлөвлөлтүүдийг нийцүүлэх нь төсөл дуусах хүртэлх хөгжлийн хувилбар боловсруулах ажлын гол хэсэг нь байх болно.

ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газраас 2-р сарын 19, 24-ний өдөр ҮХЦТ-г ХАНСХЕТ, БХБ баримт бичгүүдэд тусгах талаар хэлэлцэхээр ҮХГ болон БХБЯ, БХТ-тэй цахим уулзалтуудыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр ҮХГ болон БХТ ХАНСХЕТ, БХБ баримт бичгүүдийг боловсруулах ажлын явц, үйл ажиллагааны хуваарийг танилцуулав. ҮХГ нь Төслийн багаас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулахад дэмжлэг авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. БХТ нь ХАНСХЕТ-ийн төслийг боловсруулах ажлын явцыг танилцуулсан ба цаашид төлөвлөлтүүдийн уялдааг хангах уулзалтуудыг зохион байгуулах шаардлагатай болохыг оролцогч талууд онцолсон.

Энэ хугацаанд Эцсийн тайлангийн төсөл 2-т ЗГХЭГ, БШУЯ, ЭМЯ, БОАЖЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, ЭХЯ, СЯ, БХБЯ, ЗТХЯ, ХНХЯ, БХТ, ГЗБГЗЗГ болон ХАНСХЕТ баримт бичгийг боловсруулах зөвлөх багийн 4 гишүүнээс бичгээр санал ирсэн. Төслийн баг саналуудад хариу хүргүүлсэн ба ҮХЦТ, ХАНСХЕТ-ын уялдааг хангахын тулд 1) хүн амын хэтийн төлвийн тооцоо, 2) эдийн засгийн хэтийн төлөв, 3) хотын зэрэглэл, 4) тойрог коридор, 5) нийслэл хотын чиг үүргийг шилжүүлэх, 6) эдийн засгийн бүсчлэл, 7) эдийн засгийн кластерыг хөгжүүлэх зэрэг гол төлөвлөлт, асуудлуудыг нийцүүлэх шаардлагатай гэж тодорхойлсон.

Бүх саналыг хүлээн авч, танилцсаны дараа Монголын талаас Эцсийн тайлангийн төсөл 2-т ирүүлсэн гол саналуудад үндэслэн БХБЯ, БХТ, ҮХГ-тай хурал уулзалтуудыг зохион байгуулсан. 4 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан хурлаар ЖАЙКА-гийн Төслийн баг Монголын талаас ирүүлсэн дээр дурдсан асуудлуудын талаар тайлбарласан. Өргөтгөсөн хэлэлцүүлгээр ҮХЦТ-нд тусгасан тухайн асуудлууд, төлөвлөлтийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, цаашид хэлэлцэх асуудлыг тодруулсан. Тухайлбал нийслэлийн чиг үүргийг шилжүүлэх, улс төрийн шалтгаанаар эдийн засгийн бүсчлэлийг өөрчлөх талаар үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Хуралд оролцсон зарим зөвлөхүүд дээрх асуудлуудтай холбоотой саналаа бичгээр ирүүлсэн.

4 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан хурлаар БХТ нь Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний талаар илтгэл тавьж, дээр дурдсан асуудлууд, төлөвлөлтийн талаар үргэлжлүүлэн хэлэлцсэн. ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ, “Алсын хараа 2050”, ХАНСХЕТ баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах, зөрүүтэй асуудлуудыг шийдвэрлэх талаар санал дэвшүүлж, хуралд оролцогчдоос ирүүлсэн саналуудад хариу тайлбар өгсөн. Хурлын дараа хуралд оролцогч нэг зөвлөхөөс санал ирүүлсэн бөгөөд ЖАЙКА-гийн Төслийн баг хариултыг бичгээр хүргүүлсэн.

5 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан хурлаар ЖАЙКА-гийн Төслийн баг ҮХЦТ-ний хүрээнд “Алсын хараа 2050 баримт бичгийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” сэдвээр илтгэл тавьсан. ЖАЙКА-гийн Төслийн баг нь ҮХЦТ болон Алсын хараа 2050 баримт бичгийн ижил төстэй төлөвлөлтийн шийдлийг онцолж, ХАНСХЕТ, БХБ-д тусгах тэдгээрийн ялгаатай шийдлийн талаар тодруулсан. Дээр дурдсан асуудлууд, төлөвлөлтөөс гадна ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй

эдийн засгийн шинэ бүсчлэл, Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр, Бүсийн зөвлөлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.

## **9.2 ҮХЦТ-ний төсөл, хөтөлбөрүүдийн эхний үе шатны үнэлгээний систем**

### **9.2.1 Төсөл, хөтөлбөрүүдийн үнэлгээний систем**

#### **(1) Үнэлгээний системийн хэрэгцээ шаардлага**

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн “Эцсийн тайлангийн төсөл 1”-д хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг тусгасан бөгөөд төслийн дараагийн үе шатанд эдгээр төсөл, хөтөлбөрүүдийг нэмж боловсруулахаар төлөвлөж байна. Хэрэгжүүлэгч байгууллагууд, салбар хоорондын уялдаа холбоог хангах замаар тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохын тулд төслүүдийг үнэлэх шаардлагатай. Түүнчлэн тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүд нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үндэсний төсөл, хөтөлбөрүүдтэй нийцэж байх шаардлагатай. “Алсын хараа 2050” ба ҮХЦТ-ний хоорондын уялдаа холбоог хангахын тулд тус хоёр баримт бичигт тусгагдсан төсөл, хөтөлбөрүүдийг эрэмбэлэх үнэлгээний системийг бий болгох шаардлагатай.

#### **(2) Төсөл, хөтөлбөрүүдийн үнэлгээний систем**

Төслийг боловсруулах, үнэлэх зарчим нь: 1) хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, 2) зорилтод нийцүүлэн үнэлэх юм. Тиймээс үнэлгээний шалгуурыг ҮХЦТ-ний хөгжлийн зорилтуудад үндэслэн тодорхойлно. ҮХЦТ нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөгжлийн гурван зорилтыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- (a) Хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн бүтэц, экспортыг төрөлжүүлэх (эдийн засгийн хөгжлийн зорилт);
- (b) Ядуурал, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгахын тулд хөдөө, орон нутаг, төв суурин газруудад өгөөжтэй, тогтвортой ажил эрхлэх боломжийг бий болгох (нийгмийн хөгжлийн зорилт);
- (c) Улаанбаатар хотын хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны хэт төвлөрлийн сөрөг үр дагаврыг арилгах замаар хотын байгаль орчны асуудлыг багасгах (байгаль орчны хөгжлийн зорилт).

Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийг онцлог шинжээр нь ялган хоорондын уялдаатай байдлыг хангахын тулд дараах байдлаар 4 ангилсан. Үүнд:

- I. Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд;
- II. Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд;
- III. Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд;
- IV. Ногоон хөгжлийг дэмжих төслүүд багтаж байна.

Үнэлгээний систем нь олон агентлаг, байгууллагуудын оролцоо бүхий төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах, үнэлэх үйл ажиллагааг хөнгөвчлөх үүднээс ҮХЦТ-ний бүтэцтэй нийцтэй, уялдаатай байна.

## 9.2.2 Үндэсний хөгжлийн үнэлгээний систем

### (1) Хоёр үе шат бүхий үнэлгээний систем

ҮХЦТ-нд санал болгож буй хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг үнэлэх тогтсон, цогц үнэлгээний системийг бий болгох шаардлагатай бөгөөд уг системийг “Алсын хараа 2050” баримт бичигт тусгагдах төслүүдийг үнэлэхэд мөн ашиглаж болно. Бодлого болон мастер төлөвлөгөөний түвшний тус үнэлгээ нь төсөл тус бүрийн үр нөлөөний тоон үнэлгээг гаргадаг төслийн үнэлгээнээс ялгаатай юм. Бодлого, мастер төлөвлөгөөний түвшний үнэлгээ нь өргөн хүрээний олон төрлийн төслийг хамарч төслүүдийн шууд бус, нийлмэл үр нөлөөг үнэлнэ. Ийм шууд бус, нийлмэл үр нөлөөг ихэвчлэн чанарын хувьд үнэлэх боломжтой. Энэ төрлийн үнэлгээ нь чанарын хувьд үнэлдэг ч олон талын асуудлыг хамарсан үнэлгээний өргөн хүрээг хадгалах шаардлагатай.

Үндэсний цогц хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг үнэлэхэд хоёр үе шат бүхий үнэлгээний системийг ашиглахыг санал болгож байна. 1-р үе шатанд олон талын асуудлыг хамарсан шалгуураар, өргөн хүрээнд чанарын үнэлгээ хийх буюу өөр өөр салбарын төсөл, хөтөлбөрүүдийг нэгдсэн байдлаар үнэлнэ. 2-р үе шатанд сонгосон индексүүдээр төслүүдэд тоон үнэлгээ хийнэ. Төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараа үнэлгээний индексийг хяналт, үнэлгээ хийхэд ашиглаж болно.

### (2) Үнэлгээний 1-р үе шатны ангилал ба шалгуур

ҮХЦТ-ний төсөл, хөтөлбөрүүдийн үнэлгээний 1-р үе шатанд олон ангилалт үнэлгээний систем (multi-account evaluation system)-ийг ашиглана. Энэхүү системийг хөгжиж буй зарим улс орнуудад бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт хийхэд ашигладаг бөгөөд анх АНУ-ын голын сав газрын удирдлагын төлөвлөлт (В түвшин)-ийг хийхэд зориулж боловсруулсан. Энэхүү системийг ашиглахдаа ҮХЦТ-ний төсөл, хөтөлбөрүүдийг улсын эдийн засгийн (УЭЗ) түвшний, бүс нутгийн хөгжлийн (БНХ) түвшний, нийгмийн хөгжлийн (НХ), байгаль орчны чанарын (БОЧ), институцийн (ИН) гэсэн 5 ангилалд авч үзнэ. Ангилал тус бүрт дөрвөн шалгуурыг тодорхойлж, төсөл, хөтөлбөрүүдийн үр нөлөөний чанарын үнэлгээг Хүснэгт 9.2.1-д нэгтгэн үзүүлэв.

Институцийн ангиллаас бусад ангилал нь ҮХЦТ-ний 4 ангилал бүхий төсөл, хөтөлбөрүүдтэй дараах байдлаар дүйцэж байна.

Үнэлгээний ангиллууд	ҮХЦТ-ний төсөл, хөтөлбөрүүд
Улсын эдийн засаг (УЭЗ):	Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх
Бүс нутгийн хөгжил (БНХ):	Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх
Нийгмийн хөгжил (НХ):	Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах
Байгаль орчны чанар	Ногоон хөгжлийг дэмжих

Бүс нутгийн хөгжлийн ангилал нь орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төсөл, хөтөлбөрүүдтэй дүйцэх төдийгүй бусад ангилалд багтсан олон талт төсөл, хөтөлбөрүүдэд хамааралтай. Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төсөл, хөтөлбөрүүд нь бүс нутгийг хөгжүүлэх замаар бүс нутгийн тэнцвэрийг хадгалахад хамгийн үр дүнтэй юм. Дээрх хүснэгтэд багтаагүй институцийн ангилал нь орон нутгийн хөгжлийн санаачилгуудыг төлөөлж болно. Орон нутгийн санаачилгаар хэрэгжих төслүүдийг тодорхойлохоор институцийн ангиллын үнэлгээг тусад нь авч үзэж болно.

### Хүснэгт 9.2.1 ҮХЦТ-ний 5 ангилал бүхий үнэлгээний шалгуурууд

Ангилал	Шалгуур	Үр нөлөөний үнэлгээ		
		Маш эерэг	Эерэг	Сөрөг
<b>1. Улсын эдийн засаг: ҮЭЗ</b>				
	1.1 Эдийн засгийн үр ашигт байдал	Эдийн засгийн өгөөжийн хувь өндөр	Эдийн засгийн өгөөжийн хувь дунд зэрэг	Төслийн зорилго биш
	1.2 Эдийн засгийг төрөлжүүлэхэд оруулах хувь нэмэр	Чухал хувь нэмэр оруулна	Зарим талаар хувь нэмэр оруулна	Хувь нэмэр бага эсвэл хувь нэмэр оруулахгүй
	1.3 Гадаад валютын гүйлгээний орлогод оруулах хувь нэмэр	Чухал хувь нэмэр оруулна	Зарим талаар хувь нэмэр оруулна	Хувь нэмэр бага эсвэл хувь нэмэр оруулахгүй
	1.4 Үзүүлэх технологийн дэмжлэг	Ихээхэн дэмжлэг үзүүлнэ	Боломжтой/ магадлалтай	Зорилгод тусгагдаагүй
<b>2. Бүс нутгийн хөгжил: БНХ</b>				
	2.1 Орлогын зөрүүг бууруулах үр нөлөө	Бага орлоготой иргэдийг дэмжинэ	Үр нөлөө бага эсвэл үр нөлөө үзүүлэхгүй	Сөрөг нөлөө
	2.2 Орон нутгийн ЖДҮ-ийг сэргээх үр нөлөө	Чухал хувь нэмэр оруулна	Зарим талаар хувь нэмэр оруулна	Хувь нэмэр бага эсвэл хувь нэмэр оруулахгүй
	2.3 Олон нийтийн хөгжил	Чухал зорилго болж орно	Зорилгод тусаагүй ч эерэг үр нөлөөтэй	Ач холбогдол бага эсвэл ач холбогдолгүй
	2.4 Орон нутгийн/нутгийн заяагдмал нөөцийн ашиглалт	Ихээр ашиглана	Зарим талаар ашиглана	Бага ашиглана
<b>3. Нийгмийн хөгжил: НХ</b>				
	3.1 Ажлын байр бий болгох үр нөлөө	Ажлын байрыг олноор бий болгоно	Ажлын байрыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлнэ	Харьцангуй цөөн тооны ажлын байрыг бий болгоно
	3.2 Нийгмийн үйлчилгээг сайжруулах үр нөлөө	Ихээхэн сайжруулна	Зарим талаар сайжруулна	Бага зэрэг сайжирна эсвэл сайжрахгүй
	3.3 Орон нутгийн соёлд үзүүлэх нөлөө	Эерэг нөлөө үзүүлнэ	Бага нөлөө үзүүлнэ эсвэл нөлөөлөхгүй	Сөрөг нөлөө үзүүлнэ
	3.4 Ядуурлыг бууруулах үр нөлөө	Чухал зорилго болж орно	Зорилгод тусаагүй ч эерэг үр нөлөөтэй	Ач холбогдол бага эсвэл ач холбогдолгүй
<b>4. Байгаль орчны чанар: БОЧ</b>				
	4.1 Байгалийн нөхцөлд тохиромжтой байдал	Орон нутгийн байгалийн нөхцөлд тохируулах боломжтой	Орон нутгийн байгалийн нөхцөлтэй зөрчилдөхгүй	Орон нутгийн байгалийн нөхцөлтэй зөрчилдөнө
	4.2 Газрын шаардлага, тохиромжтой байдал	Орон нутгийн газрын нөхцөлд тохируулах боломжтой	Орон нутгийн газрын нөхцөлд тохируулахад бага зэрэг хүндрэлтэй	Газрын шаардлага хэт өндөр ба/эсвэл зохисгүй газар ашиглалт

	4.3 Усны хэрэглээ, менежмент	Орон нутгийн усны нөөцөд тохируулах боломжтой	Орон нутгийн усны тэнцвэрт бага зэрэг дарамт учруулна	Орон нутгийн усны нөөцийг хэт ихээр ашиглана
	4.4 Байгаль орчны эмзэг байдлыг бууруулахад үзүүлэх нөлөө	Чухал хувь нэмэр оруулна	Зарим талаар хувь нэмэр оруулна	Хувь нэмэр бага эсвэл хувь нэмэр оруулахгүй
<b>5. Институц: ИН</b>				
	5.1 Хэрэгжилт	Хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг тодорхойлсон	Хэрэгжүүлэх боломжит аж ахуйн нэгжүүд бий	Хэрэгжүүлэх зохицуулалт хараахан байхгүй
	5.2 Орон нутгийн иргэдийн оролцоо	Орон нутгийн иргэд төсөлд оролцоно	Орон нутгийн иргэд оролцоно гэсэн хүлээлттэй	Орон нутгийн иргэд оролцоно гэсэн хүлээлт байхгүй
	5.3 Нутагшуулалтыг дэмжих	Чухал хувь нэмэр оруулна	Зарим талаар хувь нэмэр оруулна	Хувь нэмэр бага эсвэл хувь нэмэр оруулахгүй
	5.4 Орон нутгийн иргэдийн ухамсар /хариуцлага/ санаачилгад үзүүлэх нөлөө	Шууд нөлөө үзүүлнэ	Шууд бус нөлөө үзүүлнэ	Сөрөг нөлөө үзүүлнэ эсвэл нөлөөлөхгүй

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

5 ангилал бүхий үнэлгээний системийг макро, мезо, микро түвшинд хөгжлийн бүх төсөлд ашиглана. Аль түвшинд үнэлгээ хийж байгаагаас хамааран аль ангилалд илүү ач холбогдол өгөх нь ялгаатай байна. Ангилал тус бүрийн ач холбогдлоос хамааран тусад нь авч үзэх ИН ангиллаас бусад 4 ангилалд хувийн жин ялгаатай байна. Макро түвшинд УЭЗ, мезо түвшинд БНХ, микро түвшинд НХ-ийг илүү онцолж болно. Түвшин тус бүр дэх үнэлгээний боломжит хувийн жинг жишээ болгон Хүснэгт 9.2.2-т үзүүлэв.

### **Хүснэгт 9.2.2 Макро, мезо, микро түвшний үнэлгээний 4 ангилал тус бүрийн хувийн жин**

Ангилал	Төсөл, хөтөлбөрүүд	Макро	Мезо	Микро
УЭЗ	Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх	0.40	0.20	0.10
БНХ	Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх	0.20	0.40	0.20
НХ	Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах	0.20	0.20	0.40
БОЧ	Ногоон хөгжлийг дэмжих	0.20	0.20	0.30

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### **(3) Үнэлгээний 2-р үе шат**

Үнэлгээний 1-р үе шатанд макро, мезо, микро түвшин тус бүрээр тэргүүлэх чиглэлийн төслүүдийг сонгохын тулд төслийг эрэмбэлсэн. Сонгогдсон тэргүүлэх чиглэлийн төслүүдийг 2-р үе шатанд дахин үнэлэх бөгөөд ингэхдээ аль болох тоон шалгуурыг ашиглана. Үнэлгээний 2-р үе шатанд тэргүүлэх чиглэлийн төслүүдийг 1) дэд бүтэц, 2) эдийн засаг, 3) нийгмийн гэсэн 3 төрөлд хуваана.

Эдгээр гурван төрлийн төслийн үнэлгээг нийт оноонд үндэслэн харьцуулах боломжгүй юм. Учир нь эдгээр төслүүд онцлог, үр нөлөөний хувьд ялгаатай. Үнэлгээний 2-р үе шатанд ашиглах шалгуур үзүүлэлтүүд, гурван төрлийн төслүүдэд өөр өөр шалгуурыг ашиглах боломжийг Хүснэгт 9.2.3-т тусгасан болно.

### Хүснэгт 9.2.3 Үнэлгээний 2-р үе шатны шалгуур, гурван төрлийн төслүүдэд ашиглах боломж

Шалгуур	Дэд бүтэц	Эдийн засаг	Нийгэм
1) Хөрөнгө оруулалтын зардал	✓	✓	✓
2) Ашиглалт, засвар үйлчилгээний зардал	✓		✓
3) Ажлын байрыг нэмэгдүүлэх		✓	✓
4) Эдийн засгийн өгөөжийн хувь эсвэл үр ашиг зардлын харьцаа	✓	✓	
5) Гадаад валютын гүйлгээний орлого	✓	✓	

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### 9.2.3 ҮХЦТ-ний төсөл, хөтөлбөрүүдийн үнэлгээ

#### (1) Төсөл, хөтөлбөрүүдийн үнэлгээ

5 ангилал бүхий үнэлгээний системийг ҮХЦТ-нд тусгасан бүх төслийг үнэлэхэд ашигласан. 1-р үе шатны үнэлгээг хийсэн бөгөөд үр дүнг төслийн ангиллаар Хүснэгт 9.2.4 – 9.2.7-д үзүүлэв. Эдгээр хүснэгтэд төсөл, хөтөлбөр тус бүрийг үнэлгээний 5 ангиллын 4 шалгуур тус бүрээр “0”-маш сайн, “1”-сайн эсвэл “2”-муу гэсэн оноогоор үнэлсэн. Үнэлгээний ангилал тус бүрийн оноог гаргахдаа 4 шалгуурын оноог нэмсэн ба нийт оноог гаргахдаа бүх 5 ангиллын оноог нэмсэн. Нийт оноог тооцоходоо үнэлгээний бүх ангилалд ижил хувийн жин өгсөн.

Хүснэгт 9.2.4 – 9.2.7-д тусгасан дараах үр дүнг онцолж байна. Үүнд:

- Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх 31 төсөл, хөтөлбөрийг үнэлсэн бөгөөд гол 9 төсөл, хөтөлбөрөөс “Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл” 13 оноо авч, бусад нь 20-иос дээш оноо авсан.
- Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх бусад төсөл, хөтөлбөрүүд 12-17 оноо авсан байна.
- Чацарганы үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх төсөл, Чацаргана тариалах төслүүд 30-аас дээш оноо авсан.
- Аялал жуулчлалын салбарын 6 төсөл, хөтөлбөрүүдээс гол төсөл болох ““Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолборуудыг байгуулах төсөл” хамгийн өндөр оноо буюу 28 оноо авсан байна.
- Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах 20 төсөл, хөтөлбөрийг үнэлсэн бөгөөд гол 7 төсөл, хөтөлбөр 25-аас дээш оноо авсан. Бусад төсөл, хөтөлбөрөөс “Малчдын цогц мэдээллийн санг бий болгох төсөл” 26 оноо авч бусад нь 20-иос бага оноо авсан.
- ҮХЦТ-нд тусгасан орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх 10 төсөл, хөтөлбөрийг үнэлсэн бөгөөд гол 5 төсөл, хөтөлбөр 17-оос дээш оноо авсан бол бусад төсөл, хөтөлбөрүүд 17 болон түүнээс доош оноо авсан.

- (g) Гол төсөл, хөтөлбөрт багтаагүй төслүүдээс “Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах төсөл” хамгийн өндөр буюу 17 оноо авсан
- (h) Ногоон хөгжлийг дэмжих 17 төсөл, хөтөлбөрийг үнэлсэн бөгөөд гол 8 төсөл, хөтөлбөрүүд 23-29 оноо авсан. Бусад 8 төсөл, хөтөлбөрүүд 11-15 оноо авсан.



**Хүснэгт 9.2.4 Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн  
1-р шатны үнэлгээ**

Ангилал	Шалгуур	1.1 Хилийн Чөлөөт худалдааны бүс болон ЭЗ-ийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл	1.2 Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ бүгдэлтэй ЭЗ-ийн тусгай бүсийг хөгжүүлэх төсөл	2.1 Чацарганы үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл	2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл	3.1 Ухаалаг хөдөө аж ахуйг дэмжих төсөл	3.2 Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл	3.3 Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркыг хөгжүүлэх төсөл	4.1 Тэгжлэлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл	4.2 Мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх төсөл*	5.1 Усжуулалтын төсөл	5.2 Тосны ургамлын тариалалтын төсөл	5.3 Чацарганы тариалалтын төсөл	6.1 Үхрийн аж ахуй эрхлэх төсөл	6.2 Эрдэнэ шиш дэршлах үйлдвэрлэлийн төсөл	6.3 Малын тэгжлэлийн төв байгуулах төсөл	6.4 Хуурай сүү үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх төсөл	7.1 Хөргүүр, зөөрийн сүлжээ байгуулах төсөл	7.2 Хүнний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл	8.1 Газрын ховор элементийн хайгуулын төсөл	8.2 Эрдэс металлын нөөцийн хайгуулын төсөл	9.1 Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл	9.2 Нүүрсний ордын хайгуулын төсөл	9.3 Нүүрсний салбарын мастер төлөвлөгөөг боловсруулах төсөл	9.4 Нүүрс боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх төсөл	10.1 Улаг гүрвэлийн музей байгуулах төсөл	10.2 "Өртөө" авто зам дагуух үйлчилгээний цогцлоборудыг байгуулах төсөл	10.3 Гэр хороололд гар урлалын гудамж байгуулах төсөл	10.4 Евлин спорт, амралтын төв байгуулах төсөл	10.5 Палайхын урхайн музей, соёл, боловсролын төв байгуулах төсөл	10.6 Аялал жуулчлалын салбарын мэдээллийн сан байгуулах төсөл	10.7 Аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх төсөл
1. Улсын эдийн засаг: УЗЗ	Шалгуур	2	2	1	1	2	2	2	1	2	1	1	1	1	1	1	1	1	2	0	0	2	1	1	1	1	1	0	1	0	1	1
Дүн		8	8	7	7	6	7	8	3	7	4	4	4	3	4	4	4	5	7	6	5	6	5	4	4	4	3	1	3	1	3	4
2. Бус нутгийн хөгжил: БНХ	2.1 Орлогын зөрүүг бууруулах үр нөлөө	1	0	2	2	1	1	1	1	2	1	1	2	1	1	0	1	1	1	0	0	0	0	1	0	1	1	1	1	0	1	1
	2.2 Орон нутгийн ЖДҮ-ийг сэргээх үр нөлөө	1	1	2	1	0	1	1	0	2	0	0	2	0	0	0	1	1	1	0	0	0	0	1	0	1	2	1	1	0	1	1
	2.3 Орон нийтийн хөгжил	0	0	2	1	0	1	0	1	2	0	0	2	1	1	0	0	0	0	0	0	0	1	1	0	1	2	2	1	1	1	2
	2.4 Орон нутгийн/нутгийн заяагдмал нөөцийн ашиглалт	1	1	2	2	1	1	1	1	2	1	1	2	1	1	1	1	1	1	1	1	2	1	2	1	2	1	1	1	1	1	2
Дүн		3	2	8	6	2	4	3	3	8	2	2	8	3	3	1	3	3	3	1	1	2	2	4	2	4	7	5	4	2	4	6
3. Нийгмийн хөгжил: НХ	3.1 Ажлын байр бий болгох үр нөлөө	2	2	2	2	0	1	1	1	1	0	1	1	1	1	0	0	1	0	0	0	0	0	1	1	1	1	1	1	0	1	1
	3.2 Нийгмийн үйлчилгээг сайжруулах үр нөлөө	0	0	0	0	0	0	0	0	2	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	1
	3.3 Орон нутгийн соёлд үзүүлэх нөлөө	0	0	1	2	0	0	0	0	2	0	0	1	1	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	1	2	1	1	1	1	1
	3.4 Ядуурлыг бууруулах үр нөлөө	1	0	2	2	1	1	1	1	2	1	1	2	1	1	1	1	1	1	0	0	0	0	1	1	1	2	1	1	1	1	1
Дүн		3	2	5	6	1	2	2	2	7	1	2	4	3	2	1	1	3	2	0	0	0	0	2	2	3	5	3	4	3	4	4
4. Байгаль орчны чанар БОЧ	4.1 Байгалийн нөхцөлд тохиромжтой байдал	1	0	2	2	1	1	1	1	2	1	1	2	2	1	1	0	1	1	1	1	1	1	1	0	1	2	1	1	1	1	1
	4.2 Газрын шаардлага ба тохиромжтой байдал	1	1	2	2	1	2	1	1	2	1	1	2	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1
	4.3 Усны хэрэглээ ба менежмент	1	0	1	2	1	2	1	1	2	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	0	1	1	1	1	1	1	1
	4.4 Байгаль орчны эмзэг байдлыг бууруулахад үзүүлэх нөлөө	0	0	2	2	1	1	1	1	2	1	1	2	1	2	1	0	1	1	0	0	0	0	1	1	0	1	0	0	0	0	1
Дүн		3	1	7	8	4	6	4	4	8	4	4	7	5	5	4	2	4	6	3	3	3	3	4	2	3	6	3	3	3	3	4
5. Институц: ИН	5.1 Хэрэгжилт	1	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	0	0	0	0	0	1	1	1	2	1	0	1	1	1	1	0	1	0	0
	5.2 Орон нутгийн иргэдийн оролцоо	0	0	1	2	0	1	0	1	2	1	1	2	1	1	1	1	0	1	0	0	0	1	1	1	1	2	2	1	1	1	1
	5.3 Нутагшуулалтыг дэмжих	0	0	2	2	0	1	1	0	2	0	0	2	1	0	0	0	0	1	0	0	0	1	1	0	0	2	0	1	1	1	2
	5.4 Орон нутгийн иргэдийн ухамсар/ хариуцлага/ санаачилгад үзүүлэх нөлөө	0	0	2	2	0	1	1	1	2	0	1	2	1	1	1	1	1	1	0	0	0	0	1	0	1	2	1	1	0	1	1
Дүн		1	1	6	7		4	3	3	7	3	3	7	3	2	2	2	1	4	1	1	2	3	3	2	3	7	4	3	3	3	4
Нийт оноо		18	14	33	34	13	23	20	15	37	14	15	30	17	16	12	12	16	22	11	10	13	13	17	12	17	28	16	17	12	17	22

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

**Хүснэгт 9.2.5 Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төсөл, хөтөлбөрүүдийн 1-р шатны үнэлгээ**

Ангилал	Шалгуур	II1.1 Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл	II1.2 Малчдын хүүхдэд гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл	II2.1 Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл	II2.2 Малчдын цогц мэдээллийн санг бий болгох төсөл	II3 Залуучууд, насанд хүрэгчдийн үр чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл	II4 Залуу эмэгтэйчүүдийн ажил, мөргөжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр	II5 Бизнес чиглэсэн хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр	II6 Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл	II7.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл	II7.2 Эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах төсөл	II7.3 Хүний дархал хомсдолын вирус (ХДХВ), тэмбүү, гепатитын халдвар эхээс хүүхдэд дамжихаас урьдчилан сэргийлэх төсөл	II7.4 Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө өгөх Г елемединцн/ болон Оношлогооны зорилго бүхий эрүүл мэндийн хөдөлгөөнт цахим	II8 Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн төсөл	II9.1 Булгийн динамикийн төв байгуулах төсөл	II9.2 Гүйцэтгэлийг үр дүнтэй болгоход чиглэсэн үйл ажиллагааны зөвлөгөө өгөх хөтөлбөр	II10.1 МХХТ-д суурилан боловсролын салбарыг бэхжүүлэх төсөл	II10.2 Хөдөө, орон нутагт МХХТ-ийг хөгжүүлэх, МХХТ-т суурилсан загвар хэргийг хөгжүүлэх	II10.3 Хөдөө, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээллийн нэгдсэн салжээ байгуулах төсөл	II10.4 Програмын хангамжийн аугсрсингийг дэмжих төсөл	II10.5 МХХТ-ийн экосистемийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх төсөл	
1. Улсын эдийн засаг: УЭЗ																						
1.1 Эдийн засгийн үр ашигт байдал		1	0	1	0	1	2	2	1	1	0	0	1	0	2	1	1	1	1	2	2	
1.2 Эдийн засгийг төрөлжүүлэхэд оруулах хувь нэмэр		1	0	1	0	1	2	1	2	1	0	0	0	0	1	1	1	1	1	2	1	
1.3 Гадаад валютын гүйлгээний орлогод оруулах хувь нэмэр		0	0	0	0	0	1	1	2	1	0	0	0	0	1	0	0	0	0	2	1	
1.4 Үзүүлэх технологийн дэмжлэг		1	1	1	1	0	1	1	2	1	1	1	1	1	0	1	1	1	1	2	2	
Дүн		3	1	3	1	2	6	5	7	4	1	1	2	1	4	3	3	3	3	8	6	
2. 2. Бүс нутгийн хөгжил: БНХ																						
2.1 Орлогын зөрүүг бууруулах үр нөлөө		2	0	1	1	1	2	1	2	2	0	0	0	1	2	1	2	1	1	0	1	
2.2 Орон нутгийн ЖДҮ-ийг сэргээх үр нөлөө		2	0	2	1	1	1	1	2	1	0	0	0	1	1	1	1	1	1	1	1	
2.3 Олон нийтийн хөгжил		2	2	2	2	2	1	0	1	2	1	1	1	1	2	1	1	1	1	0	1	
2.4 Орон нутгийн/нутгийн заяагдмал нөөцийн ашиглалт		2	1	1	1	1	1	0	2	1	0	1	1	0	1	1	1	0	0	0	0	
Дүн		8	3	6	5	5	5	2	7	6	1	2	2	3	6	4	5	3	3	1	3	
3. 3. Нийгмийн хөгжил: НХ																						
3.1 Ажлын байр бий болгох үр нөлөө		2	0	1	1	1	2	1	2	2	0	1	0	0	1	1	1	1	1	1	1	
3.2 Нийгмийн үйлчилгээг сайжруулах үр нөлөө		2	2	2	2	1	2	0	2	2	2	2	2	2	2	1	2	2	1	0	1	
3.3 Орон нутгийн соёлд үзүүлэх нөлөө		2	2	1	2	1	1	0	1	1	0	1	1	1	2	0	0	0	1	0	1	
3.4 Ядуурлыг бууруулах үр нөлөө		2	2	2	2	1	2	1	1	2	1	1	1	2	1	0	1	1	1	1	1	
Дүн		8	6	6	7	4	7	2	6	7	3	5	4	5	6	2	4	4	4	2	4	
4. Байгаль орчны чанар: БОЧ																						
4.1 Байгалийн нөхцөлд тохиромжтой байдал		2	2	2	2	1	1	0	2	1	1	1	1	0	0	1	0	0	0	0	0	
4.2 Газрын шаардлага ба тохиромжтой байдал		2	1	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
4.3 Усны хэрэглээ ба менежмент		2	1	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	
4.4 Байгаль орчны эмзэг байдлыг бууруулахад үзүүлэх нөлөө		2	1	2	2	1	1	0	2	2	1	1	1	1	1	0	0	0	1	1	1	
Дүн		8	5	8	6	4	4	2	6	5	4	4	4	3	3	3	1	1	2	2	2	
5. Институци																						
5.1 Хэрэгжилт		0	1	0	1	1	1	1	2	2	2	1	1	2	0	0	0	0	0	1	1	

5.2 Орон нутгийн иргэдийн оролцоо	2	2	2	2	2	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	0	1
5.3 Нутагшуулалтыг дэмжих	2	2	2	2	1	1	0	1	1	1	0	0	0	2	0	1	1	1	0	1
5.4 Орон нутгийн иргэдийн ухамсар/хариуцлага/санаачилгад үзүүлэх нөлөө	2	2	2	2	1	1	1	1	1	0	0	0	1	2	0	1	1	1	0	1
Дүн	6	7	6	7	5	4	3	5	5	4	2	2	4	6	1	3	3	3	1	4
Нийт оноо	3 3	2 2	2 9	2 6	2 0	2 6	1 4	3 1	2 7	1 3	1 4	1 4	1 6	2 5	1 3	1 6	1 4	1 5	1 4	1 9

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Хүснэгт 9.2.6 Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн 1-р шатны үнэлгээ

Ангилал	Шалгуур	III.1. Автозамын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл	III.2. Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл	III.3. Аймгуудын тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах төсөл	III.4. Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл	III.5. Хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл	III.6. Улаанбаатар хотын тойруу зам ба сүлжээг хөгжүүлэх төсөл	III.7. Улаанбаатар хотын ачаа тээврийн терминалын газрыг дахин төлөвлөн байгуулах төсөл	III.8. Хотын захын болон тойруу замын дагуух орон нутгийн хотуудыг хөгжүүлэх төсөл	III.9. Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлын дагуул хот байгуулах төсөл	III.10. Орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэх төсөл	III.11. Бусийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх төсөл	III.12. Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах төсөл
1. Улсын эдийн засаг: УЗЗ	1.1 Эдийн засгийн үр ашигт байдал	2	1	1	2	2	1	1	1	2	1	2	1
	1.2 Эдийн засгийг төрөлжүүлэхэд оруулах хувь нэмэр	2	1	2	2	2	1	1	0	2	2	2	1
	1.3 Гадаад валютын гүйлгээний орлогод оруулах хувь нэмэр	2	1	1	2	2	1	1	0	2	1	2	1
	1.4 Үзүүлэх технологийн дэмжлэг	1	0	1	1	1	0	1	0	2	1	1	1
Дүн	7	3	5	7	7	3	4	1	8	4	7	7	
2. Бус нутгийн хөгжил: БНХ	2.1 Орлогын зөрүүг бууруулах үр нөлөө	2	2	2	0	1	0	0	1	1	2	2	2
	2.2 Орон нутгийн ЖДҮ-ийг сэргээх үр нөлөө	1	2	2	0	0	0	1	0	0	2	2	1
	2.3 Олон нийтийн хөгжил	1	1	2	1	1	0	1	0	1	1	1	1
	2.4 Орон нутгийн/нутгийн заяагдмал нөөцийн ашиглалт	1	2	2	0	1	0	1	0	1	2	2	0
Дүн	5	7	8	1	3	0	3	1	3	7	7	7	
3. Нийгмийн хөгжил: НХ	3.1 Ажлын байр бий болгох үр нөлөө	1	1	2	1	1	0	1	0	2	2	2	1
	3.2 Нийгмийн үйлчилгээг сайжруулах үр нөлөө	1	2	2	0	1	1	0	1	2	1	2	1
	3.3 Орон нутгийн соёлд үзүүлэх нөлөө	0	2	1	0	1	0	0	1	1	1	1	0
	3.4 Ядуурлыг бууруулах үр нөлөө	1	1	2	0	1	0	0	0	0	1	1	1
Дүн	3	6	7	1	4	1	1	2	5	5	6	6	
4. Байгаль орчны чанар: БОЧ	4.1 Байгалийн нөхцөлд тохиромжтой байдал	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	0
	4.2 Газрын шаардлага ба тохиромжтой байдал	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1
	4.3 Усны хэрэглээ ба менежмент	2	1	1	1	1	2	1	1	0	0	1	1
	4.4 Байгаль орчны эмзэг байдлыг бууруулахад үзүүлэх нөлөө	1	2	2	1	1	1	1	2	1	1	2	2
Дүн	5	5	5	5	4	5	5	5	3	3	3	5	
5.1 Хэрэгжилт	2	2	1	2	2	2	1	1	2	1	1	1	

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл  
Эцсийн тайлан

	5.2 Орон нутгийн иргэдийн оролцоо	0	1	1	1	0	0	1	0	1	1	1	1
	5.3 Нутагшуулалтыг дэмжих	1	2	2	0	0	0	0	1	0	2	2	0
	5.4 Орон нутгийн иргэдийн ухамсар /хариуцлага/ санаачилгад үзүүлэх нөлөө	0	1	2	0	0	1	0	0	0	1	1	0
Дүн		3	6	6	3	2	3	2	2	3	5	5	2
Нийт оноо		23	27	31	17	20	12	15	11	22	24	30	17

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Хүснэгт 9.2.7 Ногоон хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн 1-р шатны үнэлгээ

Ангилал	Шалгуур	IV1. Хөрс хамгаалах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх төсөл	IV2.1 Хүнсний бүтээгдэхүүний хаягдалыг бууруулах төсөл	IV2.2 Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл	IV2.3 Цементийн үйлдвэрийг ашиглан хатуу хог хаягдлыг эргэлтэд оруулах төсөл	IV2.4 Эко-парк байгуулах төсөл	IV3.1 Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл	IV3.2 Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл	IV4. Хог хаягдалыг байгаль орчинд сөрөг нөлөөллийг гээг газарт булшилж хадгалах байгууламж-ландфилл байгуулах төсөл	IV5.1 Насжилт урттай барилга байгууламжийг барьж байгуулах төсөл	IV5.2 Хот байгуулалтын салбарын хууль эрх зүйн баримт бичгийн уялдааг хангах, эрх зүйн тогтолцоог шинэчлэх төсөл	IV6. Туул голын усан цогцолбор байгуулах төсөл	IV7.1 Хот, суурин газрын усан хангамжийг сайжруулах төсөл	IV7.2 Хөдөөгийн усан хангамжийг сайжруулах төсөл	IV8.1 Бохир ус цэвэрлэх байгууламж барих, шинэчлэх төсөл	IV8.2 Улаанбаатар хотын Дулааны цахилгаан станцуудын ашигласан усыг цэвэрлэх байгууламж барьж байгуулах төсөл	IV8.3 Ариутгах татуургын сүлжээг шинэчлэх, өргөтгөх төсөл	IV8.4 Сумын төвийн бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл	IV8.5 Мал аж ахуйн фермийн бохир усыг цэвэрлэх байгууламж барих төсөл	IV9. Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөл	IV10 Орон нутгийн эрчим хүчний сүлжээг хөгжүүлэх төсөл	
1. Улсын эдийн засаг: УЗЗ	1.1 Эдийн засгийн үр ашигт байдал	0	0	2	1	2	1	1	0	0	1	2	2	1	1	0	0	1	1	0	2	1
	1.2 Эдийн засгийг төрөлжүүлэхэд оруулах хувь нэмэр	0	0	2	1	2	1	0	0	0	0	2	2	0	0	0	0	1	1	0	2	1
	1.3 Гадаад валютын гүйлгээний орлогод оруулах хувь нэмэр	0	1	2	0	2	0	0	0	0	1	2	1	0	0	0	0	0	0	0	2	1
	1.4 Үзүүлэх технологийн дэмжлэг	1	1	2	2	2	2	0	1	2	2	1	2	1	0	1	1	0	1	1	1	2
	Дүн	1	2	8	4	8	2	2	2	3	3	8	6	1	2	2	1	2	2	7	5	
2. Бус нутгийн хөгжил: БНХ	2.1 Орлогын зөрүүг бууруулах үр нөлөө	0	0	1	0	1	2	1	0	0	0	1	1	1	0	0	0	1	0	1	1	
	2.2 Орон нутгийн ЖДҮ-ийг сэргээх үр нөлөө	0	0	2	1	2	1	1	0	1	1	1	1	1	1	0	0	2	1	1	1	
	2.3 Олон нийтийн хөгжил	0	0	0	0	0	2	2	0	0	1	1	1	1	0	0	0	2	1	0	1	
	2.4 Орон нутгийн/нутгийн заяагдмал нөөцийн ашиглалт	1	1	2	2	2	1	1	1	0	0	2	2	1	0	0	2	1	2	2		
	Дүн	1	1	5	3	5	6	5	1	1	2	5	5	4	1	1	0	7	3	4	5	
3. Нийгмийн хөгжил: НХ	3.1 Ажлын байр бий болгох үр нөлөө	0	0	2	1	2	1	1	0	0	1	1	1	1	0	0	0	1	0	1	1	
	3.2 Нийгмийн үйлчилгээг сайжруулах үр нөлөө	0	0	0	0	0	2	2	1	1	1	2	1	1	1	1	1	2	1	2	1	
	3.3 Орон нутгийн соёлд үзүүлэх нөлөө	0	1	1	0	1	1	1	0	0	2	0	1	0	1	0	0	2	1	1	0	
	3.4 Ядуурлыг бууруулах үр нөлөө	1	1	1	1	1	2	1	0	0	0	1	1	1	1	0	0	2	1	1	1	
	Дүн	1	2	4	2	4	6	5	1	1	4	3	5	3	2	1	1	7	3	5	3	
4. Байгаль орчны чанар: БОЧ	4.1 Байгалийн нөхцөлд тохиромжтой байдал	2	1	1	1	1	2	2	1	1	1	1	1	0	1	1	2	1	1	2	1	
	4.2 Газрын шаардлага ба тохиромжтой байдал	2	1	2	1	1	1	1	1	1	0	0	2	1	1	1	1	1	2	1	1	
	4.3 Усны хэрэглээ ба менежмент	1	1	1	1	1	1	1	1	1	0	2	1	1	1	1	2	2	1	2	1	
	4.4 Байгаль орчны эмзэг байдлыг бууруулахад үзүүлэх нөлөө	2	1	2	1	2	2	2	2	2	1	2	2	2	1	1	2	1	2	2	1	
	Дүн	7	4	6	4	5	6	6	5	4	3	5	6	3	4	7	5	6	7	5	4	
5. И	5.1 Хэрэгжилт	1	0	2	0	1	1	1	1	1	1	2	2	1	1	1	1	1	0	2	0	
	5.2 Орон нутгийн	1	1	0	1	0	2	2	0	0	1	1	0	1	0	0	1	2	2	0	0	

иргэдийн оролцоо																				
5.3 Нутагшуулалтыг дэмжих	0	0	0	0	0	1	1	0	0	0	1	0	1	1	0	1	2	1	0	1
5.4 Орон нутгийн иргэдийн ухамсар /хариуцлага/ санаачилгад үзүүлэх нөлөө	1	1	0	1	0	1	2	1	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1
Дүн	3	2	2	2	1	5	6	2	2	3	5	3	4	3	2	4	7	4	3	2
Нийт оноо	13	11	25	15	23	25	24	11	11	15	26	25	15	12	13	11	29	19	24	19

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## (2) Гол төсөл, хөтөлбөрүүдийн макро, мезо, микро түвшний үнэлгээ

Макро, мезо, микро түвшний ач холбогдлоос хамааран үнэлгээний 5 ангилал тус бүрт харилцан адилгүй хувийн жинг өгч болно. Хүснэгт 9.2.2-т тусгасан хувийн жинг ИН ангиллаас бусад 4 ангилалд ашиглан үр дүнг Хүснэгт 9.2.8-д нэгтгэв.

### Хүснэгт 9.2.8 Гол төсөл, хөтөлбөрүүдийн макро, мезо, микро түвшний нэгдсэн үнэлгээ

	УЭЗ	БНХ	НХ	БОЧ	ИН	Макро	Мезо	Микро
I1.1 Хилийн Чөлөөт худалдааны бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл	8	3	3	3	1	5	4	3.5
I2.1 Чацарганы үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл	7	8	5	7	6	6.8	7	6.4
I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл	6	6	6	7	7	6.2	6.2	6.3
I3.2 Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл	7	4	2	6	4	5.2	4.6	4.1
I3.3 Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркуудыг хөгжүүлэх төсөл	8	3	2	4	3	5	4	3.4
I4.2 Мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх төсөл*	7	8	7	8	7	7.4	7.6	7.5
I5.3 Чацарганы тариалалтын төсөл	4	8	4	7	7	5.4	6.2	5.7
I7.2 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл	7	3	2	6	4	5	4.2	3.9
I9.1 Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл	5	2	0	3	2	3	2.4	1.8
I10.4 “Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолборуудыг байгуулах төсөл	3	7	5	6	7	4.8	5.6	5.5
II1.1 Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл	3	8	8	8	6	6	7	7.5
II2.1 Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл	3	6	6	8	6	5.2	5.8	6.3
II3 Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл	7	5	5	4	4	5.6	5.2	4.9
II4.4 Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр	6	5	7	4	4	5.6	5.4	5.6
II4.6 Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл	7	7	6	6	5	6.6	6.6	6.3
II7.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл	4	6	7	5	5	5.2	5.6	5.9
II8.1 Бүлгийн динамикийн төв байгуулах төсөл	4	6	6	3	6	4.6	5	4.9

III1 Автозамын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл	7	5	3	5	3	5.4	5	4.4
III2 Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл	3	7	6	5	6	4.8	5.6	5.6
III3. Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл	7	1	1	4	3	4	2.8	2.5
III4 Хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл	7	3	4	4	2	5	4.2	4.1
III8. Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлын дагуул хот байгуулах төсөл	8	3	5	3	3	5.4	4.4	4.3
IV2.2 Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл	8	5	4	6	2	6.2	5.6	5.2
IV2.4 Эко-парк байгуулах төсөл	8	5	4	5	1	6	5.4	4.9
IV3.1 Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл	2	6	6	6	5	4.4	5.2	5.6
IV3.2 Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл	2	5	5	6	6	4	4.6	5
IV6 Туул голын усан цогцолбор байгуулах төсөл	8	5	3	5	5	5.8	5.2	4.5
IV7.1 Хот, суурин газрын усан хангамжийг сайжруулах төсөл	6	5	5	6	3	5.6	5.4	5.4
IV8.4 Сумын төвийн бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл	2	7	7	6	7	4.8	5.8	6.2
IV12.Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөл	7	4	5	5	3	5.6	5	5

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Төсөл нь аль түвшинд хамгийн ач холбогдолтой буюу үр дүнтэй болохыг харуулахын тулд Хүснэгт 9.2.8-д хамгийн өндөр оноотой төслийг өнгөөр ялгасан. Гол 30 төсөл, хөтөлбөрүүдээс 17 төсөл нь макро түвшинд, 8 төсөл мезо түвшинд, 9 төсөл микро түвшинд илүү ач холбогдолтой байна. Орон нутгийн иргэдийн хөгжлийн талаарх ухамсар, хариуцлага, санаачилгыг илэрхийлсэн үнэлгээний ИН ангиллыг тусад нь авч үзсэн бөгөөд 6 эсвэл 7 гэсэн оноо авсан ач холбогдол бүхий 11 төслийг Хүснэгт 9.2.8-д мөн өнгөөр ялган онцолсон болно. Эдгээр төслүүдийг Засгийн газрын дэмжлэгтэйгээр орон нутгийн удирдлагын түвшинд хэрэгжүүлж болно. Мөн эдгээр төслүүдийг мезо, микро түвшинд үнэлэхэд харьцангуй өндөр оноо авсан.

### 9.3 Гол төсөл, хөтөлбөрүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ

#### 9.3.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний хамрах хүрээ, зорилго, үйл явц

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ (БОНБЕУ) нь төслийн эхний үе шатанд хийгддэг байгаль орчны нөлөөллийг судлах зорилго бүхий үнэлгээ юм. Байгаль орчны нөлөөллийг судалгаа, үнэлгээ нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБҮ) түвшинд нарийн байхгүй ч судалгааны цар хүрээ нь өргөн байдаг. БОНБЕУ-ний зорилго нь төсөл хэрэгжүүлэх явцад БОНБҮ хийх шаардлагатай эсэх, шаардлагатай тохиолдолд ямар цар хүрээг хамрах вэ зэргийг тодорхой болгодог.

БОНБЕУ нь ихэвчлэн үнэлгээ хийх, цар хүрээг тодорхойлох гэсэн 2 хэсгээс

бүрддэг. Зорилго нь тухайн төсөлд байгаль орчны асуудлыг авч үзэх шаардлагатай эсэхийг тодорхойлох, түүнчлэн байгаль орчны чухал асуудлууд болон төслийг хэрэгжүүлснээр байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоох юм. Энэ нь БОНБҮ-гийн хүрээнд хийх шаардлагатай судалгаануудыг тодорхойлоход ач холбогдолтой. Хөгжлийн мастер төлөвлөгөөний хөгжлийн төслүүдэд БОНБЕҮ-г хийх нь түгээмэл байдаг.

### 9.3.2 ҮХЦТ-ний гол төсөл, хөтөлбөрүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ

БОНБЕҮ-г ҮХЦТ-ний гол төсөл, хөтөлбөрүүдэд хийсэн бөгөөд ингэхдээ Монгол Улсын байгаль орчин, нийгмийн нөхцөл байдал, Монгол Улсад болон бусад улс орнуудад хэрэгжсэн ижил төстэй төслүүдийн туршлагыг үндэслэн нөлөөллийг бууруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ямар байхыг үнэлсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг Хүснэгт 9.3.1-д тусгасан үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хийсэн.

#### Хүснэгт 9.3.1 ҮХЦТ-ний гол төсөл, хөтөлбөрүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Ангилал	1. Танилцуулга, зөвшөөрөл	2. Бохирдлын хяналт	3. Байгаль орчин	4. Нийгмийн асуудлууд	5. Бусад
	1.1 БОНБҮ хийх зөвшөөрөл 1.2 Орон нутаг дахь оролцогч талуудад таниулах, тайлбарлах 1.3 Хувилбаруудын үнэлгээ	2.1 Агаарын чанар 2.2 Усны чанар 2.3 Хог хаягдал 2.4 Хөрсний бохирдол 2.5 Дуу чимээ, чичиргээ 2.6 Хөрсний суулт 2.7 Үнэр 2.8 Тунадас	3.1 ТХГН 3.2 Экосистем 3.3 Гидрологи 3.4 Байрзүй, геологи 3.5 Эвдэгдсэн, орхигдсон газруудын менежмент	4.1 Нүүлгэн шилжүүлэлт 4.2 Амьдрал, аж ахуй 4.3 Өв 4.4 Байгаль, газар нутгийн байдал 4.5 Үндэстний цөөнх ба нутгийн уугуул иргэд 4.6 Ажлын орчин	5.1 Барилгын ажлын нөлөө 5.2 Аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ 5.3 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Нөлөөллийн үнэлгээ бүр нь эерэг эсвэл сөрөг утгатай байна. Эерэг болон сөрөг нөлөөллийг урьдчилан тооцоолох боломжтой тохиолдолд 1 үнэлгээний шалгуурт “/” тэмдэглэгээ бүхий 2 утгыг харуулав. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлоход хүндрэлтэй байх тохиолдолд "А: нөлөө ихтэй байж болзошгүй", "В: нөлөө ямар нэг хэмжээгээр байж болзошгүй", "С: нөлөө үзүүлэх эсэх нь тодорхойгүй" тэмдэглэгээг тавьсан. Нөлөөллийн цар хүрээг төслийг хэрэгжүүлэх үе шатанд тодорхойлно.

Хүснэгт 9.3.2-т ҮХЦТ-ний гол төсөл, хөтөлбөрүүдийн БОНБЕҮ-г нэгтгэн харуулав. Мөн хүснэгтэд тус бүлгийн өмнөх хэсэгт танилцуулсан 5 ангилал бүхий үнэлгээний системийн үнэлгээний үр дүнг үзүүлэв. Гол төсөл, хөтөлбөр бүрийг дээрх 29 шалгуураар үнэлэв. "Танилцуулга, зөвшөөрөл" шалгуурын хувьд R буюу шаардлагатай, NR буюу шаардлагагүй үнэлгээг өгөв. "Бусад ангилал"-ын бусад шалгууруудын хувьд үнэлгээг "А: нөлөө ихтэй байж болзошгүй", "В: нөлөө ямар нэг хэмжээгээр байж болзошгүй", "С: нөлөө үзүүлэх эсэх нь тодорхойгүй" зэргээр



үнэллээ.

### **9.3.3 Дараагийн үе шатанд санал болгох үйл ажиллагаа**

"А: нөлөө ихтэй байж болзошгүй", "С: нөлөө үзүүлэх эсэх нь тодорхойгүй" үнэлгээ авсан байгаль орчны үнэлгээнүүдийн үндэслэл, төслийн дараагийн үе шатны зөвлөмжийг Хүснэгт 9.3.3-т нэгтгэн үзүүлэв.

**Хүснэгт 9.3.2 ҮХЦТ-ний хүрээний төсөл, хөтөлбөрүүдийн Байгаль орчны урьдчилсан үнэлгээний (өргөтгөсөн) үр дүн**

	N	R	S	E	I	Макро	Мезо	Микро	1.1	1.2	1.3	2.1	2.2	2.3	2.4	2.5	2.6	2.7	2.8	3.1	3.2	3.3	3.4	3.5	4.1	4.2	4.3	4.4	4.5	4.6	5.1	5.2	5.3
I1.1 Худалдааны чөлөөт бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих	8	3	3	3	1	5	4	3.5	R	R	R	B-	A-	A-	A-	B-	C-	B-	D	D	B-	D	D	D	A-	B-/A+	D	B-	D	B-	B-	D	D
I2.1 Чацарганы үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх	7	8	5	7	6	6.8	7	6.4	R	R	R	D	B-	B-	D	B-	D	D	D	D	B-	B+	D	B+	A-	B-/A+	D	C-	D	C-	B-	D	D
I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх	6	6	6	7	7	6.2	6.2	6.3	R	R	R	B-	B-	B-	B-	B-	D	A-	D	D	A-	D	D	B+	A-	B-/A+	D	B-	D	C-	B-	D	D
I3.2 Хүлэмжийн аж ахуйг дэмжих	7	4	2	6	4	5.2	4.6	4.1	R	R	R	D	B-	B-	D	D	D	D	D	D	B-	D	D	B+	A-	B-/A+	D	A-	D	B+	B-	D	D
I3.3 ХАА-н мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх	8	3	2	4	3	5	4	3.4	R	R	R	D	B-	B-	D	D	D	D	D	D	B-	D	D	B+	A-	B-/A+	D	B-	D	D	B-	D	D
I4.2 МАА-н салбарт МХТ-ийн хяналтын болон дэмжлэг үзүүлэх системийг нэвтрүүлэх	7	8	7	8	7	7.4	7.6	7.5	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	B+	D	D	D	D	D	D	B+
I5.3 Чацаргана тариалалтын төсөл	4	8	4	7	7	5.4	6.2	5.7	R/ NR	R/ NR	R/ NR	B+	B+	D	D	D	D	D	D	D	B-/B+	B+	D	B+	B-	B+	D	B+	D	D	B-	D	D
I7.2 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх	7	3	2	6	4	5	4.2	3.9	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	B+	D	D	D	D	D	D	D
I9 Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих	5	2	0	3	2	3	2.4	1.8	R	R	R	A-	B-	B-	B-	A-	D	D	D	D	B-	D	D	B+	B-	B-/A+	D	D	D	B-	B-	B-	A-
I10.2"Өртөө"авто зам дагуух үйлчилгээний цогцолбор	3	7	5	6	7	4.8	5.6	5.5	NR	NR	NR	D	B-	B-	B-	B-	D	D	D	D	B-	D	D	D	B-	A+	D	B-	D	D	B-	D	D
I11.1 Малчдыг дэмжих бааз байгуулах	3	8	8	8	6	6	7	7.5	NR	NR	NR	D	B-	B-	D	D	D	D	D	D	D	D	D	D	B-	B+	D	D	D	D	B-	D	D
I12.1 Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх	3	6	6	8	6	5.2	5.8	6.3	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	B+	D	D	D	D	D	D	D
I13. Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох	7	5	5	4	4	5.6	5.2	4.9	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	A+	D	D	D	D	D	D	D
I14.4 Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр	6	5	7	4	4	5.6	5.4	5.6	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	A+	D	D	D	D	D	D	D
I14.6 Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн хөтөлбөр	7	7	6	6	5	6.6	6.6	6.3	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	A+	D	D	D	D	D	D	D
I17.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах	4	6	7	5	5	5.2	5.6	5.9	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	B+	D	D	D	D	D	D	D
I18.1 Бүлгийн динамикийн төв байгуулах	4	6	6	3	6	4.6	5	4.9	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	B+	D	D	D	D	D	D	D
III1. Автозамын тойрог коридор байгуулах	7	5	3	5	3	5.4	5	4.4	R	R	R	B-	B-	B-	D	B-	D	D	D	C-	C-	C-	B-	D	B-	A+	D	B-	D	B-	A-	B-	B-

	N E	R D	S D	E Q	I N	Макро	Мезо	Микро	1.1	1.2	1.3	2.1	2.2	2.3	2.4	2.5	2.6	2.7	2.8	3.1	3.2	3.3	3.4	3.5	4.1	4.2	4.3	4.4	4.5	4.6	5.1	5.2	5.3	
III2. Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах	3	7	6	5	6	4.8	5.6	5.6	R	R	R	B-	B-	B-	D	B-	D	D	D	C-	C-	C-	B-	D	B-	A+	D	B-	D	B-	B-	B-	D	
III3. УБ хотыг тойрон гарах төмөр замын шугам сүлжээг барьж байгуулах	7	1	1	4	3	4	2.8	2.5	R	R	R	B+	D	B-	D	A+	D	D	D	B-	C-	B-	B-	D	B-	B+	D	B-	D	B-	B-	D	B+	
III4. Хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх	7	3	4	4	2	5	4.2	4.1	R	R	R	B+	D	B-	D	A+	D	D	D	C-	C-	C-	B-	D	B-	B+	D	B-	D	B-	B-	D	A+	
III8. Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хот байгуулах	8	3	5	3	3	5.4	4.4	4.3	R	R	R	B-	B-	A-	B-	B-	C-	D	D	C-	C-	C-	C-	C+	A-	B-/A+	D	B-	D	D	A-	B-	D	
IV2.2 Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах	8	5	4	6	2	6.2	5.6	5.2	R	R	R	B-	C-	A+	A-	B-	D	B-	D	D	B-	D	D	B+	B-	A+	D	B-	D	B-	B-	D	B+	
IV2.4 Эко-парк байгуулах	8	5	4	5	1	6	5.4	4.9	R	R	R	A-	A-	A+	A-	A-	D	A-	D	D	B-	D	D	B+	B-	A+	D	B-	D	A-	B-	D	B+	
IV3.1 Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах	2	6	6	6	5	4.4	5.2	5.6	NR	NR	NR	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	B-/A+	B-/A+	D	B+	D	D	D	D	D	
IV3.2 Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах	2	5	5	6	6	4	4.6	5	R	R	R	D	A+	B+	B+	D	D	B+	D	D	D	D	D	B+	B-	A+	D	B+	D	D	B-	D	D	
IV6. Туул голын усан цогцолбор байгуулах төсөл	8	5	3	5	5	5.8	5.2	4.5	R	R	R	D	C+	D	D	D	D	D	D	A-	C-	C-	D	D	B-	A+	D	B-	D	D	C-	B-	D	
IV7.1 Хот суурины усан хангамжийг сайжруулах	6	5	5	6	3	5.6	5.4	5.4	R	R	R	D	B+	D	D	D	D	D	D	D	D	D	D	D	B-	B+	D	D	D	D	B-	D	D	
IV8.4 Сумын төвийн бага оврын цэвэрлэх байгууламж барих	2	7	7	6	7	4.8	5.8	6.2	R	R	R	D	A+	B+	B+	D	D	B+	D	D	B-	D	D	B-	B-	B+	D	D	D	D	B-	D	D	
IV12. Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах	7	4	5	5	3	5.6	5	5	R	R	R	D	D	D	D	D	D	D	D	A-	A-	A-	A-	A-	D	A-	A+	D	A-/B+	D	D	A-	A-	A+

Тайлбар: A+/-: Эерэг/сөрөг нөлөө ихтэй байж болзошгүй., B+/-: Эерэг/Сөрөг нөлөө ямар нэг хэмжээгээр байж болзошгүй., C: Нөлөө үзүүлэх эсэх нь тодорхойгүй. (Төсөл хэрэгжүүлэх дараагийн шатанд нөлөөллийг нарийвчлан үнэлэх шаардлагатай), D: Нөлөө үзүүлэхгүй., R: Хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай., NR: Хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагагүй.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Байгаль орчны үнэлгээний жагсаалт, ЖАЙКА-гийн Төслийн баг

**Хүснэгт 9.3.3 Төсөл, хөтөлбөрүүд тус бүрийг дараагийн шатанд хэрэгжүүлэхэд Байгаль орчны урьдчилсэн үнэлгээ, зөвлөмжийн тайлбар (А-С)**

Гол төсөл хөтөлбөрүүдийн "А-" эсвэл "С-"	Индикатор : Үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэх үе шатны үнэлгээ, зөвлөмж
I1.1 Худалдааны чөлөөт бүс ба эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих	2.2: А-	Үнэлгээ: Өмнөд хил дагуух бүс нутаг усны хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалж зөвхөн гүний усаар хангагддаг бөгөөд усны нөөцийн нэгдсэн менежмент, хатуу чанд хяналт мониторинг хийж гүний усны бохирдлоос урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай. Зөвлөмж: Хэдийгээр хөрш зэргэлдээ улс орнуудтай хиллэх хил орчмын газар нутагт ХЧБ/ЭЗТБ байгуулах нь эдийн засгийн хувьд үр ашигтай хэдий ч усны нөөцийн тогтвортой менежментийг урт хугацаанд сайтар тооцож төлөвлөх шаардлагатай.
	2.3: А-	Үнэлгээ: ХЧБ болон ЭЗТБ-ийг байгуулснаар хүнд, хөнгөн үйлдвэрээс гарах хортой, хоргүй хог хаягдлыг ухаалаг, дэвшилтэт технологи нэвтрүүлж, шийдвэрлэхгүй тохиолдолд байгаль орчинд ноцтой хохирол үзүүлнэ. Зөвлөмж: ХЧБ/ЭЗТБ-ийн төлөвлөлтийн үе шатанд үйлдвэр болон түрээслэгчдийн нөөц ашиглалтын үр ашгийг сайжруулах, хог хаягдлыг багасгах ухаалаг нөөцийн менежментийн төлөвлөлт хийх шаардлагатай. Мөн ХЧБ/ЭЗТБ-аас гарсан хог хаягдлыг зайлуулах / дахин боловсруулах байгууламжийг барихдаа эдийн засгийн үр ашигт тулгуурлан төлөвлөх нь зүйтэй.
	2.4: А-	Үнэлгээ: Газрын тос / химийн бодисын тархалт, нөөц / хог хаягдлын зохисгүй менежмент нь хөрсний бохирдол, эцэстээ гүний усыг бохирдуулах эрсдэлтэй. Зөвлөмж: Хог хаягдлын менежмент бүхий нөөцийн менежментийн цогц төлөвлөлт нь ХЧБ/ЭЗТБ-ийн төлөвлөлтийн чухал хэсэг байх ёстой.
	2.6: С-	Үнэлгээ: Өмнөд хил дагуух газар нутагт усны хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалж гүний усыг хяналтгүй, усны нөөцийн мониторинг хийлгүйгээр ашигласнаар хөрсний суулт үүсэх эрсдэлтэй. Зөвлөмж: ХЧБ болон ЭЗТБ-ийн төлөвлөлтийн үе шатанд гүний усны бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй зэрэгцүүлэн усны нөөцийн тогтвортой менежментийг урт хугацаанд оновчтой төлөвлөх шаардлагатай.
	4.1: А-	Үнэлгээ: ХЧБ болон ЭЗТБ-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн цар хүрээг харгалзан үзвэл дор хаяж хэдэн зуун га талбай бүхий газрыг чөлөөлөх шаардлагатай болно. Зөвлөмж: Экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
I2.1 Чацарганы үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх	4.1: А-	Үнэлгээ: Кластерын хөгжлийн эдийн засагт үзүүлэх нөлөөг харгалзан үзвэл дор хаяж хэдэн зуун га талбай бүхий газрыг чөлөөлөх шаардлагатай. Зөвлөмж: Экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг, голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй. Мөн үйлдвэрлэлийн кластерын байршлын хувьд түүхий эд тээвэрлэхтэй холбоотой тээвэр, логистикийн зардлыг бууруулах, зах зээлд ойртуулах боломж зэргийг нарийвчлан судалж, тогтоох шаардлагатай.
	4.4: С-	Үнэлгээ: Байгалийн унаган төрх, бэлчээрийн төлөв байдал өөрчлөгдөх боловч нөлөөллийн хэмжээг тодорхойлох боломжгүй. Зөвлөмж: Чацарганыг соёл, уламжлалын хувьд үнэ цэнэтэй газрууд болох шашны зан үйл, баяр наадам зохион байгуулагддаг газрууд, аялал жуулчлалын түшиц газруудад тариалахгүй байх нь зүйтэй. Байгалийн унаган төрх алдагдахтай холбоотой болзошгүй нөлөөллийн талаар орон нутгийн газар эзэмшигч, ашиглагчдад урьдчилан танилцуулах, удаа дараагийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах шаардлагатай.
	4.6: С-	Үнэлгээ: Уламжлалт технологиос орчин үеийн дэвшилтэт технологи руу шилжих үйл явцад боловсруулах үйлдвэрийн ажиллагсадын дасан зохицох, суралцахад бэрхшээл тохиолдож болзошгүй бөгөөд нөлөөллийг тодорхойлох боломжгүй. Зөвлөмж: Үйлдвэрлэлийн бусад салбар болон гадаад орнуудын туршлагаас суралцаж, шинэ технологийг нутагшуулснаар томоохон аюул, осол гэмтлээс сэргийлэх боломжтой.
I2.2 МАА-н үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх	2.7: А-	Үнэлгээ: Үйлдвэрлэлийн цогц менежментийг зүй зохистой хэрэгжүүлээгүйгээс малын ялгадас, дайвар бүтээгдэхүүнээс эвгүй үнэр их хэмжээгээр гарч болзошгүй. Зөвлөмж: Үйлдвэрлэлийн бусад салбар болон гадаад орнуудын туршлагаас суралцаж, орчин үеийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн шинэ технологийг нутагшуулснаар гарч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой.
	3.2: А-	Үнэлгээ: Экосистемд ноцтой нөлөөлөхөөр байна. Зөвлөмж: Кластераар хөгжүүлэхийн өмнө газар ашиглалтын тогтвортой менежментийн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлэх үе шатанд түүнийг сайтар даган мөрдөх шаардлагатай.
	4.1: А-	Үнэлгээ: Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн цар хүрээг харгалзан үзвэл дор хаяж хэдэн зуун га талбай бүхий газрыг чөлөөлөх шаардлагатай болно. Зөвлөмж: Экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	4.6: С-	Үнэлгээ: Уламжлалт технологиос орчин үеийн дэвшилтэт технологи руу шилжих үйл явцад боловсруулах үйлдвэрийн ажиллагсадын дасан зохицох, суралцахад бэрхшээл тохиолдож болзошгүй бөгөөд нөлөөллийг тодорхойлох боломжгүй.

Гол төсөл хөтөлбөрүүдийн "А-" эсвэл "С-"	Индикатор : Үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэх үе шатны үнэлгээ, зөвлөмж
		Зөвлөмж: Үйлдвэрлэлийн бусад салбар болон гадаад орнуудын туршлагаас суралцаж, шинэ технологийг нутагшуулснаар томоохон аюул, осол гэмтлээс сэргийлэх боломжтой.
I3.2 Хүлэмжийн аж ахуйг дэмжих	4.1: А-	Үнэлгээ: Хүлэмжийн аж ахуйн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн цар хүрээг харгалзан үзвэл дор хаяж хэдэн зуун га талбай бүхий газрыг чөлөөлөх шаардлагатай. Зөвлөмж: Экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	4.4: А-	Үнэлгээ: Байгалийн унаган төрх, бэлчээрийн төлөв байдал өөрчлөгдөх боловч нөлөөллийн хэмжээг тодорхойлох боломжгүй. Зөвлөмж: Соёл, уламжлалын хувьд үнэ цэнэтэй газрууд болох шашны зан үйл, баяр наадам зохион байгуулагддаг газрууд, аялал жуулчлалын түшиц газруудад хүлэмжийн аж ахуйг эрхлэхгүй байх нь зүйтэй. Байгалийн унаган төрх алдагдахтай холбоотой болзошгүй нөлөөллийн талаар орон нутгийн газар эзэмшигч, ашиглагчдад урьдчилан танилцуулах, удаа дараагийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах шаардлагатай.
I3.3 ХАА-н мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх	4.1: А-	Үнэлгээ: ХАА-н мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэхэд эдийн засагт үзүүлэх нөлөөллийн цар хүрээ, үр ашгийг харгалзан үзвэл томоохон хэмжээний газар эзэмших шаардлагатай болно. Зөвлөмж: Экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
I9. Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих	2.1: А-	Үнэлгээ: Нүүрс тээвэрлэх явцад болон нүүрсний агуулахын орчимд их хэмжээний тоосонцор үүсэх бөгөөд түүнийг бууруулах арга хэмжээ, хяналт шалгалтыг сайжруулаагүй тохиолдолд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлнэ. Зөвлөмж: Одоо үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын болон гадаад орны туршлагауд, агаарын бохирдлыг бууруулах дүрэм, журам, мониторингийн арга барилаас суралцах шаардлагатай.
	2.5: А-	Үнэлгээ: Нүүрс тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр дуу чимээ, чичиргээг бууруулах зүй зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд тээвэр, логистикийн сүлжээний дагуу нөхцөл байдал улам дордоно. Зөвлөмж: Монгол Улсын нүүрсний экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, ирээдүйн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд логистикийн сүлжээ/барилга байгууламжийг сайжруулах, экспортыг дэмжих стратеги төлөвлөлтийг хийх шаардлагатай.
	5.3: А-	Үнэлгээ: Хямд өртгөөр нүүрс худалдаж авахыг үргэлжлүүлэн дэмжих нь нүүрсрөрөгчийн ялгарлыг бууруулах, сэргээгдэх болон эрчим хүчний тогтвортой хөгжил бүхий нийгэм рүү шилжихэд хүндрэл учруулж байна. Зөвлөмж: Аммонийн түлш, нүүрсрөрөгчийг хуримтлуулах, хадгалах зэрэг нүүрсрөрөгчийг дахин боловсруулах, утаа ялгаруулдаггүй дэвшилтэт технологийг нүүрс олборлолттой зэрэгцүүлэн хөгжүүлэхийг дэмжих хэрэгтэй.
III1. Автозамын тойрог коридор байгуулах	3.1: С-	Үнэлгээ: Авто замын тойрог коридорын төлөвлөлтийн олон хувилбар байгаа хэдий ч тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ их тул түүнийг дайруулахгүйгээр барьж байгуулахад бэрхшээл үүсэж болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг тойрог коридорын чиглэлийг сонгосны дараа тодорхойлох боломжтой. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.2: С-	Үнэлгээ: Авто замын тойрог коридорын төлөвлөлтийн олон хувилбар байгаа хэдий ч экосистемийн өндөр үнэ цэнэтэй газар нутаг болох голын сав газар, ойн сангийн эзлэх талбай, төслийн үр ашиг/хязгаарлалт зэргийг тооцож үзэхэд уг газар нутгуудыг дайруулахгүйгээр барьж байгуулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг тойрог коридорын чиглэлийг сонгосны дараа тодорхойлох боломжтой. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.3: С-	Үнэлгээ: Авто замын тойрог коридорын төлөвлөлтийн олон хувилбар байгаа хэдий ч голын сав газрын эзлэх талбай их, санхүүгийн үр ашиг/хязгаарлалт зэргийг тооцож үзэхэд тухайн газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг тойрог коридорын чиглэлийг сонгосны дараа тодорхойлох боломжтой. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй гол мөрөн, усны ай сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	5.1: А-	Үнэлгээ: Авто замын тойрог коридорын уртаас шалтгаалан байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл их байж болзошгүй. Зөвлөмж: Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй. Монгол Улсад хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн сайн туршлагауд, гадаад орны туршлагыг төлөвлөлтийн болон барилга угсралтын үе шатанд нэвтрүүлэх шаардлагатай.
III2. Аймаг хоорондын авто замуудыг	3.1: С-	Үнэлгээ: III1. Авто замын тойрог коридор байгуулахтай адил Зөвлөмж: III1. Авт озамын тойрог коридор байгуулахтай адил
	3.2: С-	Үнэлгээ: III1. Авто замын тойрог коридор байгуулахтай адил Зөвлөмж: III1. Авто замын тойрог коридор байгуулахтай адил

**Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл  
Эцсийн тайлан**

Гол төсөл хөтөлбөрүүд- ийн "А-" эсвэл "С-"	Индикатор : Үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэх үе шатны үнэлгээ, зөвлөмж
барих, сайжруулах	3.3: С-	Үнэлгээ: III1. Авто замын тойрог коридор байгуулахтай адил Зөвлөмж: III1. Авто замын тойрог коридор байгуулахтай адил
III3. УБ хотыг тойрон гарах төмөр замын шугам сүлжээг барьж байгуулах	3.2 С-	Үнэлгээ: Төмөр замын төлөвлөлтийн олон хувилбар байгаа хэдий ч аюулгүй байдлын стандарт, экосистемийн үнэ цэнэтэй газар нутаг болох голын сав газар, ойн сангийн эзлэх талбай их тул тухайн газар нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг уг төмөр замын бүтээн байгуулалтыг шийдвэрлэсний дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй гол мөрөн, усны ай сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
III4. Хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх	3.1: С-	Үнэлгээ: Одоо байгаа төмөр замын шугамтай холбох трасс нь тусгай хамгаалалттай газар нутгийг дайран гарах тохиолдолд төмөр замыг барьж байгуулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг одоо байгаа төмөр замын сүлжээг өргөжүүлэх, шинэчлэх арга хэмжээ, ач холбогдол зэргийг тодорхой болсны дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.2 С-	Үнэлгээ: Аюулгүй байдлын стандарт, экосистемийн үнэ цэнэтэй газар нутаг болох голын сав газар, ойн сангийн эзлэх талбай их тул тухайн газар нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.3: С-	Үнэлгээ: Одоо байгаа төмөр замын шугамтай холбох трасс нь голын ай сав газрыг дайран гарах тохиолдолд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг одоо байгаа төмөр замыг шинэчлэх, өргөжүүлэх арга хэмжээ, ач холбогдол зэргийг тодорхой болсны дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатанд голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
III8. Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хот байгуулах	2.3: А-	Үнэлгээ: Ахуйн болон хөнгөн үйлдвэрээс гарах хортой, хоргүй хог хаягдлыг зайлуулах хог хаягдлын тогтвортой менежментийг нэвтрүүлэхгүй тохиолдолд байгаль орчинд ноцтой хохирол үзүүлнэ. Зөвлөмж: Дагуул хотуудын хог хаягдлын менежментийг сайжруулах, нөөц ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, хог хаягдлыг байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, ухаалаг нөөцийн менежментийн төлөвлөлт хийх шаардлагатай. Мөн ахуйн хог хаягдлын дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн гадаад орны туршлагыг хүрээлэн буй орчин болон иргэдийн эрүүл мэндийг хамгаалахын тулд нэвтрүүлэх шаардлагатай.
	2.6: С-	Үнэлгээ: Усны нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж гүний усыг хяналтгүй, усны нөөцийн мониторинг хийлгүйгээр ашигласнаар хөрсний суулт үүсэх эрсдэлтэй бөгөөд цаашдын нөлөөллийн цар хүрээг энэ шатанд тодорхойлох боломжгүй. Зөвлөмж: Дагуул хотыг хөгжүүлэх төлөвлөлтийн шатанд ус ашиглагчид, хэрэлэгчдийн усны хэрэглээ, усны нөөцийн тогтвортой менежментийг урт хугацаанд судалж, тодорхойлох шаардлагатай.
	3.1: С-	Үнэлгээ: Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ их тул Улаанбаатар хотыг орон нутагтай холбож буй одоогийн болон шинээр барьж байгуулах авто замын тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хотуудын байршил тодорхой болсны дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.2: С-	Үнэлгээ: Дагуул хот байгуулах, Улаанбаатар хотыг орон нутагтай холбож буй одоогийн болон шинээр барьж байгуулах авто замын хамрах хүрээ том тул экосистемийн үнэ цэнэтэй газар нутгийг дайруулахгүй, сүйтгэхгүйгээр барьж байгуулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хотуудын байршлыг шийдвэрлэсний дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.3: С-	Үнэлгээ: Дагуул хотууд байгуулахаар төлөвлөж буй олон байршил байгаа хэдий ч экосистемийн үнэ цэнэтэй газар нутаг болох голын сав газрын эзлэх талбай их тул тухайн газар нутгийн байгаль орчинд үзүүлэх бүтээн байгуулалтын нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг уг дагуул хотын байршлыг шийдвэрлэсний

Гол төсөл хөтөлбөрүүд- ийн "А-" эсвэл "С-"	Индикатор : Үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэх үе шатны үнэлгээ, зөвлөмж
		дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатанд голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.4: С-	Үнэлгээ: Дагуул хотууд байгуулахаар төлөвлөж буй олон байршил байгаа хэдий ч зарим уул толгодыг сэтлэх, нам дор газрыг шороогоор дүүргэж тэгшлэх зэрэг инженерийн бэлтгэл арга хэмжээ хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг дагуул хотын байршлыг шийдвэрлэсний дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Бүтээн байгуулалтын өндөр зардлаас зайлсхийх, газрын унаган тогтцыг хэвээр хадгалахын тулд газар шорооны ажлыг багасгах шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатанд голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	4.1: А-	Үнэлгээ: Бүтээн байгуулалтад хэдэн зуун га газар шаардлагатай тул газар чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэх хэрэгтэй. Зөвлөмж: Экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	5.1: А-	Үнэлгээ: Газар ашиглалтын хамрах хүрээ их тул барилга угсралтын ажилтай холбоотой нөлөөлөл маш их байна. Зөвлөмж: Төслийн төлөвлөлтийн шатанд экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газрыг хамруулахгүй байх шаардлагатай. Монгол Улсад хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн сайн туршлагауд, гадаад орны туршлагыг төлөвлөлтийн болон барилга угсралтын шатанд нэвтрүүлэх шаардлагатай.
IV2.2 Хаягдал автомашины дахин боловсруулах парк байгуулах	2.2: С-	Үнэлгээ: Гүний усан хангамжнаас хамааралтай хот, суурин газрын хувьд усны нөөцийн нэгдсэн менежмент, хатуу чанд хяналт, мониторинг хийсний үр дүнд гүний усны бохирдлоос урьдчилан сэргийлэх боломжтой. Хаягдал автомашины дахин боловсруулах үйлдвэрийн байршлаас шалтгаалж гүний усны бохирдлын зэргийг нарийвчлан тооцох бөгөөд төслийн төлөвлөлтийг хийхээс өмнө үзүүлэх нөлөөллийг тодорхойлох боломжгүй. Зөвлөмж: Хэдийгээр Монгол Улсын нөөцийн зохистой ашиглалтын бодлогод чухал ач холбогдолтой боловч усны нөөцийн нэгдсэн менежмент, ус бохирдуулагч бензин, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис асгарч байгаа эсэхэд хатуу хяналт, мониторинг хийх зэргийг тооцсоны үндсэн дээр эко-паркийн байршлыг сонгох шаардлагатай. Паркийн тодорхой байршлыг төлөвлөхөөс өмнө "Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө", "Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулж хаягдал автомашины дахин боловсруулах, эко паркийн оновчтой байршлыг тогтоох, цаашдын төлөвлөлтийг хийх шаардлагатай. Орчны бохирдлын хатуу хяналт, мониторинг, тайлан үнэлгээний системийг төлөвлөж, хууль тогтоомжийг чанд мөрдүүлэх нөхцөлийг хангах хэрэгтэй.
	2.4: А-	Үнэлгээ: Бензин, газрын тос/химийн бодисын тархалт, нөөц/хог хаягдлын нэгдсэн менежментгүй, хяналтгүйгээс хөрсний бохирдол, цаашлаад гүний ус бохирдох эрсдэлтэй. Зөвлөмж: Монгол Улсад хэрэгжүүлж буй хог хаягдлын орчин үеийн дэвшилтэт менежмент, технологийн сайн туршлага, олон улсын туршлагыг нэвтрүүлж, энэхүү паркийн төлөвлөлт, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хог хаягдлын хяналт, үнэлгээ, тайлангийн системийг сайтар тусгаж өгөх шаардлагатай.
IV2.4 Эко-парк байгуулах	2.1: А-	Үнэлгээ: Хог хаягдлыг зайлуулах үйл явцын хатуу чанд хяналт, ялангуяа хог хаягдлыг шатаах үйл явцад тавих хяналт сул байгаагаас агаарыг ноцтой бохирдуулах эрсдэл байна. Зөвлөмж: Монгол Улсад болон гадаадад хэрэгжүүлж байгаа шилдэг туршлагаудын дагуу хяналт, үнэлгээ хийж, дүрэм журмыг нарийн чанд дагаж мөрдөх шаардлагатай.
	2.2: А-	Үнэлгээ: : Гүний усан хангамжнаас хамааралтай хот, суурин газрын хувьд усны нөөцийн нэгдсэн менежмент, хатуу чанд хяналт, мониторинг хийсний үр дүнд гүний усны бохирдлоос урьдчилан сэргийлэх боломжтой. Зөвлөмж: Хэдийгээр Монгол Улсын нөөцийн зохистой ашиглалтын бодлогод чухал ач холбогдолтой боловч усны нөөцийн нэгдсэн менежмент, ус бохирдуулагч бензин, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис асгарч байгаа эсэхэд хатуу хяналт, мониторинг хийх зэргийг тооцсоны үндсэн дээр эко-паркийн байршлыг сонгох шаардлагатай. Паркийн тодорхой байршлыг төлөвлөхөөс өмнө "Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө", "Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулж хаягдал автомашины дахин боловсруулах, эко паркийн оновчтой байршлыг тогтоох, цаашдын төлөвлөлтийг хийх шаардлагатай. Орчны бохирдлын хатуу хяналт, мониторинг, тайлан үнэлгээний системийг төлөвлөж, хууль тогтоомжийг чанд мөрдүүлэх нөхцөлийг хангах хэрэгтэй.
	2.4: А-	Үнэлгээ: Бензин, газрын тос/химийн бодисын тархалт, нөөц/хог хаягдлын нэгдсэн менежментгүй, хяналтгүйгээс хөрсний бохирдол, цаашлаад гүний ус бохирдох эрсдэлтэй. Зөвлөмж: Монгол Улсад хэрэгжүүлж буй хог хаягдлыг дахин боловсруулах болон орчин үеийн дэвшилтэт менежмент, технологийн сайн туршлага, олон улсын туршлагыг нэвтрүүлж, энэхүү паркийн төлөвлөлт, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хог хаягдлын хяналт, үнэлгээ, тайлангийн системийг сайтар тусгах шаардлагатай.
	2.5: А-	Үнэлгээ: Нүүрс тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр дуу чимээ, чичиргээг бууруулах зүй зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд тээвэр, логистикийн сүлжээний дагуу нөхцөл байдал улам дордоно. Зөвлөмж: Монгол Улсад хэрэгжүүлж буй хог хаягдлыг дахин боловсруулах болон орчин үеийн дэвшилтэт менежмент, технологийн сайн туршлага, олон улсын туршлагыг нэвтрүүлж,



Гол төсөл хөтөлбөрүүд- ийн "А-" эсвэл "С-"	Индикатор : Үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэх үе шатны үнэлгээ, зөвлөмж
		энэхүү паркийн төлөвлөлт, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хог хаягдлын хяналт, үнэлгээ, тайлангийн системийг сайтар тусгах шаардлагатай.
	2.7: А-	Үйлдвэрлэлийн цогц менежментийг зүй зохистой хэрэгжүүлээгүйгээс малын ялгадас, дайвар бүтээгдэхүүнээс эвгүй үнэр их хэмжээгээр гарч болзошгүй. Зөвлөмж: Үйлдвэрлэлийн бусад салбар болон гадаад орнуудын туршлагаас суралцаж орчин үеийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн шинэ технологийг нутагшуулснаар гарч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой. Мөн сууршлын бүсийн зориулалттай газар өмчлөгч, эзэмшигчидтэй зөрчилдөөн үүсгэхгүйн тулд эко паркийн стратегийн ач холбогдлыг сайтар тодорхойлох шаардлагатай.
	4.6: А-	Үнэлгээ: Боловсруулах үйлдвэрлэлийн уламжлалт технологиос орчин үеийн дэвшилтэт технологи руу шилжих үйл явцад ажиллагсадын дасан зохицох, ялангуяа аюулгүй ажиллагааны дэг журмыг ягштал баримтлуулах, ажиллагсадыг сургаж дадлагуулахгүй тохиолдолд осол, гэмтэл гарах эрсдэлтэй. Зөвлөмж: Үйлдвэрлэлийн бусад салбар болон гадаад улс орнуудын аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн сургалт явуулснаар шинэ технологийг нутагшуулах, томоохон аюул осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжтой.
IV6. Туул голын усан цогцолбор байгуулах төсөл	3.1: А-	Үнэлгээ: Туул усан цогцолборыг байгуулах олон хувилбар байгаа хэдий ч Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Усны тухай хуулийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутагт цогцолборыг барьж байгуулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг цогцолборын байршил тодорхой болсны дараа тооцоолох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.2: С-	Үнэлгээ: Туул усан цогцолборыг байгуулах олон хувилбар байгаа хэдий ч Монгол орны экосистемийн хувьд маш чухал газар болох Туул голын сав дагуух газарт барьж байгуулахад үзүүлэх нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг цогцолборын байршил, барилга байгууламжийн овор хэмжээ тодорхой болсны дараа нарийвчлан тодорхойлох нь зүйтэй. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	3.3: С-	Үнэлгээ: Туул усан цогцолборыг байгуулах олон хувилбар байгаа хэдий ч голын сав газарт нөлөөлөх нөлөөллийг бууруулахад хүндрэл учирч болзошгүй. Нөлөөллийн цар хүрээг цогцолборын байршил тодорхой болсны дараа тодорхойлно. Зөвлөмж: Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төсөл хэрэгжүүлэх дараагийн үе шатуудад экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг болон голын сав газарт байгуулахгүй байх нь зүйтэй.
	5.1: С-	Үнэлгээ: Цогцолборын овор хэмжээнээс хамааран барилга угсралтын ажлын нөлөөлөл их байж болзошгүй. Цогцолборын байршил болон овор хэмжээг шийдвэрлэсний дараа нөлөөллийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Зөвлөмж: Экосистемийн хувьд үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутаг, голын сав газарт байгуулахгүйгээр төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Төслийн төлөвлөлтийн болон барилга угсралтын ажлын төлөвлөгөөнд Монгол Улсын болон гадаад орнуудын байгаль орчны менежментийн дэвшилтэт туршлагыг тусгах шаардлагатай.
IV12. Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах	2.8: А-	Үнэлгээ: Гол мөрний урсгалыг боож, голдрилыг өөрчилснөөр цахилгаан станцын далан болон Сэлэнгэ мөрний зарим хэсэгт хурдасжилт үүсэж болзошгүй. Зөвлөмж: Урт хугацааны хурдасжилтын менежментийн төлөвлөгөө төдийгүй байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон одоогийн ус ашиглагч, хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн цогц үнэлгээг хийж, далангийн бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй.
	3.1: А-	Үнэлгээ: Сэлэнгэ мөрний дагуух зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах тул далан барих төслийн үйл ажиллагаа энэхүү хамгаалалттай газар нутгийн байгаль орчинд ихээхэн нөлөө үзүүлнэ. Зөвлөмж: Экосистем болон ус ашиглагч, хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн цогц үнэлгээг хийж, далан барьж байгуулах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах хүчин зүйлсийг сайтар тусгах шаардлагатай. Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ.
	3.2: А-	Үнэлгээ: Усан сан, ойн сан бүхий экосистемийн үнэ цэнэтэй газар нутгийг дайруулахгүй барьж байгуулахад хүндрэл бэрхшээл тулгарч байгаа бөгөөд далан барих төсөл нь тухайн газар нутгийн экосистемд ихээхэн нөлөөлнө. Зөвлөмж: Экосистем болон төслийн үр ашиг хүртэгчдэд үзүүлэх нөлөөллийн цогц үнэлгээг хийж, далан барьж байгуулах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах хүчин зүйлсийг сайтар тусгах хэрэгтэй. Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ.
	3.3: А-	Үнэлгээ: Далангийн дагуу голын голдрилыг өөрчлөхтэй холбоотойгоор усны урсацад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Зөвлөмж: Экосистем болон төслийн үр ашиг хүртэгчдэд үзүүлэх нөлөөллийн цогц үнэлгээг

Гол төсөл хөтөлбөрүүд- ийн "А-" эсвэл "С-"	Индикатор : Үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэх үе шатны үнэлгээ, зөвлөмж
		хийж, далан барьж байгуулах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах хүчин зүйлсийг сайтар тусгах хэрэгтэй. Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ.
	3.4: А-	Үнэлгээ: Далан барьж байгуулахад тухайн орчны газрын гадаргуу тэр чигээрээ өөрчлөгдөнө. Зөвлөмж: Голын эх болон адгийн усан сангийн тогтвортой байдлыг хангасан байгаль орчны нөлөөллийн цогц үнэлгээ хийж, далан барьж байгуулах төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ
	4.1: А-	Үнэлгээ: Барилга угсралтын ажлын үеэр их хэмжээний газрын гадаргуу эрсдэлд өртөж болзошгүй. Зөвлөмж: Экосистем болон төслийн үр ашиг хүртэгчдэд үзүүлэх нөлөөллийн цогц үнэлгээг хийж, далан барьж байгуулах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах хүчин зүйлсийг сайтар тусгах хэрэгтэй. Төлөвлөлтийн эхний шатанд дараах гурван зарчмыг баримтлах хэрэгтэй. Үүнд: 1) зайлсхийх, 2) багасгах, 3) бууруулах арга хэмжээ. Төслийн дизайн, төлөвлөлтийн үе шатанд төсөлд оролцогч талуудын харилцан зөвшилцөл маш чухал.
	4.4: А-/В+	Үнэлгээ: Бэлчээр болон голын сав газрын байгалийн төрхөд ихээхэн нөлөө үзүүлж болзошгүй. Гэвч хиймэл нуурын бүтээн байгуулалтыг үзүүлэх зэргээр аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж гарна. Зөвлөмж: Соёл, уламжлалын хувьд үнэ цэнэтэй газрууд болох шашны зан үйл, баяр наадам зохион байгуулагддаг газрууд, аялал жуулчлалын түшиц газруудад байгуулахгүй байх нь зүйтэй. Байгалийн унаган төрх алдагдахтай холбоотой болзошгүй нөлөөллийн талаар орон нутгийн газар эзэмшигч, ашиглагчдад урьдчилан танилцуулах, удаа дараагийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах шаардлагатай.
	5.1: А-	Үнэлгээ: Барилгын ажлын цар хүрээнд шалтгаалан үзүүлэх нөлөөлөл их байна. Зөвлөмж: Экосистемийн үнэ цэнэтэй, тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах зорилгоор дор хаяж төслийн төлөвлөлтийн үе шатанд газар шороо, барилгын ажлыг түр хийхгүй байх шаардлагатай. Монгол Улсад хэрэгжүүлж буй барилгын менежмент, технологийн сайн туршлага, олон улсын туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай.
	5.2: А-	Үнэлгээ: Барилгын ажлын талбайн зохион байгуулалт, төлөвлөгөө, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хамгаалах хэрэгсэл, сургалтыг бүрэн явуулаагүй, барилга угсралтын ажлыг зохих дүрэм журмын дагуу гүйцэтгээгүй тохиолдолд осол аваар гарч болзошгүй. Зөвлөмж: Барилгын ажлын төлөвлөгөө, менежментийн хүрээнд Монгол Улсад болон гадаад оронд хэрэгжүүлж буй аюулгүй ажиллагааны сайн туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай.

## Бүлэг 10 Гол төсөл, хөтөлбөрийн танилцуулга

Бүлэг 8-д тусгаснаар Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд санал болгож буй гол төсөл, хөтөлбөрийг 4 ангилсан. Санал болгож буй бүх төсөл, хөтөлбөрийн дэлгэрэнгүй танилцуулгыг энэхүү бүлэгт тусгав.

### 10.1 Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд

Төслийн дугаар: 11.1

Нэр	Худалдааны чөлөөт бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл*
Байршил	Алтанбулагийн Худалдааны чөлөөт бүс (Сэлэнгэ аймаг), Замын-Үүдийн Эдийн засгийн чөлөөт бүс (Дорноговь аймаг), Цагаан нуурын Худалдааны чөлөөт бүс (Баян-Өлгий аймаг)
Хэрэгжүүлэгч агентлаг	Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, БХБЯ, ҮХГ, ТХХТ-ийн дагуу төсөл хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд
Зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>2) Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар аж үйлдвэр, худалдаа/арилжаа, үйлчилгээний төвийг бий болгох;</li> <li>3) Монгол Улс, БНХАУ, ОХУ-ыг холбосон эдийн засгийн коридор болон дэлхийд гарах гарцыг бий болгоход хувь нэмэр оруулах;</li> <li>4) Хөдөлмөр эрхлэлт болон бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх;</li> <li>5) Аж үйлдвэрийн өрсөлдөх чадвар, технологийг сайжруулах;</li> <li>6) Баруун Монголын хөгжлийг хурдасгах (Цагааннуурын ЧХБ).</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Гадаадын хөрөнгө оруулагч компани, орон нутгийн үйлдвэрлэгчид, ЖДҮ, МХТ, логистик болон үйлчилгээний салбарын уялдаа холбоог хангаж, хил орчмын бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг хангах замаар үндэсний болон орон нутгийн эдийн засгийг өргөжүүлнэ.</li> <li>2) Улсын хэмжээнд эдийн засгийн тэнцвэртэй, төрөлжсөн бүтцийг бий болгоно.</li> </ol>
Төслийн өртөг	<ol style="list-style-type: none"> <li>1) Алтанбулагийн худалдааны чөлөөт бүс: “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд (2003) төслийн нийт өртгийг 51,6 сая. ам. доллар байхаар тусгасан. Төсвөөс тус чөлөөт бүсэд 10.6 сая. ам.долларын санхүүжилтийг хийсэн.</li> <li>2) Замын-Үүдийн худалдааны чөлөөт бүс: 58.8 сая ам.долларын санхүүжилтээс 50 сая ам.доллар нь БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл бөгөөд дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийсэн болно. Мөн түүнчлэн АХБ-аас 30 сая ам.долларын нэмэлт зээл авахаар төлөвлөж байна.</li> <li>3) Цагаан нуурын худалдааны чөлөөт бүс: Төсвөөс тус чөлөөт бүсэд 0.6 сая. ам. долларын санхүүжилтийг хийсэн. Цагаан нуурын Худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны мэдээллээр барилга байгууламж, хатуу хучилттай зам барьж байгуулахад 2.3 сая. ам. долларын санхүүжилт шаардлагатай байна.</li> </ol>

Хэрэгжүүлэх хуваарь	Хууль эрх зүй, институцийн зохицуулалт: 2021-2022 Хөтөлбөрийн үе шаттай хэрэгжилт: 2022-2030 Хөтөлбөрийн бүрэн хэмжээний үйл ажиллагаа: 2030~
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>2002 онд Чөлөөт бүсийн тухай хууль батлагдаж, чөлөөт бүс байгуулах тухай анхны заалтуудыг хэрэгжүүлэх эхлэл тавигдсан. Эдгээр чөлөөт бүсийн төслүүд хэрэгжиж байгаа хэдий ч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахгүй байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд (i) Чөлөөт бүсийг хөгжүүлэх талаар төрөөс баримталж буй бодлогын зөрчилтэй байдал, (ii) санхүүжилтгүйн улмаас дэд бүтцийг бүрэн барьж байгуулаагүй, (iii) Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны үр ашиг багатай удирдлага, iv) Чөлөөт бүсийн тухай хууль эрх зүйн орчин сул, (v) хөгжлийн төлөвлөгөө хангалтгүй зэрэгтэй холбоотой байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p> <p>Одоо байгаа хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах; Чөлөөт бүс, түүний орчмын нутаг дэвсгэрийн дэд бүтэц (зам, цахилгаан эрчим хүч, ус хангамж, үйлдвэрийн бхир ус цэдэрлэх байгууламж, МХТ) барьж байгуулан дуусгах; Чөлөөт бүсийг хөгжүүлэх талаар нарийвчилсан дүрэм/журам боловсруулах; Хөрөнгө оруулагчдад зориулсан вэб сайт, мэдээллийн багц боловсруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих талаар семинар зохион байгуулах, баг томилох; (i) БНХАУ (Замын-Үүд-ийн ХЧБ, Эрээн хотын Хилийн иргэдийн худалдааны бүс, (ii) ОХУ (Алтанбулагийн ХЧБ, (iii) ОХУ болон Казахстан Улс (Цагааннуурын ХЧБ) –тай хамтран хөгжих болон уялдаа холбоог бэхжүүлэх; Чөлөөт бүсийг хөгжүүлэх, хил дамнасан бүсийг хөгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Үр дүнтэй удирдлага зохицуулалт, хэрэгжилтийг хангах үүднээс хувийн хэвшлийн оператор эсвэл Төр хувийн хэвшлийн түншлэлийг загварыг нэвтрүүлэх шаардлагатай.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, Гадаад орнуудын засгийн газар (БНХАУ, ОХУ, Казакстан Улс), хандивлагч байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагууд хоорондын нягт уялдаа холбоо чухал.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Бүсийн нутаг дэвсгэрт бохир ус цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зүй зохистойгоор зайлуулах замаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болно.
Тайлбар	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Алсын хараа 2050 баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад Замын Үүд, Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны шинэ буудал, Алтанбулаг, Цагааннуурын ХЧБ-ийг хөгжүүлэх төслүүд 170 дугаар, ТХХТ-ийн 7.9-7.17-р дугаарт тусгагдсан. Төслийг 2020-2030 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөж байна. Төслийн өртөг зардлыг тусгаагүй байна.

Төслийн дугаар: I1.2

Нэр	<b>Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлын Эдийн засгийн тусгай бүс /ЭЗТБ/-ийг хөгжүүлэх төсөл</b>
Байршил	Төв аймгийн Хөшигийн хөндий, Улаанбаатар хотын Нисэх онгоцны шинэ буудлын Эдийн засгийн тусгай бүс
Хэрэгжүүлэгч агентлаг	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци (УБХК), БХБЯ, ҮХГ, Шадар сайдын Ажлын алба, МҮХАҮТ, ТХХТ-ийн дагуу төсөл хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд
Зорилтууд	1) Эдийн засгийг төрөлжүүлэх, экспортын баримжаатай эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч болох; 2) Ажлын байрыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.
Хүлээгдэж буй үр дүн	Энэхүү төсөл нь Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагуудын олон улсад өрсөлдөх чадварт үндэслэн дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэн, ажлын байрыг бий болгоно.
Төслийн өртөг	5 сая ам.доллар (зөвхөн зөвлөх үйлчилгээ) Төслийн нийт өртөг тодорхойгүй байна.
Хэрэгжүүлэх хуваарь	Институци, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх: 2021-2022 Төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх: 2022-2030 Төслийг бүрэн хэрэгжүүлэх: 2030~
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл Улаанбаатар хотын төвөөс өмнө зүгт 50 км-т орших Нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагаа 2020 онд эхлэнэ. Энэхүү нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулсанаар гадаад орнуудаас жуулчид, хөрөнгө оруулалтыг татна. Нисэх онгоцны шинэ буудал нь логистикийн төв болж, Монгол Улсаас бусад улс руу мөн эсрэг чиглэлд ая тухтай, түргэн шуурхай, хямд тээвэрлэлт хийх боломжтой болох юм. Тиймээс ноу-хау, шинэ технологи нэвтрүүлэхийн зэрэгцээ дээр дурдсан боломжуудыг нэмэгдүүлэх зорилгоор нисэх онгоцны шинэ буудалд ЧХБ/ЭЗТБ-ийг байгуулах шаардлагатай. 2019 оны 1-р сард Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан 12,000 га газар бүхий Шинэ Зуунмод дагуул хотын ерөнхий төлөвлөгөөнд ХЧБ/ЭЗТБ-ийг 440 га газрыг хамруулахаар тусгасан байна. 2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг а) Шинэ Зуунмод дагуул хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу ЧХБ/ЭЗТБ-ийн бүтээн байгуулалтын төлөвлөгөө боловсруулах; б) Шинэ Зуунмод дагуул хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу ЧХБ/ЭЗТБ-ийн дэд бүтцийг (авто зам, цахилгаан, ус хангамж, үйлдвэрийн хог хаягдлыг цэвэрлэх, МХХТ) барьж байгуулан, дуусгах; в) Боломжит хөрөнгө оруулагчдад хамгийн сайн нөхцөл, бизнесийн орчинг бүрдүүлэхийн тулд хөрөнгө оруулагчдад зориулсан хууль тогтоомж, дүрэм журмыг боловсруулах, батлуулах; г) Хөрөнгө оруулагчдад зориулсан үр дүнтэй багц мэдээлэл боловсруулах, вэбсайт бүтээх, хөрөнгө оруулалтыг дэмжих хурал, семинар зохион байгуулах, төлөөлөгчдийг томилон ирүүлэх;

	<p>е) Шинэ Зуунмод дагуул хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу спорт, боловсролын байгууламж, эмнэлэг бүхий ХЧБ/ЭЗТБ-ийг бүтээн байгуулах;</p> <p>ф) Холбогдох яамд, МҮХАҮТ, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо зэрэг байгууллагыг багтаасан хөрөнгө оруулагчдад зориулсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх хороо байгуулах.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Улаанбаатар хотын хөгжлийн корпораци (УБХК), Шадар сайдын Ажлын алба, БХБЯ, бусад холбогдох яамд, МҮХАҮТ, хувийн хэвшлийн уялдаа холбоог хангах зайлшгүй шаардлагатай.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	<p>1) Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөөтэй.</p> <p>2) Монгол Улс аж үйлдвэржилтийн шинэ эринд нэг хүнд ногдох ДНБ-ийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.</p>
Тайлбар	<p>Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Алсын хараа 2050 баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын ЭЗТБ-ийг хөгжүүлэх төсөл нь бусад гурван ХЧБ-ийг хөгжүүлэх төслийн хамт 170 дугаар, ТХХТ-ийн 7.11-7.12-р дугаарт тусгагдсан. Төслийг 2020-2030 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөж байна. Төслийн өртөг зардлыг тусгаагүй байна.</p> <p>Улаанбаатар хотын хөгжлийн корпораци нь 2020 оны 3-р сарын 3-нд Улаанбаатар хотын Эдийн засгийн тусгай бүсийн талаар олон улсын форум зохион байгуулахаар товлосон хэдий ч хойшлогдсон.</p>

**Төслийн дугаар: 12**

Нэр	Аж үйлдвэрийн кластерыг дэмжих хөтөлбөр*
Байршил	Төслийн тодорхойлолтыг харна уу.
Хэрэгжүүлэгч агентлаг	ҮХГ, ХХААХҮЯ, орон нутгийн засаг захиргаа, хоршоод, МҮХАҮТ, Монголын жимс жимсгэний үндэсний холбоо, Монголын ноос ноолуурын холбоо, Монголын зөгийчдийн нийгэмлэг зэрэг бизнесийг дэмжих холбоод, ТББ, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургууль/эрдэм шинжилгээний хүрээлэн г.м
Зорилтууд	<p>1) Хөдөө орон нутгаас түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;</p> <p>2) Боловсруулах үйл ажиллагааны чанарыг сайжруулах;</p> <p>3) Гадаад зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулах;</p> <p>4) Кластерын үнэ цэнийн сүлжээнд өрсөлдөх, хамтран ажиллах, харилцан хамааралтай бизнесийн бүлгүүдийг байгуулах.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>1) Хөгжлийн зүй тогтол нь нөөц баялгийг зүй бусаар ашиглаж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлдэг 20-р зууны хөгжлийн загвараас нийгэм, байгаль орчны асуудал, хөдөлмөр эрхлэлт, зохих технологийг нэвтрүүлэх зэргийг чухалчлан үздэг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ хувилбар руу шилжинэ.</p> <p>2) Ядуурлыг бууруулна.</p>
Төслийн өртөг	Төслийн тодорхойлолтыг харна уу.
Хэрэгжүүлэх хуваарь	Хөтөлбөрийн үе шаттай хэрэгжилт (бүтээгдэхүүнээр): 2021-2030 Хөтөлбөрийн бүрэн хэмжээний үйл ажиллагаа: 2030~
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>ТХҮБ2030-д тусгаснаар хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай</p>


	<p>бүтээгдэхүүн боловсруулах, экспортод чиглэсэн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг зохион байгуулах замаар шинэ санаачилга, орчин үеийн дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Ийм аж үйлдвэрийн кластерууд нь уугуул аж үйлдвэрүүдээр дамжуулан экспортлох аж үйлдвэрүүд рүү шилжих замаар ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ингэснээр ядуурлыг бууруулах, нийгмийн тогтвортой байдлыг хангахад тус дөхөм болдог.</p> <p>Чацаргана Монгол Улсын Засгийн газар 2022 онд чацаргана тариалах талбайг 6,000 га-гаас 10,000 га болгон нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Нөгөө талаар фермер, боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадал бага, нийлүүлэлтийн сүлжээний менежмент сул байна. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Монголын худалдааг дэмжих төсөл”-ийг цаашид өргөжүүлэх шаардлагатай.</p> <p>Хонь, ямааны болон бусад мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл Мал нядалгааны үйлдвэр нь анхан шатны боловсруулалт, нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. АХБ-ны дэмжлэгийг цаашид өргөжүүлэн, мах, махан бүтээгдэхүүн боловсруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.</p> <p>Ноос, ноолууран бүтээгдэхүүн 80 орчим жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч компаниуд анхан шатны боловсруулалт (ангилах, ялгах), угаах, самнах, ээрэх, үйлдвэрлэх зэрэг үе шаттай ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Хандивлагч байгууллагуудын зарим нь төслийн хүрээнд үйлдвэрлэлийн кластер байгуулахаар санаачлан ажиллаж байна.</p> <p>Зөгийн аж ахуйн бүтээгдэхүүн Монгол Улсад үйлдвэрлэсэн зөгийн балны чанар АХБ, Японы Хөдөө аж ахуй, ойн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр аажмаар сайжирч байгаа боловч зөгийн балыг экспортолж эхлээгүй байна</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт малчид, тариаланчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, бүтээгдэхүүн хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа явуулах, экспортын зах зээлийг хөгжүүлэх, ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зэрэг урамшууллын арга хэмжээ хэрэгжүүлэн аж үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлнэ. Сонгосон кластерууд, тэдгээрийн боломжит байршлуудыг доор дурдав.</p> <p>Чацарганыг боловсруулан шүүс, эрүүл мэнд, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл; Энэхүү төсөл нь жимсийг нунтаглах, чацарганы тос үйлдвэрлэх зэрэг боловсруулах технологийг дэмжихээс гадна бүтээгдэхүүнийг хадгалах, борлуулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Байршил: Увс, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Улаанбаатар, Завхан</p> <p>Төслийн өртөг: 3 - 10 сая ам. доллар</p> <p>Хонь, ямаа, адуу, үхрийн гэх мэт мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, халал хүнс, гэрийн тэжээвэр амьтдын хоол тэжээл, ихэс, хонины өлөн болон бусад дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл; Тус төсөл нь мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйл ажиллагааг сайжруулна.</p>
--	--



	<p>Байршил: Сэлэнгэ, Улаанбаатар ба тэдгээрийн ойр орчмын аймгууд, Дорнод зэрэг Зүүн бүсийн аймгууд, Баруун бүсийн аймгууд Төслийн өртөг: Мал нядалгаа, анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр 5 сая ам. доллар Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл; Төсөл нь үйлдвэрийн кластер байгуулах, ялангуяа үнэ цэнийн сүлжээнд тодорхой чиг үүрэг бүхий (дэд системийн үүрэгтэй) жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ. Байршил: Улаанбаатар ба түүний ойр орчмын аймгууд Органик зөгийн бал, зөгийн жилий, эрүүл мэндийн бүтээгдэхүүнд зориулсан сүүнцэрийн үйлдвэрлэл. Энэхүү төсөл нь зөгийн балны бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлнэ. Байршил: Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Дорнод, Булган, Төв</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Хэрэгжүүлэгч агентлагууд болон оролцогч талуудаас бүтээгдэхүүн болон зах зээлийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; ЖАЙКА-гийн Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөөний төслийн мэдээлэл цуглуулах судалгаа нь 2019 оны 2 дугаар сард хэрэгжиж дууссан болно.</p>
<p>Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл</p>	<p>Боловсруулах үйлдвэрийн түүхий эд болох анхан шатны бүтээгдэхүүнийг илүү үр ашигтай, бүрэн ашиглаж байгаа тул байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.</p>
<p>Тайлбар</p>	<p>- ЖАЙКА-гийн хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө” төсөлтэй уялдуулах шаардлагатай.</p> <p>Баруун бүсийн аймгуудад хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, мал аж ахуй, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр АХБ-ны техник туслалцааны “Бүс нутагт нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагааг дэмжих нь” төсөл 2019 онд хэрэгжиж дууссан бөгөөд Монгол Улсын Засгийн газар АХБ-нд баруун Монголд ижил төстэй төсөл хэрэгжүүлэх талаар хүсэлт гаргасан.</p> <p>Дэлхийн банк Монгол Улсын эдийн засгийн төв коридорын үнэлгээ болон ноос, ноолуур, мах болон арьс ширний үйлдвэрлэлийн өртгийн сүлжээний дүн шинжилгээг 2017 онд хийсэн.</p> <p>Европын холбоо нь Монгол Улсын гадаад худалдааг төрөлжүүлэх, Монголын бараа бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд амжилттай гаргахад дэмжлэг үзүүлэх зорилготой Монголын худалдааг дэмжих төслийг 2018 оноос хэрэгжүүлж байна.</p>

Төслийн дугаар I2.2

Нэр	<b>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл*</b>																						
Байршил	Сэлэнгэ, Улаанбаатар, Дорнод, Баянхонгор, Ховд																						
Хэрэгжүүлэгч агентлаг	ҮХГ, ХХААХҮЯ, Аймгийн ЗДТГ, хоршоод, МХАҮТ, Монголын ноос ноолуурын холбоо, Монголын зөгийчдийн нийгэмлэг зэрэг бизнесийг дэмжих холбоод, ТББ, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд, их дээд сургууль/эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд г.м																						
Зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>1) Хөдөө орон нутгаас мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн боловсруулсан бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх;</li> <li>2) Боловсруулах үйл ажиллагааны чанарыг сайжруулах;</li> <li>3) Нэмүү өртөг шингэсэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулах;</li> <li>4) Кластерын үнэ цэнийн сүлжээнд өрсөлдөх, хамтран ажиллах, харилцан хамааралтай бизнесийн бүлгүүдийг байгуулах</li> </ol>																						
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Мал аж ахуйн гаралтай чанартай бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд амжилттай гаргах, сурталчлах</li> <li>2) Үнэ цэнийн сүлжээнд оролцогчдын орлого нэмэгдэх</li> </ol>																						
Төслийн өртөг	1-р үе шат: Зохион байгуулалт, төлөвлөлт 2 сая ам. доллар 2-р үе шат: Нядалгааны цех, анхан шатны боловсруулалт хийх цех 3 сая ам. доллар 3-р үе шат: Үндсэн байгууламж 50 сая ам. доллар																						
Хэрэгжүүлэх хуваарь	1 үе шат: 2021~2022: 2 үе шат: 2023~2024 3 үе шат: 2025~																						
Төслийн тодорхойлолт	<p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын үйл ажиллагаа</p> <table border="1"> <thead> <tr> <th>Анхан шатны үйлдвэрлэл</th> <th>Анхан шатны боловсруулалт</th> <th>Хоёрдагч боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</th> <th>Зах зээл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="5">Малын түүхий эд</td> <td>Мах</td> <td>Махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл</td> <td>Дотоодын</td> </tr> <tr> <td>Сүү</td> <td>Төрөл бүрийн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Омега 7</td> <td>Дотоодын, экспортын</td> </tr> <tr> <td>Арьс, шир</td> <td>Арьс, ширэн бүтээгдэхүүн, хувцас г.м</td> <td>Дотоодын, экспортын</td> </tr> <tr> <td>Ихэс</td> <td>Эм, косметик, эрүүл мэндийн бүтээгдэхүүн</td> <td>Экспортын</td> </tr> <tr> <td>Гэдэс, цус, яс</td> <td>Амьтны хоол тэжээл, хиамны бүрхүүл</td> <td>Дотоодын</td> </tr> </tbody> </table> <p>Бэлчээрийн бүс нутаг, анхан шатны боловсруулалт хийх хотууд, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах бүсийн томоохон хотууд, дотоодын хэрэглэгч бүс нутаг болон экспортын баазыг үр ашигтай тээвэр, харилцаа холбооны сүлжээгээр холбох шаардлагатай (Зураг 1). Ноос, ноолуурын бүтээгдэхүүнээс эхлэн үе шаттайгаар мал аж ахуйн бүтээгдэхүүнийг гол цэгүүдэд цахимаар худалдах, худалдан авах үйл ажиллагааг нэвтрүүлнэ.</p>			Анхан шатны үйлдвэрлэл	Анхан шатны боловсруулалт	Хоёрдагч боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Зах зээл	Малын түүхий эд	Мах	Махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Дотоодын	Сүү	Төрөл бүрийн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Омега 7	Дотоодын, экспортын	Арьс, шир	Арьс, ширэн бүтээгдэхүүн, хувцас г.м	Дотоодын, экспортын	Ихэс	Эм, косметик, эрүүл мэндийн бүтээгдэхүүн	Экспортын	Гэдэс, цус, яс	Амьтны хоол тэжээл, хиамны бүрхүүл	Дотоодын
Анхан шатны үйлдвэрлэл	Анхан шатны боловсруулалт	Хоёрдагч боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Зах зээл																				
Малын түүхий эд	Мах	Махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Дотоодын																				
	Сүү	Төрөл бүрийн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Омега 7	Дотоодын, экспортын																				
	Арьс, шир	Арьс, ширэн бүтээгдэхүүн, хувцас г.м	Дотоодын, экспортын																				
	Ихэс	Эм, косметик, эрүүл мэндийн бүтээгдэхүүн	Экспортын																				
	Гэдэс, цус, яс	Амьтны хоол тэжээл, хиамны бүрхүүл	Дотоодын																				



Зураг 1. Тээвэр, харилцаа холбооны сүлжээгээр холбогдсон цахимаар худалдах, худалдан авах үйл ажиллагааг нэвтрүүлсэн МAA-н үйлдвэрийн кластер

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын үндсэн байгууламжууд болох цогцолбор байгууламжуудыг мал аж ахуй эрхлэх бүс орчимд байгуулах боломжтой. Үүнд:

- Малын түүхий эдийг хадгалах зоорь,
- Ариун цэврийн болон бусад шаардлагыг хангасан нядалгааны цех,
- Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүд,
- Орон нутгийн маркетинг, тээвэрлэлт логистикийн байгууламж,
- Анхан шатны болон боловсруулсан бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах хяналтын лабораторийн байгууламж,
- Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах судалгаа шинжилгээний байгууламж,
- Менежментийн баг, ажиллагсадын офис.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерыг дараах үе шаттайгаар барьж байгуулна. Үүнд:

1-р үе шат:

- 1) Мал аж ахуй эрхлэгчид, холбоодыг зохион байгуулалтад оруулах/бэхжүүлэх,
- 2) Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерыг үе шаттайгаар байгуулах, шаардлагатай дэд бүтцийг сайжруулах төлөвлөгөө боловсруулах,

2-р үе шат:

- 1) Түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн зураг төслийг боловсруулах,
- 2) Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерын менежментийг хариуцах байгууллага байгуулах,
- 3) Тухайн байгууллагын албан тушаалтан, ажилтнуудыг сургах,

3-р үе шат:

- 1) Шаардлагатай дэд бүтцийн хамт кластерын цогцолбор байгууламжийн эхний бүрэлдэхүүн хэсгүүдийг барьж байгуулах,
- 2) Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, зах зээлийн судалгаа хийх.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах 1-р үе шатанд Засгийн газрын санаачилгаар холбоод, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд, фермерүүдийг зохион байгуулалтад оруулна. 2-р үе шатанд Засгийн газрын дэмжлэгтэйгээр орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийг сургалтад хамруулна. 3-р үе шатанд Засгийн газар дэд бүтцийг сайжруулах бөгөөд эрдэм шинжилгээний байгууллагууд судалгаа шинжилгээ хийж, хувийн хэвшил төслийг хэрэгжүүлнэ.

Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Түүхий эдийг бүрэн боловсруулж, үр дүнтэй ашигласнаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	- ЖАЙКА-гийн хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө” төсөлтэй уялдуулах

	<p>шаардлагатай.</p> <p>Баруун бүсийн аймгуудад хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, мал аж ахуй, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр АХБ-ны техник туслалцааны “Бүс нутагт нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагааг дэмжих нь” төсөл 2019 онд хэрэгжиж дууссан бөгөөд Монгол Улсын Засгийн газар АХБ-нд баруун Монголд ижил төстэй төсөл хэрэгжүүлэх талаар хүсэлт гаргасан.</p> <p>Дэлхийн банк Монгол Улсын эдийн засгийн төв коридорын үнэлгээ болон ноос, ноолуур, мах болон арьс ширний үйлдвэрлэлийн өртгийн сүлжээний дүн шинжилгээг 2017 онд хийсэн.</p> <p>Европын холбоо нь Монгол Улсын гадаад худалдааг төрөлжүүлэх, Монголын бараа бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд амжилттай гаргахад дэмжлэг үзүүлэх зорилготой Монголын худалдааг дэмжих төслийг 2018 оноос хэрэгжүүлж байна.</p>
--	--

**Төслийн дугаар: 13.1**

<b>Нэр</b>	<b>Ухаалаг хөдөө аж ахуйн хандлагыг дэмжих төсөл</b>
<b>Байршил</b>	Архангай, Булган, Дархан-Уул, Хэнтий, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай
<b>Хэрэгжүүлэгч агентлаг</b>	ХХААХҮЯ Хувийн хэвшил
<b>Зорилтууд</b>	Тогтвортой ургац авах, хөдөлмөрийн оролцоог бууруулахтай холбоотой технологийг тодорхойлох.
<b>Хүлээгдэж буй үр дүн</b>	1) Улаан буудай, төмс болон хүнсний ногооны эрэлт хэрэгцээг бүрэн хангах. 2) Үйлдвэрлэгчдийн ажлын орчныг сайжруулах.
<b>Төслийн өртөг</b>	2,275 сая төгрөг + зөөлөн бүрэлдэхүүн хэсэг
<b>Хэрэгжүүлэх хуваарь</b>	2021-2030
<b>Төслийн тодорхойлолт</b>	<p>1) Үндэслэл</p> <p>ТХҮБ 2030-д тусгаснаар 2030 он гэхэд улаан буудай, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг 100% хангана. Одоогийн байдлаар улаан буудай, төмсний дотоодын эрэлт хэрэгцээг бараг бүрэн хангаж байна. Харин 2018 онд хүнсний ногооны хэрэгцээний 43%-ийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна. Монгол Улсын хүн ам 2030 онд 3.8 сая, 2040 онд 4.5 саяд хүрэх төлөвтэй байгаа тул эрэлт хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлуудын нэг нь тогтвортой бус байдал юм. Хөдөлмөрийн бүтээмжийн жилийн өөрчлөлт ихээхэн ялгаатай байгаа бөгөөд аймгуудын нэгжээс хураан авах ургацын хэмжээ өөр өөр байна. Үйлдвэрлэлийг дэмжихийн тулд хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, аймгуудын нэгжээс хураан авах ургацын зөрүүг дэмжлэг үзүүлэх арга замаар багасгах хэрэгтэй. Өөр нэг асуудал бол хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй хүмүүсийн тоо буурах хандлагатай боловч нийт хөдөлмөрийн насны хүн ам жилээс жилд нэмэгдэж байгаа болно. Ухаалаг ХАА-н хандлагыг төлөвшүүлэхийн төлөө эдгээр саад бэрхшээлийг арилгах арга замыг судлах шаардлагатай.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p>

	<p>a) МХТ-ийн хэрэглээг нэвтрүүлэх нь: Уг төслөөр талбайд 7 хоногийн 24 цагийн бүрэн ажиллагаатай цаг уурын болон хөрсний мэдрэгчийг суурилуулна. Цаг агаарын урьдчилсан мэдээ, өнгөрсөн жилийн ургацын бүртгэл зэрэг цуглуулсан бүх мэдээллийг үүлэн системд оруулна. Уг систем нь тариалалт хийх болон ургац хураах цаг хугацаа, бордоо, химийн бордоо болон усалгаа хийх шаардлага, цаг уурын өөрчлөлтөөс үүсэх хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ г.м. шаардлагатай мэдээллээр хангана. Энэ нь үйлдвэрлэгч нарт орцыг оновчтой болгох, үйлдвэрлэлийг өртөг багатай, бага зардлаар нэмэгдүүлэх боломжийг олгодог.</p> <p>b) Нисэгчгүй тээврийн хэрэгслийг ашиглах нь: Дрон нь тариалалт болон бордоо хэрэглэх зэргийг орлуулах ажлуудыг гүйцэтгэдэг. Үүнээс гадна мэдрэгч бүхий төхөөрөмжөөр тоноглогдсон дрон нь өсөлтийн нөхцлийг хурдан, нарийвчлалтай хянаж, цуглуулсан мэдээлэлд үндэслэн цэг бүрийг нарийн тодорхойлох боломжтой юм. Хиймэл дагуулын байршил тогтоох технологи ашигладаг трактор, ургац хураагч комбайн зэрэг машинууд нь өдөр, шөнийн турш ажиллах боломжтой бөгөөд үйлдвэрлэгчдийн оролцоо багатайгаар тариалангийн талбайг хагалан өргөжүүлэх боломжийг олгодог.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ ХХААХҮЯ нь уг системийг суурилуулах талбайн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт болон олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. ХХААХҮЯ нь нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, системийг суурилуулах болон засвар үйлчилгээ хийх, мэргэжлийн арга зүйгээр хангах болон шаардлагатай хөрөнгө оруулалт хийх зэргийг оруулсан төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Тухайн талбай нь одоогоор тариалалт хийгдэж байгаа бөгөөд үндсэндээ ямар нэгэн сөрөг нөлөөлөл гарахгүй. Уг системийг суурилуулсны дараа орцын хэмжээг багасгах замаар байгаль орчинд эерэг нөлөөлөл үзүүлнэ. Хэрэв байгаль орчин, нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө ажиглагдвал хариу арга хэмжээ авах шаардлагатай.
Тайлбар	

**Төслийн дугаар: I3.2**

Нэр	Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл*		
Байршил	Дархан Уул, Ховд, Сэлэнгэ, Төв болон Улаанбаатар хот		
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХААХҮЯ Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо, хувийн хэвшил		
Зорилтууд	Өвлийн улиралд хүнсний ногооны ургац хураан авах, үйлдвэрлэлийн өртгийг бууруулахад тохирох технологийг тодорхойлох.		
Хүлээгдэж буй үр дүн	1) Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах 2) Хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртгийг бууруулах		
Хэрэгжүүлэх хуваарь	Үе шат 1: 2021-2022	Үе шат 2: 2023-2026	Үе шат 3: 2027-2030
Төслийн өртөг	3,375 сая төгрөг	3,600 сая төгрөг	3,600 сая төгрөг

Тоног төхөөрөмж/мэргэжилтэн	Тоног төхөөрөмж: МХХТ-ийн програм Дулаан солилцооны систем	Мэргэжилтэн: МХХТ-ийн програм Үйлдвэрлэл	Мэргэжилтэн: Өргөтгөл Маркетинг
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>ТХҮБ 2030-д тусгаснаар 2030 онд улаан буудай, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг 100% хангана. Дотоодын үйлдвэрлэлээр хүнсний ногооны хэрэгцээг хангах түвшин аажмаар буурч, 2018 онд 43% болсон байна. Монгол Улсын хүн ам 2030 онд 3.8 сая, 2040 онд 4.5 саяд хүрэх төлөвтэй байгаа бөгөөд эрэлт хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Монгол Улсын өвлийн улирлын цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан боловсрох хугацаа богино байдаг. Тиймээс өвлийн улиралд хүнсний ногоо тариалах боломжтой өвлийн хүлэмж барьж байгуулах нь чухал юм. 2017 онд хүлэмжид тариалах талбай болон үйлдвэрлэл нь тариалангийн нийт талбай болон үйлдвэрлэлийн 1%-иас бага хэвээр байсан. Хүлэмжийн нэгж талбайн үйлдвэрлэл өвлийн улиралд зуны улирлаас илүү их байдаг тул хүлэмжийн тариалалтыг өвлийн улиралд түлхүү хийхэд анхаарах хэрэгтэй боловч талбайг өргөжүүлэхэд учирч болох гол бэрхшээл нь түлшний зардал юм. Түлшний зардал нь хүлэмжийн үйлдвэрлэлээс гарсан бүтээгдэхүүний өртгийн 40 хувийг эзэлдэг гэж үздэг. Тиймээс өртөг багатай үйлдвэрлэл бүхий хүлэмжийн технологи шаардлагатай байна. Өөр нэг чухал асуудал нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй хүмүүсийн тоо буурах хандлагатай боловч нийт хөдөлмөрийн насны хүн ам жилээс жилд нэмэгдэж байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p> <p>Орчны хяналт шинжилгээний систем суурилуулах: төслийн хүрээнд хүлэмжүүдэд орчны хяналт шинжилгээний 7 хоногийн 24 цагийн бүрэн ажиллагаатай системийг суурилуулна. Тус систем нь шаардлагатай мэдээллийг цуглуулж, бүх мэдээллийг тодорхой болгоно. Орчны хяналт шинжилгээний системийн тусламжтайгаар хүлэмжинд хүнсний ногоо ургуулах орчныг оновчтой бүрдүүлэх зорилгоор температур, чийгшилтийг нэмэгдүүлэх, багасгах, усжуулах эсэх зэргийг автоматаар тооцдог. Цаг бүхий хэмжүүр нь мөн тогтоосон хуваарийн дагуу ажиллах боломжтой.</p> <p>Геодулааны системийг ашиглах: тус систем нь ууршуулагчаар шингээсэн геодулааныг хөргөлтийн явцад бага хэмтэй, нам даралтын хий болгон хувиргадаг. Компрессорын тусламжтайгаар энэ нь өндөр температуртай, өндөр даралтын хий болон хувирна. Хий нь конденсатораар усыг халаана. Геодулаан нь байгалийн эрчим хүчний нэг бөгөөд жилийн турш ашиглахад тогтвортой байдаг тул дулааны системд ашиглах боломжтой.</p> <p>Залуу үеийн боловсрол: орчин үеийн технологиос бүрдсэн орчны хяналт шинжилгээний систем бүхий хүлэмж нь залуу үеийн сонирхлыг татаж магадгүй юм. Хүлэмжийн жижиг загварыг хүлэмжийн цэцэрлэгжүүлэлтийг судлахад ашиглах бөгөөд сургалтыг танхимын хичээл, ажлын байран дахь сургалт хэлбэрээр зохион байгуулна.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>ХХААХҮЯ нь уг системийг суурилуулах талбайн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт, олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. ХХААХҮЯ</p>		

	<p>нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, системийг суурилуулах, засвар үйлчилгээ хийх, мэргэжил, арга зүйгээр хангах болон шаардлагатай хөрөнгө оруулалт зэргийг багтаасан төслийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах чиглэлээр холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.</p> <p><u>Хэрэгжүүлэх бүтэц</u></p> <p>Санал болгож буй хэрэгжүүлэх бүтцийг доор үзүүлэв.</p> <pre> graph TD     SC[Steering Committee] --&gt; PD[Project Director]     SC --&gt; CS[Consulting Service]     PD --&gt; PCO[Project Coordination Office]     PD --&gt; PIU[Project Implementation Unit]     CS --&gt; PD     CS --&gt; PCO     CS --&gt; PIU     PCO --- MOFALI_CO[MOFALI]     PCO --- GA_CO[Greenhouse Association]     MOFALI_CO -.-&gt; Collaboration  GA_CO     PIU --- MOFALI_PI[MOFALI]     PIU --- GA_PI[Greenhouse Association]     MOFALI_PI -.-&gt; Collaboration  GA_PI     </pre>
<p>Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл</p>	<p>Системийг суурилуулах явцад орцын хэмжээг багасгаснаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Геодулаан солилцооны систем нь дэлхийн хөдөлгөөний улмаас газрын хэлбэрийг өөрчилдөг тул барилга угсралтын явцад байгаль орчинд бага зэргийн сөрөг нөлөө учруулж болзошгүй юм.</p>
<p>Тайлбар</p>	<ol style="list-style-type: none"> <li>1) ХХААХҮЯ-ны мэдээллээр хүлэмжийн орчин үеийн технологи бүхий иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн компани байхгүй байна. Мөнх ногоон тал ХХК, Ногоон харш ХХК, Бат хүлэмж ХХК зэрэг ихэнх компаниуд БНХАУ, БНСУ, Европоос импортолсон бүтээгдэхүүнийг суурилуулах, угсрах ажил хийдэг. Иймд Монгол-Японы төвөөр дамжуулан Японы технологийг нэвтрүүлэх боломж байна.</li> <li>2) 2020 оны 2-р сарын байдлаар 25 га талбай бүхий хүлэмжинд хүнсний ногоо, жимс тариалж буй 125 үйлдвэрлэгч цахилгааны хөнгөлөлтөд хамрагдаж байна. Энэ нь хүлэмжийн тариалалтын нийт талбайн гуравны нэгийг эзэлж байна. Орон нутгийн цаг уурын болон бусад нөхцөлд тохирсон шинэлэг байгууламжийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор татаасын хэлбэрийг нэмэгдүүлэх хэрэгтэй.</li> </ol>

**Төслийн дугаар: 13.3**

<p>Нэр</p>	<p><b>Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх төсөл*</b></p>
<p>Байршил</p>	<p>Өвөрхангай аймгийн Хархорин, Булган аймгийн Сэлэнгэ, Хөвсгөл</p>



	аймгийн Бүрэнтогтох , Мөрөн
Хэрэгжүүлэгч агентлаг	Үндэсний хөгжлийн газрын дэмжлэгтэй бүс нутгийн аж ахуйн нэгжүүд
Зорилтууд	(i) Хөдөө орон нутгаас нийлүүлж буй газар тариалангийн болон мал аж ахуйн гаралтай бүртээгдэхүүнийг боловсруулах, тэдгээрийг Улаанбаатар болон ОХУ-ын зах зээлд гаргах, мөн жуулчдад өндөр үнэтэй борлуулах; (ii) Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төрөл бүрийн дэвшилтэт технологийг турших.
Хүлээгдэж буй үр дүн	1) Орон нутагт ажлын байр бий болно. 2) Малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлнэ. 3) Гадаад валютын орлого олно. 4) Аялал жуулчлалыг татах шинэ үйлчилгээ бий болно. 5) Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардлагатай шинэ технологийг нэвтрүүлэн түгээнэ.
Төслийн өртөг	Улсын эсхүл ТХХ-ийн хөрөнгө оруулалт Нийт өртөг: 25.5 сая ам.доллар. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт Нийт өртөг: 3.0 сая ам.доллар.
Хэрэгжүүлэх хуваарь	Төсөл боловсруулах ТЭЗҮ: 2021 Бүтэц зохион байгуулалт болон сангийн зохицуулалт: 2022 Төслийн эхний хэрэгжилт: 2023 Төслийн бүрэн хэмжээний үйл ажиллагаа: 2024~
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл Агро-МТ-ийн паркийн зорилго нь хүнсний ногоо, ноолуур/ноос/арьс шир, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг нэгтгэн үр ашигтай үйлдвэрлэл, логистикийн системийг бүрдүүлэхэд оршино. Эхний ээлжинд 40 гаруй байршлыг тогтоосон. Гэвч байршил сонгохдоо дэд бүтэц, тээвэрлэлт, газар нутгийн хувьд тэнцвэртэй байршил зэрэг үндсэн хүчин зүйлсийг авч үзээгүй байна. Агро-МТ-ийн паркийг байгуулахдаа тохиромжтой технологи, тоног төхөөрөмж зэрэг хангамжийн сүлжээний талаар сайтар нягтлах шаардлагатай. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн цөөн тооны Агро-МТ-ийн паркийг эртхэн байгуулах боломжтой. 2) Төслийн тодорхойлолт Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн парк төсөл /ХААМТП төсөл/ нь дараах гурван дэд төслөөс бүрдэнэ. Үүнд: Булган аймгийн ХААМТП төсөл, Хөвсгөл аймгийн ХААМТП төсөл болон Өвөрхангай аймгийн ХААМТП төсөл зэрэг болно. Эдгээр гурван байршлыг дэд бүтцийн хөгжил, усны нөөцийн хүртээмж болон чанар, улсын чанартай авто замд дөт байдал, орон нутгийн засаг захиргааны дэмжлэг, санаачилга, хөдөө орон нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж бололцоо, шүлхий өвчний сөрөг нөлөөлөл үгүй зэрэгт үндэслэн 17 боломжит байршлаас сонгосон. Булган аймгийн ХААМТПарк нь өөрийн аймагт тариалсан үр тариаг боловсруулах төв болж байгаа бол Хөвсгөл аймгийн ХААМТПарк, Өвөрхангай аймгийн ХААМТПарк нь малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах төв болно. Засгийн газар нь шаардлагатай бүх дэд бүтцээр тоноглогдсон гурван ХААМТПаркийг хөгжүүлэх, зохион байгуулах үйл ажиллагааг тэргүүлэх бол хувийн хэвшлийн аж ахуйн нэгж тухайн паркийн төрөл бүрийн боловсруулалт хийх үйлдвэрт

	<p>хөрөнгө оруулна.</p> <p>ХААМТГПаркийн төсөл нь илүү үр ашигтай газар тариалан, мал аж ахуй эрхлэх, өсгөж үржүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрөл бүрийн МХТ-ийн болон дэвшилтэт технологийг турших, түгээх ажлын үндэс суурь болно. Бүтээмжийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах зорилгоор Монголын нөхцөл байдалд тохируулан төрөл бүрийн дэвшилтэт технологийг мал аж ахуйн салбарт туршиж, өөрчлөх бөгөөд жишээ нь саалийн робот, ороо, мэдээлэл хүргэлтийн хяналтын төхөөрөмж зэргийг нэвтрүүлэх замаар малын хяналтыг сайжруулах болон шинээр нэвтрүүлсэн МХТ-ийн төхөөрөмжийг ашиглан мэдээлэл цуглуулах, удирдах системийг бий болгох боломжтой. Газар тариалангийн хувьд газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор "био-генераторын ус үйлдвэрлэгч", "бордоо гаргах", "жижиг оврын азотын үйлдвэр", "эрс тэс уур амьсгалд тэсвэртэй хүлэмж" г.м.-ийн дэвшилтэт технологийг турших чиглэлээр семинар зохион байгуулах бөгөөд үүнд геодулаан солилцооны систем, суваг хэлбэрийн хүлэмжийг ашиглалтад оруулна.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Төслийг ҮХГ-ын зохицуулалтын дагуу ТХХТ-ийн хэлбэрээр хэрэгжүүлнэ. ҮХГ-ын удирдамжаар тухайн аймгийн засаг захиргаа нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг байгуулж болно. ХХААХҮЯ болон холбогдох төрийн байгууллагууд техникийн дэмжлэг үзүүлнэ.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтын улмаас үүссэн бохир ус цэвэрлэх, хатуу хог хаягдлыг зайлуулах зүй зохистой арга хэмжээг авах шаардлагатай.
Тайлбар	

**Төслийн дугаар: I4.1**

Нэр	Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл
Байршил	Архангай, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Төв, Увс аймаг
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХААХҮЯ, Ургамал, хөдөө аж ахуйн шинжлэх ухааны хүрээлэн, Хувийн хэвшил
Зорилтууд	<p>1) Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих зорилгоор тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх;</p> <p>2) Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, байгалийн нөөцийг хамгаалах.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>1) Эрчимжсэн мал аж ахуй эрхлэлт нэмэгдсэн байна.</p> <p>2) Тэжээлийн ургамлын тариалалт дотоодын эрэлт хэрэгцээг хангасан байна.</p> <p>3) Бэлчээрийн талхагдал буурсан байна.</p>
Төслийн өртөг	Зөөлөн бүрэлдэхүүн хэсэг
Хэрэгжүүлэх хуваарь	2020-2030
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол орны тэжээлийн ургамал нь 4 үндсэн ангиллаас бүрдэнэ. Үүнд: ногоон тэжээл, олон наст ургамал, даршны ургамал болон бусад ургамал. Өвс нь малын гол тэжээл боловч ногоон тэжээл нь өвснөөс илүү эрдэс бодис агуулдаг. 2015 онд тэжээлийн ургамлын хүрэлцээ хангамжийн түвшинг 55 %-тай байсан бөгөөд дутагдалтай хэмжээг гадаадаас импортоор авсан. 2018 онд мал сүргийн тоо 66 сая гаруй болсон бөгөөд Монгол орны төв, хойд хэсэгт хүн ам, малын тоо толгой</p>

	<p>ихээр өсч, нягтрал их байгаа нь бэлчээрийн даацыг хэтрүүлж байна. Байгаль орчныг хамгаалах зорилгоор малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, эрчимжсэн фермерийн аж ахуйг дэмжихийн тулд тэжээлийн ургамлын хангамжийг нэмэгдүүлэх нь зүйтэй юм. Ногоон тэжээл үйлдвэрлэгчийн үнэ сүрэлнээс 3,3 дахин, өвснөөс 1,6 дахин их байгаа тул ногоон тэжээл тариалах нь фермерүүдийн амьжиргааг сайжруулахад хувь нэмэр оруулна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p> <p>a) Тохирох ургамал, сортыг сонгох, үржүүлэх: Эхний алхам нь Монгол орны байгаль орчинд нутагшуулах боломжтой ургамал, сортыг олох явдал юм. Тэжээлийн ургамалд тохиромжтой газрыг үнэлж, шаардлагатай мэдээллийг ашиглан ургамал, сортыг сонгон авна. Урьдчилсан байдлаар сонгосны дараа тариалалтын туршилтыг газар дээр нь хийж, тараах сортуудыг сонгоно. Сонгон шалгаруулалтын явцад малын ашиг шимд сайнаар нөлөөлөх, өсөлтийн хугацаа, тэжээллэг чанар зэрэг сортын үзүүлэлтүүдийг үнэлдэг. Тариалалтыг дэмжихийн тулд үрийн үржлийг мөн харгалзан үзэх хэрэгтэй.</p> <p>b) Тариалалтын арга техникийг сайжруулах нь: Тариалах арга техник нь хадлан, дарш зэргээс хамаарч өөр өөр байж болно. Нэгж талбайгаас авах ургацын хувьд тариалалтын хэмжээ, бордооны хэрэглээ, ус зайлуулах арга хэмжээ, ургац хураах цаг хугацааг харгалзан үзэх шаардлагатай. Жишээ нь: Италийн хөх тариаг хоол боловсруулах хамгийн шим тэжээлтэй үед нь хурааж авахын тулд ургац эхлэн боловсрох үед хураахыг зөвлөж байна. Тиймээс тэжээлийн ургамал тариалах зохих арга техник бүхий тариалангийн хуанли бэлтгэх хэрэгтэй. Тариалангийн хуанли нь үрслүүлэг, тариалах, шилжүүлэн суулгах, усалгаа, зэрлэг ургамал түүх, хураах хуваарь зэргийг агуулсан байх ёстой. Хоршоодын нийгэмлэг байгуулах нь мэдээлэл солилцоход хувь нэмэр оруулж болох талтай. Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эрдэс бодис хэрэглэж болох юм.</p> <p>c) Логистикийн системийг бий болгох нь: Боловсруулах үйлдвэр, хадгалалт, логистик үйлчилгээтэй логистикийн төвүүд нь бүтээгдэхүүнийг түгээхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь аж үйлдвэрийн кластер хэлбэрээр ажилладаг. Логистикийн төвүүд нь бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор дэргэдээ үйлчилгээний төв болон нэрийн барааны дэлгүүртэй байж болно.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>ХХААХҮЯ нь тэжээлийн ургамал тариалах талбайн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт, олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. ХХААХҮЯ нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэргэжлийн арга зүйгээр хангах зэрэг төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.</p>
<p>Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл</p>	<p>Бэлчээрийн талхагдал багассанаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ. Логистикийн төвийн барилга угсралтын ажил, үйл ажиллагааны явцад замын хөдөлгөөний улмаас байгаль орчинд бага зэргийн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Байгаль орчин болон нийгмийн нөлөөллийг хянана.</p>

Тайлбар	
---------	--

Төслийн дугаар: I4.2

Нэр	<b>Мал аж ахуйн салбарт МХТ-ийн хяналтын болон дэмжлэг үзүүлэх системийг нэвтрүүлэх төсөл*</b>
Байршил	Архангай, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Төв, Увс аймаг
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХААХҮЯ, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Хувийн хэвшил
Зорилтууд	1) Чанартай мах, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд голлох үүрэгтэй эрчимжсэн мал аж ахуйг өргөжүүлэх; 2) Бэлчээрийн газрыг хамгаалахад хувь нэмэр оруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Өсөн нэмэгдэж буй дотоодын эрэлт хэрэгцээг хангах, илүүдэл бүтээгдэхүүнийг экспортлох зорилгоор мах, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ улам бүр нэмэгдсэн байна. 2) Тогтвортой аж ахуй хөгжсөн байна. 3) Малын тоо толгой өссөн байна. 4) Бэлчээрийн талхагдал буурсан байна.
Төслийн өртөг	6,475 сая төгрөг + зөөлөн бүрэлдэхүүн хэсэг
Хэрэгжүүлэх хуваарь	2021-2030
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл Статистикийн мэдээгээр нийт 1.4 сая га тариалангийн талбай байна. Тариалангийн талбайгаас ойролцоогоор 1.0 сая га нь газар тариалан эрхлэхэд тохиромжтой газар гэж тодорхойлогддог бөгөөд энэхүү тариалангийн талбайн хөрсийг хамгаалах шаардлагатай. Одоогийн байдлаар газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, өрхүүдийн хувьд хөрсний доройтол асуудал болж байна. Нийт газар тариалан эрхэлдэг өрхийн 57%, аж ахуйн нэгжийн 67% нь хөрсний доройтолтой их бага хэмжээгээр тулгарч байна. Аж ахуйн нэгжүүд химийн бордоог их ашигладагтай холбоотойгоор газар тариалан эрхэлдэг өрхүүдээс илүү ноцтой нөхцөл байдалтай тулгарах хандлагатай байна. Өөр нэг асуудал бол бэлчээрийн даац хэтэрч байгаа явдал юм. 2018 онд мал сүргийн тоо 66 сая гаруй болсон бөгөөд Монгол орны төв, хойд хэсэгт хүн ам, малын тоо толгой ихээр өсч, нягтрал их байгаа нь бэлчээрийн даац хэтрэхэд хүргэж байна. Газрын доройтлыг бууруулахын тулд газар тариалан эрхлэлттэй уялдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэх замаар хөрсийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай. 2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг а) МХТ-ийн хэрэглээг нэвтрүүлэх: Төслөөр 7 хоногийн 24 цагийн бүрэн ажиллагаатай байгаль орчны хяналтын системийг малын хашаанд суурилуулна. Температур, чийгшил, тэжээлийн хэмжээ зэрэг төрөл бүрийн мэдээллийг мэдрэгчээр цуглуулна. Орчны хяналт шинжилгээ хийх замаар уг систем нь температур болон чийгшил нэмэгдэж, буурч байгаа эсэх, тэжээл өгсөн, өгөөгүй зэрэг малын хашаанд тохирох хамгийн оновчтой орчныг автоматаар тооцдог. Цаг бүхий хэмжүүр нь тогтоосон хуваарийн дагуу ажиллах боломжтой. Орчны бүхий л мэдээллийг сүлжээгээр дамжуулан үйлдвэрлэгчид хүргэдэг. Хэрэв систем ямар нэгэн асуудлыг илрүүлбэл үйлдвэрлэгчид дохио өгдөг. Малын хашааны орчинг сүлжээнд холбогдсон тоон төхөөрөмжийг ашигласнаар алсын зайнаас мөн хянаж байдаг. Ингэснээр малын эрүүл мэндэд нөлөө үзүүлэхгүй.

	<p>b) Бусад салбаруудтай хамтран ажиллах: Эрчимжсэн мал ахуйг үр дүнтэй болгохын тулд бусад салбаруудтай хослуулан хөгжүүлэхийг зөвлөж байна. Газар тариалангийн бүс нутагт эсхүл газар тариалан эрхлэлтийг дэмжиж байгаа бүс нутагт эрчимжсэн мал ахуйн фермийг байгуулж болно. Ингэхдээ улаан буудайн хивэг, рапс үрийн тосны бялуу зэрэг дайвар бүтээгдэхүүнийг малын тэжээл болгон мал ахуйд ашиглах, малын аргал, хомоол зэрэг малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг газар тариаланд бордоо болгон хэрэглэж болно. Эдгээр нь байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулна. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын салбаруудтай уялдуулах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа болон хот-хөдөөгийн харилцан үйлчлэлийн замаар нөхөн сэргээх бас нэг хувилбар болно. ТХЗ-ын 11-рт үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг бэхжүүлэх замаар хотууд, суурин газрууд, хөдөө орон нутгууд өөр хоорондоо харилцан холбогдох эдийн засаг, нийгэм, байгаль орчны эерэг уялдаа холбоог дэмжихээр тусгасан.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>ХХААХҮЯ нь нэгдсэн фермерийн аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх талбайн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт, олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. ХХААХҮЯ нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэргэжил, арга зүйгээр хангаж төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Бэлчээрийн талхагдал багассанаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ. Малын хашаанд малын тоо толгой их байх нь малын ялгадсаас болж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгох шаардлагатай. Малын эрүүл мэндийг анхаарах нь чухал.
Тайлбар	


Төслийн дугаар: 15.1

Нэр	Усжуулалтын төсөл
Байршил	Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХААХҮЯ
Зорилтууд	Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх
Хүлээгдэж буй үр дүн	1) Усжуулалтын мастер төлөвлөгөө (УМТ)-г боловсруулсан байна. 2) Улаан буудай, төмс, хүнсний ногооны дотоодын эрэлт хэрэгцээг бүрэн хангасан байна.
Төслийн өртөг	37,388 сая төгрөг + зөөлөн бүрэлдэхүүн
Хэрэгжүүлэх хуваарь	2021-2040
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл ТХҮБ 2030-д тусгаснаар 2030 он гэхэд улаан буудай, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг 100% хангана. Одоогийн байдлаар улаан буудай, төмсний дотоодын эрэлт хэрэгцээг бараг бүрэн хангаж байна. Харин 2018 онд хүнсний ногооны хэрэгцээний 43%-ийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна. Монгол Улсын хүн ам 2030 онд 3.8 сая,

2040 онд 4.5 саяд хүрэх төлөвтэй байгаа тул эрэлт хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлуудын нэг нь тогтвортой бус байдал юм. Хөдөлмөрийн бүтээмжийн жилийн өөрчлөлт ихээхэн ялгаатай байгаа ба аймгуудын нэгжээс хураан авах ургацын хэмжээ өөр өөр байна. Ган гачиг, усжуулалтын систем түүний байгууламж хангалтгүй байгаа нь талбайн нэг нэгжээс авах ургац хэлбэлзэх шалтгаан болж байгаа тул ТХҮБ 2030-д усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 120,000 га-д хүргэхээр зорилт тавьсан. Хэдийгээр өрхийн аж ахуй тариалангийн талбайн 80%, аж ахуйн нэгжийн тариалангийн талбайн 50%-аас дээш хэсэг нь усалгаатай боловч Монгол Улсын газар тариалангийн салбар ган гачигт өртөмтгий хэвээр байна. Үүнээс гадна усжуулалт хийгээгүй өрхийн аж ахуйн 45%, аж ахуйн нэгжийн 49,8% нь усны хомсдол нь хамгийн хүнд бэрхшээл, үүний дараа санхүүгийн эх үүсвэр хомс байдаг талаар дурджээ. Үйлдвэрлэлийг дэмжихийн тулд хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх шаардлагатай бөгөөд усжуулах г.м. дэмжлэг үзүүлэх замаар аймгуудын нэгжээс хураан авах ургацын хэмжээний ялгааг бууруулах хэрэгтэй.

2) Төслийн бүрэлдэхүүн

- a) УМТ-г боловсруулах: Төсөл нь улаан буудай, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг 100 хувь хангахын тулд УМТ-г боловсруулна. Төлөвлөгөө боловсруулах үйл явцын үзэл баримтлалыг дараах зурагт үзүүлэв. Төлөвлөгөө боловсруулах явцад усжуулалтын тогтвортой хөгжил, үндэсний, орон нутгийн түвшний зохион байгуулалт, ядуурлыг бууруулахад болон уур амьсгалын өөрчлөлтөд оруулах хувь нэмэр, усан сангийн зохион байгуулалт зэрэг асуудлуудыг авч үзнэ.
- b) Усжуулалтын систем, түүний байгууламжийг хөгжүүлэх: УМТ-г боловсруулахдаа одоо байгаа усалгаатай талбайг нэмэгдүүлэх зорилгоор шинээр усжуулалт хийх талбайг тодорхойлох, ач холбогдлоор нь эрэмбэлэх болно.
- c) УМТ-нд санал болгох усжуулалтын схем нь даралтат, насосон худаг, далан, усан сан, нуур, гүний усаар усжуулах зэргээс бүрдэнэ. Бүтээн байгуулалтыг төлөвлөх үед усыг олон талаар ашиглах санааг тусгах нь чухал бөгөөд усжуулалтын зэрэгцээ өдөр тутмын амьдралын хэрэгцээ, мал услахад ашиглана.
- d) Үйл ажиллагааны ба удирдлагын системийг бэхжүүлэх нь: байгууламжийг суурилуулсаны дараа тухайн байгууламжийг зохих ёсоор тогтмол ажиллуулж, засвар үйлчилгээ хийх нь чухал юм.





	<p>Үйл ажиллагааны ба удирдлагын гарын авлага, зааврыг боловсруулж, холбогдох талуудад, тухайлбал төрийн албан хаагчид, хөдөө орон нутгийн ус ашиглагчдын холбооны гишүүдэд сургалт зохион байгуулна. Чадавхыг бэхжүүлэх үүднээс мэдээлэл цуглуулах, боловсруулах, хяналт хийхэд МХТ-ийн хэрэглээг суурилуулах асуудлыг авч үзэх хэрэгтэй.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>ХХААХҮЯ нь усалгааны схемийг хөгжүүлэх талбайн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт, олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. ХХААХҮЯ нь усжуулалтын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах үүднээс хувийн хэвшлийн аж ахуй эсхүл ус хэрэглэгчдийн холбоотой гэрээ байгуулна.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	<p>Байгаль орчинд үзүүлэх хүлээгдэж буй эерэг нөлөөлөл нь үр ашигтай усжуулалтын системийг ашиглан усны нөөцийг хадгалан хамгаалах явдал юм. Усжуулалтын байгууламжийг суурилуулах нь газар зохион байгуулалтын өөрчөлтийг хийхийг шаарддаг бөгөөд барилга угсралтын ажлын явцад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд байгаль орчны стратегийн үнэлгээ хийх шаардлагатай. Сөрөг нөлөөллийг бууруулахын тулд хариу арга хэмжээ авахыг зөвлөж байна.</p>
Тайлбар	

### Төслийн дугаар: 15.2

Нэр	Тосны ургамлын тариалалтын төсөл
Байршил	Булган, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Өвөрхангай аймаг
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХААХҮЯ, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Хувийн хэвшил
Зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>1) Тосны ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,</li> <li>2) Хүнсний аюулгүй байдалд хувь нэмэр оруулах.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Тосны ургамал тариалах талбай тэлсэн байна.</li> <li>2) Тосны ургамлын тариалалт нэмэгдсэн байна.</li> </ol>
Төслийн өртөг	Зөөлөн бүрэлдэхүүн хэсэг
Хэрэгжүүлэх хуваарь	2021-2030
Төслийн тодорхойлолт	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл</li> </ol> <p>Монгол Улсад рапс, наранцэцэг зэрэг тосны ургамлыг тариалдаг. Үйлдвэрлэгчийн хураан авсан тосны үр тариаг боловсруулах үйлдвэрт шилжүүлж, эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэдэг. Тосны ургамал боловсруулах үе шатуудад (i) даралт; (ii) бохь гаргаж авах; (iii) цайруулах; (iv) шүрших; (v) сав баглаа боодол зэрэг ордог. Боловсруулалт хийж буй компанийн мэдээллээр нэг тонн рапсыг ойролцоогоор 350 ам.доллараар худалдаж авч 250 литр тос гаргадаг бөгөөд литр тосыг 1.5-2 ам.доллараар борлуулдаг байна. 2015 онд тосны ургамлын дотоодын эрэлт хэрэгцээний 21%-ийг хангаж байсан ба үлдсэнийг нь гадаадаас импортоор авсан. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулахын тулд тосны ургамлыг импортыг орлуулах бүтээгдэхүүн болгон дэмжих нь зүйтэй.</p>

	<p>2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p> <p>a) Тохирох ургамал, сортыг сонгох, үржүүлэх: Эхний алхам бол Монгол орны байгаль орчинд нутагшуулах боломжтой ургамал, сортыг хайх явдал юм. Тосны ургамал тариалах тохиромжтой бүсийн үнэлгээний газрын зургийг боловсруулсан. Энэхүү мэдээлэлд үндэслэн тариалах үр тариа, сортуудыг сонгоно. Урьдчилсан байдлаар сонгосны дараа тариалалтын туршилтыг газар дээр нь хийж, тариалах сортуудыг сонгоно. Сортыг сонгохдоо хөдөлмөрийн бүтээмж, өсөлтийн хугацаа, мэргэжилтнүүдийн үнэлгээнд үндэслэнэ. Рапс тарих тохиолдолд эрукс хүчил агуулаагүй сортуудыг хоол тэжээлийн талаас нь сонгох хэрэгтэй. Үр тарианы төрөлжүүлэлтийн үүднээс авч үзвэл гүнжидийг зөвлөж болох юм. Гүнжид нь гааны төрлийн бүлэгт багтдаг бөгөөд түүний тос нь Омега-3 тосны хүчлийн 60-аас дээш хувийг агуулдаг, нэн чухал тосны хүчлийн нэг ба ердийн хоолны дэглэмийн үед хомсдох хандлагатай байдаг. Эдгээр үр тариаг тариалах нь Монгол Улсын иргэдийн эрүүл мэндэд хувь нэмэр оруулах болно. Тариалалтыг дэмжихийн тулд үрийн үржлийг мөн авч үзэх хэрэгтэй.</p> <p>b) Тариалах арга техникийг сайжруулах: Тосны ургамлыг тухайлбал рапсын үрийг олон төрлийн хөрсөнд тариалах боломжтой боловч хөрсний нөхцөл байдлаас хамааран зохих бордоо хэрэглэснээр илүү сайн ургац хураах гол хүчин зүйл болдог. Харгалзан үзэх бусад зүйлийн хувьд тасралтгүй тариалах замаар цас бороонд цохиулахаас хамгаалах явдал юм. Тиймээс тосны үрийн ургац тариалах зохих техник бүхий тариалангийн хуанли бэлтгэх хэрэгтэй. Үүнээс гадна тосны үрийн ургац тариалахад бусад тарималд одоогоор ашиглаж байгаа техник хэрэгслийг ашиглах боломжийг бий болгох нь зүйтэй юм. Жишээлбэл улаан буудай тариалах машиныг рапс тариалах үед ашиглахдаа үр цацах хушууг тариалалтын хэмжээнд тохируулан өөрчлөх боломжтой бөгөөд ургац хураахад ашигладаг ердийн комбайныг сагаган будааны хушуу ашиглан мөн хураалтанд ашиглаж болно. Боловсруулалтын үе шатанд хатаах, ялгах ажлыг 1 мм-ийн төмөр тор байршуулсан тохиолдолд одоо байгаа машинаар хийж болно. Хоршоодын нийгэмлэг байгуулснаар мэдээлэл солилцоход хувь нэмэр оруулж болох талтай.</p> <p>c) Зах зээлд чиглэсэн үйл ажиллагаа: Мэдээлэл цуглуулах нь зах зээлд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эхний алхам юм. Тосны үрийн ургацын талаарх мэдээллийг зах зээлийн судалгаагаар цуглуулах шаардлагатай. Жишээлбэл чацарганаас гаргаж авсан витаминтай холих нь түүний үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Нэмэлт бүтээгдэхүүн, жишээлбэл, тосны бялууг малын тэжээл, бордоо болгон ашиглаж болно.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>ХХААХҮЯ нь тосны ургамлын үрийг тариалах талбайн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт болон олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. ХХААХҮЯ нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэргэжлийн арга зүйгээр хангах зэрэг төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр холбогдох</p>
--	---

	байгууллагатай гэрээ байгуулна.
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Сөрөг нөлөө байхгүй гэж тооцоолсон ч байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянаана. Хэрэв байгаль орчны болон нийгмийн ямар нэгэн сөрөг нөлөөлөл илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээ авах шаардлагатай.
Тайлбар	

Төслийн дугаар: 15.3

Нэр	Чацаргана тариалалтын төсөл*
Байршил	Булган, Сэлэнгэ, Төв, Увс, Өвөрхангай, Завхан аймаг, Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХААХҮЯ, Монголын жимс, жимсгэний үндэсний холбоо, Монголын хүнсний ногоо, жимс боловсруулах үйлдвэрлэлийн холбоо, хувийн хэвшил
Зорилтууд	Чацарганы үнэ цэнийн шинэ сүлжээ бий болгох суурийг бэхжүүлэх зорилгоор чацарганы үйлдвэрлэлийг өргөжүүлэх.
Хүлээгдэж буй үр дүн	1) Сурталчлах зорилгоор боловсруулсан бүтээгдэхүүнийг тодорхойлсон байна. 2) Чацарганад суурилсан кластерыг байгуулсан байна.
Төслийн өртөг	Зөөлөн бүрэлдэхүүн хэсэг
Хэрэгжүүлэх хуваарь	2021-2030
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл Чацаргана бол Монгол Улсын хөдөө аж ахуйн ирээдүйтэй бүтээгдэхүүний нэг юм. Энэ жимс нь 40 хэмээс доошхи цаг уурын нөхцөлд тэсвэртэй бөгөөд үүгээр шүүс, чанамал, тос, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг олон төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой. Ойролцоогоор 1 кг-ыг чацарганыг 4,000 төгрөгөөр худалдан авч, боловсруулж, 1 кг-ыг дунджаар 6,000 төгрөгөөр зарж борлуулдаг. 50 мл чацарганы тосны зах зээлийн үнэ 20,000 төгрөг орчим бол, 250 мл шүүсний үнэ 2000 төгрөг байна. Одоогийн байдлаар жимсний ихэнх хэсгийг харьцангуй бага өртөгтэй бүтээгдэхүүн болох шүүс, чанамал болгон боловсруулдаг тул илүү их үнэ цэнэ бүхий бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг судлах шаардлагатай. 2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг а) Тариалах орчныг сайжруулах нь: Чацаргана олон янзын хөрсөнд, тэр ч байтугай элсэрхэг, хайргархаг хөрсөнд ургадаг. Чацаргана нь ган гачигт тэсвэртэй боловч усалгаатай тариалан нь усалгаагүйг бодвол илүү тогтвортой ургац өгнө. Иймээс тариалалтын орчныг сайжруулах нь цаашдын үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай. Чацаргана тариалах тохиромжтой бүсийн үнэлгээний газрын зургийг боловсруулсан тул энэхүү мэдээлэлд үндэслэн сортуудыг сонгоно. Ургац хураах ажлыг ихэвчлэн гар аргаар хийдэг бөгөөд өргөс нь гэмтэл учруулж болох боловч зарим сорт нь өргөсгүй байдаг бөгөөд тэдгээрийг тариалах нь үйлдвэрлэгчдийн ажлыг хөнгөвчилнө. Ургац боловсрох хугацаа, ургац хураалтын дараах үед шувууны дайралтаас сэргийлэх арга хэмжээг авч үзэх шаардлагатай.

	<p>b) Зах зээлд чиглэсэн үйл ажиллагаа: Мэдээлэл цуглуулах нь зах зээлд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эхний алхам юм. Шүүс нь хамгийн түгээмэл бүтээгдэхүүн бөгөөд уураг, С ба Е витамин, органик хүчлийн таатай тэнцвэрийг хадгалж байдаг. Навчийг нь мөн тэжээллэг цай, малын тэжээл болгон ашигладаг. Жимснээс гарган авсан тос нь эрдэс бодисоор баялаг тул гоо сайхны болон эмийн зориулалтаар ашиглах боломжтой. Чацаргана боловсруулах талаарх мэдээллийг хоршооллын нийгэмлэг байгуулах замаар цуглуулах шаардлагатай.</p> <p>(3) Хэрэгжүүлэх арга хэмжээ ХХААХҮЯ нь чацаргана тариалах талбайн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт, олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. ХХААХҮЯ нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэргэжил, арга зүйгээр хангах зэргээр төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Сөрөг нөлөө байхгүй гэж тооцоолсон ч байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянаана. Хэрэв байгаль орчны болон нийгмийн ямар нэгэн сөрөг нөлөөлөл илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээ авах шаардлагатай.
Тайлбар	

Төслийн дугаар: 16.1

Нэр	Үхрийн аж ахуй эрхлэх төсөл
Байршил	Монгол Улсын Зүүн бүс, Дорноговь, Өмнөговь аймаг
Хэрэгжүүлэгч агентлаг	Бүс нутгийн хоршоод, их, дээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, Үндэсний хөгжлийн газар
Зорилтууд	Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: (i) гэрээт малчидтай хамтран мал бэлчээрлэх, тарга тэвээрэг авах бүсийг тогтоох, бүс нутагт мал нийлүүлэх, төлбөр тооцоо хийх сан бий болгох, малын толгой бүрийн амьдын жинг хадгалах, нэмэгдүүлэхийн тулд өвлийн улиралд малын тэжээлээр хангах, мөн орон нутгийн болон бүсийн тэжээлийн газар, хашаа саравч, багаж хэрэгслээр тоноглогдсон төвүүдийг тэжээлээр хангах; ба (ii) жилийн турш амжилттай ажиллахын тулд төрөл бүрийн тэжээл, өвсийг турших, зам дагуу өвс тэжээлийг тавьж өгөх, удамшлын хувьд өндөр бүтээмжтэй махны чиглэлийн үхрийн үржлийн сүргийг бий болгох, үйл ажиллагааны болон зохион байгуулалтын багийг тусгай машин техникээр хангаж бэхжүүлэх зэрэг болно.
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Орон нутагт ажлын байр бий болно.</li> <li>2) Малчдын орлогыг нэмэгдүүлнэ.</li> <li>3) Хангамжийн гол сүлжээг бий болно.</li> <li>4) Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор шинэ технологийг түгээн дэлгэрүүлнэ.</li> </ol>
Төслийн өртөг	Төсвийн эсхүл ТХХТ-ийн хөрөнгө оруулалт, богино хугацаанд үйлдвэрлэл эрхлэх зорилгоор гэрээт фермерүүдтэй хязгаарлагдмал хариуцлагатай түншлэл (ХХТ) байгуулан хамтран ажиллах; Арилжааны гэрээний үндсэн дээр турших зорилгоор сонгон авсан малыг үржүүлэх; саалийн төв, гэрээт засвар үйлчилгээний төв (саалийн газар, зөөврийн саалийн машин, тэжээлийн төв, сүү хадгалах болон хөргөх цистерн г.м.) байгуулах 1.5 сая ам.доллар.

	<p>Дэвшилтэт технологи бүхий сургалт семинар зохион байгуулах: 1.0 сая ам.доллар. Нийт зардал: 2.5 сая ам.доллар. Хувийн хөрөнгө оруулалт Боловсруулах үйлдвэр, агуулах зэрэг байгууламжид 1 сая ам.доллар. 100,000 ам.доллар./ хөрөнгө оруулалт * 10 тооцоолсон хөрөнгө оруулалт</p>
Хэрэгжүүлэх хуваарь	<p>Төсөл боловсруулах ТЭЗҮ: 2021 Бүтэц зохион байгуулалт ба сангийн зохицуулалт: 2022 Төслийн эхний хэрэгжилт: 2023 Төслийн бүрэн хэмжээний үйл ажиллагаа: 2024~</p>
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл Мал аж ахуй эрхлэлт нь бэлчээрийн доройтол, малын тэжээл, худаг усны хангамж хүрэлцээгүй, малчдын бүлэг, хоршоо хангалтгүй, техникийн тусламж, дэмжлэг сул зэрэг олон бэрхшээлтэй тулгарч байгаагаас үүдэн ган, зуд, уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байна. Мал аж ахуйн салбар оршин тогтнох, цаашлаад дэлхийн эдийн засагт байр суурь эзлэхэд зохион байгуулалттай, цогц дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай байна.</p> <p>2) Төслийн тодорхойлолт Төслийн хүрээнд бэлчээрийн даацыг сайжруулах зорилгоор өвс ургамлын ургалтыг тэтгэхийн тулд малын бэлчээрийг орон нутгийн улирлын чанартай ажилладаг сүлжээтэй хамтран судалгаан дээр үндэслэн тогтооно. Энэхүү сүлжээ нь эдийн засгийн нөөц ашиглах боломжгүй алслагдсан бүс нутгийг говийн бүс нутагтай холбох, уул уурхайн хэрэгцээнд зориулж чанартай үхрийн махны нийлүүлэлтээр эрэлт хэрэгцээг хангах, малчид, үйл ажиллагааны болон зохион байгуулалтын баг, гадаадын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах замаар орон нутгийн хангамжийн логикийн сүлжээг бий болгох, бизнесийн загварчлалыг сайжруулах мэдээллийн санг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна. Энэхүү сүлжээгээр дамжуулан тэжээлийн нийлүүлэлтийг сайжруулах шаардлагатай.</p> <p>Орон нутгийн нөөцийг бусад боловсруулах салбарт үнэтэй түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх зорилгоор цуглуулж амьжиргаа дээшлүүлдэг алслагдсан хөдөө орон нутгийн бага орлоготой малчид иргэдийн дунд хамтарсан аж ахуй эрхлэлт хэрэгжих болно.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ Төслийг ҮХГ-ын зохицуулалтын дагуу ТХХТ-ийн зарчмаар хэрэгжүүлнэ. ҮХГ-ын удирдамжаар тухайн аймгийн засаг захиргаа нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг байгуулж болно. ХХААХҮЯ болон холбогдох төрийн байгууллагууд техникийн дэмжлэг үзүүлнэ</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	<p>Бэлчээрийн доройтлын эрсдэлийг бууруулна. Төлөвлөж буй хэрэгжилт нь ямааны тоо толгойг хянах үүднээс байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалахад тус дөхөм болно.</p>
Тайлбар	

**Төслийн дугаар: 16.2**

Нэр	<b>Эрдэнэ шиш даршлах үйлдвэрийн төсөл</b>
Байршил	Булган аймгийн Орхон сум
Хэрэгжүүлэгч	Булган Агро ХХК, Үндэсний хөгжлийн газар

агентлаг	
Зорилтууд	Дарш үйлдвэрлэлийн бааз суурийг бий болгох, бүс нутгийн сүүний фермийн хангамжийн сүлжээг байгуулж, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотуудын зах зээлд нийлүүлэх сүүний хангамжийг тогтмол нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх.
Хүлээгдэж буй үр дүн	1) Орон нутагт ажлын байр бий болно. 2) Малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлнэ. 3) Гадаад валютын орлого олно.
Төслийн өртөг	Төр эсхүл ТХХ-ийн хөрөнгө оруулалт Дэд бүтэц бүхий бүтээн байгуулалт: 1.5 сая ам.доллар. (30 ам.доллар / м <sup>2</sup> * 5 га) 30/м <sup>2</sup> барилгын ажлын нэгж өртгийг бусад орнуудын үйлдвэрийн барилга байгууламжийн өртгөөс тооцож авсан. Нядалгааны байрны барилгын ажил: 9.0 сая ам.доллар. (30 м <sup>2</sup> * 3000 м <sup>2</sup> талбай) Төсөөлөл: Шаардлагатай талбайн хэмжээ: том малд 100/м <sup>2</sup> , жижиг мал 10/м <sup>2</sup> талбайтай байх Нядалх малын тоо: өдөрт 20 бод мал, 100 бог мал Өндөр хөгжилтэй орнуудын (Япон, АНУ) туршлагад үндэслэн нэгж талбайн барилгын өртөг: 30 ам.доллар /м <sup>2</sup> МХТ-ийн хэрэглээний талаар семинар зохион байгуулах зардал: 1.0 сая ам.доллар. Нийт зардал: 11.5 сая ам.доллар. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт Боловсруулах үйлдвэр, агуулах зэрэг газар дээрх барилга байгууламжид 1 сая ам.доллар. 100,000 ам.доллар / хөрөнгө оруулалт * 10 тооцоолсон хөрөнгө оруулалт
Хэрэгжүүлэх хуваарь	Төсөл боловсруулах ТЭЗҮ: 2021 Бүтэц зохион байгуулалт ба сангийн зохицуулалт: 2022 Төслийн эхний хэрэгжилт: 2023 Төслийн бүрэн хэмжээний үйл ажиллагаа: 2024~
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх гол хөшүүрэг нь бүтээмжийг нэмэгдүүлэх бөгөөд ингэснээр хот суурин, экспортын зах зээлд өрсөлдөх чадвартай болох юм. Сүүний чиглэлийн мал аж ахуй эрхлэхэд чанартай тэжээлээр хангах шаардлагатай бөгөөд даршны ургамал тариалах нь үр дүнтэй юм. 2) Төслийн тодорхойлолт Сүү, хуурай сүү, бяслаг зэрэг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай, чанартай төрөл бүрийн дагалдах бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэж хөгжүүлэх болно. Эрдэнэ шиш богино хугацаанд боловсрох чадвартай тул санхүүжилтийг бодлогоор шийдвэрлэсэн тохиолдолд эрдэнэ шиш даршлах үйлдвэрлэл явуулах боломжтой юм. Төслийн үйл ажиллагаанд хуурай сүү үйлдвэрлэх технологи зэрэг сүүн бүтээгдэхүүний төрөл бүрийн үйлдвэрлэлийг туршин үзэх семинарыг оруулсан болно. Мал аж ахуйн болон үйлдвэрлэлийн менежментэд их өгөгдлийг ашиглан симуляц хийх үйл ажиллагааг нэмэх боломжтой. 3) Хэрэгжүүлэх арга хэмжээ

	Засгийн газар нь төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл ТХХТ-ийн зарчмаар санхүүжилтийг татан төвлөрүүлж, төслийн талбай, дэд бүтэц болох усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, мал нядалгааны газар зэрэг бүтээн байгуулалтыг хийнэ. Засгийн газраас байгуулсан паркад үйл ажиллагаа явуулах үйлдвэрүүдэд хувийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулна. Түрээслэгчдэд зориулсан борлуулалт, түрээсийн асуудлыг тусгана.
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Нядалгааны газар, арьс шир боловсруулалтын улмаас үүдсэн хатуу хог хаягдал, бохир ус цэвэрлэх зохих арга хэмжээг авах шаардлагатай. Бууцыг бордоо болгон ашиглах бөгөөд газар тариалангийн эргэлтэд царгас, арвай орно. Орон нутгийн газар зохион байгуулалт нь бэлчээрийн зохион байгуулалтын адил сайжрах болно.
Тайлбар	

**Төслийн дугаар: 16.3**

Нэр	Малын тэжээлийн төв байгуулах төсөл
Байршил	Төв аймгийн Жаргалант хороо (Булган, Сэлэнгэ аймагт мөн боломжтой)
Хэрэгжүүлэгч агентлаг	Орон нутгийн хоршоологчид, Их дээд сургуулиудын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, ҮХГ
Зорилтууд	(i) Улаанбаатар, Эрдэнэт, Дархан орчмын Бүрэн найрлагат хүчит тэжээлийн (БНХТ) төвүүдийг хангахаар гэрээт тариаланчидтай хамтран эрдэнэ шиш, царгас, арвайг туршилтаар тарих, (ii) Тэжээлийн ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн дэвшилтэт технологийг турших, орчин үеийн хөдөө аж ахуйн машин төхөөрөмжийг талбайд турших суурь баазыг бий болгох.
Хүлээгдэж буй үр дүн	1) Малын тэжээлийн үлдэгдлийг ашиглан орон нутагт ажлын байрыг бий болгоно; 2) Малчид, хөдөөгийн өрхийн орлогыг нэмэгдүүлнэ; 3) Гадаад валютын орлого/хадгаламж нэмэгдэнэ; 4) Үр тариа үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр шинэ технологийг нэвтрүүлнэ.
Төслийн өртөг	Төрийн эсвэл төр хувийн хэвшлийн түншлэлээр (ТХХТ) хийгдэх хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл эрхлэх гэрээт тариаланчидтай богино хугацаанд хамтран ажиллах орон нутгийн хязгаарлагдмал хариуцлагатай түншлэл: Гэрээт техникийн үйлчилгээний төвүүдийг (дэвшилтэт техник хэрэгслийг түрээслэх хөдөө аж ахуйн үйлчилгээний төв гэх мэт) худалдааны гэрээний үндсэн дээр хөгжүүлэх туршилтын ажилд зориулж 1.5 сая ам.доллар (өөр өөр бус нутагт нийтдээ 500 га). Үүнд сэлбэг хэрэгслийн агуулах, үүрэн холбооны оператор, механикчдын сургалт багтана. Дэвшилтэт технологийн талаарх семинар: 1.0 сая ам.доллар Нийт өртөг: 2.5 сая ам.доллар Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт: Үр тариа боловсруулах, хадгалах барилга байгууламжуудад 1 сая ам.доллар 100,000 ам.доллар / х.ор * 10 тооцоолж буй х.ор
Хэрэгжүүлэх хуваарь	Төсөл боловсруулах, ТЭЗҮ: 2021 Зохион байгуулалтыг эхлүүлэх, төсвийн бүрдүүлэлт: 2022 Төслийн анхан шатны хэрэгжилт: 2023



	Төслийн бүрэн хэмжээний хэрэгжилт: 2024 оноос
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжихийн тулд дотоодын тэжээл үйлдвэрлэлийг ихээхэн нэмэгдүүлэх шаардлагатай. Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: 1) эрдэнэ шишний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, 2) тэжээл бэлтгэх гэрээлэгч, 3) механикжсан аргаар эрдэнэ шиш тариалалтыг өргөжүүлэх 4) холимог тэжээлийн нийт хэмжээг (total mixed ration) тогтоох. Тэжээл бэлтгэх гэрээлэгчид нь тариалангийн талбайгаас үр тариа хураан авсны дараа тэжээлийн түүхий эдийг хураах хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага байна. Холимог тэжээлийн нийт хэмжээ гэдэг нь бага өртөгтэй, тэжээллэг чанартай малын тэжээл үйлдвэрлэх зорилгоор орон нутгийн тэжээлийн ургамлыг хольж, гаргасан тэжээл юм.</p> <p>2) Төслийн тодорхойлолт</p> <p>БНХТ төв - сүүний фермерүүдэд зориулсан тэжээлийн төвүүд нь сүүний нөөцийг чанартай, тогтмол нийлүүлэх зорилгоор газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих төрөл бүрийн дэвшилтэт технологийг туршиж нэвтрүүлэх үйлдвэр байхаас гадна тэжээлийн ургамлын тариалалтад хэрэглэх бордоо болгож ашиглах өтөг бууцны арвин их нөөц (органик бордоо) байх юм.</p> <p>Тариалангийн талбайд машин техникийн туршилтыг хийх бөгөөд нэг үнээний сүүний гарц нэмэгдэх болно. Тугалыг тусад нь тэжээдэг үнээний фермийн менежмент нь хуурай сүүг (сүүний үнэ бага, зуны улиралд сүүг хатааж нунтаглан гаргаж авдаг) тэжээлд ашигладаг бөгөөд үнээний төллөлт ойрын ирээдүйд сайжирна.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Хувийн хөрөнгө оруулагчид (мөн гэрээт тариаланчид) Засгийн газраас чиглэл болгосон тэжээлийн ургамалд хөрөнгө оруулалт хийх болно. Түрээслэгчдэд зориулсан газар түрээслэх гэрээнд тэжээлийн фондод зориулсан түрээсийн гэрээ орно.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Химийн бордооны оронд малын бууц хэрэглэнэ.
Тайлбар	

#### Төслийн дугаар: 16.4

Нэр	<b>Хуурай сүү үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх төсөл</b>
Байршил	Говийн бүс, Говь-Алтай, Сүхбаатар аймаг
Хэрэгжүүлэгч агентлаг	Орон нутгийн хоршоологчид, их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, ҮХГ
Зорилтууд	<p>(i) Хөдөөгийн бага орлоготой малчдын оролцсон хоршооллыг зохион байгуулах, бүс нутгаар сүү нийлүүлэх нэгжид зориулж тэмээ, ямааг хамтран хариулах, өвлийн улиралд тэжээлээр баталгаатай хангах, ингэний сүүний гарцыг нэмэгдүүлэх, аймгийн төвүүдэд орон нутгийн болон бүс нутгийн чанартай хуурай сүү үйлдвэрлэх төвүүдийг байгуулах;</p> <p>(ii) Үйлдвэрийг бүтэн жилийн турш ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс нунтагласан бүтээгдэхүүний дэвшилтэт технологи ашиглан ургамлын гаралтай нунтаг, хуурай айраг зэрэг бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий сүү хүлээн авах, өтгөрүүлэх, саалийн машин, малын эрүүл мэндийн бааз суурийг бий болгох.</p>

Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Орон нутагт ажлын байрыг бий болгоно;</li> <li>2) Малчдын орлого нэмэгдэнэ;</li> <li>3) Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх сүлжээг бий болгоно;</li> <li>4) Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлийн шинэ технологийг түгээнэ.</li> </ol>
Төслийн өртөг	<p>Төрийн эсвэл төр хувийн хэвшлийн түншлэлээр (ТХХТ) хийгдэх хөрөнгө оруулалт, мөн үйлдвэрлэл эрхлэх гэрээт тариаланчидтай богино хугацаанд хамтран ажиллах орон нутгийн хязгаарлагдмал хариуцлагатай түншлэл:</p> <p>Туршилтад зориулж үнээ шилж авах, саалийн төвүүд хамтран саахад зориулж сүрэг үүсгэх, гэрээт техникийн үйлчилгээний төв (саалийн үнээ, саалийн хөдөлгөөнт машин, тэжээлийн төв, сүү хадгалах, хөргөх сав гэх мэт): 1.5 сая ам.доллар Дэвшилтэт технологийн семинар: 1.0 сая ам.доллар Нийт зардал: 2.5 сая ам.доллар Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт Боловсруулах үйлдвэр, агуулахын барилга байгууламжуудад 1 сая ам.доллар 100,000\$/х.ор * 10 тооцоолж буй х.ор</p>
Хэрэгжүүлэх хуваарь	<p>Төсөл боловсруулах, ТЭЗҮ: 2021 Зохион байгуулалтыг эхлүүлэх, төсвийн бүрдүүлэлт: 2022 Төслийн анхан шатны хэрэгжилт: 2023 Төслийн бүрэн хэмжээний хэрэгжилт: 2024 оноос</p>
Төслийн тодорхойлолт	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл Хуурай сүү үйлдвэрлэх технологи нь нунтаг бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн технологи юм. Энэхүү технологиор ямаа, ингэний хуурай сүү үйлдвэрлэж, бүтээгдэхүүн тээвэрлэлтийг хялбаршуулан, зах зээлийг өргөжүүлэх боломжтой.</li> <li>2) Төслийн тодорхойлолт Гоо сайхны болон бусад салбарын үйлдвэрлэлд байгалийн гаралтай орц болгож нийлүүлэх боломж буюу ургамлын гаралтай нунтаг, байгалийн гаралтай бусад нунтаг орцыг өөр бүтээгдэхүүнд хамтруулах, хөнгөн жинтэй, өндөр үнэтэй, тээвэрлэхэд хялбар, удаан хугацаагаар хадгалах боломж бүхий өөр бүтээгдэхүүн болгох замаар сүүн бүтээгдэхүүний эдийн засгийн үнэ цэнийг өсгөх талаар анхаарсан. Энэ нь хөдөөгийн бага орлоготой малчдад илүүтэй нийцэх бөгөөд ингэснээр тэд орон нутгийнхаа нөөцийг өндөр үнэ бүхий экспортын нунтаг бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болно. Одоогоор ямааны тоо толгой хэт өсч, тэмээ эдийн засгийн хувьд ашиггүй байгаа боловч түүхий сүү нийлүүлэх сүлжээ үүсгэн, савлахад хялбар хуурай сүү үйлдвэрлэснээр хадгалалтын үнэ зэрэг бусад зардлыг багасган эдийн засгийн хувьд ашигтай болно.</li> <li>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ Төслийг ҮХГ-ын зохицуулалтын дагуу ТХХТ-ийн хэлбэрээр хэрэгжүүлнэ. ҮХГ-ын удирдамжаар тухайн аймгийн засаг захиргаа нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг байгуулж болно. ХХААХҮЯ болон холбогдох төрийн байгууллагууд техникийн дэмжлэг үзүүлнэ.</li> </ol>
Байгаль орчин ба нийгмийн	<p>Бэлчээр талхлагдах эрсдэл буурна. Ямааны тоо толгойг хяналтад авах зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлэх нь байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд тус дэм болно.</p>

нөлөөлөл	
Тайлбар	Ямааны тоо толгой ихтэй нутгуудад энэ төсөл зохих үр өгөөжтэй байх болно. Ямаа болон гүүний сүүг орлогын нэмэлт эх үүсвэр болгон ашиглаж болно.

**Төслийн дугаар: 17.1**

Нэр	<b>Хөргүүр, зоорийн сүлжээ байгуулах төсөл</b>
Байршил	Дархан-Уул, Хэнтий, Ховд, Сэлэнгэ, Төв, Увс, Өвөрхангай
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХААХҮЯ Хувийн хэвшил
Зорилтууд	1) Үр тариа, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй тээвэрлэх, хадгалах; 2) Үндэсний хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах
Хүлээгдэж буй үр дүн	1) Хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөргүүр, агуулахын аж ахуйг хөгжүүлнэ; 2) Дотоодын хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ.
Төслийн өртөг	3,500 сая төгрөг + программын хангамж
Хэрэгжүүлэх хуваарь	2021-2030
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл ТХҮБ 2030-д дотоодын зах зээлийг улаан буудай, төмс хүнсний ногоогоор 100 хувь хангана гэж тодорхойлсон. Гэвч хүнсний ногооны хангамж байнга буурсаар 2018 онд 43 хувьтай байна. 2030 оны түвшинд Монгол Улсын хүн ам 3.8 сая, 2040 онд 4.5 сая болох төлөвтэй байгаа бөгөөд үүсэх эрэлт хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Цаг агаарын нөхцөлөөс шалтгаалж ургалтын хугацаа тун богино байдаг. Хүлэмж барьж ашиглах нь хүнсний ногоог өвөл ургуулах нэг хувилбар болж байна. Үйлдвэрлэл нэмэгдсэн ч ургацаа хэрэглэгчдэд хүргэж чадахгүй бол хүнсний ногооны хэрэгцээг дотоодоос хангах хэмжээг нэмэгдүүлэхэд тус болж чадахгүй. Иймд хөргүүр/зоорийг нэмэгдүүлэх нь үр дүнтэй байх болно. ТХҮБ 2030 баримт бичигт мал аж ахуйн салбарын түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн. Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн нь Монголчуудын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн тул өсөн нэмэгдэж буй хүн амыг шинэ мах, сүүгээр хангах зорилгоор зориулалтын хөргөлттэй агуулахын сүлжээг байгуулж, бүтээгдэхүүнийг хөдөө орон нутгийн үйлдвэрлэгчээс хот суурины хэрэглэгчид тээвэрлэн хүргэнэ. Нэг хүнд ногдох махны хэрэглээг жилд 112,6 кг-аар тооцдог бөгөөд махыг экспортод гаргахгүй тохиолдолд дотоодын зах зээлийг хангах боломжтой. 2017 оны байдлаар нийт 661,9 сая литр сүү үйлдвэрлэсэн бөгөөд үүний 81.6%-ийг үнээний сүү эзэлж байна. Малчид саасан сүүнийхээ ихэнхийг өөрсдийн хэрэгцээнд зориулдаг. Дотоодын махны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахын зэрэгцээ мах экспортлох, нэмүү өртөг шингэсэн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хөргүүр, зоорийн сүлжээ байгуулах зайлшгүй шаардлагатай. 2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг

	<p>a) Агуулах/зоорийн олон төрлийн хувилбар байдаг тул үүнээс хадгалах зохистой технологийг сонгох. Хадгалалтын үндсэн хэлбэр бол цахилгаан хөргүүр боловч энэ нь барилгын болон ашиглалтын зардал өндөр. Өөр нэг хувилбар нь нарны зайгаар ажилладаг хөргүүр юм. Энэ хувилбарын Монгол дахь өртөг ойролцоогоор 15.000 ам.доллар бөгөөд байгаль хамгаалах асуудалд нэмэр болно. Томоохон хэмжээний агуулахын хувьд нарны болон цахилгаан эрчим хүчийг хамтруулсан хосолмол цахилгаан үүсгүүрийг ашиглахыг зөвлөж байна. Учир нь зөвхөн нарны эрчим хүчээр хангах төхөөрөмж нь ашиглалтын үед хангалттай эрчим хүч үйлдвэрлэхэд хүчин чадал нь хүрэхгүй байх талтай. Байгалийн мөс ашигладаг мөсөн зоорийг мөн хэрэглэж болох ба энэ нь байгаль орчинд ээлтэй арга юм. Мөсөн зoorь нь бага температурт хадгалах байгууламж бөгөөд байгалийн мөсний далд дулаан эффeктийг ашиглан тасалгааны температурыг жилийн турш тэг хэмд барьдаг. Өвлийн улиралд ус шингэн хэлбэрээс шилжиж мөс болох үедээ дулааныг ялгаруулдаг бөгөөд зуны улиралд эсрэг байдлаар үйлчилдэг. Нойтон элсээс гарах ууршилт ба нарны цацрагийн эмиссээс үүсэх хөргөх эффeктийг ашигладаг “Zeeg pot” аргыг мөн байгаль орчинд ээлтэй технологи болгон ашиглаж болох юм.</p> <p>b) Зохистой байршлыг сонгох: бүтээгдэхүүнийг агуулах, зоориноос тодорхой цэгт хүргэх шаардлага дээр суурилж хөргүүр/зoorь, боловсруулах үйлдвэр, тээвэр үйлчилгээ зэргийг багтаасан логистикийн төвүүдийг байгуулах боломжтой болно.</p> <p>3) Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>ХХААХҮЯ нь агуулах, зoorь байгуулах талбайн байршлыг тогтоох, түүний хүчин чадлыг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх үүрэгтэй. ХХААХҮЯ нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэргэжлийн арга зүй зэрэг төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.</p>
<p>Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл</p>	<p>Ерөнхийдөө сөрөг нөлөөлөл харагдахгүй байгаа ч байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд хяналт тавьж байх болно. Гэхдээ хөрс хуулах, тээврийн хөдөлгөөн үүсэх зэргээр логистикийн төвүүдийн барилга угсралтын ажлын явцад болон ашиглалтын үед байгаль орчинд бага зэргийн сөрөг нөлөө үзүүлнэ. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянаж байх болно.</p>

**Төслийн дугаар: 17.2**

<p>Нэр</p>	<p><b>Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл*</b></p>
<p>Байршил</p>	<p>Дархан-уул, Хэнтий, Ховд, Сэлэнгэ, Төв, Увс, Өвөрхангай аймаг</p>
<p>Хэрэгжүүлэгч агентлаг</p>	<p>ХХААХҮЯ (ХХМТГ-ын дэмжлэгтэй) Хувийн хэвшил</p>
<p>Зорилтууд</p>	<p>1) Хүнсний салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах;</p>

	2) Малчид, малчдын бүлэг, жижиг дунд фермерүүдийн бизнес, эдийн засгийг дэмжих; орчин үеийн техник, технологи ашиглах, тогтвортой үйлдвэрлэлийн санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх
Хүлээгдэж буй үр дүн	1) Ферм/сүргийн менежментийг сайжруулна. 2) Малын өвчний хяналт, эрт сэрэмжлүүлэх системийг сайжруулна. 3) МХХТ-ийн сургалт, мэдлэгийн менежментээр дамжуулан шинэ технологийг нэвтрүүлснээр чадавхыг нэмэгдүүлнэ. 4) Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг тогтооход олон улсын стандартыг дагаж мөрдөх, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ. 5) Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн зах зээлийн өрсөлдөх чадвар болон экспортын зах зээлийг өргөжүүлнэ.
Төслийн өртөг	5 сая ам.доллар
Хэрэгжүүлэх хуваарь	Энэ системийг бүрдүүлэхэд 2-3 жил шаардагдана. Эхний жил: Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, системийн загварыг гаргах. Прототип загварыг туршиж үзэх. 2 дахь жил: Сургалт, чадавхыг бэхжүүлэх, туршилтын төсөл хэрэгжүүлэх. 3 дахь жил: хяналт, үнэлгээ, нийтэд дэлгэрүүлэх.
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл ТХҮБ 2030 баримт бичигт хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбартай холбоотой хөгжлийн гол зорилтуудыг дэвшүүлсэн: Олон улсын стандартыг нэвтрүүлснээр өрсөлдөх чадварыг бэхжүүлэх; Хангамжийн сүлжээг сайжруулах; Эрчимжсэн газар тариалангийн технологийг нэвтрүүлэх; Газар тариалангийн жижиг үйлдвэрлэгчдийг дэмжих; Худалдааны сүлжээний үйл явцыг түргэтгэх. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дижитал технологийг зүй зохистой нэвтрүүлэх нь нэн чухал юм. Хөдөө аж ахуй, хүнсний салбарт үндэсний дижитал технологийн платформ байхгүй үед жижиг үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид бизнесийн үйл явцдаа хүнсний чанар, аюулгүй байдлын олон арга хэмжээг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй тулгардаг бол ийм дижитал платформ нь Засгийн газар шийдвэр гаргах, зохих цаг хугацаанд нь бодлогоор нөлөөлөх, цаашдын судалгаа, шинжилгээнд ашиглах зорилгоор санал хүсэлт, өгөгдөл мэдээллийг авахад тус дэм болдог. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газар нь Олон улсын Цахилгаан холбооны байгууллагатай хамтран Монгол Улсын Засгийн газарт Цахим хөдөө аж ахуйн стратегийн баримт бичиг боловсруулахад туслалцаа үзүүлж байна. Цахим хөдөө аж ахуй нь хөдөө аж ахуйн салбарт анхаарал хандуулж, хөдөө орон нутагт МХХТ-ийг ашиглах шинэлэг арга хэрэгслийг боловсруулах, хөгжүүлэх, ашиглах тухай юм. НҮБ-ын ХХААБ, ОУЦХБ-ын боловсруулж гаргасан хөдөө аж ахуйн үндэсний стратегийн гарын авлагыг ( <a href="http://www.fao.org/3/a-i5564e.pdf">http://www.fao.org/3/a-i5564e.pdf</a> ) хэд хэдэн оронд өөрийн үндэсний стратегиа боловсруулахад ашиглажээ. Цахим хөдөө аж ахуйн стратеги нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын дэвшил хөгжлийг ашиглах "Засгийн газрын хандлага", хөдөө аж ахуйн салбарын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд даван туулах шаардлагатай байгаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд илүү сайн хөшүүрэг, хурдан ахиц дэвшил өгдөг хөрөнгө оруулалтыг оновчтой болгох, эрэмбэлэхэд чухал үүрэгтэй.

	<p>Монгол Улсын Цахим хөдөө аж ахуйн стратегийн баримт бичиг нь Монголд дижитал хөдөө аж ахуй, тэр дундаа маш өндөр боломж бүхий мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх стратегийг тодорхойлно. НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар энэ чиглэлээр Малыг эзэмгүүлж, цахимд бүртгэх төсөл, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг хянах blockchain гэсэн хоёр төсөл хэрэгжүүлээд байна. НҮБ-ын ХХААБ-аас ОУЦХБ, ХХААХҮЯ, ХХМТГ-тай хамтарч төслийн эхний шатанд төрийн ба хувийн салбарын гол оролцогч талуудтай хэд хэдэн уулзалт зөвлөгөөн зохион байгуулсан. Эдгээр төсөл нь олон салангид байгаа төрөл бүрийн дижитал болон ердийн үйлчилгээг үндэсний нэгдмэл цахим системд оруулж хооронд нь уялдуулж нэгтгэхэд тусална.</p> <p>Дараагийн алхмаар НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар ОУЦХБ-ын техникийн туслалцаатайгаар хүнсний салбарт үндэсний дижитал технологийн систем бий болгоход Засгийн газарт туслахыг зорьж байгаа бөгөөд энэ нь засгийн газраас хөдөө аж ахуй, хүнсний салбарт тавьж буй зорилтуудыг хэрэгжүүлэх, хянах боломжийг олгоно. Энэхүү дижитал систем нь Засгийн газрын хувьд сайн чанарын, ул мөрийг нь бүрэн мөрдөн тогтоох боломжтой хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх замаар дотоодын болон экспортын хүнсний зах зээлийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны чухал элемент байх болно.</p> <p>Монголын хүнсний бүтээгдэхүүн тэр дундаа махан бүтээгдэхүүн нь ОХУ, БНХАУ болон Европын бусад зах зээлд "бэлчээрийн мал"-ын чанартай мах гэдгээрээ өндөр үнэлэгддэг. Гэсэн хэдий ч хүчтэй бөгөөд өргөжүүлж болохуйц бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох систем байхгүй тохиолдолд энэ боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна. Түүнчлэн тариаланчид, малчдыг нэг дижитал сүлжээнд оруулснаар тэдэнд бэлчээрийн менежментийг сайжруулах, газар тариалангийн үйлдвэрлэлийн шинэ технологи гэх мэт техникийн мэдлэгийг нэвтрүүлэхэд хялбар болох ба энэ тал дээр НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газраас ХХААХҮЯ болон бусад холбогдох агентлагуудад туслахад бэлэн байна. Төсөлд ОУЦХБ-тай түншлэх нь техникийн зураг төсөл, хэрэгжилтийг хялбар болгох болно. Тиймээс энэхүү төслийн утга санаа нь улс орны тэргүүлэх чиглэлд нийцсэн, цаашдаа хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн гол хөдөлгөгч хүч болох бөгөөд энэ зорилгод хүрэхийн тулд үндэсний болон олон улсын агентлагууд хамтран ажиллаж байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн дижитал платформын ерөнхий зураг төслийг гаргах:</p> <ul style="list-style-type: none"><li>a) Хөдөө аж ахуй, хүнсний салбарын гол оролцогч талууд болон хэрэглэгчдийн бүлгийн бизнес үйл явц, хэрэглэгчийн зорчилт/тээврийн судалгаа хийх;</li><li>b) Одоо байгаа тоон систем/үйлчилгээнд техникийн дүгнэлт хийх;</li><li>c) Одоо байгаа дижитал үйлчилгээг бичил үйлчилгээний бүтцээр нэгтгэх;</li><li>d) Өгөгдлүүд өөр хоорондоо зохицож уялдах, аюулгүйн стандарт тогтоох;</li><li>e) Прототип загвар боловсруулах, турших;</li><li>f) Хэрэглэгчдээс түүвэр бүлэг/сонирхогч тал/түншүүдийг тодорхойлох;</li><li>g) Хөдөлгөөнт болон вэб програмуудыг боловсруулах;</li></ul>
--	---

	<p>h) Туршилтын төсөл хэрэгжүүлэх; i) Прототип загварыг үнэлэх, сайжруулах, дахин давталт хийх. j) Сургалт, чадавхыг бэхжүүлэх; k) Ур чадвар/мэдлэгийн дутагдалтай талыг тогтоосны үндсэн дээр сургалт/чадавхыг бэхжүүлэх загвар бий болгох; l) Сургалт явуулах. m) Хяналт, үнэлгээ хийх; n) Нөлөөллийн үнэлгээ (технологи суурилуулах, эдийн засгийн ашгийн хувь гэх мэт) хийх; o) Цаашид өргөжүүлэх зорилготой төр хувийн хэвшлийн түншлэлийн дэд төслүүдийг (тухайлбал холбооны операторуудтай) хэрэгжүүлэх.</p> <p>3) Хэрэгжилт НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар ХХААХҮЯ, ХХМТГ-тай хамтарч Үндэсний цахим хөдөө аж ахуйн стратегийн хэрэгжилтийн хүрээнд төслийн үр дүнтэй байдлыг хангах болно.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	<p>1) Бэлчээрийн менежментийг сайжруулах; 2) Байгалийн нөөцийг хамгаалах менежментийг сайжруулах; 3) Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байх; 4) Ядуурлыг арилгах; 5) Найдвартай, шим тэжээл сайтай хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх; 6) Экспортын боломж нэмэгдсэнээр хүнсний салбарын микро, жижиг, дунд үйлдвэрлэгчид эдийн засгийн хувьд ашигтай байх.</p>
Тайлбар	

**Төслийн дугаар: 18.1**

Нэр	Газрын ховор элементийн хайгуулын төсөл
Байршил	Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч агентлаг	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)
Зорилтууд	<p>1) Олборлох боломжтой газрын ховор элементийн нөөцийн хайгуул хийх; 2) Монгол Улсын эдийн засгийг дэмжих зорилгоор уул уурхайн салбарыг төрөлжүүлэхэд хувь нэмэр оруулах; 3) Дэлхийн технологийн шинэчлэлд зайлшгүй шаардлагатай түүхийг эд нийлүүлэх замаар Монгол Улсын стратегийн байр суурийг дээшлүүлэх.</p>
Хүлээгдэж буй үр дүн	Ирээдүйтэй ордуудыг тодорхойлох замаар газрын ховор элементийн нөөцөд суурилсан уул уурхайг тогтвортой хөгжүүлнэ.
Төслийн өртөг	
Хэрэгжүүлэх хуваарь	<p>Хайгуулын хуваарь: 1-р үе шат: 2022 онд Өмнөговь аймгийн Мушгиа худаг, Хотгор 2-р үе шат: 2023 онд Ховд аймгийн Халзан бүрэгтэй 3-р үе шат: 2024 онд Дорноговь аймгийн Лугын гол</p>
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл Газрын ховор элемент гэдэг нь ашигт малтмалын 17 элементийг багтаасан нэр томъёо бөгөөд дэлхий дээр байдаг ховор металл юм. Газрын ховор элементийн 5 төрлийн орд байдаг. Үүнд: карбонатитын орд, төмрийн хүдрийн орд, ион агуулсан нэгдлийн орд, элсэрхэг орд,</p>

шүлтлэг чулуулгийн орд багтана. Эдгээр ордуудад газрын ховор шороон элементүүд агуулагддаг. Газрын ховор шороон элемент нь шинж чанараасаа шалтгаалан бүхий л үйлдвэрлэлд ашиглагддаг бөгөөд цахилгаан автомашин (EV), дижитал камер, гар утас, зөөврийн компьютер, телевизор зэрэг бусад үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай түүхий эд юм. Тэдгээрийг цаашдаа шилэн субстратын зүлгүүр, авто машины катализатор, жижиг мотор, хагас дамжуулагч, шингэн талст, хэт дамжуулагч зэргийг үйлдвэрлэхэд өргөнөөр ашиглана. Тиймээс газрын ховор шороон элементийн эрэлт хэрэгцээ ихээхэн өснө. АНУ нь дэлхийд газрын ховор шороон элементийн томоохон үйлдвэрлэгч байсан. Гэвч БНХАУ-ын хямд үнийн стратеги бүхий газрын ховор элементийн үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжил, экспортын улмаас ихэнх улс орнуудын үйлдвэрлэл шахагдан гарсан. 1990-ээд онд БНХАУ-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь бусад орны үйлдвэрлэлийг давсан тул тус улс нь олон жилийн туршид газрын ховор элементийн зах зээлд ноёрхож байв. Үйлдвэрлэлийн асар их хувийг эзэлдэг БНХАУ газрын ховор шороон элементийг үндэсний стратегийн бараа гэж үздэг. Энэхүү чухал нөөцийг дотоодын зах зээлд тэргүүн ээлжинд нийлүүлдэг.

2018 оны байдлаар дэлхийн хэмжээнд 130,000 тонн газрын ховор элемент үйлдвэрлэсний 79% нь БНХАУ, 15% нь Австрали, 2% нь ОХУ, 2% нь Бразил улсад ногдож байна. 2010 онд БНХАУ газрын ховор элементийн олборлолт, үйлдвэрлэл, экспортын квотыг бууруулсан нь дэлхийн хэмжээнд газрын ховор элементийн үнийг өсгөж, худалдан авалтад хүндрэл учруулсан юм. Тиймээс газрын ховор элементийн зах зээлийг төрөлжүүлэх зорилгоор дэлхийн хэд хэдэн улс шинэ уурхай байгуулах төлөвтэй байна. 2018 оны байдлаар дэлхийн хэмжээнд 126,000 тонн газрын ховор элементийн оксидын нөөц байгаа ба үйлдвэрлэлийн хэмжээг авч үзвэл уурхайн ашиглалтын хугацаа урт байна. Нийт нөөцийн 36% нь БНХАУ, 18% нь Бразил, 18% нь Вьетнам, 6% нь Энэтхэг улсад байна. БНХАУ-ын газрын ховор элементийн оксидын нөөц нь үйлдвэрлэлийн хэмжээнээс бага юм. Шинэ уурхайн бүтээн байгуулалтаас хамааран цаашид БНХАУ-ын эзлэх хувь хэмжээ буурч магадгүй. Газрын ховор элементийн үнэ тухайн элементээс хамааран харилцан адилгүй байдаг ба зарим элементийн үнэ бусдаасаа 10 дахин түүнээс ч илүү үнэтэй байдаг. БНХАУ газрын ховор элементийн олборлолт, үйлдвэрлэл, экспортын квотыг бууруулсны улмаас 2011 онд түүний үнэ дунджаар 1 кг нь 180 ам. долларт хүрч байсан бол одоогийн байдлаар 1 кг нь 40-60 ам. долларын хооронд хэлбэлзэж байна. Нэн ховор металлаас неодими, диспросиум, тербиум нь өндөр температурт шахалтын хүч/соронзон урсгалын нягтыг нэмэгдүүлэх шинж чанартай байдаг. Тиймээс тэдний хэрэглээ улам бүр нэмэгдсээр байна. Хавтгай дэлгэцийн шилэн зүлгүүрийн бодис болох церий, иттрий, фосфор, автомашины утааг цэвэршүүлэгч лантанумын эрэлт нэмэгдэж байгаа бөгөөд цаашид ч эрэлт улам бүр нэмэгдсээр байх төлөвтэй байна. 2018 оны байдлаар 1 кг неодимийн үнэ 70-75 ам. доллар, 1 кг иттрийн үнэ 3-4 ам. доллар, 1 кг лантерны үнэ 4-5 ам. доллар байсан. Бастнасит, моназит, ксенотим, ионы агууламж бүхий анхны хүдрийн биетийг олборлон, халууны задралын аргаар газрын ховор шороон элементийг ялгаж авдаг. Дараа нь нэгдлийг ялгаж, цэвэршүүлэн газрын ховор металл үйлдвэрлэгддэг. Бастнезитийн хөвүүлэн баяжуулах, өвөрмөц таталцал, моназитын соронзон тусгаарлалтыг ашигладаг. Ховор металлыг цэвэршүүлэх, боловсруулах нь тээврийн үр ашгийг нэмэгдүүлж, өртгийг бууруулна.



	<p>Гэвч газрын ховор элементүүд нь уран зэрэг цацраг идэвхт элементүүдэд төстэй хариу үйлдэл үзүүлдэг тул тэдгээрийг цэвэршүүлсний дараа агуулгад нь цацраг идэвхт материал орж болзошгүй. Энэ нь өртгийн хувьд сул тал болно. Өөр нэг асуудал нь газрын ховор элементийг хямд өртгөөр хүдрээс ялгаж авах технологийг хөгжүүлэх явдал юм.</p> <p>2) Одоогийн байдал</p> <p>БНХАУ-ын газрын ховор элементийн хамгийн том орд ӨМӨЗО-ны Баян-Овоогийн орд юм. БНХАУ-аас гадна АНУ-ын Mountain Pass, Канад улсын Hoidas, Thor нуур, Австрали улсын Dabbo Zirconia, Mount Weld, Nolans Boga-гаас газрын ховор элементийг олборлож байна. Газрын ховор элементийн эрэлт ирээдүйд улам бүр нэмэгдэж, цахилгаан авто машин, электрон төхөөрөмж улам боловсронгуй болсоор байх болно. Түүнчлэн 2011 онд БНХАУ-ын уул уурхайн экспортын хязгаарлалтаас үүдэн газрын ховор элементийн үнийг өсгөхгүйн тулд бусад улс оронд газрын ховор элементэд түшиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр зорьж байна. Монгол Улсад газрын ховор элементэд түшиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь БНХАУ-ын монополийг задлахад чухал ач холбогдолтой юм.</p> <p>3) Монгол Улсын газрын ховор элементийн нөөц баялаг</p> <p>Монгол Улсын Өмнөговь аймгийн газрын ховор элементийн орд БНХАУ-ын Баян-Овоотой хиллэж оршдог тул геологийн тогтцын хувьд ижил төстэй шинж чанартай. Монгол Улс нь газрын ховор элементийн нөөц баялаг ихтэйд тооцогддог. АНУ-ын Геологийн судалгааны албаны 2009 оны судалгаагаар Монгол Улс 31 сая тонн газрын ховор элементийн баялагтайг тогтоожээ. Монгол Улсад газрын ховор элементийн 4 ордыг тогтоосон. Үүнд Өмнөговь аймгийн Мушгиа худаг, Хотгор, Ховд аймгийн Халзан бүргэдэй, Дорноговь аймгийн Лугын голын орд багтана. Мушгиа худгийн ордод 1983 онд ЗХУ, Монгол Улс хамтран хайгуул хийсэн бөгөөд өрөмдлөгийн хайгуулыг 2007- 2012 онуудад хийж байжээ. Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай хилэн оршдог нь экспортын бараа бүтээгдэхүүний үнэд нөлөөлдөг. Тиймээс газрын ховор элементийг боловсруулж арилжааны бүтээгдэхүүн үйлдвэрлэн, контейнер тээвэрлэлтээр бус агаараар шууд экспортлох боломжтой юм.</p> <p>4) Хайгуулын хамрах хүрээ</p> <p>Монгол орны газрын ховор элементийн дөрвөн ордод нөөцийн судалгаа хийнэ.</p> <p>Гадаргын эрэл хайгуул: Энэ бүс нутагт хиймэл дагуулын зураг, геологийн шинжилгээ хийнэ.</p> <p>Өрөмдлөг: Гүний өрөмдлөгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах. Өрөмдлөгийн дээжээс чулуулгийг ангилна (фосфатын хүдэр, карбонатитын хүдэр, флюорит хүдэр гэх мэт). Үүнээс гадна ерөнхий чулуулгийн бүтэц, чулуулгийн эрдэсжилтийн бүтэц, хэлбэр зэргийг шинжилнэ.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар анхаарах нь судалгааны чухал хэсэг байх ёстой.
Тайлбар	

Төслийн дугаар: 18.2

Нэр	<b>Металл ашигт малтмалын нөөцийн зах зээлийн судалгаа хийх төсөл</b>
Байршил	Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч агентлаг	УУХҮЯ, АМГТГ
Зорилтууд	1) Ойрын хугацаанд олборлож болох ирээдүйтэй ордуудыг тодорхойлох зорилгоор эрдэс металлын нөөцийн хайгуул хийх; 2) Монгол Улсын эдийн засаг, экспортыг тогтмол дэмжихийн тулд уул уурхайн салбарыг төрөлжүүлэхэд хувь нэмэр оруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Ашигт малтмалын нөөц, тэдгээрийн бүтээгдэхүүний экспортыг өргөжүүлнэ; 2) Ашигт малтмалын нөөцийг боловсруулах технологийг бий болгоно.
Төслийн өртөг	
Хэрэгжүүлэх хуваарь	Үе шат 1: Зэс, алт, молибден, мөнгө, цагаан тугалга, гянтболдын олон улсын эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийх; Үе шат 2: 1) Эдгээр ашигт малтмалын эрэлт, нийлүүлэлтийн олон улсын хэмжээний ирээдүйн урьдчилсан таамаглалыг бий болгох; 2) Олон улсын үнийн чиг хандлагад дүн шинжилгээ хийж, ашигт малтмалын ирээдүйн үнийг урьдчилан таамаглах; Үе шат 3: Ашигт малтмалын экспортын чиглэлд үнэлгээ хийж, сонгох.
Төслийн тодорхойлолт	1) Үндэслэл Монгол Улс нь ашигт малтмалын арвин нөөцтэй боловч зөвхөн зэсийн үйлдвэрлэлийг далайцтайгаар хөгжүүлж байна. Алт, мөнгө, цагаан тугалга, гянтболд, төмрийн хүдэр, никель, цайр, вольфрам, хайлуур жонш, молибден зэрэг бусад ашигт малтмалыг бага хэмжээгээр олборлож байна. Учир нь дэд бүтэц, зах зээлийн хөгжил сул, хэтийн эрэлт хэрэгцээний урьдчилсан тооцоо хийгдээгүйд оршиж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэн, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд хааш нь экспортлох, зах зээлийн хэтийн төлөв байдал, ашигт малтмалын хүлээгдэж буй эрэлтэд үндэслэн дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. Ашигт малтмалын дэлхийн зах зээлийн дундаж үнийг Лондонгийн металлын бирж тодорхойлдог. Дэлхийн эдийн засаг хөгжихийн хэрээр эрдэс баялгийн түүхий эдийн эрэлт хэрэгцээ жил ирэх тусам өсч байгаа нь үнийн өсөлтөд нөлөөлдөг. Тухайлбал 2000 оноос хойш дэлхийн зах зээл дээр эрдэс баялгийн үнэ огцом өссөн. 2005 он хүртэл дэлхийн зах зээл дээр 1 тонн зэсийн үнэ 3,000 ам. доллараас доогуур байсан. Гэвч 2005 оноос хойш дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ өсч, одоогийн байдлаар 1 тонн зэсийг 5,000 ам. доллараар худалдаалж байна. 2019 онд дээд цэгтээ хүрч, 1 тонн зэсийн үнэ 6,572 ам. доллар болсон. Өнгөрсөн хугацаанд 1 тонн цайр, хар тугалганы үнэ 1,000 ам.доллараас доогуур байв. Харин 2005 оноос хойш өсч, одоогийн байдлаар 1 тонныг нь 2,000 ам. доллараас дээш үнээр худалдаалж байна. 2019 онд 1 тонн цайрын үнэ 3,018 ам. доллар, 1 тонн хар тугалганы үнэ 2,267ам. долларт хүрсэн. Зэс, цайр, хар тугалганы үнэтэй харьцуулахад никель ба цагаан тугалганы үнэ харьцангуй хурдан өсч, өмнө нь 1 тонн нь 5,000-6,000 ам.доллар байсан бол 10,000-15,000 ам.доллар болж өсчээ. Дэлхийн зах зээл дээрх алтны үнийг 2000 онтой харьцуулбал 4 дахин өсчээ.

Металл ашигт малтмалын эрэлт хэрэгцээний чиг хандлагыг харахад ирээдүйд цахилгаан хөдөлгүүрт автомашин, цэнэглэдэг гибрид автомашин үйлдвэрлэснээр зэсийн эрэлт нэмэгдэх хандлагатай байгаа тул үнэ нь өсөхөөр байна. Цахилгаан хөдөлгүүрт машин нь энгийн машинаас 3-4 дахин их зэс ашигладаг. Цахилгаан автомашины үйлдвэрлэл хөгжсөнөөр ирэх арван жилд зэсийн эрэлт 9 дахин нэмэгдэнэ. Цахилгаан хөдөлгүүрт машинаас гадна цахилгаан эрчим хүчний эрэлт нэмэгдсэнтэй холбогдуулан ирээдүйд зэсийн эрэлт өндөр байх төлөвтэй байна.

Зэвэрдэггүй ган материалын үйлдвэрлэл нь никелийн гол хэрэглэгч бөгөөд цэнэг хураагуурын үйлдвэрлэлийн хувьд никелийн эрэлт жилээс жилд нэмэгдэх төлөвтэй байгаа нь никель бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж байна. Литийн эрэлт цахилгаан автомашины худалдааны зах зээл тэлэхийн хэрээр нэмэгдэх бөгөөд литийн нийлүүлэлтийн хомсдолоос болж 2023 оноос хойш литийн үнэ огцом нэмэгдэх төлөвтэй байна. Ховор металл, газрын ховор элементүүд нь дижитал камер, гар утас, зөөврийн компьютер, телевизор, шилэн субстратын зүлгүүр, авто машины катализатор, жижиг мотор, хагас дамжуулагч, шингэн талст, хэт дамжуулагч зэргийг үйлдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай эрдэс баялаг юм. Цаашдаа эдгээр эрдэс баялгийн эрэлт огцом өсөх хандлагатай байна. Дээр дурдсанаар зах зээлийн хэтийн төлөв байдал, цаашдын эрэлт хэрэгцээг тусгасан металл ашигт малтмалын зах зээлийг хөгжүүлэх хэрэгтэй.

#### 2) Одоогийн байдал

2018 онд Монгол Улсын нийт экспортын 93%-ийг ашигт малтмалын бүтээгдэхүүн эзэлж байсан байна. Түүнээс металл ашигт малтмал 45%, нүүрс 42%, газрын тос 6%-ийг тус тус эзэлж байна. Ашигт малтмалын бүтээгдэхүүн бус экспорт зөвхөн 7% байна. Металл ашигт малтмалын экспорт 3,028 сая ам.долларт (45%) хүрч, уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засгийн голлох салбар юм.

Зэсийн баяжмал нь металл ашигт малтмалын экспортын нийт үнийн дүнгийн 66.5% (2,013 сая ам. доллар), төмрийн хүдэр 11.3% (342 сая ам. доллар), цайр 6.5% (197 сая ам.доллар), флюорит 6.3% (191 ам. доллар) байна. сая), алт 4.8% (145 сая ам. доллар), зэс 2.7% (81 сая ам. доллар), молибден 1.6% (48 сая ам. доллар), вольфрам 0.3%-ийг (9 сая ам.доллар) тус тус эзэлж байна. Металл ашигт малтмал нь Монгол Улсын экспортын чухал бүтээгдэхүүн бөгөөд цаашид тогтвортой үйлдвэрлэж, экспортлох төлөвтэй байна. Тиймээс зах зээлийн хэтийн төлөв байдал, цаашдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан ашигт малтмалын экспортын стратегийг боловсруулах зайлшгүй шаардлагатай.

#### 3) Үр дүн

Ашигт малтмалын эрэлт, нийлүүлэлтийн цаашдын чиг хандлага, олон улсын үнэ ханшийг урьдчилан таамагласнаар урт хугацааны тогтвортой хөгжлийн төлөвлөгөө, экспортын зорилтыг найдвартай хангах боломжтой болно.

#### 4) Бизнесийн тодорхойлолт

Эхний ээлжинд зэс, алт, молибден, мөнгө, цагаан тугалга, гянтболд, төмрийн хүдэр, хайлуур жонш, хар тугалга, цайр зэргийн олон улсын өнөөгийн эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийнэ. Үүний дараа эдгээр ашигт малтмалын дэлхийн хэмжээний ирээдүйн эрэлт, нийлүүлэлтийн талаар урьдчилсан тооцоо хийнэ. Дараагийн алхам нь олон улсын үнийн чиг хандлагыг судалж,

	ашигт малтмалын цаашдын үнийг урьдчилан таамаглах судалгаа байх болно. Эдгээр мэдээлэлд үндэслэн олборлолт, экспортын болон боловсруулах технологийг нэвтрүүлэх төлөвлөгөөг сонгоно.
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар анхаарах нь судалгааны салшгүй чухал хэсэг байх ёстой.
Тайлбар	

Төслийн дугаар: I9.1

Нэр	<b>Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл*</b>
Байршил	Нүүрсний уурхай болон тээвэрлэх чиглэл
Хэрэгжүүлэгч агентлаг	УУХҮЯ, ЭХЯ
Зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>1) Азийн бүс нутаг, зүүн хойд Азийн зах зээлийн чиг хандлагыг ойлгох;</li> <li>2) Экспортын нүүрс тээвэрлэх оновчтой маршрутыг тодорхойлох;</li> <li>3) Таван толгойн нүүрсний хангамжийн сүлжээг байгуулах;</li> <li>4) Нүүрсний экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	Нүүрсний тээврийн зардлыг бууруулна; Нүүрсний тээвэрлэлтийг оновчтой болгон сайжруулах замаар нүүрсний экспортыг дэмжинэ.
Төслийн өртөг	
Хэрэгжүүлэх хуваарь	<p>Үе шат 1: Дэлхийн эрчим хүч, нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн дүн шинжилгээ</p> <p>Үе шат 2: Нүүрс тээвэрлэлтийн дэд бүтцийн судалгаа, маршрутын харьцуулалт, дүн шинжилгээ</p> <p>Үе шат 3: Нүүрсний экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах цогц үнэлгээ</p>
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>Таван толгойн уурхайн нүүрсний тээвэрлэлтийн тухайд одоогийн байдлаар зүүн болон өмнөд чиглэлийн төмөр замууд баригдаж байна. Зүүн чиглэлийн төмөр зам Таван толгойгоос Сайншандыг холбох бөгөөд дараа нь Чойбалсантай холбогдоно. Өмнөд чиглэлийн төмөр зам Таван толгойгоос Гашуун Сухайт хүртэлх төмөр зам юм. Таван толгойн нүүрсийг олон улсын зах зээлд аль чиглэлээр гаргах нь одоогоор шийдээгүй байна. Энэхүү судалгаагаар Таван толгойн нүүрсийг Япон улсад экспортолно гэж тооцон Таван толгойн нүүрс тээвэрлэлтийн сүлжээг бүрдүүлэхийн тулд дээрх хоёр чиглэлд эдийн засгийн үнэлгээ хийх болно. Түүнчлэн судалгааны хүрээнд Азийн бүс нутаг, зүүн хойд Азийн зах зээлийн чиг хандлагыг судална.</p> <p>Монгол Улсаас нүүрсээ олон улсын зах зээлд гаргах хоёр маршрутаас ОХУ-ын төмөр замын царигийн өргөн нь Монголын төмөр замын царигийн өргөнтэй ижил тул хил дээр зөөж ачих шаардлагагүй. Үүнээс гадна Сибирийн төмөр зам Монголын нүүрсийг тээвэрлэх хүчин чадалтай. Гэсэн хэдий ч одоо байгаа боомтын хүчин чадал хангалтгүй байгаа тул ихээхэн хэмжээний ачааг зохицуулах хүчин чадалтай боомт шаардлагатай байна. Өөр нэг дутагдалтай тал бол тээвэрлэх зай нь БНХАУ руу тээвэрлэх маршрутаас илүү урт. БНХАУ руу тээвэрлэх маршрут нь ОХУ-тай харьцуулахад богино зайтай бөгөөд тээвэрлэх боомтын багтаамж хангалттай боловч Монголын төмөр замын царигийн өргөн зөрдөг тул хил дээр зөөх ачилт хийх</p>

шаардлагатай болдог. Үүнээс гадна БНХАУ-ын төмөр замын ачаа тээвэрлэлтийн хүчин чадал хангалтгүй зэрэг сул талууд бий. Ямартай ч аль нэг чиглэлийг нь ашиглан нүүрс тээвэрлэхээс өөр сонголт байхгүй тул цаашдаа маршрутын сонголтыг авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Ялангуяа Азийн улс орнуудын эдийн засгийн өсөлт өндөр байгаа нь нүүрсний эрэлтийг нэмэгдүүлэхээр байна. Олон улсын эрчим хүчний агентлагийн боловсруулсан бодлогын хувилбараас үзэхэд 2040 онд Энэтхэг улсын нүүрсний эрэлт 97%-иар, Зүүн өмнөд Азийн улс орнуудын нүүрсний эрэлт 91%-иар тус тус өснө. Монгол Улсын нүүрсний экспортын хувьд Ази, ялангуяа Зүүн хойд Азийн улс орнуудын нүүрсний эрэлт, нийлүүлэлт, цаашдын зах зээлийн чиг хандлагыг ойлгох нь чухал юм. Энэхүү судалгааны хүрээнд БНХАУ, зүүн хойд Азийн бусад орнууд (Япон, БНСУ, БНХУ), Энэтхэг, зүүн Өмнөд Азийн улс орнуудын нүүрсний эрэлт хэрэгцээ, нүүрсний томоохон нийлүүлэгчдийн талаар судална. Монголын нүүрсний экспортын өрсөлдөх чадварын талаар дүн шинжилгээ хийж, үр дүнтэй стратегийг хэрэгжүүлэх боломжтой.

Одоогийн байдлаар олон улсын зах зээлд Австрали, Индонези, Мозамбик, Колумби, Канад, АНУ нүүрс экспортолж байна. Олон улсын зах зээлд эдгээр улсуудтай Монголын нүүрсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлийн зардал, тээврийн зардал, боомтын үйлчилгээ, БНХАУ, ОХУ-аар дамжин өнгөрсний төлбөр зэргийг анхааран үзэх шаардлагатай.

Монгол Улсын коксжих нүүрсний чанарыг дэлхий дахинд өндөр үнэлдэг тул Зүүн Ази руу экспортлох өндөр боломж байгаа бөгөөд нүүрсийг чанараас нь хамаарч экспортлох боломжтой.

## 2) Одоогийн байдал

Өмнөговь аймгийн нүүрсний ордыг ашиглахтай холбогдуулан нүүрс тээвэрлэх 4 чиглэлийг судалж байна. Чиглэл 1: БНХАУ-аар дамжин өнгөрөх (Нарийнсухайт нүүрсний уурхай → Тэньжин боомт), Чиглэл 2: (Таван Толгойн нүүрсний уурхай → Тэньжин боомт), Чиглэл 3: (Таван Толгойн нүүрсний уурхай → Бичигт → Жинзоу боомт), Чиглэл 4: ОХУ-аар дамжин өнгөрөх (Толгойн нүүрсний уурхай → Сүхбаатар → Владивосток боомт)-ыг тооцсон.

Төмөр замын тээврийн зардлыг тооцоход 1-р чиглэлийн замын урт 2,056 км, тээврийн зардал 1 тонн ачаа 58.58 ам. доллар, 2-р чиглэлийн замын урт 1,622 км, тээврийн зардал 1 тонн ачаа 60.64 ам. доллар, 3-р чиглэлийн замын урт 2,188 км, тээврийн зардал 1 тонн ачаа 91.72 ам. доллар тус тус байна. 4-р чиглэлийн замын урт 5,490 км, тээврийн зардал 1 тонн ачаа 120.61 ам. долларын үнэтэй байна. Тээврийн зардалд төмөр замын тээврийн тариф, гаалийн төлбөр, ачаа шилжүүлэн ачилтын хөлс, боомтын карго үйлчилгээ, экспортын татвар зэрэг орно. Улс орнуудын төмөр замын тээврийн тариф өөр өөр байдаг бөгөөд Монгол Улсад ачаа тээврийн 1 тн.км-ийн жишиг тариф 0.036 ам. доллар, БНХАУ-д 1.75+0.009 ам. доллар, ОХУ-д 0.0193 ам. доллар байна.

2018 онд Монгол Улс 36.67 сая тонн нүүрс экспортолсон нь Монгол Улсын нийт экспортын 42% -ийг эзэлж байна. Үүнээс боловсруулсан коксжих нүүрс 5.48 сая тонн (1 тн~100-120 ам. доллар), түүхий нүүрс 14.4 сая тонн (1 тн~ 60-65 ам. доллар), хагас коксжих нүүрс 11.68 сая тонн (1 тн~ 35-40 ам. доллар), дулааны нүүрс 5.11 сая тонн (1 тн~15-20 ам. доллар) эзэлж байна.

## 3) Үр дүн

	<p>Монгол Улсаас Япон улс руу гаргах нүүрсний экспортын эдийн засгийн үнэлгээг танилцуулна.</p> <p>4) Төслийн хамрах хүрээ</p> <p>a) Дэлхийн эрчим хүчний эрэлт, нийлүүлэлтийн дүн шинжилгээ</p> <p>b) Зүүн хойд Ази болон бусад Азийн улс орнуудын нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн төсөөлөл</p> <p>c) Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын дэд бүтцийн судалгаа</p> <p>d) Задгай боомтын чиг хандлага, далайн ачаа тээврийн тооцоо</p> <p>e) ОХУ, БНХАУ-ын ачаа тээврийн тарифын судалгаа</p> <p>f) ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн маршрутын харьцуулалт, иж бүрэн үнэлгээ</p> <p>g) Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварт нөлөөлж буй үйлдвэрлэлийн зардал, тээврийн зардал, боомтын үйлчилгээ, БНХАУ, ОХУ-аар дамжин өнгөрсний төлбөр зэрэг холбоотой асуудлуудыг нэгтгэж, шаардлагатай сайжруулалтыг хийх.</p> <p>h) Нүүрсний экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээний талаар дүгнэлт хийх</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар авч үзэх нь судалгаа, үнэлгээний нэг хэсэг болно.
Тайлбар	

**Төслийн дугаар: 19.2**

Нэр	<b>Нүүрсний ордын хайгуулын төсөл</b>
Байршил	Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч агентлаг	УУХҮЯ, ЭХЯ
Зорилтууд	Монгол Улсын хэмжээнд геологийн тогтоц, нүүрсний давхарга, нөөц, нүүрсний чанарын талаар дүн шинжилгээ хийх замаар Монгол Улсын нүүрсний салбарын хөгжлийн потенциалыг үнэлэх.
Хүлээгдэж буй үр дүн	Энэхүү төсөл нь Монгол Улсын нүүрсний нөөцийг тодорхойлоход хувь нэмэр оруулна. Нүүрсний шинэ ордыг илрүүлсний үндсэн дээр уул уурхайн хөгжлийн стратегийг болвсруулна.
Төслийн өртөг	
Хэрэгжүүлэх хуваарь	<p>Үе шат 1: Нүүрсний нөөцийн геологийн хайгуул судалгаа хийх нутаг дэвсгэрийг судалж, судалгаа эрлийн ажил хийх нутаг дэвсгэрийг тогтоон, судалгаа хайгуулыг өргөн хүрээнд хийж гүйцэтгэнэ. (2 жил)</p> <p>Үе шат 2: Нүүрсний ордын нарийвчилсан хайгуул, эрэл хийх байршлыг тодруулан сонгож, тухайн байршилд нарийвчилсан хайгуул хийж, нүүрс олборлох боломжийг тодруулах. (2 жил)</p> <p>Үе шат 3: Нүүрсний нөөцийн үнэлгээ хийх (1 жил)</p>
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол оронд 15 нүүрсний сав газарт 320 гаруй орд бий. Нүүрсний ордын геологийн нас нь эрт төрмөлийн эрин, цэрдийн галавын үе бөгөөд нүүрсний техникийн шинж чанарын үзүүлэлтүүд Монгол Улсын баруун хязгаараас зүүн хязгаар хүртэлх өргөн уужим газар нутагт харилцан адилгүй байна.</p> <p>Баруун Монголд орших Хархираа, Баян-Өлгий, Монгол Алтайн нүүрсний сав газар нь эрт төрмөлийн эринд бүрэлдэн тогтсон. Эдгээр</p>

	<p>сав газарт битумтэй тослог нүүрсний (дулааны болон коксжих нүүрс) орд бий. Эдгээр нүүрсний сав газрууд нь далайн эрэг дагуу хуримтлагдсан чулуулаг, коксжилтын өвөрмөц шинж чанартай. Монгол орны өмнө зүгт орших Өмнөговийн сав газар нь пермийн галвын эрин үед бүрэлдэн тогтсон бөгөөд битумтэй тослог нүүрсний (дулааны болон коксжих нүүрс) орд бий. Таван толгойн орд зэрэг нүүрсний ордыг агуулсан энэхүү сав газрыг коксжих нүүрс олборлох зорилгоор хөгжүүлж ирсэн. Монгол орны төв хэсэгт орших Чойр-Нялгын хүрэн нүүрсний сав газар, зүүн зүгт орших Тамсагийн сав газар нь юрийн галав болон цэрдийн галавын үед тус тус бүрэлдэн тогтсон. Баруун, өмнөд зүгийн нүүрсний сав газрын нүүрсний чанарт хүрэхгүй хагас битумт нүүрс, хүрэн нүүрс бөгөөд тунамал гарал үүсэлтэй гэж үздэг. Монгол орны нүүрсний давхарга нь наснаас хамааран тунамал хурдсын давхарга, төрөл бүрийн чиглэлтэй тектоник хөдөлгөөний улмаас үүссэн.</p> <p>2007 он хүртэл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед дотоодын хэрэгцээнд 10 сая тонн хүрэн нүүрс үйлдвэрлэсэн байна. Үүний дараа Өмнөговь аймагт пермийн галавын эрин үеийн өндөр чанартай коксжих нүүрс олдсоноор Эрдэнэс Таван толгойн нүүрсний уурхай, Ухаа худаг нүүрсний уурхай, Нарийн сухайтын нүүрсний уурхайг бүрэн хэмжээгээр хөгжүүлж ирсэн юм.</p> <p>Өмнөговь аймгаас баруун зүгт орших Баянхонгор, Говь-Алтай аймаг, Монгол Улсын умард хэсэгт ОХУ-тай хиллэн оршдог Хөвсгөл, Булган аймаг нүүрсний баялаг орд газруудтай. Өмнөговь аймагт нүүрсний нөөцийн геологийн эрэл хайгуул, судалгааг бүрэн хийгээгүй байна. Эдгээр газар нутагт тархсан нүүрсний ордтой холбоотой цөөн баримт мэдээлэл, бүртгэл байгаа ба нүүрсний нөөцийг бүрэн хэмжээгээр тодорхойлох геологийн эрэл хайгуул, судалгаа хийх шаардлагатай байна. Тиймээс нүүрсний салбарын хөгжлийн потенциалыг тодруулах нь зүйтэй. Одоогийн байдлаар Монгол Улсын нүүрсний геологийн таамаг нөөц 162 тэрбум тонн бөгөөд геологийн эрэл хайгуулын үд дүнд тогтоосон нөөц бага байна. Тиймээс Монгол Улсын хэмжээнд хайгуул хийгдээгүй газар нутагт нүүрсний нөөцийн хайгуул хийх, нүүрсний ордын геологийн тогтоц, нүүрсний давхаргын төлөв байдал, нүүрсний нөөцийн хэмжээ, нүүрсний чанарыг нарийвчлан судлах нь нэн чухал ач холбогдолтой юм.</p> <p>2) Судалгааны хамрах хүрээ</p> <p>Нүүрсний нөөцийн геологийн хайгуул судалгаа, эрлийн ажлыг дор дурдсанаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p>Алсын зайн тандалт судалгаа</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Газар нутаг, геологийн тогтоцын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авна. Нүүрсний ордын нарийвчилсан хайгуул, эрэл хийх байршлыг сонгоход ашиглана.</li></ul> <p>Геологийн хайгуул судалгаа</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Чулуулгийн найрлага, хувирал, бүтэц зэргийг тухайн байршил дээрх судалгаагаар тогтоох</li></ul> <p>Геофизикийн судалгаа</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Газрын хэвлийн талаарх мэдээлэл болон соронзон/таталцал/цахилгаан соронзон геофизикийн аргыг ашиглан агаараас судалж, нарийвчилсан хайгуул, эрэл хийх байршлыг сонгоно.</li></ul>
--	--

	<ul style="list-style-type: none"><li>✓ Геологи хайгуул хийхдээ агаараас судлах нь томоохон газар нутгийг хамруулах боломжтой. Өрөмдлөг хийж чулуулгийн физик-механикийн шинж чанарыг тогтооно.</li></ul> <p>Өрөмдлөгийн ажил</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Хайгуулын талбайд өрөмдлөг хийж, газрын доор болон гадарга дээрх чулуулгийн дээжийг авч ашигт малтмалын ордыг судлах, эрдэс түүхий эдийн химийн шинжилгээ, физикийн шинж чанарын шинжилгээ хийнэ.</li></ul> <p>Ордын үнэлээ</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Судалгаа шинжилгээний програм хангамж ашиглан олж авсан өгөгдлийг боловсруулж, ашигт малтмалын ордын нөөцийн гурван хэмжээст тархалт, геологийн тогтоцыг тодорхойлно.</li></ul> <p>Дээр дурдсанаар Өмнөговь аймгийн Таван толгойн нүүрсний орд газарт олон жилийн турш нүүрсний нөөцийн хайгуул хийж ирсэн бөгөөд үүний үр дүнд ган хайлуулахад зориулагдсан өндөр чанарын коксжих нүүрс байгааг тогтоосон. 2018 онд нүүрсний уурхайн бүрэн хэмжээний бүтээн байгуулалтыг эхлүүлсэнээр Монгол Улсын коксжих нүүрсний нийлүүлэлт нэмэгдсэн.</p> <p>Таван толгойн нүүрсний ордоос бусад газарт өнөөг хүртэл хайгуул судалгаа хийгээгүй байгаа бөгөөд геологийн тогтоц, нүүрсний нөөцийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал байна. Нүүрсний боломжит нөөцийг илрүүлэхийн тулд өргөн хүрээг хамарсан суурь судалгаа хийх нь чухал юм. Өнөөг хүртэл нүүрсний уурхайн бүтээн байгуулалтыг Өмнөговь аймагт голлон хэрэгжүүлж байсан ба сүүлийн жилүүдэд Хөвсгөл аймгийн Овоотын коксжих нүүрсний төслийг Aspire Mining (Австрали) компани хэрэгжүүлж байна.</p> <p>3) Үр дүн</p> <p>Монголын нүүрсний нөөц, нүүрсний чанарын талаар ойлгож, мэдэх, Нүүрсний нөөцийг баталгаажуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар нүүрсний уурхайн бүтээн байгуулалтыг дэмжих, Чанартай нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх замаар экспортыг сайжруулах, Нүүрсний үйлдвэрлэлийг төрөлжүүлэх.</p> <p>4) Хамрах хүрээ</p> <p>Энэхүү судалгааг I, II үе шатуудаар хэрэгжүүлэх бөгөөд нүүрсний нөөцийн хайгуул судалгааг үе шаттайгаар явуулна. Үе шатны үйл ажиллагааг доор дурдав. Үүнд:</p> <p>[Үе шат I]</p> <p>Хайгуул, судалгааг ойролцоогоор 120,000 км<sup>2</sup> газар нутгийг хамруулан хиймэл дагуулын газрын зургийн дүн шинжилгээ, аэромагнитийн судалгаа, гадаргуугийн эрэл хайгуулын судалгааг тус тус хийнэ. Одоо байгаа өрмийн цооногийн мэдээлэл, нүүрсний судалгааны мэдээллийг цуглуулж, мэдээллийн сан бүрдүүлэн, томоохон газар нутгийг хамруулан геологийн тогтоц, нүүрсний ордын дүн шинжилгээ хийнэ. Дүн шинжилгээнд үндэслэн нарийвчилсан хайгуул хийх байршлыг тогтооно.</p> <p>[Үе шат II]</p> <p><u>Гадаргуугийн эрэл хайгуул</u></p> <p>Нарийвчилсан хайгуул хийх байршилд хиймэл дагуулын газрын зургийн дүн шинжилгээ, геологийн судалгаа хийж, нүүрс, чулуулгийн илэрцийг судална.</p> <p><u>Түршилтын өрөмдлөг</u></p>
--	--



	<p>Нарийвчилсан хайгуул хийх байршилд дээж авах өрөмдлөг хийж, төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай нарийвчилсан мэдээллийг олж авна. Өрөмдлөг хийх замаар нүүрсний давхаргын зузаан, нүүрсний агууламж, чулуулгийн төрлийг тогтооно.</p> <p><u>Физикийн шинж чанарын судалгаа</u> Өрөмдлөгийн үеэр ажиглалт хийхээс гадна эрдсийн нягтрал, гамма зэрэг физикийн шинж чанарыг судална. (Газар хөдлөлтийн судалгаа) Өрөмдсөн цооногт долгионы хурдны (VSP) судалгаа, газар хөдлөлтийн судалгаа хийнэ.</p> <p><u>Нүүрсний чанарын шинжилгээ</u> Нүүрсний давхаргын чанарыг шинжилнэ.</p> <p><u>Байр зүйн/геологийн мэдээллийн сан бүрдүүлэх</u> Энэхүү төслийн хүрээнд одоо байгаа мэдээллийн санг баяжуулан шинэчилнэ.</p> <p>[Үе шат III]</p> <p><u>Геологийн судалгаа, үнэлгээ</u> Одоо байгаа геологи хайгуулын мэдээлэл, өрөмдлөгийн цооногийн мэдээлэл, геофизикийн судалгаанд үндэслэн геологийн иж бүрэн судалгаа, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэнэ.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	
Тайлбар	

### Төслийн дугаар: I9.3

Нэр	<b>Нүүрс угааж баяжуулах үйлдвэрийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах төсөл</b>
Байршил	Гангийн үйлдвэрт ашиглах коксжих нүүрсний уурхай
Хэрэгжүүлэгч агентлаг	УУХҮЯ, ЭХЯ
Зорилтууд	Нүүрс нийлүүлэлт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, хүлэмжийн хий бууруулалтад хувь нэмэр оруулна. Коксжих нүүрсийг угааж баяжуулан гангийн үйлдвэрт нийлүүлснээр коксжих нүүрсэнд нэмүү өртөг шингээж, сайн чанартай нүүрсээр хангах боломжийг бүрдүүлэх бөгөөд нүүрсний нэгжийн экспортын үнэ нэмэгдэж, Монгол Улсын төсвийн орлого нэмэгдэнэ. Мөн дотоодын нүүрс боловсруулалтын үр дүнд тээврийн үр ашиг дээшилж хүлэмжийн хийн ялгарал буурах ба дэлхийн дулаарлын үр дагаврыг бууруулахад хувь нэмэр оруулна. Түүнчлэн нүүрсийг баяжуулсны үр дүнд гарах завсрын бүтээгдэхүүнийг үр дүнтэй ашиглах нөхцөл бүрдэнэ.
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Нүүрсийг баяжуулснаар нүүрсний борлуулалтын үнэ нэмэгдэнэ.</li> <li>2) Тээврийн үр ашиг дээшилж, байгаль орчныг хамгаална.</li> <li>3) Хаягдаж буй завсрын бүтээгдэхүүнийг үр дүнтэй ашиглана.</li> <li>4) Нүүрсийг баяжуулснаар цахилгаан станцын хорт утааны ялгарал буурч, хүлэмжийн хийн ялгарлыг багасна.</li> </ol>
Төслийн өртөг	
Хэрэгжүүлэх хуваарь	Үе шат 1: Нүүрс олборлох бүс нутагт судалгаа хийх, нүүрс угаах, баяжуулах боломжийг судлах, мастер төлөвлөгөөний зорилтыг тодорхойлох (2021)

	<p>Үе шат 2: Нүүрсийг хуурай, нойтон аргаар баяжуулах, нүүрс баяжуулах арга технологийг судлах, нүүрс баяжуулах үйлдвэрээс гарсан завсрын бүтээгдэхүүнийг ашиглах талаар үнэлгээ хийх ( 2022) Үе шат 3: Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ( 2023)</p>
<p>Төслийн тодорхойлолт</p>	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол орны өмнөд хэсгийн говьд гангийн үйлдвэрлэлд шаардлагатай коксжих нүүрс элбэг бий. Тухайлбал Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн зүүн хэсэгт орших Таван толгойн нүүрсний орд нь 6.4 тэрбум тонн нүүрсний нөөцөөрөө дэлхийд тэргүүлдэг. Дэлхий даяар ган төмөрлөгийн салбарт шаардлагатай коксжих нүүрсний үйлдвэрлэл хязгаарлагдмал байдаг тул Монгол Улсад тус үйлдвэрлэлийн шинэ бүсийг хөгжүүлэх нь дэлхийн нүүрсний салбарын хөгжилд чухал ач холбогдолтой юм. Одоогийн байдлаар Монгол Улс нь нүүрсийг ихэвчлэн БНХАУ-д экспортолж байна. Түүхий нүүрс экспортлолтын улмаас нүүрсний үнэ тариф хямд, нүүрсний тээвэрлэлтийн үр ашиг муу байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Нүүрс нь органик (шатах) материал, эрдэс (үнс) агуулна. Нүүрсний баяжуулалт нь тоосонцор, чийгшил, илчлэг чанар, үнслэг, хүхэрлэгийн агуулгын хувьд чанарын шаардлага хангасан нүүрс үйлдвэрлэх үйл явцыг хэлнэ. Нүүрсийг баяжуулан үнслэгийн агуулгыг багасгана.</p> <p>Нүүрсний уурхайд нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах нь ихээхэн ач холбогдолтой. Үүнд: 1) тээврийн зардал буурах, 2) нүүрсний агуулахын хэрэгцээ буурах, 3) бутлагчийн ачаалал буурах, 4) үнс багасах, 5) тоосжилтын шүүлтүүрийн ачаалал буурах, 6) утааг хоргүйжүүлэх төхөөрөмжийн ачаалал буурах, 7) боловсруулах үнслэгийн хэмжээ буурах, 8) агаарын бохирдол буурах, 9) эрчим хүч үйлдвэрлэлийн үр ашиг сайжрах зэрэг болно.</p> <p>Нүүрсийг баяжуулах технологийн үндсэн 2 арга бий. Үүнд хүндийн хүчээр баяжуулах, хөвүүлэн баяжуулах технологи юм. Олборлосон нүүрсний чанарт нийцүүлэн нүүрс баяжуулах тоног төхөөрөмжийг оновчтой сонгох шаардлагатай. Нүүрс баяжуулах төхөөрөмжид хүнд орчны сепаратор, хүнд суспензын циклон, баяжуулах машин, спирал сортлогч, чичиргээт ширээ, хөвүүлэх машин орно. Нүүрсний шинж чанар, нүүрсний том, жижгийн хэмжээ, ангиллын нарийвчлал зэргээс хамааруулан тоног төхөөрөмжийг оновчтой сонгох шаардлагатай.</p> <p>Коксжих нүүрснээс гангийн үйлдвэрт ашиглах кокс гарган авч тэсэлгээний зууханд төмрийн хүдрийн хэмжээг бууруулахад ашиглана. Олборлосон түүхий нүүрс нь ихэвчлэн чанарын хувьд ялгаатай бөгөөд нүүрсний үнслэг, хүхэрлэг агуулга өндөр байдаг. Ган хайлуулахад зориулагдсан коксжих нүүрс нь "чанартай, үнслэг, хүхэрлэгийн агуулга багатай" байх шаардлагатай. Тиймээс сайн чанарын нүүрсийг шаарддаг. Хэрэв үнслэг, хүхэрлэгийн агуулга өндөр байвал чанар муутай кокс үүсч, тэсэлгээний зууханд үйлдвэрлэсэн гахайн төмөр нь хэврэг болдог. Иймээс ган хайлуулахад зориулан түүхий нүүрсний чанарыг сайжруулж, нүүрс баяжуулах замаар үнслэг, хүхэрлэгийн агуулгыг багасгадаг. Завсрын бүтээгдэхүүн, хаягдлыг хэрхэх асуудал үүсдэг. Гангийн үйлдвэрт ашиглах чанартай коксжих нүүрс (анхдагч бүтээгдэхүүн) үйлдвэрлэхэд завсрын бүтээгдэхүүн (хоёрдогч бүтээгдэхүүн) гардаг. Энэхүү завсрын бүтээгдэхүүнийг хоёрдогч бүтээгдэхүүн гэж нэрлэдэг. Завсрын бүтээгдэхүүн нь хэдийгээр үнслэгийн агуулга өндөртэй боловч түүний илчлэгийн хэмжээ нь 4,000 ккал/кг байна. Завсрын бүтээгдэхүүн нь хаягдлаас ялгаатай бөгөөд түүнийг үр дүнтэй ашиглаж, нүүрсээр ажилладаг цахилгаан станцууд болон нам даралтын зуухуудад ашиглаж болно.</p>

2) Одоогийн байдал

Монгол Улсад Энержи Ресурс компани нь Таван толгойн нүүрсний орд дахь Ухаа худгийн уурхайд нүүрс баяжуулах үйлдвэр байгуулсан. Энэхүү үйлдвэрийн модуль тус бүр жилд 5 сая тонн (цагт 900 тонн) х 3 модуль, жилд 15 сая тонн (цагт 2,700 тонн) нүүрс угааж, баяжуулах хүчин чадалтай. 1.2-аас 50 мм-ийн хэмжээтэй түүхий нүүрсийг анхдагч, хоёрдагч хүнд суспензын циклоноор баяжуулахад коксжих нүүрс, завсрын бүтээгдэхүүн, хаягдал гарна. 1.2 мм-ээс жижиг түүхий нүүрсийг 0.2 мм хүртэл ангилан, 0.2-1.2 мм-ийг спираль сортлогчоор, 0,2 мм ба түүнээс жижиг коксжих нүүрсийг хөвүүлэх машинаар боловсруулна. Цагт 135 м3 ус зарцуулдаг. Нүүрс баяжуулах үйлдвэрээс 20 км зайтай худгаас ус авч ашигладаг. Нийт 12 худгийн зургаан худаг нь нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станцад 350-400 м3/цаг ус нийлүүлж байна. Ухаа худгийн нүүрс баяжуулах үйлдвэрээс жилд 30 орчим сая тонн завсрын бүтээгдэхүүн гардаг. "Энержи Ресурс" компаний эзэмшлийн цахилгаан эрчим хүчний үйлдвэр (18 МВт) зарим хэсгийг нь ашигладаг. Үлдсэн завсрын бүтээгдэхүүнийг ашиглахгүйгээр хаяж байна. Тиймээс завсрын бүтээгдэхүүнийг хэрхэн ашиглах талаар сорилт тулгарч байна.

Монгол оронд хур тунадасны нийт хэмжээ бага тул нүүрсний уурхайн усны хэрэгцээг хангахад хүндрэл учирдаг. Их хэмжээний ус ашиглах шаардлагатай тул нүүрс баяжуулах үйлдвэрийн усны хэрэгцээг гүний ус ашиглах буюу голоос ус дамжуулах хоолойгоор татан хангадаг. Сүүлийн жилүүдэд нүүрсний уурхайн бүс нутагт амьдарч буй нутгийн иргэд нүүрсний уурхайд ус ашиглахыг эрс эсэргүүцэж байна. Тиймээс нүүрс баяжуулах үйлдвэрийн усны зарцуулалтыг бууруулах, усыг дахин ашиглах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна. Орчин үед ус ашигладаггүй хуурай аргаар нүүрс баяжуулах технологи бүтээсэн. Нүүрсийг хуурай аргаар баяжуулахад ус огт ашиглахгүйгээр элсийг доороос нь хүндийн хүчний эсрэг агаараар үлээлгэж нүүрсийг чулуунаас нь салгах тодорхой таталцал бүхий псевдо-шингэнийг ашигладаг. Гэвч туршилт хараахан эхлээгүй байна.

Энэхүү судалгаагаар Монгол Улсын байгалийн нөхцөл байдал, бүс нутгийн онцлог шинж чанар, нүүрсний уурхайн олборлолтоос хамааруулан нүүрс баяжуулах технологийг нарийвчлан судална. Түүнчлэн уг судалгааны хүрээнд нүүрс баяжуулахад шаардагдах ус хангамж, усыг дахин ашиглах, завсрын бүтээгдэхүүнийг үр дүнтэй ашиглах аргыг судална. Энэхүү судалгаа нь Монгол Улсын нүүрсний чанарыг сайжруулах, нүүрсэнд нэмүү өртөг шингээхэд тус нэмэр болно.

3) Үр дүн

Нүүрс баяжуулалт нь нүүрсний борлуулатын үнэ тарифыг нэмэгдүүлнэ.

Нүүрсний тээвэрлэлтийн үр ашгийг дээшлүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг ихээхэн бууруулна.

Одоогоор хаягдаж буй завсрын бүтээгдэхүүнийг үр дүнтэй ашиглана.

Нүүрсийг баяжуулсанаар цахилгаан станцын шаталтын систем үл доголдон, хүлэмжийн хий ялгарлыг бууруулна.

4) Хамрах хүрээ

Уурхай тус бүрийн хээрийн судалгаанд онцгой анхаарал хандуулна. Судалгааны ажлын агуулгыг доор дурдав. Үүнд:

	<p>Зорилтот нүүрсний уурхайнуудад хээрийн судалгаа хийж, нүүрс олборлолтын цар хүрээ, нүүрсний чанар, усны хүрэлцээ зэргийг судлан үнэлэх замаар нүүрс угаах технологийг сонгоно.</p> <p>Зорилтот нүүрсний уурхайг хөгжүүлэх төлөвлөгөө, баяжуулсаны дараа гарах завсрын бүтээгдэхүүнийг ашиглах төлөвлөгөө, борлуулалтын төлөвлөгөө боловсруулна.</p> <p>Зорилтыг (CO<sub>2</sub>-ыг бууруулах, эрчим хүч хэмнэх, ашиг орлого олох г.м), тодорхойлж, үнэлгээ хийн, бизнесийн санал дэвшүүлнэ.</p> <p>Бизнес модел боловсруулж, мастер төлөвлөгөөг эцэслэн боловсруулна.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	<p>Нүүрс угаах арга технологи нэвтрүүлснээр дэлхийн байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулна.</p> <p>Түүнчлэн газар зүйн онцлог, байгаль орчны нөхцөл байдалд нийцсэн нүүрс баяжуулах технологийг нэвтрүүлнэ.</p>
Тайлбар	Одоогийн байдлаар Эрдэнэс Таван толгой компани нь Японы Шинэ эрчим хүч хөгжлийн төвтэй (NEDO) хамтран хуурай аргаар нүүрс баяжуулах туршилтын төсөл хэрэгжүүлж байна.

**Төслийн дугаар: I9.4**

Нэр	<b>Нүүрсэд түшиглэсэн үйлдвэрийн кластер байгуулах төсөл</b>
Байршил	Таван толгойн нүүрсний уурхай, Багануур, Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний уурхай
Хэрэгжүүлэгч агентлаг	УУХҮЯ, ЭХЯ
Зорилтууд	Нүүрсний уурхай, байгаль орчинд ээлтэй нүүрс олборлолт, ашиглалт бүхий нүүрсэд тулгуурласан үйлдвэрийн кластер байгуулах мастер төлөвлөгөө боловсруулах.
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Нүүрсэд түшиглэсэн үйлдвэрлэлийн кластер байгуулснаар Монгол Улсын аж үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байрыг бий болгоход хувь нэмэр оруулна.</li> <li>2) Нүүрсний нөөцөө үр дүнтэй ашиглаж, нүүрсний салбарын тогтвортой хөгжлийг хангана.</li> <li>3) Нүүрсний салбарын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг ихээхэн бууруулна.</li> <li>4) Уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн бохирдолгүй, нүүрстөрөгч багатай, оршин суугчидтай хамтран дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн уурхайн хотхон байгуулж, бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулна.</li> </ol>
Төслийн өртөг	
Хэрэгжүүлэх хуваарь	<p>Үе шат 1: Уурхайг сонгох, мастер төлөвлөгөөний зорилтыг тодорхойлох, 2021 онд судалгаа хийх</p> <p>Үе шат 2: 2022 онд Монгол Улсын нөхцөл байдалд нийцсэн Японы технологийг судлах, үнэлэх, сонгох</p> <p>Үе шат 3: Мастер төлөвлөгөө боловсруулах</p>
Төслийн тодорхойлолт	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл</li> </ol> <p>Монгол Улс нь дэлхийн нүүрсний хамгийн том хэрэглэгч Япон, БНХАУ, БНСУ-тай газар зүйн хувьд ойр байршилтай ба нүүрсний тогтвортой нийлүүлэгчийн хувьд Азийн хэрэглэгчдийн анхаарлыг татдаг. Сайн чанарын коксжих нүүрсний Таван толгойн орд болон бусад томоохон нүүрсний уурхайн бүтээн байгуулалтыг өрнүүлэн хөгжүүлж ирсэн. Эдгээр нүүрсний уурхайн бүтээн байгуулалт нь Монгол Улсын бүс</p>

нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулсаар байна. Нүүрс олборлолт, боловсруулалт, ашиглалтыг хамарсан үйлдвэрийн кластер, сүлжээ байгуулах үзэл санаа нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, нүүрсэд түшиглэсэн уурхайн хотхон байгуулахад хувь нэмэр оруулах шинэлэг санаа юм. Нүүрсэд түшиглэсэн үйлдвэрийн кластер, сүлжээ байгуулах нь нүүрсэнд нэмүү өртөг шингээх, цэвэр нүүрс хэрэглэснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, цэвэр нүүрсний технологи, бохир ус цэвэрлэх технологи нэвтрүүлсэнээр үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, дээрээс доош чиглэсэн шат дараалсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой. Нүүрсний нөөцийг үр ашигтай ашиглахын зэрэгцээ эрчим хүч, түүхий эд материалыг байгаль орчинд ээлтэйгээр ашиглана. Жишээлбэл нүүрсний уурхайн усыг татан зайлуулах байгууламж, шахмал нүүрс, идэвхижүүлсэн нүүрс үйлдвэрлэх замаар ус, агаарын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах боломжтой. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрдэм шинжилгээний хотхон байгуулах үйл ажиллагааг нүүрсний нөөцийг үр ашигтай ашиглах, байгаль орчныг хамгаалах, сайжруулахад чиглэсэн мастер төлөвлөгөөг боловсруулах замаар хэрэгжүүлнэ. Нүүрсэд түшиглэсэн үйлдвэрийн кластер байгуулах үзэл баримтлал нь нүүрсний уурхайг илүү үр ашигтай ажиллуулах, байгаль орчныг хамгаалах, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулахад оршино. Нүүрсний нөөцийг удаан хугацаагаар ашиглах үүднээс нүүрсний нөөцийн геологийн хайгуул судалгаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангасан үйлдвэрлэл, байгаль орчны хамгаалал, дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэг цогц төслүүдийг авч үзэх шаардлагатай. Нүүрсэд суурилсан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, нүүрс химийн үйлдвэр, бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг уялдуулан нэгтгэж, нүүрс олборлох уурхайгаас холбогдох үйлдвэрийг холбосон үр дүнтэй кластер, сүлжээг байгуулна. Мастер төлөвлөгөө боловсруулах үе шатанд эрчим хүч хэмнэх, хог хаягдлыг бууруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт тавина. Нүүрсний салбарын хөгжил, үйлдвэрлэлд шинэ технологи (seeds technology) нэвтрүүлэхэд гарах үр ашгийг үе шат болон тоон үзүүлэлтээр судална. Бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөгөө бүхий бүс нутагт хамаарах нүүрсний уурхайд цэвэр нүүрсний технологи, байгаль орчинд ээлтэй эрчим хүч хэмнэх технологийг нэвтрүүлснээр гарах үр дүн болон бодлого төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийнэ.

## 2) Одоогийн байдал

Өмнөговь аймгийн Таван толгойн коксжих нүүрсний орд нь стратегийн орд газарт хамаарах бөгөөд Монгол Улсын коксжих нүүрсний экспортын томоохон тоглогч юм. Таван толгойн нүүрсний олборлолтыг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулж, тээврийн дэд бүтэц, авто зам, төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Энэхүү нүүрсний уурхайд хувийн болон төрийн өмчит хэд хэдэн аж ахуйн нэгжүүд зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар төрөөс баримталж буй бодлогод нийцүүлэн нийгмийн дэд бүтцийг сайжруулах талаар хүчин чармайлт гаргаж байна. Нүүрсний уурхайн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр сумын хүн ам нэмэгдэж байгаа ба 10 жилийн өмнө 1,000 хүрэхгүй хүн амтай байсан бол одоо бараг 10,000 болжээ. Сум нь тохилог орон сууцтай бөгөөд хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг, жижиг оёдлын үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Уурхайчид, орон нутгийн иргэд эв

	<p>найртайгаар хамтран амьдарч сумаа хөгжүүлэхээр зорьж байна. Гэвч тус суманд ундны усыг цэвэршүүлэх, аюулгүй байдлыг хангах, хог хаягдлыг зайлуулах, уурхайн тоосжилтыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг асуудал тулгарч байна.</p> <p>Нүүрсэд түшиглэсэн үйлдвэрийн кластер, сүлжээ байгуулах мастер төлөвлөгөө нь эдгээр асуудлыг шийдэж, нүүрсний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үнэ цэнийн сүлжээг бий болгоно. Түүнчлэн уул уурхайгаас үүдэлтэй нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулсанаар сумын хэмжээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүчин чармайлт гаргана. Төрийн өмч давамгайлсан Багануурын уурхайг түшиглэн нүүрс хийжүүлэх үйлдвэр, цахилгаан станц, цементийн үйлдвэрийг барьж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нүүрсний үнэ цэнийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэдийнээ эхлүүлсэн.</p> <p>3) Үр дүн</p> <p>Нүүрсний салбарыг хөгжүүлж буй улс оронд ашиглагдаагүй эрчим хүч, хог хаягдал, байгаль орчин бохирдуулагчийг ихээр ялгаруулдаг гэсэн болгоомжлол байдаг. Үүнд нүүрс олборлолтоос үүссэн метан хий, бохир ус, тэсэлгээний явцад үүссэн хаягдал, лаг, цахилгаан станцаас ялгарч буй хий, үнс зэрэг орно. Гэвч боловсруулах арга технологиос хамааран тэдгээрийг дахин боловсруулан ашиглаж болох ба хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах боломжтой юм. Түүнчлэн уул уурхайн бүс нутагт үйлдвэрүүд хамтран ажиллаж, эрчим хүчийг дундаа ашиглаж, хаягдлыг дахин боловсруулсанаар шинэ үйлдвэр байгуулагдаж, нүүрсний нунтаг хаягдлыг бууруулан, нөөцийг дахин боловсруулах боломж бүрдэнэ. Энэхүү төслийн хүрээнд нүүрсэд суурилсан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, нүүрс химийн үйлдвэр зэрэг органик, үр ашигтай үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлсэн (загвар нүүрсний уурхай) нүүрсэд түшиглэсэн үйлдвэрийн сүлжээ, кластер байгуулах мастер төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.</p> <p>Мастер төлөвлөгөө боловсруулахад Японы цэвэр нүүрсний технологийг бүх шатанд нэвтрүүлэн үйлдвэрлэлийн үр ашгийг оновчтой болгох, нөөцийг үр дүнтэй ашиглах, хүрээлэн буй орчинд хор нөлөө багатай эрчим хүч, түүхий эд материалыг ашиглана.</p> <p>4) Хамрах хүрээ ба хэрэгжүүлэх зохион байгуулалт</p> <p>Судалгааг 5 хэсэгт хуваан, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд: 1) Уурхайг сонгох, 2) Төрөөс баримталж буй бодлогыг судлах, 3) Японы талын эзэмшиж буй технологийг судлан, тодорхойлох, 4) ТЭЗҮ боловсруулах, 5) Мастер төлөвлөгөө боловсруулах. Тодорхой аргачлалыг доор дурдав. (Зураг 1)</p> <p>Үүнд:</p> <p>Зорилтот нүүрсний уурхайд Японы seed технологийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх боломжийн талаар судалж, нүүрсэд түшиглэсэн үйлдвэрийн кластер байгуулах эсэхийг шийдвэрлэнэ.</p> <p>Зорилтот нүүрсний уурхайнуудын хэрэгцээ шаардлагыг судалж, хөгжлийн төлөвлөгөөний зорилтуудыг тодорхойлно.</p> <p>Нүүрсхүчлийн хийн хэмжээг бууруулах, эрчим хүч хэмнэх, ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилт тавьж, seed технологийг нэвтрүүлэх бизнесийн төлөвлөгөө боловсруулна.</p> <p>Загвар уурхайн бүтээн байгуулалт, (хэрэгжүүлэх механизм, бодлогын арга хэрэгсэл, санхүүгийн схем г.м) ТЭЗҮ, төлөвлөгөө бүхий ерөнхий төлөвлөгөөг санал болгоно.</p>
--	---

	<p>Зураг 1. Хэрэгжүүлэх үе шат ба зохион байгуулалт</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө хамгийн бага байхаар нүүрсийг олборлон ашиглана.
Тайлбар	Энэхүү төсөл нь Монгол орны нүүрсний уурхай бүхий нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдэд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын Засгийн газар болон холбогдох уул уурхайн компаниудын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Түүнчлэн байгаль орчинд ээлтэй нүүрс боловсруулах технологи бүхий Японы компаниудын тогтвортой, бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулна.

**Төслийн дугаар: I10.1**

Төслийн нэр	<b>Үлэг гүрвэлийн музей байгуулах төсөл</b>
Байршил	Говь / Улаанбаатар
Хэрэгжүүлэгч	Монголын Динозавр Судлалын Хүрээлэн, Монголын ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн, БОАЖЯ, Азийн үлэг гүрвэлийн холбоо, хувийн хэвшил
Зорилго	<p>Эцсийн зорилго: Үлэг гүрвэлийн олдворуудын эх нутагт дэлхийн хэмжээний үлэг гүрвэлийн музей байгуулах, дэлхийн өнцөг булан бүрээс үлэг гүрвэл сонирхогчдыг татах. Тодорхой зорилтууд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Говьд үлэг гүрвэлийн музей байгуулах;</li> <li>2) Үлэг гүрвэлийн ховор олдворуудыг дэлгэн харуулах, үлэг гүрвэл сонирхогчдыг татах чиглэлээр дэлхийд тэргүүлэх орон болох.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Монголын үлэг гүрвэлийн чулуужсан ясыг дэлхий дахинд сурталчилна;</li> <li>2) Аялал жуулчлалыг нэмэгдүүлнэ;</li> <li>3) Үлэг гүрвэлтэй холбоотой төрөл бүрийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, жуулчдад худалдана;</li> <li>4) Үлэг гүрвэлийн талаар мэдлэг олгоно;</li> <li>5) Үлэг гүрвэлийн үнэт олдворыг хадгална.</li> </ol>
Төслийн зардал	ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2023 он: Төслийг боловсруулах 2022-2024 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2024 оноос: Бүрэн хэмжээнд хэрэгжих
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Өмнөговь аймгийн Баянзагаас Америкийн эрдэмтэн Рой Чепмен Эндрюс анхны үлэг гүрвэлийн өндөг бүхий үүрийг зуу гаруй жилийн

	<p>тэртээ олсон. Монгол Улс үлэг гүрвэлийн чулуужсан олдвороороо дэлхийд тэргүүлдэг хэдий ч энэхүү шинжлэх ухааны өв нь тухайн нутгийн ард иргэд болон зочлон ирж буй жуулчдад танигдаагүй хэвээр байна. Одоогийн байдлаар үлэг гүрвэлийн талаар мэдээлэл өгөх тэмдэглэгээ, газрын зураг, музей үгүй байна. Нутгийн иргэдэд мэдлэг боловсрол олгох, тухайн газар нутгийн ач холбогдлыг баталсан мэдлэгийг түгээхийг зорьж буй цорын ганц явуулын музей ажилладаг. Үүнээс гадна энэхүү үнэт өвийн талаарх мэдлэг боловсрол дутмаг, хариуцаж хамгаалах эзэнгүй байгаагийн улмаас үлэг гүрвэлийн олдворуудыг хулгайлах асуудал жил ирэх тусам даамжирсаар байна. ВВС-гийн хийсэн сурвалжлагаас үзэхэд сүүлийн таван жилийн хугацаанд АНУ-ын Цагаачлал, гаалийн хяналтын газар 44 сая ам.долларын үнэ бүхий үлэг гүрвэлийн олдворыг хууль бусаар хил давуулах гэсэн оролдлогыг таслан зогсоосон байна.</p> <p>Тиймээс үлэг гүрвэлийн талаар мэдлэг боловсролыг олгох, үлэг гүрвэлийн олдвор дээр суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх нь дараагийн үеийн эрдэмтэд, палеонтологичдыг бэлтгээд зогсохгүй үлэг гүрвэлийн олдворуудыг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн үр дүнтэй шийдэл болно. Энэхүү санаачилгын хүрээнд нутгийн иргэд үлэг гүрвэлийн олдвортой танилцах аяллыг жуулчдад санал болгох боломжтой бөгөөд энэ нь тухайн газар нутгийг хамгаалахад хувь нэмэр оруулахын зэрэгцээ орон нутгийн орлогыг нэмэгдүүлнэ. Ийм төрлийн төслүүдийг хэрэгжүүлэхгүй байгаагийн улмаас асар их орлого олох боломжийг алдаж байдаг бөгөөд энэ нь жуулчдад төдийгүй энэхүү үнэт өвийг хамгаалахад гол үүрэгтэй оролцох орон нутгийн иргэдэд мэдлэг боловсрол олгох боломжийг алдахад хүргэнэ.</p> <p>Үлэг гүрвэлийн олдворуудын эх орон болох Монгол Улс нь тэдгээрийг танилцуулах чиглэлээр дэлхийд тэргүүлэх орон болох өндөр магадлалтай юм. Үлэг гүрвэлийн нийслэл хотод ирэх сонирхолтой олон тооны үлэг гүрвэл сонирхогчид дэлхийд байдаг.</p> <p>Түүнчлэн хүн төрөлхтний шинжлэх ухааны хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж буй энэхүү палеонтологийн нээлтэд нутгийн иргэд оролцож, бахархаж, хариуцаж хамгаалах хэрэгтэй.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Үлэг гүрвэлийн музей байгуулах. Үүнд:</p> <p>Монгол олдворууд, үлэг гүрвэлийн амьдралд чиглэсэн байнгын болон шинэчлэгдэж байдаг үзэсгэлэн;</p> <p>Монголын болон олон улсын сургуулийн насны хүүхдүүдийн сургалтад зориулсан барилга байгууламж;</p> <p>Монгол орны алдартай олдворуудын нээлтийг багтаасан археологийн цэцэрлэгт хүрээлэн;</p> <p>Үлэг гүрвэлтэй холбоотой судалгааг явуулж байх зорилгоор Монголын болон олон улсын их дээд сургуулиудтай түншлэх асуудал багтана.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БОАЖЯ нь үлэг гүрвэлийн аялал жуулчлалын чиглэлийг сурталчлах үүргийг хүлээх ба Монголын Динозавр судлалын хүрээлэн, ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн нь музейн үзмэр, цуглуулгыг хариуцах гол байгууллага байна. Техникийн тусалцааг Фүкүй мужийн үлэг гүрвэлийн музей, Азийн үлэг гүрвэлийн холбооноос авах боломжтой.</p> <p>Оролцогч талууд төслийн талбайг сонгох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалт олоход туслах зэрэг ажлыг хариуцна. Улаанбаатараас зорчиход хялбар</p>
--	---



	дөхүү байдлыг харгалзан үзэх, цаашдаа музейг хоёр байршилд буюу нэгийг нь Улаанбаатарын ойролцоо, нөгөөг нь Монголын үлэг гүрвэлийн олдвор ихээхэн олддог говьд байгуулах боломжийг онцгой анхаарах хэрэгтэй.
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Монгол Улсын аялал жуулчлалын салбарт мэдэгдэхүйц эерэг сурталчилгаа болно. Боловсрол, оролцооны замаар нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ. Орон нутгийн иргэд ба судалгааны байгууллагуудын хоорондын холбоог бэхжүүлнэ. Нутгийн иргэдийн орлого мэдэгдэхүйц нэмэгдэж, газар нутгаа хамгаална. Үлэг гүрвэлийн олдворуудыг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд тусална.
Тайлбар	

**Төслийн дугаар: I10.2**

Төслийн нэр	<b>“Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолборуудыг байгуулах төсөл</b>
Байршил	Аялал жуулчлалын гол чиглэл, замын дагуу (эхний ээлжинд Сайншанд болон Замын-Үүдийн хооронд)
Хэрэгжүүлэгч	ЗТХЯ, БОАЖЯ, БХБЯ, хувийн хэвшил; Японы Гудамж замын судалгааны институт (RIRS)
Зорилго	Эцсийн зорилго: Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах, аюулгүй найдвартай байдлыг хангахад чиглэсэн Өртөөний сүлжээ бий болгох. Тодорхой зорилтууд: 1) Өртөөний загвар боловсруулах; 2) Мэдээлэл солилцох, бараа бүтээгдэхүүн солилцох замаар жуулчид, нутгийн иргэдийг холбох.
Хүлээгдэж буй үр дүн	1) Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуух дэд бүтэц сайжирна; 2) Жуулчид, орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, аюулгүй амарч зугаалах бүсийг зохих байгууламж, үйлчилгээгээр хангах. Энэ нь орон нутгийн эдийн засагт мөн хувь нэмэр оруулна.
Төслийн зардал	ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2020-2022 он: Төслийг боловсруулах 2022-2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2023 оноос: Төсөл бүрэн хэрэгжих
Төслийн танилцуулга	1) Үндэслэл ТХҮБ 2030, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлого зэрэг холбогдох бодлогын баримт бичигт аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах асуудал нэн тэргүүний зорилтоор тодорхойлсон. Өнөөгийн аялал жуулчлалын гол чиглэл замын дагуу зогсож үйлчлүүлэхэд зориулагдсан зохих барилга байгууламж, үйлчилгээ, тогтвортой менежмент дутагдаж байна. Японы All Nippon Мичи-но-Эки загвар нь дүүргүүд мэдээлэл солилцох, харилцан хамтарч ажиллах зорилгоор бүс нутгийн сүлжээ байгууллага юм. Японд 1160 мичи-но-эки өртөө байдаг бөгөөд үйлчилгээ нь түр амрах, олон нийт, мэдээлэл өгөх гэсэн гурван онцлог шинж чанартай. 800 жилийн тэртээ Монголын эзэнт гүрний үед өртөө улаа, шуудан холбоог үүсгэсэн нь хааны буухиа элчийг амраах, морь унааг сэлбэх зэрэг үйлчилгээтэй, тодорхой зайнд байрласан өртөөнүүдээс бүрдсэн

	<p>байв. Мөн энэ үед Торгоны замаар аялах нь эд бараа, үнэт эдлэл зөөж буй худалдаачид болон бүх хүмүүст аюулгүй байв. Энэ үеийг Рах Mongolica буюу Монголын их амар амгалан гэж нэрлэдэг байжээ.</p> <p>Төслийн эцсийн зорилго нь түүхэн уламжлалт Өртөөний түүхэн дүр төрхийг хадгалахын зэрэгцээ Японы мичи-но-эки стандартын дагуу Өртөөний сүлжээг дахин байгуулах явдал юм. Энэхүү систем нь түүхэн ач холбогдол бүхий Өртөөний сүлжээг сурталчлах үр дүнтэй арга болох бөгөөд аялагчид эдгээр зориулалтын өртөөнөөс амрах газар, орон нутгийн түүх соёлын дурсгалын талаар мэдээлэл авах боломжтой байх юм. Эдгээр өртөө нь аялагч, зорчигчдын аюулгүй байдал, тэдэнд туслах боломжийг сайжруулна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Япон стандартын дагуу мичи-но-эки загварын амрах газрыг байгуулах.</p> <p>Үүнд:</p> <p>Зохих байгууламж бүхий жуулчид, зочдын амрах цэг байгуулах; Орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчидтэй мэдээлэл солилцох, бүтээгдэхүүн борлуулалтын талаар хамран ажиллах; Амрах байгууламжуудад бүс нутгийн түүх, соёлын дурсгалуудын талаар мэдээллийг багтаах; Мичи-но-эки өртөө нэмж байгуулах байршлыг тогтооно.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ЗТХЯ нь БОАЖЯ, БХБЯ, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд болон Японы Гудамж замын судалгааны институттэй өртөө байгуулах цэгүүдийн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалт олоход туслах зэрэг үйл ажиллагааг хариуцна. Загвар өртөө байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг ЖАЙКА, АХБ, Дэлхийн банкнаас гаргана. Хэрэв тухайн байгууллага хувийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд хангалттай хувь нэмэр оруулах боломжтой бол санхүүжилтийн байгууллагыг сонгох чухал шалгуур болно.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж сайжирснаар байгаль орчинд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>Маркетинг, аюулгүй байдлын үүднээс Монгол Улсын аялал жуулчлалын ерөнхий дүр төрхөд маш чухал хувь нэмэр болно.</p> <p>Орон нутгийн эдийн засгийг сайжруулна.</p>
Тайлбар	

### Төслийн дугаар: 110.3

Төслийн нэр	<b>Улаанбаатар хотод гар урлалын гудамж байгуулах төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот, Урт цагаан (Жуулчны гудамж)
Хэрэгжүүлэгч	Нийслэлийн аялал жуулчлалын газар Олон нийт, Хувийн хэвшил
Зорилго	<p>Эцсийн зорилго:</p> <p>1) Гэр хороолол/Урт цагаанд өөрсдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүнийг жуулчид, зочдод зардаг гудамж байгуулах.</p> <p>Тодорхой зорилтууд:</p> <p>1) Гэр хороолол/жуулчны гудамжинд худалдааны зах байгуулах; 2) Орон нутгийн иргэд, жуулчид, зочдын хооронд соёлын солилцоог бий болгох.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>1) Бага орлоготой өрхүүдэд нэмэлт орлого олох боломж олгоно; 2) Соёлын солилцоог дэмжинэ;</p>

	3) Зах зээлд бараагаа нийлүүлэх хүсэлтэй оршин суугчдад зориулсан чадавхыг дээшлүүлэх сургалт явуулна.
Төслийн зардал	ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2022 он: Төсөл боловсруулах 2022- 2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2024 оноос: Төсөл бүрэн хэрэгжих
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Улаанбаатар хотын гэр хороолол нь томоохон газар нутгийг хамран оршдог бөгөөд нийслэлийн хүн амын 60% нь амьдардаг. Гэр хорооллын дэд бүтэц хангалтгүй байгаа нь асуудал үүсгэж байгаа боловч нийслэл хот болон нүүдлийн амьдралын хэв маягт суурилсан Монгол үндэстний өвөрмөц байдлын хоорондын уялдаа холбоог бий болгодог. Гадаадын олон иргэд гэр хорооллыг сонирхдог боловч очиж үзэх энгийн аюулгүй нөхцөл дутагдаж байгаа юм. Төслийн санаа нь аялал жуулчлалын салбарын зарим судлаач, сурган хүмүүжүүлэгчдээс гарсан.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>а) Орон нутгийн гар урлалын бүтээгдэхүүнийг зарах зориулалттай гудамж байгуулах;</p> <p>б) Гадаадын жуулчид, зочдыг орон нутгийн иргэдтэй холбох;</p> <p>с) Орлогоо нэмэгдүүлэхийн тулд гар урлал хийх, жуулчидтай харилцах талаар суралцах сонирхолтой хүмүүст зориулсан чадавхыг дээшлүүлэх сургалт явуулах төв байгуулах.</p> <p>2005 оноос Жуулчны гудамж гэж нэрлэсэн Урт цагаанд гар урлалын гудамжийг байгуулж, гар урлалын үйл ажиллагааг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй болон гэр хорооллын дэд төвүүдтэй уялдуулан тодорхойлох хэрэгтэй (<a href="http://www.ub-subcenter.mn/en/page/1">http://www.ub-subcenter.mn/en/page/1</a>). Энэхүү төсөл нь өрхийн орлого, ялангуяа эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах болно.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь орон нутгийн иргэд, хувийн хэвшил, холбогдох талуудтай хамтран зах зээлийн байршлыг сонгох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалт олоход туслах зэрэг үйл ажиллагааг хариуцна.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Бага орлоготой өрхүүд нэмэлт орлого олох замаар нийгэмд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Гэр хорооллын оршин суугчид болон зочдын хооронд соёлын солилцоо эрчимжсэнээр нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

**Төслийн дугаар: I10.4**

Төслийн нэр	<b>Өвлийн спорт, амралтын төв байгуулах төсөл</b>
Байршил	Улаанбаатар хотын ойролцоо
Хэрэгжүүлэгч	ЗТХЯ, БОАЖЯ, БХБЯ Хувийн хэвшил
Зорилго	Эцсийн зорилго: Цаг уурын эрс тэс нөхцөлд нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, нутгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих. Тодорхой зорилтууд:

	<p>1) Монгол Улсын иргэд, тэр дундаа Улаанбаатар хотын иргэдийг амралт зугаалга, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжоор хангах;</p> <p>2) Өвлийн улиралд олон улсын аялал жуулчлалыг нэмэгдүүлэх.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>1) Монгол хүний эрүүл мэндийг сайжруулна;</p> <p>2) Соёлын мэдлэгийг дээшлүүлнэ;</p> <p>3) Өвлийн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.</p>
Төслийн зардал	ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>2021-2022 он: Төсөл боловсруулах</p> <p>2022-2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх</p> <p>2024 оноос: Төсөл бүрэн хэрэгжих</p>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Өвлийг аялал жуулчлалын улирал биш гэж үздэг бөгөөд гадаадын жуулчид Монголын өвлийг зорьж ирдэггүй. Өвлийн улиралд Улаанбаатарт дасгал хөдөлгөөн хийх боломж хязгаарлагдмал тул олон оршин суугчид амьдралын хэв маягаас шалтгаалсан архаг өвчнөөр өвддөг буюу өвдөх эрсдэлтэй байдаг. Өвлийн улиралд агаарын чанар муу байгаа нь хотын иргэдийн эрүүл мэндийг эрсдэлд оруулж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд өвлийн спорт, халуун рашаан, соёлын хөтөлбөр бүхий шинэ цогцолборыг тохирохуйц байршилд байгуулахыг санал болгож байна. Энэхүү санаачилга нь олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, Монгол хүний эрүүл мэндийг сайжруулахад тус дэм болно.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Өвлийн спортын дотор талбай: керлинг хийх мөсөн талбай, тэшүүр, хоккей, биеийн тамирын заал;</p> <p>Амралт зугаалга, эмчилгээнд зориулагдсан халуун рашаан;</p> <p>Гадаа хийгдэх адал явдалт спорт: цанаар гулгах, алсын зайд цанаар аялах, нохойн чарга, морин чарга, ан хийх, загасчлах;</p> <p>Соёлын үйл ажиллагаа: Цасан гэр, Камакура, цасны баяр;</p> <p>Ресторан, зочид буудал;</p> <p>Хүнсний ногооны аж ахуй: зочдод шинэ ногоо нийлүүлэх.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Төлөвлөлт, зураг төсөл боловсруулах, зардлын тооцоо хийх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих боломжийг эрэлхийлнэ. Судалгааны үе шатанд ЖАЙКА, АХБ, Дэлхийн банк санхүүжилтийг гаргана. Санхүүжүүлэх байгууллагыг сонгох чухал шалгуур нь тухайн байгууллага хувийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд хангалттай хувь нэмэр оруулах боломжтой байхад оршино.</p> <p>Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ гэж үзэж байгаа тул хувийн хөрөнгө оруулагчдыг эхний үе шатанд тодорхойлох нь нэн чухал юм. ТЭЗҮ боловсруулж дуусмагц уг төслийг Монгол Улс, Япон улс, БНСУ, БНХАУ болон бусад сонирхсон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулах болно. Төслийг хэрэгжүүлэхийн тулд олон улсын болон хоёр талын донор байгууллагуудын санхүүжилтийг давхар судалж үзэх шаардлагатай.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Улаанбаатар хотын ойр орчмын өвлийн амралтын арга хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ.</p> <p>Монголчууд болон олон улсын жуулчдын соёлын харилцаагаар дамжуулан нийгэмд эерэг нөлөөллийг бий болгоно.</p>
Тайлбар	



Төслийн дугаар: I10.5

Төслийн нэр	<b>Налайхын уурхайн музей, соёл, боловсролын төв байгуулах төсөл</b>
Байршил	Налайх дүүрэг
Хэрэгжүүлэгч	Монгол Улс, ХБНГУ, Канад, Японы олон улсын байгууллагууд, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
Зорилго	Эцсийн зорилт: Уурхайн хот Налайхын түүх соёлыг хадгалан хамгаалахад чиглэсэн уул уурхайн музей, соёл, боловсролын төв байгуулах. Тодорхой зорилтууд: 1) Налайхад уурхайн музей, боловсролын төв байгуулах; 2) Налайх дүүргийн соёлын өвийг хамгаалах ажлыг дэмжих; 3) Дамжин өнгөрөх жуулчдын анхаарлыг татахуйц газар болгох.
Хүлээгдэж буй үр дүн	1) Орон нутгийн онцлог бүхий загвар хот болгон уул уурхайн музей, соёл, боловсролын төв байгуулна; 2) Нутгийн иргэд, хотод зочлон очигсдод ашиг тусаа өгнө; 3) Жижиг хотын амьдралыг мэдэгдэхүйц сэргээж, олон нийтийн идэвхийг сэргээхэд хувь нэмэр оруулна; 4) Оршин суугчдын хувьд нутаг орондоо эзэн байх, түүх соёл уламжлалаа мэдэх, өөрсдийн онцлог шинж чанараа хадгалах хүслийг сэргээнэ.
Төслийн зардал	ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2022 он: Төсөл боловсруулах 2022-2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2024 оноос: Төсөл бүрэн хэрэгжих
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Налайхын нүүрсний уурхай нь 1905 оноос 1990 он хүртэлх урт түүхтэй бөгөөд Монгол Улсын хэмжээнд уул уурхайн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Мөн энд цахилгаан станц руу нүүрс тээвэрлэдэг Монголын анхны төмөр зам тавигдсан. Налайх нь олон үндэстний соёл бүхий (энд казах үндэстний суурин бий) баялаг түүхтэй хот. Энэхүү музей, соёл, боловсролын төв нь Налайх дүүргийн болон Монголын цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдэд ашиг тусаа өгөх болно. Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (GMIT) энэ дүүрэгт байрладаг тул дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх байнгын хөдөлгөөнийг бий болгодог. Музей, соёл, боловсролын төвийг энд байгуулах нь жуулчид төдийгүй нутгийн иргэдэд ашиг тустай байна. Түүнчлэн тус төв нь нутгийн иргэдийн итгэл найдвар, хүсэл мөрөөдөл, хүсэл тэмүүллийг нэгтгэж түүх, бахархалыг нь холбон харуулсан газар байх юм. Ийнхүү орон нутгийн өвөрмөц онцлогтой жижиг суурин газрын тэр дундаа нийслэл хотын ойр орчимд байрлах суурин газрын иргэдийн нэгдмэл байдлыг сэргээж, тэдний боловсрол, чадавхыг бэхжүүлэх замаар хотын оршин тогтнох чадварыг тэлсэн загвар жишээ болно. Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар нь энэхүү төслийн гол санаачлагч юм. Энэхүү санал санаачилгыг Канадын судлаачид дэмжсэн. Налайхын уурхайн музей, соёл, боловсролын төв нь Налайх дүүргийн иргэдийг олон талаар хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд үүгээрээ дамжуулан дүүргийн хөгжилд эергээр нөлөөлөх боломжтой.

	<p>2) Төслийн бүрэлдэхүүн Одоо байгаа Налайхын нүүрсний уурхайн захиргааны байр, уурхайн босоо ам, төмөр замын станцын ойролцоо музейг байгуулна. Уурхайн захиргааны гурван давхар байранд гол үзмэрүүдийг байрлуулах бөгөөд босоо ам нь тайлбарлагчтай аялал хийх газар байх ба зочдын үзэх гол цэг болно.</p> <p>3) Хэрэгжилт Монгол Улс, ХБНГУ, Канад, Японы олон улсын байгууллагууд Налайх дүүргийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр төслийг хамтран хэрэгжүүлэх боломжтой. Налайхын Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь ХБНГУ-тай хамтын ажиллагаа идэвхтэй явагдаж байгааг илтгэж байна. ХБНГУ нь уул уурхайн хотуудаараа алдартай. Олон улсын донор байгууллагын санхүүжилтээр ODA-ийн ажлыг хэрэгжүүлдэг ХБНГУ-ын боломжит компаниудыг (CDM Smith г.м) урих боломж бий. Ийм түүх, соёлын төвүүдийг тууштай дэмждэг Канадын хэд хэдэн судлаачид байдаг.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Түүх, соёлын хувьд эерэг нөлөө үзүүлнэ. Уурхайн хотхоны түүхийг зааж сургах, хадгалах замаар нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

**Төслийн дугаар: I10.6**




Төслийн нэр	<b>Аялал жуулчлалын салбарын мэдээллийн сан байгуулах төсөл</b>
Байршил	Заагаагүй
Хэрэгжүүлэгч	БОАЖЯ, ҮСХ, Аймгийн ЗДТГ, Монголын Аялал жуулчлалын холбоо
Зорилго	Мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах зорилгоор аялал жуулчлалын салбарын иж бүрэн мэдээллийн сан байгуулах.
Хүлээгдэж буй үр дүн	Засгийн газрын бодлого, дүрэм, журмыг боловсруулахад мэдээлэл, нотолгоогоор хангаж, үр дүнтэй тогтолцоог бий болгоно.
Төслийн зардал	ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	3 үе шатаар хэрэгжүүлнэ.
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл Одоогийн байдлаар аялал жуулчлалын салбарын мэдээлэл нь мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай цорын ганц найдвартай эх сурвалж болж чадахгүй байна. Системчилсэн мэдээлэл цуглуулах арга зүй дутмаг байна. Бодит байдал дээр одоо цуглуулж байгаа өгөгдөл, мэдээлэл нь бүрэн, үр дүнтэй ашиглагддаггүй. Учир нь тэдгээрийг нэгтгэх, зохион байгуулах эрх бүхий байгууллага байхгүй бөгөөд өөр өөр байгууллагуудад харьяалагддаг. Зарим тохиолдолд мэдээлэл цуглуулах маягтууд нь хуучирсан эсвэл нэгдсэн загвар үгүй байгааг сайжруулах шаардлагатай. Найдвартай, нарийвчлалтай мэдээлэл цуглуулах аргыг нэвтрүүлэх нь системийг сайжруулахад туслах ач холбогдол бүхий мэдээллийг олж авахад хувь нэмэр оруулна. Зочид буудлын өрөө, байр, аялалын багц хөтөлбөр, аялал жуулчлалын байгууламж, арга хэмжээ, хүний нөөц зэрэг мэдээллийг цуглуулж, нэгтгэнэ. Мэдээллийг бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг оновчтой боловсруулах болон жуулчдын сонирхол татахуйц газрыг тодорхойлоход ашиглах боломжтой.</p>


	<p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>a) Одоо ашиглаж буй мэдээлэл цуглуулах аргуудыг нэгтгэн дүгнэх;</p> <p>b) Мэдээлэл цуглуулах аргыг боловсруулж, системийг сайжруулах;</p> <p>c) Шаардлагатай загвар маягтуудыг боловсруулах;</p> <p>d) Өгөгдөл, мэдээллийг ашиглах;</p> <p>e) Мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах механизмыг бүрдүүлэх.</p> <p>Мэдээллийн технологийн салбарын мэдээлэл цуглуулах/хадгалах/дүн шинжилгээ хийх шинэ арга зүй, технологийн дэвшлийг аялал жуулчлалын салбарын хөгжилд ашиглаж болно.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БОАЖЯ нь ҮСХ, Монголын Аялал жуулчлалын холбоо, Аймгийн ЗДТГ-тай хамтран мэдээлэл цуглуулах системийн арга зүй, удирдамжийг боловсруулна. Түүнчлэн шинээр хөгжин тэлж буй зах зээлд ихээхэн анхаардаг Дэлхийн аялал жуулчлалын форумын хүрээлэн (ДАЖФХ) зэрэг бусад олон улсын байгууллагууд, платформуудтай хамтран ажиллах боломжтой. ДАЖФХ-тэй холбоо тогтоосон болно.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Аялал жуулчлалын салбарт байгаль орчин болон соёлыг хамгаалах оновчтой бодлого боловсруулахад чухал нөлөө үзүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
Тайлбар	

Төслийн дугаар: I10.7

Нэр	<b>Аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх төсөл</b>
Байршил	Өмнөговь, Баян-Өлгий, Сүхбаатар
Хэрэгжүүлэгч агентлаг	Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ); Хувийн хэвшил
Зорилтууд	<p>1) Жуулчдын зорин очдог газар, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг орон нутаг, гадаад, дотоодын аялал жуулчлалын агентлагуудыг холбож сүлжээ үүсгэх замаар гадаад, дотоодын жуулчдад зориулсан аялал жуулчлалын гол газрууд, үзмэрийг бий болгох;</p> <p>2) Холбогдох аймагт аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх</p>
Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> <li>- Жуулчдын тоо болон аялал жуулчлалын салбараас олох орлого нэмэгдэнэ;</li> <li>- Монгол Улсын аялал жуулчлалын үзвэр үйлчилгээ төрөлжинэ;</li> <li>- Бүс нутаг хоорондын орлогын зөрүү буурна.</li> </ul>
Төслийн өртөг	US\$
Хэрэгжүүлэх хуваарь	<p>Аялал жуулчлалын сүлжээ байгуулах мастер төлөвлөгөө: 2022</p> <p>Аялал жуулчлалын кластер тус бүрийн жуулчдын зорин очдог газар, холбогдох дэд бүтцийн төлөвлөлт: 2023-24</p> <p>Төслийн үе шаттай хэрэгжилт: 2025~</p>
Төслийн тодорхойлолт	<p>Үндэслэл</p> <p>Монгол Улс нь жуулчдын сонирхол татахуйц төрөл бүрийн аялал жуулчлалын нөөцтэй хэдий ч тэдгээрийн хөгжил төдийлөн хангалттай сайн биш байна. Гол шалтгааныг доор дурдав. Үүнд:</p> <p>1) эдгээр нөөц нь зам, тээвэр, харилцаа холбооны сүлжээгээр хоорондоо</p>



<p>төдийлөн холбогдоогүй өргөн уудам газар нутагт тархай бутархай байршсан 2) Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг орон нутаг, гадаад, дотоодын аялал жуулчлалын агентлагууд зэрэг салбарын оролцогч талуудын төрөл бүрийн аялал жуулчлалын нөөцийг хамтран хөгжүүлэх, маркетинг хийх хамтын ажиллагаа хангалтгүй байна. Аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх нь тодорхой байршил дахь аялал жуулчлалын объектуудыг холбох, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг орон нутаг, гадаад, дотоодын аялал жуулчлалын агентлагуудыг холбох үр дүнтэй стратеги юм.</p> <p>Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p> <p>ҮХЦТ-ний хүрээнд Хархорин-Орхон-Цэцэрлэгийн аялал жуулчлалын гурвалжин, Сайншанд-Замын-Үүд-Говийн бүсийн аялал жуулчлалын гурвалжинг хөгжүүлэхээр тодорхойлсон. Тэдгээр нь авто замын сүлжээнд нэгдэх боломжтой тул үндэсний болон бүс нутгийн хөгжилд чухал ач холбогдолтой. Түүнчлэн хөгжлийн боломжтой ч авто замын сүлжээнд холбогдоогүй аялал жуулчлалын нөөц их бий. Аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх тулд доор дурдсан зүйлсийг тодорхойлов. Үүнд:</p>		
Аймаг	Гол нөөц	Хот
Баян-Өлгий 	Хурган нуур, ян сарьдаг бүхий өндөр уулын зэрлэг араатан амьтадтай Алтай таван богдын байгалийн цогцолбор газар, өвөрмөц уламжлал, соёл зан заншил бүхий олон ястан	Баруун бүсийн аялал жуулчлалын зангилаа болох Ховд хоттой холбогдсон аялал жуулчлалын бааз Өлгий хот
Өмнөговь 	Ёлын ам, Баянзаг, Толь хад болон байгалийн үзэсгэлэнт газрууд; төлөвлөгдөж буй Динозаврын музей	Агаараар, төмөр замаар болон авто замаар нэвтрэх боломжтой аялал жуулчлалын бааз Даланзадгад хот (хэтийн төлөв)
Сүх-баатар 	6 нуур бүхий Дарьгангын байгалийн цогцолбор газар, Шилийн богд уул, Талын агуй болон соёлын өв; тал хээрийн ландшафт болон худалдан авалт хийх боломжтой Бичигтийн хил орчмын аялал жуулчлал	Аялал жуулчлалын бааз Бичигт, Эрдэнэцагаан, Дарьганга

	 <p>Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>БОАЖЯ нь тухайн орон нутгийн засаг захиргаатай хамтран Аялал жуулчлалын сүлжээ байгуулах мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг удирдан, зохион байгуулна. ҮХЦТ-ний хүрээнд боловсруулсан Үлэг гүрвэлийн музей байгуулах төлөвлөлтийн ажлын туршлагаас суралцана. Авто замын сүлжээнд холбох зэрэг холбогдох дэд бүтцийн төлөвлөлт, бүтээн байгуулалтыг холбогдох яам, агентлагууд хариуцах бөгөөд БОАЖЯ нь уялдаа холбоог ханган, хамтран ажиллана. Олон улсын аялал жуулчлалын агентлагуудтай хамтран ажилладаг дотоодын аялал жуулчлалын компаниуд маркетингийг идэвхтэй хийнэ.</p>
<p>Байгаль орчин болон нийгмийн нөлөөлөл</p>	<p>Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжилд мэдэгдэхүйц нөлөө үзүүлнэ; Боловсрол, оролцоог хангах замаар нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ; Орон нутгийн иргэд хоорондын харилцаа холбоог бэхжүүлнэ; Орон нутгийн иргэдийн орлого мэдэгдэхүйц нэмэгдэнэ; Тухайн газар нутгийг хадгалан хамгаална; Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангахад хувь нэмэр оруулна.</p>
<p>Тайлбар</p>	

## 10.2 Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд

### Төслийн дугаар: II1.1

Төслийн нэр	<b>Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл*</b>
Байршил	Чойбалсан, Говь-Алтай, Ховд
Хэрэгжүүлэгч	ХХААХҮЯ, БХБЯ, Аймгуудын ЗДТГ
Зорилго	1) Залуучуудыг уламжлалт болон орчин үеийн мал аж ахуй эрхлэлтэд сургах; 2) Монгол соёл заншлын чухал хэсэг болох нүүдлийн соёл, уламжлалыг хадгалах, аялал жуулчлалтай холбох.
Хүлээгдэж буй үр дүн	Залуу малчдын тоо нэмэгдэнэ; Нүүдлийн соёл, зан заншлыг хадгална.
Төслийн зардал	
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2 үе шатаар хэрэгжүүлнэ.
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Уламжлалт нүүдлийн мал аж ахуйг эдийн засагт эзлэх байр суурийг хадгалж үлдэхийн тулд малчдын шинэ залуу халааг тасралтгүй бэлтгэх шаардлагатай. Шинэ залуу малчин бэлтгэхдээ мал аж ахуй илүү давамгайлсан орон нутгийн төв суурин газрын ойролцоо бааз суурийг байгуулж болох юм. Эдгээр бааз суурийг ашиглан хагас эрчимжсэн мал аж ахуйн фермийг уламжлалт бэлчээрийн мал аж ахуйтай хослуулан уялдуулах замаар цаашид дэмжинэ.</p> <p>Бааз суурь бүрт анхан шатны боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээнд ашиглах бусад олон нийтийн барилга айгууламжийг барьж байгуулах нь зүйтэй. Бага сургуулийн байгаль орчны боловсролын хичээлийн хөтөлбөрт байгаль орчинд ээлтэй мал аж ахуйн уламжлалт арга туршлагыг хүүхдүүдэд өвлүүлэх талаар оруулах хэрэгтэй. Эдгээр бааз сууриуд нь зөвхөн ТХҮБ 2030-д тусгагдсан соёлын болон өв соёлын аялал жуулчлал төдийгүй хөдөө орон нутгийн аялал жуулчлал зэрэг өөр төрлийн жуулчлалыг зохион байгуулж, хүлээн авах цэг болох юм.</p> <p>Дараа нь бага сургуульд аялал жуулчлалын үйлчилгээний талаарх сургалтыг явуулж болно. Ингэснээр орлого олох боломжийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг сайжруулахад тус дэм болно. Өрхийн хүнсний ногооны тариалан эрхлэлтийг аялал жуулчлалын салбарт нэмэлт орлого олох, нүүдэлчдийн уламжлалт хоол хүнсийг сайжруулах зорилгоор нэвтрүүлж болно.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>a) Байгаль орчин, аялал жуулчлалын үйлчилгээтэй холбоотой сургуулийн өмнөх насны болон бага боловсрол;</p> <p>b) Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний барилга, байгууламж;</p> <p>c) Олон нийтийн үйл ажиллагаанд зориулсан барилга, байгууламж;</p> <p>d) Хагас эрчимжсэн мал аж ахуй;</p> <p>e) Хүлэмжийн аж ахуй;</p> <p>f) Малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, агуулах барилга, байгууламж.</p> <p>3) Хэрэгжилт</p>

	ХХААХҮЯ, БХБЯ-ны удирдлага зохицуулалтын хүрээнд аймгийн ЗДТГ, сонгогдсон эсхүл сайн дураараа оролцох сумын ЗДТГ-тай хамтарч хэрэгжүүлнэ.
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Бэлчээрийг хамгаалах чиглэлээр залуучуудыг сургах сургалтын хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны талаарх боловсрол олгох нь байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

Төслийн дугаар: II1.2

Төслийн нэр	<b>Малчдын хүүхдэд гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл</b>
Байршил	Архангай, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар аймаг, цаашид улсын хэмжээнд дэлгэрүүлэх
Хэрэгжүүлэгч	БШУЯ Боловсролын салбарт ажилласан туршлагатай ТББ
Зорилго	Алслагдсан хөдөө орон нутгийн эмзэг бүлгийн 50,000 орчим хүүхдийн боловсрол, хөгжлийг дэмжих.
Хүлээгдэж буй үр дүн	Нийт 50,000 малчны хүүхдэд гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх чанартай боловсрол олгох, сургуульд элсэхэд бэлтгэх, бага сургуульд амжилттай суралцах, хөгжих үндэс суурь тавигдана.
Төслийн зардал	20 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021 оноос 2025 оны 8-р сар хүртэл
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Алслагдсан хөдөө орон нутгийн хүүхдүүдийн ихэнх нь бэлтгэлд хамрагдалгүйгээр сургуульд ордог. Японы Хүүхдийг ивээх сангаас БШУЯ-тай хамтран Дэлхийн банк, Японы Нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилтээр малчдын хүүхдүүдийг гэр бүлийн орчинд нь сургуульд элсэхэд бэлтгэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Сургуулийн өмнөх боловсролын шинэ хэлбэрийг дөрвөн аймгийн 30 суманд туршиж үзсэн. Таван настай хүүхдүүд хөтөлбөрийг амжилттай дүүргэж, сургуульд элсэн суралцаж байна. Сургуулийн дотуур байранд хамрагдсан 6 настай хүүхдийн тоо нэмэгдсэн. Хүүхдүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэхийн тулд сургуулиас завсардсан хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх, бага ангийн сурагчдын хичээлийн хоцрогдлыг хялбаршуулан нөхөх зэргээр одоогийн хүчин чармайлтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>а) Олон нийт, гэр бүлд нь түшиглэсэн бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрүүд;</p> <p>б) Дотуур байр, хамаатан садныдаа амьдардаг малчны хүүхдүүдэд зориулсан хичээлийн дараа чөлөөт цагаа өнгөрөөх олон төрлийн арга хэмжээ;</p> <p>с) Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар сургуулиас завсардсан хүүхдүүдэд бага ангийн боловсрол гэрээр нөхөн олгох хөтөлбөр.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БСШУСЯ болон боловсролын салбарт ажилласан туршлагатай ТББ гол хэрэгжүүлэгч байх бөгөөд аймгуудын Боловсролын газар, Насан туршийн боловсролын төвүүд нь төслийг тухайн орон нутагтаа хэрэгжүүлнэ.</p>

	БШУЯ эхний 2-3 жилийн хугацаанд төслийн хэрэгжилтийг зохицуулах, менежментийг цаашид аажмаар шилжүүлэн авахад нь туслах зорилгоор ТББ-уудад техникийн болон чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх болно. Сумдад хүүхдийн боловсрол хүмүүжилд чухал үүрэг гүйцэтгэдэг эцэг эх, олон нийт, сургууль, цэцэрлэг, Насан туршийн боловсролын төв, сумын засаг захиргааны сайн дурын төлөөллөөс бүрдэх Олон нийтийн боловсролын зөвлөлийг (ОНБЗ) байгуулна.
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нийгэмд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

**Төслийн дугаар: II2.1**

Төслийн нэр	<b>Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл*</b>
Байршил	Алслагдсан аймгууд
Хэрэгжүүлэгч	ХХААХҮЯ, БХБЯ, аймгуудын ЗДТГ, хувийн хэвшил
Зорилго	1) Малчид, нутгийн удирдлагуудын хооронд цаг уурын мэдээ зэрэг мал аж ахуйтай холбоотой мэдээлэл солилцох ажлыг хөнгөвчлөх; 2) Малчдын болон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Ус, тэжээл, цаг уурын нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангагдсан мал аж ахуй эрхлэх; 2) Малчдын эрэлт хэрэгцээг илүү анхаарч ажилладаг хариуцлагатай засаг захиргааг бий болгох.
Төслийн зардал	
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2 үе шатаар хэрэгжүүлнэ.
Төслийн танилцуулга	1) Үндэслэл НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай хэрхэн нийцэж буйг тодорхойлох үүднээс ТХҮБ 2030-ын хэрэгжилтийг хянаж, үнэлэх шаардлагатай. ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэхийн тулд зөвхөн макро өгөгдөл төдийгүй орлогын ангилал, бүс нутаг, хүйс, нийгмийн бүлгээр төрөлжүүлсэн бичил өгөгдлүүд шаардлагатай болно. Аймаг, сумын түвшинд бичил мэдээлэл цуглуулах нь захиргааны зардал, ялангуяа орон нутгийн засаг захиргааны зардлыг нэмэгдүүлдэг. Орон нутагт захиргааны зардлыг бууруулахын тулд ТХЗ-ын хяналт, үнэлгээ хийхэд шаардлагатай бичил мэдээллийг цуглуулах ажилд нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд сайн дураараа хувь нэмэр оруулна гэж найдаж байна. Энэ байдлыг орон нутгийн засаг захиргаа ба нутгийн иргэд, малчдын хоорондох харилцааг сайжруулах боломж болгон ашиглах хэрэгтэй. Малчдын үйл ажиллагааны онцлог, бүтэц, тоо хэмжээ, нүүдлийн чиглэл, нүүдлийн зам дагуух тэжээл, ус худалдан авах боломж, тулгарч буй бэрхшээл зэрэг асуудлыг засаг захиргааны байгууллагууд цаг тухайд нь мэдсэнээр тусламжийн арга хэмжээг мөн цаг тухайд нь шуурхай үзүүлэх боломжтой. Нөгөө талаас малчдыг цаг уурын мэдээ, малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт, үнэ, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлэн байдал, тэжээлийн хангамжийн талаарх мэдээллээр яг хэрэгтэй цагт нь шуурхай хангадаг байвал

	<p>тэдний амьжиргаа дээшилж, улмаар ТХЗ-ыг хангахад хувь нэмэр оруулна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>МХХТ-д суурилсан системийг эхлээд ухаалаг гар утас ашиглан мэдээлэл солилцох системийн загвар хэлбэрээр сонгосон хэсэгт туршиж үзэх хэрэгтэй. Ийм байдлаар цуглуулсан бичил мэдээллийг статистикийн мэдээлэлтэй хамтатган ашигласнаар илүү оновчтой арга хэмжээг аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгахад нэмэр болно. Энэ нь засаг захиргаа болон иргэдийн хоорондын харилцааг улам сайжруулахтай холбоотой ажлын эхлэл болно.</p> <p>Нутгийн удирдлага, иргэд, олон нийттэй МХХТ-ийн сүлжээгээр холбогдосноор оролцогч талуудын чадавх сайжирч, харилцан итгэлцэл, хариуцлагын мэдрэмж нэмэгдэх болно. Үүнийг үнэхээр нийгмийн шинэчлэл гэж үздэг. Мэдээлэл цуглуулах асуудлын хувьд Монгол Улс төв суурины хүн ам болон малчдын аль алиныг нь хамарсан үүрэн холбооны үйлчилгээ, интернэтэд холбогдсон байдлаараа бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад давуу талтай юм. Иймд Монгол Улс энэ чиглэлээр МХХТ-ийг ашиглах өндөр боломжтой.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ХХААХҮЯ, БХБЯ-ны удирдлага, зохицуулалтын хүрээнд аймгийн ЗДТГ, сонгогдсон эсхүл сайн дураараа оролцох сумын ЗДТГ-тай хамтарч хэрэгжүүлнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

Төслийн дугаар: II2.2

Төслийн нэр	Малчдын цогц мэдээллийн санг бий болгох төсөл
Байршил	
Хэрэгжүүлэгч	ҮСХ, Аймгийн ЗДТГ
Зорилго	<p>1) Малчдын үйл ажиллагааны талаарх мэдээллийн нэгдсэн сан бий болгох;</p> <p>2) Нүүдлийн мал аж ахуй эрхлэлтэд зохих үнэлгээ өгөх замаар тогтвортой хөгжлийн зорилтод тусгасан түвшинд хүрэхэд хувь нэмэр оруулах.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>1) Малчдын ахуй амьдралыг сайжруулах чиглэлээр тэдний хэрэгцээ шаардлагыг хангана;</p> <p>2) Удирдлагын хариуцлага сайжирна.</p>
Төслийн зардал	
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	3 үе шатаар хэрэгжүүлнэ.
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол Улсад албан ёсны статистикийн тоо мэдээллийг олон салбар, чиглэл, үзүүлэлтээр маш сайн цуглуулж гаргадаг. Гэвч малчдад шаардлагатай тус дэмжлэгийг цаг тухайд нь зохих байдлаар хүргэх урьдчилсан нөхцөл болох тэдний тухай мэдээллийг системчилж, сайжруулах шаардлагатай байна. Малчдын талаарх мэдээллийн</p>

	<p>баазыг бий болгох иж бүрэн төслийг дээр дурдсан (Төсөл II2.1) мэдээлэл харилцааны технологид тулгуурласан системээр эхлүүлж болох юм. Дээр дурдсанаар малчдад чиглэсэн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлснээр нүүдлийн уламжлалт соёлыг цаашид үндэсний хөгжлийн үндэс суурь болгон хүндэтгэн үзэж буй төрийн бодлогын талаар ард түмэнд зөв мессежийг хүргэх болно. Цуглуулж нэгтгэх мэдээлэлд малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, бэлчээрийн газар, отор нүүдлийн замын маршрут, малын худаг ус, тэжээлийн хангамж, бараа бүтээгдэхүүний маркетинг, нийгэм соёлын шаардлага зэрэг мэдээллүүд орно. Эдгээр мэдээлэл нь орон нутгийн удирдлагад малчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, дэмжлэг туслалцааны үр дүнг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>a) Малчдын үйл ажиллагааны онцлог, уламжлалт зан заншил, амьдралын хэв маяг гэх зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах;</p> <p>b) Малчид, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хооронд МХХТ-д суурилсан мэдээлэл солилцох системийг хөгжүүлж, ашиглах.</p> <p>c) Мэдээллийн санг уламжлалт соёлд суурилсан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд үр дүнтэй ашиглах.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Үндэсний статистикийн хорооноос мэдээллийн сан, МХХТ-д суурилсан мэдээлэл солилцох системийг хөгжүүлнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

**Төслийн дугаар: II3**

Төслийн нэр	<b>Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл*</b>
Байршил	Улаанбаатар хотын 9 дүүрэг Бүс нутагтаа хамгийн олон хүн амтай 5 аймаг: 1) Баян-Өлгий, 2) Хөвсгөл, 3) Дорнод, 4) Орхон**, 5) Дархан-Уул. **Монгол Улсын хоёр дахь том хот Орхон аймагт оршдог.
Хэрэгжүүлэгч	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) Дэмжлэг үзүүлэх байгууллагууд: Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ); Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим; Монголын Залуу ажил олгогч эздийн нийгэмлэг; Монголын Залуу мэргэжилтнүүдийн нийгэмлэг; Японы Олон улсын хамтын ажиллагааны төв; Япон улсад сургалт явуулдаг Хүний нөөцийг хөгжүүлэх JDS хөтөлбөр болон Японы Гадаад худалдааны байгууллага зэрэг байгууллагууд
Зорилго	Компаниуд болон ажил хайгчдын хоорондын түншлэлийг хөгжүүлэх: залуучууд ба насанд хүрэгчид, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд. Ажилгүй иргэдэд зориулж дадлага, сургалт зохион байгуулах, ажлын байр бий болгох зорилгоор гэр хороолол, хөдөө орон нутаг буюу төвөөс алслагдсан нутаг болон жижиг бизнес/олон улсын/дотоодын компаниудад чиглэнэ.
Хүлээгдэж буй үр дүн	1) Залуучууд, насанд хүрэгчдийн ажилгүйдлийг бууруулна;

	<p>2) Төсөлд хамрагдагсадад ажил хөдөлмөрийн талаар эерэг соёл, ёс зүй тогтож, ажилд хариуцлагатай ханддаг болно;</p> <p>3) Ажил олгогчдын бодит эрэлтэд үндэслэн залуучууд болон насанд хүрэгчдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлнэ;</p> <p>4) Харилцааны соёл, чадварыг хөгжүүлнэ;</p> <p>5) Залуучууд болон ажил олгогчдын харилцан ашигтай түншлэл бий болно;</p> <p>6) Сонгогдсон ажил олгогчид дадлагын байрыг бий болгох ба эхний ээлжинд тодорхой хугацаанд дадлагын ажилтнуудыг авч ажиллуулна;</p> <p>7) Зээл, тусламж олгох замаар аж ахуйн нэгжүүдийн зүгээс төсөлд оролцох боломжийг дэмжинэ.</p>
Төслийн зардал	<p>1-р үе шат: 3 сая ам.доллар</p> <p>2-р үе шат: 5 сая ам.доллар</p> <p>3-р үе шат: 7 сая ам.доллар</p> <p>Нийт: 15 сая ам.доллар</p>
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>1-р үе шат (2022)</p> <p>Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ;</p> <p>Ажил хайгч/залуучуудын ур чадварыг ажил олгогчдын хүлээж буй ур чадвартай харьцуулж судалгаа хийнэ. Цаашилбал тогтвортой ажлын байрны тоо, ажлын байрны прогнозыг тодорхойлно;</p> <p>Суурь судалгаа хийнэ;</p> <p>Төслийн стратеги, төлөвлөгөө, төслийн баримт бичиг, ложистик, хяналт, үнэлгээг боловсруулна;</p> <p>Төслийг Улаанбаатар хотын 2 гэр хороололд туршилтаар хэрэгжүүлнэ;</p> <p>Төсөлд оролцох ажил олгогчдыг сонгон шалгаруулна;</p> <p>10 дадлагажигчийг 1 жилийн дадлагын хөтөлбөрт хамруулна.</p> <p>Төсвийн задаргаа: Зөвлөх үйлчилгээний зардал: 1 сая ам.доллар, Дадаглажигчдын амьдрах зардал: 400,000 ам.доллар, Замын зардал: 450,000 ам.доллар, Тоног төхөөрөмжийн зардал: 100,000 ам.доллар, Судалгааны зардал: 400,000 ам.доллар, Орчуулгын зардал: 500,000 ам.доллар, Япон хэлний сургалтын зардал: 50,000 ам.доллар.</p> <p>2-р үе шат (2023)</p> <p>Улаанбаатар хотын бусад гэр хороололд хэрэгжүүлнэ;</p> <p>Төслийн дунд хугацааны үнэлгээ хийнэ.</p> <p>3-р үе шат (2024):</p> <p>5 аймагт хэрэгжүүлнэ;</p> <p>Төгсгөлийн үнэлгээ хийнэ.</p>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>2018 оны ажиллах хүчний судалгаанаас үзэхэд 15-29 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин* нийт ажилгүйдлийн түвшнээс 3%-16.5%-иар өндөр байна. Боловсролын түвшний хувьд авч үзвэл дунд болон дээд боловсролтой залуучуудын дунд ажилгүйдлийн түвшин өндөр байна. Ажилгүй залуучуудын бараг гуравны нэг нь ур чадварын шаардлага хангахгүй, туршлагагүйгээс болж тохирох ажил олж чадахгүй байна (АХС, 2018). Тиймээс чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа нэн чухал юм.</p> <p>Ажил олгогчид нь ажил горилогчдын мэргэжлийн ур чадвар төдийгүй ерөнхий хандлага, харилцааны чадварыг анхаарч үздэг. Ажил олгогчдын талаас илүү хувь нь шинэ ажилтнуудын дадлага туршлагад сэтгэл дундуур байсан (Ажил олгогчдын зүгээс тавигдах шаардлагын судалгаа, 2017). Чадварыг дээшлүүлэх нь ажил хайгчдад өөрсдийн ур чадварт тохирсон ажил олоход нь тус болно.</p>



	<p>Швейцарын Хөгжлийн агентлаг залуучуудын ажилгүйдлийг системтэйгээр шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээр зорьж байна. Үүнтэй холбогдуулан 2011 оноос хойш “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар сүүлийн үе шат нь залуу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготойгоор хэрэгжиж байна. Төслөөс шууд ашиг хүртэх хүмүүс нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн төгсөгчид юм. Залуучуудын ажил эрхлэлтийг дэмжиж буй бусад байгууллагууд мөн л МСҮТ-ийн төгсөгчид болон оюутнуудад голчлон анхаардаг. Гэтэл залуу ажиллах хүчинд зориулж ажлын байр бий болгох зорилготой бизнесийг дэмжих, бэхжүүлэх үйл ажиллагаа сул байна.</p> <p>Тиймээс санал болгож буй төслийн гол зорилгыг дор дурдав. Үүнд: (i) хөдөлмөрийн зах зээлд анх удаа оролцож буй залуу эрэгтэй, эмэгтэй хүмүүст чиглэнэ; (ii) ирээдүйн ажилд нь бэлтгэх гүүр болно; (iii) бичил, жижиг бизнес/олон улсын/дотоодын компаниудын үйл ажиллагааг бэхжүүлнэ.</p> <p>* Ажилгүйдлийн түвшин 15-19 насныхны дунд 24.5%, 20-24 насныхны дунд 19.4%, 25 насанд 10,8% байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Дараах дөрвөн хэсгээс бүрдэнэ: Ажлын ур чадвар олгох, харилцааны чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулна; Оролцогчдын мэргэжилд нийцүүлэн олон улсын болон дотоодын компаниудад дадлага хийлгэх хөтөлбөр (Дадлага нь практик, ур чадварыг сурахад чиглэнэ. Япон улстай хэрэгжүүлэх солилцооны хөтөлбөрт хамрагдахын тулд залуучууд Японы хувийн компаниудад (шууд ажил эрхлэлттэй холбоогүй) 1 жил хүртэлх хугацаанд дадлага хийнэ); Хөдөлмөрийн гэрээ: Дадлага амжилттай төгссөн залуучууд 1 жилийн хугацаатай, хоёр тал зайлшгүй биелүүлэх нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ байгуулна. Гэрээний биелэлтийг төслийн дагуу хянах болно;</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Жилд хоёр ээлжээр хэрэгжинэ. МАОЭНХ-ээс дотоодын хэрэгцээ шаардлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлагад суурилсан ерөнхий удирдамж, техникийн зөвлөгөөгөөр хангана.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Тодорхой нөлөөлөлгүй
Тайлбар	Энэ төсөлд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн туршлагаас авч ашиглана.

**Төслийн дугаар: II4**

Төслийн нэр	<b>Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр</b>
Байршил	Улаанбаатар хот, 15 аймаг
Хэрэгжүүлэгч	Монголын Хараат бус судалгааны хүрээлэн, бусад хүрээлэнгүүд
Зорилго	Эмэгтэй удирдагчдаас зөвлөгөө авах, сүлжээ тогтоох зэргээр залуу эмэгтэйчүүдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олж авахад нь дэмжлэг үзүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн	Хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох эмэгтэйчүүдийн тоо дараах байдлаар нэмэгдэнэ: Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжилд ахиц дэвшил гарна; Мэдээлэл, чиглэл, удирдамжаар хангана; Амжилттай ажиллаж буй эмэгтэй удирдагч, тэргүүлэх идэвхтэн, мэргэжилтнүүдийг залуу эмэгтэйчүүдийн сүлжээнд татан оролцуулна; Охид, эмэгтэйчүүдийг шинжлэх ухаан, технологи зэрэг бүхий л салбарт суралцахыг уриалан дэмжинэ; ТХҮБ 2030-д тусгагдсан "нийгмийн хөгжилд жендэрийн тэгш байдлыг хангах" чиглэлд хувь нэмэр оруулна.
Төслийн зардал	9.1 сая ам.доллар Сургалтын зардал: 4 сая ам.доллар, Семинар, бага хурлын зардал: 1 сая ам.доллар, Замын зардал: 1 сая ам.доллар, Сургалтын тэтгэлэг: 1 сая ам.доллар, Хэвлэх зардал: 500,000 ам.доллар, Харилцаа холбоо ба бусад: 100,000 ам.доллар, Санал зөвлөгөө авах болон үнэлгээ: 500,000 ам.доллар, Вебсайт, онлайн семинар, онлайн курс, хичээл: 1 сая ам.доллар.
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	I үе шат: 2021-2022 Суурь судалгаа хийнэ/сургалтын хэрэгцээ шаардлагыг үнэлж тогтооно; Төслийн стратеги, төлөвлөгөөг боловсруулна; Улаанбаатар хотод төслийг туршилтаар хэрэгжүүлнэ; Сонирхсон залуу эмэгтэйчүүд, оюутнуудад зориулж мэдээлэл солилцох, асуулт, хариулт өрнүүлэх виртуал платформ байгуулна; *Төсвийн задаргаа: Гэрээ: 500,000 ам.доллар, Семинарууд: 500,000 ам.доллар, Тэтгэлэг: 500,000 ам.доллар, Замын зардал: 1 сая ам.доллар, Вебсайт, платформ: 500,000 ам.доллар. II үе шат: 2023-2024 Сурталчилгааны материал, семинарын хөтөлбөрийг боловсруулна; Эхлээд 7 аймагт хэрэгжүүлнэ. Цаашид нэмэлтээр 8 аймагт хэрэгжүүлнэ; Төслийн дунд хугацааны үнэлгээ хийнэ. III үе шат: 2025 Монгол болон Япон улсын Парламентын эмэгтэй гишүүдтэй санал бодол солилцоно; Төгсгөлийн үнэлгээ хийнэ.
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Үндэсний статистикийн хорооны мэдээллээр үзэхэд удирдлагын түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны хувь эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. 2018 оны байдлаар ажиллах хүчний оролцоонд жендэрийн ялгаа 16.1% байна. Их, дээд сургуулиудын нийт оюутны 58-59% нь эмэгтэйчүүд боловч албан тушаал ахих нь хангалтгүй байна. Эмэгтэйчүүдэд ажил, мэргэжлийн талаар мэдээлэл дутагдаж байна. Ялангуяа хөдөлмөрийн зах зээл дээр шаардагдаж буй мэргэжил, дэмжлэг тусламж, хэлхээ холбоо зэрэг мэдээлэл дутагдалтай байна (Дэлхийн банк, 2018 он). 2) Төслийн бүрэлдэхүүн Энэ төслийг их, дээд сургуулийн эмэгтэй оюутнуудад зориулах ба дараах гурван бүрэлдэхүүн хэсэгтэй байна. а) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөгжүүлэх хөтөлбөр: Их дээд сургуулийн эмэгтэй оюутнуудад зориулж дараах чиглэлээр сургалт хийх: Түвшнээ ахиулахад тус болохуйц хөдөлмөрийн зах зээл дээр шаардагдаж буй мэргэжил, ур чадвар, бусад туслах чанарын чадваруудыг хөгжүүлэх сургалт;

	<p>Манлайлал, шүүмжлэлтэй сэтгэх чадвар, өөртөө итгэх итгэл, харилцаа холбоо, олон нийтийн өмнө үг хэлэх, яриа хэлэлцээр хийх чадвар, карьер хөгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийн талаарх мэдлэг, бусдыг удирдах, аналитик үндэслэл зэргийг хамарсан харилцааны чадварыг хөгжүүлэх сургалт.</p> <p>b) Ахлах сургуулийн эмэгтэй сурагчдад зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа:</p> <p>Сургууль дээр сурагчид, тэдний эцэг эхэд зөвлөгөө өгөх, олон улсын/гадаадын их дээд сургуульд зочлох, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр шалгалтанд бэлтгэх зэрэг ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох;</p> <p>ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг (ажил мэргэжлийн тухай танилцуулга, чадварыг тодорхойлох, мэргэжил сонгох, ур чадвар, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага гэх мэт) багтаах.</p> <p>c) Амжилттай ажиллаж буй эмэгтэй удирдагчидтай хийх цуврал уулзалт, семинар:</p> <p>Их дээд, ахлах сургуулийн эмэгтэй оюутан сурагчид удирдагч эмэгтэйчүүдээс туршлага, амжилт, сорилт бэрхшээлүүдийнх нь талаар сонсоно.</p> <p>d) Үйлдвэр, ажлын байрыг газар дээр нь очиж үзэх аялал:</p> <p>Тухайн салбарын талаар туршлага олж авах зорилгоор эмэгтэй удирдагчидтай ажлын байран дээр нь очиж ярилцана.</p> <p>e) Шинжлэх ухаан, технологийн салбарт охид эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр:</p> <p>Шинжлэх ухааны чиглэлээр суралцаж буй болон тус салбарт ажиллаж буй залуу эмэгтэйчүүдэд тэтгэлэг олгоно.</p> <p>f) Ажил амьдралын тэнцвэрийн талаарх хэлэлцүүлэг, зөвлөгөө:</p> <p>Эмэгтэйчүүдийн уламжлалт үүрэг болон тэдний гэр бүлдээ хүлээх үүргийн талаарх бодол саналыг сонсох, тэднийг дэмжих сүлжээ бий болгох чиглэлээр хэлэлцүүлэг хийнэ.</p> <p>g) Монгол болон Япон улсын Парламентын эмэгтэй гишүүд оюутнуудтай санал бодол солилцох уулзалт:</p> <p>Монгол Улсын парламентын нийт гишүүдийн 17.1% нь эмэгтэй гишүүд ба энэ үзүүлэлтээрээ дэлхийд 120-т жагсдаг. Харин Япон улс 10.2%-иар 164-т жагсдаг. Монгол Улс жендэрийн тэгш байдлыг хангах туршлагаа хуваалцах боломжтой юм.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Монголын Хараат бус судалгааны хүрээлэн нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлагад суурилсан удирдамж, техникийн зөвлөмжөөр хангах ба дотоодын хэрэгцээг тодорхойлно.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Нийгэмд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>Урьдаас мэдэгдэх байгаль орчны сөрөг нөлөө байхгүй боловч агаарын хөлгөөр нислэг үйлдсэний улмаас бага зэргийн нүүрстөрөгчийн ул мөр үлдэнэ. Нисэх онгоцоор аялахын оронд онлайн уулзалтууд зохион байгуулах боломжтой.</p>
Тайлбар	

Төслийн дугаар: II5

Төслийн нэр	<b>Бизнест чиглэсэн хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр</b>
Байршил	Улаанбаатар
Хэрэгжүүлэгч	БСШУСЯ
Зорилго	Монгол-Японы Инженер, технологийн дээд боловсрол төслийг (M-JEED) бусад хүрээлэнгүүдтэй холбож, цаашид өргөжүүлэх замаар шинжлэх ухаан, технологийн салбараас бусад мэргэжлийн хүний нөөцийг хөгжүүлэх.
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Эдийн засгийн хөгжлийн ирээдүйн хэрэгцээг хангах зорилгоор мал аж ахуй, сүү сүүн бүтээгдэхүүн, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардагдах өндөр боловсролтой хүний нөөцийг бэлтгэнэ;</li> <li>2) Олон монгол залуусыг “Коосен” болон бусад хүрээлэнгүүдтэй хамтран Япон болон гуравдагч орнуудад докторын зэрэг хамгаалах чиглэлээр сургаж, туршлагажуулна.</li> </ol>
Төслийн зардал	30 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2022 он: Төсөл боловсруулах 2022 - 2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2024 – 2030 он: Төсөл бүрэн хэрэгжих
Төслийн танилцуулга	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл                      2015 оноос хойш хэрэгжиж эхэлсэн Японы "Коосен (техникийн их сургууль)" болон Япон дахь их дээд сургуулиудад тэтгэлэгт хөтөлбөрөөр дамжуулан 1000 монгол залуусыг шинжлэх ухаан, технологийн чиглэлээр сургаж байна.                      2020 онд нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орсноор Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангах шинэ логистик, тээврийн давуу талыг ашиглах өндөр боловсролтой хүний нөөц шаардлагатай болно.                      Газар тариалан, мал аж ахуй, хууль эрх зүй, бизнесийн удирдлага, эдийн засаг, хэлний чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор Монгол-Японы Инженер, технологийн дээд боловсрол төслийн хэрэгжилтээс сургамж авч шинэ төсөл хэрэгжүүлэх нь зүйтэй.</li> <li>2) Төслийн бүрэлдэхүүн                     <ol style="list-style-type: none"> <li>a) Шинжлэх ухаан, технологийн салбараас бусад буюу мал аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, газар тариалан, хууль эрх зүй, бизнесийн удирдлага, эдийн засаг, хэл судлал зэрэг салбарын мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээг дахин тогтоохын тулд урьдчилсан судалгаа хийх шаардлагатай.</li> <li>b) Төсөл нь нисэх онгоцны шинэ буудлаар дамжих логистикийн давуу талыг ашиглан аж үйлдвэрийн хөгжилд хувь нэмэр оруулах 450 залуусыг тэтгэлэгт хамруулах хөтөлбөрийг боловсруулна.</li> <li>c) Судалгаагаар цаашдаа зохих технологи бүхий гадаадын бизнес эрхлэгчидтэй түншлэхэд нь монголын бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл, мэргэжлийн бус байдлыг тодорхойлох ёстой.</li> </ol> </li> </ol>

	<p>d) Японд сурч төгсөөд Монголдоо буцаж ирсэн боловсролтой залуучуудыг ажилд авсанаар Монгол Улсад бизнесийг хэрхэн хөгжүүлэх боломжийг судалгаагаар тодорхойлох шаардлагатай. ШУТИС-ийн Бизнесийн удирдлагын сургуулийг оролцуулсан хөдөө аж ахуй-аж үйлдвэрийг холбосон төслүүдийн нэгийг үлгэр жишээ болгон авч үзэж болно.</p> <p>e) Эдийн засгийн тогтвортой хөгжилд чиглэсэн 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахын тулд мэргэжил дээшлүүлэх сургалт, санхүүжилт, зохих технологи бүхий бизнес эрхлэгчидтэй хамтарч ажиллах зэрэгт суурилан ур чадварыг хөгжүүлэх багц зөвлөмж гаргана.</p> <p>3) Хэрэгжилт БСШУСЯ-ны хэрэгжүүлэх энэ төсөлд Ерөнхий сайдын Ажлын албанаас Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр хяналт тавина.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нийгэмд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ-ний түвшин Ирланд, Скандинавын орнуудтай дүйцэхүйц хэмжээний өндөр түвшинд хүрэх боломжтойг олж харна.
Тайлбар	

**Төслийн дугаар: II6**

Төслийн нэр	<b>Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл</b>
Байршил	Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч	БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Зорилго	<p>1) Хөгжлийн шинэ загварыг хэрэгжүүлэх суурь болох Монголын өв уламжлалын үнэ цэнийг хадгалан ерөнхий боловсролын чанар, тоон үзүүлэлтийг сайжруулах;</p> <p>2) Шинээр гарч ирж буй бизнесийн хэрэгцээ, олон улсад өрсөлдөх чадварыг хангах дэвшилтэт технологи, шинжлэх ухаанд онцлох ач холбогдол өгч, сургалтын хөтөлбөрийг сайжруулснаар дээд, техникийн боловсролыг дээшлүүлэх;</p> <p>3) Бүхий л салбарыг хамарсан, хүчирхэг ажиллах хүчтэй байх зорилгоор насан туршийн боловсролыг бэхжүүлэх.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>Монголын өвөрмөц өв соёл, соёлын үнэт зүйлд суурилсан хөгжлийн шинэ загварыг дэмжих өргөн салбарыг хамарсан, хүчирхэг мэргэшсэн ажиллах хүчинтэй болно.</p> <p>Хөгжлийн шинэ загвартай уялдуулан эдийн засгийн хөгжлийг удирдан чиглүүлэх, соёлжсон сэтгэлгээ бүхий хүн хүчний нөөц бий болно.</p>
Төслийн зардал	7 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p><u>I үе шат 2021-2022</u></p> <p>Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх туршилтын төслийг хэрэгжүүлнэ. (Зайны сургалтыг бэхжүүлэх төсөл; Аж үйлдвэрийн салбар болон их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, академийн хоорондын уялдаа холбоог сайжруулах төсөл);</p> <p>Ажилтнуудыг сонгож ажилд авна, удирдлагын багийг бүрдүүлнэ, ажлын төлөвлөгөөг боловсруулна, хэрэгцээ шаардлагын үнэлгээ болон туршилт хийнэ.</p>

	<p>*Төсвийн задаргаа: Зөвлөх үйлчилгээ ба ажилтнууд: 1 сая ам.доллар, Замын зардал: 500,000 ам.доллар, Тоног төхөөрөмж, харилцаа холбоо, бусад: 1 сая ам.доллар.</p> <p><u>II үе шат 2023-2024:</u> Санал хүсэлт, үнэлгээ, зохицуулалтын талаар судлах; Ажлын төлөвлөгөөнд үндэслэн төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх; “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021 – 2030” баримт бичгийн хэрэгжилтэд үндэслэн төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн дунд хугацааны үнэлгээ, тохируулгыг хийнэ.</p> <p><u>III үе шат 2024-2025</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн үр дүнг “Алсын хараа 2050” баримт бичигт тусгана.</li> <li>- Үнэлгээний механизмыг бүрдүүлнэ.</li> <li>- Төгсгөлийн үнэлгээ хийж, семинар зохион байгуулна.</li> </ul>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол Улс нь НҮБ-ын ТХЗ болон ТХҮБ 2030-тай нийцүүлэн хөгжлийн шинэ загвараар хөгжихөд бэрхшээл тулгарч байна. ТХЗ болон ТХҮБ 2030-ын хэрэгжилт нь зохих технологийн шинэчлэл, Монгол Улсын гол нөөц, хөрөнгө болох ажиллах урам зоригтой, чадварлаг хүний нөөцөөс хамаарна. Технологийн шинэчлэл, хүний нөөцийг хөгжүүлэхийн тулд боловсролын салбарыг үр дүнтэйгээр, өргөн хүрээнд шинэчлэх шаардлагатай байна. Хөтөлбөрийн зорилтод хүрэх шинэчлэлийг хэрэгжүүлэхийн тулд боловсролын бүх түвшин, олон төрлийн асуудлаар Монгол Улсын Засгийн газраас гаргаж буй хүчин чармайлтуудыг цааш нь өргөжүүлэх, нэгдсэн стратеги дээр үндэслэсэн цогц арга хэмжээ авах хэрэгтэй. Алс хэтэд чиглэсэн хөгжлийн шинэ загварыг хэрэгжүүлэхийн тулд Монгол хүний сэтгэлгээг илүү бие даасан, шинэлэг болгож өөрчлөх, сайжруулах шаардлагатай байна. Өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн өмнөх боловсролоос эхлүүлэх хэрэгтэй бөгөөд үүнд гэр бүл, олон нийтийг зайлшгүй оролцуулна. Энэ чиглэлийн дагуу ерөнхий боловсролын чанарыг сайжруулахын тулд багш нарыг дахин сургалтад хамруулж, илүү өндөр ур чадвартай багш нарыг олноор бий болгох шаардлагатай болно.</p> <p>Үүний зэрэгцээ шинэ загвараар хөгжихийн тулд дэвшилтэт ур чадвар, дэвшилтэт технологи эзэмшсэн хүний нөөцийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахад зориулж дээд болон техникийн боловсролыг дэмжих шаардлагатай. Түүнчлэн хөгжлийн шинэ загвараар хөгжихөд хоцорч үлдэхгүйн тулд одоо байгаа ажиллах хүчинд өөрсдөө сургалтад хамрагдах боломжийг олгох хэрэгтэй. Монгол Улсын хүн ам залуу, тиймээс ч улс орноо цэцэглэн хөгжүүлэхэд хүн бүр чадварлаг, бүтээмжтэй ажиллах хүч болох замаар бүрэн дүүрэн хувь нэмрээ оруулах шаардлагатайгаас гадна мэдлэг чадвартай хүмүүс гадаад руу гарахаас зайлсхийх, мэргэжилтэй бэлтгэгдсэн хүмүүсээ гадаадаас эргэж ирэхийг нь урамшуулах нь зүйтэй. Энэ хөтөлбөр нь бүхэлдээ хөгжлийн шинэ загварыг ирээдүйд урт хугацаанд хэрэгжүүлэхэд тус дэм болох өргөн хүрээтэй, хүчтэй, мэргэшсэн ажиллах хүчийг бий болгоход хувь нэмэр оруулах болно. Батлагдсан Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд тусгаснаар Монгол Улсын Засгийн газрын эрс шийдэмгий санаачилга нь боловсрол эзэмшиж буй залуусын хөгжилд чухал хувь нэмэр оруулна. Түүнчлэн хувийн бизнес эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулах, насан туршийн боловсролыг бий болгож хэрэгжүүлэхийн тулд хувийн хэвшилтэй хамтран ажиллах зайлшгүй</p>

	<p>шаардлагатай юм. Төслийг Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор туршилтын төслүүдийн үр дүнд суурилсан зайны сургалтыг бүх түвшинд тэр дундаа насан туршийн боловсролд өргөн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд сургуулийн өмнөх боловсролыг мөн хамруулж болно.</p> <p><u>Бага сургуулийн боловсрол:</u></p> <p>Саяхан хэрэгжүүлсэн ЖАЙКА-гийн төслийн үр дүнг мониторинг, үнэлгээ зэргийн гүйцэтгэлийг сайжруулахад бүрэн ашиглана. Төслийн зорилго нь БСШУСЯ болон Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт зэрэг бусад хамаарал бүхий байгууллагуудын оролцоог ханган боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох тогтвортой арга барилыг бий болгох явдал юм.</p> <p>Шаардлага хангасан боловсролын сургалтын хөтөлбөр нь боловсролын чанарыг хангах үндэс суурь болох нь ойлгомжтой. Монгол Улсад боловсролын сургалтын хөтөлбөрийг үндэс суурьтай дүн шинжилгээ хийлгүйгээр ойр ойрхон өөрчилдөг тул боловсролын үр дүн тогтвортой бус байдаг. Тиймээс баримт нотолгоонд суурилсан дүн шинжилгээнд үндэслэн боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох тогтвортой арга барилыг бий болгох зорилт тавин ажиллана.</p> <p>Бүрэлдэхүүн 1: Сурагчдын хичээлийн үнэлгээг гаргах чадавхыг бий болгох/хөгжүүлэх.</p> <p>Бүрэлдэхүүн 2: Сурах бичиг, гарын авлага зэрэг сургалтын материалыг боловсруулах чадавхыг сайжруулах.</p> <p>Бүрэлдэхүүн 3: Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүнг үнэлэх, туршлага хуримтлуулах, түүнийг шинэ сургалтын хөтөлбөрт тусгах дарааллыг нэвтрүүлэх.</p> <p><u>Дунд сургуулийн боловсрол:</u></p> <p>Бүрэлдэхүүн 1: Олон төрлийн курсүүдийг санал болгодог боловсролын төвүүдэд сурагчдыг элсүүлэх, ур чадвар эзэмшүүлэх явуулын багийг ажиллуулах зэрэг арга замаар сургалтын хөтөлбөрт багтсан бүх хичээлд хамрагдах, орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд тухайлбал мэдээллийн технологийн дадлага хийх боломжийг олгох замаар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-үүдийг цогцоор нь дэмжих.</p> <p>Бүрэлдэхүүн 2: Сурагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэхэд нэмэлт дэмжлэг үзүүлэх.</p> <p>Бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсролын салбарын шинэчлэгдсэн дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн оруулж болно.</p> <p><u>Дээд боловсрол ба судалгаа:</u></p> <p>Зорилт: Хувийн хэвшлийн боловсролын асуудлыг зохицуулах бодлогыг* дэмжиж, сонгосон туршилтын сэдвээр үйлдвэрлэл, сургалт, судалгааны ажлын уялдаа холбоог бий болгох.</p> <p>* ЮНЕСКО-гийн тайланд үндэслэн боловсруулсан Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ хэвлэгдсэн. Уг тойм шинжилгээ нь бодлого болон салбар дундын зохицуулалтыг хангахад тус дэм болно.</p> <p>Бүрэлдэхүүн 1: Инженер, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, байгалийн ухаан зэрэг Монгол Улсын ирээдүйд хэрэг болох мэргэжил рүү оюутнуудыг хөтлөх.</p>
--	--

	<p>Бүрэлдэхүүн 2: Хувийн их, дээд сургуулиудын үйл ажиллагааны зохицуулалт болон өрийн дарамттай гэр бүлийн боловсролын өртөг болон үр ашигт дүн шинжилгээ хийх; дээд боловсролын төлбөрийн дээд хэмжээг тогтоох, их дээд сургуулиудын мэргэшлийн тогтолцоог бий болгох.*</p> <p>* Хувийн дунд сургуулийн төлбөр нь их, дээд сургуулийн сургалтын төлбөрөөс ярвигтай байдаг гэсэн үзэл бодол байдаг. Тиймээс энэ төслийн голлох бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлоход уг асуудал дээр нэмэлт нотолгоо шаардлагатай болно.</p> <p>Бүрэлдэхүүн 3: Стратегийн ач холбогдол бүхий судалгааны сэдвүүдийг боловсруулах, судалгааны их сургууль болон судалгааны байгууллагуудыг бэлтгэх.</p> <p><u>Хяналт ба салбар хоорондын/донор байгууллагуудын зохицуулалт</u> Зорилт: Хуримтлуулсан туршлагыг төлөвлөлтөд тусгахад ашиглах санал хүсэлтийг боловсруулах механизмыг бий болгож салбар хоорондын зохицуулалтад нөлөөлөх донор байгууллагуудын зохицуулах нэгжийг байгуулах.</p> <p>Бүрэлдэхүүн: ТХҮБ2030, Алсын хараа 2050, Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөгөөр дамжуулан боловсролын салбарын шинэчлэлийн гүйцэтгэлийг хянах, хуримтлагдсан туршлагыг шинэчлэгдсэн төлөвлөгөөнд тусгах, донор байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, чадавхыг хөгжүүлэх нэгжийг БСШУСЯ-ны дэргэд байгуулахыг дэмжих.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Байгаль орчны зохистой менежмент нь хөгжлийн шинэ загварын үнэ цэнийг бий болгох салшгүй хэсэг юм. Уламжлалт арга ухаан, ур чадварыг дэвшилтэт технологитой хослуулах замаар зохистой технологийг хөгжүүлэх хэрэгтэй.
Тайлбар	Энэхүү төслийг Монгол Улсын “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030” баримт бичигтэй уялдуулан хэрэгжүүлнэ. Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл болон “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх Арга хэмжээний төлөвлөгөө нь харилцан бие биенээ нөхөх бөгөөд давхардахгүй. Төслийн аливаа бүрэлдэхүүн хэсгийг Арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

#### Төслийн дугаар: II7.1

Төслийн нэр	<b>Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл</b>
Байршил	Улаанбаатар, Ховд, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь дахь Бүсийн оношилгоо эмчилгээний 4 төв. Алтайн бүсийн үйл ажиллагааг ҮХГ-аас санал болгосон БХБ-ын хүрээнд авч үзнэ.
Хэрэгжүүлэгч	ЭМЯ, Эрүүл мэндийн хөгжлийн төв, ДЭМБ
Зорилго	Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн тусламж үйлчилгээний сүлжээгээр дамжуулан аймгуудын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах. Энэхүү төсөл нь ЖАЙКА-гийн дараах төслүүдийн үр дүнд тулгуурлан хэрэгжинэ: Анхан ба хоёр дахь шатлалын төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл, Монгол-Японы Сургалтын эмнэлэг барьж байгуулах төсөл.
Хүлээгдэж буй үр дүн	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг дараах байдлаар бэхжүүлнэ: Эмч, сувилагч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх; Хүний нөөцийг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэх; Мэдээллийн менежментийг сайжруулах;



	Технологи нэвтрүүлэх; Эм, багаж хэрэгслээр хангах.
Төслийн зардал	13 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p><u>I үе шат (2021-2022)</u> ДЭМБ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, бэлэн байдлын төсөл, ЭМЯ-наас баталсан Тусламж үйлчилгээний багцын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэнэ; Хуримтлуулсан туршлага, гол чиглэл, бэлтгэгдсэн ажилтнуудад үзүүлэх дэмжлэг зэрэг асуудлаар ЖАЙКА-гийн төслийн хүрээнд нэмэлт судалгаа явуулна; Төслийн удирдлага, хяналтын нэгж байгуулна; Төслийн стратеги, төлөвлөлтийг боловсруулна; Төслийн багийг бүрдүүлж, тоног төхөөрөмж худалдаж авна; Улаанбаатар, Орхон болон бусад байршлуудад сургалтын хөтөлбөрөө үргэлжлүүлнэ; Өрхийн эрүүл мэндийн 218 төвд ажилладаг богино хугацааны эмчлэх эрхийн зөвшөөрөл бүхий эмч нарт зориулсан сургалтыг зохион байгуулна. *Төсвийн задаргаа: Тоног төхөөрөмж: 1 сая ам.доллар, Сургалт: 2 сая ам.доллар, Зөвлөх үйлчилгээ, ажилтнууд: 1 сая ам.доллар, Замын зардал: 500,000 ам.доллар, Эм, материал: 500,000 ам.доллар, Тэтгэлэг: 200,000 ам.доллар, Харилцаа холбоо, хангамж, бусад: 200,000 ам.доллар, Тавилга, компьютер: 100,000 ам.доллар.</p> <p><u>II үе шат (2023-2024)</u> Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд болон аймгуудад ажлын байран дээрх сургалтыг нэвтрүүлнэ; Бүсийн хэмжээнд дадлага туршлагатай эмч нарыг дагалдуулж, туршлага суулгана; Сумын эрүүл мэндийн 219 төвд (малчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээ авдаг хүмүүсээсээ дунджаар 100 км-ын зайтай байдаг) ажилладаг богино хугацааны эмчлэх эрхийн зөвшөөрөл бүхий эмч нарт зориулсан сургалтыг зохион байгуулна</p> <p><u>III үе шат (2025)</u> Үр дүнг нэгтгэж, төгсгөлийн хяналт дүгнэлт гаргана.</p>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө (2019-2026 он) боловсруулах талаарх АХБ-ны техникийн тайланд дор дурдсан асуудлыг нэн тэргүүний ач холбогдол бүхий хэмээн тодорхойлсон. Үүнд: “... эмнэлгийн байршлын газрын зургийг боловсруулж, эрүүл мэндийн байгууллага тус бүрт ногдох үйлчлүүлэгчдийн тоог тодорхойлох; үйлчлүүлэгчид ээлтэй үзлэгийн цаг авах стандарт систем болон эмчийн үзлэгийг үр дүнтэй зохион байгуулах, санал хүсэлтийг хүлээн авах системийг нэвтрүүлэх; тусламж үйлчилгээний түвшин тус бүрт сайжруулсан үйлчилгээний багцыг санал болгох замаар лавлагааны системийг нягтлан шалгаж, цаашид сайжруулах шаардлагатай.” Аймаг, сумдын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг яаралтай сайжруулах шаардлагатай байна. Эмнэлгийн хүний нөөц, тоног төхөөрөмж, чанарын стандарт хомс байгаа тул эрүүл мэндийн ажилтнууд хөдөө орон нутагт томилогдон ажиллах хүсэлгүй байдаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагууд, эмч, сувилагч, ажилтнуудын үүргийг нарийвчлан тогтоож, ажилтнуудыг сэлгэх системийг бий болгох шаардлагатай байна. Технологи, мэдлэг,</p>

	<p>мэдээллийн менежментийг сайжруулж, ажлын байрны сургалтад хамруулах хэрэгтэй.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн Түр хугацаагаар ажиллах зөвшөөрөлтэй эмч нарт зориулсан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулах; Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний эмч, сувилагч нарт зориулсан хүний нөөцийн стратеги боловсруулах; Төгсөлтийн дараах сургалтыг үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.</p> <p>3) Хэрэгжилт ЖАЙКА-гийн төслүүдийн хүрээнд хэрэгжиж буй сургагчдыг бэлтгэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн дэмжиж, эмч, сувилагч, сургагч багш нарын үүрэг оролцоог дэмжинэ. ДЭМБ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандартыг сайжруулахад чиглэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн сайн туршлагад суурилсан ерөнхий удирдамж, техникийн зөвлөгөө өгнө. Залуу эмч, эмнэлгийн ажилтнуудад дэмжлэг үзүүлэх шаардлагатай тохиолдолд сургагч багшийг бэлтгэх сургалт зохион байгуулна.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлын хэмжээг бууруулах зорилгоор алсын болон зайны холболтыг ашиглан чадавхыг бэхжүүлнэ.
Тайлбар	

### Төслийн дугаар: II7.2

Төслийн нэр	<b>Эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах төсөл</b>
Байршил	Улаанбаатар
Хэрэгжүүлэгч	ЭМЯ
Зорилго	ЭМЯ-ны хэмжээнд өгөгдөл, мэдээллийн нэгдсэн удирдлага, зохицуулалт хийх зорилгоор ЭМЯ-ны харьяа 4300 нэгж байгууллага, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг холбосон мэдээллийн технологийн нэгдсэн платформ бий болгох.
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Өнөөгийн байдлаар эмнэлэг, клиник, бусад байгууллага тус бүрийн өөр өөр програмаар зохицуулагддаг мэдээллийн технологийн өгөгдлүүдийг стандартчилна/нэгдсэн журамд оруулна;</li> <li>2) ЭМЯ-ны хувьд мэдээлэл цуглуулах ажлыг үр дүнтэй болгоно;</li> <li>3) Бодлого боловсруулах явц, эрүүл мэндийн байгууллагуудад өгөх удирдамжийг шуурхай, үр дүнтэй болгоно;</li> <li>4) Эмнэлэг, клиникүүдийн оношлогоо, эмчилгээг нарийн, үр дүнтэй болгоно;</li> <li>5) Эмчлүүлэгчид ая тухтай орчинд эмчлүүлнэ.</li> </ol>
Төслийн зардал	Тоног төхөөрөмж, тавилга худалдан авах, түрээслэх, сургалт, суурилуулалт, туршилт, холболтод 10 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>2022 он: Төслийн бэлтгэл, сонгон шалгаруулалт, худалдан авалт</p> <p>2023 он: ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, сонгогдсон байгууллага, нэгжүүдэд туршилт хийх, сүлжээг байгуулах, аймгуудтай холбох (1-р шат)</p> <p>2024 он: Аймгийн хэмжээнд бүх нэгжүүдийг холбох (2-р шат)</p> <p>2025 он: Сүлжээг бүрэн дуусгах, үнэлгээ, хяналт</p>
Төслийн танилцуулга	1) Үндэслэл

	<p>Олон жилийн туршид эрүүл мэндийн төрөл бүрийн төслийн хүрээнд янз бүрийн МХХТ системийг ДБ, АХБ, ДЭМБ, мөн Люксембург, БНХАУ, БНСУ, Япон улсын зэрэг хоёр талт тусламжийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр нэвтрүүлж ирсэн. Эдгээр бие даасан төслүүд нь Монгол Улсын иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулж байгаа боловч ЭМЯ, эрүүл мэндийн байгууллагуудад төслийн ололт амжилтыг харилцан түгээх асуудал төвөгтэй байна. Эрүүл мэндийн бодлогын томъёолол, эмнэлгийн үйлчилгээний түвшинг сайжруулахын тулд мэдээллийн стандартчилагдсан, нэгдсэн менежмент шаардлагатай байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн ЭМЯ-ны дэргэд Эрүүл мэндийн мэдээллийн төвийг барилга, тоног төхөөрөмжийн хамт байгуулах; Ажилтнуудад мэдээллийн технологийн шийдэл, хэрэглээний талаар сургалт явуулах; Сүлжээнд холбогдоогүй анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх; Хуучирсан тоног төхөөрөмжүүдийг сольж, засварлах.</p> <p>3) Хэрэгжилт ЭМЯ, ҮСХ, Засгийн газрын төлөөллөөс бүрдсэн Удирдлагын хороо ТХЗ-ыг хангахын тулд төслийн явц, түүний нөлөөллийг хянах болно. Дэлхийн банк, ДЭМБ, АХБ зэрэг үйл ажиллагааны түншүүд болон оролцогч талуудтай зохицуулалт хийнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Урьдчилсан байдлаар байгаль орчин, нийгмийн сөрөг асуудал гарахгүй гэж үзэж байна.
Тайлбар	

Төслийн дугаар: II7.3

Төслийн нэр	<b>Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), тэмбүү, гепатитын халдвар эхээс хүүхдэд дамжихаас урьдчилан сэргийлэх төсөл</b>
Байршил	Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг
Хэрэгжүүлэгч	ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ), Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)
Зорилго	Аймаг, орон нутгийн түвшинд ХДХВ, тэмбүү, гепатит халдвар эхээс хүүхдэд дамжихаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг нэмэгдүүлэх замаар тэмбүүтэй төрөлтийг бууруулах.
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Улсын хэмжээнд ХДХВ, тэмбүү, В гепатитын халдварыг эхээс хүүхдэд дамжихаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн зохицуулалт, уялдаа холбоог сайжруулна;</li> <li>2) Эх, хүүхдийн эрүүл мэндийн чанартай үйлчилгээг хангах үүднээс жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсний хяналтад хамрах хүрээг нэмэгдүүлнэ;</li> <li>3) Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд бэлгийн замын халдварт өвчин, төрөлхийн тэмбүүгийн өвчлөлийг бууруулна;</li> <li>4) Сонгогдсон аймаг, дүүргүүдэд БЗДХ-ын тандалтын системийг сайжруулна;</li> </ol>

	5) ХДХВ, тэмбүү, гепатит зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар шийдвэр гаргагчид, хүн ам, түүний дотор нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон жирэмсэн эмэгтэйчүүдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.
Төслийн зардал	220,000 ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2023
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Сүүлийн хорин жилийн хугацаанд ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй төслүүдийн дүнд эх, нялхсын эндэгдлийг бууруулах чиглэлээр Монгол Улс томоохон ахиц дэвшилд хүрсэн. Монгол Улс 2030 онд эрүүл мэндтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилгыг (ТХЗ) хангах боломжтой хэдий ч нөхөн үржихүйн насны болон жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү, бэлгийн замаар дамжих халдварын (БЗДХ) хувь хэмжээ өндөр байгааг харгалзан үзвэл ТХЗ-ын 3,5-р зорилгод тусгасан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэхэд ихээхэн хөрөнгө оруулалт шаардлагатай болно. ХӨСҮТ-ийн 2019 онд хийсэн судалгаагаар жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд В, С, Д вируст гепатитын өвчлөл 6,5% байжээ. Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтын 4 (хүүхдийн эндэгдлийг бууруулах), 5а (эхийн эндэгдлийг бууруулах) зорилтот түвшинд хүрсэн цөөхөн орны нэг бөгөөд бүс нутагтаа эхээс хүүхдэд дамжих халдварыг гурав дахин бууруулж чадах орнуудын нэг болж чадна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>ХДХВ, тэмбүү, гепатит гэсэн гурван өвчнийг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх нөхцөл байдлын дүн шинжилгээ, зохицуулалтыг сайжруулах, орон нутагт буюу сонгосон газруудад өвчлөлийг гурав дахин багасгах стратеги боловсруулах; Эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх ажилтнуудад сургалт явуулах; Яаралтай шинжилгээ хийх зориулалтын тоног төхөөрөмж худалдан авах; Мэдээлэл, сургалт, харилцааны материалыг боловсруулах, түгээх.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Төслийг 2020-2021 он хүртэл хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. ДЭМБ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар нь ХӨСҮТ, ЭХЭМҮТ, Хөвсгөл аймаг, УБ хотын Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн газруудыг хамарсан хэрэгжүүлэгч байгууллагуудаас уг төслийн зохицуулалт, менежментийн чиглэлээр Захиргааны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэнэ. Төслийн өдөр тутмын менежментийг ДЭМБ-ын Монгол дахь суурин Төлөөлөгчийн газар хариуцан, хяналт тавих ба төслийн саналд дурдсан бүх үйл ажиллагаатай холбоотой бодлогын хэлэлцүүлэг, ухуулга сурталчилгааны ажлыг аймаг болон дүүргийн удирдлагуудын идэвхтэй оролцоотойгоор явуулна. Төслийн хяналт шинжилгээг ДЭМБ-ын хяналт шинжилгээ, тайлагнах журмын дагуу гүйцэтгэнэ. Төслийн хэрэгжилтийн явцыг ДЭМБ жил бүр арга зүйн болон санхүүгийн хувьд дэмжигч түнш байгууллагад тайлагнана.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Энэхүү төсөл нь жирэмсэн эмэгтэйчүүдийг санхүүгийн дарамтанд оруулахгүйгээр чанартай, эрүүл мэндийн зохих тусламж үйлчилгээ авах боломж олгох зорилготой.

Тайлбар	Төрөлхийн тэмбүү зэрэг бэлгийн замын халдварт өвчний тархалт өндөртэй аймаг, дүүргийг сонгоно.
---------	--

**Төслийн дугаар: II7.4**

Төслийн нэр	<b>Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө өгөх /Телемедицин/ болон Оношлогооны зорилго бүхий эрүүл мэндийн хөдөлгөөнт цахим тусламж үйлчилгээг нэвтрүүлэх төсөл</b>
Байршил	Улаанбаатар
Хэрэгжүүлэгч	ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс сонгогдсон хэрэгжүүлэгч талууд болон мэдээллийн технологи дамжуулагчидтай хамтарч ажиллана.
Зорилго	<ol style="list-style-type: none"> <li>1) Яамны хүрээнд мэдээлэл, өгөгдлийн удирдлага, зохицуулалтын нэгдсэн платформ бий болгох;</li> <li>2) Салбарын 4,300 нэгж, байгууллага, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг үе шаттайгаар бүртгэх;</li> <li>3) ЭМЯ-ны харьяа бүх байгууллагуудыг шилжилтийн үед сүлжээнээс гадуур юм уу эсвэл PDF-ээр дамжин холбогдох төрөл бүрийн дэд системүүдтэй нэг платформд холбох;</li> <li>4) Өвчтөний талаарх мэдээллийн баазыг ашиглан өвчтөнтэй сүлжээгээр дамжуулан холбогдох, эмнэлэг рүү шилжүүлэх зарчим бүхий тухайн тохиолдол бүрийг зохицуулах системийг бүрдүүлэх.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Хүний нөөц, эд хөрөнгө, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, төсөв хөрөнгө оруулалт, тухайн тохиолдлын менежмент, өвчтөний эмчилгээ, лавлагаа зэрэг ЭМЯ-ны үйл ажиллагааны бүхий л чиглэлүүдийн талаарх мэдээллийг нэг платформоор дамжуулна. Эхний шатанд томхон газар нэгжүүдийг холбож, бусад нэгжүүдийг аажмаар хамрах болно.</li> <li>2) Эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн салбаруудад суурилуулсан бусад бүх мэдээллийн технологийн МТ системүүд шинэ системд шилжих үед интерфэйсээр холбогдох юм уу нэгтгэгдэнэ.</li> </ol>
Төслийн зардал	Тоног төхөөрөмж, байрны түрээс, ажилтнууд, тавилга, сургалт, тоног төхөөрөмж суурилуулах, турших, холбох зэрэгт: 10 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>2021 он: Зөвлөхүүдэд зориулсан ажлын гэрээний нөхцлийг тогтоох, ЭМЯ, түүнтэй дүйхүйц төрийн байгууллагуудад хэрэгжиж буй МТ-ийн төслүүдийг авч үзэх, хэрэгцээг тооцох, ажлын төлөвлөгөө, тендер, худалдан авалт</p> <p>2022 он: ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, сонгогдсон байгууллага, нэгжүүдэд туршилт, туршилтын суурилуулалт хийх, аймгуудтай холбох үе шат (1-р үе шат)</p> <p>2023 он: Аймгууд дахь бүх холбогдох нэгжүүдийг холбох (2-р үе шат)</p> <p>2024 он: Сүлжээг бүрэн дуусгах, үнэлгээ хийх, хянах</p>
Төслийн танилцуулга	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл Монгол Улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь ЭМЯ-ны харьяа 4,300 газар, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд болон бусад нэгжүүдийн үйл ажиллагааг нэгтгэх, зохион байгуулах зэрэг олон бэрхшээлтэй тулгарч байна. Олон жилийн туршид тодорхой салбар эсвэл чиглэлүүдэд МТ-ийн төрөл бүрийн системүүдийг ашиглаж байна. Дэлхийн банкны 19.5 сая төгрөгийн энэхүү төсөл нь цахим эрүүл мэндийн мэдээллийн технологийн ерөнхий дүр зургийг гаргахад туслах боловч зохицуулах төв функц дутагдаж байна. ЭМЯ, түүний харьяа газар, нэгжүүдэд МТ-ийн системд төвлөрсөн сүлжээнд холбогдох шаардлагатай 23,000 орчим хэрэглэгч (компьютер) байдаг.</li> </ol>

	<p>Мэдээллийн нэгдсэн платформ нь яам, түүний бодлогын газрын удирдлагуудад нийтийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, төсөв, хүний нөөц, өвчтөний түүх баримт бичиг, лавлах түүх, олон улсын туршлага стандартаас суралцах судалгаа шинжилгээний ажил зэрэг бүхий л үйл ажиллагааг хянах, удирдах боломжийг олгоно. Өвчтөний мэдээллийн менежментийн хувьд хувийн нууц, нууцлалын стандартыг баримтална. Монгол Улсын аймаг, сумдад өвчтөнүүдэд зориулсан интернет холболт харьцангуй сайн хөгжсөн байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Энэхүү төсөл нь ЭМЯ-нд хэрэгжиж буй бодлогын чанартай арга хэмжээнд үндэслэнэ. Үүнд: Эрүүл мэндийн салбарын стратегийн мастер төлөвлөгөө<sup>1</sup>, БНХАУ-ын санхүүжилттэй МТ-ийн (Ширээний компьютер суурилуулах), Дэлхийн банк, Люксембургийн санхүүжилттэй МСН болон зүрх судасны тасгууд дахь телемедицины төслүүд, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр аймаг, сумдад хэрэгжиж буй e-Эрүүл мэндийн санаачилга<sup>2</sup>, бусад төрлийн МТ-ийн платформууд.</p> <p><u>Ажлын дараалал:</u></p> <p>Байгаа мэдээ материалтай танилцах, Зөвлөхүүдийн ажлын гэрээний нөхцөлийг боловсруулах, ажилтнуудыг сонгох, үүрэг, хариуцлагын талаар зөвшилцөх.</p> <p>Тоног төхөөрөмж худалдан авах, хэрэгжүүлэгч байгууллага, зөвлөхүүдийг сонгох;</p> <p>Бодлогын төлөвлөлтийн газарт туршилтаар суурилуулах, яамны сонгогдсон газрууд болон эмнэлгүүдийн эхний хэсэгт сүлжээний холболт хийх;</p> <p>Нэгж, аймаг сумдыг холбох 2-р хэсгийн холболт;</p> <p>Төслийн дунд шатны үнэлгээ, зөвлөмж.</p> <p>Бүрэлдэхүүн:</p> <p>Эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах;</p> <p>Хэрэгцээг үнэлж, дүгнэх, ажлын төлөвлөгөө гаргах;</p> <p>МТ-ийн шийдэл, хэрэглэгчидтэй зөвшилцөх, худалдан авах ажиллагааны зохицуулалт;</p> <p>Хэрэглэх МТ-ийг худалдан авах, боловсруулах;</p> <p>ЭМЯ-ны ажилтнууд, түншүүд болон үйлчлүүлэгчдээс (ҮХГ, ЗГ г.м) бүрдсэн Зохицуулах хорооноос төслийн явцыг ТХҮЗ 2030-д хүрэх зорилттой уялдуулж хянах;</p> <p>Дэлхийн банк, ДЭМБ, АХБ зэрэг үйл ажиллагааны түншүүд/оролцогч талуудтай уялдуулах.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ЭМЯ нь төслийн хэрэгжилтэд оролцох төрийн байгууллага, мэдээлэл технологийн болон зөвлөх компаниудын ажлын даалгаврыг боловсруулна. Эдгээр байгууллагууд нь ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар аймгийн харьяа байгууллагуудтай холбогдох мэдээллийн сан бүхий мэдээллийн технологийн цогц системийг үе шаттайгаар хөгжүүлнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	
Тайлбар	

<sup>1</sup> Эрүүл мэндийн салбарын стратегийн мастер төлөвлөгөөг /2019- 2026 он/ Японы Ядуурлыг бууруулах Сангийн тусалцаатайгаар АХБ-ны мэргэжилтнүүдийн баг боловсруулсан болно.

<sup>2</sup> Гар утсаар группээр харилцах /чаатлах/ замаар эмнэлгийн зөвлөгөө өгөх.

Төслийн дугаар: II8

Төслийн нэр	<b>Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн цогц төсөл</b>
Байршил	Улаанбаатар
Хэрэгжүүлэгч	ХНХЯ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
Зорилго	<ol style="list-style-type: none"> <li>1) Тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж, тэтгэмж зэрэг нотолгоо, үнэлгээнд суурилсан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;</li> <li>2) Нарийвчилсан дүн шинжилгээнд үндэслэн нийгмийн даатгалаас ашиг хүртэгчдийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт, шинэчлэгдсэн тэтгэмжийн багц, сангийн менежментийг тодорхойлох;</li> <li>3) Төрийн байгууллагуудын вэбсайтууд болон бусад сувгуудаар нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн явцын талаар мэдээлэл хүргэх, хэлэлцэх замаар иж бүрэн, ил тод хяналтын системийг бий болгох.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Монгол Улсын нийгмийн даатгалын багцыг ‘хүртээмжтэй, тогтвортой, шударга’ (Мельбурн болон Мерсерийн Дэлхийн тэтгэврийн индекс) байдлын шалгуурууд эсвэл Монгол Улсын хэрэглэгчид, тодруулбал 18-40 насны залуучууд хэлэлцэж дэмжсэн ижил төстэй олон улсын стандартад нийцүүлэх;</li> <li>2) Ажилгүйдэл, өндөр насны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг багтаасан, хоорондын уялдаа холбоо, логикийг сайжруулж амьжиргааны өртөг, хүн ам зүйн нөхцөл байдалд нийцүүлсэн нийгмийн даатгалын тогтолцооны бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх;</li> <li>3) Малчид зэрэг албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах;</li> <li>4) Нийгмийн даатгалын тогтолцоог тогтвортой хадгалахын тулд ирээдүйн ажиллах хүчнийг оролцуулан үе үеийнхний оролцоог өргөн хүрээнд хамруулан нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн талаар харилцан зөвшилцөлд хүрэх;</li> <li>5) Өсөлт, орлогоор дамжуулан нийгмийн даатгалын төлбөр төлөлтийг тогтвортой хадгалах бие даасан сангийн менежмент зэргийг хэрэгжүүлэх замаар тэтгэврийн санг бүрдүүлэх тогтсон мөчлөгийг нэвтрүүлэх.</li> </ol>
Төслийн зардал	6 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p><u>I үе шат. 2021-2022</u></p> <p>Одоогийн нийгмийн даатгалын тогтолцооны сул талуудыг нягтлан судалж, тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийнэ; Тэтгэврийн шинэчлэл хийж буй орнуудын туршлагыг судална; Тэтгэврийн сангийн бүтцийг судалж, үнэлэх мэргэжилтнүүдийн зөвлөл байгуулна; Сонгон шалгаруулах шалгуур, үнэлгээний тогтолцоог үнэлж дүгнэнэ; Шинэчлэлийн эхний саналыг мэргэжилтнүүдээр тодорхойлуулна; Ажлын хэсгийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулна.</p> <p>*Төсвийн задаргаа: Зөвлөхүүд: 1 сая ам.доллар, Замын зардал: 250,000 ам.доллар, Тоног төхөөрөмж: 500,000 ам.доллар, Харилцаа, холбоо: 250,000 ам.доллар, Сургалт, семинар: 250,000 ам.доллар, ХНХЯ-ны зарим тайлангуудын орчуулга: 100,000 ам.доллар.</p> <p><u>II үе шат. 2022-2023</u></p>

	<p>Дунд хугацааны үнэлгээ хийж, шинэчлэгдсэн загваруудыг туршилтаар хэрэгжүүлнэ; Мэргэжилтнүүдийн баг боловсруулсан төгсгөлийн тайлангаа ХНХЯ-нд танилцуулна. <u>III үе шат. 2024</u> Шаардлагатай тохируулгуудыг хийж хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулна.</p>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Одоогийн байдлаар Монгол Улсад нийгмийн даатгалын цогц тогтолцоог ХНХЯ-ны харьяа дөрвөн агентлагаар дамжуулан хэрэгжүүлж байна (Эрүүл мэндийн даатгалыг Эрүүл мэндийн яам хариуцаж байна). Нийгмийн даатгалын сан дараах даатгалаас бүрддэг. Үүнд: Тэтгэврийн даатгал, Тэтгэмжийн даатгал, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, ажилгүйдлийн даатгал.</p> <p>Олон жилийн турш хэрэгжиж буй нийгмийн даатгалын тогтолцоо нь, тэр дундаа тэтгэвэр, тэтгэмжийн даатгал хоорондоо давхардал үүсгэх болж хуучирсан байна. Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжсэн хэдий ч тэтгэврийн тогтолцоо нь хуучин тогтолцооны үеийнхээс өөрчлөгдөөгүй. Энэхүү тогтолцоонд Монгол Улсын хүн ам зүйн суваргыг анхааран авч үзээгүй ба ирээдүйд Монгол Улсын хүн амыг бүрдүүлэх өндөр настнуудад ашигтай бус байна. Үнэлгээнээс үзэхэд өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоо нь дараах сул талуудтай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн дутуу санхүүжилт олон жилийн турш үргэлжилсэн;</li> <li>- Амжиргааны бодит өртөг болон тэтгэвэр, тэтгэмж хүртэгчдийн орлогыг харгалзан үзэж тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээнд өөрчлөлт оруулаагүй;</li> <li>- Өндөр насны тэтгэвэр болон бусад тэтгэмжийн хоорондох давхардал үүсдэг;</li> <li>- Малчид зэрэг албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд бүрэн хамруулдаггүй;</li> <li>- Өсөлт, орлого бүрдүүлдэггүй, тэтгэвэр, тэтгэмж хүртэгчдийн дунд цаашдын хуваарилалтын тогтвортой байдлыг хангаагүй зэргээр даатгалын сангийн үр ашиггүй менежмент зонхилж байна.</li> </ul> <p>ЖАЙКА-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл (2016 - 2020 он)” нь ХНХЯ-наас нийгмийн даатгалын ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулахад, гарын авлага, удирдамж боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн уг төсөл нь нийгмийн даатгалын тухай ойлголтыг их, дээд сургууль, дунд сургуулийн сурагчид болон олон нийтэд түгээх зорилгоор олон нийтийг хамруулсан хөтөлбөр хэрэгжүүлсэн. Үүнээс гадна нүүдэлчин малчдын гэр бүл болон албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын санд хамруулахыг дэмжиж, бүртгэлийн системийг шинэчилсэн.</p> <p>2015 онд Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг (2015-2030) баталж, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. 2021 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны<sup>3</sup> вэбсайтад тус яам нь УИХ-ын 2021 оны хаврын чуулганд төрөөс баримтлах бодлогын хүрээнд нийгмийн даатгалын тухай багц хуулийн төслийг өргөн барихаар төлөвлөж байгааг дурджээ. Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлээс дурдвал:</p>

<sup>3</sup> ХНХ-ын сайд А. Ариунзаяа



	<ul style="list-style-type: none"><li>- Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлнэ (1-р давхарга-суурь тэтгэвэр, 2-р давхарга-шимтгэлд суурилсан тэтгэврийн даатгал, 3-р давхарга-хувийн тэтгэврийн нэмэлт даатгал),</li><li>- Нийгмийн даатгалын засаглал, хөрөнгө оруулалтын тогтолцоог сайжруулна</li><li>- Ажил олгогч, даатгуулагч болон улсын төсөвт ээлтэй шимтгэлийн тогтолцоотой болно</li><li>- Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулна</li><li>- Тэтгэвэр өвлөгдөнө</li><li>- Тэтгэмжийг нэг сангаас олгоно</li><li>- Хүн бүрийг нийгмийн даатгалд хамруулна.</li></ul> <p>Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулж хувийн хэвшлийн оролцоо, менежментийг хэрэгжүүлнэ. Тус хуулийн төсөл нь 2020 оны 10 дугаар сард УИХ-ын чуулганы хэлэлцүүлгээр дэмжигдээгүй. Хувийн тэтгэврийн тогтолцооны талаарх асуудлыг 6 дугаар сард дахин хэлэлцэх магадлалтай<sup>4</sup>. Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийг батлуулахаар АРД санхүүгийн нэгдэл лобидож байгаа тухай мэдээлэл байна. 3 дугаар сарын эхээр Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-ын даргад өргөн барьсан. Энэхүү хуулийн төслийг УИХ-аар хараахан хэлэлцээгүй байна.</p> <p>Энэхүү төсөл нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын<sup>5</sup> зорилтыг хангахад хувь нэмэр оруулна. Санал болгож буй төслийг ажилтнууд болон ард иргэдийн хуримтлуулсан туршлага, олон нийтэд хандсан хөтөлбөрөөр дамжуулан нийгмийн даатгалын талаар олж авсан ойлголт, мэдлэгт үндэслэн хэрэгжүүлнэ. Монгол Улсын ард иргэд ялангуяа залуучуудын тэтгэврийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн. Ажиллах хүчний нөөцийг бүрдүүлэхтэй холбоотойгоор тэтгэврийн шинэчлэлийн талаар өөрсдийн дуу хоолойг өргөсөөр байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлсон болно. Мөн саяхан хэрэгжиж дууссан ЖАЙКА-гийн төсөлтэй харилцан уялдуулах шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"><li>- ХНХЯ болон харъяа агентлагуудын хийсэн судалгааг англи хэл рүү орчуулах<sup>6</sup>;</li><li>- Мэргэжилтнүүдийн багаар үнэлгээ хийлгэх;</li><li>- Дотоодын болон олон улсын мэргэжилтнүүд, хувийн хэвшлийн төлөөлөгчдийг багтаасан Нийгмийн даатгалын шинэчлэлийн зөвлөлийг байгуулах;</li><li>- Дэлхийн банкны дэмжлэгийн үр дүнг харгалзан үзэж тэтгэврийн тогтолцооны шинэчлэл болон бусад улс орнуудын туршлагыг харьцуулсан судалгаа хийх;</li><li>- Туршлага судлах аяллууд зохион байгуулах;</li><li>- Тэтгэвэр, тэтгэмж хүртэгчдийн одоогийн шалгуур үзүүлэлт, судалгаа, хорооны үүргийг нягтлан дүгнэх;</li><li>- Олон нийт, оролцогч талууд, хэрэглэгчид, нийгмийн даатгалын механизмыг хэрэгжүүлэгчдийг хамруулан зөвлөлдөж шинэчлэлийн загварыг боловсруулах;</li><li>- Шинэчлэл хийх саналыг ХНХЯ-д танилцуулах.</li></ul>
--	---

<sup>4</sup> Хууль санаачлагч УИХ-ын гишүүн Н.Учрал хүндээр өвчилсөн.

<sup>5</sup> Холбогдох хэсгийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

<sup>6</sup> Судалгааны бүрэн жагсаалтыг Хавсралт II-д тусгасан болно.

	3) Хэрэгжилт Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн төслийн хэрэгжилтийг үйл ажиллагааны төлөвлөгөө, хуваарийн дагуу ХНХЯ удирдан, зохион байгуулна. ХНХЯ нь мэргэжилтнүүдийн багийг зохион байгуулан, Зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Тодорхой нөлөө үзүүлэхгүй.
Тайлбар	

**Төслийн дугаар: II9.1**

Төслийн нэр	<b>Бүлгийн динамикийн төв байгуулах төсөл*</b>
Байршил	Улаанбаатар
Хэрэгжүүлэгч	Монголын бүтээмжийн төвийн (МБТ) дэмжлэгтэйгээр шинээр байгуулагдсан Бүлгийн динамикийн төвийг бүх яамд, өөрийн гишүүн болох Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ) зэрэг дэмжигч бизнес түншүүдийн хамт хэрэгжүүлнэ.
Зорилго	Эцсийн зорилго нь Япон, Сингапур зэрэг улсуудын амжилттай туршлагад үндэслэн "цомхон бүтэцтэй багийн үйл ажиллагаа"-гаар дамжуулан яамд, бусад байгууллагууд, төр болон хувийн хэвшлийн менежментэд бизнесийн динамик соёлыг өргөжүүлэн түгээх явдал юм.
Хүлээгдэж буй үр дүн	Сар бүр Кайзен (үр ашигтай) ба Кензен (ёс зүй) сургалт-уулзалт зохион байгуулснаар байгууллагууд төслийн ерөнхий гүйцэтгэлийн хувьд өндөр бүтээмжтэй, ажилдаа илүү өөриймсөг, үнэнч ханддаг ажилтнуудтай болно.
Төслийн зардал	3 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2022 он: Төсөл боловсруулах 2022-2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2024 оноос: Төсөл бүрэн хэрэгжих
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Монгол Улс нь тухайн үедээ харилцаа холбоо, хэвлэмэл мөнгө, дэвшилтэт зэвсэг бүхий хүчирхэг тогтолцоотой, дэлхийн хамгийн том эзэнт гүрний нэг байв. Гэсэн хэдий ч уламжлалт нүүдлийн соёл, богино хугацаанд их ашиг олохыг хичээдэг, бизнесийн хэлэлцээрт өнөөг хүртэл буулт хийж суралцаагүй байдал зэрэг нь гадаадын боломжит түншүүдийг тодорхой цаг хугацааны дараа өөрийн эрхгүй хүндрэл бэрхшээлээс зугтан зайгаа барихад хүргэж байна. Гадаадын түншүүдийн технологи, менежментийн ноу-хау, гадаад зах зээл зэрэг сайн боломжуудыг Монгол Улсын эдийн засагт үр дүнтэй ашиглах боломж олгох бизнесийн шинэ соёлыг бүрдүүлэн түгээх хэрэгцээ шаардлага тулгамдаад байна. 2) Төслийн бүрэлдэхүүн Сургалт зохион байгуулах, бизнесийн шинэ соёлыг түгээх зорилго бүхий "Бүлгийн динамикийн төв"-ийг удаан хугацаагаар ажиллуулах. а) Шинэ байгууллага байгуулах: Яамд, МҮХАҮТ, МБТ, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний болон бусад мэргэжлийн байгууллагууд хооронд зохицуулж, зөвшилцсөний дагуу Ерөнхий сайдын Ажлын албаны дэргэд Бүлгийн динамик төвийг байгуулах;

	<p>b) Кайзен ба Кензен, 5S, үнэ цэнэ дээр суурилсан цалин хөлсний систем, гадаад түншүүдтэй гэрээ хийх зэрэг Японы сайн туршлагын талаар үндсэн мэргэжилтнүүдийн явуулах сургалтын гарын авлага боловсруулах. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, байгууллагын төлөв байдал, маркетинг, санхүү, үйлдвэрлэл зэрэг сэдвээр “цомхон бүтэцтэй уулзалтууд” зохион байгуулах;</p> <p>c) Бүлгийн динамикийг өргөжүүлэх зорилгоор “цомхон бүтэцтэй бүлгүүд”-ийн бүртгэлийн систем бий болгох;</p> <p>d) Амжилттай туршлагыг гадаадад болон дотооддоо нэвтрүүлэх, сурталчлах зорилгоор мэдээллийн товхимол, сар тутмын бизнесийн сэтгүүл гаргах;</p> <p>e) Зохион байгуулалтын болон удирдлагын чиглэлээр амжилт гаргасан төр болон хувийн хэвшлийн байгууллагуудыг урамшуулах зорилгоор Бүлгийн динамик, Кайзен ба Кензен гэх мэт үндэсний хөдөлгөөн мөн шагналын систем бий болгох.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Улсын хэмжээгээр бүх байгууллагуудад нүүдлийн соёлыг өрсөлдөх чадвартай бизнесийн соёл болгон шинэчлэн сайжруулах үүрэгтэй "Бүлгийн динамик төв"-ийг байгуулах, хөгжүүлэх, үйл ажиллагааг нь хянах, зохицуулах үүргийг Ерөнхий сайдын Ажлын алба Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний дагуу гүйцэтгэнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Төсөл хэрэгжүүлэх хурдыг хоёр дахин нэмэгдүүлэх зэргээр нийгэмд дорвитой эерэг нөлөө бий болгох; Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-ний түвшин Ирланд, Скандинавын орнуудтай дүйцэхүйц хэмжээний өндөр түвшинд хүрэх боломжтойг удирдан манлайлах түвшний хүмүүс олж харна.
Тайлбар	

**Төслийн дугаар: II9.2**

Төслийн нэр	<b>Гүйцэтгэлийг үр дүнтэй болгоход чиглэсэн үйл ажиллагааны зөвлөгөө өгөх хөтөлбөр</b>
Байршил	Улаанбаатар
Хэрэгжүүлэгч	Бүлгийн динамикийн төв (байгуулна)
Зорилго	Эцсийн зорилго нь Монгол Улсын тогтвортой хөгжилд зориулж сонгосон төслүүдийн хэрэгжилтийг зөвлөхүүдийн оролцоотойгоор "бодит үр дүн"-д хүргэнэ. Зөвлөх үйлчилгээ нь олон нийтийн оролцоо бүхий зөв бодлогод үндэслэсэн зохих шийдвэр гаргах шаардлагатай болдог агаарын бохирдол, бохир ус, замын хөдөлгөөний түгжрэл, аялал жуулчлал, үйлдвэрлэлийн хөгжил зэрэгт чиглэгдэнэ.
Хүлээгдэж буй үр дүн	Үйл ажиллагааны зөвлөгөө өгөх үйлчилгээний тусламжтайгаар шинэ сорилт бэрхшээлийг давах ба бизнесийн амжилт эрс сайжирч, иргэдэд хүрэх ашиг тус урт хугацааны туршид нэмэгдэх болно
Төслийн зардал	3 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2022 он: Төсөл боловсруулах 2022-2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2024 оноос: Төсөл бүрэн хэрэгжих
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Монгол Улсын эдийн засгийн хөгжилд тустай олон төслүүдийг гадаадын бизнесийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэхээр хэлэлцэж, энэ тал дээр эхний алхмууд хийгдэж эхэлдэг боловч бизнесийн

	<p>соёлын ялгаанаас болж ихэнх нь нэг, хоёр жилийн хугацаанд бүтэлгүйдэг. Гэхдээ сайн бодож төлөвлөсөн менежментийн бодлого, зохих дэмжлэгтэйгээр төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой. Ер нь ЖАЙКА-гийн төсөл хэрэгжүүлэх хугацааны 70-80%-ийг судалгаа, тайлан боловсруулахад, үлдсэнийг нь зохицуулалт, хурал уулзалтад зарцуулж байна. Гэхдээ, Монголд тулгарч буй бэрхшээлүүд нь дүн шинжилгээ хийх, төлөвлөхөөс илүүтэй шийдвэр гаргах, хэрэгжүүлэх шатанд учирч байна. Зөвлөгөө өгөх үйл явц нь Засгийн газар болон холбогдох компаниудын хоорондох гуравдагч тал болох зөвлөхүүдийн зохих оролцоонд суурилах замаар хэрэгжүүлэх шатанд тулгарч буй бэрхшээлийг арилгах болно.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Амжилтын түвшинг дээшлүүлэх зорилгоор “Үйл явцын зөвлөгөө” үзүүлнэ:</p> <p>a) Шинэ бүтцэд тулгуурлах: Ерөнхий сайдын Ажлын албаны дэргэдэх Бүлгийн Динамик Төв нь менежментийн зөвлөхүүдийг жилд 60-90 хүн-өдрөөр, хэд хэдэн удаа Монголд ирж үйл явцын зөвлөгөө өгөх зорилгоор ажиллуулдаг. Холбогдох бизнесийн чиглэлээр зөвлөгөө, зохицуулалт хийх зорилгоор нийт хүн-өдрийн гуравны нэгийг Японд гүйцэтгэх ажилд зарцуулахыг зөвшөөрнө;</p> <p>b) Зөвлөхүүд бичиг цаас үйлдвэрлэх бус харин ярилцлага, зохицуулалтаар дамжуулан хөндлөнгийн оролцоог хангах бөгөөд ингэснээр төлөвлөсөн зөвлөгөө өгөх жил дуусахаас өмнө “бодит үр дүн”-д хүрэх боломжтой болно;</p> <p>c) Зөвлөхүүд томилолтоор ажилласны дараа ЖАЙКА болон холбогдох талуудад 5 хуудас тайланг гаргаж өгөх ёстой (эхлэл хэсэг - 1 хуудас + хийсэн арга хэмжээ - 3 хуудас, авах арга хэмжээний төлөвлөгөө - 1 хуудас);</p> <p>d) Зөвлөхүүд томилолтоор ажиллах бүрдээ холбогдох талууд шийдлийг хэрэгжүүлж чадна гэдгийг үнэмшүүлэх 1-2 хуудас бүхий санамж бичиг боловсруулж тараах ёстой;</p> <p>e) Зөвлөх хоёр удаа ирж ажилласны дараа үйлчлүүлэгчийн зүгээс таагүй хариу ирэх тохиолдолд зөвлөх үйлчилгээг зогсоож болно.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Ерөнхий сайдын дэргэдэх Ажлын албанаас холбогдох бүх төслүүдийг "бодит үр дүнд хүрэх" зорилгоор "үйл ажиллагааны зөвлөгөө" өгөхтэй холбогдсон ажлуудыг төлөвлөх, хөгжүүлэх, хянах үйл ажиллагааг зохицуулах үүрэг гүйцэтгэнэ.</p>
<p>Байгаль орчин, нийгмийн нөлөө</p>	<p>Нийгэмд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Цаг тухайд нь зохих шийдвэр гаргах шаардлагатай болдог агаарын бохирдол, бохир ус цэвэрлэх, замын хөдөлгөөний түгжрэл, аялал жуулчлал, аж үйлдвэрийн хөгжил зэрэг удаан хугацаанд үргэлжилж буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн зүй зохистой арга хэмжээ авч чадахуйц эдийн засгийн хөгжлийн боломжууд байна гэдгийг Монгол Улс харах болно.</p>
<p>Тайлбар</p>	

Төслийн дугаар: II10.1

Нэр	<b>МХХТ-д суурилан боловсролын салбарыг бэхжүүлэх төсөл</b>
Байршил	Бүх аймгууд
Хэрэгжүүлэгч агентлаг	БШУЯ, Аймгийн ЗДТГ, ХХМТГ, ҮХГ
Зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>1) Иргэдийг цахим сургалтанд хамруулан уншиж, бичиж сургах;</li> <li>2) Цахим сургалтаар дамжуулан хөдөө, орон нутгийн багш нарын МХХТ-ийн чадамжийг сайжруулах;</li> <li>3) Сургуулийн орчны хүчирхийллийг судалж, тэдгээрийг мэдээлэх, бүртгэх мэдээллийн системийг хөгжүүлэх, турших.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Бүрэлдэхүүн хэсэг 1: Бичиг үсэгт тайлагдаагүй сургууль завсардсан хүүхэд, залуучууд болон насанд хүрэгчдийн тоог бууруулж, тэднийг бие даан хувийн хэвшлийн болон төрийн үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ. Цаашид бүх шатны боловсролын байгууллагуудад дахин ашиглах боломжтой загвар, аргачлалыг боловсруулна.</li> <li>2) Бүрэлдэхүүн хэсэг 2: Хөдөө, орон нутгийн багш нарын МХХТ-ийн чадамжийг сайжруулснаар багш нарыг чадавхжуулж, сургалтад МХХТ-ийг ашиглах чадварыг дээшлүүлнэ. Түүнчлэн сургалтын үйл ажиллагаанд МХХТ-ийг ашигласнаар хөдөө, орон нутгийн сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэх, багшийг чадавхжуулах давуу талтай. Цаашид багш нарыг зайаас сургах болон МХХТ-ийн чадамжийг сайжруулах сургалтад дахин ашиглах боломжтой загвар, аргачлалыг боловсруулна.</li> <li>3) Бүрэлдэхүүн хэсэг 3: Програм хангамж / платформ хөгжүүлж, туршсанаар хүчирхийллийн талаарх тоо баримт, мэдээлэл цуглуулах, сургуулийн орчны хүчирхийллийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ. Програм хангамж/платформыг ашиглан сургуулийн орчны хүчирхийллийн талаарх мэдээллийг гар утаснаас илгээх/хүлээн авах, бүртгэх, дамжуулах боломжтой.</li> </ol>
Төслийн өртөг	0.5 сая ам. доллар
Хэрэгжүүлэх хуваарь	<ul style="list-style-type: none"> <li>- Төсөл боловсруулах: 2021-2022</li> <li>- Төсөл бүрэн хэрэгжих: 2022~2023</li> </ul>
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>Энэхүү төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 1: Монгол Улсад сургууль завсардсан хүүхэд залуучууд төдийгүй насанд хүрэгчдийн дунд уншиж, бичиж чаддаггүй хүн олон байдаг. Үүнд шоронгийн хүмүүжигчид, цэрэгт явсан залуучууд, малчид багтаж байна. Тэд уншиж, бичиж чадахгүйн улмаас хувийн хэвшлийн болон төрийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүйд хүрдэг. Сургалтыг гар утас, планшетаар цахимаар зохион байгуулах бөгөөд ҮХЦТ-ний хүрээнд хэрэгжүүлсэн туршилтын төслийн үр дүн, туршлага, технологийг ашиглана.</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 2: Багш нарын мэдлэг, ур чадвар ялангуяа МХХТ-ийн чадамж нь МХХТ-ийг сургалтад хэрэглэх, сургалтын чанарыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.</p> <p>МХХТ нь асар хурдацтай хөгжиж буй өнөө үед багш нарын МХХТ-ийн чадамжийг тасралтгүй дээшлүүлэх шаардлагатай байна. Багш нарт зориулсан сургалт нь модульчлагдсан сургалт байх бөгөөд төсөл</p>

	<p>хэрэгжиж дууссаны дараа түүнийг ашиглах боломжтой. Сургалтын модульд компьютертай ажиллах, цахим сургалтын материал, контент боловсруулах, интернет ашиглах зэрэг асуудлууд хамрагдана.</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 3: Сургуулийн орчинд сурагчид болон багш нарын дунд хүүхдийг хүчирхийлэх, дээрэлхэх явдал ихээхэн тохиолддог. Тиймээс судалгаанд үндэслэн хүчирхийллийн талаарх мэдээллийг гар утаснаас хурдан бөгөөд хялбархан илгээх/хүлээн авах, бүртгэх, дамжуулах програм хангамж/платформыг боловсруулж, турших боломжтой юм. Тус платформ нь хүчирхийллийн түвшинг тодорхойлж, багш, эцэг, эх, сургуулийн удирдлага зэрэг хамаарал бүхий этгээдэд мэдэгдэл илгээх бөгөөд тодорхой шалгуурт үндэслэсэн мэдээллийг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд шууд дамжуулнах боломжтой.</p> <p>2) Хэрэгжүүлэх арга хэмжээ Эхний ээлжинд МХХТ-т суурилсан системийг ухаалаг гар утас, таблетыг ашиглаж мэдээлэл солилцох прототайп систем байдлаар хөгжүүлж, сонгогдсон аймагт туршилтаар хэрэгжүүлнэ. Тухайн өгөгдөл мэдээ нь статистикийн мэдээллийг баяжуулж, аймгийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой боловсруулахад хувь нэмэр оруулна. Энэ нь аймгийн засаг захиргаа, иргэд, багш нарын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх эхний алхам болох юм.</p> <p>Аймаг, орон нутгийн засаг захиргааг оршин суугчид, олон нийттэй харилцаа холбооны сүлжээгээр холбосноор талуудын чадавхыг бэхжүүлж, харилцан итгэлцэл, хариуцлагыг сайжруулна. Үүнийг нийгмийн инноваци хэмээн нэрлэдэг. Монгол Улс нь хөгжиж буй бусад орнуудтай харьцуулахад үүрэн холбооны үйлчилгээний хүртээмж, интернетийн нэвтрэлтийн түвшингийн хувьд давуу талтай. Тиймээс Монгол Улс энэ чиглэлээр МХХТ-ийг нэвтрүүлэх, ашиглах бүрэн боломжтой юм.</p> <p>3) Хэрэгжилтийн зохицуулалт БШУЯ, Аймгийн ЗДТГ, ХХМТГ хамтран ажиллаж, төслийг хэрэгжүүлэх бөгөөд ҮХГ удирдан зохион байгуулна</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Нийгэмд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	Төслийг хэрэгжүүлсний дараа Боловсрол, шинжлэх ухааны яам болон бүх шатны боловсролын сургалтын байгууллагууд төслийн хүрээнд боловсруулсан аргачлал, загвар, програм хангамжийг ашиглах боломжтой.

Төслийн дугаар: II10.2

Нэр	<b>Хөдөө, орон нутагт МХХТ-ийг хөгжүүлэх, МХХТ-т суурилсан загвар хотыг хөгжүүлэх</b>
Байршил	Дархан, Цэцэрлэг хот
Хэрэгжүүлэгч агентлаг	ХХМТГ, Мэдээлэл технологийн үндэсний парк (МТҮП)
Зорилтууд	Төсөл нь аймгуудад МХХТ-ийг хөгжүүлэх болон МХХТ-т суурилсан үйлдвэрлэлийн кластерын хөгжлийг удирдан чиглүүлэх загвар хотыг байгуулах зорилготой. Зорилтууд:

	<ol style="list-style-type: none"> <li>1) МХХТ-ийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор мэдээллийн технологи, МХХТ-ийн салбарын инженерүүдийг сургах;</li> <li>2) Гарааны бизнес эрхлэгчид зэрэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын шинэ програм хөгжүүлэлтийг дэмжих;</li> <li>3) Аймгуудад МХХТ-т суурилсан үйлдвэрлэлийн кластер байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Мэдээллийн тэгш байдлыг хангах, МХХТ-ийг ашиглан иргэд мэдээлэл цуглуулах зэргээр хүртээмжтэй хөгжилд хувь нэмэр оруулах;</li> <li>2) Аймгуудад МХХТ-т суурилсан үйлдвэрлэлийн кластер байгуулах;</li> <li>3) Хөдөө, орон нутагт МХХТ-ийн салбартай холбоотой үйлдвэрлэлийг хөгжүүлэх;</li> <li>4) Монгол Улсын Засгийн газраас хөхүүлэн дэмжиж буй дижитал нийгмийг хөгжүүлнэ.</li> </ol>
Төслийн өртөг	1.0 сая ам. доллар
Хэрэгжүүлэх хуваарь	<ul style="list-style-type: none"> <li>- Төсөл боловсруулах: 2021-2022</li> <li>- Төсөл бүрэн хэрэгжих: 2023-2024</li> </ul>
Төслийн тодорхойлолт	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл Улаанбаатар хот төдийгүй Монгол Улсын хувьд хүртээмжтэй хөгжлийн асуудал нэн чухлаар тавигдаж байна. Энэ нь МХХТ-ийн хөгжил, хүртээмж, хэрэглээтэй нягт холбоотой юм. МХХТ-ийг хөгжүүлэх, МХХТ-ийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх чадвартай хотыг тодорхойлсноор МХХТ-т суурилсан үйлдвэрлэлийн кластерыг байгуулж, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэнэ. МХХТ-ийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан загвар хотыг байгуулах боломжтой. ЖАЙКА-гийн Төслийн баг Архангай аймгийн Цэцэрлэг хот, Дархан-Уул аймгийн Дархан хотыг загвар хотоор сонгосон. Эдгээр аймгуудын хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн потенциалыг харгалзан мал аж ахуй, газар тариалан эрхлэлтэд МХХТ-ийг ашиглах нь ирээдүйтэй юм.</li> <li>2) Сонгогдсон аймаг, хот <ul style="list-style-type: none"> <li>• Дархан-Уул аймаг нь 32,750 км<sup>2</sup> газар нутагтай. Аймгийн нийт газар нутгийн 70%-ийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар эзэлдэг. Аймаг нь байгалийн баялаг, ашигт малтмалын орд газруудтайгаас гадна ургамал, ан амьтнаар элбэг. Аймгийн нийт хүн амын 64.5%-ийг 35-аас доош насны залуучууд, хүүхдүүд эзэлдэг. Дархан хот нь Монгол Улсын томоохон аж үйлдвэрийн төв бөгөөд ялангуяа барилгын материалын үйлдвэрлэлийн бааз болж байгуулагдсан. Дархан хот Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн олон улсын авто замын дагуу Улаанбаатар-Сүхбаатарын төмөр замын зангилаан дээр оршдог бөгөөд төвийн эрчим хүчний системд холбогдсон, өндөр хурдны шилэн кабель, дижитал радио релейны шугам, хөдөлгөөнт холбооны үйлчилгээтэй дэд бүтэц хөгжсөн Монгол Улсын томоохон аж үйлдвэрийн төв юм.</li> <li>• Цэцэрлэг хот нь Архангай аймгийн төв юм. Архангай аймаг нь 55,300 км<sup>2</sup> газар нутагтай. Аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбар гол байр суурь эзэлдэг. Аймгийн нийт газар нутгийн 70%-</li> </ul> </li> </ol>

	ийг бэлчээрийн газар эзэлдэг. 3) Хэрэгжүүлэх арга хэмжээ ЖАЙКА-гийн Төслийн баг Төслийн дижитал шилжилт, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын тайланд загвар аймаг, хот байгуулахыг санал болгосон. Энэхүү саналд үндэслэн зарим төсөл, хөтөлбөрийг цаг алдалгүй хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энхий ээлжинд МХХТ-ийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх шаардлагатай. Одоогийн байдлаар мэдээллийн технологийн инженерүүд, програм хөгжүүлэгчид ихэвчлэн Улаанбаатар хотод ажиллаж байгаа бөгөөд улс даяар МХХТ-ийн салбарын тэнцвэртэй хөгжлийг хангах шаардлагатай байна. Мөн МХХТ-ийн салбарыг хөгжүүлэхийн тулд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд харилцан бие биенээ дэмжих үзэл баримтлалд үндэслэн зохион байгуулалттайгаар, системтэйгээр хамтран ажиллах шаардлагатай. Төрийн зүгээс нь МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх, олон нийт, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллага, аж үйлдвэрийн салбарын дунд гарааны бизнесийг дэмжих, корпорацийн тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллана. Нөгөөтэйгүүр хувийн хэвшил нь инженер/хөгжүүлэгч зэрэг хүний нөөц болон өндөр чанартай програм хангамжийг хөгжүүлж, програм хангамжийн аутсорсингийг дэмжих төслүүдийг урагшлуулах хэрэгтэй. ЖДҮ-ийг оролцуулан МХХТ-ийн үйлдвэрлэлийг хэвтээ байдлаар хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд сууриар нь сайжруулах болно. 4) Хэрэгжилтийн зохицуулалт Төслийг ХХМТГ болон МТҮП хамтран хэрэгжүүлнэ.
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Нийгэмд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	Төслийн аргачлал, загвар, үр дүнг цаашид бусад хотыг хөгжүүлэх загвар болгон ашиглах боломжтой.

Төслийн дугаар: II10.3

Төслийн нэр	<b>Хөдөө, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах төсөл</b>
Байршил	1-р үе шат: Улаанбаатар хот, Булган аймаг 2-р үе шат: Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч байгууллага	ҮХГ, орон нутгийн удирдлага, Үндэсний дата төв, ХНХЯ, ЭМЯ, Онцгой байдлын ерөнхий газар, Ус, цаг уур орчны шинжилгээний газар зэрэг яам, агентлаг, хувийн хэвшил
Зорилтууд	1) Малчид болон нутгийн захиргааны байгууллагуудын хооронд мал аж ахуйтай холбоотой мэдээ мэдээллээр (цаг агаарын мэдээг оролцуулан) хангах; 2) Малчдын ахуй амьдралыг дэмжих, бодит орлогыг нэмэгдүүлэх; 3) Мал аж ахуйн салбарын цаашдын хөгжилд МХХТ-ийн платформыг нэвтрүүлэх замаар салбарын хуваарилалтыг оновчтой болгох; 4) Орон нутгийн захиргааны байгууллагын тоон технологийн чадавхыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Малчдын хэрэгцээ шаардлагыг авч үздэг хариуцлагатай нутгийн захиргааны байгууллага;



	<p>2) Ус, тэжээлийн хүртээмж, цаг уурын мэдээлэлд суурилсан мал аж ахуйн салбар;</p> <p>3) Мал аж ахуйн зах зээл дэх малчдын оролцоо, чадавх нэмэгдэх;</p> <p>4) Орон нутгийн захиргааны байгууллагын чадавх нэмэгдэх.</p>
Төслийн өртөг	
Хэрэгжүүлэх хуваарь	<p><u>1-р үе шат: 2021-22 (9 сар)</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн мэдээллийн платформын шаардлагын тодорхойлолтыг боловсруулах <ul style="list-style-type: none"> <li>✓ Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалт, түгээлтийн судалгааг хийх;</li> <li>✓ Яамд/агентлагтай хамтын ажиллагааг зохион байгуулах;</li> <li>✓ Дата сервер байгуулах, сервер болон системийг холбох.</li> </ul> </li> <li>- Булган аймагт хэрэгжүүлэх концепцийг эцэслэх <ul style="list-style-type: none"> <li>✓ Системийн администратор, хэрэглэгчдэд зориулсан Орон нутгийн мэдээллийн платформын удирдамж боловсруулж, орон нутгийн удирдлага, малчид, борлуулагчдад зориулж сургалт зохион байгуулах;</li> <li>✓ Орон нутгийн захиргааны байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулах;</li> <li>✓ Логистикийн хаб байгуулах газрыг сонгох;</li> <li>✓ Орон нутгийн мэдээллийн платформын үйл ажиллагааг турших.</li> </ul> </li> </ul> <p><u>2-р үе шат: 2022-23 (12 сар)</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн мэдээллийн платформыг бүх аймагт өргөжүүлэн хэрэгжүүлэх <ul style="list-style-type: none"> <li>✓ Орон нутгийн удирдлага, малчид, борлуулагчдад сургалт зохион байгуулах;</li> <li>✓ Орон нутгийн захиргааны байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулах;</li> <li>✓ Логистикийн хаб байгуулах газрыг сонгох.</li> </ul> </li> </ul>
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол Улсад малчид өргөн уудам газар нутагтаа тархан нүүдэллэж, суурьшдаг тул тэдэнд зах зээл болон эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн мэдээлэл авах боломж хомс байдаг. Энэ нь тэдний бизнес эрхлэх боломж, ченжүүдтэй үнэ тохиролцох, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахад хүндрэл учруулдаг. Түүнчлэн малчид төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон тэдгээрийн тухай мэдээллийг бүрэн авч чаддаггүй бөгөөд энэ байдал нь хот, суурин газрын иргэд оршин суугчидтай харьцуулахад хангалтгүй байдаг. Цаашид энэ бэрхшээлийг даван туулахын тулд мэдээлэл, харилцаа холбооны технологийг (МХХТ) ашиглах шаардлагатай юм. Хүн ам цөөн, зам, тээврийн дэд бүтэц хангалттай хөгжөөгүй өргөн уудам газар нутагтай Монгол Улсад онлайн платформ нь нийтийн харилцаа холбооны суурь дэд бүтэц болох юм.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p> <p>МХХТ-д суурилсан системийг ухаалаг гар утас ашиглан мэдээлэл солилцох системийн загвар хэлбэрээр эн түрүүнд хөгжүүлж, сонгосон газарт туршилтаар нэвтрүүлнэ. Улмаар цуглуулсан өгөгдлийг статистик мэдээллийн хамт аймгийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөнд тусгахад ашиглана. Энэ нь орон нутгийн удирдлага, иргэд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Нутгийн удирдлага иргэд, олон нийттэй МХХТ-ийн сүлжээгээр холбогдосноор</p>

	<p>оролцогч талуудын чадавх сайжирч, харилцан итгэлцэл болон хариуцлагыг бэхжүүлнэ. Энэ төрлийн үйл ажиллагааг нийгмийн шинэчлэл, инновацид тооцно. Түүнчлэн малчид, орон нутгийн бизнес эрхлэгчдэд зориулсан платформыг нэвтрүүлснээр мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг идэвхжүүлнэ.</p> <p>3) Хэрэгжүүлэх зохион байгуулалт</p> <p>ҮХГ-ын удирдлага дор холбогдох яам, аймгийн ЗДТГ-тай хамтран төслийг хэрэгжүүлнэ.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Нийгмийн мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	Төсөл нь малчдын ахуй амьдралыг дэмжиж, бодит орлогыг нэмэгдүүлнэ.

Төслийн дугаар: II10.4

Төслийн нэр	<b>Програм хангамжийн аутсорсингийг дэмжих төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч байгууллага	ХХМТГ, Мэдээллийн технологийн үндэсний парк (МТҮП), ҮХГ, хувийн хэвшил
Зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>1) Монгол Улсын програм хангамжийн аутсорсинг хөгжүүлэлтийн (оффшор хөгжүүлэлт) чадавхыг сурталчлах, гадаадын орнуудаас Монгол улсад хэрэгжүүлэх аутсорсингийн төслийн тоог нэмэгдүүлэх;</li> <li>2) Аутсорсинг хөгжүүлэлтийг дэмжих зорилгоор МХХТ-ийн аж ахуйн нэгж, старт-ап компаниуд болон ХХМТГ, МТҮП зэрэг төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих орчинг бий болгох.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Аутсорсинг хөгжүүлэлтийг дэмжих МХХТ-ийн орчинг бүрдүүлнэ;</li> <li>2) МХХТ-ийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ;</li> <li>3) Хүний нөөцийг (МХХТ-ийн мэргэжилтнүүд) аутсорсинг хөгжүүлэлтийн төслийн туршлагаар дамжуулан хөгжүүлнэ;</li> <li>4) Монгол Улсын Засгийн газраас дэмжиж буй дижитал нийгмийг бэхжүүлнэ.</li> </ol>
Төслийн өртөг	1.0 сая ам.доллар
Хэрэгжүүлэх хуваарь	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийн төлөвлөлт: 2021-2022</li> <li>- Төслийн хэрэгжүүлэлт: 2023~2025</li> </ul>
Төслийн тодорхойлолт	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл</li> </ol> <p>Програм хангамжийн аутсорсинг хөгжүүлэлтийн (оффшор хөгжүүлэлт) төслийн тоо жил бүр нэмэгдэж байна. 2021 оны сүүл гэхэд МХХТ-ийн аутсорсингийн үйлчилгээний нийт үнийн дүн 413.72 тэрбум ам.доллараас давах төлөвтэй байна. Энэхүү өсөлт нь үйл ажиллагааны өртөг, зардал буурч, үр ашиг нэмэгдэж байгаатай холбоотой. Сүүлийн жилүүдэд програм хангамжийн аутсорсинг нь хамгийн их эрчээ авч буй үйл ажиллагаа болоод байна. Технологийн бус салбарт бизнес эрхлэгчид ихэвчлэн гадны экспертүүдээс үйлчилгээ авдаг бол програм хангамж хөгжүүлэгч компаниудын 60 гаруй хувь нь хөгжүүлэлтийнхээ тодорхой хэсэгт аутсорсинг ашигладаг. Монгол Улсын тухайд том хэмжээний болон жижиг тоон/МТ-ийн системийг хөгжүүлэх зорилготой гадаадын аж ахуйн нэгжийг татах давуу талтай. Үүний нэг шалтгаан бол Монголын МХХТ-ийн</p>

	<p>мэргэжилтнүүд дотоодын их дээд сургуулиуд, Япон, АНУ болон бусад хөгжингүй орнуудад техникийн өндөр боловсрол эзэмшсэнтэй холбоотой. Түүнчлэн монгол хөгжүүлэгч/ инженерүүдийн англи болон бусад хэлний мэдлэг өндөр төдийгүй тэдний дундаж цалин нь Хятад, Вьетнам, Филиппин улсуудтай (оффшор хөгжүүлэлт хөгжсөн орнууд) харьцуулахад харьцангуй доогуур байдаг. Гэсэн хэдий ч одоогоор Монгол Улс аутсорсинг хөгжүүлэлтээр төдийлөн танигдаагүй байна.</p> <p>2) Төсөл хэрэгжүүлэх явц</p> <p>Төслийн баг нь Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн хүрээнд “Аж үйлдвэрийн салбар болон их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, академийн хоорондын уялдаа холбоог сайжруулах” туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд холбогдох талууд санамж бичигт гарын үсэг зурж, МХХТ-ийн салбарын хамтын ажиллагааны платформыг байгуулсан. Энэхүү платформоор дамжуулж хүний нөөцийн хөгжил, МХХТ-ийн орчинг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар Монгол Улсын аутсорсинг хөгжүүлэлтийг өргөжүүлэх боломжтой. Түүнчлэн аутсорсинг хөгжүүлэлтэд хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагаах хөхиүлэн дэмжих, сурталчлах шаардлагатай. Энэ чиглэлээр 1) МХХТ-ийн салбарын төрийн албан хаагчдыг Монгол Улсад урих; 2) Яам, холбоо, худалдааны танхим зэрэг гадаадын МХХТ-ийн оролцогч талуудтай хамтран ажиллах сүлжээг бий болгох; 3) Эстони, Хятад, Орос зэрэг өндөр хөгжилтэй орнуудын аутсорсинг хөгжүүлэлтийн нөхцөл байдлыг судлах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p> <p>3) Хэрэгжүүлэх зохион байгуулалт</p> <p>ҮХГ-ын удирдлага дор ХХМТГ болон МТҮП хамтран төслийг хэрэгжүүлнэ.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Нийгмийн мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

Төслийн дугаар: II10.5

Төслийн нэр	<b>МХХТ-ийн экосистемийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч байгууллага	ХХМТГ, ҮСХ, ҮХГ
Зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>1) Нээлттэй өгөгдлийг олон нийтэд ил болгох, ашиглах талаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад зориулсан удирдамжийг бий болгох;</li> <li>2) Бизнес нээлттэй өгөгдлийг ашиглах чадвартай хүний нөөцийг (өгөгдөл судлаач) сургах;</li> <li>3) Бизнес төлөвлөгөөний санал авах, нээлттэй өгөгдлийг ашиглан төлөвлөгөөг сайжруулах төсөл, хөтөлбөрийг дэмжих;</li> <li>4) Нээлттэй өгөгдлийг сурталчлах замаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас бүрдсэн органик экосистемийг бий болгох.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	МХХТ-ийн экосистемийг "Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хүргэх байгууллагуудын сүлжээ" гэж тодорхойлдог. Энэхүү экосистем нь гурван чухал салбар болох тоног төхөөрөмж, програм хангамж, үйлчилгээний салбарт хамаардаг.


	Нээлттэй өгөгдлийг ашиглах замаар МХХТ-ийн органик экосистемийг бий болгоно. Энэ нь ялангуяа амьдралынхаа чанарыг сайжруулахын тулд МХХТ-ийг ашиглах сонирхолтой байдаг эдийн засгийн өндөр өсөлттэй орнуудад хамаарна.
Төслийн өртөг	1.0 сая ам.доллар
Хэрэгжүүлэх хуваарь	- Төслийн төлөвлөлт: 2021-2022 - Төслийн хэрэгжүүлэлт: 2022~2023
Төслийн тодорхойлолт	<p>1) Үндэслэл</p> <p>Төрийн байгууллагууд их хэмжээний өгөгдөл, мэдээллийг нээлттэй өгөгдөл хэлбэрээр гаргах, хэрэглээнд оруулах боломжтой. Ийнхүү мэдээллийг нээлттэй болгосноор төрийн байгууллагуудын үйл ажиллагаа илүү нээлттэй, ил тод болж, иргэд болон хувийн хэвшлийн өмнө илүү хариуцлагатай болно. Мэдээллийг ашиглах, дахин ашиглах, үнэ төлбөргүй түгээснээр төрөөс бизнес эрхлэлт, иргэдэд чиглэсэн шинэлэг үйлчилгээг дэмжих боломжтой болох юм.</p> <p>Нээлттэй өгөгдлийг ашиглах нь дараах зорилго, ач холбогдолтой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Засгийн газрын чиг үүрэг, хариуцлагын ил тод, найдвартай байдлыг дээшлүүлэх;</li> <li>➢ Олон нийтийн оролцоо, төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих;</li> <li>➢ Эдийн засгийг сэргээх, удирдлагын үр дүнтэй байдлыг хангах.</li> </ul> <p>2) Төсөл хэрэгжүүлэх явц</p> <p>Төрийн холбогдох байгууллагууд удирдамжийг боловсруулж, улмаар нээлттэй мэдээллийг нийтэд нээлттэй болгох, ашиглах нэгдсэн форматыг нэвтрүүлнэ. Үүний зэрэгцээ МХХТ-ийн экосистемийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын хүчин чармайлтаар сайжруулах шаардлагатай. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн хооронд техникийн болон хамтын ажиллагааг бий болгож, аутсорсинг хөгжүүлэлтийн орчинг сайжруулна.</p> <p>3) Хэрэгжүүлэх зохион байгуулалт</p> <p>ҮХГ-ын удирдлага дор ХХМТГ, ҮСХ-той хамтран төслийг хэрэгжүүлнэ.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Нийгмийн мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	Төслийн арга зүй, загвар, үр дүнг цаашид МХХТ-ийн экосистемийг хөгжүүлэхэд ашиглах боломжтой.

## 10.3 Нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд

Төслийн дугаар: III1

Төслийн нэр	<b>Авто замын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл *</b>																																																																																	
Байршил	Монгол Улсын төв хэсэг																																																																																	
Хэрэгжүүлэгч	ЗТХЯ																																																																																	
Зорилго	<p>1) Нийт нутаг дэвсгэрийн төв хэсэгт хөгжлийн гол бүсийг бий болгоход хувь нэмэр оруулах зорилгоор Баруун, Хангайн, Төвийн болон Зүүн бүсийн хотуудыг холбосон авто замын тойрог сүлжээ барьж байгуулах;</p> <p>2) Нутгийн хойд талд байрлаж буй аймгуудыг авто замтай холбох;</p> <p>3) БНХАУ-ын хил залгаа аймгуудаас төвийн бүс рүү нэвтрэх боломжийг сайжруулах;</p> <p>4) Төвийн бүс нутгаас Баруун болон Зүүн бүс нутгууд руу нэвтрэх боломжийг сайжруулах.</p>																																																																																	
Хүлээгдэж буй үр дүн	Улс орон даяар бүс нутгийн хөгжлийг илүү тэнцвэржүүлж, нийгмийн болон төрийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоно.																																																																																	
Төслийн зардал	<p>1-р үе шат: Дархан - Эрдэнэт/Орхоны замыг өргөн болгоход (190 км) 71 сая ам.доллар Сүлжээний өмнөд хэсгийг сайжруулахад 52 сая ам.доллар (Өндөрхаан - Чойр - Арвайхээр, 274 км)</p> <p>2-р үе шат: Сүлжээний өмнөд ба баруун тойрог хэсгийн сэргээн сайжруулалтад зориулж 125 сая ам.доллар (Орхон - Мөрөн - Улиастай - Арвайхээр, 793 км, зарим хэсэгт замыг хэдийнээ барьсан)</p>																																																																																	
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>1-р үе шат: санал болгож буй тойрог замын шороон болон эвдэрсэн хэсгийг сайжруулах</p> <p>2-р үе шат: авто замын сүлжээ тойргийн дагуух уулархаг хэсэгт шинэ автозам барьж байгуулах</p> <p>Төслийн зорилтот хэсэг, төслийн код, замын нийт урт, замын өнөөгийн байдал, барьж байгуулах дараалал (1-3-р үе шат, "0" гэсэн код нь хэдийнээ барьж дууссан гэсэн үг), газрын байдал, шаардлагатай эгнээний тоо, замыг хэсэгчлэн зассан бол засах, барьж байгуулах шаардлагатай замын урт болон зардлыг дараах байдлаар нэгтгэн харуулав. Замын хучилтын нөхцөл байдлыг 2019 оны эцсийн байдлаар шинэчлэн боловсруулсан.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Ангилал</th> <th>Код</th> <th>Төсөл</th> <th>Урт (км)</th> <th>Статус</th> <th>Эрэмбэ</th> <th>Газрын байдал</th> <th>Эгнээ</th> <th>Барьж байгуулах замын уртын сонголт</th> <th>Нийт зардал (ам.доллар)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="7">Тойрог замын сүлжээ</td> <td>RA1</td> <td>Дархан-Эрдэнэт</td> <td>190</td> <td>A1001-1002, 2 эгнээтэй засмал зам</td> <td>1</td> <td>Тэгш гадаргуутай</td> <td>4</td> <td>1</td> <td>71,060,000.00</td> </tr> <tr> <td>RA2</td> <td>Булган-Мөрөн-А603/А1102 огтлолцол</td> <td>599</td> <td>A0902, 50% засмал зам, 50% шороон зам</td> <td>2</td> <td>Гүвээ толгодтой</td> <td>2</td> <td>50%</td> <td>67,207,800.00</td> </tr> <tr> <td>RA3</td> <td>Улиастай-Алтай</td> <td>194</td> <td>A1103, шороон зам</td> <td>2</td> <td>Уулархаг</td> <td>2</td> <td>1</td> <td>58,044,800.00</td> </tr> <tr> <td>RA4</td> <td rowspan="2">Арвайхээр-Мандалговь-Чойр</td> <td>114</td> <td>A3401 - A37 шороон зам</td> <td>1</td> <td>Тэгш гадаргуутай</td> <td>2</td> <td>1</td> <td>21,318,000.00</td> </tr> <tr> <td>RA5</td> <td>160</td> <td>A37 шороон зам</td> <td>1</td> <td>Тэгш гадаргуутай</td> <td>2</td> <td>1</td> <td>29,920,000.00</td> </tr> <tr> <td>RA6</td> <td>УБ-Дархан</td> <td>211</td> <td>A0401, АХБ-аас аль хэдий нь барьж байгуулж эхэлсэн</td> <td>0</td> <td>Гүвээ толгодтой</td> <td>4/2</td> <td>1</td> <td>0.00</td> </tr> <tr> <td>RA7</td> <td>УБ-Чойр</td> <td>200</td> <td>A0101, саяхан сайжруулсан, Налайхын замыг сайжруулж байгаа</td> <td>0</td> <td>Гүвээ толгодтой</td> <td>4/2</td> <td>1</td> <td>0.00</td> </tr> </tbody> </table> <p>Зорилтот хэсгүүдийн байршлыг газрын зураг дээр код болон өнгөөр ялган үзүүлсэн болно. Тод шулуун шугам бүхий кодтой зам нь 1-р үе шатанд барьж байгуулахаар эрэлбэлсэн замын хэсгүүд юм.</p>									Ангилал	Код	Төсөл	Урт (км)	Статус	Эрэмбэ	Газрын байдал	Эгнээ	Барьж байгуулах замын уртын сонголт	Нийт зардал (ам.доллар)	Тойрог замын сүлжээ	RA1	Дархан-Эрдэнэт	190	A1001-1002, 2 эгнээтэй засмал зам	1	Тэгш гадаргуутай	4	1	71,060,000.00	RA2	Булган-Мөрөн-А603/А1102 огтлолцол	599	A0902, 50% засмал зам, 50% шороон зам	2	Гүвээ толгодтой	2	50%	67,207,800.00	RA3	Улиастай-Алтай	194	A1103, шороон зам	2	Уулархаг	2	1	58,044,800.00	RA4	Арвайхээр-Мандалговь-Чойр	114	A3401 - A37 шороон зам	1	Тэгш гадаргуутай	2	1	21,318,000.00	RA5	160	A37 шороон зам	1	Тэгш гадаргуутай	2	1	29,920,000.00	RA6	УБ-Дархан	211	A0401, АХБ-аас аль хэдий нь барьж байгуулж эхэлсэн	0	Гүвээ толгодтой	4/2	1	0.00	RA7	УБ-Чойр	200	A0101, саяхан сайжруулсан, Налайхын замыг сайжруулж байгаа	0	Гүвээ толгодтой	4/2	1	0.00
Ангилал	Код	Төсөл	Урт (км)	Статус	Эрэмбэ	Газрын байдал	Эгнээ	Барьж байгуулах замын уртын сонголт	Нийт зардал (ам.доллар)																																																																									
Тойрог замын сүлжээ	RA1	Дархан-Эрдэнэт	190	A1001-1002, 2 эгнээтэй засмал зам	1	Тэгш гадаргуутай	4	1	71,060,000.00																																																																									
	RA2	Булган-Мөрөн-А603/А1102 огтлолцол	599	A0902, 50% засмал зам, 50% шороон зам	2	Гүвээ толгодтой	2	50%	67,207,800.00																																																																									
	RA3	Улиастай-Алтай	194	A1103, шороон зам	2	Уулархаг	2	1	58,044,800.00																																																																									
	RA4	Арвайхээр-Мандалговь-Чойр	114	A3401 - A37 шороон зам	1	Тэгш гадаргуутай	2	1	21,318,000.00																																																																									
	RA5		160	A37 шороон зам	1	Тэгш гадаргуутай	2	1	29,920,000.00																																																																									
	RA6	УБ-Дархан	211	A0401, АХБ-аас аль хэдий нь барьж байгуулж эхэлсэн	0	Гүвээ толгодтой	4/2	1	0.00																																																																									
	RA7	УБ-Чойр	200	A0101, саяхан сайжруулсан, Налайхын замыг сайжруулж байгаа	0	Гүвээ толгодтой	4/2	1	0.00																																																																									






Төслийн танилцуулга

1) Үндэслэл

Сүүлийн үед хийгдсэн судалгаа болон УИХ-ын тогтоолоор батлагдсан улсын нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалттай холбоотой баримт бичиг нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт зохистой үйлчилж чадахгүй байгаа тул тохиромжтой бус байна. Хөгжлийн гол бүс нутаг нь Улаанбаатар хотоор дайрсан хойд-урд чиглэлийн эдийн засгийн коридорын дагуу байрлах бол хойд зүгт зүүн-баруун чиглэлийн ногоон коридорын дагуу байрлана. УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор баталсан хойноос урагш чиглэсэн дэд бүтцийн босоо таван тэнхлэгийн дөрөв нь батлагдаагүй байна. Нийслэл хотын байршил нь эдийн засгийн үйл ажиллагаа болон хүн амын суурьшилд гол нөлөө үзүүлдэг.



2) Төслийн бүрэлдэхүүн

Санал болгож буй авто замын сүлжээ тойрог нь Баруун бүсэд Улиастай, Хангайн бүсэд Мөрөн, Баянхонгор, Арвайхээр, Төвийн бүсэд Чойр, Дархан, Эрдэнэт, Зүүн бүсэд Өндөрхаан зэрэг томоохон хотуудыг холбоно. Энэ нь дор дурдсан хувь нэмрийг оруулах болно. Үүнд:

- Авто замын сүлжээ тойрог доторх нутаг дэвсгэрийг 21-р зуунд Монгол Улсын хөгжлийг манлайлах, чанартай дэд бүтэц бүхий бүс болгон хөгжүүлэх боломжтой;
- Улаанбаатар хотын ач холбогдол бүхий зарим үйл ажиллагааг тойрог коридорын дагуу хотууд руу үр ашигтай шилжүүлж болно;

	<p>c) Баруун бүсийг нийслэлтэй холбох сүлжээг бэхжүүлэхийн тулд авто замын сүлжээ тойргийн баруун төгсгөл дэх Улиастай хотын үйл ажиллагааг сайжруулна;</p> <p>d) Зүүн бүсийг нийслэлтэй холбох сүлжээг бэхжүүлэхийн тулд авто замын сүлжээ тойргийн зүүн төгсгөл дэх Өндөрхаан хотын үйл ажиллагааг сайжруулна;</p> <p>e) Авто замын сүлжээ тойргийн хойд хэсэг нь ОХУ-тай аялал жуулчлал, худалдааг хөгжүүлэх зорилгоор хил орчмын аймаг, хотуудыг холбож өгнө;</p> <p>f) Авто замын сүлжээ тойргийн урд хэсэг нь БНХАУ-тай хиллэдэг аймгуудаас хойд хэсэг дэх дэвшилтэт бүс рүү нэвтрэх боломжийг сайжруулна.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ЗТХЯ нь төслийн хүрээнд одоо байгаа авто замыг сайжруулах, баруун болон баруун урд хэсгийн уулархаг нутгаар дайран өнгөрөх шинэ авто замыг барьж байгуулах замаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Авто замын сүлжээ тойргийн зүүн хойд хэсэг нь тусгай хамгаалалттай газар нутгаас зайлсхийх ёстой.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Одоо байгаа авто замыг сайжруулах нь нийгэм болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Авто замын шинэ чиглэлийг боловсруулахдаа сайтар төлөвлөж, БОНБУ-ийн дагуу хийх хэрэгтэй.
Тайлбар	Салбарын тайланд нарийвчилсан дүн шинжилгээ, зардлын тооцоог тусгана.


### Төслийн дугаар: III2

Төслийн нэр	Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл *
Байршил	Монгол Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч	ЗТХЯ
Зорилго	Боловсруулах түүхий эдийг тээвэрлэхэд хялбар болгох зорилгоор аймаг хоорондын уялдаа холбоог бэхжүүлж, аймгуудын бие даан хөгжих болон тэдгээрийн хоорондын худалдаа, харилцаа холбоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
Хүлээгдэж буй үр дүн	Анхан шатны үйлдвэрлэл, боловсруулалт, маркетингийн чиглэлээр аймгуудын бие даасан хөгжлийг дэмжинэ. Аймгууд болон хот, хөдөөгийн хооронд нийгмийн болон төрийн үйлчилгээг илүү үр дүнтэй болгоно.
Төслийн зардал	1-р үе шат (2021-2025): 1 дүгээрт эрэмбэлэгдсэн 225 км автозамын хэсэгт 50 сая ам.доллар. 2-р үе шат (2025-2030): 2 дугаарт эрэмбэлэгдсэн 1,023 км автозамын хэсэгт 211 сая ам.доллар. 3-р үе шат (2030-2040): 2 дугаарт эрэмбэлэгдсэн, доод түвшний 614 км автозамын хэсэгт 129 сая ам.доллар.
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	Төслийн зорилтот хэсэг, төслийн код, замын нийт урт, замын өнөөгийн байдал, барьж байгуулах дараалал (1-3-р үе шат, "0" гэсэн код нь аль хэдий нь барьж дууссан гэсэн үг), газрын байдал, шаардлагатай эгнээний тоо, замыг хэсэгчлэн засах, барьж байгуулах шаардлагатай замын урт болон зардлыг дараах байдлаар нэгтгэн харуулав. Замын хучилтын нөхцөл байдлыг 2019 оны эцсийн байдлаар шинэчлэн боловсруулсан.

**Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл  
Эцсийн тайлан**

Ангилал	Код	Төсөл	Урт (км)	Статус	Эрэмбэ	Газрын байдал	Эгнээ	Барьж байгуулах замын уртын сонголт	Нийт зардал (ам.доллар)
Аймаг хоорондын авто зам	IA1	Чойбалсан-Өндөрхаан	225	A0502, засмал зам	0	Тэгш гадаргуутай	2	1	0
	IA2	Чойбалсан-Баруун-Урт-Сайншанд	497	A2201, A35, шороон зам	2	Тэгш гадаргуутай	2	1	92,939,000
	IA3	Матад-Баруун-Урт	163	Зам байхгүй (A2201 замтай параллель)	3	Гүвээ толгодтой	1.5	1	27,432,900
	IA4	Чойр-Өндөрхаан	225	A35 шороон зам	1	Гүвээ толгодтой	2	1	50,490,000
	IA5	Улаангом-Ховд	163	(A1701) замын хэсгийн 80% нь шороон зам	2	Уулархаг	1.5	1	36,577,200
	IA6	Арвайхээр-Шивээхүүрэн-БНХАУ	451	A29 Шороон зам	3	Уулархаг	1.5	1	101,204,400
	IA7	Дархан-Алтанбулаг-ОХУ	122	A0402-0403, засмал, АХБ-ны төслийн хүрээнд засагдаж байгаа	0	Тэгш гадаргуутай	2	1	0
	IA8	Ховд-Өлгий	220	A0305, саяхан АХБ-аас засмал зам тавигдсан	0	Уулархаг	2	1	0
	IA9	Говьсүмбэр-Хэнтий аймгийн Дархан сум	93	Шороон зам, жижиг, Баганууртай ойрхон, А35 замтай параллель	2	Гүвээ толгодтой	2	1	20,869,200
	IA10	Баянхонгор-Шаргалжуут-Найман нуур-Улаан цутгалан-Хужирт	270	Зам байхгүй, уулархаг нутаг, байгалийн үзэсгэлэнт жуулчдын очдог газар	2	Уулархаг	1.5	1	60,588,000

Зорилтот хэсгүүдийн байршлыг газрын зураг дээр код болон өнгөөр ялган үзүүлсэн болно. Тод шулуун шугам бүхий кодтой зам нь 1-р үе шатанд барьж байгуулахаар эрэлбэлсэн замын хэсгүүд юм.



**Төслийн танилцуулга**

**1) Үндэслэл**

Одоогийн байдлаар авто замын сүлжээ нь ихэвчлэн Улаанбаатар хотоос гадагш цацарсан замуудтай байгаа бөгөөд аймгийн төвүүдийг холбосон зам хангалттай бус, ялангуяа нийслэл хотоос алс хол орших аймгуудын хувьд нөхцөл байдал тийм ч сайн биш байна. Доорх зурагт үзүүлснээр тус төсөл нь аймгийн төвүүдийг холбосон авто замыг сайжруулах замаар авто замын сүлжээг бэхжүүлэх юм.

**2) Төслийн бүрэлдэхүүн**

Энэхүү төсөл нь УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам буюу Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийн хүрээнд хойд зүгээс урд зүг рүү чиглэсэн хөгжлийн дөрвөн тэнхлэгийг, мөн Баян-Өлгийгээс ОХУ-ын Ташанта хот хүртэлх олон талын харилцааг бий болгоход туслах болно. Түүнчлэн Улаанбаатар болон Даланзадгад хооронд, Даланзадгадаар дайран Сайншанд болон Гурвантэс сум руу, Сайншанд болон Чойбалсан хоорондох автозамууд санал болгож буй авто замын сүлжээ тойргийн хүрээнд багтжээ.

**3) Хэрэгжилт**

Төслийг ЗТХЯ-наас үе шаттайгаар хэрэгжүүлнэ.



Байгаль орчин, нийгмийн нөлөө	Говь, хээрийн бүс нутгаар дамжин өнгөрөх авто замын хэсэгт байгаль орчинд үзүүлэх зарим сөрөг нөлөөлөл гарна. Мөн орон нутгийн иргэд, түүний дотор малчдад үзүүлж буй нийгмийн үр нөлөөг сайтар үнэлэх хэрэгтэй.
Тайлбар	Салбарын тайланд нарийвчилсан дүн шинжилгээг тусгана.


### Төслийн дугаар. IIIЗ

Төслийн нэр	<b>Аймгуудын тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах төсөл *</b>
Байршил	Монгол Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч	ЗТХЯ
Зорилго	Аялал жуулчлалын үйл ажиллагаа, экспортын/импортын үйл ажиллагаа, аймгийн төв болон аялал жуулчлалын байршлууд, хилийн боомт хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, аймгуудын бие даан хөгжих болон тэдгээрийн хоорондын худалдаа, харилцаа холбоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
Хүлээгдэж буй үр дүн	Анхан шатны үйлдвэрлэл, боловсруулалт, маркетингийн чиглэлээр аймгуудын бие даасан хөгжлийг дэмжинэ. Аймгууд болон хот, хөдөөгийн хооронд нийгмийн болон төрийн үйлчилгээг илүү үр дүнтэй болгоно.
Төслийн зардал	1-р үе шат (2021-2025): 1 дүгээрт эрэмбэлэгдсэн 979 км автозамын хэсэгт 214 сая ам.доллар. 2-р үе шат (2025-2030): 2 дугаарт эрэмбэлэгдсэн 1,167 км автозамын хэсэгт 284 сая ам.доллар. 3-р үе шат (2030-2040): 2 дугаарт эрэмбэлэгдсэн, доод түвшний 1,085 км автозамын хэсэгт 211 сая ам.доллар.
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	Төслийн зорилтот хэсгүүдийн ангилал (аялал жуулчлал, хилийн худалдаа, уул уурхай, бусад), төслийн код, замын нийт урт, замын өнөөгийн байдал, барьж байгуулах дараалал (1-3-р үе шат, "0" гэсэн код нь хэдийнээ барьж дууссан гэсэн үг), газрын байдал, шаардлагатай эгнээний тоо, замыг хэсэгчлэн зассан бол засах, барьж байгуулах шаардлагатай замын урт болон зардлыг дараах байдлаар нэгтгэн харуулав.

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл  
Эцсийн тайлан

Ангилал	Код	Төсөл	Урт (км)	Статус	Эрэмбэ	Газрын байдал	Эгнээ	Барьж байгуулах замын уртын сонголт	Нийт зардал (ам.доллар)
Аялал жуулчлал	T1	Жаргалтхаан-Өмнөдэлгэр-Бинда	166	Жаргалтаас зүүн хойш шороон зам	2	Гүвээ толгодтой	2	1	37,250,400
	T2	Норовлин-Дадал	56	A19, Хэнтий аймгийн зүүн хойд нутаг, шороон зам	2	Гүвээ толгодтой	2	1	12,566,400
	T3	Баг-Өлзийт-Төвхөн хийд-Цэнхэрийн халуун рашаан-Цэцэрлэг	100	A0602, замын ихэнх хэсэг Архангай аймагт оршино, засмал зам	2	Уулархаг	2	1	29,920,000
	T4	Арвайхээр-Хужирт	56	A0602, засмал зам, халуун рашаанд хүрэх зам	2	Уулархаг	2	1	16,755,200
Хилийн худалдаа	B1	Чойбалсан-Ульхан боомт-ОХУ	224	A21, хайрга	1	Уулархаг	2	1	67,020,800
	B2	Чойбалсан-Хавирга боомт-БНХАУ	125	A2202, A23, шороон зам	1	Тэгш гадаргуутай	2	1	23,375,000
	B3	Чойбалсан-Эрэнцэв боомт-ОХУ	215	A2202, шороон зам	2	Тэгш гадаргуутай	2	1	40,205,000
	B4	Баруун-Урт-Бичигт боомт-БНХАУ	272	A2002, 2020 оны байдлаар бэлэн болохоор төлөвлөгдсөн, төсөл хэрэгжиж байгаа	0	Тэгш гадаргуутай	2	80%	0
	B5	Өндөрхаан-Ульхан боомт-ОХУ	250	A19, шороон зам. T2-тай холбогдоно	2	Уулархаг	2	1	74,800,000
	B6	Сайншанд-Зүүнбаян-Хатанбулаг	200	A39, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах газар, шороон зам	1	Тэгш гадаргуутай	2	1	37,400,000
	B7	Алтай-Бургастай боомт-БНХАУ	320	A1104, хэсэгчлэн сайжруулж байгаа, 60% нь шороон зам	3	Уулархаг	1.5	60%	43,084,800
	B8	Хатгал-Ханх-ОХУ	180	A1101, Хөвсгөл нуур дагуу, 50% нь засмал зам, 50% нь шороон зам	1	Гүвээ толгодтой	2	1	40,392,000
	B9	Өлгий-Алтай-Таванбогд	118	A15, маш уулархаг нутаг, шороон зам	3	Уулархаг	1.5	1	26,479,200
	B10	Улаанхус-Хөх-Цагааннуур боомт-ОХУ	113	Тодорхой бус, уулархаг нутаг	3	Уулархаг	2	1	33,809,600
	B11	Хутагт-Өндөр-Тэшиг-Бага Илэнх боомт-ОХУ	124	A13, шороон зам	2	Уулархаг	1.5	1	27,825,600
	B12	Нөрмөг-Тэс-Арцсуурь боомт-ОХУ	200	A0603 замд хэсэгчлэн засмал зам тавигдаж байгаа, 60% нь шороон зам	2	Гүвээ толгодтой	2	1	44,880,000
Уул уурхай	M	Таван толгой-Гашуун сухайт боомт-БНХАУ	250	A0203 засмал зам тавигдаж байгаа, 2020 онд дуусна	1	Тэгш гадаргуутай	2	1	46,750,000
Бусад	O1	Булган-Хишиг-Өндөр-Гурванбулаг	134	A0901, шороон зам	3	Уулархаг	1.5	1	30,069,600
	O2	Мөрөн-Шинэ-Идэр-Жаргалан, Цэцүүх	180	A40, шороон зам	3	Уулархаг	1.5	1	40,392,000
	O3	Даланзадгад-Баяндалай-Гурвантэс	220	A33, хэсэгчлэн засмал зам тавьсан, 50% ердийн шороон зам, 25% сайжруулсан шороон зам	3	Уулархаг	1.5	75%	37,026,000

Зорилтот хэсгүүдийн байршлыг газрын зураг дээр код болон өнгөөр ялган үзүүлсэн болно. Тод шулуун шугам бүхий кодтой зам нь 1-р үе шатанд барьж байгуулахаар эрэлбэлсэн замын хэсгүүд юм.



**Төслийн танилцуулга**

1) Үндэслэл

Улсын чанартай автозамын сүлжээг тойрог авто замын сүлжээ болон аймаг хоорондын автозамыг барьж байгуулсанаар өргөн уудам нутгийг холбох холбоосыг бий болгохгүй. Орон нутгийн бие даасан хөгжлийг хангасан тохиолдолд хөдөө орон нутгийг холбох холбоосыг бий болгох боломжтой. Аялал жуулчлал, худалдаа, уул уурхайг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэн бүс нутаг болон олон нийтийн хөгжлийг дэмжих зорилгоор хөдөө орон нутаг руу хүрэх замыг сайжруулах хэрэгтэй.

	<p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Хөдөө орон нутагт ашиглагдаж байгаа ихэнх зам нь нарийн зам бөгөөд уулархаг хэсгээр байрладаг. Хэнтий, Өвөрхангай/Архангай аймгийн аялал жуулчлалын зориулалттай замуудыг аялал жуулчлалын салбарын төслүүдэд ("Өртөө" төсөл) зориулан сонгон авсан. Хилийн худалдааны үйл ажиллагаанд зориулагдах замын хэсгүүд нь БНХАУ, ОХУ-ын хил дагуух бага хөгжсөн боомтуудтай холбогддог бөгөөд энэ нь олон улсын худалдааг дэмжихээс илүүтэйгээр орон нутгийн ойр орчмын хот суурин газруудын худалдааг дэмжих болно. Таван толгойгоос БНХАУ-ын хил хүртэлх уул уурхайн үйл ажиллагааны зориулалттай замуудыг бараг барьж байгуулж дууссан боловч худалдааны үйл ажиллагааг дэмжихийн тулд дахин зохих хэмжээгээр өргөжүүлж, сайжруулах шаардлагатай байна. Автозамын зэрэгцээ төмөр замын бүтээн байгуулалт үргэлжилж байгаа хэдий ч автозамыг барьж байгуулах ажлыг дэмжих нь уул уурхайн салбарт зайлшгүй шаардлагатай. Дараах хүснэгтэд замын урт болон барьж байгуулах дарааллыг нэгтгэн үзүүлэв.</p> <table border="1" data-bbox="647 779 1177 1025"> <thead> <tr> <th>Cost Mil. USD</th> <th>2020-2025</th> <th>2025-2030</th> <th>2030-2040</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Tourism</td> <td>0</td> <td>96</td> <td>0</td> </tr> <tr> <td>Border trade</td> <td>168</td> <td>188</td> <td>103</td> </tr> <tr> <td>Other</td> <td>47</td> <td>0</td> <td>107</td> </tr> <tr> <th>Length (km)</th> <th>2020-2025</th> <th>2025-2030</th> <th>2030-2040</th> </tr> <tr> <td>Tourism</td> <td>0</td> <td>378</td> <td>0</td> </tr> <tr> <td>Border trade</td> <td>729</td> <td>789</td> <td>551</td> </tr> <tr> <td>Mining / Other</td> <td>250</td> <td>0</td> <td>534</td> </tr> </tbody> </table> <p>3) Хэрэгжилт</p> <p>Төслийг ЗТХЯ-наас үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	Cost Mil. USD	2020-2025	2025-2030	2030-2040	Tourism	0	96	0	Border trade	168	188	103	Other	47	0	107	Length (km)	2020-2025	2025-2030	2030-2040	Tourism	0	378	0	Border trade	729	789	551	Mining / Other	250	0	534
Cost Mil. USD	2020-2025	2025-2030	2030-2040																														
Tourism	0	96	0																														
Border trade	168	188	103																														
Other	47	0	107																														
Length (km)	2020-2025	2025-2030	2030-2040																														
Tourism	0	378	0																														
Border trade	729	789	551																														
Mining / Other	250	0	534																														
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Говь, хээрийн бүс нутгаар дамжин өнгөрөх авто замын хэсэгт байгаль орчинд үзүүлэх зарим сөрөг нөлөөлөл гарна. Мөн орон нутгийн иргэд, түүний дотор малчдад үзүүлж буй нийгмийн үр нөлөөг сайтар үнэлэх хэрэгтэй.																																
Тайлбар	Салбарын тайланд нарийвчилсан дүн шинжилгээ, зардлын тооцоог тусгана.																																

**Төслийн дугаар: III4**

Төслийн нэр	<b>Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл*</b>
Байршил	Улаанбаатар хотын орчим
Хэрэгжүүлэгч	УБТЗ/МТЗ
Зорилго	<p>1) Дамжин өнгөрөх тээврийн болон экспортын тээврийн эрэлт хэрэгцээнд зориулж хойд-урд чиглэлийн төмөр замын коридорын хүчин чадлыг сайжруулах;</p> <p>2) Улаанбаатар хотын захын бүсэд шинэ ачаа тээврийн терминалыг холбосон шинэ холболтыг бий болгох, бусад тээврийн хэрэгслүүдтэй холбох, Улаанбаатар хот руу ихэвчлэн жижиг оврын ачааны машинаар хүргэлтийг хийх</p>
Хүлээгдэж буй үр дүн	Инженерийн хуучин дизайн стандартын дагуу баригдсан Улаанбаатарын хэсгээр дайрахгүй, төмөр замын дамжин өнгөрөх тээврийн болон экспортын тээврийн хүргэлтийг хурдасгах; Улаанбаатар хотод зориулсан логистикийн сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх.
Төслийн зардал	300-400 сая ам.доллар

Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021: Эхний үнэлгээ (инженерийн судалгаа) 2022-2025: Хэрэгжилт ба үнэлгээ
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Улаанбаатар хот нь төмөр замаар тээвэрлэдэг дотоодын нүүрс болон төрөл бүрийн импортын бүтээгдэхүүний ихэнх хэсгийг хүлээн авдаг цэг юм. Хойд-урд чиглэлийн төмөр замын гол шугам нь Улаанбаатар хот руу нийлүүлэгддэг хангамжийн үйл ажиллагааны улмаас түгжрэл үүсдэг. Улаанбаатар болон Налайхын чиглэлийн төмөр замыг 1930-аад онд Налайхын огцом эгц хэсгийг тойрон өнгөрөх зорилгоор хуучин технологи ашиглан байгуулсан тул төмөр замын үйл ажиллагааг удаашруулж байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Энэхүү тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам)-ыг 2018 онд АХБ-ны төмөр замын салбарын судалгаа болон 2010 онд боловсруулсан ЖАЙКА-гийн Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлөгөөний судалгаа, хот байгуулалтын хөтөлбөрт тус тус санал болгосон. Энэхүү шинэ шугам нь түгжрэлийг тойрон гарч, Налайх, нисэх онгоцны шинэ буудлын орчим, Улаанбаатар хотын баруун хэсгийг холбосноор дамжин өнгөрөх галт тэрэг Улаанбаатар хотын түгжрэлтэй хэсгүүдээс зайлсхийх боломжтой болно.</p> <p>ЖАЙКА-гийн Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлөгөөний судалгаа, хот байгуулалтын хөтөлбөрт төмөр замын тойрон гарах шугамын уртыг Мандал өртөөнөөс Багахангай өртөө хүртэл 170 км, 2 хонгил, 2 гүүр, 20 хоолойтой байхаар санал болгосон нь өртөг зардлыг ихээр нэмэгдүүлнэ. Мандал өртөөнөөс Багахангай өртөө хүртэлх одоогийн хэсэг нь 194 км, тиймээс ЖАЙКА-гийн Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлөгөөний судалгаа, хот байгуулалтын хөтөлбөрт санал болгосон шинэ шугам нь 24 км-р богино байна. Гэсэн хэдий ч ЖАЙКА-гийн Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлөгөөний судалгаа, хот байгуулалтын хөтөлбөрт санал болгосон шинэ шугам нь одоогийн замын чиглэлтэй давхцаж байгаа тул үүнийг оновчтой болгох шаардлагатай. Цаашид орчин үеийн технологийг ашиглан боломжит, богино чиглэлийг тогтоохын тулд инженерийн судалгаа хийх шаардлагатай ба энэ нь эхний хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах боломжтой.</p> <p>Шинэ шугамыг барьсанаар Улаанбаатар хотоор дайран өнгөрч байгаа галт тэргийг бүс нутгийн ачаа тээвэр, зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглана.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Төслийг УБТЗ/МТЗ өөрсдийн хүчин чадлын хүрээнд хэрэгжүүлнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Энэхүү төсөл нь бүтээн байгуулалтын хугацаанд төмөр замын шугамын дагуу газар нутгийн байгаль орчинд ихээхэн нөлөө үзүүлнэ. Барилга угсралтын ажлын явцад төмөр замын дагуух хүн амын суурьшил нь сийрэг тул нийгмийн нөлөөлөл эерэг байна.</p> <p>Ашиглалтын хугацаанд төмөр замын тойрон гарах шугамын нийгмийн нөлөөлөл нь зөвхөн нийслэл бүсэд төдийгүй олон улсын дамжин өнгөрөх төмөр замын ашиглалтын үр ашигт эерэгээр нөлөөлнө.</p>
Тайлбар	

Төслийн дугаар: III5

Төслийн нэр	<b>Хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл *</b>
Байршил	Хойд-урд чиглэлийн дагуу
Хэрэгжүүлэгч Зорилго	УБТЗ (Оросын хувь нийлүүлэгчид) /МТЗ/ЗТХЯ 1) Төмөр замын сүлжээгээр дамжуулан цаашид дамжин өнгөрөх болон экспортын эрэлт хэрэгцээг хангах, бодит болон зохион байгуулалтын чадавхыг бэхжүүлэх; 2) Ачаа тээврийн логистикийн үйл ажиллагаанд төмөр замын үйл ажиллагааг хэрэглээг түлхүү оруулах, хүнд даацын тээврийн хөдөлгөөний улмаас зам дээрх замын элэгдлийг багасгах.
Хүлээгдэж буй үр дүн	Төмөр замын бүтээмж, үр ашгийг хамгийн бага хөрөнгө оруулалтаар хангана, төмөр замын хөдөлгөөний ачааллаас үүсэх саатлыг багасгана.
Төслийн зардал	i) Анхан шатны үнэлгээ хийхэд 2.0 сая ам.доллар. ii) Хэрэгжүүлэлтэд нийт 250 сая ам.доллар (жилд 50 сая ам.доллар).
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021 он: Анхан шатны үнэлгээ хийж, хэрэгжүүлэх багцыг бэлтгэнэ 2022-2025: Хэрэгжилт ба үнэлгээ
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Далайд гарцгүй төв Азийн бусад орнуудтай харьцуулахад Монгол Улсын төмөр замын үйл ажиллагааны үр бүтээмж нэг салаатай төмөр замын хувьд өндөр гэж тооцогддог. Гэсэн хэдий ч үндсэн шугамыг ашиглах хүчин чадал нь байгууллагын болон зам дээрх саадуудаас шалтгаалан хязгаартаа тулдаг. 2) Төслийн бүрэлдэхүүн Хойд-урд төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авах шаардлагатай. а) Хүчин чадлыг нэмэгдүүлэх янз бүрийн арга барилд дүн шинжилгээ хийж, өнөөгийн эрэлт хэрэгцээний загварыг үнэлэх. б) Хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар хийсэн шинжилгээнд дараах зүйлийг хязгаарлахгүйгээр анхаарч үзэх шаардлагатай. Үүнд: Дотоодын зорчигч тээврийн болон олон улсын зорчигч тээврийн үйлчилгээг багасгах замаар ачаа тээврийн үйл ажиллагааг сайжруулах, Бодит сайжруулалтад дараах ажлуудыг оруулна. Үүнд: i) дамжин өнгөрөх шинэ шугамыг нэмэх, ii) шинэ зүтгүүрүүд болон урт хөдлөх бүрэлдэхүүнтэй галт тэрэгний үйл ажиллагааг нэмэх, iii) цаашид хурдыг нэмэгдүүлэхийн тулд босоо болон хэвтээ чиглэлүүдийг дахин шинэчлэх, iv) хэсэгчилсэн хос зам суурилуулах, v) цахилгаанжуулах,vi) салбар замуудын шинэ чиглэлүүдийг хөгжүүлэх, vii) хос замыг хөгжүүлэх зэрэг болно. Хил дээр саатах хугацааг багасгах зорилгоор хил нэвтрэх үйл ажиллагаанд бичиг баримтыг шалгах ажиллагааг хөнгөвчлөх, Вагоны ашигтай ажиллагааг дээшлүүлэх, цаашид чингэлэгээр ачих боломжийг бий болгосноор нэг чиглэлийг барьсан ачааны хэмжээг бууруулна. с) Уялдаа холбоог сайжруулахын тулд харилцан бие биенээ дэмжих төрөл бүрийн арга барилыг нэгтгэх болно. 3) Хэрэгжилт Төслийг ЗТХЯ-ны удирдлага дор УБТЗ/МТЗ хэрэгжүүлнэ.
Байгаль	Авто замын хөдөлгөөнөөс илүү эрчим хүчний хэмнэлттэй төмөр

орчин, нийгмийн нөлөө	замын ачаа тээврийн хөдөлгөөнийг дэмжсэнээр эерэг үр нөлөө гарах ба хүлэмжийн хийн ялгаруулалт буурна.
Тайлбар	13 дугаартай төсөл нь энэ төслөөс үргэлжилнэ.

**Төслийн дугаар: III6**

Төслийн нэр	<b>Улаанбаатар хотын тойруу зам, сүлжээг хөгжүүлэх төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот, хотын ойр орчим
Хэрэгжүүлэгч агентлаг	ЗТХЯ, Төв аймаг, Нийслэл хотын захиргаа
Зорилтууд	1) Улаанбаатар хот болон түүний орчмын замын хөдөлгөөний урсгалыг сайжруулах; 2) Улаанбаатар хот болон түүний орчмын нутаг дэвсгэр дэх логикийн сүлжээний олон талт байдлыг сайжруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Улаанбаатар хотод зам хөндлөн гарах хөдөлгөөн болон түгжрэл буурсан байх; 2) Улаанбаатар хотын логикийн сүлжээ болон бүс нутгийн хэмжээний хүргэлтийн сүлжээний найдвартай байдал сайжирсан байх.
Төслийн өртөг	1) 30-40 сая ам.доллар: хагас тойрог коридорыг хөгжүүлэх (хотын зах орчимд 30 км гол зам); 2) 40 сая ам.доллар: Улаанбаатар хотын хойд-урд чиглэлийг холбох.
Хэрэгжүүлэх хуваарь	2035 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Шинэ нисэх онгоцны буудал хүрэх хурдны замыг нээсний дараа бүс нутгийн болон улсын чанартай авто замын хөдөлгөөн Улаанбаатарын урд хэсгээр тойрон гарч Налайх, Зуунмод, нисэх онгоцны буудлаар дамжин Улаанбаатарын түгжрэлээс зайлсхийх ба шинээр хагас тойрог хэлбэртэй тээврийн коридор бий болно. Мөн ачааны терминалыг хотоос нүүлгэн шилжүүлэх төсөл (17 дугаартай төсөл) нь Улаанбаатар хотын тээврийн сүлжээг хөгжүүлэхэд ашиглаж болох газрыг хотын гол бүсэд бий болгох юм. 2) Төслийн танилцуулга Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байх боловч үүгээр хязгаарлагдахгүй. Хагас тойрог хэлбэртэй тээврийн коридорын хөгжлийн дагуу Улаанбаатар хотын автозамын сүлжээг сайжруулах, Улаанбаатар хотын сүлжээний хөгжил тухайлбал төмөр замын газар нутгийг хөндлөн гарах хойд-урд холболтыг хөгжүүлэх. 3) Хэрэгжилт ЗТХЯ нь Төв аймаг болон Улаанбаатар хотын захиргаатай хамтарч төслийг хариуцан хэрэгжүүлнэ.
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Улаанбаатар хотын тээврийн хөдөлгөөний ачааллыг бууруулснаар агаарын бохирдол багасах, эрчим хүчийг хэмнэх, түгжрэлийг багасах, хүргэлтийг сайжруулах зэрэг эерэг нөлөө гарна.
Тайлбар	13, 16 дугаартай төслүүдтэй холбоотой.

Төслийн дугаар: III7

Төслийн нэр	<b>Улаанбаатар хотын ачаа тээврийн терминалын газрыг ашиглан дахин төлөвлөлт хийх төсөл</b>
Байршил	Улаанбаатар хотын орчмын газар болон төмөр зам дагуух хотын төв газрууд
Хэрэгжүүлэгч агентлаг	УБТЗ/ Хотын захиргаа / Хувийн хөрөнгө оруулагчид
Зорилтууд	1) Хотын чиг үүргийг сайжруулах зорилгоор ачаа тээврийн терминалыг нүүлгэн шилжүүлснээр суларсан боломжтой газрыг дахин төлөвлөн барилгажуулах; 2) Хойд-урд шугамын хүчин чадлыг бэхжүүлэх төсөлд зориулсан сан бүрдүүлэхэд дахин төлөвлөлтийг ашиглах
Хүлээгдэж буй үр дүн	1) Улаанбаатар хотын түгжрэл буурна. 2) Улаанбаатар хотын үйл ажиллагааны хэт төвлөрлийг дагуул хотууд руу шилжүүлэх замаар бууруулна.
Төслийн өртөг	Төслийн зардлыг хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэн олох ашгаас гаргах болно.
Хэрэгжүүлэх хуваарь	2021-30: Улаанбаатар хот орчимд логистикийн шинэ парк байгуулах 2030-40: Бусад холбогдох бүтээн байгуулалт
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Улаанбаатар хотын төв хэсэгт төмөр замд суурилсан ачаа ачих, буулгах зориулалттай хэд хэдэн талбай байдаг боловч тэдгээр нь Энхтайваны өргөн чөлөөний дагуу байрладаг тул эргэн тойрны газруудаас тохиромжтой газар нь харьцангуй бага юм. АХБ-ны 2018 онд хийсэн судалгаагаар эдгээр ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг нэгтгэж, нисэх онгоцны шинэ буудлын ойролцоо шинээр баригдах ачаа тээврийн логистикийн төв рүү шилжүүлэхийг санал болгосон. Учир нь төмөр замын тойрон гарах зам (12 дугаартай төсөл) холбогдох юм. Сүүлийн үед БНХАУ-аас импортлох эрэлт төмөр замаас авто зам руу шилжих болсон шалтгаан нь Улаанбаатар хотын төмөр замын ачааны терминалын хүчин чадал сул, жижиг терминалын талбайд ачааны машинууд хэт төвлөрснөөс ачаа тээврийн операторууд хохирдог, терминалууд нь хүчин чадлаа өргөжүүлэх боломж хомс байдаг зэрэгтэй холбоотой. Терминалын байршил нь гол замын дагуух төмөр замын үйл ажиллагаанд түгжрэл үүсгэдэг. 2) Төслийн танилцуулга Төсөлд дараах бүрэлдэхүүн хэсгүүд багтсан боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: Улаанбаатар хотын ойролцоо логистикийн шинэ паркийг байгуулна. АХБ-ны зүгээс олон улсын нисэх онгоцны шинэ буудалтай ойр байрлах боломжтой газрыг санал болгосон. Шинэ логистикийн парк нь төмөр зам, авто зам, агаарын тээврийн үйлчилгээг нэгтгэх юм. Улаанбаатар хот руу дунд оврын ачааны машинаар хүргэх томоохон ачааг логистикийн шинэ паркад хүргэнэ. Ачаа буулгах, ачих талбайнуудыг худалдааны болон орон сууцны зориулалттай талбай болгон зарах эсхүл түрээслэнэ. Газар ашиглалтын журмыг хотын захиргаатай хамтран шинэчлэх хэрэгтэй. Төмөр замын тойрон гарах шугамыг хөгжүүлэх (13 дугаартай төсөл) эсвэл үйл ажиллагааны чадавхыг хөгжүүлэхэд (14 дугаартай төсөл) зориулж талбайг худалдах/түрээслэхээс олсон орлогыг ашиглана.

	Токио дахь Интер Шиодом, Японы Осака дахь Кита-Умэда зэрэг нь энэхүү төслийн хэрэгжүүлэлтийн үзэл баримтлалтай ижил төстэй. Өөрөөр хэлбэл, хотын төв хэсэг дэх бага ашиглалттай төмөр замын ачаа тээврийн талбайг дахин төлөвлөж, төмөр замын шинэ сүлжээг хөгжүүлэхэд тухайн талбайг дахин төлөвлөснөөс олох орлогоор санхүүжүүлэх юм. Энэхүү саналыг Улаанбаатар хотод зориулж боловсруулсан хэдий ч Дархан болон Эрдэнэтэд ашиглаж болно. 3) Хэрэгжилт Энэхүү төслийг УБТЗ-ын зохицуулалт дор хувийн хэвшлийн оролцоотойгоор, ТХХТ-ийн хүрээнд хэрэгжүүлнэ.
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Хотын хөгжилд ашиглагдаагүй төмөр замын газрыг шинэчлэн сайжруулах замаар хотын төвийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	13 дугаартай төсөлтэй холбоотой. (Улаанбаатар хотыг тойрч гарах төмөр зам)

Төслийн дугаар: III8

Төслийн нэр	<b>Хотын захын болон орон нутгийн тойруу замуудыг хөгжүүлэх төсөл</b>
Байршил	Эхний зорилтот хотууд: Эрдэнэт, Мөрөн; Хоёрдахь зорилтот хотууд: тогтоогүй байна.
Хэрэгжүүлэгч агентлаг	ЗТХЯ
Зорилтууд	Хот тус бүр рүү тойруу замаар дамжин гарах болон хөндлөн гарах хөдөлгөөнийг шилжүүлэх, тухайн хотын төвд тээвэрлэлтийн үр ашигтай ажиллагааг хэрэгжүүлэх
Хүлээгдэж буй үр дүн	Аймгийн төвүүдийн замын хөдөлгөөний түгжрэл багасна.
Төслийн өртөг	10-15 сая ам.доллар: Эрдэнэт хотод (15 км), 3-8 сая ам.доллар: Мөрөн хотод (5-15 км)
Хэрэгжүүлэх хуваарь	2030 он хүртэлх үе шаттай хөгжил
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Аймгийн төвүүдийн замын хөдөлгөөний түгжрэлийн асуудалтай хараахан тулгараагүй. Гэсэн хэдий ч ойрын арван жилийн хугацаанд зарим аймгийн төвүүдийн замын хөдөлгөөн болон хот хоорондын замын хөдөлгөөнийг уялдуулах шаардлага гарна гэж үзэж байна. Эрдэнэтийн хувьд хот хоорондын авто зам (Эрдэнэт-Булганы хурдны зам) хотын төвөөр дайрч өнгөрдөг бөгөөд хотын замын хөдөлгөөн, хот хоорондын хөдөлгөөн давхацдагаас хотын түгжрэл бий болж байна. Орхон, Булган аймгууд хот, суурин газраас зайлсхийх тойруу замыг боловсруулж, хоёр эгнээ бүхий хатуу хучилттай зам барих төлөвлөгөө боловсруулсан. Энэхүү төлөвлөгөөнд тойруу замын дагуу малын мах боловсруулах цогцолборыг хөгжүүлэх төлөвлөгөөг багтаасан болно. Мөрөн болон бусад аймгийн төвүүдийн хувьд одоогийн байгаа хот суурин газрууд нь хот хоорондын замын дагуу байгуулагдсан бөгөөд тойруу зам барих хөгжлийн зохистой төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна. Чойр, Сайншандын хувьд хот хоорондын гол замууд хотын захын хэсгээр дайрч байгаа тул тойруу зам шаардлагагүй. 2) Төслийн танилцуулга



	<p>Тойруу замын бүтээн байгуулалтын эхэнд замын хөдөлгөөний түгжрэл үүсэх магадлалтай хотуудын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж эсвэл шинэчилж ЖАЙКА-гийн ҮХЦТ боловсруулах төслийн багийн гаргасан замын хөдөлгөөний болон хотын хүн амын өсөлтийн хэтийн тооцоог тусгах хэрэгтэй. Төлөвлөгөө бүрт эдийн засгийн шинэ үйл ажиллагаа, тэдгээрийн байгууламжуудад зориулсан хотжилтын тэлэх талбай, тойруу замын трассын талбай зэргийг тусгаж өгнө. Хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг хотуудын одоогийн нөхцөл байдал болон замын хөдөлгөөний цаашдын эрчим зэргийг харгалзан тодорхойлох шаардлагатай.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ЗТХЯ нь БХБЯ зэрэг холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, төлөвлөлтүүдийг боловсруулах, сайжруулахад аймгийн удирдлагуудад чиглэл өгөх, тэдгээрийг хувийн хэвшлийн хэрэгжүүлж буй эдийн засгийн үйл ажиллагаатай уялдуулах үүрэгтэйгээр оролцоно.</p>
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Хотын төвүүд дэх замын хөдөлгөөний түгжрэл, зам тээврийн ослыг бууруулах, шатахуун зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
Тайлбар	

**Төслийн дугаар: III9**

Төслийн нэр	<b>Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудалд түшиглэсэн дагуул хот байгуулах төсөл</b>
Байршил	Төв аймаг, Сэргэлэн сум (Улаанбаатар хотоос 53км-ийн зайтай)
Хэрэгжүүлэгч агентлаг	Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ), Хувийн хэвшил
Зорилтууд	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын орчим байрлах шинэ дагуул хот байгуулах замаар аж үйлдвэр, логистик, олон улсын худалдаа болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд зориулсан шинэ бааз суурь бий болгох. Төсөл нь Улаанбаатар хотын эдийн засгийн үйл ажиллагаа болон хүн амын хэт төвлөрлийг бууруулахад хувь нэмрээ оруулах бөгөөд олон улсын гарцад тулгуурлан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана.
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Хүн амын тав тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.</li> <li>2) Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулна.</li> <li>3) Эдийн засгийн өсөлтийг хурдасгана.</li> </ol>
Төслийн өртөг	10.9 тэрбум ам.доллар.
Хэрэгжүүлэх хуваарь	2021-2022: мастер төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, зураг төсөл боловсруулах болон санхүүжилтийг зохион байгуулах зэргийг багтаасан бэлтгэл ажил 2023-: үе шаттайгаар хэрэгжүүлэх
Төслийн танилцуулга	<ol style="list-style-type: none"> <li>1) Үндэслэл</li> </ol> <p>Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал 2020 онд ашиглалтанд орохоор бэлтгэл ажил хангагдаж байна. Нисэх онгоцны шинэ буудлын төслийг газарзүйн байршлын хязгаарлалт, үйл ажиллагааны үр ашиггүй байдлаас болж хохирол үүсдэг байдлыг арилгах зорилгоор одоогийн Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлыг орлох, шинэ олон улсын агаарын гарц бий болгохын тулд санаачилсан болно. Нисэх онгоцны шинэ буудал нь 3600 метр нисэх, буух гүйлтийн замтай, 37,000 м2 талбай бүхий терминалын барилга</p>

	<p>байгууламжтай болно. Энэ нь жилд 3 сая зорчигчийг хүлээн авах хүчин чадалтай юм.</p> <p>Монгол Улсын Засгийн газар АХБ-ны тусламжтайгаар хэдийн түгжрэлтэй байгаа Улаанбаатар хотыг тойрч гарахын тулд одоо байгаа хойд-урд чиглэлийн төмөр замын хувьд төмөр замын тойрон гарах шугамыг барихаар төлөвлөж байна. Энэхүү тойрон гарах төмөр зам нь олон улсын нисэх онгоцны шинэ буудалд хүрэх бөгөөд ингэснээр тус нисэх онгоцны буудал олон улсын холимог тээврийн гарцын үүрэг гүйцэтгэх боломжтой болно.</p> <p>Улаанбаатар хотод хүн ам, эдийн засгийн үйл ажиллагаа хэт их төвлөрөсөн нь байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал үүсгэж, эдийн засгийн үйл ажиллагааны үр ашгийг бууруулж байна. Засгийн газрын бодлого нь хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, Улаанбаатар хотын хэт ачааллыг бууруулах явдал юм.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Монгол Улсын Засгийн газар нь Сэргэлэн сумын захиргаанаас санал болгосон 12,000 га талбай бүхий төслийн газрыг баталгаажуулсан болно. Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)-аас нисэх онгоцны буудлын дагуул хотын төсөлд зориулж мастер төлөвлөгөө боловсруулсан. Дагуул хот нь 350,000 хүн амтай байх ба газар ашиглалт, хувийн хөрөнгө оруулалтыг үйлдвэрийн, логикийн, эдийн засгийн чөлөөт бүс, аялал жуулчлалын бүс болон дэд бүтцийн барилга байгууламжууд зэрэгт оруулах боломжтой. 2038 он хүртэл нийт хөрөнгө оруулалтын зардлыг 10.9 тэрбум ам.доллар байхаар тооцсон ба үүнд төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтыг оруулсан.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Цаашид мастер төлөвлөгөөнд нэмэлт оруулах зорилгоор хувийн салбарын зүгээс хийх дүгнэлт, хөрөнгө оруулалт хийх боломж, төрийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг зах зээлийн боломж болон санхүүгийн зохицуулалт, санхүүжилтийн эрсдэл, үнэт цаасны эргэн төлөлт, ялангуяа усны нөөцийн олдоц зэрэг төрөл бүрийн аргуудыг багтаасан дүн шинжилгээ хийх шаардлагатай байна. Нарийвчилсан зураг төслийг хэрэгжүүлэхийн өмнө бэлтгэл ажлыг хангана.</p>
<p>Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл</p>	<p>Улаанбаатар хотын одоо байгаа барилгажсан газар нутгийн хувьд байгаль орчны эрсдлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ. Эрчим хүчний эх үүсвэр, бохир ус болон хатуу хог хаягдлын менежментийн асуудлыг анхааралдаа авч, байгаль орчинд ээлтэй нисэх онгоцны шинэ буудлын хот байгуулах арга хэмжээ авах шаардлагатай.</p>

Төслийн дугаар: III10

Төслийн нэр	<b>Орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэх</b>
Байршил	Аймгийн төв хотууд
Хэрэгжүүлэгч агентлаг	ЗТХЯ
Зорилтууд	(1) Монгол Улсын дотоодын агаарын тээврийн нислэгийн сүлжээг нэмэгдүүлэх, (2) Дотоодын агаарын тээврийн үйлчилгээг өргөн уудам нутаг дэвсгэрийн алслагдсан бүс, орон нутгийн иргэдэд хүргэх
Хүлээгдэж буй үр дүн	Өөр бүс нутгийн иргэд хоорондын харилцаа холбоог сайжруулах, Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд хувь нэмэр оруулах
Төслийн өртөг	Дотоодын агаарын тээврийн нислэгийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлт: 2.0 сая. ам. доллар Нисэх онгоцны буудлын байгууламж, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж: 12 сая. ам. доллар Үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэхэд татаас олгох: жилд 0.5 сая. ам. доллар
Хэрэгжүүлэх хуваарь	Дотоодын агаарын тээврийн нислэгийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлтийг 2021-2022 онд хийж гүйцэтгэнэ. II үе шатанд орон нутгийн зарим нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, зураг төслийг боловсруулна. II, III үе шатанд хэрэгжүүлнэ.
Төслийн танилцуулга	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орсноор нийслэл хот ба Ази, Европын бусад хотуудын олон улсын агаарын тээврийн харилцаа сайжирна. Одоогийн байдлаар орон нутгийн агаарын тээврийн хүртээмж хангалтгүй, Улаанбаатар хотыг орон нутгийн хотуудтай холбох тогтмол нислэг хязгаарлагдмал байна. Дотоодын агаарын тээврийн үйлчилгээг өргөн уудам нутаг дэвсгэрийн алслагдсан бүс, орон нутгийн иргэдэд хүргэхийн тулд дотоодын агаарын тээврийн нислэгийн сүлжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Орон нутгийн зарим нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон хөгжүүлж, эхний ээлжинд баруун болон зүүн бүсэд Ховд, Чойбалсан хотуудын нисэх онгоцны буудлыг сонгох боломжтой. Төслийн хүрээнд шаардлагатай бол онгоц хөөрч, буух зурвас болон хил, гаалиар нэвтрүүлэх үйл ажиллагаа бүхий терминалын байгууламжийг сайжруулан өргөтгөж, алс хэтдээ олон улсын нислэгийн шууд үйлчилгээ үзүүлэхэд аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулна. Ховд хотыг БНХАУ-ын Өрөмч хот, ОХУ-ын Новосибирск хоттой, Чойбалсан хотыг БНХАУ-ын Зүүн хойд бүс нутагтай холбох боломжтой юм. Түүнчлэн төлөвлөлтийн үе шатанд бүс нутгийн нисэх онгоцны буудлын үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай. Төлөвлөлтийн үе шатанд АНУ-ын Агаарын тээврийн үйлчилгээний байгууламж, Япон улсын бүс нутгийн нислэгийн үйл ажиллагаанд татаас олгох тогтолцоо зэргийг судалж, Монгол Улынд бүс нутгийн агаарын тээврийн үйлчилгээг дэмжих татаас олгох системийг авч үзэх шаардлагатай.

Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Төлөвлөх, зураг төсөл боловсруулах явцад нийгэм, байгаль орчны асуудлыг авч үзэх шаардлагатай.
Тайлбар	Япон улсад үндэсний агаарын тээврийн сүлжээг хөгжүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор зангилаа нисэх онгоцны буудалд газардах, тийрэлтэт түлшний албан татвар, нисэх онгоцны буудлын барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын 50 хүртэлх хувийн татаас олгодог. Японд бүс нутгийн агаарын тээврийн үйлчилгээний тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2019 оны санхүүгийн жилд ойролцоогоор 27 сая ам.долларын татаас олгосон.

Төслийн дугаар: III11

Төслийн нэр	<b>Бүсийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх</b>	
Байршил	Томоохон хотууд	
Хэрэгжүүлэгч агентлаг	БХБЯ	
Зорилтууд	(1) Хотын зэрэглэлийн хувьд дээгүүр эрэмбэлэгдэх томоохон хотуудын зарим барилга, байгууламжийг сайжруулах, (2) Бүс нутгийн хөгжлийг дэмжих хотын зарим чиг үүргийг хуваарилах	
Хүлээгдэж буй үр дүн	Бүс нутгийн онцлогт тулгуурлан тухайн бүсийн бие даасан хөгжлийг хангах	
Төслийн өртөг	Үе шат бүхий хэрэгжүүлэх арга хэмжээний (ач холбогдолоор нь эрэмбэлэн) төлөвлөгөөг боловсруулах: \$2.0 сая. ам. доллар Хэрэгжүүлэхэд нэг хотод ойролцоогоор \$10 сая. ам. доллар	
Хэрэгжүүлэх хуваарь	2021-2022 онд үе шат бүхий хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна. II-III үе шатанд хэрэгжүүлнэ.	
Төслийн танилцуулга	ҮХЦТ-ий хүрээнд хотуудын зэрэглэлд дүн шинжилгээ хийж, хотын зэрэглэлийн хувьд дээгүүр эрэмбэлэгдсэн хотуудын чиг үүргийг бэхжүүлэх зорилгоор хотын зэрэглэл, чиг үүргийг санал болгосон. Хотын эдгээр чиг үүрэг нь бүс нутгийн онцлог, заяагдмал нөөц баялагт тулгуурлан тухайн бүс нутгийн бие даасан хөгжлийг дэмжинэ. Бүсийн хөгжлийн тулгуур төв хот, орон нутгийн хөгжлийн төв хотын үндсэн чиг үүргийг доор нэгтгэн үзүүлэв.	
	Хот	Үндсэн чиг үүрэг
	Өлгий	Байгаль, соёлын аялал жуулчлалын төв.
	Улаангом	ОХУ-тай хийх худалдаа, арилжааны төв, Барилгын материал, бараа бүтээгдэхүүн түгээх төв.
	Ховд	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх биологийн олон янз байдал, чацаргана боловсруулах чиглэлээр дээд боловсрол олгох, судалгаа шинжилгээ хийх, Баруун аймгийн аялал жуулчлалын зангилаа, Барилгын материал, хангалтын төв.
	Сүхбаатар	Хилийн худалдааны төв.
	Дархан	Газар тариаланд шинэ технологи нэвтрүүлэх төв.
	Эрдэнэт, Булган	Транзит худалдаа, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээний төв.
	Цэцэрлэг	Төвийн бүсийн МХХТ-ийн төв, Өвлийн аялал жуулчлалын төв.
	Улиастай	Баруун аймгуудын төрийн үйлчилгээний төв.
	Алтай	Байгалийн, өв соёлын, эрүүл мэндийн аялал жуулчлалын төв,

		Боловсрол, эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын төв, Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх судалгааны төв.
	Баянхонгор	Эрүүл мэндийн аялал жуулчлалын төв.
	Арвайхээр	Логистикийн төв, Байгаль, соёлын аялал жуулчлалын дэд төв.
	Хархорин	Түүх соёл, аялал жуулчлалын төв.
	Мандалговь	Монгол Улсын өмнөд бүсийн логистикийн төв.
	Чойр	Цэвэр эрчим хүчний технологийн төв, Логистикийн төв.
	Сайншанд	Логистик болон аялал жуулчлалын үйлчилгээний төв.
	Замын-Үүд	Хилийн худалдаа, аялал жуулчлалын төв.
	Чойбалсан	Олон улсын логистик, бизнесийн төв, Зүүн бүс дэх аялал жуулчлалын бааз.
	Баруун-Урт	Нүүдлийн мал аж ахуйг дэмжих бааз.
	Өндөрхаан	Зүүн бүсийн аймгуудын аялал жуулчлалын түшиц газар, Барилгын материал нийлүүлэх бааз.
	Эдгээр томоохон хотуудын чиг үүргийг бэхжүүлэх зорилгоор ус хангамж, ариутгах татуурга, авто зам, нийгмийн болон олон нийтийн барилга байгууламжийг сонгон сайжруулна.	
Байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл	Төлөвлөх, зураг төсөл боловсруулах явцад нийгэм, байгаль орчны асуудлыг авч үзэх шаардлагатай.	
Тайлбар		

Төслийн дугаар: III12

Төслийн нэр	<b>Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл</b>
Байршил	Говийн бүс дэх уул уурхайн бүтээн байгуулалт
Хэрэгжүүлэгч агентлаг	Эрчим хүчний яам (ЭХЯ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Дэлхийн банкны санхүүжилттэй Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) нь Сангийн Яам (СЯ), Орон нутгийн засаг захиргаа, Голын сав газрын захиргаа (ГСГЗ)-тай хамтран ажиллана.
Зорилтууд	1) Уул уурхайн салбарын ус хангамжийг нэмэгдүүлэх; 2) Уурхайн талбайн ойролцоох хөдөө орон нутгийн ус хангамжийг сайжруулах.
Хүлээгдэж буй үр дүн	Уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийг сайжруулна. Говийн бүсийн газар доорх усны нөөцийг хамгаална.
Төслийн өртөг	Нийт: 730-830 сая ам.доллар; (2015 онд ТЭЗҮ хийхэд 29.05 сая ам.доллар , 2017-2021 оны хооронд 700~800 сая ам.долларын санхүүжилтээр барилга угсралтын ажлыг хийхээр төлөвлөсөн байсан.) (Улсын төсөв: 10%, Орон нутгийн төсөв: -%, Гадаадын: 90%, Хувийн: -%)
Хэрэгжүүлэх хуваарь	2015: ТЭЗҮ-ийн өмнөх судалгаа, ТЭЗҮ (Дэлхийн банк, Австралийн ТФ-ээс санхүүжүүлсэн) 2025-30: Барилга угсралтын ажил
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Уурхайн үйл ажиллагааны улмаас усны хэрэгцээ нэмэгдэх төлөвтэй байна; Уул уурхайн үйлдвэрлэлийн усны хэрэглээ туйлын хангалтгүй байна;

	<p>Ашигт малтмалын ордын ойролцоо усны нөөц хомс байгаа нь уул уурхайн үйл ажиллагааг хязгаарлаж байна; Уул уурхайн шинэ ордын олборлолтын талаар шийдвэр гаргахад усны нөөцийн талаарх мэдээлэл дутагдалтай байгаа нь саад болж байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн Говийн бүс нутаг дахь уурхай болон бусад ус хэрэглэгчдийг усаар хангах зорилгоор Шүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл мөн Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийг 2025 онд багтаан хийж, барилгын ажлыг 2025 оноос хойш хийж эхэлнэ.</p> <p>3) Хэрэгжилт ЭХЯ, БОАЖЯ, УУХҮЯ нь Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн байршлыг тогтоох, бүтээн байгуулалтын хэмжээ, цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж болон хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд юм.</p> <p>4) Төслийн танилцуулга <u>Орхон гол:</u> Орхон гол нь Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал гол юм. Ус хурах талбай нь 53,786 км<sup>2</sup> ба түүний цутгал Туул, Хараа, Ерөө голын ус хурах талбайг оруулбал 143,372 км<sup>2</sup> болно. Голын нийт урт 1,124 км урт бөгөөд Монголын хамгийн урт гол болно. Сэлэнгэ мөрөн нь Байгал нуурт цутгадаг тул төсөл хэрэгжилттэй холбоотойгоор ОХУ-тай зөвшилцөх шаардлагатай.</p> <p><u>Ерөнхий танилцуулга:</u> Булдаж нягтруулсан бетон далан, ус хуримтлуулах сан, усны барилга байгууламж, шугам хоолой, шахуургын станц, дамжуулж, түгээх усыг цэвэршүүлэх систем зэргээс бүрдэнэ.</p> <p><u>Ус цуглуулах байгууламж:</u> Төслийн гол бүрэлдэхүүн хэсгийн нэг нь боомт бөгөөд Орхон голын ажиглалтын цэгээс 20 км орчим зайд байрлана. Боомтын өндөр 70 м, хярын урт 300 м, суурийн өргөн 80 м бөгөөд далангийн эзлэхүүн нь 675,000 м<sup>3</sup> байна. Боомтыг тухайн орон нутгаас олборлосон чулуун материалаар хийх бөгөөд гол хэсэгт нь бетон цутгана. Далангийн зураг төсөл нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд (БОНБУ) үндэслэх ба загас нэвтрэн гарах шийдэл зэргийг тусгасан байна. Ус зайлуулах болон оролтын байгууламж нь бетон барилга байгууламж байх ба 30 МВт-ын усан цахилгаан турбинтай байна. Энэхүү турбин нь далангийн байгууламж болон шахуургын 1-р станцыг цахилгаан эрчим хүчээр хангана.</p> <p>Төслийн хүрээнд 575 сая м<sup>3</sup> эзэлхүүнтэй хиймэл нуур бий болно. Хиймэл нуур нь 23 км<sup>2</sup> талбайг хамрах ба боомтоос дээш 18 км зайд үргэлжилнэ.</p> <p><u>Ус дамжуулалт, түгээлт:</u> Дамжуулах хоолой нь далангаас эхлэх ба шахуургын 1-р станцаар усыг шахна. Дамжуулах хоолойн диаметр 1500 мм-ээс эхлэх ба эцсийн хэрэглэгчдэд хүрэх хүртэл диаметр нь багасна. ТЭЗҮ-ээр эцэслэн тогтоогдох дамжуулах гол шугам хоолой нь Таван толгойн өмнөд хэсэг (613 км) рүү чиглэлтэй байх ба Мандалговь (96 км), Даланзадгад (85 км), Оюу толгой (123 км) руу салаална.</p> <p><u>Төслийн үр ашиг:</u> Орхон-Говь төсөл нь Монгол Улсад дараах үр ашгийг өгнө. Үүнд:</p>
--	---

Хоёр хот, найман сумын төвийн (нийт 50,000 хүн ам) ус хангамжийг сайжруулна.

100,000 га талбайг хамарсан хүн ам, мал амьтны усалгааны (135,000 мал, амьтныг услах хүчин чадалтай) 50 цэгийг бий болгосноор эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгох, суурин газрыг хөгжүүлэх, малчдын уламжлалт амьдралын хэв маягийг шинэчлэхэд хувь нэмэр оруулна.

Хүнсний ногоо тарих, малын тэжээлийн ургац, чанарыг сайжруулах зорилгоор 2000-3000 га талбайг усжуулна.

Уул уурхай, эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сайжруулсан, тогтвортой ус хангамжийг нэмэгдүүлнэ.

Ногоон байгууламжийн төслүүдийг дэмжиж, ус хангамжийг нэмэгдүүлснээр цөлжилтийг бууруулж, говийн экологийн тогтолцоог сайжруулна.


Цэвэр, найдвартай цахилгаанаар хангах усан цахилгаан станц нь Монгол Улсын эрчим хүчний салбарын бие даан байдлыг дэмжиж, гадаад худалдааны алдагдлыг бууруулахад хувь нэмэр оруулна.

Амралт, аялал жуулчлалын салбарт боломжуудыг бий болгож, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

Зураг 1 Төсөл хэрэгжих талбай



Зураг 2 Орхон гол дээрх далан



Зураг 3 Орхон-Говь төслийн ус дамжуулах шугам хоолойн чиглэл



Эх сурвалж: Үндэсний Ус хөтөлбөрийг дэмжих төв, “Орхон-Говь” төсөл, 2007 оны 10 дугаар сар.

Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэж буй ТЭЗҮ:

Дэлхийн банкны санхүүжилттэй “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” (МИНИС) төсөл нь уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх дотоодын

	<p>чадавхийг бэхжүүлэх зорилгоор дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх холбогдох судалгаа, үнэлгээг хийсэн. Монгол Улсын уул уурхайн салбар дэлхийн хэмжээнд хүрч байгаа бөгөөд ашигт малтмалын хайгуул хийсэн болон ашиглаж эхэлж буй стратегийн ач холбогдол бүхий зэс, алтны нөөцтэй Оюутолгой гэх мэт томоохон орд газрууд нь Монгол Улсын говийн бүс нутагт оршдог.</p> <p>Уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжлөөс хамаарч энэ бүс нутагт өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг хангах нь дэд бүтцийн чухал асуудлын нэг болж байгаа бөгөөд төсөл хэрэгжих бүс нутгийн усны хэрэгцээг хангах зорилгоор тухайн бүс нутгийн газрын доорх хязгаардлагдмал усны нөөцийг цааш хэрэглэж болох эсэх талаар үнэлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ говийн бүс нутгаас алслагдмал зайд орших усны нөөцийг ашиглах замаар орон нутгийн усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судлах шаардлага тулгарч байна.</p> <p>Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах төслийн техникийн судалгааг МИНИС төслийн хүрээнд хийнэ. Уг төслийн хүрээнд Орхон голоос ус татаж, Булган, Төв, Дундговь аймгийн нутгаар ус дамжуулах хоолойгоор дамжуулан Өмнөговь аймагт усны шинэ эх үүсвэрийг бий болгох юм. Төслийг хэрэгжүүлэхийн тулд далан, ус татах байгууламжийг Улаанбаатар хотоос 300 км, Булган аймгаас 30 орчим км зайд барина. Ус дамжуулах үндсэн хоолой нь гурван салбар хоолой, шахуурга, бусад дагалдах байгууламжтай байх ба ус дамжуулах хоолой дагуу байрлах Мандалговь, Даланзадгад хот болон Оюу Толгой уурхайд ус дамжуулна.</p> <p>Далан буюу боомтод түшиглэн 30 MW хүчин чадалтай УЦС барих ба Монгол Улсын хойд бүс нутагт эрчим хүч нийлүүлнэ. Сэлэнгийн сав газраас Өмнийн говийн бүс рүү ус татах санааг анх 1986 онд гаргаж байсан бөгөөд 2008 онд тус төслийн саналыг боловсруулсан байдаг.</p> <p><u>Гадаргын ус ашиглахтай холбоотой бодлогын баримт бичгүүд:</u></p> <p>Монгол Улсын томоохон голууд дээр боомт бүхий усан сан байгуулах ажлыг сүүлийн жилүүдэд амжилттай хийсэн. Завхан гол дээр булдаж нягтруулсан бетон боомт бүхий усан сангийн цогцолбор (Тайширын УЦС), Чоно харайхын гол дээр боомт, усан сангийн цогцолборыг (Дөргөний УЦС) байгуулан ашиглаж байна. Орхон голын урсацад тохируулга хийснээр хот, суурин газрууд, бэлчээр, газар тариалан эрхлэлт, үйлдвэрийн ус хангамж, аялал жуулчлал, загас үржүүлэг, цахилгаан эрчим хүч гарган авах зэрэгт урт хугацаанд үр ашигтай байна. Түүнчлэн говийн аж үйлдвэрийн бүсэд ус татаж, усан сангийн усыг ашиглан цахилгаан гарган авах нь эдийн засагт шууд нөлөө үзүүлнэ. Монгол Улсын УИХ, Засгийн газраас тус төслийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч дараах бодлогын баримт бичгүүдэд тусгасан байдаг. Үүнд:</p> <p>а) УИХ-ын 2008 оны 1-р сарын 31-ний 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 5-р тэргүүлэх чиглэлийн Стратегийн Зорилт 3 буюу “Гадаргын усны тодорхой хэсгийг аж ахуйн эргэлтэнд оруулан арвижуулах замаар хүн ам, үйлдвэрлэлийн усан хангамжийг шийдвэрлэх”;</p>
--	--



	<p>b) УИХ-ын 2008 оны 11-р сарын 21-ний 35 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын Засгийн газрын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Зорилт 3.5 буюу “Усны талаар баримтлах төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, гол мөрний урсацад тохируулга хийх, хуримтлагдсан усны нөөцийг шилжүүлэн ашиглах дэд бүтцийг байгуулах”;</p> <p>c) УИХ-ын 2010 оны 7-р сарын 15-ны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.1.7 заалт буюу “Монгол орны гадаргын усны ашиглалтыг сайжруулах үүднээс томоохон гол, мөрөнд урсацын тохируулга хийж, усан сан байгуулах”;</p> <p>d) УИХ-ын 2010 оны 5-р сарын 20-ны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Ус” үндэсний хөтөлбөрийн 3.3.2 заалт буюу “зарим голууд дээр урсацын тохируулга хийж, усан сан байгуулах, шилжүүлэн ашиглах талаар судалгаа хийх”;</p> <p>e) Засгийн газрын 2010 оны 11-р сарын 23-ны 304 дүгээр тогтоолоор батлагдсан “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2 буюу “2011-2015 онд эхний ээлжинд “Орхон-Говь” төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, усны нөөц дутагдалтай байгаа бүс нутгийг усаар хангах”;</p> <p>f) Засгийн газрын 2009 оны 10-р сарын 14-ний 320 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газраас эхний ээлжинд хэрэгжүүлэх томоохон төслийн жагсаалт” дахь “Орхон голоос говийн бүс нутгийн усны хэрэгцээг хангах төсөл”;</p> <p>g) Засгийн газрын 2010 оны 6-р сарын 16-ны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 3.1.3.3 буюу “Усны хэрэгцээг газрын доорх болон гадаргын усаар, хосолмол аргаар хангах бодлого барьж ирээдүйд өсөн нэмэгдэх усны хэрэгцээг “Орхон-Говь” болон “Хэрлэн-Говь” төслүүдийг хэрэгжүүлж хангах хувилбар боловсруулж шийдвэрлэх;</p> <p>h) Засгийн газрын 2010 оны 7-р сарын 21-ний 198 дугаар тогтоолоор батлагдсан “Концессийн зүйлийн жагсаалт”-ын 109 буюу “Орхон-Говь усан сан байгуулах”;</p> <p>i) УИХ-ын 2012 оны 9-р сарын 18-ны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4-т заасан “томоохон гол, мөрнүүдэд урсацын тохиргоо хийх замаар усан сан байгуулж бүс нутгийн усны хэрэгцээг хангах” зорилт;</p> <p>j) Усны үндэсний хорооны 2012, 2013 оны хуралдааны шийдвэр.</p> <p>k) Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.3.8 буюу “Хөх морьт төслийн хүрээнд өндөр уулын бүсийн Сэлэнгэ, Орхон, Эг, Хэрлэн, Ховд зэрэг томоохон гол мөрөнд урсацын тохируулгатай, олон зориулалтын цуваа усан сангууд байгуулах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж барилгын ажлыг эхлүүлнэ.”.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, БОАЖЯ нь Дэлхийн банктай хамтарч МИНИС төслөөр дамжуулан төслийг хэрэгжүүлж эхлэх алхмуудыг эхлүүлээд байна.</p>
<p>Байгаль орчин, нийгмийн нөлөө</p>	<p>Говийн бүсийн газар доорх усны нөөцийг хамгаалахад мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг ТЭЗҮ боловсруулах болон төслийн зургийг гаргах үе шатанд хийнэ. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ</p>

	<p>Уг төсөл нь Дэлхийн Банкны Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх 4.01 бодлогод зааснаар бүрэн хэмжээний байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг шаардах А ангиллын төсөлд хамаарна. Төслийн хамрах хүрээ, болзошгүй нөлөөллийг харгалзан байгаль орчин, нийгмийн нөлөөллийг үнэлэх ажил бүс нутгийн байгаль орчны үнэлгээ (БНБОУ)-нээс эхэлнэ. БНБОУ-ний хүрээнд Орхон гол дээр урсацын тохируулга хийх, Өмнийн говийн бүсэд усны шинэ эх үүсвэрийг бий болгохтой холбоотойгоор бүс нутгийн болон хуримтлагдах нөлөөллийг үнэлгээг хийнэ. Төслийн танилцуулга, хамрах хүрээг нарийвчлан тодруулах үүднээс БНБОУ-г төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаатай (ТЭЗУС) уялдуулсан. ТЭЗУС, БНБОУ-ний үр дүн нь төслийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн (цахилгаан станц, ус дамжуулах хоолой, зам, дагалдах байгууламжууд г.м.) байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний агуулга болон хамрах хүрээг тодруулахад зайлшгүй шаардлагатай бөгөөд тус үнэлгээг төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар шийдвэрүүдийг гаргахад нөлөөлөх техник, эдийн засгийн үндэслэлтэй нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэнэ.</p>
Тайлбар	<p><u>Хэрэгжилт:</u> Дэлхийн банкны санхүүжилттэй Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих (МИНИС) төслийн хүрээнд Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах төслийн ТЭЗҮ, байгаль орчин, нийгмийн нөлөөлөл үнэлгээг хийсэн. Тус төслийн зорилго Орхон голоос өмнийн Говь руу ус татах боломжийг судлах, өсөн нэмэгдэж буй усны хэрэглээний эрэлт хэрэгцээг хангах юм.</p> <p>Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг 2019 оны 5-р сарын 24-25-ны өдрүүдэд ОХУ-ын төлөөлөгчидтэй усан цахилгаан станц барих төслийн талаар зөвлөлдөх уулзалт хийсэн. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын 6-7 дүүрэгт 2017 оны 3-р сард байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБҮ) талаарх нээлттэй хэлэлцүүлгийг МИНИС төслийн нэгж, ЭХЯ-тай хамтран хийсэн. МИНИС төслийн нэгж Дэлхийн банкны дүрэмд үндэслэн ТЭЗҮ-ийн ажлын даалгавар, БОНБҮ-г шинэчилсэн.</p> <p>2016 оны 9-р сарын 20-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж, 10-р сарын 24-ний дотор тендерийн материалыг хүлээж авсан. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/52 тоот тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсан. Нийт гадаад, дотоодын 19 компани ТЭЗҮ хийх сонгон шалгаруулалтад, 12 компани БОНБҮ хийх сонгон шалгаруулалтад саналаа ирүүлсэн. Оросын тал ТЭЗҮ, БОНБҮ боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд зөвлөх компаниудыг томилохоосоо өмнө компаниудын хураангуй жагсаалтыг Дэлхийн банкинд хүргүүлнэ.</p> <p>Эх сурвалж 1): Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013</p> <p>Эх сурвалж 2): Үндэсний Ус хөтөлбөрийг дэмжих төв, “Орхон-Говь” төсөл, 2007 оны 10 дугаар сар.</p> <p>Эх сурвалж 3): Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах төслийн Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний Ажлын даалгавар (RFP No.: WB/MOF/MINIS/CS/QCBS/1.1.1. (d)/2016)</p>

## 10.4 Ногоон хөгжлийг дэмжих төслүүд

### Төслийн дугаар: IV1

Төслийн нэр	<b>Хөрс хамгаалах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх төсөл</b>
Байршил	Улсын хэмжээнд
Хэрэгжүүлэгч	ХХААХҮЯ Хувийн хэвшил
Зорилго	1) Газар тариалан эрхлэх замаар хөрс, газрын доройтлыг бууруулах, урьдчилан сэргийлэх; 2) Байгаль орчныг хамгаалах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Газрын доройтлыг бууруулах технологи, арга хэмжээг дэлгэрүүлнэ; 2) Доройтож, талхлагдсан газарт ургамлан бүрхэвч сэргэнэ.
Төслийн зардал	2,588 сая төгрөг + зөөлөн бүрэлдэхүүн хэсэг
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2 үе шаттай хэрэгжинэ
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Статистикийн мэдээгээр 1.4 сая га газрыг тариаланд тохиромжтой гэж тодорхойлсон. Үүнээс 1.0 сая га нь газар тариалан эрхлэхэд тохиромжтой газар гэж тодорхойлогддог бөгөөд хөрс хамгаалах үүднээс бол энэ нь тариалан эрхлэх хамгийн дээд хэмжээ юм. Одоогийн байдлаар газар тариалан эрхэлж буй олон өрх, аж ахуйн нэгжүүд хөрсний доройтолд санаа зовж буйгаа илэрхийлж байна. Газар тариалан эрхэлдэг нийт өрхийн 57%, аж ахуйн нэгжийн 67% нь хөрсний доройтолд их бага ямар нэг хэмжээгээр өртсөн гэж үзэж байна. Томхон аж ахуйн нэгжүүдийн хувьд тэд химийн бордоог их хэрэглэдгээс шалтгаалж тариалан эрхэлдэг өрхүүдтэй харьцуулахад нөхцөл байдал нь бүр ч хүндэрч байна. Газрын доройтлыг багасгахын тулд бордооны зохистой хуваарилалт, хэрэглэлт, хөрс хамгаалах арга туршлага, тухайлбал тэг элдэншүүлэлт гэж нэрлэгддэг тариалан эрхлэх аргыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Тогтвортой хөгжлийн зорилгод нийт тариалангийн талбайн 90% хувьд тэг элдэншүүлэлт ашигладаг болох зорилтыг дурдсан. 2) Төслийн бүрэлдэхүүн а) Тэг элдэншүүлэлтийн технологийн судалгаа: 2019 оны байдлаар 8 аймагт хөрс хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд нийт 123,000 га талбайг хамруулсан. Эдгээрээс Сэлэнгэ аймагт 45,000 га, Булган аймагт 20,000 га, Төв аймагт 15,000 га талбай тус тус хамрагдсан. Гэвч тус талбайг аймгуудын машин техникийн тоонд үндэслэж тооцдог бөгөөд нийт 631 машин техник байна. Тиймээс хэтийн тооцоог боловсруулахын тулд хөрс хамгаалалтын арга хэмжээний талаарх нарийвчилсан мэдээллийг цуглуулах шаардлагатай байна.

	<p>b) Газрын доройтлыг нөхөн сэргээх арга хэмжээ: жишээ нь тэг элдэншүүлэлтийн технологийн хувьд тариалангийн машин нь шаардлагатай бүхий л тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Монгол Улсын газар тариалан эрхлэгч өрх, аж ахуйн нэгжийн тариалангийн талбайн 50-иас дээш хувь нь хөрсний доройтолд их бага ямар нэг хэмжээгээр өртсөн байна. Хөрс хамгаалах нь байгаль орчинд ээлтэй тариалан эрхлэх бодлогын нэг хэсэг тул тэг элдэншүүлэлт зэрэг хөрс хамгаалах аргыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Тэг элдэншүүлэлт хийх машин нь шаардлагатай бүх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг. Өөр нэг технологийн жишээ бол полилактик хүчлийн өнхрүүлгэн үр суулгагч юм. Энэ бол хөрс, элсээр дүүргэгдсэн цилиндр хэлбэртэй сүлжиж хийгдсэн био-задрагч материал юм. Ургамлын үндэсний хөгжлийг усны хамгийн оновчтой хадгалалт, агааржуулалт, тэжээлийн хангамжаар дэмжиж өгдөг учир доройтсон газарт ургамалжилтыг сэргээж, ургац хураах боломж олгодог. Энэ аргыг дуслын усжуулалтын системтэй хослуулан ашиглавал усны хэрэглээ, ажиллах хүчийг хэмнэх боломжтой. Эдгээр технологийг цаг уурын ухаалаг газар тариалан гэж нэрлэдэг.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ХХААХҮЯ нь газрын доройтлыг бууруулах арга хэмжээг нэвтрүүлэх туршилтыг гүйцэтгэх байгууллага, байршлыг тогтоох, үйл ажиллагааны хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх үүрэгтэй ажиллана. ХХААХҮЯ нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэргэжлийн арга зүй өгөх зэрэг төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.</p>
<p>Байгаль орчин, нийгмийн нөлөө</p>	<p>Байгаль орчныг сэргээхэд ихээхэн эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа ч байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах болно. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл ажиглагдаж байвал хариу арга хэмжээ авах шаардлагатай.</p>

**Төслийн дугаар: IV2.1**

Төслийн нэр	<b>Хүнсний бүтээгдэхүүний хаягдлыг бууруулах төсөл</b>
Байршил	Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч	ХХААХҮЯ, БОАЖЯ, Улаанбаатар хот Хувийн хэвшил
Зорилго	<ol style="list-style-type: none"> <li>1) Нийгэм, эдийн засгийн шинэ үзэл санаатай уялдуулж хүнсний алдагдал, хаягдлыг эрс бууруулах;</li> <li>2) Дахин боловсруулж хэрэглэхэд суурилсан нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1) Улаанбаатар хот дахь хүнсний бүтээгдэхүүний алдагдал, хаягдлын хэмжээг тогтооно;</li> <li>2) Хүнсний алдагдал, хаягдлыг бууруулах хэрэгцээ, шаардлагын талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлнэ;</li> <li>3) Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж, бордоо болгон газар тариалан эрхлэхэд ашигладаг болно.</li> </ol>
Төслийн зардал	2,500 сая төгрөг + зөөлөн бүрэлдэхүүн хэсэг
Хэрэгжүүлэх	2 үе шаттай хэрэгжинэ.

төлөвлөгөө	
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Бордооны хэрэглээний тухайд үзвэл 2010 онд нийт тариалангийн талбайн 22%, үүнээс өрхийн аж ахуй 16%, аж ахуйн нэгж 23%-ийг тус тус борджээ. Улсын хэмжээгээр өрхийн аж ахуйн тариаланд байгалийн болон бусад органик бордоог бараг 100% хэрэглэж байна. Аж ахуйн нэгжүүдийн хувьд байгалийн болон органик бордоогоос бусад төрлийн бордоо ашиглах хувь нь дунджаар 6% байдаг. Монгол Улсын хүн ам 2030 онд 3.8 сая, 2040 онд 4.5 саяд хүрэх төлөвтэй байгаа тул хот суурин газрын, ялангуяа Улаанбаатар хотын хэрэгцээг хангахын тулд хүнсний үйлдвэрлэл тогтмол өсөх шаардлагатай. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд бордоог зохистой байдлаар хэрэглэх явдлыг хөрс хамгаалах арга техникийн хамт дэмжих шаардлагатай байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Төслийн хүрээнд хүнсний хог хаягдлыг органик бордоо болгон боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулна. Ингэхийн тулд Монгол Улс дахь хүнсний хог хаягдлыг өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийж, хүнсний хаягдлыг боловсруулах зорилгоор цуглуулах үр дүнтэй аргуудыг судална. Туршилтын үйлдвэрийг ажиллуулснаар нь хүнсний хог хаягдлыг Монгол орны цаг уурын нөхцөл байдалд тааруулан, боломжит технологийг ашиглан боловсруулалтыг үр дүнтэйгээр хийх нөхцлийг туршиж үзнэ.</p> <p>Хүнсний алдагдалтай холбоотой судалгаа: НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас 2009 онд дэлхий даяар үйлдвэрлэсэн бүх хүнсний бүтээгдэхүүний 32% нь хаягдсан эсвэл үрэгдсэн гэсэн тооцоог гаргажээ. Энэ тооцоог хүнсний жингээр бодсон. Илчлэг болгон хувиргаж тооцвол дэлхийн хүнсний алдагдал, хаягдал нь нийт үйлдвэрлэсэн хүнсний 24 орчим хувийг эзэлдэг. Эндээс үзвэл хүмүүст зориулагдсан хоолны илчлэгийн дөрөвний нэгийг нь хүмүүс эцсийн дүндээ хэрэглэдэггүй байна. Хүнсний алдагдал, хаягдал нь эдийн засаг, байгаль орчинд олон сөрөг нөлөө үзүүлдэг. Эдийн засгийн хувьд бол энэ нь үргүй зарцуулж буй хөрөнгө оруулалт гэсэн үг бөгөөд тариаланчдын орлогыг бууруулж, хэрэглэгчдийн зардлыг нэмэгдүүлнэ. Байгаль орчны хувьд хүнсний алдагдал, хаягдал нь олон янзын ноцтой сөрөг нөлөөлөл, тухайлбал хүлэмжийн хийг ихээр ялгаруулах, ус болон газар нутгийг үр ашиггүй хэрэглэхэд хүргэх бөгөөд энэ нь эргээд байгалийн экосистемийг алдагдуулж, үзүүлэх үйлчилгээ нь буурахад хүрдэг (Дэлхийн нөөцийн хүрээлэн, Хүнсний хомсдол, хаягдлыг бууруулах үйл ажиллагаа). Орлого болон хоол хүнсний алдагдлын хооронд эерэг хамаарал байгааг тогтоосон байна. Тогтвортой хөгжлийн зорилтын 12-рт нэг хүнд ногдох дэлхийн хүнсний хаягдлыг жижиглэнгийн болон хэрэглэгчийн түвшинд хоёр дахин багасгах, үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн явцад гарах болон ургац хураалтын дараах алдагдлыг бууруулах зорилготой юм.</p> <p>Дахин боловсруулах төхөөрөмжийг суурилуулах: хаягдал зайлуулах процессор ашигласнаар хог нь биологийн задралд орж, үнэр нь багасдаг. Хаягдлыг процессорт хийсний дараа бичил организмын тусламжтайгаар биологийн задрал эхэлж, эсэлтийн дэвсгэр болж хувирдаг. Үүнийг хагас жилд нэг удаа гаргаж авна. Эссэн дэвсгэр нь бүрэн задарснаар бордоо, хөрсний сийрэгжүүлэгч болдог. Үүнийг Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн тариалан эрхлэгчид рүү тээвэрлэнэ. Ийм маягаар Улаанбаатар хотын иргэд газар тариалан</p>

	<p>эрхлэхэд хувь нэмэр оруулах боломжтой болно. Дахин боловсруулж, хэрэглэхэд суурилсан нийгмийг дэмжиж сурталчлахын тулд сургуулиудад энэ тоног төхөөрөмжийг суурилуулж байгаль орчны боловсролын нэг хэсэг болгож ашиглана.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ХХААХҮЯ ба БОАЖЯ нь хүнсний хаягдал дахин боловсруулах системийг суурилуулах туршилтыг зохион байгуулах, байршлыг тогтоох, үйл ажиллагааны хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх эх үүсвэрийг дэмжих, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх үүрэгтэй ажиллана.</p> <p>Улаанбаатар хот нь холбогдох байгууллагатай гэрээний дагуу төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, түүнчлэн дахин боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах, мэргэжлийн засвар үйлчилгээ хийх технологийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр гэрээ байгуулна.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Байгаль орчныг сэргээхэд ихээхэн эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа ч байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах болно. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл ажиглагдаж байвал хариу арга хэмжээ авах шаардлагатай.
Тайлбар	

**Төслийн дугаар: IV2.2**

Төслийн нэр	<b>Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл*</b>
Байршил	Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч	ЗТХЯ Хувийн хэвшил
Зорилго	<p>Эцсийн зорилго: автомашины “Тараах үйлдвэрлэл”-ийн эсрэг “Хураах үйлдвэрлэл”-ийн нэг хэсэг болгон автомашиныг бүрэн дахин боловсруулалтад оруулах системийг бий болгох.</p> <p>Тодорхой зорилтууд нь:</p> <p>Улаанбаатар хотод хаягдал автомашиныг задалж дахин боловсруулах парк байгуулах;</p> <p>Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, хуучин автомашиныг хаяхтай холбоотой үүсдэг төрөл бүрийн хатуу хог хаягдлын улмаас үүсч буй байгаль орчны асуудлыг багасгах.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>Хуучин болон чанар муутай тээврийн хэрэгслээс шалтгаалах агаарын бохирдлыг бууруулна;</p> <p>Хуучин машинаас дахин эргүүлж ашигласан материал дээр үндэслэн төрөл бүрийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ;</p> <p>Ашиглалт дууссан тээврийн хэрэгслээс гарах хатуу хог хаягдлыг зохисгүй зайлуулснаас үүдэх байгаль орчны асуудлыг эрс багасна;</p> <p>ТХҮБ 2030-д заагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.</p>
Төслийн зардал	ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>2021-2022 он: Төсөл боловсруулах</p> <p>2021-2023 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх</p> <p>2023 оноос: Төсөл бүрэн хэрэгжих</p>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо 2018 онд 970,000-д хүрч, 2017 оныхоос 7.8%</p>

	<p>-иар буюу 70,100-аар өсчээ. Эдгээр тээврийн хэрэгслийн 789,200 буюу 81.3% нь 10-аас дээш жил ашиглагдсан байна.</p> <p>Хог хаягдлын талаарх олон нийтийн ойлголтыг өөрчлөх зорилгоор 2017 оны 5-р сард УИХ “Хог хаягдлын тухай” хуулийг баталж, эргэлтийн эдийн засгийн тухай ойлголтыг нэвтрүүлэв. УИХ-аас 2016 онд баталсан Монгол Улсын ТХҮБ 2030-д 2020 он гэхэд хог хаягдлын хэмжээг 20%, 2030 он гэхэд 40% бууруулах зорилт дэвшүүлсэн.</p> <p>2016 онд батлагдсан Ногоон хөгжлийн бодлогын үйл ажиллагааны хөтөлбөрт ЗТХЯ нь нийслэлийн Засаг даргатай хамтран авто тээврийн хэрэгслийг задлаж, зайлуулах төслийг хэрэгжүүлэхээр тусгасан. Засгийн газраас баталсан Авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлогод (2018-2026) "Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгсэл болон эдэлгээний явцад гарах хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах, түүхий эд ангийг ялгах" тухай заасан.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Улаанбаатар хотод тогтоосон 30 га газарт автомашины дахин боловсруулах парк байгуулах. Үүнд дараах багтана:</p> <p>Хаягдсан тээврийн хэрэгслийг хүлээн авах, хадгалах; Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг задлах төв; Хуучин сэлбэг хэрэгслийг дахин ашиглах туршилт, баталгаажуулалтын төв; Төмөр хийц, эд ангиудыг салгаж задлах, түүхий эд бэлтгэх төв; Хаягдал дугуй, аккумулятор, моторын тос, хайлш, хөнгөн цагаан эд анги, хуванцар эд анги, машины шил зэргийг дахин боловсруулах үйлдвэр; Дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг зайлуулах байгууламж.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ЗТХЯ нь энэхүү паркийн байршлыг тогтоох, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, санхүүжилтийн эх үүсвэрийг олох, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх үүрэгтэй засгийн газрын байгууллага байна.</p> <p>ЗТХЯ нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах мэргэжлийн арга зүй, шаардлагатай хөрөнгө оруулалт зэрэг төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр хувийн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулна. МҮХАҮТ гадаадын хөрөнгө оруулагчдыг уг төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахыг урина.</p>
<p>Байгаль орчин, нийгмийн нөлөө</p>	<p>Байгаль орчинд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>Нөөцийг ашиглах, дахин боловсруулж ашиглах талаарх олон нийтийн ойлголтыг өөрчлөх замаар нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлнэ.</p> <p>Хортой бодисуудын хаягдлаас үүдэн хөрс, усны бохирдол зэрэг сөрөг нөлөө үүсэх магадлалтай.</p>
<p>Тайлбар</p>	

Төслийн дугаар: IV2.3

Төслийн нэр	<b>Цементийн үйлдвэрийг ашиглан хатуу хог хаягдлыг эргэлтэд оруулах төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот, Эргэдэг зуух бүхий цементийн үйлдвэрүүд
Хэрэгжүүлэгч	БСШУСЯ (судалгаа, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохицуулалт); УУХҮЯ, БОАЖЯ, их дээд сургуулиуд, цементийн компаниуд.
Зорилго	Эцсийн зорилго: Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн утаа ялгаруулдаггүй нийгмийг байгуулах. Тодорхой зорилтууд: 1) Цементийн үйлдвэрийг үр дүнтэй ашиглах замаар үйлдвэрийн болон аюултай хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах; 2) Цементийн үйлдвэрийг ашиглах замаар материалыг эргэлтэд оруулах бүтцийн өөрчлөлтийг бий болгох. Үйлдвэрийн болон аюултай хог хаягдлыг боловсруулж, цементийн үйлдвэрийн кальцийн процесст ордог найрлага болгож ашиглах.
Хүлээгдэж буй үр дүн	Үйлдвэрийн болон аюултай хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулна; Хог хаях эцсийн цэг дээр ангилагдах хог хаягдлыг бууруулна.
Төслийн зардал	1 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2022 он: Төсөл боловсруулах 2021-2023 он: Ажиллах хүч бэлтгэх, материалын эргэлтэд дүн шинжилгээ хийх (1-р үе шат) 2023-2024 он: туршилтын төслийн ТЭЗҮ (2-р үе шат)
Төслийн танилцуулга	1) Үндэслэл а) Баримталж буй бодлого ба авч байгаа арга хэмжээ: Ногоон хөгжлийн бодлогод (2015-2030) хог хаягдлын менежментийн зорилтыг “хаягдлыг дахин боловсруулах хувь” 2020 он гэхэд 20%, 2030 он гэхэд 40% байхаар тодорхойлсон. Стратегийн зорилт нь нөөцийг хэмнэлттэй ашигладаг, хүлэмжийн хий бага ялгаруулдаг, хаягдалгүй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихэд чиглэнэ. Улаанбаатар хотын захиргаа хог хаягдлыг дахин боловсруулах, хатуу хог хаягдлын зохистой менежмент бүхий эко парк байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү төсөл нь хог хаягдлыг цахилгаан станцад, органик хаягдлыг дизель станцад, хиймэл чулуу үйлдвэрлэхэд зориулж хаягдал шилийг дахин боловсруулах үйлдвэр зэргээс бүрдэнэ. Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөний нийгэм эдийн засгийн хүрээнд хүн амыг 2040 онд 4.6 сая хүрнэ гэж тооцож байна. ДНБ-ий өсөлтийн зорилтот түвшинг үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарт 7.5-8.5%, уул уурхайн салбарт 2040 он хүртэл 5.0% байхаар тогтоосон. Хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжил нь үйлдвэрийн болон аюултай хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэхэд хүргэдэг. б) Үйлдвэрийн болон аюултай хог хаягдлыг дахин боловсруулж цементийн найрлагад ашиглах:




Цементийн үйлдвэрүүд нь чулуунцар (клинкер) үйлдвэрлэхэд ашиглах шохойн чулуу, цахиурлаг түүхий эд, төмрийн хүдэр болон бусад орцыг шатаах зуухаар тоноглогдсон байдаг. Зуухны температурыг 1450 °C ба түүнээс дээш түвшинд барьдаг. Зуухны өндөр температур нь найрлага дахь химийн шинж чанарыг тогтвортой байлгах, хорт хий ялгаруулахаас урьдчилан сэргийлэх давуу талыг бий болгоно. Зуухны өндөр температурын давуу талыг ашиглан доорх зурагт үзүүлсэн шиг үйлдвэрийн болон аюултай хог хаягдлыг цементийн найрлагад хөрвүүлж болно. Тухайлбал 2016 онд Японд 1 тонн цемент үйлдвэрлэхэд 0.474 тонн хатуу хог хаягдал ашиглажээ.

с) Монгол дахь цементийн үйлдвэрүүд

Манай улсад эргэлдэгч зуухаар тоноглогдсон цементийн үйлдвэр тав байдаг. Үүнд:

<u>Компанийн нэр</u>	<u>Байршил</u>	<u>Тооцоот хүчин чадал (тн/жил)</u>
Эрэл цемент	Дархан	175,000
Хөтөл цемент	Хөтөл	500,000
Налгар түшиг цемент	Налайх	100,000
Ховд цемент	Ховд	10,000
Монголын алт	Даланжаргалан	1,000,000

Цементийн жилийн тооцоот хэрэглээ 2012 онд 1.75 сая тонн/жил байв. 2018 онд цементийн хэрэглээ 969,600 тонн байсан ба үүнээс 933,800 тонныг дотооддоо үйлдвэрлэж, 35,800 тонныг импортлосон байна. Хүн амын тоо нэмэгдэж, эдийн засгийн үйл ажиллагаа сайжирч байгаа тул цементийн эрэлт нэмэгдэх болно.



2) Төслийн бүрэлдэхүүн

Төсөл нь доор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ.

1-р үе шат: Ажиллах хүч бэлтгэх, материалын эргэлтийн дүн шинжилгээ (эхний болон хоёр дахь жил):

Үйлдвэрийн болон аюултай хог хаягдлаас цементийн найрлага үйлдвэрлэдэг цементийн үйлдвэрт очиж үзнэ/туршлага судална; Цемент үйлдвэрлэх талаарх үйлдвэр дээрх сургалт, эрдэм шинжилгээний ажил;

	<p>Үйлдвэрийн болон аюултай хог хаягдлыг цуглуулах, боловсруулахад гүйцэтгэх үүрэг, хариуцлага, шаардлагатай зардал зэрэгт төвлөрсөн хатуу хог хаягдлын менежментийн системийн тойм гаргах; Монгол Улсын томоохон хотууд дахь үйлдвэрийн болон аюултай хог хаягдлыг цуглуулах гэх мэт чиглэл гаргах; ТЭЗҮ боловсруулах цементийн үйлдвэр, загвар хот сонгох. <u>2-р үе шат: Түршилтын төслийн ТЭЗҮ (3 дахь жил):</u> Цементийн үйлдвэрт үйлдвэрийн болон аюултай хог хаягдлыг боловсруулах технологийн схемийг бэлтгэх; Цементийн найрлага дахь үйлдвэрийн болон аюултай хог хаягдлын хамгийн зохистой холимгийг тодорхойлох; Цементийн үйлдвэрийг шинэчлэх зардлын тооцоо; Эдийн засаг, санхүүгийн шинжилгээ; Хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмж.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Энэхүү төслийг хэрэгжүүлэх гол байгууллага нь БСШУСЯ байна. БСШУСЯ нь УУХҮЯ, БОАЖЯ, их дээд сургуулиуд, цементийн компаниудын төлөөллөөс бүрдсэн төслийн зохицуулах хороог байгуулна. Их, дээд сургууль, цементийн компаниуд техникийн судалгааг хийх мэргэжилтэн, шинжээчдээр хангах болно. Төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлэх ажлыг яамдууд хариуцна.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Байгаль орчинд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Нөөц ашиглах, дахин боловсруулж ашиглах талаарх олон нийтийн ойлголтыг өөрчлөх замаар нийгмийн суурь нөлөөлөл үзүүлнэ.
Тайлбар	

**Төслийн дугаар: IV2.4**

Төслийн нэр	<b>Эко-парк байгуулах төсөл *</b>
Байршил	Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч	ЗАА Эко Парк Улаанбаатар ХХК буюу Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны гишүүд (17 хувийн хэвшлийн компани)
Зорилго	<ol style="list-style-type: none"> <li>1) Дахин боловсруулж болох хог хаягдлыг сонгох;</li> <li>2) Хаягдлыг дахин боловсруулсан шинэ нөөц болгон хувиргах;</li> <li>3) Барилгын хог хаягдал, ашиглалтаас гарсан том хаягдал дугуй, үйлдвэр компаниас гарсан хорт бодисыг дахин боловсруулах.</li> </ol>
Хүлээгдэж буй үр дүн	Хог хаягдлыг дахин боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эрчим хүч болгон дотоод, гадаад зах зээлд борлуулах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн хог хаягдлыг дахин боловсруулах 20 үйлдвэр барина.
Төслийн зардал	108 сая ам.доллар (хоёр эко-парк байгуулах) Хувийн хэвшлийн санхүүжилтээр: Барилга, байгууламж, технологи; Улсын болон Нийслэл хотын төсөв, хандивлагч байгууллагуудын санхүүжилтээр: Эко паркийн дэд бүтэц, цахилгаан хангамж, авто зам.
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2016-2018 он: Төсөл боловсруулах 2018-2021 он: Төслийг хэрэгжүүлэх 2021-2032 он: Төсөл бүрэн хэрэгжих

Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол Улсад хатуу хог хаягдлыг зайлуулах олон үйл ажиллагаатай холбоотой төлөвлөлт, технологи, байгууламжийн хүчин чадал хомс байгаа нь томоохон бэрхшээл болж байна. Уламжлалт амьдралын хэв маягаас зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотойгоор хүн амын тоо огцом өсч, хэрэглээний хэв маяг өөрчлөгдөж, хог хаягдлын хэмжээ нэмэгдэж, хог хаягдлын менежменттэй холбоотой асуудлууд улам бүр хүндэрч байна.</p> <p>Монголчууд хог хаягдлыг ялгаж салгах дадал туршлагагүй, хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой хууль, эрх зүйн орчин боловсронгуй бус. Түүнчлэн айл өрх болон үйлдвэрийн аль алины хатуу хог хаягдлыг ялгаж салгахгүйгээр хаядгаас болж Улаанбаатар хотын хоёр хогийн цэг ихэвчлэн хэт ачаалалтай байдаг.</p> <p>Түүнчлэн мэдлэг, ухамсар дутагдсанаас болж хууль бусаар хог хаях үзэгдэл зөвхөн Улаанбаатарт төдийгүй бусад хот сууринд өргөн тархсан байна.</p> <p>Европын холбооноос санхүүждэг томоохон хөтөлбөр болох БНЧУ-д төвтэй SWITCH-Asia хөтөлбөр нь 2016 оноос барилгын хог хаягдлыг зохистой менежментэд хувь нэмэр оруулах төслийг хэрэгжүүлж байна. Эко парк байгуулах төслийг нь энэ төсөлтэй уялдуулж, төслөөс туршлага судлах шаардлагатай.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Энэ төслөөр Улаанбаатар хотын Нарангийн энгэр (81.47 га), Цагаан даваа (92.6 га) гэсэн хоёр байршилд эко-парк байгуулна. Энэхүү төсөл нь хог хаягдлыг цахилгаан станцад, органик хаягдлыг дизель станцад, хиймэл чулуу үйлдвэрлэхэд зориулж хаягдал шилийг дахин боловсруулах үйлдвэр зэрэг хэд хэдэн системээс бүрднэ. Дахин боловсруулсан материалыг ашиглан гар урлалын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэснээр жуулчдын сонирхлыг татахуйц орон нутгийн онцлог бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг 110.3 дугаартай төслийн хэрэгжилттэй уялдуулан бий болгож болох юм.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>Эко Парк Улаанбаатар ХХК буюу Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны гишүүдээс (17 хувийн хэвшлийн компани) бүрдсэн компани нь барилга, байгууламжуудын барилга угсралтыг хариуцна.</p> <p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба цахилгаан хангамж, авто замын бүтээн байгуулалтыг хариуцна. Төслийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (цахилгаан, дулаан), Улаанбаатар хотын хөгжлийн корпорациас дэмжиж болно.</p> <p>Шинээр бий болох ажлын байрны тооцоо:</p> <table border="1" data-bbox="587 1648 1267 1798"> <thead> <tr> <th>Эко парк</th> <th>Ажлын байр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нарангийн энгэр</td> <td>270</td> </tr> <tr> <td>Цагаан даваа</td> <td>371</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>641</td> </tr> </tbody> </table>	Эко парк	Ажлын байр	Нарангийн энгэр	270	Цагаан даваа	371	Нийт	641
Эко парк	Ажлын байр								
Нарангийн энгэр	270								
Цагаан даваа	371								
Нийт	641								
Байгаль орчин, нийгмийн нөлөө	1) Байгаль орчинд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.								

	<p>2) Хог хаягдлыг дахин зохистой боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр агаар, хөрс, усны бохирдлыг мэдэгдэхүйц бууруулах боломж олгоно. Нарангийн энгэр, Цагаан даваа орчмын хог хаягдлын цэгүүдэд хог түүдэг хүмүүсийг дахин боловсруулах үйлдвэрт ажиллуулснаар тэдэнд ажиллаж амьдрах нөхцлөө сайжруулах боломж олгоно.</p>
Тайлбар	

**Төслийн дугаар: IV3.1**

Төслийн нэр	<b>Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл*</b>
Байршил	Бүх томхон хотуудад
Хэрэгжүүлэгч	БХБЯ
Зорилго	<p>Эцсийн зорилго: Гэр хорооллыг цаашид дахин төлөвлөлт хийхэд зохицсон бүтцэд оруулах. Тодорхой зорилт: Гэр хороололд газар олгох талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>1) Хотжилтын зохисгүй тэлэлтээс урьдчилан сэргийлнэ; 2) Цаашдын бүтээн байгуулалтын төслүүдийн техник эдийн засгийн үндэслэлийг сайжруулна.</p>
Төслийн зардал	500,000 ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>2021 он: Төсөл боловсруулах 2022 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2023 оноос: Төсөл бүрэн хэрэгжих</p>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл Хот суурин газарт шилжин ирэгсэд тухайн хотоос гаргасан журмын дагуу газар эзэмшинэ. Улаанбаатар хотын гэр хороолол нь барилгажсан талбайн бараг 50%-ийг эзэлж байгаа бөгөөд зохих дэд бүтэц байхгүйн улмаас хүрээлэн буй орчныг ихээр бохирдуулдаг. Түүнчлэн гэр хорооллын зарим хэсгүүд хотын төв хэсгийн байршил сайтай газруудыг барилгажилтад үр дүнтэй ашиглах бололцоог хааж байна. Монгол Улсын Засгийн газар нь газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрх шилжүүлэх тогтолцоог бүрдүүлж, барилгажсан хэсгийн газар ашиглалтыг сайжруулах, амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Гэхдээ төсөл хэрэгжүүлэхэд учирдаг саад бэрхшээлийн</p>

	<p>нэг нь санхүүгийн асуудал байдаг нь ойлгомжтой. Нөгөөтэйгүүр нам байшин барилга, хүн амын нягтрал бага зэргээс үүдэн гэр хороолол нь агаар цэвэр, гудамжинд тусах нарны гэрэл сайн, нэг хүнд ногдох зай талбайн хэмжээ их, шилжин ирж суурьших айл өрхөд хямд тусдаг зэрэг амьдралын нөхцөл сайн байх давуу талтай. Энэ нь хотын хөгжлийг дагалдан гэр хорооллын үүрэг, байршил, шаардагдах дэд бүтэц нь ч өөрчлөгдөж байна гэсэн үг юм.</p> <p>Гэр хорооллын шинэ хэсгүүд, ялангуяа ойрын жилүүдэд хурдан хөгжих хандлага бүхий их хэмжээний гэр хороололгүй орон нутгийн төв суурингуудад цаашдаа дахин төлөвлөлтийг уян хатан байдлаар хэрэгжүүлэх боломжтой юм.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Энэхүү төсөл нь а) гэр хороололд орлогод нийцсэн орон сууц барих, б) цаашид хийгдэх дахин төлөвлөлтийн уян хатан байдлыг хангах зорилго бүхий гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулна.</p> <p>Эдгээр дүрэм, журмуудад гэр хорооллын төлөвлөлттэй холбоотойгоор нийтийн эзэмшлийн болон өмчлөх, эзэмших эрх бүхий газруудын төлөвлөлт, нөхцөлүүдийг тусгана. Үүнд: 1) байгууллагын үүрэг, хариуцлага, 2) гэр хорооллын төлөвлөлтийн үзэл баримтлал, хүн амын төлөвлөлт, 3) авто зам, цэцэрлэгт хүрээлэн, ус зайлуулах суваг, нийтийн эзэмшлийн барилга байгууламжийг барьж байгуулах зорилгоор газар олгох концепц, 4) замын өргөний хэмжээ, цэцэрлэгт хүрээлэнгийн талбай ба барилгын талбай, 5) шалны талбайн хэмжээ, барилгын талбай ба өндөр, 5) барилга, байгууламж хоорондын зай зэрэг зохицуулалтууд багтсан байна.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БХБЯ дүрэм, журам, заавар, нормыг боловсруулж гаргах үүрэг хүлээнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Дахин төлөвлөлтийн төслөөс нийгэмд үзүүлж болох сөрөг нөлөөллийг бууруулах, цаашид тохижилтгүй гэр хорооллын хэмжээг багасгах замаар хүрээлэн буй орчны бохирдлын эрсдлийг бууруулна.
Тайлбар	

**Төслийн дугаар: IV3.2**

Төслийн нэр	<b>Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл*</b>
Байршил	Орон нутгийн хотууд
Хэрэгжүүлэгч	БОАЖЯ, БХБЯ орон нутгийн засаг захиргаатай хамтарч ажиллана
Зорилго	Гэр хорооллын жорлон, бохир ус зайлуулах системийг сайжруулах замаар эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Орон нутгийн хот, хөдөөгийн хүмүүсийн эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна. 2) Усны нөөцийг бохирдлоос сэргийлэх ажлыг сайжруулна.
Төслийн зардал	Нийт: 157,575 сая төгрөг 2014-2016 он: 42,075 сая төгрөг, 2017-2021 он: 115,500 сая төгрөг (Улсын төсвөөс 10%, орон нутгийн төсвийн -%, гадаадын хөрөнгө оруулалт 10%, хувийн хэвшил 80%)
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2024 он
Төслийн танилцуулга	1) Үндэслэл

	<p>Хөдөөгийн хүн амын 59% нь ундны усаар хангагдаж, 41% ариун цэврийн байгууламжтай байгаа нь газар зүйн байршил, орлого, хүйсийн ялгааг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна (ДЭМБ/НҮБХС-ийн ХХТ, 2017).</p> <p>Хяналтын хөтөлбөрийн тайланд тусгаснаар хотод оршин сууж буй иргэдийн 95% нь ундны усаар хангагдаж байсан бол хөдөөгийн хүн амын 59% ийм түвшний үйлчилгээг авч байжээ. Ариун цэврийн байгууламжийн хувьд ч хот, хөдөөгийн ялгаа их буюу хотын хүн амын 66 хувь нь энгийн ариун цэврийн байгууламжтай байсан бол хөдөөд зөвхөн 41 хувь нь жорлонтой байжээ. Хөдөөгийн хүн амын 31% нь жорлонгүй байна. Тус тайланд тусгаснаар гарын саван, гар угаах газартай айл өрх улсын дунджаар 72% (хөдөөгийн айл өрхийн 49%, хотын айл өрхийн 81%) байгаа нь зарим үзүүлэлт сайжрах хандлагатай байгааг харуулж байна (ДЭМБ/НҮБХС-ийн ХХТ, 2017).</p> <p>Монгол Улсад усны бохирдолтой холбоотой дараах асуудлууд тулгарч байна.</p> <p>Эрсдэл, өвчлөлийг бууруулахын тулд гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах шаардлагатай байна.</p> <p>Гэр хороололд шаардлага хангасан ариун цэврийн байгууламж дутмаг байна.</p> <p>2010 онд 41.400 удаа халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэний 30% нь устай холбоотой өвчин (гепатит ба суулгалт) байжээ. Эдгээр халдварт өвчин нь цэвэр усны хүртээмжгүй байдал, ариун цэврийн байгууламж шаардлага хангаагүйгээс үүдэлтэй юм.</p> <p>Хөдөө орон нутагт шаардлага хангасан ариун цэврийн байгууламж хангалтгүй байгаа (69%) ба амьжиргааны боломжтой иргэдийн 25% нь, ядуу иргэдийн 48% нь шаардлага хангасан ариун цэврийн байгууламжгүй байна.</p> <p>Сумын төвүүдэд бохир ус цэвэрлэх байгууламж дутмаг байна.</p> <p>Сумын төвүүдэд сайжруулсан ариун цэврийн байгууламж дутмаг байна.</p> <p>МХЗ-ын зорилт нь 2015 он гэхэд шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай хүн амын эзлэх хувийг 40% (хотын хүн амын 50%) хүртэл нэмэгдүүлэх, төвлөрсөн ариун цэврийн системд холбогдсон орон сууцны айл өрхийн тоог 30%-д (эсвэл хотын хүн амын 44%) хүргэх байв.</p> <p>Цэвэршүүлээгүй усыг шууд гол руу эсвэл хөрсөнд хаядаг.</p> <p>Усан сан, уст цэг орчмын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хангалттай түвшинд тордож, ашиглах шаардлагатай байна.</p> <p>Ус бохирдуулагчдад төлбөр тооцох зохицуулалт үр дүн багатай байна. Эдгээр асуудлууд нь гэр хороололд амьдарч буй өрхүүдийн эрүүл ахуйд шууд болон шууд бусаар нөлөөлж байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Гэр хорооллын жорлон, бохир ус зайлуулах системийг сайжруулна. Оршин суугчдын санхүүгийн боломж хязгаарлагдмал тул Улаанбаатар хотын гадна байрлах эко болон био жорлонгийн хөрөнгө оруулалт бага байх төлөвтэй байна.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БОАЖЯ, БХБЯ нь гэр хорооллын ариутгах татуургын байгууламжийн байршил, хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ажиллана.</p>
<p>Байгаль орчин,</p>	<p>Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.</p>

нийгмийн нөлөө	
Тайлбар	** Тус төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.4.22 буюу “Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ” гэсэн заалттай уялдаж байна. Эх сурвалж: Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013

Төслийн дугаар: IV4

Төслийн нэр	<b>Хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламж-ландфилл байгуулах төсөл</b>
Байршил	Эрдэнэт хот, Дархан хот
Хэрэгжүүлэгч	БОАЖЯ
Зорилго	1)Төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах ландфилл байгуулах; 2)Ландфилл ашиглалт үйлчилгээг зохистой зохион байгуулах; 3) Ландфиллын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах техникийн мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, 4)Хог хаягдлын талаарх иргэдийн ойлголт, мэдээллийг сайжруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Хог хаягдлыг зүй зохистой хаядаг болно; 2) Дархан, Эрдэнэт хотуудын хог булшлах цэгийн ойр орчмын байгаль орчин сайжирна; 3) Хог шатааснаас үүсэх хорт бодисыг багасгана.
Төслийн зардал	5 сая ам.доллар (тус бүр нь 1 га орчим талбай бүхий 2 ландфилл байгуулах)
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021 он: Төсөл боловсруулах 2021-2022 он: Төслийг хэрэгжүүлж эхлэх 2022 оноос: Төсөл бүрэн хэрэгжих
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Одоогийн байдлаар Монголд хатуу хог хаягдлыг энгийн байдлаар хогийн цэг дээр даран устгаж байгаагийн уршгаар бүх хот суурин газруудын хогийн цэгүүдэд байгаль орчин доройтож, хог шатааснаас үүсэх түймэр, хөрсний элэгдэл зэрэг олон асуудал үүсч байна. Хатуу хог хаягдлын зохисгүй менежментээс үүдэлтэй байгаль орчны доройтол, өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах ландфилл буюу хяналттай ландфилл байгууламжийг үе шатаар нэвтрүүлэх шаардлагатай. Эхний шатанд Эрдэнэт, Дархан хотуудад ландфилл барих төслийг эхлүүлнэ. Эдгээр хотуудад 50, 60 жилийн өмнөөс хогийг ил задгай асган зайлуулж ирсэн. Монгол Улсад хатуу хог хаягдлыг зайлуулах олон үйл явцтай холбоотой төлөвлөлт, технологи, байгууламжийн хүчин чадал хомс байгаа нь гол бэрхшээл болж байна. Энэхүү төсөл нь бусад бүх хотын хогийн цэгийн зохистой менежментийн загвар болох юм. Орхон аймгийн Эрдэнэт хотод хоногт 840м <sup>3</sup> хатуу хог хаягдлыг ялгалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт хаядаг. Хууль бус хаягдлыг тооцвол нийт 5 орчим сая тонн хатуу хог хаягдал энэхүү цэгт хуримтлагджээ. Гэвч хог хаягдлын менежмент сул байгаагаас нутгийн удирдлагын байгууллага хуримтлагдсан хогийн хэмжээг нарийвчлан гаргаж чадахгүй байна. Хатуу хог хаягдлын менежментийн хүрээнд техник, төсөв хөрөнгөний дутагдлаас үүдэн

	<p>үндэсний стандартыг боловсруулан, мөрдөж чадахгүй байна. Дархан-Уул аймгийн хатуу хог хаягдлын нөхцөл байдал Орхон аймагтай ижил төстэй байна. Дархан-Уул аймгийн нутгийн удирдлагын байгууллага хог хаягдлын төвлөрсөн цэгийг нүүлгэн шилжүүлэхээр хэлэлцэж байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн Энэ төслөөр Орхон аймгийн Эрдэнэт хот, Дархан-Уул аймгийн Дархан хотод төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах ландфилл байгуулна. Ландфилл нь хог хаягдал замбараагүй тарах, үнэр, гал түймэр, нянгийн тархалт, хөрс, гүний ус бохирдох гэх мэт хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг хянадаг инженерийн байгууламж юм.</p> <p>3) Хэрэгжилт БОАЖЯ нь төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах ландфилл байгуулах ажлыг хариуцна. Ашиглалт, засвар үйлчилгээг хувийн компани хариуцах нь зүйтэй.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Байгаль орчинд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Хог хаягдлыг зохистой дахин боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь агаар, хөрс, усны бохирдлыг мэдэгдэхүйц бууруулах боломж олгодог. Дээрх хотуудын хог хаягдлын цэгүүдэд хог түүдэг хүмүүсийг ландфиллд ажиллуулснаар тэдэнд ажиллаж, амьдрах нөхцлөө сайжруулах боломж олгоно.</p>
Тайлбар	

#### Төслийн дугаар: IV5.1

Төслийн нэр	<b>Байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах төсөл</b>
Байршил	Эрдэнэт, Дархан, Чойр, Ховд хотууд
Хэрэгжүүлэгч	БХБЯ Аймаг тус бүрийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
Зорилго	<p>1) Дэд бүтцийн барилга байгууламжийн насжилт хэтэрсний улмаас үүсэх эвдрэл, доголдлоос урьдчилан сэргийлэх;</p> <p>2) Насжилт ихтэй байгууламжуудад урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ хийх зарчим бүхий зохистой төлөвлөлтийг бий болгох.</p>
Хүлээгдэж буй үр дүн	<p>Дэд бүтцийн байгууламжуудын ашиглалтын зардлыг бууруулах боломжтой.</p> <p>Ашиглалтын хугацааг уртасгах гол арга замууд нь: 1) байгууламжид тогтмол шалгалт хийж байх ээлжит засвар үйлчилгээ, 2) засвар, шинэчлэлт хийх шаардлагатай мэдээллийн бааз бүхий систем, 3) байгууламжийн нөхцөл байдлыг техникийн аргаар үнэлэх ажилтнуудыг бэлтгэх.</p>
Төслийн зардал	0.4 сая ам.доллар (мэдээллийн сан болон хүний нөөц бэлтгэх)
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>2021 он: Төсөл боловсруулах</p> <p>2021-2022 он: Төсөл хэрэгжүүлэх</p> <p>2022 оноос: Төсөл бүрэн хэрэгжих</p>
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл Монгол Улсад социалист нийгмийн үед баригдсан авто зам, гүүр, ус цэвэршүүлэх болон бохир ус цэвэрлэх байгууламж, шугам сүлжээ хоолой зэрэг дэд бүтцийн олон байгууламжууд 30 гаруй жилийн настай болжээ. Эдгээрийг шинэчлэх шаардлага ойрын хугацаанд бүгд ар араасаа давхцаж гарч ирэх болно. Гэсэн хэдий ч зохих засвар үйлчилгээг төлөвлөх чадавх, мэдээллийн сан байгуулах технологи, засварын нөхцөл байдлыг үнэлэх хүн хүчний нөөц дутагдалтай байгаа</p>



	<p>нь гол бэрхшээл болж байна. Хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр дэд бүтцийн байгууламж эрчимтэй нэмэгдэж байгаа тул засварын зардлыг бууруулах явдал ач холбогдолтой. Техникийн шинжилгээ хийснээр байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах боломжтой.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Төсөл нь зохих засвар үйлчилгээний системийг бий болгох, барилга байгууламжийн ашиглалтын хугацааг сунгах төлөвлөгөө гаргахад чиглэнэ. Төслийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь барилга байгууламжийг барьсан/суурилуулсан хугацаа, материал, байршил, лицензийн хамаарал гэх мэт мэдээллээс бүрдэх бүхий мэдээллийн дижитал системийг бий болгох явдал юм. Уг мэдээллийн санг ГМС-ээр (газар зүйн мэдээллийн систем) удирдаж байх шаардлагатай. Ингэснээр байгууламжийн нөхцөл байдлыг техникийн аргаар дүгнэх боломжтой болно. Бусад бүрэлдэхүүн хэсэг нь засвар үйлчилгээ, ашиглалтын төлөвлөлтийг зөв боловсруулах чадвар бүхий хүн хүчний чадавхыг хөгжүүлэх явдал юм.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ЖАЙКА зэрэг донор байгууллагуудаас техникийн дэмжлэг авах шаардлагатай. БХБЯ-ны дэмжлэгтэйгээр аймаг тус бүрийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар бүх ажлыг хариуцаж гүйцэтгэнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ. Барилга байгууламжийн эвдрэлээс болж гарах осол аваар багасах тул байгаль орчны нөхцөл байдал тогтвортой байх болно.
Тайлбар	

Төслийн дугаар: IV5.2

Төслийн нэр	<b>Хот байгуулалтын салбарын хууль эрх зүйн баримт бичгийн уялдааг хангах, эрх зүйн тогтолцоог шинэчлэх төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч	БХБЯ, БХТ, ГЗБГЗЗГ
Зорилго	Хот байгуулалтын салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, норм норматив, дүрэм, журам, стандартын баримт бичгүүдэд үзлэг хийх, дүн шинжилгээ өгөх, давхардал хийдлийг арилгах, хууль тогтоомж, норм, норматив, дүрэм, журам, стандартын баримт бичгүүдийг нэгдсэн цогц байдлаар боловсруулж тогтолцоог олон улсын түвшинд хүргэн шинэчлэх.
Хүлээгдэж буй үр дүн	НҮБ-ын Хабитат III хөтөлбөрт тусгагдсан хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилго, зорилтууд хэрэгжинэ; Хот байгуулалт, барилгын салбарын хууль эрх зүйн орчин бодитоор боловсронгуй болж салбарын эрх зүйн тогтолцоо шинэчлэгдэнэ; Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагуудын эрх, үүрэг тодорхой болно; Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, хэрэгцээ, шаардлагад илүү нийцсэн, хүрээлэн буй байгаль орчинтойгоо харилцаа холбоо бүхий ногоон хөгжлийн шаардлагыг хангасан, ногоон хот байгуулалт бий болох нөхцөл бүрдэнэ.
Төслийн зардал	1.5 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2020-2021: Хот байгуулалтын салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, норм норматив, дүрэм, журам, стандартын баримт

	<p>бичгүүдэд үзлэг хийх, дүн шинжилгээ өгөх; 2021-2022: Хот байгуулалтын салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, норм норматив, дүрэм, журам, стандартын баримт бичгүүдийг шинэчлэх, шинээр боловсруулах.</p>
<p>Төслийн танилцуулга</p>	<p>1) Үндэслэл Хот байгуулалтын тухай хуулийг анх 1998 онд батлан мөрдүүлсэн бөгөөд хот байгуулалтын салбарын хөгжлийн чиг хандлагад үүссэн цаг үеийн шаардлагаар уг хуулийг 2008 онд шинэчлэн найруулж, баталсан өдрөөс хойш 2015 он хүртэл 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. 2008 онд батлагдсан энэхүү хууль нь хэдийгээр тухайн цаг үеийн хөгжлийн шаардлагыг хангаж байсан боловч орчин үеийн нийгмийн хөгжилд нийцэхгүй, өнөөгийн шаардлагыг тэр бүр хангахгүй болсон байна. Сүүлийн 20 гаруй жил хотжих үйл явц эрчимтэй явагдаж, хөдөөнөөс хот, суурин газрыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилтын түвшин хурдацтай нэмэгдэж 67.6 хувьд хүрээд байна. Тухайлбал нийслэл, бүсийн тулгуур төв болон аймгийн төв болох 23 хотод манай орны нийт хүн амын 60.0 гаруй хувь нь оршин сууж, ажил, хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс зөвхөн Улаанбаатар хотод оршин суугчдын тоо нэг сая дөрвөн зуун мянгад хүрч, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршин дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Мөн Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон хотуудын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрлийн улмаас дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн зэрэг иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний даац хэтэрч, хүртээмж муудан нийгэм, эдийн засгийн олон тулгамдсан асуудлыг бий болгож байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын UN-HABITAT байгууллагаас дэлхийн 60 улс орныг хамруулан 2015 онд хийсэн хотын хөгжлийн индексийн судалгаагаар Улаанбаатар хот нь хөгжлийн үзүүлэлтээр дундаж сул хөгжилтэй хот ангилалд багтаж 42 дугаар байранд жагссан байна. Одоогийн байдлаар хот байгуулалттай холбогдолтой нийт 21 гаруй норм дүрэм, журам, стандарт мөрдөгдөж байна. Эдгээрээс зарим норм, дүрэм нь 1970-аад оноос мөрдөгдөж байгаа болно. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хот байгуулалтын тухай хуулийг бусад хууль тогтоомж, эрх зүйн акттай уялдуулах ажлын хүрээнд “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу уг хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн судалгаа хийгдэж, тус хуультай холбоотой нийт 56 давхардал, хийдэл, зөрчил байна гэсэн дүгнэлт гарсан болно. БХБЯ-аас Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төсөлтэй уялдуулан 8 хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, 25 гаруй норм дүрмийг шинэчлэх, шинээр боловсруулах шаардлагатай байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн Төсөл нь эхний ээлжинд хот байгуулалтын салбарын хууль эрх зүйн тогтолцоонд мониторинг хийж үнэлэлт, дүгнэлт өгнө. Бусад хууль тогтоомжийн уялдаа, давхцал, хийдлийг нарийвчлан тогтооно. Хууль тогтоомж, норм, норматив, дүрэм, журам, стандартыг нэгдсэн цогц байдлаар боловсруулж батлуулах гэсэн үндсэн бүтэцтэй байна.</p> <p>3) Хэрэгжилт</p>

	БХБЯ нь тус төслийг хэрэгжүүлэх үндсэн байгууллага байх бөгөөд БХТ, ГЗБГЗЗГ, бусад холбогдох мэргэжлийн байгууллагууд, олон улсын зөвлөхүүдтэй хамтран боловсруулна. Боловсруулалтын явцад аймаг, нийслэл, иргэдийн оролцоог ханган ажиллана. Төсөл хэрэгжих үед нарийвчилсан төлөвлөгөөний дагуу ажиллана.
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Монгол Улсын бүс нутаг, хот, суурины хөгжлийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааны талаарх бодлого, хэрэгжилтийн зохицуулалт нь нэгдмэл болж, хот байгуулалтын талаарх хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил арилж салбарын хууль эрх зүйн тогтолцоо шинэчлэгдэнэ.</p> <p>Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, хэрэгцээ, шаардлагад илүү нийцсэн, хүрээлэн буй байгаль орчинтойгоо харилцан холбоо бүхий ногоон хөгжлийн шаардлагыг хангасан, ногоон хот байгуулалт бий болох нөхцөл бүрдэнэ.</p> <p>Хот байгуулалтыг бүсчлэлийн хэлбэрээр зохицуулан холбогдох мэргэжлийн байгууллага, зөвлөлийн саналыг урьдчилж тусгах нь байгаль орчинд ээлтэй буюу хот, суурины нөөцийг оновчтой тооцоолсон, хөрөнгө оруулалтын бодлогод суурилсан, улсын хөгжлийн нэгдсэн бодлогод нийцсэн хот байгуулалтыг бий болгох нөхцөл бүрдэнэ.</p> <p>Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харилцан уялдуулах нь хот, суурины тэлэлт, шаардлагагүй дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, одоогийн үүссэн бүх хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.</p>

#### Төслийн дугаар: IV6

Төслийн нэр	Туул голын усан цогцолбор байгуулах төсөл *
Байршил	Улаанбаатар хотоос дээш Туул голын сав газарт
Хэрэгжүүлэгч	УБ хотын Ус сувгийн удирдах газар нь БХБЯ, БОАЖЯ, УБ хотын Захирагчийн ажлын алба, ҮХГ, СЯ, Туул голын сав газрын захиргаатай хамтарч ажиллана.
Зорилго	<p>1) Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг хангах зорилгоор одоо байгаа болон шинэ нөөцийг тодорхойлох;</p> <p>2) Далангийн төслийн хэрэгжилтийг түргэсгэхэд дэмжлэг үзүүлэх.</p>
Хүлээгдэж буй үр дүн	Улаанбаатар хотын усан хангамж нэмэгдэж, илүү найдвартай болно.
Төслийн зардал	229.2 сая ам.доллар (Улсын төсвөөс: 10%, Орон нутгийн төсвөөс: 4%, Гадаадын х.о 14%, Хувийн хэвшил 72%); Үр өгөөж, өртгийн харьцаа = 1.210
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	<p>Туул голын усан цогцолборын ТЭЗҮ: 2012 онд УСУГ, КОЙКА хамтарч боловсруулсан.</p> <p>Туул голын усан цогцолборын инженерийн зураг төсөл: боловсруулж байна</p> <p>Туул голын далангийн цогцолборын барилгын ажил: 2026-2030 онуудад (5 жил)</p>

Төслийн танилцуулга

1) Үндэслэл

Улаанбаатар хотын ус хангамж нь газрын доорх усны эх үүсвэр буюу Туул голын сав газрын гүний уснаас хамааралтай. Хуурай, хүйтэн өвлийн улиралд газрын доорх усны нөөц багасдаг тул Улаанбаатар хотын усны нөөц мөн хомс болно.

Хүснэгт А-д үзүүлсний дагуу Улаанбаатар хотын гүний худгийн ундарга 2026 оноос хойш жилд 193.5 сая м3 болно. Энэ тооцоололд АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн (МСК) төслийн хүрээнд байгуулах Улаанбаатар хотын газрын доорх усны баруун эх үүсвэрийг (өдөрт 140,000 м3 буюу жилд 51.1 сая м3 ус) оруулсан болно. МСК-ийн төсөлд 1) Ус хангамжийн шинэ эх үүсвэрийг байгуулах (32 гүний худаг), 2) Дэвшилтэт технологи бүхий ус гүн цэвэршүүлэх байгууламж барих (урвуу осмосын технологи), 3) ус дамжуулах шугам, хоолойг угсарч суурилуулах зэрэг үйл ажиллагаа багтана. МСК-ийн төслийн хүрээнд урсгал дагуу талбайд шинэ худгийг барих тул хөрс, газрын доорх усыг бохирдлоос хамгаалах дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламж шаардлагатай.

**Хүснэгт А. Улаанбаатар хотын газрын доорх усны эх үүсвэр (гүний худаг)**

Эх үүсвэр		Ашиглах боломжит усны нөөц (м3/өдөр)	Гүний худгийн тоо, 2026 оноос хойш	Гүний худгийн ундарга, 2020 оны байдлаар (м3/өдөр)	Шинээр бий болгох усны эх үүсвэр, 2026 оноос хойш (м3/өдөр)	Гүний худгийн ундарга, 2026 оноос хойш (м3/өдөр)	Гүний худгийн ундарга, 2026 оноос хойш (сая м3/жил)
Төвийн ус хангамж	Дээд эх үүсвэр	72,000	55	72,000		72,000	26.3
	Төвийн эх үүсвэр	114,000	93	114,000		114,000	41.6
	Үйлдвэр	36,000	16	36,000		36,000	13.1
	Мах комбинат	15,000	11	15,000		15,000	5.5
	Гачуурт	25,700	25	25,700		25,700	9.4
	Баруун эх үүсвэр (МСК-ийн төсөлд)	140,000	32	-	140,000	140,000	51.1
Нийт		402,700	232	262,700	140,000	402,700	147.0
ДЦС		83,500	30	83,500		83,500	30.5
Яармаг		20,000	2	20,000		20,000	7.3
Нисэх, Биокомбинат		23,800	4	23,800		23,800	8.7
Бүгд		530,000	268	390,000	140,000	530,000	193.5

Эх сурвалж: УСУГ, Мянганы сорилтын корпораци

**Зураг А. Улаанбаатар хотын газрын доорх усны эх үүсвэр**



Эх сурвалж: УСУГ/КОЙКА, 2012

Хүснэгт В -д харуулснаар 2040 он гэхэд Улаанбаатар хотын усны эрэлт 268.5 сая м3/жил байх тооцоо байна. Түүнчлэн 2040 онд усны хомсдол жилд 75 сая м3 (268.5 сая м3-193.5 сая м3 = 75 сая м3) хүрэх тооцоо байна.

**Хүснэгт В. Улаанбаатар хотын усны эрэлтийн тооцоо, 2040 оны байдлаар**

Аймаг/хот	2040 оны усны эрэлтийн тооцоо (сая м3/жил)								
	Ундны ус	Нийтийн аж ахуй & аялал жуулчлал	Үйлдвэржилт	Бусад салбарууд (эрчим хүч, барилга, зам тээвэр)	Үйлдвэржилт, уул уурхай & боловсруулалт	Нийт	ХАА/бэлгээр	Усжуулалтын систем	Нийт
Улаанбаатар хот	122.8	37.31	15.79	76.25	11.27	263.42	2.3	2.83	268.5

Эх сурвалж: БХБЯ, ҮХГ, ЖАЙКА-гийн “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн Явцын тайлан (2019)

КОЙКА, УСУГ-ын 2012 онд боловсруулсан “Улаанбаатар хотын ус хангамжийн нөөцийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд тусгаснаар Улаанбаатар хотын усны нөөц бүхий сав газруудын (7,514 км<sup>2</sup>) газар доорх усны дахин сэлбэгдэх хэмжээг татралтын муруйн аргачлалаар тооцоход жилд 238.5 сая м3 байна. Дахин сэлбэгдэх газар доорх усны тогтвортой ундарга 40% байх тохиолдолд 70%-д хүргэж болдог гэсэн зарим судалгаа (Майлс & Чамбэр, 1995; Ханн, 1997) байдаг байна. Хүснэгт С-д үзүүлснээр газар доорх усны 60% дахин сэлбэгдсэн тохиолдолд тогтвортой ундарга (газар доорх усны нэмэгдэх боломж) жилд 143.1 сая м3 болно.

**Хүснэгт С. Улаанбаатар хотын газрын доорх усны нөөцийн нэмэгдэх боломж**


Газрын доорх усны нөөц	Дахин сэлбэгдэх газар доорх ус	Тогтвортой ундаргын коэффициент	Газрын доорх усны нөөцийн нэмэгдэх боломж
2,348 сая м3/жил	238.5 сая м3/жил	60%	143.1 сая м3/жил

Эх сурвалж: УСУГ/КОЙКА, 2012

Тиймээс Улаанбаатар хотын газар доорх усыг хангалттай ашигласан тохиолдолд гадаргын усыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлага тулгарна. Ялангуяа хуурай, хүйтэн өвлийн улиралд газрын доорх усны түвшин буурдаг тул Улаанбаатар хотын усны нөөцийн хомсдол тооцоолж байгаагаас эрт болох магадлалтай гэж таамаглаж байна.


Зураг В, С-д Туул-Улаанбаатар харуулын усны зарцуулгын ажиглалтын өдөр тутмын гидрограф болон зарцуулга үргэлжлэлийн муруйг үзүүлэв. Зурагт үзүүлсэнчлэн өвлийн улиралд голын урсацын 15% урсаж байна. Түүнчлэн өвлийн улиралд газрын доорх ус дахин сэлбэгдэх нь тун хязгаарлагдмал байдаг. Тиймээс Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх далан, усан сан гэх мэт байгууламжуудыг ашиглах шаардлагатай.

### Зураг В. Туул-Улаанбаатар харуулын усны зарцуулгын ажиглалтын гидрограф



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (ЦУОШГ-ын мэдээлэлд үндэслэсэн)


### Зураг С. Туул-Улаанбаатар харуулын зарцуулга үргэлжлэлийн муруй



Duration (%)	Discharge (m³/s)	Duration (%)	Discharge (m³/s)	Duration (%)	Discharge (m³/s)	Duration (%)	Discharge (m³/s)	Duration (%)	Discharge (m³/s)	Duration (%)	Discharge (m³/s)
Max	721.0	15%	37.3	30%	18.6	45%	8.87	60%	2.35	75%	0.20
5%	95.1	20%	29.0	35%	14.7	50%	6.61	65%	1.22	80%	0.03
10%	54.2	25%	23.4	40%	11.6	55%	4.25	70%	0.54	85%	0.00
										90%	0.00
										95%	0.00
										100%	0.00

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (ЦУОШГ-ын мэдээлэлд үндэслэсэн)

### Зураг D. Туул-Улаанбаатарын ажиглалтын ай савд газрын доорх усны дахин сэлбэгдэх байдлын симуляци, танк загвараар




Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (ЦУОШГ-ын мэдээлэлд үндэслэсэн)

1981-1983 онд ЗХУ-ын мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар Улаанбаатар хотын ус хангамжийн шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Энэхүү ТЭЗҮ-ээр Улаанбаатар хотоос 200 км эргэн тойронд гүний усны нөөц бүхий 11 талбайг ашиглах хувилбарыг санал болгосон. Эдгээр талбайд харьцуулалт хийж үзсэний үндсэн дээр Гачуурт тосгоноос дээш 2.5 км-ын зайд далан барих, Улаанбаатар хотыг ил усан сангаас усаар хангах хувилбарыг хамгийн ашигтай нь гэж сонгосон тул 1989 онд хайгуул, зураг төслийг гүйцэтгэсэн. БОАЖЯ, Ус сувгийн удирдах газрын захиалгаар Монгидроконстракшн ХХК 2007 оны 11-р сараас 2008 оны 4-р сар хүртэл Туул гол дээр усан цахилгаан станц барих техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад зориулсан урьдчилсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Энэ төслийн хүрээнд далан барьж болох гурван талбайг сонгосон. Үүнд 1-р талбайг Туул гол Гачууртын орчимд Хар усан тохойд байхаар сонгосон бөгөөд ЗХУ-ын мэргэжилтнүүд өмнө нь сонгосон талбайтай давхцаж байсан. 2-р талбайг ЗХУ-ын мэргэжилтнүүд өмнө нь сонгож байсан 2-р талбайгаас доош 2 км зайд сонгосон. 3-р талбайг Улаанбаатар хотоос дээш 70 км буюу Тэрэлжийн цутгалаас доош 4 км-т байрлах газрыг сонгосон.

Түүнчлэн Престиж Инженеринг ХХК нь Туул голын урсацыг зохицуулах, цаашид Улаанбаатар хотын усан хангамжийг найдвартай байдлыг хангах, усны эрчим хүч ашиглах, ус ариутгах төхөөрөмж бүхий усны цогцолбор байгууламж барих, томоохон үйлдвэр, объектуудыг усаар хангах шийдэл, Туул голын сав газарт экосистемийн тохилог орчинг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг судлах зорилгоор 2010-2011 онд Туул голын усан цогцолборыг судалсан. ТЭЗҮ-ийн урьдчилсан тооцоо хийж, далан барих 4 талбайг сонгосон.

Зураг Е-д Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Туул голын дээд хэсэгт барих далангийн төлөвлөлтүүдийг харуулав. Эдгээр төлөвлөлтүүд нь: 1981-1986 оны хооронд ЗХУ-ын мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар боловсруулсан Улаанбаатар хотын ус хангамжийн шинэ эх үүсвэрийн хөгжлийн төлөвлөгөө (төсөл), 1993-1995 оны хооронд ЖАЙКА-гийн боловсруулсан хөгжлийн төлөвлөгөө (төсөл), Монгол мэргэжилтнүүдийн боловсруулсан хөгжлийн төлөвлөгөө (төсөл) болон 2009 онд хийсэн урьдчилсан судалгааны хүрээнд Хилийн чанадын гэрээлэгч компаниудын холбооны боловсруулсан Туул, Тэрэлж голын төлөвлөгөө юм. Эдгээр төлөвлөгөөнүүдийг боловсруулж, төсөл хэрэгжүүлэх талбарыг санал болгосноос хойш шинэчлээгүй тул шинэчилж, сайжруулах шаардлагатай.

**Зураг Е. Туул усан цогцолбор төсөлтэй холбоотойгоор хийгдэж төлөвлөгөө, судалгаанууд**



Эх сурвалж: УСУГ/КОЙКА, 2012 он, 12 дугаар сар



Зураг F-д үзүүлсэнчлэн КОЙКА, УСУГ-ын 2012 онд боловсруулсан мастер төлөвлөгөөний хүрээнд даланг барьж байгуулах дөрвөн хувилбарыг өмнө нь хийгдэж байсан төлөвлөгөөнүүдийг нь судалж, газар дээрх судалгааг хийж, орчин нөхцөлийг нь судалсны дүнд санал болгосон. Даланг барьж




байгуулах байршлыг сонгохдоо зөвхөн техникийн үзүүлэлтүүдийг нь харгалзан үзээд зогсохгүй нийгэм, эдийн засаг, байгаль орчин, улс төрийн нөхцөл байдлыг нь мөн үндэслэх шаардлагатай. Мастер төлөвлөгөөнд 1) даланг барьж байгуулах зорилготой нийцэж буй эсэх; 2) барилга угсралтын ажилд тулгарах асуудлууд, байгалийн нөхцөл байдал (жишээ нь: газарзүйн болон геологийн нөхцөл байдал); 3) орон нутгийн эдийн засаг, ус ашиглахтай холбоотой эрхийн асуудал; 4) ирээдүйн хөгжлийн нөөц боломж; 5) нэг далан эсвэл хэд хэдэн далан барих боломжтой эсэх; 6) байгаль орчинд ээлтэй байдлаар даланг барьж байгуулах боломжтой эсэх зэргийг харгалзан үзсэн байна.

2040 онд хотын ус хангамжийг зөвхөн газар доорх усаар хангах боломжгүй тул гадаргын усаар хангах даланг барих шаардлагатай байна. Үүнтэй холбогдуулан КОЙКА, УСУГ-ын 2012 онд боловсруулсан мастер төлөвлөгөөнд даланг барьж байгуулах дөрвөн байршлыг харьцуулсан. Үүний үр дүнд Туул голын дээд хэсэгт байрлах 1-р байршил нь усны хэрэглээ, эдийн засгийн үр ашигтай байдлаар хамгийн оновчтой байршилд тооцогдсон. Тиймээс энэ байршлыг даланг барьж байгуулах хамгийн оновчтой байршил гэж тодорхойлж байна. Тус байршилд даланг барьж байгуулснаар 2040 оны усны эрэлт, хэрэгцээг хангах нөхцөл бүрдэж болох юм.


Цаашлаад цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан температурын өсөлтөөс болж ууршилт ихсэх төлөвтэй байгаа бөгөөд Туул голын урсац хуурай улиралд (өвөл, хавар) буурах магадлалтай тул усан сан барих нь үр дүнтэйд тооцогдож байна.




### Зураг Г. Улирлын температур, хур тунадасны ирээдүйн өөрчлөлт




Өвлийн температур (+1.8~3.1 оС)



Зуны температур (+1.6~3.1 оС)



Өвөл ордог хур тунадас (+18~28 %)




Зун ордог хур тунадас (+5~8 %)

Эх сурвалж: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа 2050"

Зураг 10.4.8-д Туул-Улаанбаатар харуулын урсацын ажиглалтын олон жилийн дундаж урсац буюу 28 жилийн урсацын өөрчлөлтийг харуулав.

### Зураг Н. Олон жилийн дундаж урсац, Туул-Улаанбаатар харуулаар



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (ЦУОШГ-ын мэдээлэлд үндэслэсэн)

#### 2) Төслийн бүрэлдэхүүн

Ус хангамж, үерийн хамгаалалт, усны эрчим хүч болон бусад шууд бус ашиг тус бүхий далан,

Техникийн урьдчилсан зураг төсөл, санхүүгийн төлөвлөгөө,

Нарийвчилсан зураг төсөл,

Ус хангамжийн байгууламжуудын хамт даланг барьж байгуулах ажил.

Далангийн үзүүлэлтүүд:

Хамрах талбай: 2,261 км<sup>2</sup> (байршил: өргөрөг 48-01-31, уртраг 107-41-47),

Эзлэхүүн: 82.6 сая м<sup>3</sup>,

Далангийн төрөл: бетон гадаргатай чулуун далан, далангийн өндөр: 39.6 м.

Усан цахилгаан станцын хүчин чадал нь 240 кВт бөгөөд жилд 1,754 МВт/цаг эрчим хүч үйлдвэрлэнэ.

#### 3) Хэрэгжилт

УСУГ, БОАЖЯ нь далангийн талбайн байршил, төслийн хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон аргазүйн зөвлөгөө өгөх, ТЭЗҮ, зураг төслийн болон барилгын ажилд олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт хийх санхүүжилтийг хангах үүрэг ажиллана.

Байгаль

2012 онд УСУГ, КОЙКА мастер төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулахдаа

орчин, нийгмийн нөлөө	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг (БОНБУ) хийсэн байна. БОНБУ-ний үр дүн нь төслийг хэрэгжүүлснээр төслийн талбай болон түүний ойр орчимд зайлшгүй нөлөөлөл (янз бүрийн бохирдуулагч бодисууд урьдынхаас нэмэгдэх, даланг барьж байгуулснаар экосистемийг гэмтээх, усны чанар, экосистемд өөрчлөлт орох, оршин суугчдын нүүлгэн шилжүүлэх гэх мэт.) үзүүлнэ гэсэн байна.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үе шат бүрт төслийн хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулна. Байгаль орчинд учруулах гэнэтийн хохирлыг хамгийн бага түвшинд байлгахын тулд тогтвортой менежмент, мониторингийн төлөвлөгөөг мөн хэрэгжүүлнэ. Төслийг хэрэгжүүлснээр агаар, усны чанарт нөлөөлөх нөлөөлөл, экосистемд үзүүлэх нөлөөлөл, үүсэх дуу чимээний бохирдол зэргийг бууруулах төлөвлөгөөг боловсруулсан байх шаардлагатай.</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд (2002) БОНБУ-г том цар хүрээг хамарсан хөгжлийн төслийг хэрэгжүүлэхийн өмнө хийнэ гэж заасан байдаг. Тиймээс далангийн бүтээн байгуулалт бүхий усны нөөцийг нэмэгдүүлэх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нь үнэлэхийн тулд БОНБУ-г хийсэн байх шаардлагатай. БОНБУ-ний үр дүнг төслийн нарийвчилсан төлөвлөгөө, зураг төсөлд тусгана. Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах оновчтой төлөвлөгөө нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг хангасан байна.</p> <p>Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх, шаварлаг хөрсийг хамгаалах, намгархаг газрыг бий болгох төлөвлөгөө бүхий байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, төслийн хэрэгжсэний дараах мониторингийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахад чухал ач холбогдолтой.</p>
Тайлбар	<p>** Тус төсөл нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.3.8 буюу “Хөх морь төслийн хүрээнд өндөр уулын бүсийн Сэлэнгэ, Орхон, Эг, Хэрлэн, Ховд зэрэг томоохон гол мөрөнд урсацын тохируулгатай, олон зориулалтын усан сангуудыг байгуулах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж барилгын ажлыг эхлүүлэх” гэсэн заалттай уялдаж байна.</p> <p>Эх сурвалж 1): Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013</p> <p>Эх сурвалж 2): УСУГ-ын “КОЙКА” байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Яармагийн шинэ хорооллын усан хангамжийн эх үүсвэрийг хөгжүүлэх” төсөл, 2012;</p> <p>Эх сурвалж 3): ЖАЙКА-гийн “Улаанбаатар хот орчмын усан хангамжийн судалгаа” төсөл, 1995.</p>

Төслийн дугаар: IV7.1

Төслийн нэр	<b>Хот суурины усан хангамжийг сайжруулах төсөл*</b>
Байршил	Улаанбаатар хот 21 аймгийн төв Хархорин, Бор-Өндөр, Замын-Үүд, Шарын гол, Сайхан/Хөтөл, Мандал/Зүүнхараа, Ханбогд, Цогтцэций зэрэг том суурингууд
Хэрэгжүүлэгч	БХБЯ, БОАЖЯ, СЯ, Голын сав газрын захиргаад, УСУГ-тай хамтарч ажиллана.
Зорилго	Хот сууринг ундны цэвэр усаар хангах
Хүлээгдэж буй үр дүн	1) Усны хангамж сайжирч, амьдрах орчин сайжирна; 2) Цэвэр усан хангамжийн замаар устай холбоотой өвчлөлийг бууруулна.
Төслийн зардал	Нийт: 896,484 сая төгрөг 2014-2016: 469,379 сая төгрөг, 2017-2021: 427,105 сая төгрөг (улсын төсвөөс: 40%, орон нутгийн төсвөөс: 10%, гадаадын х.о: 40%, хувийн хэвшил: 10%)
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2014-2022 он
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Монгол Улсад усны нөөцтэй холбоотой дараах асуудлууд тулгарч байна. Ундны цэвэр усны хүртээмж хомс; Өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ нь нэмэлт усны эх үүсвэр шаарддаг; Гэр хорооллын усан хангамж хангалтгүй; Усны чанарын стандарт хангагдаагүй; Орон сууцанд усны хэрэглээ үр ашиггүй, маш өндөр байдаг; Хот суурин газрын хөгжлийг хангах усан хангамжийн дэд бүтэц; Усны эх үүсвэрүүдийн хамгаалалт илүү сайн байх шаардлагатай; Одоо байгаа усан хангамжийн системийн засвар үйлчилгээ хангалтгүй. <u>Баталгаат эх үүсвэрээс усаар хангах үйлчилгээ:</u> 2010 онд хотын хүн амын 86.7% нь баталгаат эх үүсвэрээс ус авч байсан нь 2015 онд хэрэгжүүлэх МХЗ-ын зорилтод зааснаас давсан (70%) байна. ТХҮБ 2030-д баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Түүнчлэн бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд хотжилт, хүн амын өсөлтөөс шалтгаалан усны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүтэй байдал улам нэмэгдэнэ. Тиймээс ус хангамжийг сайжруулах үйл ажиллагааг алхам алхмаар хийх хэрэгтэй. Улаанбаатар хотын усны балансын шинжилгээний үр дүнгээс харахад ус хангамжийн хүчин чадал 120 сая м3 байх тохиолдолд усны хомсдол 2018, 2030, 2040 онд -38.3 сая м3, -432.8 сая м3, -701.3 сая м3 гэсэн тооцоотой байна. Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл нь Улаанбаатар хотын ус хангамжийн цэвэр усны хэмжээг нэмэгдүүлэх үр дүнтэй төсөл юм. АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх цогц хөтөлбөрийн хүрээнд 350 сая ам.долларын буцалтгүй тусламжаар газрын доорх эх үүсвэрээс ус хангамжийг нэмэгдүүлэх дэд бүтэц, ус цэвэршүүлэх байгууламжийг барьж байгуулна. Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр нь 2018 оны 9 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. Баталгаат эх үүсвэрээс ус авдаг хотын хүн амыг 2030 онд 90%, 2040 онд 95% хүргэх шинэ зорилтыг тавьсан.

	<p><u>Айл өрхийг усны шугамд холбох:</u> 2010 онд хот, суурин газруудын усны шугамд холбогдсон айл өрх 32.9% эзэлж байв. Шинэ орон сууц барих, гэр хорооллын айл өрхийг усны шугам сүлжээнд холбох (Улаанбаатар хотод 40,000 холболт хөтөлбөр) хувь, хэмжээг 2015 онд 45%, 2021 онд 50% байхаар төлөвлөсөн.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн Улаанбаатар хотын усан хангамжийн шугам сүлжээг өргөтгөх; 400 ус түгээх цэг барих; 21 аймгийн төв болон бусад том суурингуудын усан хангамжийн шугам сүлжээг өргөтгөх; Алтай хотын ус хангамжийг сайжруулах Тайшир-Алтай төсөл Барилга, хот байгуулалтын яам болон Австрийн Тиролер Рооре компани хамтран Монгол, Австрийн Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 14 сая еврогийн санхүүжилтээр уг төслийг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд Тайширын усан цахилгаан станцын усан сангаас 52 км ус дамжуулах шугам хоолойгоор усыг дамжуулах тул хүрээлэн буй орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхгүй.</p> <p>3) Хэрэгжилт БХБЯ-наас усны эх үүсвэрийн байршил, хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэхэд чиглэсэн үүргийг гүйцэтгэнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.
Тайлбар	<p>** Тус төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.3.13 буюу “Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ” гэсэн заалттай уялдаж байна.</p> <p>Эх сурвалж: Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013</p>

### Төслийн дугаар: IV7.2

Төслийн нэр	<b>Хөдөөгийн усан хангамжийн өргөтгөлийн төсөл</b>
Байршил	Хөдөө орон нутагт
Хэрэгжүүлэгч	ХХААХҮЯ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), нийслэл, орон нутгийн засаг захиргаа, Гол мөрний сав газрын захиргаатай хамтран ажиллана.
Зорилго	Хөдөө орон нутагт амьжиргаа, мал аж ахуй эрхлэх усан хангамжийг сайжруулах
Хүлээгдэж буй үр дүн	Амьжиргаа сайжирна, малын бэлчээрлэлт, ашиг шим сайжирна.
Төслийн зардал	<p>Нийт: 104,858 сая төгрөг 2014-2016 он: 32,270 сая төгрөг, 2017-2021 он: 72,588 сая төгрөг (улсын төсвөөс: 60%, орон нутгийн төсвөөс: %, гадаадын х.о: 25%, хувийн хэвшил: 15%)</p> <p>- АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "G0204- MON" төсөл 15.00 сая ам. доллар АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "MON-3388" төсөл 19.43 сая ам. доллар</p>

Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2014 - 2022
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Хөдөөгийн хүн амын 59% нь ундны усаар хангагдаж байгаа нь газар зүйн байршил, орлого, хүйсийн ялгааг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна (ДЭМБ/НҮБХС-ийн ХХТ, 2017).</p> <p>Хяналтын хөтөлбөрийн тайланд тусгаснаар хотод оршин сууж буй иргэдийн 95% нь ундны усаар хангагдаж байсан бол хөдөөгийн хүн амын 59% ийм түвшний үйлчилгээг авч байжээ. Тус тайланд тусгаснаар гарын саван, гар угаах газартай айл өрх улсын дунджаар 72% (хөдөөгийн айл өрхийн 49%, хотын айл өрхийн 81%) байгаа нь зарим үзүүлэлт сайжрах хандлагатай байгааг харуулж байна (ДЭМБ/НҮБХС-ийн ХХТ, 2017).</p> <p>Хөдөө, орон нутагт ус хангамжтай холбоотойгоор дараах асуудлууд тулгарч байна. Үүнд, Ашиглах уст цэг дутагдалтай; Зарим газруудад бэлчээрийн талхагдал хэт их байна; Ашиглаж буй уст цэгүүдийн тоо буурч байна; Малыг усаар хангах нь худаг усны тоо болон чанарын хувьд хангалтгүй.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Барих буюу сэргээх худгийн тоо: 2011-2015 онд 2466 худаг, 2016-2021 онд 6050 худаг. 2011-2015 онд засаж сэргээсэн булаг цөөрөм 5, шинээр барьсан 54 2016-2021 онд засаж сэргээх булаг цөөрөм 7, барих 125 Төслүүдийн хүрээнд хийгдэх ажлууд:</p> <p>а) Өмнөговь, Дорноговь аймаг, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн (G0204-MON) хүрээнд хийгдсэн ажлууд:</p> <p>Сайншанд, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон “Шинэ Сайншанд” орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулсан.</p> <p>Сайншанд хотод 6,45 км цэвэр усны шугам, 5,06 км бохир усны шугам, 2,7 км дулааны шугам, 8,4 МВт хүчин чадалтай дулааны зуух, дагалдах насос, тоног төхөөрөмж, зуухны барилга, харуулын байр, цахилгаан дамжуулах дэд станц, дизель цахилгаан үүсгүүр, хамгаалалтын хашаа, 2 км хатуу хучилттай авто зам барьж, ашиглалтанд оруулж, хатуу хог хаягдлын машин ханган нийлүүлсэн.</p> <p>Даланзадгад хотод 1,000 м3 усан сан, 1,4 км цахилгаан дамжуулах шугам, гүний худаг, 1,4 км ус дамжуулах шугам, гэр хороололд 4,7 км бохир усны шугам барьж, ашиглалтад оруулсан.</p> <p>Замын-Үүд суманд 13,4 км цэвэр усны шугам, 7,87 км бохир усны шугам, 3 ш ус түгээх байр, 2 ш бохир усны насосны станц, 3 км дулааны шугам, 3 ш дулаан дамжуулах төв, 3 ш дизель цахилгаан үүсгүүр барьж, ашиглалтанд оруулж, хог пресслэгч ханган нийлүүлж, хатуу хаягдлыг булж зайлуулах цэгийн ажил болон цэцэрлэг, сургуулийг нэгдсэн дулааны шугамд холбосон.</p> <p>Гурвантэс суманд 100 м3 багтаамжтай усан сан, 2 ш гүний худаг, 3,2 км цахилгаан дамжуулах шугам, 5,7 км цэвэр усны шугам, 4,1 км бохир усны шугам, бохир ус цэвэрлэх байгууламж, 3 ш ус түгээх байр, 2 км хатуу хучилттай авто зам, 1,8 км үерийн далан барьж, ашиглалтад оруулсан.</p>

	<p>Цогтцэций суманд 2 ш 100 м3 багтаамжтай усан сан, 0,6 км цахилгаан дамжуулах шугам, 3 ш ус түгээх байр, бохир усны насосны станц, 6,6 км цэвэр усны шугам, 5,8 км бохир усны шугам барьж, ашиглалтад оруулсан.</p> <p>Ханбогд суманд 5.5 км цэвэр усны шугам, 8.4 км бохир усны шугам, 5.4 км цахилгаан дамжуулах шугам, 2 км дулааны шугам, 2 ш ус түгээх байр, бохир ус цэвэрлэх байгууламж барьж, хүлээлгэн өгсөн.</p> <p>б) Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн (MON-3388) хүрээнд хийгдсэн ажлууд:</p> <p>Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын цэвэрлэх байгууламжийн барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулалтын ажил бүрэн дуусч барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр ажиллаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.</p> <p>Арвайхээр хотын 1, 9, 10, 11-р хорооны гэр хорооллын 3 байрлалд 80 өрх болон Архангай аймгийн Цэцэрлэг хотын 1, 2, 3, 4, 5-р хорооны 80 өрхөд тус тус битүү доторлогоотой, суллах боломжтой сайжруулсан нүхэн жорлон барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн дээрх 160 өрхийн бохир усыг соруулахад зориулан бохирын тусгай зориулалтын машин механизмыг ханган нийлүүлсэн.</p> <p>Өмнөгөвь аймгийн Даланзадгад хотын цэвэрлэх байгууламжийн ЦДАШ-ын угсралтын ажил, дэд өртөөний барилга, трансформаторын угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр ажиллаж, У/2018/58 тоот актаар баталгаажсан. Цэвэрлэх байгууламжийн механик цэвэрлэгээ, үйлдвэрийн барилга, захиргааны барилгуудын төмөр бетон цутгалтын ажил хийгдсэн. Биологи цэвэрлэгээний блокын төмөр бетон цутгалтын ажил 100% хийгдсэн. Бохир ус, ариутгах татуургын 4,01 км шугамын ажил хийгдэж дууссан.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>ХХААХҮЯ нь шинээр барих болон засварлах усны эх үүсвэрүүд (худаг, булаг, цөөрөм) болон тоо хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон аргазүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй байна.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.</p>
Тайлбар	<p>** Тус төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.3.13 буюу “Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ” гэсэн заалттай уялдаж байна.</p> <p>Эх сурвалж: Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013</p> <p>Эх сурвалж: БХБЯ, 2019.</p>

Төслийн дугаар: IV8.1

Төслийн нэр	<b>Бохир ус цэвэрлэх байгууламж барих, шинэчлэх төсөл</b>
Байршил	<p>Улаанбаатар хот</p> <p>21 аймгийн төв</p> <p>Бусад томхон суурин (Хархорин, Бор-Өндөр, Сайхан/Хөтөл, Замын-Үүд, Шарын гол, Мандал/Зүүнхараа, Ханбогд, Багануурт 2015 он хүртэл, Хархорин, Мандал/Зүүнхараа, Цогтцэцийд 2021 он хүртэл)</p>

Хэрэгжүүлэгч	БХБЯ, БОАЖЯ, ҮХГ, СЯ, Нийслэлийн болон орон нутгийн засаг захиргаа, УСУГ, Голын сав газрын захиргаатай хамтарч ажиллана
Зорилго	Хот суурин газрын бохир усыг зохих байдлаар цэвэрлэх
Хүлээгдэж буй үр дүн	1) Бохир усыг цэвэрлэх замаар устай холбоотой өвчлөлийг бууруулна; 2) Ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.
Төслийн зардал	Нийт: 1,029,069 сая төгрөг 2014-2016 онд: 301,846 сая төгрөг, 2017-2021 онд: 727,223 сая төгрөг (улсын төсвөөс: 45%, орон нутгийн төсвөөс: -%, гадаад х.о: 55%, хувийн хэвшил: -%) <ul style="list-style-type: none"> <li>✓ Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж шинээр барих төсөл (БНХАУ-ын Засгийн газрын 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл);</li> <li>✓ Баян-Өлгий, Говь-Сүмбэр, Дорнод, Завхан, Увс аймгийн төвүүдийн “Бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл (Монгол Улс, БНПУ-ын ЗГ хоорондын нөхцөлт зээл: 50,697 сая төгрөг);</li> <li>✓ Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл (АХБ-ны зээл: 20.68 сая ам.доллар);</li> <li>✓ Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл (Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын 9,54 сая еврогийн хөнгөлөлттэй зээл).</li> </ul>
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2014-2022
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ хомс; Усны чанарын стандарт хангагдаагүй; Усны эх үүсвэрүүдийн хамгаалалтыг илүү сайжруулах шаардлагатай; Ариун цэврийн дэд бүтэц нь хотжилтын түвшинг гүйцэхгүй; Гэр хороололд сайжруулсан ариун цэврийн байгууламж дутмаг. Хот суурин газарт хэвийн үйл ажиллагаа явуулдаг бохир ус цэвэрлэх байгууламжийн тоо 2010 онд 17 байсан бол энэ тоог 2015 онд 32, 2021 онд 40 болгож нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт нэмэгдсэнээр нийт хаягдаж буй бохир усны цэвэрлэгээ 2021 онд бараг 100%-д хүрэх болно. Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн 140 орчим газарт 72 гол мөрөн, 9 нуурын усны чанарт хяналт, шинжилгээ хийдэг. Хяналт, шинжилгээгээр катион, анион, ууссан нийт давсны хэмжээ, рН, O <sub>2</sub> , BOD болон металлийн илэрц зэргийг хянадаг. Олон аймаг, сумын төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжуудын хангалтгүй ажиллагаанаас үүдэн гадаргын ус бохирдож байна. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж Туул голыг бохирдуулж байна. Цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн ус нь усны чанарын стандартын дагуу “маш их бохирдолтой” байсаар байна. Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа үр дүн бага байгаа ба зөвхөн ахуйн бохир усыг цэвэрлэх зориулалттай цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээс гарсан бохир усыг цэвэрлэж, доголдуулж байна. Түүнчлэн арьс, ширний үйлдвэрүүдийн ашигладаг хромын идээлэгч бодис усны бохирдолд нөлөөлж байна. Монгол Улсад хот, суурин газрын хүн амын 13 орчим, хөдөөгийн хүн амын 56 орчим хувьд ундны усны хүрэлцээ муутай байгаа нь усны хүртээмжгүй байдлаас гадна

	<p>усны чанар нь шаардлага, стандартыг хангадаггүйтэй холбоотой юм.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, сайжруулах, өргөтгөх: 1/ ЦБ-ын төвийн шинэчлэл, мембраны реактор шинэчлэх; 2/ ЦБ-ын тоног төхөөрөмж, үр ашгийг сайжруулах; 3/ Нисэх - Яармагийн шинэ цэвэрлэх байгууламж; 4/ Эмээлтийн шинэ ЦБ; 5/ Жижиг оврын цэвэрлэх байгууламжууд;</p> <p>Өдөрт 250,000 м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай, лагийг боловсруулан биохий гарган авах замаар эрчим хүч үйлдвэрлэх технологи бүхий төв цэвэрлэх байгууламж шинээр барих төсөл (БНХАУ-ын Засгийн газрын 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл);</p> <p>21 аймгийн төв болон бусад томоохон суурингийн ЦБ-уудын шинэчлэл, барилгын ажил: Хархорин, Бор Өндөр, Сайхан/Хөтөл, Замын-Үүд, Шарын гол, Мандал/Зүүнхараа, Ханбогд, Багануурт 2015 он хүртэл, Хархорин, Мандал/Зүүнхараа, Цогтцэцийд 2021 он хүртэл;</p> <p>Баян-Өлгий, Говь-Сүмбэр, Дорнод, Завхан, Увс аймгийн төвүүдийн “Бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл (Монгол Улс, БНПУ-ын ЗГ хоорондын нөхцөлт зээл: 50,697 сая төгрөг);</p> <p>Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл (MON-3244/3245 дугаартай АХБ-ны зээл: 20.68 сая ам.доллар). 2019 оны байдлаар хэрэгжилт нь 64%-тай байгаа ба 6.8 км бохир усны шугамыг татаж, ашиглалтанд оруулсан.</p> <p>Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл (Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын 9,54 сая еврогийн хөнгөлөлттэй зээл). 2019 оны байдлаар хэрэгжилт нь 93.3%-тай байна.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БХБЯ нь цэвэрлэх байгууламжуудын байршил, хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	<p>Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.</p>
Тайлбар	<p>** Тус төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.4.22 буюу “Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.” гэсэн заалттай уялдаж байна.</p> <p>Эх сурвалж: Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013</p> <p>Эх сурвалж: БХБЯ, 2019.</p>

**Төслийн дугаар: IV8.2**

Төслийн нэр	<b>Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин боловсруулж, дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд ашиглах үйлдвэр байгуулах төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот
Хэрэгжүүлэгч	УСУГ нь БХБЯ, БОАЖЯ, НЗДТГ-тай хамтарна.
Зорилго	Дулааны цахилгаан станцаас гарсан бохир усыг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор цэвэрлэх.
Хүлээгдэж буй үр дүн	Үйлдвэрлэлийн бохир усанд агуулагдах хүнд метал болон химийн бодисын бохирдлоос ангижирсан аюулгүй орчин



	Дулааны цахилгаан станцаас гарсан бохир усыг байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийн дагуу цэвэрлэж, хөргөлтөд ашиглах
Төслийн зардал	Эхний ээлжийн бүтээн байгуулалт: 96 сая ам.доллар
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	Барилга угсралтын ажил 2021 онд эхэлж, 5 жилийн хугацаанд үргэлжилнэ.
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжүүлэх Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг нь хаягдал усыг дахин боловсруулж, техникийн зориулалтаар эргүүлэн ашиглах үйлдвэр байгуулах юм. Төслийн хүрээнд Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг тус үйлдвэрт дахин боловсруулж, дулааны цахилгаан станц (ДЦС3, ДЦС4)-уудын хэрэгцээнд техникийн зориулалтаар эргүүлэн ашиглах боломжийг бүрдүүлнэ.</p> <p>Улаанбаатар хотод дахь ДЦС-ууд жилд нийтдээ 21.0 сая м3 (хоногт 50,000 м3) усыг газрын доорх усны эх үүсвэрээс авч ашигладаг. 2034 онд жилд 18.3 сая м3 хаягдал ус дахин боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэр ашиглалтад орж, цэвэрлэсэн усыг ДЦС-уудад үйлдвэрлэлийн зориулалтаар эргүүлэн ашигласнаар газрын доорх усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг бууруулна.</p> <p>Цэвэрлэх байгууламжаас гарч буй бохир усан дахь аммиакийг коагуляци, флокуляци хийх замаар цэвэрлэдэг бөгөөд бусад биологийн хатуу бодисыг эцсийн шүүлтүүрээр оруулж, хлороор халдваргүйжүүлэхээс өмнө өндөр агууламж бүхий ламелла хавтангийн тунадасны төхөөрөмжөөр зайлуулдаг. Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэх хүчин чадал нь хоногт 50,000 м3 (18.0 сая м3/жил) бөгөөд үүнийг 100,000 м3 (36.0 сая м3/жил) хүртэл нэмэгдүүлэх боломжтой. ТЭЗҮ-ийг Францын зөвлөх компани хийсэн ба төв цэвэрлэх байгууламжийн зураг төслийг БНХАУ-ын тал хийж гүйцэтгэсэн.</p> <p>2) Төслийн танилцуулга</p> <p>Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин боловсруулж, ДЦС 3, ДЦС 4-ийн хөргөлтөд ашиглана.</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БОАЖЯ, БХБЯ-ны мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдсан. УСУГ усны бохирдлын мэдээллийг цуглуулж, цэвэрлэх хүчин чадлыг тодорхойлно. Шинэ төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн усны чанарыг хянах шаардлагатай.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Хүнд метал, химийн бодис (хром) агуулсан лаг нь асуудал болж байгаа тул энэ асуудлыг шийдэх нь тус төслийн гол зорилт юм.
Тайлбар	

**Төслийн дугаар: IV8.3**

Төслийн нэр	<b>Ариутгах татуургын сүлжээг шинэчлэх, өргөтгөх төсөл</b>
Байршил	Улаанбаатар хот Аймгийн төвүүд Бусад томоохон суурин (Хархорин, Бор Өндөр, Сайхан/Хөтөл, Замын-Үүд, Шарын гол, Мандал/Зүүнхараа, Ханбогд, Цогтцэций, Багануур)
Хэрэгжүүлэгч	БХБЯ нь ҮХГ, Нийслэлийн болон орон нутгийн засаг захиргаа, Голын сав газрын захиргаадтай хамтарч ажиллана.

Зорилго	Хот суурин газрын бохир усыг зохих байдлаар цэвэрлэх
Хүлээгдэж буй үр дүн	1) Бохир усыг цэвэрлэх замаар устай холбоотой өвчлөлийг бууруулна; 2) Ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.
Төслийн зардал	Нийт: 739,507 сая төгрөг 2014-2016 онд: 287,249 сая төгрөг, 2017-2021 онд: 452,258 сая төгрөг (улсын төсвөөс: 37%, орон нутгийн төсвөөс: 23%, гадаадын х.о 10%, хувийн хэвшил 30%)
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2014 - 2022 он
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ хомс; Усны чанарын стандарт хангагдаагүй; Усны эх үүсвэрүүдийн хамгаалалтыг илүү сайжруулах шаардлагатай; Ариун цэврийн дэд бүтэц нь хотжилтын түвшинд гүйцээгүй; Гэр хороололд сайжруулсан ариун цэврийн байгууламж дутмаг. 2) Төслийн бүрэлдэхүүн Улаанбаатар хотын зарим хэсэг, аймгийн төвүүд болон Хархорин, Бор-Өндөр, Сайхан/Хөтөл, Замын-Үүд, Шарын гол, Мандал/ Зүүнхараа, Ханбогд, Цогтцэций, Багануур зэрэг бусад томхон суурины ариутгах татуургын системийг шинэчлэх. 3) Хэрэгжилт БХБЯ-аас шинэчилж өргөтгөх бохир усны системийн байршил, хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.
Тайлбар	** Тус төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.4.22 буюу “Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.” гэсэн заалттай уялдаж байна. Эх сурвалж: Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013

**Төслийн дугаар: IV8.4**

Төслийн нэр	<b>Сумын төвийн бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл *</b>
Байршил	51 сумын төвүүд
Хэрэгжүүлэгч	БХБЯ-аас ҮХГ, Голын сав газрын захиргаатай хамтарч ажиллана
Зорилго	1) Хөдөө орон нутагт бохир усыг зүй зохистой цэвэрлэх; 2) Хөдөө орон нутагт амьдрах орчныг сайжруулах.
Хүлээгдэж буй үр дүн	1) Бохир усыг цэвэрлэх замаар устай холбоотой өвчлөлийг бууруулна; 2) Ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.
Төслийн зардал	Нийт: 94,830 сая төгрөг 2014-2016 он: 26,406 сая төгрөг, 2017-2021 он: 68,424 сая төгрөг (улсын төсвөөс: 20%, орон нутгийн төсвөөс: -%, гадаадын х.о 80%, хувийн хэвшил -%)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2014 - 2022
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Хөдөөгийн хүн амын 59% нь ундны усаар хангагдаж, 41% ариун цэврийн байгууламжтай байгаа нь газар зүйн байршил, орлого, хүйсийн ялгааг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна (ДЭМБ/НҮБХС-ийн ХХТ, 2017). Хяналтын хөтөлбөрийн тайланд тусгаснаар хотод оршин сууж буй иргэдийн 95% нь ундны усаар хангагдаж байсан бол хөдөөгийн хүн амын 59% ийм түвшний үйлчилгээг авч байжээ. Ариун цэврийн байгууламжийн хувьд ч хот, хөдөөгийн ялгаа их буюу хотын хүн амын 66 хувь нь энгийн ариун цэврийн байгууламжтай байсан бол хөдөөд зөвхөн 41 хувь нь жорлонтой байжээ. Хөдөөгийн хүн амын 31% нь жорлонгүй байна. Тус тайланд тусгаснаар гарын саван, гар угаах газартай айл өрх улсын дунджаар 72% (хөдөөгийн айл өрхийн 49%, хотын айл өрхийн 81%) байгаа нь зарим үзүүлэлт сайжрах хандлагатай байгааг харуулж байна (ДЭМБ/НҮБХС-ийн ХХТ, 2017).</p> <p>Нийслэл хотын хүн амын 64%, хөдөөгийн хүн амын 29 % нь ариун цэврийн байгууламжтай байна. Түүнчлэн Улаанбаатар хотын хүн ам 590,000 (1990) -аас 1.13 сая (2014 он) хүртэл огцом нэмэгдсэн. Монгол Улсын нийт хүн амын 50 орчим хувь нь Улаанбаатар хотод амьдарч байгаа тул гэр хороолол хяналтгүй тэлж, ус хангамж, ариутгах татуургын байгууламж, шугам сүлжээ хүрэлцэхгүй байна. Гэр хорооллын нүхэн жорлон нь гүний ус, хөрсийг бохирдуулж ноцтой байдал үүсгэж байна (ЖАЙКА, 2014).</p> <p>Төслийн үндэслэлийг дараах байдлаар нэгтгэн харуулав. Үүнд:</p> <p>Ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ хомс; Усны чанарын стандарт хангагдаагүй; Усны эх үүсвэрүүдийн хамгаалалтыг илүү сайжруулах шаардлагатай; Ариун цэврийн дэд бүтэц нь хотжилтын түвшинг гүйцээгүй; Гэр хороололд сайжруулсан ариун цэврийн байгууламж дутмаг</p> <p>Ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тайланд дурдсанаар 2012 оны байдлаар хүн амын 56% сайжруулсан ариун цэврийн байгууламжтай, 85% ундны усаар хангагдаж байсан байна (ДЭМБ/НҮБХС 2014). Мөн ДЭМБ-ын 2014 оны “Ундны ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйг сайжруулсанаар суулгалт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” тайланд дурдсанаар суулгалт өвчний улмаас нас барсан тохиолдол 85 гарчээ.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p>2015 он хүртэл баригдсан бохир ус цэвэрлэх байгууламж: 15; 2021 он хүртэл баригдах бохир ус цэвэрлэх байгууламж: 36 сумын төв</p> <p>3) Хэрэгжилт</p> <p>БХБЯ-аас жижиг оврын бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хэмжээг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Нийгмийн хувьд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.
Тайлбар	** Тус төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.4.23 буюу “Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн хаягдал лагийг байгальд

	ээлтэй аргаар устгах туршилтын төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.” гэсэн заалттай уялдаж байна. Эх сурвалж: Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013
--	---


**Төслийн дугаар: IV8.5**

Төслийн нэр	<b>Мал аж ахуйн фермийн бохир усыг цэвэрлэх байгууламж барих төсөл</b>
Байршил	Туул голын сав газарт
Хэрэгжүүлэгч	ХХААХҮЯ, БОАЖЯ, НЗДТГ
Зорилго	Мал аж ахуйн үйлдвэрлэлээс гарч буй бохир усыг хүйтэн уур амьсгалд тохирсон технологийг ашиглан цэвэршүүлэх үйл ажиллагааг турших
Хүлээгдэж буй үр дүн	Ус хангамжийн эх үүсвэр болсон Туул голын усны чанарыг сайжруулах
Төслийн зардал	500,000 ам.доллар: туршилтын төсөл
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2022 онд төслийг туршилтаар хэрэгжүүлсний дараа бүрэн хэмжээгээр хэрэгжүүлнэ.
Төслийн танилцуулга	<p>1) Үндэслэл</p> <p>Туул гол нь Улаанбаатар хотыг газрын доорх усны долоон эх үүсвэрээр хангадаг. Нийслэл хотын усны хэрэгцээ нэмэгдэхийн хирээр Туул голын усыг ашиглах шаардлага улам ихсэх боловч голын ус хэдийнээ ихээр бохирдсон байдалтай байна. Цэвэрлээгүй эсвэл хангалттай түвшинд цэвэрлээгүй үйлдвэрлэлийн бохир уснаас гадна мал аж ахуйн үйлдвэрлэл нь бохирдлын томоохон эх үүсвэр болдог. Мал аж ахуй, гахай, шувууны аж ахуйгаас гарч буй бохир усыг ихэнх тохиолдолд цэвэрлэлгүйгээр зайлуулдаг. Цэвэрлэх байгууламжтай байх тохиолдолд өвлийн улирлын бага температурт бохир ус цэвэрлэх үйл ажиллагааны үр дүн буурдаг.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн</p> <p><u>Туршилтын төсөл</u></p> <p>Мал аж ахуйн үйлдвэрлэлээс гарсан бохир усыг татан, цэвэрлэх үйл ажиллагааны нөхцөл байдлыг судлах;</p> <p>Мал аж ахуйн үйлдвэрлэлээс гарсан бохир усыг зайлуулах, цэвэрлэхтэй холбоотой технологийн, хууль, эрх зүйн болон институцийн нөхцөл байдлыг судлах;</p> <p>Бусад улс орнуудын мал аж ахуйн үйлдвэрлэлээс гарсан бохир усыг цэвэршүүлэх дэвшилтэт технологиудыг судлах;</p> <p>Мал аж ахуйн үйлдвэрлэлээс гарсан бохир усыг цэвэршүүлэх технологиудыг үнэлэх;</p> <p>Мал аж ахуйн фермийн бохир усыг цэвэрлэх байгууламжийг улсын хэмжээнд ашиглах төлөвлөлтийг гаргах;</p> <p>Зохих технологи бүхий бохир ус цэвэрлэх байгууламжийн туршилтын төслийг хэрэгжүүлэх.</p> <p><u>Төслийн бүрэн хэмжээний хэрэгжилт</u></p> <p>Төслийг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэхийн тулд үе шаттай төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.</p>
Байгаль орчин, нийгмийн нөлөө	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг харгалзан бохир усыг цэвэршүүлэх технологиудыг үнэлэх.
Тайлбар	

Төслийн дугаар: IV9

Төслийн нэр	<b>Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөл*</b>
Байршил	Сэлэнгэ мөрний сав газар
Хэрэгжүүлэгч	ЭХЯ нь Дэлхийн банкны санхүүжилттэй “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” (МИНИС) төсөл, БОАЖЯ, ҮХГ, СЯ, Сэлэнгэ мөрний сав газрын захиргаатай хамтарч ажиллана.
Зорилго	1) Эрчим хүчний үйлдвэрлэл, усан хангамжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах; 2) Нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих.
Хүлээгдэж буй үр дүн	1) Дотоодын сэргээгдэх эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ; 2) Улирлын чанартай голын урсацын тохируулга хийнэ; 3) Усан хангамж нэмэгдэнэ.
Төслийн зардал	Нийт: 304,160 сая төгрөг 2014-2016 он: 4,160 сая төгрөг, 2017-2021 он: 300,000 сая төгрөг (улсын төсвөөс: -%, орон нутгийн төсвөөс: -%, гадаадын х.о: 100%, хувийн хэвшил: -%)
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	2021-2023 он: ТЭЗҮ 2025-2030 он: Барилга угсралтын ажил
Төслийн танилцуулга	1) Үндэслэл Өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлт хэрэгцээг хангахын тулд эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Усан цахилгаан станцыг барьж байгуулснаар эрчим хүчний импортоос хамааралтай байдлыг бууруулна. Шүрэнгийн усан цахилгаан станц (УЦС) төслийн гол зорилго нь уул уурхайн салбарт эрэлт хэрэгцээтэй байгаа цахилгаан, эрчим хүчийг хангах, эрчим хүчний системийн эх үүсвэрийн дутагдлыг арилгах юм. Түүнчлэн сэргээгдэх эрчим хүчээр хангах, ОХУ-ын эрчим хүчний системийн хамаарлаас гарч эрчим хүчний салбарын бие даасан байдлыг хангах, хямд өртөгтэй сэргээгдэх эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх явдал юм. Сэлэнгэ мөрний 400 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцын анхны ТЭЗҮ-ийг 1974-1975 оны үед ЗХУ-ын “Гидро-Проект” хүрээлэн боловсруулсан бөгөөд усан цахилгаан станцын байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тооцоололгүйгээр Шүрэнгийн усан цахилгаан станцын төслийг боловсруулсан. Сэлэнгэ мөрний сав газарт усан цахилгаан станц барьж байгуулснаар байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн урьдчилсан үнэлгээг багтаасан урьдчилсан ТЭЗҮ-ийг хийсэн. Тус урьдчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг Эрчим хүчний яамны ажлын хэсэгтэй хэлэлцэж, зөвшилцсөн. Сэлэнгэ мөрний дагуу судалгаа хийсний дүнд Хялганатаас Зүүнбүрэнгийн хооронд санал болгож буй Шүрэнгийн УЦС барихад тохиромжтой гэж үзсэн байна. Хялганатаас Зүүнбүрэнгийн хооронд далан барих зургаан боломжит газрыг урьдчилсан ТЭЗҮ болон 1973 онд хийсэн Оросын техник, эдийн засгийн үндэслэлд үндэслэн тогтоосныг Зураг 10.4.9-д үзүүлэв. .

### Зураг А. Шүрэнгийн УЦС-ын байршил



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг (MINIS төслийн мэдээлэлд үндэслэсэн)

Талбарын дугаар	Байршил	
	Өргөрөг	Уртраг
Боомтын хөндлүүр - 1	49°48'24.45" N	105° 9'51.70"E
Боомтын хөндлүүр -2	49°44'43.07"N	105° 2'58.63"E
Боомтын хөндлүүр -3	49°43'59.27"N	104°57'15.60"E
<b>Боомтын хөндлүүр -4</b>	<b>49°42'29.70"N</b>	<b>104°56'25.72"E</b>
Боомтын хөндлүүр -5	49°41'60.73"N	104°47'54.18"E
<b>Боомтын хөндлүүр -6</b>	<b>49°40'31.20"N</b>	<b>104°45'52.26"E</b>

Эх сурвалж: MINIS төсөл, 2016

Хөндлүүр 4, 6 хоёрын байршлыг УЦС барихад хамгийн тохиромжтой гэж үзсэн тул техник, эдийн засгийн үнэлгээг нь хийсэн. Тиймээс байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын мэдээлэлд үндэслэн тус 2 байршлыг нарийвчлан судлах шаардлагатай. Байгаль орчин, нийгмийн шалгуур үзүүлэлтүүд нь УЦС барих байршлыг сонгоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Шүрэнгийн УЦС-ыг барих боломжтой газруудыг судалж үзсэний дараа урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулах үед Хөндлүүр 4-ийг үргэлжлүүлэн судалсан. Урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулах явцад Шүрэнгийн УЦС төсөл нь Төвийн эрчим хүчний системийн эрчим хүч үйлдвэрлэлд чухал нөлөөтэй төсөл болохыг тогтоосон.

ТЭЗҮ-ийн хүрээнд хийсэн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээгээр (БОННБҮ) өмнө судлагдсан байршлуудыг хянан үзэж, Хөндлүүр 4, 6-г хамгийн оновчтой байршил мөн эсэхийг нь нягталсан. Ийнхүү Хөндлүүр 4, 6 хоёрын байршил УЦС барихад хамгийн тохиромжтой болох нь тогтоогдсон.

Хоёр байршлыг харьцуулахдаа байршлын онцлог, зураг төслийн хувилбаруудыг харгалзан үзнэ. Үүний дараа хамгийн оновчтой байршлыг зураг төслийн шатанд нарийвчлан авч үзнэ. Шүрэнгийн УЦС нь ойролцоогоор 65 м өндөр, 1,200 м урт хөндлүүртэй булдаж нягтруулсан бетон (буюу RCC) далантай байна. Боомтын суурь нь 900 м өргөнтэй, 4.8 тэрбум м<sup>3</sup> эзлэхүүнтэй байхаар тооцоолсон байна. Төслийн хүрээнд нийт 4,5 тэрбум м<sup>3</sup> ус нөөцлөх, үүний 3,8 тэрбум м<sup>3</sup> нь ашигтай нөөц байх усан сан байгуулна. Усан сангийн усны түвшин нь ус бүрэн дүүрэх үед 761 м, үйл ажиллагаа явуулах хамгийн бага үед 739 м тус тус далайн түвшнээс дээш өндөрт байна.

Төсөлд төсөл хэрэгжиж дууссаны дараа логистикийн үйл ажиллагааг дэмжих байгууламж (ажилчдын сууц, агуулах, цех) болгон ашиглах барилгын бааз, цахилгаан, эрчим хүчний байр, шилжүүлэгч, нэвтрэх шинэ зам (225 км), холбох зам болон УЦС-ыг сүлжээнд холбох 73 км орчим дамжуулах шугам зэрэг барилга байгууламжууд багтана.

	<p>Барилга угсралтын явцад чулуу, дүүргэлтийн материалын карьер ажиллах ба урьдчилсан байдлаар 4 сая м3 хэмжээтэй үйлдвэрлэл хийх тооцоотой байна.</p> <p>2) Төслийн бүрэлдэхүүн Сэлэнгэ мөрөнд усан цахилгаан станц барих ТЭЗҮ, барилгын ажил; Хөрөнгө оруулалтын зардлын урьдчилсан тооцоо.</p> <p>3) Хэрэгжилт ЭХЯ нь Сэлэнгэ мөрөн дээр далан барих төслийн байршил, хүчин чадлыг тодорхойлох, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, олон улсын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ажиллана.</p>
<p>Байгаль орчин, нийгмийн нөлөө</p>	<p>Сэлэнгэ мөрөн нь Монгол Улсын хамгийн том мөрөн бөгөөд Хойд мөсөн далайн ай савд багтдаг, ОХУ руу хил дамнан урсдаг. Сэлэнгэ мөрөн нь Байгал нуурт цутгах усны бараг тал хувийг бүрдүүлдэг тул нуурын экосистемд чухал үүрэгтэй.</p> <p>Төлөвлөсөн УЦС-ын хөндлүүр нь Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Орхон багт буюу Сэлэнгэ мөрөнд цутгах Шүрэн голын цутгалаас дээш 3 км-т байрладаг. УЦС-ын боомтыг барьж дууссаны дараа усан сан нь Булган аймгийн Сэлэнгэ, Хангал сумд, түүнчлэн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Хушаат, Цагааннуур сумдыг хамрах болно. Иймд, тус төслийн техник, эдийн засгийн үнэлгээний үе шатанд төслийн байгаль орчин, экологи, нийгэм-эдийн засгийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон төслийн талбарт нөлөөлөх эерэг, сөрөг бүхий л талуудыг судлах шаардлагатай.</p> <p>Төслийн нөлөөллийн бүсийг орон нутгийн болон бүсийн түвшний гэж 2 хувааж байна.</p> <p>Орон нутгийн нөлөөллийн бүс нь усан сан, УЦС-ын байгууламжуудийн ойролцоох газар нутгийг хамрах ба голын эргээс дээш, доош 5 км үргэлжилнэ. Бүсийн түвшний нөлөөллийн бүс нь Сэлэнгэ мөрний ай саваас Байгал нуур хүртэл үргэлжлэх ба намгархаг газрууд, голын адаг, садраа зэргийг хамарна. Бүс нутгийн байгаль орчны үнэлгээнд (БНБОУ) Эрхүүгийн усан сан, УЦС-д үзүүлж болзошгүй нөлөөллийн нэмэлт судалгааг тусгана. Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний хүрээнд Шүрэнгийн УСЦ төслийн орон нутгийн болон бүсийн түвшний нөлөөллийн бүсүүдэд үзүүлэх нөлөөллийг судалж, нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгоно.</p>
<p>Тайлбар</p>	<p><u>Хэрэгжилт:</u> Эрчим хүчний яам 2016 оны 10-р сарын 5-нд Шүрэнгийн усан цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулах, БОНБУ хийх гүйцэтгэгчийг шалгаруулсан. Хороо нь зөвлөх компаниудын бэлтгэсэн ТЭЗҮ, БОНБУ-ний хураангуйг бэлтгэсэн. 2017 оны 3-р сард ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс олон нийтийн хэлэлцүүлэгт бэлдсэн.</p> <p>2019 оны 1-р сард БНБОУ-ний ажлын даалгаврыг эцэслэн, баталсан; 2019 оны 8-р сард МИНИС төсөл ОХУ-ын Екатеринбург хотод зохион байгуулагдсан “Хилийн орчмын усыг хамгаалах, ашиглах тухай Монгол Улс, ОХУ-ын ЗГ хоорондын Хэлэлцээрийг хэрэгжүүлэх Бүрэн эрхт төлөөлөгчдийн ээлжит XV зөвлөгөөн”-д оролцож, батлагдсан БНБОУ-ний ажлын даалгаврын талаар илтгэл тавьж, мэдээлэл өгсөн;</p>

	<p>МИНИС төслийн нэгж Улаанбаатар хотноо болсон “Сэлэнгэ мөрний ус хурах талбайд Монгол Улсын барихаар төлөвлөж буй усны барилга байгууламжтай холбоотой асуудлуудыг цогцоор нь авч үзэх хамтарсан ажлын хэсгийн 2 дугаар хуралдаан"-д оролцож, БНБОУ-ний ажлын даалгаврыг хэрхэн боловсруулж эцэслэсэн талаарх түүхэн замнал, мөн оролцогч талуудаас хэрхэн санал, зөвлөмж авч ажлын даалгаварт тусгасан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгөв. Монгол Улс, ОХУ санал болгож буй төслүүдийн БНБОУ-ний ажлын даалгаврыг эцэслэн боловсруулсныг харилцан хүлээн зөвшөөрч, нэгдсэн нэг ойлголцолд хүрсэн.</p> <p>Төсөл хэрэгжих хугацаа дуусч байгаатай холбогдуулан Бүс нутгийн байгаль орчны үнэлгээг МИНИС төслийн хүрээнд хийхгүй бөгөөд Монгол улсын Засгийн газар үнэлгээг хэрхэн хийх судалж байна.</p> <p>** Тус төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ын 6.3.8 буюу “Хөх морь төслийн хүрээнд өндөр уулын бүсийн Сэлэнгэ, Орхон, Эг, Хэрлэн, Ховд зэрэг томоохон гол мөрөнд урсацын тохируулгатай, олон зориулалтын цуваа усан сангууд байгуулах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж барилгын ажлыг эхлүүлэх” гэсэн заалттай уялдаж байна.</p> <p>Эх сурвалж: Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин), 2013</p> <p>Эх сурвалж: “Шүрэнгийн УЦС” болон “Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах” төслүүдийн хүрээнд Сэлэнгэ мөрний сав газар, Байгал нуурыг хамруулан хийх Бүс нутгийн байгаль орчны үнэлгээний ажлын даалгавар (RFP No. WB/MOF/MINIS/CS/QCBS/1.1.4 (d)/2016)</p>
--	---

**Төслийн дугаар: IV10**

<b>Нэр</b>	<b>Орон нутгийн эрчим хүчний сүлжээг хөгжүүлэх төсөл</b>
<b>Байршил</b>	Говь-Алтай
<b>Хэрэгжүүлэгч агентлаг</b>	ЭХЯ, ХХААХҮЯ, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшил
<b>Зорилтууд</b>	<p>1) Нар, салхи, ус, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх;</p> <p>2) Нүүрсэд түшиглэсэн цахилгаан, дулааны үйлдвэрлэл болон импортын эрчим хүчний хамаарлыг бууруулахад хувь нэмэр оруулах;</p> <p>3) Орон нутгийн эрчим хүчний үйлдвэрлэлд тулгуурлан орон нутгийн үйлдвэрүүдийг байгуулах.</p>
<b>Хүлээгдэж буй үр дүн</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих,</li> <li>- Гадаадаас эрчим хүч импортлоход зарцуулах гадаад валютыг хэмнэх,</li> <li>- Байгаль орчинд ээлтэй эдийн засгийн үйл ажиллагаа явуулах.</li> </ul>
<b>Төслийн өртөг</b>	US\$
<b>Хэрэгжүүлэх хуваарь</b>	<p>Сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэх, хөгжүүлэх мастер төлөвлөгөө: 2022</p> <p>Туршилтын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх: 2023-24</p> <p>Сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэх мастер төлөвлөгөө, сэргээгдэх эрчим хүчийг улс орон даяар ашиглах</p>
<b>Төслийн тодорхойлолт</b>	<p>Үндэслэл</p> <p>2010-аад онд нүүрс олборлож, экспортолсны үр дүнд Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь дэлхийд хамгийн өндөр өсөлттэй гарч байв. Дэлхий даяар нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэж, ашиглахыг хүчтэй</p>



	<p>эсэргүүцэж байгаа тул нүүрсэд түшиглэсэн эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдах боломжгүй юм. Гэвч Монгол Улс нь эрчим хүчний импортын хараат байдлыг бууруулах, гадаад валютын орлого олохын тулд нүүрсийг үргэлжлүүлэн олборлох шаардлагатай болж байна. Монгол Улс нь богино болон дунд хугацаандаа нүүрс ашиглах хэдий ч сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж эрчим хүч үйлдвэрлэх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Монгол Улс нь нар, салхи, ус, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний баялаг нөөцтэй. Тэр дундаа Говь-Алтай аймаг нь сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх хамгийн боломжтой аймаг юм.</p> <p>Төслийн бүрэлдэхүүн хэсэг</p> <p>Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн өмнөд хэсэг нарны эрчим хүчний арвин их нөөцтэй. Мөн нутгийн өмнөд хэсэг салхины эрчим хүч үйлдвэрлэх томоохон байгууламжуудыг суурилуулах өргөн уудам талбайтай. Завхан голын уснаас эрчим хүч үйлдвэрлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглаагүй байна. Түүнчлэн тус аймгийн Алтай, Хангайн нуруу, уулс хоорондын хотгорт газрын гүний дулааны эх үүсвэр бий. Эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нэмэлтээр холбох орон нутгийн эрчим хүчний системийг бий болгохын тулд сэргээгдэх эрчим хүчийг бусад эх үүсвэртэй хослуулсан орон нутгийн эрчим хүчний системийг хөгжүүлэх шаардлагатай. Нар, салхинаас эрчим хүч үйлдвэрлэх орчин үеийн технологийг нэвтрүүлэх туршилтын төслийг нэн даруй хэрэгжүүлэх нь зүйтэй. Газрын гүний дулааныг төрөл бүрийн зориулалтаар ашиглах технологиуд бэлэн байна. Газрын гүний дулааныг эхний ээлжинд орон сууц, хүлэмжийг халаахад ашиглах боломжтой. Сэргээгдэх эрчим хүчний эдгээр эх үүсвэрийг бүрэн дүүрэн хөгжүүлж, ашиглах Засгийн газрын бодлого, зохицуулалтын дагуу мастер төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй. Орон нутгийн нөхцөл байдлыг сэргээгдэх эрчим хүчний хэрэглээтэй уялдуулсан байх шаардлагатай. Эхлээд төрөл бүрийн системийг турших хэрэгтэй. Говь-Алтай аймагт сэргээгдэх эрчим хүчний төрөл бүрийн эх үүсвэрүүдийг хөгжүүлэхээр туршихын сацуу улсын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх цогц бодлого, төлөвлөгөөг боловсруулна.</p> <p>Хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Эрчим хүчний яам нь БОАЖЯ, орон нутгийн засаг захиргаа болон хувийн хэвшилтэй хамтран Сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэх, хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг удирдан, зохион байгуулна. Төр, хувийн хэвшил, орон нутгийн хөрөнгө оруулалтаар орон нутгийг цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах орон нутгийн эрчим хүчний компани байгуулах боломжтой.</p>
<p>Байгаль орчин болон нийгмийн нөлөөлөл</p>	<p>Олон улсын гэрээний дагуу нүүрстөрөгчийн хийн ялгаралтыг бууруулахад ихээхэн хувь нэмэр оруулна.</p>
<p>Тайлбар</p>	

## **Бүлэг 11 Хэрэгжүүлэх төлөвлөгөө**

ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг 4 ангилж, Бүлэг 8-д тусгасан. Мөн эдгээр төсөл, хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг Бүлэг 10-т нэгтгэсэн болно. Энэхүү бүлгийн 11.1-д төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зохицуулалтыг танилцуулсан бөгөөд 11.2-т бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг хариуцаж, хэрэгжүүлэх байгууллагуудыг санал болгосон. Санал болгож буй бүх төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахын тулд Бүлэг 8-д тусгасан хөгжлийн хувилбарын дагуу үе шатуудад хуваасан. Түүнчлэн, 11.3-т хөрөнгө оруулалтын хуваарилалтыг тусгасан болно. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссаны дараах хяналт-шинжилгээ, үнэлгээний санал, арга хэмжээг 11.4-т санал болгов.

### **11.1 ҮХЦТ-д санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт**

#### **11.1.1 Төсөл, хөтөлбөрүүд ба хөгжлийн зорилтууд**

ҮХЦТ нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөгжлийн гурван зорилтыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:


- (a) Хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн бүтэц, экспортыг төрөлжүүлэх (эдийн засгийн хөгжлийн зорилт);
- (b) Ядуурал, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгахын тулд хөдөө, орон нутаг, төв суурин газруудад өгөөжтэй, тогтвортой ажил эрхлэх боломжийг бий болгох (нийгмийн хөгжлийн зорилт);
- (c) Улаанбаатар хотын хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны хэт төвлөрлийн сөрөг үр дагаврыг арилгах замаар хотын байгаль орчны асуудлыг багасгах (байгаль орчны хөгжлийн зорилт).

Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийг онцлог шинжээр нь ялган хоорондын уялдаатай байдлыг хангахын тулд дараах байдлаар 4 ангилсан. Үүнд:

- I. Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд;
- II. Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд;
- III. Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд;
- IV. Ногоон хөгжлийг дэмжих төслүүд багтаж байна.

Зураг 11.1.1-д ҮХЦТ-нд тусгагдсан төсөл, хөтөлбөрүүд, хөгжлийн зорилтуудын хамаарлыг харуулав.

### Зураг 11.1.1 Төсөл, хөтөлбөрүүд, хөгжлийн гурван зорилт бүхий ҮХЦТ-ний бүтэц



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Зураг 11.1.1-д бүс нутгийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогын ерөнхий схемийг үзүүлэв. Энэ нь эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх эдийн засгийн хөнгөлөлтүүд, орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх хот, зам тээвэр, худалдаа арилжааны дэд бүтэц, бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах нийгмийн үйлчилгээ болон эдгээрийн суурь болох хууль, эрх зүй болон институцийн арга хэмжээнүүдээс бүрдэнэ. Монгол Улсын нутаг дэвсгэрийн орон зайн тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс бүс нутгуудад эдийн засгийн хөнгөлөлтүүдийг нэвтрүүлж болно. Хууль, эрх зүйн болон институцийн арга хэмжээ нь бизнесийн орчныг сайжруулна. Нийгмийн үйлчилгээг сайжруулах нь эрүүл ажиллах хүч, үнэ цэнэ, мэдлэгээ хөгжүүлэх эрмэлзэлтэй иргэд, өндөр ур чадвар, технологийг эзэмшсэн хүний нөөцийг бий болгох урьдчилсан нөхцөл юм. Энэ бүгд нь ҮХЦТ-нд санал болгож буй хөгжлийн шинэ загвар болох нийгэм, эдийн засгийн хөгжлийн загвараар замнахад чиглэгдсэн болно.

Санал болгож буй ихэнх төсөл, хөтөлбөрүүдийг Монгол Улсын Засгийн газрын холбогдох агентлагууд хэрэгжүүлнэ. Төрийн бус байгууллага, нийгэмлэг, судалгааны хүрээлэн, хувийн хэвшил, Улаанбаатар хотын захиргаа, орон нутгийн удирдлага зэрэг байгууллагууд зарим төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээгээр оролцоно. Эдгээр байгууллагуудын оролцооноос хамаарч санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийг салбар дундын төсөл, хөтөлбөр, салбарын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр, хот, аймагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд болон бусад төслүүд гэж ангилна. Төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бүтцийг дараах хэсэгт тайлбарлав.

#### 11.1.2 Салбар дундын төсөл, хөтөлбөр

Холбогдох яамд, байгууллагууд салбар дундын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд оролцоно (Хүснэгт 11.1.1). Төслийг хэрэгжүүлэх байгууллага нь төслийн цар хүрээ, бүрэлдэхүүнийг эцэслэн тодорхойлох зорилгоор байгууллага дундын Төслийн удирдах хороо эсвэл үүнтэй дүйцэх ажлын хэсгийг байгуулна. Үүний дараа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хуваарийг тодорхойлж, төсвийг нь бүхэлд нь эсвэл оролцогч байгууллагуудаар гаргаж, хэрэгжилтийг хангана.

### Хүснэгт 11.1.1 Салбар дундын төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллагууд

Д/д	Хариуцах байгууллага	Төслийн нэр
I1.1	Шадар сайдын удирдлага дор ҮХГ	Хилийн Чөлөөт худалдааны бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл*
I1.2	Шадар сайдын удирдлага дор ҮХГ	Улаанбаатар хотын нисэх онгоцны буудлын Эдийн засгийн тусгай бүс (ЭЗТБ)-ийг хөгжүүлэх төсөл
I2	ҮХГ	Аж үйлдвэрийн кластеруудыг дэмжих хөтөлбөрүүд*
I10.2	БОАЖЯ	“Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолборуудыг байгуулах төсөл*
I10.4	БХБЯ	Өвлийн спорт, амралтын төв байгуулах төсөл*
I10.7	БОАЖЯ	Аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх төсөл
II1.1	ХХААХҮЯ	Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл*
II2.1	ХХААХҮЯ	Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл*
II10.1	БШУЯ	МХХТ-д суурилан боловсролын салбарыг бэхжүүлэх төсөл
II10.3	ҮХГ	Хөдөө, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах төсөл
II10.4	ХХМТГ	Програм хангамжийн аутсорсингийг дэмжих төсөл
II10.5	ХХМТГ	МХХТ-ийн экосистемийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх төсөл
III6	ЗТХЯ	Улаанбаатар хотын тойруу зам ба сүлжээг хөгжүүлэх төсөл
III8	ЗТХЯ	Хотын захын болон тойруу замын дагуух орон нутгийн хотуудыг хөгжүүлэх төсөл
III10	УУХҮЯ	Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл
IV2.1	БОАЖЯ	Хүнсний бүтээгдэхүүний хаягдлыг бууруулах төсөл
IV2.3	БШУЯ	Цементийн үйлдвэрийг ашиглан хатуу хог хаягдлыг эргэлтэд оруулах төсөл
IV6	Улаанбаатар	Туул голын усан цогцолбор байгуулах төсөл*
IV7.1	БХБЯ	Хот, суурины ус хангамжийг сайжруулах төсөл*
II7.3	ЭМЯ	Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), тэмбүү, гепатитын халдвар эхээс үрд дамжихаас урьдчилан сэргийлэх төсөл
IV8.1	БХБЯ	Бохир ус цэвэрлэх байгууламж барих, шинэчлэх төсөл
IV8.2	БХБЯ	Улаанбаатар хотын Дулааны цахилгаан станцуудын ашигласан усыг цэвэрлэх байгууламж барьж байгуулах төсөл
IV8.5	ХХААХҮЯ	Мал аж ахуйн фермийн бохир усыг цэвэрлэх байгууламж барих төсөл
IV9	ЭХЯ	Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөл*
IV10	ЭХЯ	Орон нутгийн эрчим хүчний сүлжээг хөгжүүлэх төсөл

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### 11.1.3 Салбарын төсөл, хөтөлбөр

Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн дунд тухайн салбарын төсөл, хөтөлбөр олон байгаа бөгөөд тэдгээрийг Хүснэгт 11.1.2-т жагсаав. Энэ төрлийн төсөл,

хөтөлбөрүүдийг хариуцаж, хэрэгжүүлэх нэг байгууллагыг санал болгосон. 18.1, 18.2, 19.1, 19.2, 19.3, 19.4 дугаартай төслүүд нь эрчим хүчний эх үүсвэр болох ашигт малтмалтай холбоотой тул уг төслүүдийг УУХҮЯ, ЭХЯ хамтран хэрэгжүүлэх байдлаар санал болгосон. IV8.3, IV8.4 дугаартай төслүүдийг БХБЯ, ҮХГ хариуцаж хэрэгжүүлэхээр санал болгосон. ХХААХҮЯ-ны хэрэгжүүлэх ихэнх төслүүд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотой хэрэгжинэ. ХХААХҮЯ нь үйлдвэрлэл, системийн хөгжүүлэлт, суурилуулалт, ашиглалт, менежмент, хөрөнгө оруулалт зэрэг төслийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийг оролцуулж, яамны зүгээс мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, олон улсын буцалтгүй тусламжийн санхүүжилт, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлнэ. Төсөл, хөтөлбөр бүрийн төсвийг хэрэгжүүлэгч байгууллага тооцно.

### Хүснэгт 11.1.2 Салбарын төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллагууд

Д/Д	Хариуцах байгууллага	Төслийн нэр
13.1	ХХААХҮЯ	Ухаалаг хөдөө аж ахуйг дэмжих төсөл
13.2	ХХААХҮЯ	Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл*
14.1	ХХААХҮЯ	Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл
14.2	ХХААХҮЯ	Мал аж ахуйд зориулсан МХТ-ийн хяналтын болон дэмжлэг үзүүлэх системийг нэвтрүүлэх төсөл*
15.1	ХХААХҮЯ	Усжуулалтын төсөл
15.2	ХХААХҮЯ	Тосны ургамлын тариалалтын төсөл
15.3	ХХААХҮЯ	Чацарганы тариалалтын төсөл*
17.1	ХХААХҮЯ	Хөргүүр, зоорийн сүлжээ байгуулах төсөл
17.2	ХХААХҮЯ	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл*
18.1	УУХҮЯ, ЭХЯ	Газрын ховор элементийн хайгуулын төсөл
18.2	УУХҮЯ, ЭХЯ	Эрдэс металлын нөөцийн хайгуулын төсөл
19.1	УУХҮЯ, ЭХЯ	Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл*
19.2	УУХҮЯ, ЭХЯ	Нүүрсний ордын хайгуулын төсөл
19.3	УУХҮЯ, ЭХЯ	Нүүрсний салбарын мастер төлөвлөгөөг боловсруулах төсөл
19.4	УУХҮЯ, ЭХЯ	Нүүрс боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх төсөл
110.1	БОАЖЯ	Үлэг гүрвэлийн музей байгуулах төсөл
110.6	БОАЖЯ, ҮСХ	Аялал жуулчлалын салбарын мэдээллийн сан байгуулах төсөл
111.2	БШУЯ	Малчдын хүүхдэд гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл
112.2	ҮСХ	Малчдын цогц мэдээллийн санг бий болгох төсөл
115	БШУЯ	Бизнест чиглэсэн хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр
116	БШУЯ	Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл
117.1	ЭМЯ	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл*
117.2	ЭМЯ	Эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах төсөл
117.4	ЭМЯ	Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө өгөх /Телемедицин/ болон Оношлогооны зорилго бүхий эрүүл мэндийн хөдөлгөөнт цахим тусламж үйлчилгээг нэвтрүүлэх төсөл
118	ХНХЯ	Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн төсөл
1110.2	ХХМТГ	Хөдөө, орон нутагт МХХТ-ийг хөгжүүлэх, МХХТ-т суурилсан загвар хотыг хөгжүүлэх төсөл
1111	ЗТХЯ	Автозамын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл*
1112	ЗТХЯ	Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл*
1113	ЗТХЯ	Аймгуудын тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах

		төсөл
III4	УБТЗ/МТЗ	Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл*
III5	УБТЗ/МТЗ, ЗТХЯ	Хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл*
III9	БХБЯ	Улаанбаатар шинэ нисэх онгоцны буудлын дагуул хот байгуулах төсөл
III10	ЗТХЯ	Орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэх
III11	БХБЯ	Бүсийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх
IV1	ХХААХҮЯ	Хөрс хамгаалах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх төсөл
IV2.2	ЗТХЯ	Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл*
IV3.1	БХБЯ	Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл*
IV4	БОАЖЯ	Хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламж-ландфилл байгуулах төсөл
IV5.1	БХБЯ	Байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах төсөл
IV5.2	БХБЯ	Хот байгуулалтын салбарын эрх зүйн баримт бичгийн уялдааг хангах төсөл
IV8.3	БХБЯ	Ариутгах татуургын сүлжээг шинэчлэх, өргөтгөх төсөл
IV8.4	БХБЯ	Сумын төвийн бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл*

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

#### 11.1.4 Хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр

Хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил хамтарч оролцоно. Төслүүдийг Хүснэгт 11.1.3-т жагсаав. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотойгоор хувийн хэвшил, судалгааны хүрээлэн болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүрэг бүхий зохицуулах байгууллагуудыг тодорхойлсон. Зохицуулах байгууллага нь шалгуур, стандартыг тогтоож, удирдамж өгөх бөгөөд харин хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагууд нь төслүүдийг хэрэгжүүлнэ. Зохицуулах байгууллага нь төслийн төсвийн хуваарилалтыг хийнэ.

#### Хүснэгт 11.1.3 Хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийг зохицуулах байгууллагууд

Д/д.	Зохицуулах байгууллага	Төслийн нэр
13.3	ҮХГ	Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркуудыг хөгжүүлэх төсөл*
16.1	ҮХГ	Үхрийн аж ахуй эрхлэх төсөл
16.2	ҮХГ	Эрдэнэ шиш даршлах үйлдвэрлэлийн төсөл
16.3	ҮХГ	Малын тэжээлийн төв байгуулах төсөл
16.4	ҮХГ	Хуурай сүү үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх төсөл
II3	БШУЯ	Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл*
III7	Улаанбаатар	Ачаа тээврийн терминалын газрыг ашиглах Улаанбаатар хотын дахин төлөвлөлт хийх төсөл
IV7.2	ХХААХҮЯ	Хөдөөгийн ус хангамжийн өргөтгөлийн төсөл

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### 11.1.5 Хот, аймагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд

Хүснэгт 11.1.4 дэх төслүүдийг хот, нутгийн захиргааны байгууллагууд хариуцан хэрэгжүүлнэ. Орон нутгийн захиргааны байгууллагууд нь оногдсон төслүүдээ хэрэгжүүлэхийн тулд нутгийн иргэд, хувийн хэвшил, холбогдох талуудтай хамтран ажиллаж болно. Хот, аймгийн удирдлага нь холбогдох дэд бүтцийн зардлыг төсөвлөх бөгөөд хандивлагч эсвэл хувийн хөрөнгө оруулагчдаас санхүүжилт бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

#### Хүснэгт 11.1.4 Хот, аймагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд

Д/д	Хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн нэр
110.3	НЗДТГ	Гэр хороолол дахь гар урлалын гудамж байгуулах төсөл
110.5	Налайх дүүргийн ЗДТГ	Налайхын уурхайн музей, соёл, боловсролын төв байгуулах төсөл
IV3.2	Улаанбаатар, зарим аймгуудын ЗДТГ	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл*
IV2.4	НЗДТГ	Эко-парк байгуулах төсөл*

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

Хүснэгт 11.1.5-д жагсаасан 3 төслийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлнэ. II9.1, II9.2 дугаартай төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Бүлгийн динамикийн төвийг олон нийтийн байгууллага, бизнесийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр байгуулах бөгөөд Ерөнхий сайдын удирдлага дор төслийг хэрэгжүүлнэ.

#### Хүснэгт 11.1.5 Төрийн бус байгууллага, ААН, байгууллагын хэрэгжүүлэх төслүүд

Д/д	Хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн нэр
II4	Хараат бус Судалгааны Хүрээлэн	Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр*
II9.1		Бүлгийн динамикийн төв байгуулах төсөл*
II9.2		Гүйцэтгэлийг үр дүнтэй болгоход чиглэсэн үйл ажиллагааны зөвлөгөө өгөх хөтөлбөр

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## **11.2 Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохицуулалт**

### **11.2.1 Бүсчилсэн хөгжлийн нөхцөл**

#### **(1) Суурь нөхцөл**

Бүсчилсэн хөгжил нь тухайн бүс нутгийн хүн амд ашиг хүртээх зорилгоор уугуул нөөц баялгийг нутгийн хүн ам ашиглахад суурилсан нийгэм, эдийн засгийн хөгжлөөр тодорхойлогдох юм. Бүсчилсэн хөгжилд ашиглах хөгжлийн нөөц баялагт байгалийн нөөц, хүний нөөц, санхүүгийн нөөц, технологийн нөөц төдийгүй бүс нутаг дахь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, түүх, соёлын өв багтана. Гэхдээ зарим бүсэд бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай дээрх нөөцүүд хангалттай бус байна. Тиймээс зарим нөөцийг бүсийн гаднаас нөхөх шаардлагатай болно.

Монгол Улсын хувьд шаардлагатай ур чадвар, мэргэшилтэй хүний нөөц болон санхүүгийн нөөцийг гаднаас татаж, бүсчилсэн хөгжлийг хэрэгжүүлэх хэрэгтэй болно. Нэмэлт нөөцийг татах шийдвэрийг тухайн нутгийн иргэд, орон нутгийн засаг захиргаа гаргах нь оновчтой. Гэхдээ олон тохиолдолд ийм шийдвэрийг Засгийн газраас дэмждэг авсан бусад улс орны гаднын хувийн хөрөнгө оруулагчид гаргадаг. Энэ нь нөөц баялгийг тухайн бүс нутгийн хүн амын ашиг тусын тулд ашиглана гэх баталгаа болж чадахгүй.

Бүсчилсэн хөгжилд тухайн бүс нутгийн нөөц баялгийг аль болох ихээр ашиглах нь чухал бөгөөд орон нутгийн иргэдийн ашиг сонирхлыг хууль ёсны дагуу төлөөлж, ард иргэд, нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрээр нэмэлт нөөцийг гаднаас татах хэрэгтэй. Бүсчилсэн хөгжлийн суурь нөхцлийг хангахын тулд тухайн бүс нутгийн захиргааны байгууллагууд иргэдийн дэмжлэгийг хүртэж хангалттай хүчин чадал, чадавхтай байх ёстой.

#### **(2) Бүсчилсэн хөгжилтэй холбоотой хууль тогтоомж, институцийн өөрчлөлт, шинэчлэл**

##### Үндсэн хууль

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан шинэ Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.3-т Монгол Улсын Засгийн газар "салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх" үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан. Энэ нь бүсчилсэн хөгжлийн эрх зүйн үндэс суурийг тавьсан. 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 2-т "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ." гэж заасан.

Мөн Үндсэн хуулинд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,



татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй гэж заасан. Ингэснээр орон нутаг дахь эдийн засгийн бие даасан байдал сайжрах боломж бүрдэх юм.

#### Хот байгуулалтын тухай хууль

1998 онд Хот байгуулалтын тухай анхны хуулийг анхлан баталсан (2008 онд хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан). Хуулийн нэг зорилт нь харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэхэд оршино. Хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичиг нь хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны бусад зураг төслүүдээс бүрдэнэ.

Монгол Улсад Бүс нутгийн хөгжлийн төсөл боловсруулах ажлын захиалагч нь хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна. Мөн бүсийн хөгжлийн төсөл боловсруулах ажлыг эрх бүхий байгууллага улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Хуулийн дагуу Бүс нутгийн хөгжлийн төсөл нь тухайн нутаг дэвсгэрт хот байгуулалтын тодотгосон үнэлгээ хийсний үндсэн дээр бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсийн төвүүд болон нийгэм, соёл, ахуйн үйлчилгээний зохистой хүрээгээр сум дундын төвийг тогтоон бусад бүс нутагтай харилцан уялдаатай харьцангуй бие дааж хөгжих шаардлагыг хангасан байна.

#### Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь 1998 онд анхлан батлагдсан. Энэ хуулийн нэг зорилт нь бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

#### Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль

Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг 2003 онд баталсан. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. Түүнчлэн хуулийн дагуу Улсын Их Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1) Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах; 2) бүсчилсэн хөгжлийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох; 3) эдийн засгийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвч, бүсийн хөгжлийн тулгуур төвүүдийг тогтоох; 4) бүсүүдийн хөгжлийн стратегийг хэлэлцэж батлах; 4) тодорхой бүс нутагт зам тээвэр, эрчим хүч, холбоо, мэдээллийн үндсэн тэнхлэгийн сүлжээг байгуулах бодлогыг тодорхойлох; 6) бүсийн хөгжлийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах.

#### Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2015 онд баталсан. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино. Хуульд тодорхойлсноор “бүсчилсэн хөгжлийн бодлого” гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих

зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг юм.

1986-1987 онд БНМАУ-ын Улсын төлөвлөгөөний комиссын шийдвэрээр БНМАУ-ын нутаг дэвсгэр дэх хүн амын нутагшилт, суурьшлын 2005 он хүртэлх ерөнхий схем"-ийг боловсруулсан боловч батлаагүй. Улмаар 1992-1995 оны хооронд Дэд бүтцийн хөгжлийн яам (хуучнаар)-ны харьяа байсан байгууллага болох Зураг төсөл, судалгааны үндэсний төв "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулсан. "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн хүрээнд Монгол Улсыг 5 үндсэн бүсээр бүсчлэн хөгжүүлэх саналыг дэвшүүлж байсан.

2000 оноос "Хот байгуулалт" ТӨҮГ (хуучнаар)-т Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн зарим хэсэгт тодотгол хийж байсан хэдий ч иж бүрнээр нь шинэчилж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулахгүй өнөөдрийг хүрсэн. Харин тус төслийн агуулгад багтсан Мянганы зам болон дэд бүтцийн босоо 5 тэнхлэгийн чиглэл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн тулгуур төв хотууд, Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегийг УИХ-аас баталсан.

#### Бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд

Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоолоор Баруун бүс, Зүүн бүс, Төвийн бүс, Хангайн бүсийн 2006-2015 оны хөгжлийн хөтөлбөр, 2006 оны 197 дугаар тогтоолоор Улаанбаатарын бүсийн 2006-2015 оны хөгжлийн хөтөлбөрийг тус тус баталсан. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажлын хүрээнд "Хот байгуулалт, зураг төсөл, төлөвлөлтийн институт"-ийг "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцэд харьцангуй бие даалган зохион байгуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 85 дугаар тогтоолоор баталсан. Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) нь 2016 онд "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль"-ийн хүрээнд байгуулагдсан. ҮХГ нь аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд 2016 онд Үндэсний хөгжлийн газар байгуулагдсан бөгөөд тус байгууллага нь аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэсэн Монгол Улсын Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүс, Зүүн бүс, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссан (нэгдүгээр үе шат - 2006-2010, хоёрдугаар үе шат - 2011-2015) тул хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

#### Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд

2003 онд батлагдсанаас хойш Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нийт 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуулийн 6.1-д "Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороо Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллана" гэж заасан. Хуулийн 7.1-д зааснаар "Бүсийн зөвлөл нь бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна".

Хуулийн 7.2-т зааснаар “Зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 1) Зөвлөлийн дарга; 2) тухайн бүсэд багтаж буй аймгийн Засаг дарга; 3) бүсийн хөгжлийн тулгуур төв хотын захирагч”. Хуулийн 7.3-т зааснаар “Зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөллийг оруулж болно: 1) тухайн бүсэд багтаж буй аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал; 2) иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны хамтын ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллага; 3) тухайн бүсийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж буй дотоод, гадаадын хөрөнгө оруулагч байгууллага, аж ахуйн нэгж”. Гэхдээ Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хороо, Бүсийн зөвлөл нь санхүүгийн болон бусад шалтгаанаар байгуулагдаж, үйл ажиллагаа нь хангалттай хэрэгжээгүй.

Цаашид Хот байгуулалтын тухай хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга) зэрэг холбогдох хуулийн уялдааг хангах шаардлагатай байна. Түүнчлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулах хууль эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлагатай.

### **(3) Хэрэгжиж буй хууль тогтоомжууд, институцийн зохион байгуулалт**

“Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан. Түүнчлэн уг тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г тус тус баталсан.

Үүнээс гадна дээрх тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдсан тул “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон.

“Алсын хараа-2050” баримт бичгийн Зорилт 8 “Бүс, орон нутгийн хөгжил”-ийн зорилгыг “Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” гэж тодорхойлсон.

Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Хуулийн төслийг 2020 оны Улсын Их Хурлын 2020 оны намрын чуулганы хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн бөгөөд 2021 оны 1 дүгээр сард хуулийн төслийг Улсын Их Хурлын ажлын хэсэг хэлэлцэнэ.

2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурал Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2015 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хүчингүй болгосон. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7-д хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж заасан байдаг. Шинэ хууль нь Монгол Улсын

хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой байдал, залгамж чанарыг хангах, үндэсний зарчмуудыг тодорхойлох, хөгжлийн бодлогыг боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) нь “Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулж, Засгийн газар 2022 онд батлахаар төлөвлөж байна. Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын баримт бичиг болох Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн бодлогын дагуу боловсруулах, эрх зүйн зохицуулалтыг холбогдох хуулиудад тусган хэрэгжүүлэх нь чухал юм.

“Хөгжлийн зорилтот хөтөлбөр” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичиг юм.

Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад иргэдийн оролцоотойгоор төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх өөрчлөлтүүдийг багтааж, 2011 оны 12 дугаар сард баталсан. Тухайлбал, аймаг, сум, дүүрэг, хорооны хөгжлийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч эдгээр төсөл, хөтөлбөрийн сонголт, хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй байна гэж хуульчилсан.

#### **(4) Орон нутгийн засаг захиргааны чадавх**

##### Засаг захиргааны статус

1992 онд анх батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3.1-д зааснаар “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”, 3.2-т зааснаар “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн том нэгж болох аймаг нь сумдаас бүрдсэн, Засгийн газартай шууд харьцдаг, сумдын санхүү, эдийн засаг, хүн амын чадавхаас давсан чиг үүргийг гүйцэтгэх үүрэгтэй холбох нэгж гэдгээрээ бусад засаг захиргааны нэгжүүдээс ялгаатай.

##### Хүн ам, эдийн засаг

Бүх 21 аймгийн нийт хүн амын тоо 2019 онд 1,757,100 байсан бөгөөд аймгийн дундаж хүн амын тоо 83,671 байсан. Хамгийн олон хүн амтай аймаг болох Хөвсгөл аймгийн хүн амын тоо 2019 онд 135,100 байсан. Нийт 21 аймгийн бүс нутгийн ДНБ 12,391,123 сая төгрөг байсан бөгөөд энэ нь Монгол Улсын ДНБ-ний 33,6%-ийг эзэлж байна. Бүх 21 аймгийн нэг хүнд ногдох бүс нутгийн ДНБ 7,052,000 төгрөг байсан бөгөөд энэ нь Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-ний 63.0% буюу Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ДНБ-ний 44.3%-тай тэнцэж байна.

2018 оны байдлаар бүх 21 аймагт нийт 43,723 хуулийн этгээд үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд энэ тоо нь Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй 170,160 хуулийн этгээдийн 25.7%-ийг эзэлж байна. Монгол Улсад 40 хүн ам тутамд 19 аж

ахуйн нэгж, Улаанбаатар хотод 12 аж ахуйн нэгж ногдож байгаатай харьцуулахад аймгуудад 40 хүн ам тутамд 1 аж ахуйн нэгж ногдож байсан.

### Санхүүгийн чадавх

2019 оны орон нутгийн болон улсын нэгдсэн төсвийн орлогыг Хүснэгт 11.2.1-д нэгтгэн үзүүлэв. Нэг хүнд ногдох орон нутгийн төсвийн орлого нь нэг хүнд ногдох улсын нэгдсэн төсвийн орлогын ердөө 24.7%-тай тэнцэж байна. Орон нутгийн төсвийн орлогын 40 орчим хувь нь одоогийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд үүний 35% нь татварын орлого, 5% нь татварын бус орлого болно. Харин үлдсэн хувийг улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг буюу 8% нь тусламж, 42% нь тусгай зориулалтын шилжүүлэг, 10% нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг бүрдүүлж байна.

### **Хүснэгт 11.2.1 2019 оны орон нутгийн болон улсын нэгдсэн төсвийн нийт орлого**

Бүс /УБ/ Монгол Улс	Нийт орлого (сая төг)	Хүн ам (мян)	Нэг хүнд ногдох орлого (төг/хүн)
Баруун	355,001	412.0	861,653
Хангайн	495,814	605.2	819,256
Төв	526,765	516.6	1,019,677
Зүүн	183,877	223.3	823,452
Нийт бүс	1,561,458	1,757.1	888,656
Улаанбаатар	1,381,386	1,539.8	897,120
Орон нутаг	2,942,844	3,296.9	892,261
Монгол Улс	11,936,638	3,296.9	3,620,564

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, 2019

### **(5) Монгол Улсын төвлөрлийг сааруулах бодлого**

Монгол Улс 1992 онд Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш төрийн захиргааны байгууллагын бүтцийг амжилттай шинэчилж, орон нутгийн захиргааны байгууллагад эрх мэдлийн хуваарилалт хийсэн. Монгол Улс дахь төвлөрлийг сааруулах үйл явцыг дараах байдлаар тоймлов. 1992-1996 онд төвлөрлийг сааруулах бодлогыг идэвхтэй хэрэгжүүлсэн байна. Үүний үр дүнд 1996-2002 онд орон нутгийн захиргааны байгууллага илүү бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулсан байна. Гэсэн хэдий ч орон нутгийн захиргааны байгууллагын чадавх сул байснаас үүдэн төвлөрлийг сааруулах бодлого төдийлөн амжилттай хэрэгжээгүй байна. Энэ нь төвлөрөл саарах бус улам төвлөрөл үүсэхэд нөлөөлсөн.

2002-2013 оны хооронд эрх мэдлийг эргэн төвлөрүүлж, орон нутгийн бие даасан байдал бүтэц, зохион байгуулалт, санхүү, төсвийн хувьд суларсан. 2013 оноос өнөөг хүртэл төвлөрлийг ялангуяа, төсвийн төвлөрлийг сааруулах, иргэдийн оролцоог төрийн удирдлагын бүх түвшинд нэмэгдүүлэх чиглэлээр шинэ арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Эдгээр арга хэмжээ нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд туссан.

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд төвлөрлийг сааруулах чиглэлийн тогтвортой хөгжлийн гол зорилтуудыг тусгасан. Үүний хүрээнд төвлөрлийг сааруулах бодлого, арга хэмжээгээр дамжуулж урт хугацааны тогтвортой хөгжлийн үндсэн нөхцөлүүдийг тодорхойлсон. ТХҮБ 2030-ыг багтаасан “Алсын хараа 2050” баримт бичиг нь үүнийг улам бэхжүүлсэн.

Одоогийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2016 онд Засгийн газрын тогтоолоор батлагдсан төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлогын 2-р үе шатанд (2020-24) төвлөрлийг сааруулах бодлогыг бүрэн хэрэгжүүлэн Засгийн газар, орон нутгийн түвшинд чиг үүргийн оновчтой хуваарилалт бий болж, захиргааны болон төсвийн төвлөрөл саарсан байна. Хүлээгдэж үр дүн нь нийт төрийн албан хаагчийн тоонд орон нутагт ажиллах төрийн албан хаагчдын эзлэх хувийг 33%-аас (2019 оны байдлаар 198,463-аас 66,147) 60%-д хүргэх явдал юм.

## **11.2.2 Санал болгож буй бүсчилсэн хөгжлийн институцийн арга хэмжээ**

### **(1) Шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл**

Дэд хэсэг 11.2 (2)-т дурдсанчлан Монгол Улсын Засгийн газар нь 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдаж бүсчилсэн хөгжлийн эрх зүйн үндэс суурь тавигдсан цагаас хойш бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. 11.2.1 (1) дэд хэсэгт тайлбарласан бүсчилсэн хөгжлийн санаанаас ялгаатай нь бүсчилсэн хөгжлийн өмнөх хүчин чармайлтууд Засгийн газрын санаачилгаар хэрэгжиж ирсэн. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулиар бүсчилсэн хөгжлийн институци болон байгуулагдсан Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хороо, Бүсийн зөвлөл нь санхүүгийн болон бусад шалтгаанаар байгуулагдаж, үйл ажиллагаагаа хангалттай хэрэгжүүлээгүй. Баруун, Хангайн, Төв, Зүүн бүс, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд бүрэн хэрэгжээгүйгээр хугацаа нь дууссан.

Орон нутгийн удирдлага болон санхүүгийн чадавх маш сул байх үед Засгийн газраас бүсийн хөгжлийн бодитой санаачилгууд, хүчин чармайлт гарч байсан нь сайшаалтай. Бүс хоорондын тэнцвэрт байдлыг хадгалсан илүү тогтвортой Монгол Улсын нийгэм, эдийн засгийг бий болгохын тулд Засгийн газрын санаачилгуудыг ашиглан бүсийн хөгжлийг бодитоор хэрэгжүүлэх цаг болсон. Бүсийн хөгжлийн зайлшгүй нөхцөл нь 1) уугуул нөөц баялгийг ашиглах, 2) орон нутгийн засаг захиргааны чадавхыг бэхжүүлэх явдал юм.

### **(2) Япон Улсын бүсчилсэн хөгжлийн жишээ**

Япон Улсад өмнө нь Засгийн газарт эрх мэдэл, хяналт төвлөрдөг байсан ба төвлөрлийг сааруулж, орон нутгийн удирдлагын эрх мэдлийг бэхжүүлж чадсан туршлагатай. Орон нутгийн бие даасан байдлын тухай хууль 1947 онд батлагдсан байдаг бөгөөд тус хуулиар Засгийн газар болон орон нутгийн удирдлагууд хоорондын харилцааг зохицуулсан. Хуулийн дагуу орон нутгийн засаг захиргаа нь муж, хотын захиргаа гэсэн хоёр шатлалтай байна. Орон нутгийн захиргааны байгууллагын эрх мэдэлтэй холбоотой заалтуудыг олон удаа шинэчилсэн байдаг.

Төвлөрлийг сааруулах цогц хууль 2000 онд батлагдсан ба тус хуулиар бүсчилсэн хөгжилд Засгийн газар болон орон нутгийн захиргааны байгууллага хоорондын харилцаа ижил тэгш байх зарчмыг тусгасан. Тус хуулийн хүрээнд нэвтрүүлсэн зарчим нь орон нутгийн захиргааны байгууллагуудын иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг өргөжүүлэх явдал юм. Үүний зэрэгцээ Засгийн газар орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулж зарим үйл ажиллагааг явуулдаг байсан механизмыг болиулсан.

Одоогийн байдлаар мужийн захиргаанаас хотын захиргаа руу чиг үүрэг

шилжүүлэх ажил явагдаж байна. Орон нутгийн захиргаад иргэдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүргээ гүйцэтгэхэд иргэд, хөршийн холбоод чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн орон нутгийн захиргаад чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нөөцийн чадавх, санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарах нь чухал ба үүнд Засгийн газраас дэмжлэг үзүүлнэ. Мөн Засгийн газар болон орон нутгийн захиргааны байгууллагын уялдаа холбоог чиг үүргийн нарийн, тодорхой хуваарилалтыг хийж хангах институцийн механизмыг бий болгох нь чухал юм.

Орон нутгийн бие даасан байдлын тухай хуулийн дагуу орон нутгийн захиргааны байгууллага нь эдийн засгийн хөгжил, нийтийн дэд бүтэц, нийтийн орон сууц, нийгмийн хамгааллын бодлого, нийгмийн эрүүл мэнд зэрэг олон салбарт чиг үүрэг хэрэгжүүлнэ. Орон нутгийн захиргааны байгууллага нь "орон нутгийн чиг үүрэг" болон "хууль ёсны чиг үүрэг"-тэй байна. Хууль ёсны чиг үүргийг Засгийн газрын удирдлага дор хэрэгжүүлнэ. Засгийн газар нь бодлого, зохицуулалтуудыг хэрэгжүүлэх замаар орон нутгийн захиргааны байгууллагуудад хяналт тавина. Орон нутгийн захиргааны байгууллагын бүтэц дэх мужийн захиргаа нь дараах асуудлуудыг хариуцдаг. Үүнд:

- Хотын захиргаад хоорондын уялдаа холбоог хангах;
- Техник, санхүү болон бусад чиглэлээр хотын захиргааны үйл ажиллагаанаас давсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

Хүснэгт 11.2.2-т Засгийн газар, муж, хотын захиргааны үндсэн чиг үүрэг тоймлон үзүүлэв.

**Хүснэгт 11.2.2 Засгийн газар, муж, хотын захиргааны үндсэн чиг үүрэг, салбараар**

	Засгийн газар	Мужийн захиргаа	Хотын захиргаа
1. Төрийн үйлчилгээ	Мужуудтай холбоотой харилцаа холбоо, зохицуулалт	Хотын захиргаатай холбоотой харилцаа холбоо, зохицуулалт	Дотоод удирдлага, гэр бүл, оршин суугчдын бүртгэл
2. Нийтийн хэв журам, аюулгүй байдал	Гадаад харилцаа, батлан хамгаалах	Цагдаа	Галын аюулаас хамгаалах
3. Эдийн засаг, зам тээвэр	Санхүүгийн бодлого, худалдаа, гааль, улсын чанартай хурдны зам, боомт, хөдөлмөр эрхлэлтийн журам	Эдийн засгийн хөгжил, нийтийн дэд бүтэц, орон нутгийн чанартай зам, улсын чанартай хурдны зам, боомт, хөдөө аж ахуй, хөдөлмөр эрхлэлт	Орон нутгийн чанартай зам, боомт
4. Байгаль орчин хамгаалал	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	Ой мод, гол мөрнийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа	Бохир ус зайлуулах, хог хаягдлыг устгах үйл ажиллагаа, цэцэрлэгт хүрээлэн
5. Орон сууц, нийтийн үйлчилгээ		Нийтийн орон сууц	Хот төлөвлөлт, нийтийн орон сууц, ус хангамж

6. Эрүүл мэнд	Эрүүл мэндийн даатгал	Нийгмийн эрүүл мэндийн төвүүд	Сувилахуй
7. Амралт, соёл, шашин шүтлэг			Амралт, чөлөөт цагт зориулсан үйлчилгээ, спорт, номын сан
8. Боловсрол	Үндэсний их, дээд сургуулиуд	Ерөнхий боловсролын сургуулиуд	Сургуулийн өмнөх болон анхан шатны боловсрол
9. Нийгмийн хамгаалал	Тэтгэвэр	Нийгмийн халамж	Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, тэтгэмж, эрүүл мэндийн даатгал, ахмад настны даатгал

Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

### (3) Санал болгож буй арга хэмжээ

Бүлэг 6-д шинээр тодорхойлсон бүс тус бүрийн хөгжлийн нэгдсэн 6 хөтөлбөрийг Бүлэг 8-д санал болгосон. Бүлэг 8-д тусгасан 4 төрөлд хуваасан төсөл, хөтөлбөрүүд нь бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг бүрдүүлнэ. Үүнд зам тээвэр, логистикийн дэд бүтцийн төслүүд, эрчим хүч, усны нөөцийг нэмэгдүүлэх төслүүд, хотын дэд бүтцийн төслүүд, газар тариалан, мал аж ахуй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулалттай холбоотой төслүүд, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг нийгмийн үйлчилгээний төслүүд багтаж байна. Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, хувийн хэвшил болон бусад байгууллагууд хамтран оролцоно.

Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр тус бүрт багтаж буй төслүүдийг хэд хэдэн байгууллага хэрэгжүүлэх тул үйл ажиллагаагаа уялдуулж, цаг хугацаанд нь төслүүдээ хэрэгжүүлэх шаардлага тулгарна. Салбар дундын төслүүдээс ялгаатай нь эдгээр төслүүдийг хариуцаж хэрэгжүүлэх нэг байгууллагыг тодорхойлох нь хүндрэлтэй юм. Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах хоёр нөхцөлийг хангах шаардлагатай. Эдгээр нь 1) хэд хэдэн байгууллагын оролцоог хангах зохицуулалтыг хийх газартай байх, 2) чадавх бүхий захиргааны байгууллагатай байх юм. Нутгийн удирдлагын байгууллагын чадавх хангалтгүй үед эхний үе шатанд Засгийн газрын оролцоо байх шаардлагатай.

Дээрх нөхцлийг хангахын тулд бүс бүрт ҮХГ-ын санаачилгаар холбогдох аймгийн Засаг даргатай нягт хамтран ажиллах Бүсийн хөгжлийн зөвлөл байгуулахыг санал болгож байна. Энэхүү зорилгоор ҮХГ-т бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий шинэ хэлтэс байгуулж болох юм. Уг зөвлөл нь тухайн бүсийн аймгийн засаг дарга, холбогдох яамд болон харьяа байгууллагууд, орон нутгийн аж ахуйн нэгжүүд, ТББ болон бусад байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ. ҮХГ-ын бүтцэд шинээр байгуулагдах хэлтэс нь Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг (БХНХ) хэрэгжүүлэх төсөв санхүүгийн асуудлыг хариуцахын зэрэгцээ нутгийн захиргааны байгууллагад БХНХ боловсруулахад нь дэмжлэг үзүүлнэ. Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ҮХГ-ын Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан хэлтэст эдийн засгийн бүс тус бүрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг томилон ажиллуулахыг зөвлөж байна.



Энэ нь Засгийн газар болон аймгийн засаг захиргааг холбосон бүсийн засаг захиргаа байгуулах эхний алхам болж болох юм. Одоогийн байдлаар бүс нь засаг захиргааны нэгж биш бөгөөд аймгууд нь цөөн хүн амтай, эдийн засаг нь төрөлжөөгүй гэдэг шалтгаанаар чадамж нь хязгаарлагдмал байсаар байна. Бүлэг 6-д үзүүлсэнчлэн шинээр тодорхойлсон бүсүүд нь 200,000~500,000 хүн амтай байна. Бүсийн засаг захиргааны нэгж байгуулснаар бүрэлдэхүүндээ багтаж буй аймгуудын нөөцийг дайчлах, эдийн засгийн үр ашигтай үйл ажиллагааг хөгжүүлэх замаар бүсийн хөгжлийг хангах боломжийг бий болгож болно.

Бүсийн хөгжлийн зөвлөлийг эхэндээ шаардлагатай үед хуралддаг байдлаар байгуулж, ажиллуулна. Улмаар төлөвлөгдсөн үйл ажиллагааг дэмжих чиг үүрэгтэй байгууллага болгон зохион байгуулж болно. Үүнийг Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хийж болно. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад дараах зүйлийг тодорхой болгох шаардлагатай. Үүнд:

- (a) Бүсийн хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орох гишүүдийг оновчтой тодорхойлж, шаардлагатай бүх оролцогч талуудын оролцоог хангах;
- (b) Аймаг, нийслэлийн Засаг даргын санаачилгаар Бүсийн хөгжлийн зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах;
- (c) Төлөвлөлт боловсруулах ажлыг алхамчлан тайлбарлаж, Бүсийн хөгжлийн зөвлөлийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох;
- (d) Яамдын төлөөллийн түвшинг тодорхойлж, цаг тухайд хариуцлагатай шийдвэр гаргах үүднээс холбогдох төв байгууллагуудтай онлайн харилцаа холбоо тогтоох ажлыг тодорхой болгох;
- (e) Бүсийн хөгжлийн сан байгуулах эсвэл бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрт зориулагдсан тусдаа данс нээх зэргээр санхүүжилтийн аргуудыг тодорхой болгох.

Бүсийн хөгжлийн зөвлөлийн үндсэн чиг үүргийг доор жагсаав. Үүнд:

- (a) Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн төслүүдийг хянах;
- (b) Зарим төслүүдийг өөрчлөх, нэмэх;
- (c) Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийн төсөл тус бүрийг хэрэгжүүлэх хугацааг тодорхой болгохын тулд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлох;
- (d) Нэн тэргүүний төслүүдийн төсвийг хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээр нь тооцох.
- (e) Бүсийн хөгжлийн зөвлөлөөс төсвийг тооцсоны дараагаар холбогдох яамдууд төслүүдээ цаг тухайд нь хэрэгжүүлэхийн тулд төсвийг нь гаргана.

Аймгийн захиргааны байгууллагын чадавх сайжирсны дараа Бүсийн хөгжлийн зөвлөл нь нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд бүсүүдэд хэрэгжүүлэх дараа дараагийн төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлж болно. Түүнчлэн Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрүүдэд зориулан тусгай данс нээх буюу бүсийн хөгжлийн төсвийг төсөвлөж болно. Бүсийн хөгжлийн төсвийг бий болгох нь яам, агентлагуудын хувьд салбарын төслүүдээ дэмжих нэмэлт хөшүүрэг болно. Үүнээс гадна аймгийн

захиргааны байгууллага Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулахад дэмжлэг үзүүлнэ.

Бүсийн хөгжлийн зөвлөлийг Монгол Улсын Засгийн газрын бүс нутгийн хөгжлийн албан ёсны институт болгон байгуулсны дараа доорх үйл ажиллагааг хэрэгжүүлж болно. Нэгдүгээрт Бүсийн хөгжлийн зөвлөлийн гишүүнчлэлд дараах байгууллагууд багтаж болно. Үүнд:

- (a) Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд: аймгийн Засаг дарга, хотын захирагч, сумын Засаг дарга, бүсийн хөгжлийн тулгуур төв хот болон орон нутгийн хөгжлийн төв хотын дарга нар;
- (b) Төрийн байгууллагууд: ҮХГ, БХБЯ, ХХААХҮЯ, ЭМЯ, БШУЯ, УУХҮЯ, ЗТХЯ болон бусад төрийн байгууллагууд;
- (c) Хувийн хэвшил: тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй хувийн компани, ТББ, нийгэмлэг зэрэг хувийн хэвшлийн төлөөллүүд;
- (d) Дээрх гишүүдийн дийлэнхийн саналаар зөвшөөрсөн тусгай гишүүд.

Хоёрдугаарт Бүсийн хөгжлийн зөвлөлийн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- (i) Бүсийн хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр, холбогдох бодлого, хамрах хүрээ, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх ажлыг зохицуулах;
- (ii) Аймаг, хот, салбарын агентлагууд, улсын их дээд сургууль, коллеж, төрийн өмчит болон зохицуулалттай компаниуд, хөгжлийн тусгай байгууллагуудын батлагдсан хөгжлийн төлөвлөгөөг бүсийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгах;
- (iii) Бүсийн хөрөнгө оруулалтын жилийн болон урт хугацааны хөтөлбөрийг хянан үзэж, эрэмбэлэж, улсын төсөвт тусгуулах;
- (iv) Бүсийн хөгжлийн зорилт, бодлого, стратегийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн бүс нутагт хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтыг хуваарилах ажлыг дэмжиж, чиглүүлэх;
- (v) Бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд, улсын коллеж, их дээд сургуулиуд, төрийн өмчит болон зохицуулалттай компаниудын хэрэгжүүлж буй хөгжлийн төслүүдийн хяналт, үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах.

## 11.3 Хэрэгжүүлэх үе шат ба хөрөнгө оруулалтын хөтөлбөр

### 11.3.1 Төсөл, хөтөлбөрүүдийн үе шат

Бүлэг 8-д санал болгосон төсөл, хөтөлбөрүүдийг 4 ангилж, хуваасан. Үүнд: 1) эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд, 2) бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд, 3) орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд болон 4) ногоон хөгжлийг дэмжих төслүүд багтаж байна. Бүх төсөл, хөтөлбөрийг гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүний зэрэгцээ төсөл, хөтөлбөрүүдийг эрэмбэ, дараалалтайгаар хэрэгжүүлнэ. Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн эрэмбэ дарааллыг тодорхойлох зорилгоор тайлангийн 8.1-д үзүүлсэн хөгжлийн хувилбартай уялдуулан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үе шатыг Хүснэгт 11.3.1-д тусгав.

**Хүснэгт 11.3.1 Төсөл, хөтөлбөрүүдийн үе шат**

Төсөл, хөтөлбөр	I үе шат (~2025)	II үе шат (2026-30)	III үе шат (2031~40)
<b>I. Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Уул уурхайн салбар нь хариуцлагатай уул уурхай руу аажмаар шилжих ба улсын хэмжээнд ЭЗ-ийн гол салбар хэвээр байна.</li> <li>- Түүхий нүүрсийг угаан, баяжуулж, шахмал түлш үйлдвэрлэн, чанартай нүүрсийг дотоодын зах зээлд нийлүүлнэ.</li> <li>- Газар тариалан болон мал аж ахуйн гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх эдийн засгийн шинэ үйл ажиллагааг нэвтрүүлнэ.</li> <li>- Чацаргана болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж эхэлнэ.</li> <li>- Томоохон хотуудыг холбосон гол авто замын дагуу хагас эрчимжсэн мал, амьтны аж ахуйг хөгжүүлэн, чанартай мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.</li> <li>- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослуулсан аж ахуйг хөгжүүлнэ.</li> <li>- Дотоодын малын тэжээл болон хүнсний ногооны хэрэгцээг хангахын тулд газар тариаланг өргөжүүлнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хариуцлагатай уул уурхайг өргөн хүрээнд хөгжүүлэх ба уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь буурна.</li> <li>- Цэвэр нүүрс үйлдвэрлэх шинэ технологи нэвтрүүлнэ.</li> <li>- Төмөр, зэсийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.</li> <li>- Уран, газрын ховор элементүүд зэрэг уул уурхайн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.</li> <li>- Чацаргана болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластерыг бүрэн хөгжүүлж эцсийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлнэ.</li> <li>- Хөргүүр, зоорийн сүлжээ байгуулж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох системийг нэвтрүүлнэ.</li> <li>- Бусад үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж эхэлнэ.</li> <li>- Инновацид суурилсан ХАА-н салбарын хөгжил, МХХТ-д суурилсан мал аж ахуйг өргөжүүлнэ.</li> <li>- ОХУ, БНХАУ-ын хил</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- МХХТ бүхий үйлдвэрлэлийн кластеруудад түшиглэн эдийн засаг, экспортын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх боломжийг бүрэн ашиглана.</li> <li>- Өндөр бүтээмжтэй газар тариалан, мал аж ахуй эрхэлнэ.</li> <li>- Орон нутгийн онцлогтой бүтээгдэхүүнийг ашиглан аялал жуулчлал, алжаал тайлах үйлчилгээ хослуулсан цогцолборыг байгуулна.</li> <li>- Үйлчилгээнд суурилсан кластеруудыг хөгжүүлнэ.</li> <li>- Дэлхийн зах зээлд чанараараа танигдсан брендийг бий болгох экспортын бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ.</li> <li>- Үйлчилгээнд суурилсан кластеруудыг хөгжүүлж, хил дагуух чөлөөт бүс болон эдийн засгийн тусгай бүсүүдийг бүрэн хөгжүүлнэ.</li> </ul>

	<p>- Инновацид суурилсан ХАА-н салбарыг хөгжүүлнэ. МХХТ-д суурилсан мал аж ахуйг хөгжүүлнэ.</p> <p>- Улаанбаатар хотын ойролцоо аж үйлдвэрийн парк, сонгогдсон зарим газруудад хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркыг хөгжүүлнэ.</p> <p>- Хүний гараар бүтээгдсэн аялал жуулчлалын үзмэрүүдийг хөгжүүлнэ.</p>	<p>дагуух чөлөөт бүс болон эдийн засгийн тусгай бүсүүдийн хөгжлийг эрчимжүүлнэ.</p> <p>- Олон төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор дотоодын аяллын агентлаг, тур операторууд нь олон улсын аялал жуулчлалын агентлагуудтай шууд хамтран ажиллана.</p>	
<p><b>II. Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд</b></p>	<p>- Нийгмийн салбарын төсөв, хөрөнгийг бүхэлд нь эргэн харж, дахин хуваарилалт хийнэ.</p> <p>- Мэргэжлийн боловсрол, дээд боловсролын тогтолцоо болон сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог сайжруулах боловсролын салбарын цогц шинэчлэлийг эхлүүлнэ.</p> <p>- Анхан шатны болон урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлнэ.</p> <p>- Малчдыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p> <p>- Ур чадварыг сайжруулах сургалт, ур чадварт тохирсон ажлын байрны зуучлалыг бий болгоно.</p>	<p>- Сургуулийн өмнөх болон бага боловсролын тогтолцоог сайжруулж нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ загварын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлнэ.</p> <p>- Хөгжлийн шинэ загвар руу шилжиж, нийгмийн сэтгэлгээ өөрчлөгдөхөд хүүхдүүд чухал үүрэг гүйцэтгэнэ.</p> <p>- Эрүүл мэндийн анхан шатны болон урьдчилан сэргийлэх тусламжийг түгээн эрүүл ажиллах хүчийг нэмэгдүүлнэ.</p>	<p>- Гадаадад ажиллаж, амьдарч байгаад Монгол Улсад буцаж ирсэн иргэдийн нийгмийн асуудлыг орхигдуулалгүй бүх хүнд хүртээмжтэй, чанартай нийгмийн цогц үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>- Иргэдийн амьжиргаагаа дээшлүүлэх үйл ажиллагааг экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд нийлүүлэлт хийдэг орон нутгийн үйлдвэрлэлтэй холбосноор ядуурлыг бүрэн устгана.</p>
<p><b>III. Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд</b></p>	<p>-Тойрог коридорын хэсэг болох гол замуудыг сайжруулна.</p> <p>-Аймгийн төвүүдийг холбосон замуудыг хатуу хучилттай болгоно.</p> <p>-Улаанбаатар хотын дагуул хотуудыг хөгжүүлж эхэлнэ.</p> <p>-Аялал жуулчлал, аж үйлдвэр, уул уурхайд түшиглэсэн хотуудын дэд бүтцийг сайжруулна.</p> <p>-Цөөн тооны хотыг сонгож, олон улсын худалдаа логистикийн төв болгон хөгжүүлж эхэлнэ.</p> <p>-Төмөр замын бүтээн байгуулалт, хилийн боомтын барилга,</p>	<p>-Монгол Улсын нутаг дэвсгэрийг жигд хамарсан тойрог коридорыг байгуулна.</p> <p>-Баруун бүсийн Улиастай болон Зүүн бүсийн Өндөрхаан хотыг Улаанбаатар хотоор дайруулан холбосон харилцаа холбооны суурь шугамыг барина.</p> <p>- Улаанбаатар хотын дагуул хотуудыг эрчимтэй хөгжүүлнэ.</p> <p>-Хотын зэрэглэлийн хувьд томд тооцогдох хот, суурингуудыг тодорхойлсон чиг үүргийн дагуу хөгжүүлнэ.</p> <p>-Хөдөө орон нутгийн</p>	<p>-Тойрог коридорыг байгуулснаар авто замын гол сүлжээ бүрэн ашиглалтад орох ба түүнийг даган хөдөө, орон нутгийг холбосон замын сүлжээ өргөжин, хөгжинө.</p> <p>-Түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэр, логистикийн төвүүдийг холбосон олон үйлдэлт системд суурилсан тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.</p> <p>-Олон үйлдэлт системийн нэг хэсэг болох төмөр замыг</p>

	байгууламж зэрэг тээвэр, логистикийн сүлжээг бүрдүүлдэг томоохон байгууламжуудын ТЭЗҮ-г боловсруулна. -Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эд бэлтгэх, тээвэрлэх, бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах зорилгоор хөдөө орон нутгийн авто замыг сайжруулна.	авто замыг үргэлжлүүлэн сайжруулна. -Уул уурхай болон аялал жуулчлалын томоохон бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг барьж, байгуулна.	зорчигч тээвэрт түлхүү ашиглана. -Том хотуудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсноор хотуудын зэрэглэл илүү боловсронгуй болно. -Нэг нэгнийхээ хөгжилд эерэгээр нөлөөлдөг томоохон хотуудын сүлжээг бий болгохын тулд хөрш зэргэлдээ орнуудын хотуудыг (Өвөр Монголын өөртөө засах орон, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын хот г.м.) хотын зэрэглэлд хамруулна.
<b>IV. Ногоон хөгжлийг дэмжих төслүүд</b>	-Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны сөрөг асуудал тулгарсаар байна. -Хариуцлагатай уул уурхайн талаар иргэдийн мэдлэг нэмэгдэнэ. -Улаанбаатар хотын дагуул хотууд хөгжиж, нийслэл хотод тулгардаг байгаль орчны асуудлууд багасна. -Гэр хорооллын амьдрах орчин сайжирна. -Хяналттай бэлчээрийг ашигладаг болно. -Авто машины хаягдлыг дахин боловсруулж эхэлснээр дахин боловсруулалт хийдэг нийгмийг цогцлоож эхэлнэ. -Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор байгаль орчны асуудалд хяналт тавих орон нутгийн захиргааны чадавхыг байнга сайжруулна.	-Хариуцлагатай уул уурхайн талаар иргэдийн мэдлэг нэмэгдэж, уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны сөрөг асуудал буурч эхэлнэ. -Улаанбаатар хотын дагуул хотууд хөгжиж, нийслэл хотод тулгардаг байгаль орчны асуудлууд улам буурна. -Гэр хорооллын амьдрах орчин улам сайжирна. -Аймгийн төвүүдэд хотод тулгардаг байгаль орчны асуудлууд тулгарч эхэлнэ. - Дахин боловсруулалтын бизнесүүд өргөжиж эхэлнэ. -Бэлчээр ашиглалттай холбоотойгоор орон нутгийн захиргааны байгаль орчны асуудалд хяналт тавих чадавх сайжирна.	-Орон нутагт байгаль орчны хяналт ихээхэн сайжирна. -Орон нутгийн төсвийг нэмэгдүүлсэнээр хатуу хог хаягдлын менежмент, ус хангамж, ус зайлуулах сувагтай холбоотой байгаль орчинд тулгамдаж буй асуудлууд багасна. -Нийслэл хот нөөц бололцоогоо ногоон байгууламж, амарч зугаалах орчин бүхий чанартай амьдрах орчинг бүрдүүлэхэд ашиглана.

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### 11.3.2 Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

#### (1) Төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлохын тулд гурван үе шатад хуваах байдлаар тэргүүлэх чиглэлүүдийг нь үнэлсэн. Төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийн ерөнхий тооцоог үе шатуудаар гаргаж, Хүснэгт 11.3.2-оос 11.3.5-т төсөл тус бүрээр харуулав. Хүснэгт 11.3.2-т улаанаар тодруулсан төслийн зардал нь төслийн цар хүрээ, үйл ажиллагааг харгалзан ерөнхийлөн тооцоолсон зардал болно.

Тус тайлангийн 8.3-т дурдсан бүс нутгийн хөгжлийн 6 нэгдсэн хөтөлбөрийг мөн үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрт багтаж буй төслүүд нь хөрөнгө оруулалтаас хамаарах ч нэгдсэн хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах үүднээс зарим төслүүдийг тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай байж болох юм. Хөрөнгө оруулалтын нарийн тооцооллыг хийхэд төслүүдийн хэрэгжилтэд нөлөөлөх бусад хүчин зүйлсийг нэмж тусган оруулж болно.

Хөрөнгө оруулалтын нарийн тооцоололд үндэслэн төсөл, хөтөлбөрүүдийг хамаарах яамд, агентлагуудын төлөвлөгөөнд тусгана. 11.2.2 хэсэгт санал болгосноор Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж төсөв, хөрөнгийг тусгайлан төсөвлөж болно. Ингэснээр яамд, агентлагуудын Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг илүү үр дүнтэй болгож болно.

#### Хүснэгт 11.3.2 Санал болгож буй эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүдийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Төслийн дугаар	Төслийн нэр	Хэрэгжүүлэгч	Төслийн зардал (сая ам.доллар)			
			Нийт	I үе шат	II үе шат	III үе шат
11	Чөлөөт худалдааны бүс, Эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлэх төслүүд	ТХХТ	164	64	50	50
11.1	Хилийн Чөлөөт худалдааны бүс болон Эдийн засгийн тусгай бүсүүдийг дэмжих төсөл *	ТХХТ	300	100	100	100
11.2	Улаанбаатар хотын нисэх онгоцны буудлын Эдийн засгийн тусгай бүс /ЭЗТБ/-ийг хөгжүүлэх төсөл	ТХХТ	50	25	25	
12	Аж үйлдвэрийн кластеруудыг дэмжих хөтөлбөрүүд	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ҮХГ)	15	15		
12.1	Чацарганы үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл*	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ҮХГ)	5	5		
12.2	МАН-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төсөл *	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ҮХГ)	5	5		
13	Инновацид суурилсан ХАА-н салбарыг хөгжүүлэх төслүүд					
13.1	Ухаалаг хөдөө аж ахуйг дэмжих төсөл	ХХААХҮЯ	1	1		
13.2	Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл *	ХХААХҮЯ	3	3		

13.3	Хөдөө аж ахуйн мэдээллийн технологийн паркийг хөгжүүлэх төсөл *	ТХХТ	26	26		
14	МАН, газар тариалангийн салбар хосолсон төслүүд					
14.1	Тэжээлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх төсөл	ХХААХҮЯ	5	5		
14.2	Мал аж ахуйн салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх төсөл*	ХХААХҮЯ	3	3		
15	Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх төслүүд					
15.1	Усжуулалтын төсөл	ХХААХҮЯ	14	14		
15.2	Тосны ургамлын тариалалтын төсөл	ХХААХҮЯ	5	5		
15.3	Чацарганы тариалалтын төсөл*	ХХААХҮЯ	5	5		
16	Үхрийн аж ахуйн хосолсон төслүүд					
16.1	Үхрийн аж ахуй эрхлэх төсөл	ТХХТ(ҮХГ)	3	3		
16.2	Эрдэнэ шиш даршлах үйлдвэрийн төсөл	ТХХТ(ҮХГ)	12	12		
16.3	Малын тэжээлийн төв байгуулах төсөл	ТХХТ(ҮХГ)	3	3		
16.4	Хуурай сүү үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх төсөл	ТХХТ(ҮХГ)	3	3		
17	Хөдөө аж ахуйн салбарын зах зээлийн орчинг сайжруулах төслүүд					
17.1	Хөргүүр, зоорийн сүлжээ байгуулах төсөл	ХХААХҮЯ	2	2		
17.2	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох систем нэвтрүүлэх төсөл*	ХХААХҮЯ	5	5		
18	Уул уурхайн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх төсөл, хөтөлбөрүүд					
18.1	Газрын ховор элементийн хайгуулын төсөл	УУХҮЯ, ЭХЯ	5	5		
18.2	Эрдэс металлын нөөцийн хайгуулын төсөл	УУХҮЯ, ЭХЯ	5	5		
19	Нүүрсний салбарын шинэчлэлийн төслүүд	УУХҮЯ, ЭХЯ				
19.1	Нүүрс тээвэрлэлт, нүүрсний экспортыг дэмжих төсөл*	УУХҮЯ, ЭХЯ	50	50		
19.2	Нүүрсний ордын хайгуулын төсөл	УУХҮЯ, ЭХЯ	10	10		
19.3	Нүүрсний салбарын мастер төлөвлөгөөг боловсруулах төсөл	УУХҮЯ, ЭХЯ	5	5		
19.4	Нүүрс боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх төсөл	УУХҮЯ, ЭХЯ	5	5		
110	Жуулчдыг татах шинэ үзвэрүүд бүхий аялал жуулчлалыг цогц хөгжүүлэх төслүүд					
110.1	Үлэг гүрвэлийн музей байгуулах төсөл	ТХХТ (БОАЖЯ)	5	5		
110.2	“Өртөө” авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл*	ЗТХЯ, БОАЖЯ, БХБЯ	15	5	5	5
110.3	Гэр хороололд гар урлалын гудамж байгуулах төсөл	ТХХТ (НЗДТГ)	5	5		
110.4	Өвлийн спорт, амралтын төв байгуулах төсөл*	ЗТХЯ, БОАЖЯ, БХБЯ	10	5	5	
110.5	Налайхын уурхайн музей, соёл, боловсролын төв байгуулах төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (Налайх дүүрэг)	20	5	10	5
110.6	Аялал жуулчлалын салбарын мэдээллийн сан байгуулах төсөл	БОАЖЯ, ҮСХ	5	5		

110.7	Аялал жуулчлалын кластерыг хөгжүүлэх төсөл	Холбогдох байгууллагууд (БОАЖЯ)	10	10		
-------	--	---------------------------------	----	----	--	--

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Хүснэгт 11.3.3 Санал болгож буй бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүдийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Төслийн дугаар	Төслийн нэр	Хэрэгжүүлэгч	Төслийн зардал (сая ам.доллар)			
			Нийт	I үе шат	II үе шат	III үе шат
II1	Залуу малчдыг дэмжих төслүүд					
II1.1	Малчдыг дэмжих бааз байгуулах төсөл *	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ХХААХҮЯ)	80	30	30	20
II1.2	Малчдын хүүхдэд гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл	БШУЯ	60	20	20	20
II2	Мэдээлэл, харилцаа холбооны технологийг мал аж ахуйн салбарт нэвтрүүлэх төслүүд					
II2.1	Нутгийн удирдлага болон малчдын харилцаа холбоог бэхжүүлэх төсөл *	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ХХААХҮЯ)	15	5	10	
II2.2	Малчдын цогц мэдээллийн санг бий болгох төсөл	ҮСХ, Аймгийн ЗДТГ	15	5	10	
II3	Залуучууд, насанд хүрэгчдийн ур чадварыг сайжруулах, ажлын байр бий болгох төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (БШУЯ)	15	3	5	7
II4	Залуу эмэгтэйчүүдийн ажил, мэргэжил дээшлүүлэх, дэмжих хөтөлбөр *	Хараат бус судалгааны хүрээлэн	9	4	3	2
II5	Бизнес чиглэсэн хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр	БШУЯ	30	6	12	12
II6	Боловсролын салбарын өргөн хүрээтэй шинэчлэлийн төсөл*	БШУЯ	37	7	20	10
II7	Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл, хөтөлбөрүүд					
II7.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг сайжруулах төсөл *	ЭМЯ	43	13	20	10
II7.2	Эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах төсөл	ЭМЯ	20	10	10	
II7.3	Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), тэмбүү, гепатитын халдвар эхээс хүүхдэд дамжихаас урьдчилан сэргийлэх төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ЭМЯ)	1	1		
II7.4	Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө өгөх /Телемедицин/ болон Оношлогооны зорилго бүхий эрүүл мэндийн хөдөлгөөнт цахим тусламж үйлчилгээг нэвтрүүлэх төсөл	ЭМЯ	50	10	20	20
II8	Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн төсөл	ХНХЯ	26	6	10	10
II9	Бизнесийн шинэ соёл, сэтгэлгээг хөгжүүлэх төслүүд					
II9.1	Бүлгийн динамикийн төв байгуулах төсөл*	Бүлгийн динамикийн төв (шинэ)	13	3	10	



II9.2	Гүйцэтгэлийг үр дүнтэй болгоход чиглэсэн үйл ажиллагааны зөвлөгөө өгөх хөтөлбөр	Бүлгийн динамикийн төв (шинэ)	13	3	10	
II10	МХХТ-ийг хөгжүүлэх, нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрүүд					
II10.1	МХХТ-д суурилан боловсролын салбарыг бэхжүүлэх төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (БШУЯ)	1			
II10.2	Хөдөө, орон нутагт МХХТ-ийг хөгжүүлэх, МХХТ-т суурилсан загвар хотыг хөгжүүлэх төсөл	ХХМТГ	1			
II10.3	Хөдөө, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ҮХГ)	1			
II10.4	Програм хангамжийн аутсорсингийг дэмжих төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ХХМТГ)	1			
II10.5	МХХТ-ийн экосистемийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх төсөл	ХХМТГ	1			

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

### Хүснэгт 11.3.4 Санал болгож буй нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүдийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Төслийн дугаар	Төслийн нэр	Хэрэгжүүлэгч	Төслийн зардал (сая ам.доллар)			
			Нийт	I үе шат	II үе шат	III үе шат
III1	Автозамын тойрог сүлжээ барьж байгуулах төсөл*	ЗТХЯ	248	123	125	
III2	Аймаг хоорондын авто замуудыг барих, сайжруулах төсөл *	ЗТХЯ	390	50	211	129
III3	Аймгуудын тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах төсөл	ЗТХЯ	709	214	284	211
III4	Улаанбаатар хотыг тойрон гарах төмөр замын шугам (Богд Хаан шугам) сүлжээг барьж байгуулах төсөл*	УБТЗ/МТЗ	400	300	100	
III5	Хойд-урд чиглэлийн төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл *	УБТЗ/МТЗ, ЗТХЯ	252	202	50	
III6	Улаанбаатар хотын тойруу зам, сүлжээг хөгжүүлэх төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ЗТХЯ)	80	20	40	20
III7	Улаанбаатар хотын ачаа тээврийн терминалын газрыг ашиглан дахин төлөвлөлт хийх төсөл	ТХХТ (УБТЗ)	50	10	40	
III8	Хотын захын болон орон нутгийн тойруу замуудыг хөгжүүлэх төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ЗТХЯ)	23	15	8	
III9	Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудалд түшиглэсэн дагуул хот байгуулах төсөл *	ТХХТ (БХБЯ)	11	6	5	
III10	Орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэх	ЗТХЯ	72	14	48	36
III11	Бүсийн болон орон нутгийн хотуудыг хөгжүүлэх	БХБЯ	106	42	40	24

III12	Орхон гол дээр урсацын тохируулга хийж, говийн бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ЭХЯ, БОАЖЯ)	830	30	500	300
-------	--	--	-----	----	-----	-----

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

**Хүснэгт 11.3.5 Санал болгож буй ногоон хөгжлийг дэмжих төслүүдийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр**

Төслийн дугаар	Төслийн нэр	Хэрэгжүүлэгч	Төслийн зардал (сая ам.доллар)			
			Нийт	I үе шат	II үе шат	III үе шат
IV1	Хөрс хамгаалах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх төсөл	ХХААХҮЯ	1	1		
IV2	Хог хаягдлыг дахин боловсруулах төслүүд					
IV2.1	Хүнсний бүтээгдэхүүний хаягдлыг бууруулах төсөл	Яамд, агентлагууд хамтарна (ХХААХҮЯ)	1	1		
IV2.2	Хаягдал автомашиныг дахин боловсруулах парк байгуулах төсөл*	ЗТХЯ	50	10	20	20
IV2.3	Цементийн үйлдвэрийг ашиглан хатуу хог хаягдлыг эргэлтэд оруулах төсөл	Яамд, агентлагууд хамтарна (БШУЯ)	1	1		
IV2.4	Эко-парк байгуулах төсөл*	НЗДТГ, МХХДБҮХ	108	43	45	20
IV3	Гэр хорооллыг хөгжүүлэх төслүүд					
IV3.1	Гэр хорооллыг хөгжүүлэх талаарх дүрэм, журам, заавар, нормыг боловсруулах төсөл*	БХБЯ	1	1		
IV3.2	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл*	БОАЖЯ, БХБЯ	57	27	30	
IV4	Хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламж-ландфилл байгуулах төсөл	БОАЖЯ	5	5		
IV5	Барилга байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах, сэргээн засварлах төслүүд					
IV5.1	Насжилт урттай барилга байгууламжийг барьж байгуулах төсөл	БХБЯ	1	1		
IV5.2	Хот байгуулалтын салбарын хууль эрх зүйн баримт бичгийн уялдааг хангах, эрх зүйн тогтолцоог шинэчлэх төсөл		1	5		
IV6	Туул голын усан цогцолбор байгуулах төсөл*	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (БХБЯ)	229	9	150	70
IV7	Ус хангамжийг сайжруулах төслүүд					
IV7.1	Хот, суурины ус хангамжийг сайжруулах төсөл *	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (БХБЯ)	322	222	100	
IV7.2	Хөдөөгийн ус хангамжийн өргөтгөлийн төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ХХААХҮЯ)	38	20	18	
IV8	Бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулах төслүүд					
IV8.1	Бохир ус цэвэрлэх байгууламж барих, шинэчлэх төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (БХБЯ)	369	108	261	
IV8.2	Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин боловсруулж, техникийн зориулалтаар ашиглах үйлдвэр байгуулах төсөл	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (БХБЯ)	96	60	36	
IV8.3	Ариутгах татуургын сүлжээг шинэчлэх, өргөтгөх төсөл	БХБЯ, ҮХГ	265	103	162	

IV8.4	Сумын төвийн бага оврын цэвэрлэх байгууламж барих төсөл *	БХБЯ, ҮХГ	34	9	25	
IV8.5	Мал аж ахуйн фермийн бохир усыг цэвэрлэх байгууламж барих төсөл	ХХААХҮЯ, БОАЖЯ, НЗДТГ	41	31	10	
IV9	Сэлэнгэ мөрний усан цахилгаан станцын далан байгуулах төсөл*	Яамд, агентлагууд хамтран хэрэгжүүлнэ (ЭХЯ)	109	9	100	
IV10	Орон нутгийн эрчим хүчний сүлжээг хөгжүүлэх төсөл	Холбогдох байгууллагууд (ЭХЯ)	20	100	250	

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## (2) Хөрөнгө оруулалтын хуваарилалт

Хүснэгт 11.3.2-оос 11.3.5-т үзүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг Хүснэгт 11.3.6-д нэгтгэн үзүүлэв. Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийг 2040 оныг хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хөрөнгө оруулалт нь 6,507 сая ам.доллар болж байгаа бөгөөд эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүдэд 774 сая ам.доллар (11.9%), бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүдэд 432 сая ам.доллар (6.6%), орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүдэд 3,197 сая ам.доллар (49.1%), ногоон хөгжлийг дэмжих төслүүдэд 2,104 сая ам.доллар (32.3%) тус бүр ногдож байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн нийт хөрөнгө оруулалт нь 8,428,297 тэрбум төгрөг буюу 3,025,232 сая ам.доллар (1 ам.доллар = 2,786 төгрөг) болж байгаа ба дээрх тооцоонд Таван толгойн уурхайн 2 мега төслийг тусгаагүй тохиолдолд 127,443 тэрбум төгрөг буюу 45,744 сая ам.доллар болж байна. Хэрэв 1.0 тэрбум төгрөгөөс дээш зардал бүхий бусад мега төслүүдийг үл тусгасан тохиолдолд үлдсэн төсөл, хөтөлбөрүүдэд шаардлагатай нийт хөрөнгө оруулалт нь 27,014 тэрбум төгрөг буюу 9,697 сая ам.доллар болно. Хүснэгт 11.3.6-д үзүүлсэн ҮХЦТ-ний хүрээнд санал болгож буй 2040 оныг хүртэл хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн зардал нь 2050 он хүртэл хэрэгжүүлэх мега төслүүдийг эс тооцвол урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын зардлын 67 хувьтай тэнцэж байгаа юм.

### Хүснэгт 11.3.6 4 төрлийн төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын хуваарилалт

Төслүүд	Хөрөнгө оруулалт (сая ам.доллар)			
	Нийт	I үе шат	II үе шат	III үе шат
Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүд	774	414	200	160
Бүх талын оролцоо, хүртээмжийг сайжруулах төслүүд	432	131	190	111
Орон зайн төлөвлөлтийг бэхжүүлэх төслүүд	3,197	1,026	1,451	720
Ногоон хөгжлийг дэмжих төслүүд	2,104	682	1,062	360
Нийт	6,507	2,253	2,903	1,351

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Төслийн баг

## **11.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээ**

### **11.4.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ**

Хөгжлийн бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийдэг. Шаардлагатай тохиолдолд тодорхой бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад тусгадаг хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, чиглэлд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, өөрчилж болно.

Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт болон гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийдэг. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээнд хэрэгжих хугацаа, төсвийн гүйцэтгэл, төсөл, хөтөлбөрийн явц, хэрэгжиж дуусах хугацаа зэргийг хамруулдаг. Түүнчлэн төсөл хэрэгжих явцад ашиглагдаж буй биет байгууламжийн ашиглалт, төслийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор төслийн үйл ажиллагаа, менежментийн хяналт-шинжилгээг хийж болно. Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээг хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө эсвэл хөгжлийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн нийт хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн ерөнхий үр нөлөөнд хийнэ.

Хөгжлийн төсөл, хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд багц индексийг ашигладаг. Хэрэгжилтийн хяналт-шинжилгээнд тухайн төсөл, хөтөлбөр нь төлөвлөгдсөн тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, хэмжээсийн дагуу хэрэгжсэн эсэхийг шалгахын тулд ашиглалт, зориулалтад шаардлагатай байгууламжуудтай холбоотой биет индекс, үзүүлэлтүүдийг голчлон ашигладаг. Энэ төрлийн хяналт-шинжилгээнд төсвийн гүйцэтгэлийг тухай бүрт нь хийж байсан эсэхийг хянахын тулд мөнгөний индексийг ашигладаг. Мөн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээнд индексүүдийг ихээр ашигладаг. Нийгэм, эдийн засгийн янз бүрийн индексийг ашигладаг бөгөөд хүрээлэн буй орчин, соёл, зан үйл болон бусад нөлөөллийг илэрхийлэх нэмэлт индексийг ашиглах нь түгээмэл байдаг.

### **11.4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилт**

#### **(1) Монгол Улсын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо**

Монгол Улсад хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн хяналтын тогтолцоо болон хэрэгжилтийн хяналт-шинжилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдаг. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтийн чухал хэсгийг бүрдүүлдэг. 2020 оны 5-р сард шинэчлэн найруулсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулинд хөгжлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг тусгасан.

Тус хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хуулийн нэр томъёог тодорхойлсон.

Тухайлбал “хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагааг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичиг гэж тусгасан. Мөн “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ”-г хуульд заасан зарчмыг баримталсан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын чиг үүргээ хэрэгжүүлсэн болон хамтран ажилласан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн цогц үнэлгээ гэж тусгасан байна (4 дүгээр зүйл).

Хуулинд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмууд, тэдгээрийн агуулгыг тодорхойлсон. Хуулинд зааснаар “бүх талын оролцоог хангасан байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулах зарчим бол “төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн хуулийн этгээдийг зохистойгоор оролцуулах зарчим юм (5 дугаар зүйл).

Түүнчлэн хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрлүүдийг тодорхойлсон. Тухайлбал дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, байгаль орчны зорилтот хөтөлбөр, засаглалын зорилтот хөтөлбөр, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрүүд байна (6 дугаар зүйл).

Хуулинд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогч талууд болон тэдний эрх, үүргийг зааж тусгасан. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдоос гадна аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, улс төрийн нам, хувийн хэвшил оролцоно (8 дугаар зүйл). Засгийн газрын бүрэн эрхэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг улсын түвшинд удирдан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах үйл ажиллагааг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа багтана.

Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах болон бусад үүргийг заасан (хуулийн 9.4).

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотойгоор Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх чиг үүрэгтэй байна. Мөн Засаг дарга нь сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна (хуулийн 9.10).

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотойгоор тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан эсэх талаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан тухайн бодлогын баримт бичгийг хэлэлцэн, батлах, эсхүл буцаах чиг үүрэгтэй байна (хуулийн 9.11).

Үндэсний хөгжлийн хүрээлэн нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотойгоор эдийн засгийн хөгжлийн суурь дэвсгэр болох хүн ам, хөдөлмөрийн нөөц, эдийн засгийн эргэлтэд оруулах малын гаралтай түүхий эд, ус, газрын баялгийн нөөцийн судалгааг байршлаар нарийвчлан хийж, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн төсөөлөл, нөөцийг ашиглах оновчтой арга замыг тодорхойлох чиг үүрэгтэй байна (хуулийн 9.12).

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотойгоор хуулинд дараах заалтууд орсон. Засгийн газар баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэх зорилгоор хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ (21 дүгээр зүйл).

## **(2) Бүсчилсэн хөгжлийн үнэлгээ, санал**

Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна. Баримт бичгийг боловсруулахад үндэсний хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдоос гадна аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, улс төрийн нам, хувийн хэвшил оролцоно. Засгийн газар баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулж, олон талын оролцоог хангана.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангана. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотойгоор тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн бодлогын баримт

бичгийг хэлэлцэн, батална эсхүл буцаана. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн боловсруулалт доороос дээш чиглэсэн байгаа бол бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр нь дээрээс доош чиглэсэн төлөвлөлттэй байна. Орон нутгийн түвшинд төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчмыг баримталж, хэрэгжүүлдэг эсэх нь тодорхой бус байна.

Хуулинд заасан дээрээс доош, доороос дээш чиглэсэн төлөвлөлтийн тодорхойлолт нь олон улсад түгээмэл байдаг тодорхойлолтоос ялгаатай байна. Дээрээс доош, доороос дээш чиглэсэн төлөвлөлт нь орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд зэрэг хөгжлийн удирдлагын доод түвшний оролцогч талуудыг хамарсан төлөвлөлтийн үйл явц байдаг. Дээрээс доош чиглэсэн төлөвлөлтийг хөгжлийн удирдлагын дээд түвшний оролцогч тал буюу Засгийн газар хийдэг ба доод түвшний оролцогчдоод чиглэсэн байдаг. Доороос дээш чиглэсэн төлөвлөлтийг орон нутгийн захиргааны байгууллага, иргэдийн хамт санаачилж, хэрэгжүүлдэг.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулна гэж заасан (23 дугаар зүйл). Харин хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах шатанд эсвэл баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор олон нийтийн хэлэлцүүлэг хийх, санал, хүсэлт авах үйл явц талаар зааж, тусгаагүй. Энэ нь улсын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангахад тодорхой бус байдлыг бий болгоно.

Эдгээрээс дүгнэхэд хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан орон нутгийн удирдлагын ашиг сонирхол, үйл ажиллагааны зорилтыг хангах институцийн механизм байхгүй ба Засгийн газраас боловсруулдаг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр тусгагддаг. Өөрөөр хэлбэл хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хоёр тусдаа байгаа ба нэгийг нь Засгийн газар, нөгөөг нь нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлж байна. Эдгээр үйл ажиллагааг нэгтгэхийн тулд орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад зориулсан удирдамжийг Засгийн газраас хангах, Засгийн газар болон нутгийн захиргааны байгууллагын хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтийн уялдааг хангасан, хоорондоо уялдаа холбоо бүхий хөтөлбөр боловсруулалт, төсөвлөлт, хяналт, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авч, хэрэгжүүлэх шаардлагатай. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, тэдгээрт хяналт тавих үйл ажиллагааг хэн хариуцаж, ямар цаг хугацаанд хийж байгааг тодорхой болгож, үр дүнд нь үндэслэн төсөл, хөтөлбөр боловсруулах, төсөв, санхүүг төлөвлөх, хяналт, үнэлгээ хийх үйл ажиллагааг сайжруулах тогтолцоог нэвтрүүлэх нь чухал.

ҮХЦТ-нд санал болгосон Бүсийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр (БХНХ) болон Бүсийн хөгжлийн зөвлөл (БХЗ) нь Засгийн газар болон нутгийн захиргааны байгууллагын хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтийг уялдуулах институцийн үр дүнтэй механизмыг бий болгоно. БХНХ-ийг БХЗ-өөр дамжуулж, ҮХГ-ын заавар, чиглэлийн дагуу тухайн бүсийн аймгуудын төлөөллүүд боловсруулна. Эхэндээ төсөвлөлт, төслийн хэрэгжилтийг салбарын агентлаг хэрэгжүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн агентлагтай хамтран орон нутгийн удирдлага хэрэгжүүлж болно. Харин яваандаа орон нутгийн удирдлагын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг дэмжих чиг үүрэг бүхий ҮХГ-т шинээр байгуулагдах нэгжээр дамжуулж бүсчилсэн хөгжлийн төсвийг тусад нь төсөвлөж, гүйцэтгэх



зохицуулалттай байж болно.

### **11.4.3 Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

#### **(1) Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээг сайжруулах хэрэгцээ, шаардлага**

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээг салбарын хэрэгжүүлэгч агентлагууд хийдэг. Үндэсний статистикийн хороо (ҮСХ) хөгжлийн зорилтын гүйцэтгэлийг нийгэм, эдийн засгийн болон бусад индексүүдээр нэгтгэн гаргадаг. ҮСХ нь гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэж, статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулж, олон нийтийг хялбар олж авах боломжтой, цогц, нарийвчлал бүхий, сүүлийн үеийн мэдээллээр хангаж байгаа нь сайн жишиг юм.

НҮБ-ын ТХЗ-уудын хүрээнд жендэр, орлогын хуваарилалт, аймаг, сумд, үндэс угсаа, нийгмийн бүлэг болон бусад холбогдох микро түвшний мэдээллийг цуглуулах шаардлагатай болсон. Үүний дагуу ҮСХ микро түвшний мэдээллийг цуглуулж, нэгтгэх ажлыг эхлүүлсэн. АХБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон бусад хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр асуулгын хуудсыг илүү нарийвчлалтай болгож, нэмэлт индекс, микро өгөгдлийг ашиглаж, хөдөлмөрийн эрхлэлтийн улирлын судалгаа, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, таван жил тутамд явуулдаг нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа зэрэг тогтмол хийгддэг судалгаануудыг сайжруулсан.

Уламжлалт бус мэдээллийн эх үүсвэр болох их өгөгдөл, Google-д суурилсан өгөгдөл, Facebook болон бусад эх үүсвэрийг ашиглан илүү нарийвчилсан, тодорхой өгөгдлийг цуглуулах шинэ үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн. Цаашид АНУ-ын Үндэсний сансар судлалын агентлаг (NASA), хиймэл дагуул, арилжааны банк болон үүрэн телефоны харилцаа холбоо ч мэдээллийн эх үүсвэр болж болох юм. ТХЗ-уудын хүрээнд ядууралтай холбоотой өгөгдөл, индекс тлүү ач холбогдол өгч байна. НҮБХХ нь ТХЗ-ын хэрэгжилтийг хянах систем /dashboard/-ийг байгуулах, ажиллуулахад дэмжлэг үзүүлж байна. Ийнхүү шинэ санаачилгуудыг хэрэгжүүлж байгаа ч ТХЗ-уудын хяналт, үнэлгээнд шаардлагатай мэдээллээр бүрэн хангаж чадахгүй байна.

#### **(2) Санал**

ТХЗ-уудыг хэрэгжүүлэх зорилгоор илүү цогц, өргөн хүрээний мэдээлэл цуглуулахад хувь хүмүүс, хувийн хэвшил болон орон нутгийн захиргааны байгууллагуудын идэвх оролцоо зайлшгүй шаардлагатай. Энэ ажилд олон талын оролцоог хангаж чадаагүй тохиолдолд ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай микро өгөгдлийг цуглуулах, нэгтгэх үйл ажиллагаа нь маш өндөр зардалтай болно. Ухаалаг гар утас, үүлэн системийг ашиглан вэбэд суурилсан хөдөлгөөнт хяналт, үнэлгээний системийг бий болгох хэрэгтэй. Энэхүү системд хувь хүмүүс, ААНБ-ууд сайн дураараа мэдээлэл оруулах боломжтой байх ба орон нутгийн захиргааны байгууллагын мэдээлэл боловсруулалтад Засгийн газраас дэмжлэг үзүүлнэ.

Жишээлбэл малчидтай холбоотой мэдээлэл буюу малын бүлэглэлт, малын тоо толгой, бүтэц, малчин өрхийн нутаг сэлгэлт, байршил, ус, тэжээлийн хүрэлцээтэй байдал болон бусад мэдээллийг бодит цаг хугацаанд авснаар орон нутгийн захиргааны байгууллага тэдэнд тулгарч буй асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэхэд ач холбогдолтой. Мөн малчид орон нутгийн захиргааны байгууллагаас өгдөг орон нутгийн цаг уур, малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт,

үнийн мэдээлэл, малын өвчлөлийн эсрэг авч буй арга хэмжээ, тэжээлийн хангамжийн талаар мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой болно. Ингэснээр малчдын аж байдлыг дэмжиж, ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулах болно.

Энэхүү хоёр талт харилцаа холбооны үйл ажиллагааг дэмжихийн тулд нэг талаас хувь хүн, компаниуд, нөгөө талаас захиргааны байгууллагаас сайн дурын оролцооны урамшууллыг олгох хэрэгтэй. Иргэд, тухайлбал малчид өөрсдийн хэрэгцээ, шаардлага болон орон нутагт хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд (аялал жуулчлалын г.м.) шаардлагатай нөөц, боломжийн талаар мэдээллийг өгөх боломжтой ба хувийн хэвшил орон нутгийн нөөц, нутгийн удирдлагын дэмжлэгийг харгалзан хөрөнгө оруулалт хийж болно. Мөн орон нутгийн удирдлага нь хамгийн бага зардлаар нийгэм, эдийн засгийн микро өгөгдлийг цуглуулах боломжтой болно.

Орон нутгийнханы оролцоо, дэмжлэгтэйгээр мэдээлэл цуглуулж, үүсгэдэг тул гаднаас мэдээлэл цуглуулах үйлчилгээ авахаас ихээхэн ялгаатай байдаг. Түүнчлэн энэ нь нэг талаар иргэд, олон нийтийн чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагаа болно. Нөгөө талаар орон нутгийн захиргааны байгууллагууд нутгийн иргэд, олон нийттэй харилцахдаа илүү цогц мэдээлэл, МХХТ-ийн хэрэгслүүдийг ашиглах чадавхаа дээшлүүлнэ. Үр дүнд нь орон нутгийн захиргаа, иргэд хамтарч илүү оновчтой төсөл, хөтөлбөрүүд, институцийн арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

#### **11.4.4 “Алсын хараа 2050”, ХАНСХЕТ, БХБ, ҮХЦТ-ний хяналт-шинжилгээ, үнэлгээ**

ҮХЦТ-г тусгаж, уялдуулж боловсруулах ХАНСХЕТ, БХБ-ын баримт бичгүүдийг хууль тогтоомжид заасан байдаг тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. ҮХЦТ-нд тусгагдсан одоогийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ нь хяналт-шинжилгээ, үнэлгээний суурь мэдээлэл болно. “Алсын хараа 2050” баримт бичигт үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд болон хүрэх түвшинг 2030, 2040, 2050 оноор тодорхойлсон.

“Алсын хараа 2050” баримт бичигт ДНБ, нэг хүнд ногдох ДНБ ба уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан. Тиймээс хяналт-шинжилгээ нь эдгээр болон бусад шалгуур үзүүлэлтүүд дээр хийгдэнэ. “Алсын хараа 2050”-д тусгасан ДНБ-ий өсөлтийн түвшин 2030 он хүртэлх хугацаанд өндөр, 2030-2040 онд ҮХЦТ-нд тооцоолсноос бага байгаа ба 2030, 2040 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь ҮХЦТ-нд тооцоолсноос нэлээд өндөр байна. “Алсын хараа 2050”, ҮХЦТ-ийн 2030, 2040 оны хүн амын хэтийн тооцоо нийцэж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” баримт бичигт 2050 онд орон нутгийн хүн ам нь нийт хүн амын 50 хувьтай тэнцэнэ гэж тооцоолол хийсэн. ҮХЦТ-нд бүсчилсэн хөгжлөөр дамжуулж орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах төлөвлөлтүүдийг тусгасан ба орон нутгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь нь бүсчилсэн хөгжлийн үр дүнг илтгэнэ.

“Алсын хараа 2050”-д бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдэд 1) шинээр байгуулагдсан хүнс, хөнгөн үйлдвэрийн тоо, 2) шинээр байгуулагдсан ХААҮТП-ийн тоо, 3) олон улсын зэрэглэлтэй нисэх буудлын тоо зэрэг үзүүлэлтүүдийг багтаасан. Эдгээр үзүүлэлтүүд нь бүсчилсэн хөгжлийн үр дүнг төдийлөн илтгэхгүй. Харин шинээр байгуулагдсан хөнгөн үйлдвэрүүдийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, эдгээр үйлдвэрүүдийн бий болгосон ажлын байрууд, ХААҮТП-ууд дээр

байгуулагдсан ААН-үүдийн тоо зэрэг үзүүлэлтүүдийг харгалзаж үзэх нь чухал. ҮХЦТ-нд Чойбалсан, Ховд хотуудын нисэх онгоцны буудлуудыг олон улсын нисэх онгоцны буудал болгож хөгжүүлэхийг санал болгосон. Нисэх онгоцны буудлуудын тогтмол нислэгийн тоо, зорчигчдын тоо нь шалгуур үзүүлэлт болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай нийгмийн бусад үзүүлэлтүүдэд ядуурлын түвшин, ажилгүйдлийн түвшин, хөдөө орон нутгийн ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, хатуу хог хаягдлын менежмент зэрэг багтана. Эдгээр үзүүлэлтүүдэд шаардлагатай жендэрийн, орлогын хуваарилалтын болон бусад холбогдох микро түвшний мэдээллийг ҮХЦТ-нд тусгасан шинэ аргачлалын дагуу үе шаттайгаар цуглуулж, нэгтгэх ба эдгээр нь ТХЗ-ын үнэлгээнд мөн шаардлагатай мэдээлэл юм.